



ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ
ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл-VII

Улаанбаатар хот

2020 он

ГАРЧИГ

БҮЛЭГ 1. БОЛОВСРОЛ

БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦООН ДАХЬ ЗОРИЛТОД БҮЛГИЙН СУРАГЧИД
/МОНГОЛ УЛСЫН ЖИШЭЭ ДЭЭР/

Х.Сансармаа.....10

ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛД ЦАХИМ ХИЧЭЭЛИЙГ АШИГЛАСАН НЬ
Д. Алтансүх.....35

КАУФМАНЫ ХҮҮХДИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХОЁРДУГААР СОРИЛЫН СУДАЛГААНЫ
ҮР ДҮН (СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ЖИШЭЭН ДЭЭР)

Л. Соёлмаа.....55

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ СУРАГЧДЫН ИХ ДЭЭД СУРГУУЛЬД СУРАЛЦАХ
СОНИРХОЛ, НӨЛӨӨЛӨХ ЗАРИМ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН СУДАЛГАА

Г. Энхжин, Б. Гүнсэнхорол.....73

ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ҮГ ЯРИА- УТГЫН ОЙН
ХӨГЖЛИЙН СУДАЛГАА

Д. Хорлоо.....81

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ СУРАЛЦАГЧИД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ДАДЛАГАД
ГАРАХАД ТУЛГАРДАГ БЭРХШЭЭЛҮҮДИЙГ ТОДОРХОЙЛЖ, ШИЙДВЭРЛЭХ
АРГА ЗАМУУДЫГ ДЭВШҮҮЛЭХ

Э.Бямбадаш.....91

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙГ ПАРА СПОРТОД ТАТАН
ОРОЛЦУУЛАХ БОЛОМЖИЙГ СУДАЛСАН ДҮН

Ж.Загас.....105

ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ БОЛОВСРОЛ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ХЭЛБЭР, БАГШ
МЭРГЭЖИЛТНИЙ АСУУДЛЫГ СУДАЛСАН НЬ

Г.Батцэнгэл, Б.Золзаяа.....116

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛ БА ИННОВАЦИ

Д.Батмөнх.....132

ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛ ШААРДЛАГАТАЙ ХҮҮХДИЙГ
БОЛОВСРОЛД ТЭГШ ХАМРУУЛАХ ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЭХ НЬ /ХӨВСГӨЛ
АЙМГИЙН ЖИШЭЭН ДЭЭР/

Д.Баасансүрэн.....144

ТӨРИЙН ӨМЧИЙН ИХ, ДЭЭД СУРГУУЛЬД
ТУЛГУУР ЭРХТНИЙ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ОЮУТАН СУРАЛЦАХ
БОЛОМЖИЙГ ҮНЭЛЭХ НЬ

Д.Мөнх-Учрал, Б.Түвшинбаатар, Т.Оюун-Эрдэнэ.....152

ОЮУНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ТУСГАЙ СУРГУУЛЬД
СУРАЛЦАГЧДЫН ТАНИН МЭДЭХҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ГАРСАН
ӨӨРЧЛӨЛТИЙГ СУДАЛСАН ЛОНГИТЮД СУДАЛГААНЫ ТОЙМ ҮР ДҮН

Ж.Нямцэцэг, Б.Туяа, Г.Уянга, Ж.Лхагваторгох, Р.Нэнсэндэн, Д.Цогзолмаа.....161

ЦАХИМ БОЛОН УЛАМЖЛАЛТ СУРГАЛТЫГ ХОСЛУУЛАН ХӨГЖЛИЙН
БЭРХШЭЭЛТЭЙ ОЮУТНУУДЫН СУРАЛЦАХ БОЛОМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ

Ц.Цэвэгмид, Р.Нурбек.....170

ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛ ШААРДЛАГАТАЙ ХҮҮХДҮҮДИЙН
СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮНИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

Н.Баярмаа, Х.Сайнсанаа, С.Өнөрсайхан.....181

БОЛОВСРОЛЫН САЛБАРААС ТУСГАЙ СУРГУУЛЬ-ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ
СУРАГЧИД РУУ ЧИГЛЭСЭН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮДИЙН СУДАЛГАА БА
БЭРХШЭЭЛ-ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

МУБИС.....190

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН БОЛОВСРОЛЫН ЗАРИМ АСУУДАЛ,
ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭХ НЬ

М.Мөнхзул.....204

МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБОО ТЕХНОЛОГИЙГ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ
ИРГЭНД ХЭРЭГЛЭХ НЬ

Ц.Нямаа.....223

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД БОЛОН ХӨГЖЛИЙН
БЭРХШЭЭЛГҮЙ ИРГЭДИЙН ЯЛГААТАЙ БАЙДАЛ

Х.Цэвээнжав.....231

БҮЛЭГ 2. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

ОЮУНЫ ЯЛГААТАЙ ЧАДВАРТАЙ ХҮНИЙГ АЖИЛД ДАДЛАГАЖУУЛАГЧ БУЮУ
ЖООБ КООЧЫН АЖЛЫН ТУРШЛАГААС

П. Мөнхчимэг.....250

СЭРГЭЭН ЗАСАЛТ, СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН МЭРГЭЖЛИЙН
БОЛОВСРОЛ, УР ЧАДВАР ОЛГОХ СУРГУУЛИЙН ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТ БА БОЛОВСРОЛЫН ҮР АШИГ

С.Цэрэндулам, Т.Мөнхбат.....254

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН
СУДАЛГАА

Б. Элбэгдорж.....269

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН СУРЧ БОЛОВСРОХ ЭРХИЙН
ХЭРЭГЖИЛТЭД ЭЦЭГ, ЭХИЙНХ НЬ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ НӨЛӨӨЛӨХ НЬ

С.Мягмарсүрэн.....290

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭДТЭЙ ЭХЧҮҮДИЙН СЭТГЭЛ ГУТРАЛЫГ
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛТАЙ ХОЛБОН СУДАЛСАН НЬ

Р.Энхчулуун.....297

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАРГҮЙ ИРГЭД МӨН
ҮҮ?

Б.Энхням.....302

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ТОХИРОХ АЖЛЫН БАЙРУУДЫГ
ҮҮСГЭХЭД ХОРШООЛЛЫН ХӨДӨЛГӨӨНИЙГ АШИГЛАХ НЬ

Л.Дансранбавуу, Ж.Гантулга.....309

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТ БА
НОРВЕГИ УЛСТАЙ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Д.Ариунгэрэл, Б.Уянга, Э.Балжинням, Г.Чанцалдулам, Г.Нямдулам.....324

БҮЛЭГ 3. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН
ТӨЛӨӨЛЛИЙГ ХАНГАХ АСУУДАЛ

С.Номынбаясгалан.....347

ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДАЛТЫГ ТОГТООХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА Б.Цэнд, М.Цэрэнбат.....	357
ГАМШГИЙН ҮЕД НИЙГМИЙН ЭМЗЭГ БҮЛГИЙГ ХАМГААЛАХ ТӨРИЙН БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ Ц.Ганчимэг.....	360
МОНГОЛ ДОХИОНЫ ХЭЛИЙГ ХУУЛИАР БАТАЛГААЖУУЛАХ НЬ А.Энхбаатар.....	381
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БЭЛГИЙН ЭРХ ЧӨЛӨӨГ ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ Л.Эрдэнэхүү, Т.Сумъяабазар.....	390
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ Д.Батням, Э.Буяндэлгэр.....	405
БҮЛЭГ 4. ДЭД БҮТЭЦ	
ТЭРГЭНЦЭР ЧИРЭГЧИЙН ЗАГВАР О. Хатанбүүвэй, Б.Зоригтбаатар, Т.Амартүвшин.....	418
REINFORCEMENT LEARNING АШИГЛАН АВТОМАТ УДИРДЛАГАТАЙ ТЭРГЭНЦРИЙН АЛГОРИТМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ Г.Гантулга, Б. Луубаатар.....	426
ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ОЮУТНУУДЫН НОМЫН САНГААР ҮЙЛЧЛҮҮЛЭХ БОЛОМЖ Ж.Еркеш.....	439
ХИЙМЭЛ ОЮУН УХААН: ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛЫН ИННОВАЦИЙН АСУУДАЛ БОЛОХ НЬ М.Нарантуяа.....	446
БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨЛТӨНД ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭН ЗОРЧИХОД ЗОРИУЛСАН ШАТЫГ ОНОВЧТОЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ БОЛОМЖ Д. Алтанцэцэг.....	453

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖИЙН
ЭМПИРИК СУДАЛГАА: ГАМШГИЙН ҮЕИЙН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН ЖИШЭЭН
ДЭЭР

Ч.Батзориг.....463

БҮЛЭГ 5. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

БАЙНГЫН АСАРГАА ШААРДЛАГАТАЙ ХҮҮХДҮҮДЭД ОЛГОХ НИЙГМИЙН
ХАЛАМЖИЙН МӨНГӨН ТЭТГЭМЖИЙН ХҮРЭЛЦЭЭ, ҮР АШИГТАЙ
ЗАРЦУУЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ

Б.Төмөрчулуун, Ж.Өлзийсайхан.....479

ТАРХИНЫ СААТАЙ ХҮҮХДИЙН ХӨГЖИЛД
ГЭР БҮЛИЙН ОРОЛЦОО

Б.Сувд-Эрдэнэ.....498

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ

Г.Золзаяа, Б.Өсөхбаяр.....523

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН СЭТГЭЛЗҮЙН ХАНДЛАГЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН СУДАЛГАА

Г. Болормаа.....530

ХАРАА, СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ҮЗҮҮЛЖ БУЙ НИЙГМИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ БА ОРЧНЫ ХҮРТЭЭМЖИЙГ СУДАЛСАН ҮР ДҮН

Т.Батдулам.....543

ТӨРИЙН ӨМЧИЙН ИХ, ДЭЭД СУРГУУЛЬД
ТУЛГУУР ЭРХТНИЙ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ОЮУТАН СУРАЛЦАХ
БОЛОМЖИЙГ ҮНЭЛЭХ НЬ

Д.Мөнх-Учрал, Б.Түвшинбаатар, Т.Оюун-Эрдэнэ.....568

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ТУСЛАМЖ ХҮССЭН ТАНИХ ТЭМДГИЙГ
ШИНЭЭР НЭВТРҮҮЛЭХ НЬ

Б. Анударь, Ч. Дэлгэрмаа.....577

ТЭРГЭНЦЭРТЭЙ ИРГЭДИЙН АРИУН ЦЭВРИЙН АСУУДЛЫГ ШИЙДСЭН
ТҮГЭЭМЭЛ ЗАГВАРЫГ БИЙ БОЛГОХ НЬ

А.Лхамсүрэн, Б.Отгон-эрдэнэ, Ч.Энхжавхлан, Т.Эрхэс.....596

ХҮҮХДИЙН ТӨВ СУВИЛЛЫН СЭРГЭЭН ЗАСАХ АМБУЛАТОРИЙН ТАСГИЙН
ХЯНАЛТАНД ХАМРАГДСАН ХҮҮХДҮҮДИЙН НИЙГМИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА

Р.Отгонсайхан, Х.Циендолгор, Н.Баяржаргал.....616

БҮЛЭГ 6. ЭРҮҮЛ МЭНД

ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДАЛТЫГ ТОГТООХОД ОЛОН УЛСЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АНГИЛЛЫГ (ICF) АШИГЛАХ НЬ: ICF – BSSQ Э.Насантогтох, С.Оюударь, Ц.Тэмүүлэн Г.Маралгуа, Б.Марал, М.Лхамсүрэн, П.Батсүх С.Мөнхзаяа, Б.Ариунтунгалаг.....	623
ТАВХАЙ УНЖИЛТТАЙ ХҮҮХДИЙН АЛХАХ ҮЕИЙН ШАГАЙН ҮЕНИЙ ДАЛАЙЦАД НАЙМЫН ТОО ХЭЛБЭРИЙН ТЭПИНГИЙН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ Н.Цэсэнжав, Х.Энхгэрэл, Ц.Батчимэг.....	632
ХАВТГАЙ ТАВХАЙН АЛХААНЫ ФАЗЫГ СУДЛАХ НЬ А.Нямсүрэн, Ц.Батчимэг.....	642
ДУНГИЙН СУУЛГАЦЫН ХАГАЛГААНЫ ДАРААХ ҮР ДҮНГ ТОДОРХОЙЛОХ НЬ Х. Бямбажава. Лхагвасүрэн, Г. Ням-Осор, Н. Солонго, Ц. Эрдэнэтуяа.....	647
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ ИЛРҮҮЛЭХ АРГАЧЛАЛЫГ ЗОХИЦУУЛАН ХЭРЭГЛЭСЭН НЬ Х.Алтанхундага, Б.Туяа, Д.Баяраа.....	669
ТАРХИНЫ СААЖИЛТТАЙ ХҮҮХДИЙН БОБАТ ЭМЧИЛГЭЭНИЙ ДАРААХ ӨДӨР ТУТМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЙЖРАЛЫГ ҮНЭЛСЭН Э.Баасанхүү Д.Батлхам Б.Мөнх-Эрдэнэ.....	685
АХМАД НАСТНЫ ТАРГАЛАЛТ БА ИЛҮҮДЭЛ ЖИНГИЙН ТАРХАЛТЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН Х.Бямбасүрэн, У.Эрхэмбаяр, Н.Болормаа, С.Гэрэлмаа, Д.Нарантуяа, С.Өнөрсайхан.....	690
БУЛЧИНГИЙН ЧАНГАРЛЫН ҮЕД ГҮНИЙ МАССАЖ АППАРАТЫН ЭМЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮНГ ТООЦОХ О.Энхжаргал ,Ба.Дулмаа,Н.Бат-Уянга ,Х.Туул.....	696
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ТЕХНОЛОГИ АШИГЛАН ЦАГ АЛДАЛГҮЙ ХҮРГЭХ Б.Ганзориг.....	700
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЭРҮҮЛ МЭНДЭД ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ Д. Батням, Э. Буяндэлгэр.....	703

СЭТГЭЦИЙН ЭМГЭГТЭЙ ХҮНИЙ СЭТГЭЦ-НИЙГМИЙН РЕАБИЛИТАЦИ
Л.Уянга, Б.Оюунтуяа, Я.Сампил.....715

АХМАД НАСТНЫ ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ АНХДАГЧ ЭРСДЭЛТ ХҮЧИН
ЗҮЙЛСИЙН ТАРХАЛТЫН СУДАЛГАА
У.Эрхэмбаяр, Х.Бямбасүрэн, Х.Сайнсанаа, Н.Болормаа, П.Ундармаа,
С.Гэрэлмаа, Д.Дэлгэрмаа, Д.Нарантуяа, С.Өнөрсайхан.....720

Өмнөх үг



Монгол Улс Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид нэгдэн орсон НҮБ-ын гишүүн орон бөгөөд 2016 онд конвенцийн үзэл баримтлалд тулгуурлан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүндэтгэсэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг Улсын Их Хурлаас батласан ба бусад холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр ажиллаж байна.

Үндэсний статистикийн хорооны 2020 оны Хүн ам, орон сууцны тооллогоос хөгжлийн бэрхшээлтэй 106.4 мянган хүн байгаа нь хүн амын 3.3 хувийг эзлэж байна. Иймээс тэд нийгмийн нэг гишүүн байж нийгэмд бүрэн дүүрэн, үр дүнтэй, тэгш боломжтой, хүртээмжтэй оролцох нөхцөл боломж бүрдүүлэхийг судалгаа шинжилгээнд тулгуурлах нь чухал ач холбогдолтой байна.

Бид энэхүү эрдэм шинжилгээний хурлыг анх хөгжлийн бэрхшээл салбарыг судалгаа нотолгоонд тулгуурлан хөгжүүлэх, энэ салбарт судалгаа, шинжилгээ хийж байгаа эрдэмтэн, судлаач, оюутан залуусыг идэвхжүүлэх зорилгоор зохион байгуулж эхэлсэн ба энэхүү зорилгодоо хүрч байгааг жил бүр бидэнд илгээж байгаа судалгааны өгүүлэлээс харах боломжтой байна.

Энэ жил 7 дах жилдээ зохион байгуулагдаж байгаа эрдэм шинжилгээний хурлыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах олон улсын өдрөөр “Хөгжлийн бэрхшээл судлал ба инноваци-2020” сэдвийн хүрээнд цахим хэлбэрээр зохион байгуулагдлаа. “Инноваци гэж шинэ бас шинэчилсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх, технологийн процессыг боловсронгуй болгох, нийгмийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр явуулж буй үйл ажиллагааны эцсийн үр дүн” гэж тодорхойлсон байдаг. Өнөө цагт шинжлэх ухаан, техник технологи асар хурдацтай хөгжиж бүх салбарт өөрчлөлт, шинэчлэлтийг авчирч байгаа бөгөөд манай салбарын хувьд бас нөлөөгөө үзүүлж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг илүү хүртээмжтэйгээр нийгмийн амьдралд оролцох боломжуудыг бий болгох арга замыг хайж буй судлаачид нэмэгдэж байгаа нь таатай байна.

Бидэнд судалгаа шинжилгээний бүтээлээ ирүүлж, хөгжлийн бэрхшээл судлалын шинжлэх ухааныг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж буй эрдэмтэн, багш, эмч, судлаач, мэргэжилтэн та бүхэнд талархал илэрхийлж ажлын амжилт хүсье.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ДАРГА Э. ТАМИР

1118270630
6345492 С.БА0120



1

БОЛОВСРОЛ

БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦООН ДАХЬ ЗОРИЛТОД БҮЛГИЙН

СУРАГЧИД

/МОНГОЛ УЛСЫН ЖИШЭЭ ДЭЭР/

Х.Сансармаа¹

¹Унгар улсын Сэгэдийн их сургуулийн докторант

Хураангуй

Улс орнууд, олон улсын байгууллагууд дэлхийд өрсөлдөхүйц, мэдлэг, ур чадвартай иргэнийг боловсролын тогтолцоогоор дамжуулан бий болгох нь чухал гэж үзэн зорилтод бүлгийн сурагчдын сурлагын амжилтыг үнэлэх замаар зөвхөн тухайн үндэсний хүрээнд судлахгүй, хамгийн амжилттай хэрэгжиж буй боловсролын тогтолцоонуудыг харьцуулан судалж, улс орны онцлог, соёл, хөгжил, нөхцөл байдалд тохируулан үр дүнтэй бодлогыг тодорхойлж байна. Иймд энэхүү судалгаагаар онолын бүтээл, судалгааны тайланд үндэслэн Монгол Улсын боловсролын тогтолцоон дахь тэгш байдлыг илэрхийлэх зорилтод бүлгийн сурагчдыг тодорхойлсон. Судалгааны үр дүн нь боловсролын чанарыг олон улсад нэвтэрсэн арга, аргачлалаар үнэлэх, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг илрүүлэх, улмаар салбарын бодлогын санал, зөвлөмжүүдийг боловсруулах практик ач холбогдолтой болно.

Түлхүүр үг: Тэгш байдал, Сургууль завсардалт, Сурлагын амжилт, Хөгжлийн бэрхшээл

Оршил

1990 оны шилжилтийн үе нь Монгол Улсын улс төр, нийгэм, эдийн засагт томоохон өөрчлөлт, шинэчлэлтийг авчирсан [1, 2, 3]. Улмаар энэхүү шилжилтийн үе нь боловсролын тогтолцоонд хүчтэй нөлөөлж, тухайлбал, боловсролын эрх тэгш байдалд илүү анхаарлаа хандуулахыг шаардаж эхэлсэн [4, 5, 6]. Монгол Улсын Засгийн газар олон улсын стандарт, шинэ үеийн хөгжлийг даган боловсролын салбарт бодлогын олон шинэчлэлтийг хийж, тэр дундаа тогтолцооны өөрчлөлтийг нэлээдгүй удаа өөрчилсөөр өнөөгийн 12 жилийн тогтолцоонд шилжин ирсэн. Харамсалтай нь Монгол Улсын хүний хөгжлийн индекс 0.73 буюу бусад улс орнуудтай харьцуулахад 92-р байранд [7], улсын хэмжээнд ядуурлын түвшин 2016 оны 29.6 хувиас 2018 онд 28.4 хувь болж бага зэрэг буурсан боловч хүн амын 15 хувь нь ядуурлын үндэсний төвшнөөс дээгүүр, 3 малчин өрхийн нэг нь ядуу, 25-29 насны эмэгтэйчүүд ихэвчлэн их дээд сургууль төгссөн дипломтой боловч илүү сайн цалинтай ажилд шилжихгүй байна [8, 9]. Бага, дунд боловсролын хамран сургалт 2018 оны байдлаар 98,5 хувьтай байгаа

боловч сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 3-5 насны хүүхдүүдийн дунд 70 хувьтай байна [7]. Нөгөөтээгүүр хамран сургалтын түвшин харьцангуй өндөр тоон үзүүлэлттэй байгаа хэдий ч ядуу өрхийн, малчдын, хөгжлийн бэрхшээлтэй болон үндэсний цөөнхийн зэрэг зорилтод бүлгийн хүүхдүүд цэцэрлэг, сургуульд хамрагдах боломж хязгаарлагдмал, сургууль завсардалтын статистик мэдээллүүд зөрүүтэй байсаар байна [10]. Монгол Улсын хувьд олон улсын судалгааны аргачлалд хамрагдаагүй, зөвхөн жишиг даалгаврын сангаас авч үнэлсэн байдаг ба боловсролын чанарын асуудал салбарын хөгжилд саад болсоор байгаа [11] ба тухайлбал, Боловсролын үнэлгээний төвөөс гаргасан 2012 оны боловсролын чанарын үнэлгээний тайланд хот ба хөдөөгийн сурагчдын чанарын үнэлгээний түвшин ялгаатай, мөн улсын нийт сурагчдын гүйцэтгэлийн дундаж үзүүлэлт доогуур гарч байсан бол энэ байдал 2018 оны судалгаагаар хэвээр байсаар байгаа ба түүнд нөлөөлөх учир шалтгааныг нарийн олж илрүүлэхгүй байна. Нөгөөтээгүүр боловсролын салбарт хүний хөгжлийн чиглэлээр баримтлах төрийн бодлогын үндэс, суурь болчхоор чанар суурь судалгаанууд үгүйлэгдэж байна гэж Боловсролын салбарын 2019 оны суурь тайланд мэдээлжээ [12].

Эдийн засаг, хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага [OECD]-ын Олон улсын сурагчдын үнэлгээний хөтөлбөр [PISA], Олон улсын сурлагын амжилтын үнэлгээний хороо [EIA]-ны Олон улсын математик болон шинжлэх ухааны судалгааны төв [TIMSS] зэрэг нь дэлхийн эдийн засгийн амжилтыг зөвхөн тухайн үндэсний хүрээнд судлахгүй, хамгийн амжилттай, үр дүнтэй хэрэгжиж буй боловсролын тогтолцоонуудыг сурагчдын сурлагын амжилтыг үнэлэх замаар хэмжиж, улмаар тухайн улс орны эрх баригчид, боловсролын байгууллагуудад өөрийн орны онцлог, соёл, хөгжил, нөхцөл байдалд тохируулан хэрэгжүүлэх үр дүнтэй бодлогыг тодорхойлох боломжийг олгож байна [13]. Иймд энэхүү олон улсад нэвтэрсэн арга, аргачлалаар боловсролын тогтолцооны тэгш байдлыг үнэлж, түүнийг хэмжих зорилтод бүлгийн сурагчдыг тодорхойлон, өнөөгийн Монгол Улсын боловсролын тогтолцооны нөхцөл байдлыг үнэлэн, цаашид авч хэрэгжүүлэх бодлогын санал, зөвлөмжийг боловсруулах нь зайлшгүй болоод байна. Өөрөөр хэлбэл, боловсролын тогтолцооны тэгш байдал хангагдаж чадаж байна уу?, Бид хэнийг голлон анхаарч авч үзэх хэрэгтэй вэ? гэсэн асуултууд тавигдаж байна.

Судалгааны ажлын зорилго, практик ач холбогдол

Монгол Улсын боловсролын тогтолцооны тэгш байдалд өртөж буй зорилтод бүлгийн сурагчдыг тодорхойлох, улмаар боловсролын чанарыг олон улсад нэвтэрсэн арга, аргачлалаар үнэлэх, тэр дундаа зорилтод бүлгийн сурагчдын сурлагын амжилтад нөлөөлөх хүчин зүйлсийг илрүүлэх, улмаар салбарын бодлогын санал, зөвлөмжүүдийг боловсруулахад ашиглагдах шинжлэх ухааны үндэслэлтэй судалгааны баримт бичиг болно.

Судалгааны хэрэглэгдэхүүн, арга зүй

Судалгааны сайтууд (ERIC, Researchgate, EBCOhost, Science Direct, Organizations of cross-national educational research, e.g. PISA, TIMSS) болон онолын бүтээлүүдийн судалгаануудын тайлан, илтгэлүүдэд дүн шинжилгээ хийв.

Судалгааны үр дүн

1. Эрсдэлт бүлгийн сурагчдад дэмжлэг үзүүлэхийн нийгэмд үзүүлэх үр нөлөө


Энэхүү дэд сэдвийн хүрээнд дараах асуултуудыг дэвшүүлж байна: Үүнд:

- (1) Боловсролын тогтолцоонд хөрөнгө оруулах нь яагаад чухал вэ?
- (2) Зорилтод бүлгийн сурагчдад дэмжлэг туслалцаа үзүүлснээр нийгэмд ямар үр нөлөөтэй вэ?
- (3) Зорилтод бүлгийн сурагчдын боловсролыг хэрхэн системийн түвшинд дэмжих вэ? эдгээр асуултууд нь судалгааны үндсэн асуултууд биш боловч энэхүү судалгааны ажлын үр дүнг ойлгоход чухал ач холбогдолтой онолын мэдлэгийг өгөх бөгөөд тодорхой хэдэн судлаачдын хийсэн судалгааны ажлын үр дүнг товч тоймлов. Hanushek болон Woessmann (2009) судалгаа нь хувь хүний таних мэдэх чадвар буюу мэдлэгийн түвшин болон эдийн засгийн өсөлтийн хоорондын хамаарлыг судалжээ. Судалгааны үр дүнд сурагчдын мэдлэгийн түвшиний ялгаа нь эдийн засгийн өсөлтөд чухал ач холбогдолтой ялгаа үүсгэдэг болохыг нотолжээ. Насанд хүрэгчдийн чадавхийг үнэлэх хөтөлбөр (PIAAC) нь нийгэмд эерэг нөлөө үзүүлэгч эрүүл мэнддээ анхаарах, сайн дурын ажилд оролцох, бусдад итгэх итгэл, улс төрд үр нөлөө үзүүлэх зэрэг үр чадварууд нь тухайн хүний боловсролын түвшинтэй холбоотой болохыг баримтжуулжээ [14]. Судалгааны үр дүнгээс харахад эрүүл мэндийн хувьд өөрийгөө маш сайн, сайн, эсвэл хэвийн гэж хариулсан хүмүүсийн дийлэх нь дээд буюу бүрэн дунд боловсрол эзэмшсэн хүмүүс байжээ. OECD (2013) судалгаа нь өндөр боловсролтой хүмүүс эрүүл

мэнддээ илүү их анхаарал хандуулдаг болохыг дүгнэж тэмдэглэжээ. Түүнээс гадна тэд нийгмийн хууль тогтоомжийг хэрэгжүүлдэг бусдад хүчтэй итгэдэг. Дээд өндөр боловсролтой хүмүүс сайн дурын ажил, нийгмийн идэвхтэй байдлаар дамжуулан нийгмийн сайн сайхны төлөө өөрчлөлтүүдийг хийх дуртай байдаг гэжээ. Мөн хэрхэн улс орноо хөгжүүлэх ба ялангуяа улс төрд шүүмжлэлтэй хандаж, асуудлыг ойлгож ухаарах, улмаар улс төрийн үйл ажиллагааг эхлүүлдэг гэжээ. Нэмж хэлэхэд тухайн боловсролын тогтолцоо нь зүгээр нэг стандарт хангах төдий мэдлэгийн хүрээтэй сурагчдыг бэлдэх биш маш өндөр боловсролтой өөрөөр хэлбэл, дээд болон боловсролын өндөр зэрэгтэй насанд хүрэгчдийг бэлдэх нь нийгэмд илүү эерэг үр дүнг авчирна гэж үзжээ. Hanushek болон Woessmann (2010) судалгаа нь олон улс орнууд боловсролын чанараа ахиулах явцдаа санхүүгийн болон бусад асуудалтай тулгарах үед түүнийг даван туулах бодлогын баримт бичгүүдийг хэрхэн боловсруулж буйг тайлбарласан [15]. Учир нь засгийн газар боловсролын салбарт хөрөнгө оруулах нь ирээдүйд үр өгөөжтэй гэдгийг олж харж ойлгодоггүй. Энэхүү судалгаа нь сурагчдын сурлагын амжилтыг дээшлүүлэхэд боловсролын хөрөнгө оруулалт чухал болохыг тайлбарлаж байгаа боловч өнөө үед улс орнууд боловсролын салбарт хангалттай хэмжээний хөрөнгө оруулалт хийж чадахгүй байна гэж харжээ. Heckman болон Masterov (2007) нар эрсдэлт буюу эмзэг, зорилтод бүлгийн бага насны сурагчдад илүү анхаарч хөрөнгө оруулалт хийхийн ач холбогдол, үр нөлөөний талаар хэлэлцэж танилцуулсан. Судалгааны үр дүнгээс харахад зорилтод бүлгийн хүүхдүүдэд бага насанд нь дэмжлэг, туслалцаа үзүүлж чадвал ирээдүйд нийгэмд учрах зардал бага зарцуулдаг болохыг нотолжээ [16]. Нобелийн шагналт эдийн засагч Heckman (2008) нь хүний янз бүрийн насанд нь хөрөнгө оруулсан нэгж долларын үр өгөөжийн түвшингийн ялгаатай дүр зургийг харуулжээ (Загвар 1) [17]. Өөрөөр хэлбэл, боловсролд хөрөнгө оруулсан 1 доллар тутмын эргэх ашиг нь 13 доллар байна гэдгийг тооцоолжээ. Тэр дундаа бага насны хүүхдийн боловсролд хөрөнгө оруулах нь тэдний сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангаж, улмаар боловсролын үр дүнд сайнаар нөлөөлж, хувь хүний зүгээс эерэг хөгжил, үр ашгийг бий болгож, нийгэмд тус дэмийг өгдөг байна.

Загвар 1.

Returns to a Unit Dollar Invested (Heckman, 2008.p.311)



2. Боловсролын тогтолцооны тэгш байдал

Хүн бүр боловсролын гадна үлдэх ёсгүй юм. Бүхий л боловсролын тогтолцоо нь сурагч бүрийг амжилтанд хүрэх тэгш боломжоор хангахыг зорьдог [13]. Гэхдээ тэгш байдлын тухай ойлголтыг судлаачид янз бүрээр тайлбарлагддаг төдийгүй энэ нь үр дүнгийн тухай юу? (outcome), нөөц үү? (Resources), санхүүжилт үү? (Funding), сурлагын амжилтыг ахиулах дэмжлэг үү? (academic support) гэсэн ойлголтуудаас бүрддэг ба боловсролын тэгш байдлын тухай тодорхой ойлгохын тулд бүх талаас нь буюу тогтолцооны үүднээс болон хувь хүн буюу суралцагчийн өнцгөөс харах хэрэгтэй юм [18]. Өөрөөр хэлбэл, боловсролын тэгш байдал нь боловсролын бодлого, шийдвэр гаргагч нар, сургуулийн удирдлага, багш, эцэг эхчүүд сургууль, анги, гэр бүл, хувь хүний түвшинд тэгш байдлыг сайжруулахын тулд юу хийж чадах талаар нарийвчлан авч үздэг судлагдахуун юм. Leaders (12, March, 2018) тодорхойлсны дагуу “Equity” гэдэг үг нь “байгалийн хууль буюу эрхийн дагуу, шударга ёс, өрөөсгөл хандлага, үл алагчлалаас ангид байх” гэсэн утгатай ба ихэвчлэн “шударга ёс”-той төстэй зүйлийг хэлдэг байна. OECD (2008) үзэж буйгаар боловсролын тэгш байдал нь боловсролын давуу талыг хүн бүрт нээлттэй байлгах шударга (fair), хүртээмжтэй (inclusive) тогтолцоо нь нийгмийг илүү тэгш (equitable) болгох хамгийн хүчирхэг хөшүүргүүдийг нэг юм гэжээ [19]. Жишээ нь: эмэгтэйчүүд өндөр боловсрол эзэмшсэн хэдий ч нийгэмд эзлэх байр суурь бага, зарим газарт орлого, эд хөрөнгийн тэгш байдал нэмэгдсэн байх, их дээд сургуульд эсвэл мэргэжлийн боловсрол эзэмшигчдийн тоо ихсэж байгаа

хэдий ч цаана нь олон хүүхдүүд боловсрол эзэмшиж чадахгүй орхигдох, шилжилт хөдөлгөөн, үндэсний цөөнхийн хүүхдүүдэд боловсролоос хаягдах зэрэг нь боловсролын тэгш байдлыг тэгш бус болгож байгаа явдал юм гэжээ. Өөрөөр хэлбэл, боловсролын тэгш байдал хоёр хэмжигдэхүүнээр тодорхойлогдоно. Үүнд:

- Шударга байдал (fairness): хувийн болон нийгмийн асуудлууд сурагчдын сурах чадварт саад болж чадахгүй.
- Хүртээмжтэй байдал (inclusive): гарал үүсэл, гэр бүлийн байдал, хувийн шинж чанар, хаана амьдарч буйгаас үл хамааран бүх сурагчдад боловсролын наад захын үндсэн стандартыг эзэмшүүлэх.

Дээрх хэмжүүрүүдийг хангахын тулд боловсролын тэгш байдлыг хэд хэдэн талаас нь авч үзэх шаардлагатай байдаг байна. Тухайлбал,

- Мөнгөний эх үүсвэр (monetary resources): Сургуулиудад санхүүжилтийг ижил тэгш хуваарилж чадаж байна уу?, Шаардлага ихтэй байгаа сургуулиуд илүү их санхүүжилтийг авч хэрэгтэй сурагчдадаа зарцуулж чадаж байна уу?.
- Академик стандарт буюу боловсролын чанар (academic standard): Бүх сурагчид боловсролын стандартыг хангаж, өндөр амжилтыг үзүүлж чадаж байна уу?, Тусгай хэрэгцээт шаардлагатай сурагчдад стандартыг хэрхэн нийцүүлдэг вэ.?
- Сургалтын агуулга ба дэмжлэг (academic content and support): бүх сурагчид өөрсдийн хэрэгцээнд нийцсэн өндөр чанартай боловсролыг олж авах боломжтой юу? Боловсролын чанарыг дээшлүүлэхэд зорилтод бүлгийн сурагчдад ямар дэмжлэг үзүүлэх вэ?, Бүх сурагчид өөрсдийн хэрэгцээг хангахад сайн бэлтгэгдсэн өндөр мэргэшсэн багш нартай юу?.

Дээрхээс үзэхэд equity гэсэн нэр томъёо нь бүх нийтийн боловсрол гэсэн нэр томъёонд илүү дүйцэх буюу “ядуу, бие эрхтний, оюун ухааны хомсдолтой, ажил хөдөлмөр эрхэлдэг, алслагдсан хөдөө орон нутагт байгаа нүүдэлчний, дайнд нэрвэгдсэн, хүүхэд залуучууд, насанд хүрэгсэд, хүүхдүүдэд боловсрол олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх ёстой төдийгүй сургууль завсардсан, суралцах боломжгүй хүүхдүүдийг боловсролд хамруулах үүднээс боловсролын тогтолцоог

уян хатан болгох ёстой гэсэн Дакарын үйл ажиллагааны хөтөлбөр (2000)-өөр тодорхой тайлбарлагдаж байна. Тэр ч утгаараа PISA, TIMSS олон улсын судалгаанууд сурагчдын сурлагын амжилтыг үнэлэх замаар тухайн боловсролын тогтолцоон дахь бие эрхтэн, нийгэм, хэл зүй, байршил зэрэг ялгаатай хэрэгцээнүүдээс үүдэн боловсролын гадна орхигдож болох эрсдэлтэй “disadvantaged students” буюу зорилтод бүлгийн сурагчдыг улс орны соёл, заншил, нийгэм-эдийн засгийн нөхцөлд тодруулан equity-г хэмжиж байна [13]. Харин манай улсын хувьд хэнийг зорилтод бүлгийн сурагчид болгон авч үзэж, equity-г хэрхэн хэмжих вэ? Энэхүү асуултад хариулахын тулд аль болох equity өргөн утгаар нь ойлгож, боловсролын гадна үлдэж орхиж болохооргүй хэн бүхнийг хамруулахын тулд энэ чиглэлийн судалгаа, шинжилгээний бүтээлүүд, хуулийн нэр томъёонуудад дүн шинжилгээ хийж, equity өнөөдрийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн тодорхойлох нь чухал бөгөөд өргөн утгаар нь авч үзсэн болно.

3. Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын өнөөгийн нөхцөл байдал

Сургуулийн өмнөх боловсрол:

Сургуулийн өмнөх боловсролд хамран сургалтын тоо ихсэж байгаа хэдий ч хот суурин газрын ядуу болон шилжин суурьшсан өрхийн хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон алслагдсан хөдөө орон нутгийн буюу малчдын хүүхдүүдийн хамрагдалт маш муу байна. Хот, хөдөө, төр болон хувийн, хувилбарт сургалтын хүүхдийн хөгжлийн үзүүлэлт харилцан адилгүй байгаад цэцэрлэгийн байршил, эцэг эхийн боловсрол (хүүхдийн ээж боловсролтой байх), амьжиргааны түвшин зэрэг хүчин зүйлүүд нөлөөлж байна. Хамгийн бага орлоготой өрхийн хүүхдүүд дунд орлоготой гэр бүлээс 3 дахин бага СӨБ-д хамрагдаж байна. СӨБ-ын салбарт хийгдсэн хөрөнгө оруулалт нь сургалтын хэрэглэгдэхүнээр бүрэн хангахгүй байна. Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээгээр алслагдсан буюу малчин өрхийн хүүхдүүдийн үр дүн хамгийн бага байна. Цэцэрлэгийн багш нарын ачаалал их тул мэргэжил дээшлүүлэх цаг хомс байна. Цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдийн талаарх статистик тоон судалгаа хангалтгүй ба орон нутгууд харилцан адилгүй мэдээлэлтэй байна [10, 11, 12, 20]. Гэр цэцэрлэгт зарим хүндрэл бэрхшээл гардаг ба тухайлбал, ундны цэвэр ус, ариун цэврийн өрөө, гал түлэх зэрэг болно [21]. Гэр цэцэрлэгт суралцаж буй

хүүхдийн танин мэдэхүй болон танин мэдэхүйн бус хөгжлийн чадвар ердийн цэцэрлэгийн хүүхдүүдээс доогуур байна.

Бага, дунд боловсрол

Хамран сургалтын түвшин өндөр байгаа хэдий ч түүнд зорилтод бүлгийн сурагчдын хамран сургалтын үзүүлэлт маш доогуур байна (үүнийг дор дэлгэрэнгүй тайлбарлав.). Улаанбаатар хот дахь сурагчдын суудлын тоо нэлээд өндөр, харин хөдөө орон нутаг, тэр дундаа сумдын сургуулиуд хүчин чадлаасаа доогуур ажиллаж байна. Алслагдсан бүс нутаг, сумдад багшийн далд хомсдол үүсэж, нэг багш олон төрлийн хичээлийг зааж, ажлын ачаалал ихсэж, хөгжих боломж нь хязгаарлагдаж байгаа нь хичээл, сургалтын чанарт сөргөөр нөлөөлж байна. Ерөнхий боловсролын хамран сургалт бараг 95 хувь байгаа боловч 2017-2018 оны хичээлийн байдлаар ЕБС-ийн гадна байгаа 6-14 насны 682 хүүхэд байна. Үүний дийлэнх нь эрэгтэй хүүхдүүд байна. Хөдөө орон нутгаас аймаг, нийслэлд, нийслэлийн захын хорооллоос төврүү гэх шилжилт хөдөлгөөнүүд нь бүлэг дүүргэлтийг хот, хөдөөд ялгаатай болгож, боловсролын үйлчилгээний чанар, үр дүнд сөрөг нөлөө үзүүлж байна. Сурагчдын сургууль явах хугацаа, бартаа саад зэрэг сургуульд хамрагдах боломж болон эдийн засаг, нийгэм-соёлын бусад хүчин зүйлийг шинжлэх ухааны үндэстэй тооцож, ЕБС-ийн бүтэц, байршил, хамран сургах тойргийг дахин хуваарилах шаардлагатай байна. 1998-2019 оны хооронд сургалтын цөм хөтөлбөрийг боловсруулж үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа хэдий ч зохих бэлтгэлийг бүрэн хангаагүйн улмаас сургалтын төлөвлөгөөнүүд болон сурах бичгүүд байнга өөрчлөгдөж байгаа ба сурах бичгийн хангамжийн асуудал бүрэн шийдэгдэхгүй, мөн багшлах боловсон хүчинг бэлтгэж амжихгүй байна. Сурагчдын сурлагын чанарын үзүүлэлтэд хангалтгүй, нөгөөтээгүүр суралцахуйн үр дүнг үнэлэх үнэлгээний журам тогтвортой бус байна. Сургуулийн удирдах албан тушаалтнуудын 32 хувийг багш бус мэргэжилтэй, 17 хувийг 5 хүрэхгүй ажлын туршлагатай хүмүүс удирдаж байгаа нь удирдан ажилтны мэргэшсэн байдал ба тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл байдал алдагдсаныг харуулж байна. Түүнчлэн сургалтын орчин, сургалтын хэрэглэгдэхүүнд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, суралцагчдад олсон мэдээллээ мэдлэг болгох лаборатори танхимууд шаардлагатай байна [10, 11, 12, 22].

4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролд хамрагдалт

Монгол Улс 2009 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенцыг соёрхон баталж, энэ хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, нийгэм-сэтгэл зүйн хэрэгцээт үйлчилгээг авах, бусдын нэгэн адил амьдрах тэгш эрхийг хүлээн зөвшөөрч, энэхүү эрхээ эдлэх явдлыг хангахын тулд 2016 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг батлан хэрэгжүүлж байна. “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай” НҮБ-ын конвенцод хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хүлээн зөвшөөрч, үл алагчлахыг арилган тэгш боломж бүрдүүлэх тухай онцгойлон дурдаж, энэхүү зорилгод чиглэсэн тэгш хамруулан сургах боловсролын тогтолцоог бий болгох, Ази, номхон далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг бодит болгоё” Инчеоны стратегид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бага, дунд сургуульд хамрагдалтын тоог нэмэгдүүлэхийг тэргүүлэх зорилт болгон тус тус заажээ. Дээр дурдсан олон улсын конвенц, хамтарсан тунхаглал, хуулийг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улс ч тодорхой хүчин чармайлт гарган ажиллаж, Монгол Улсын Их хурлын 2018 оны 56 дугаар тогтоол, Засгийн газрын 250 дугаар тогтоолоор хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжил, хамгааллын талаарх Засгийн газрын бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, салбар дундын зохицуулалт хийх, хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хангах, бие даан хөгжих чадварыг сайжруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар байгуулагдан ажиллаж байна [23]. Тэгш хамруулан сургах, тэгш боломжийг бүрдүүлэх үүднээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд чиглэсэн арга хэмжээг салбарын яамнаас авч, 2003 онд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах хөтөлбөр”, 2018 онд “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар”, “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал”, Боловсрол, Эрүүл мэнд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын 3 сайдын хамтарсан тушаалаар 2018-2022 онд хэрэгжүүлэх “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө” тус тус батлан хэрэгжүүлж байна.

Үндэсний статистикийн хорооны 2018 оны албан ёсны тайланд дурдсанаар Монгол Улсын хүн амын 3.2 хувь (105,691) нь ямар нэгэн хөгжлийн бэрхшээлтэй,

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

тэдгээрийн 11 орчим хувийг (10,512) 0-17 насны хүүхэд эзэлж байна. Үүнээс сургуулийн өмнөх насны боловсролд 2017-2018 оны хичээлийн жилд 1,599 буюу нийт суралцагчдын 0.6 хувь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. СӨБ-д суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, 2013-2018 он

Хичээлийн жил	Хүүхдийн тоо	Харааны	Сонсгол	Хэл ярианы	Оюун ухааны	Бие эрхтэний	Хавсарсан
2013-2014	1,368	246	71	242	118	389	302
2014-2015	1,437	242	82	288	119	514	192
2015-2016	1,369	218	81	252	151	390	277
2016-2017	1,513	241	102	282	170	451	267
2017-2018	1,599	274	97	261	198	391	378

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2018

Монгол Улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан төрийн өмчийн 2 тусгай цэцэрлэг, аймгийн төв дээр хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан хувийн хэвшлийн цэцэрлэгүүд, мөн төрийн өмчийн ердийн цэцэрлэг дээр тусгай бүлгүүд ажиллаж байна. Үүнээс ерөнхий боловсролын сургуульд 2017-2018 оны хичээлийн жилд 7,279 буюу 1.2 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй сурагчид байна. Өөрөөр хэлбэл, 2907 хүүхэд боловсролын гадна хамрагдаагүй ба эдгээр хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын тоо нь тусгай сургуульд суралцагчдын тооноос дийлэнх хувь нь бүрдэж байгаа юм (Хүснэгт 2).

Хүснэгт 2. ЕБС-д суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, 2013-2018 он

Хичээлийн жил	Хүүхдийн тоо	Харааны	Сонсгол	Хэл ярианы	Оюун ухааны	Бие эрхтэний	Хавсарсан
2013-2014	16,197	7,220	2,060	2,308	1,274	2,017	1,318
2014-2015	11,072	4,104	1,214	1,560	1,185	1,796	1,213
2015-2016	9,143	3,086	1,053	1,387	766	1,374	1,477
2016-2017	8,362	2,632	951	1,286	881	1,252	1,360
2017-2018	7,279	2,102	828	1,136	788	1,091	1,334

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2018

Монгол Улсад 1964 оноос хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан төрийн өмчийн 6 тусгай сургуулиуд (25, 55, 63, 70, 29, 116) үйл ажиллагаа явуулж байгаа ба үүнд нийт хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын ойролцоогоор 1500 сурагчид нь хамрагджээ.

Ерөнхий боловсролын сургуульд хамрагдаж буй хүүхдүүдийн тоо, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тоо жилээс жилд нэмэгдэж байхад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн ерөнхий боловсролд хамрагдалтын түвшин буурсаар байна (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн ЕБС-д хамрагдалтын түвшин, хувиар, 2004-2018 он

Хичээлийн жил	2004/ 05	2005/ 06	2006/ 07	2007/ 08	2008/ 09	2009/ 10	2010/ 11	2011/ 12	2012/ 13	2013/ 14	2014/ 15
Number of total students	557,3	556,9	542,5	537,5	532,1	522,1	512,2	505,4	496,1	497,0	505,8
Number of disabled students	52,74	46,67	38,50	35,89	23,90	22,90	18,29	18,01	10,37	10,19	11,07
Percent of all total (%)	9.4%	8.53%	7.01%	6.6%	4.4%	4.3%	3.6%	3.5%	2.1%	2.0%	2.1%
Academic year	2015/ 16	2016/ 17	2017/ 18	2018/ 2019	2019/ 2020						
Number of total students	535,1	552,0	572,8	593,2	640,5						
Number of disabled students	9143	8362	7279	6518	6053						
Percent of all total (%)	1.7%	1.5%	1.2%	1.1%	0.9%						

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2018

Бэрхшээл ба асуудлууд

Тусгай хэрэгцээт боловсролыг орчин үеийн үзэл хандлагаар нь ойлгож хөгжүүлэх талаарх арга хэмжээнүүд учир дутагдалтай байна [24]. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролд хамрагдалт хангалтгүй, хүнд хэлбэрийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсролын гадна үлдэж байна [10, 25, 26]. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ердийн цэцэрлэгт суралцах, нэмэлт туслалцаа дэмжлэг авах бололцоо хангалтгүй байна [20]. Цэцэрлэгийн удирдлага, багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах арга зүй дутмаг, тэдэнтэй ажиллахаас төвөгшөөн мөн сургалтын орчин бүрдээгүйн улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг элсүүлэх дургүй байна. Эцэг эхчүүдийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ сургууль, цэцэрлэгт зөөвөрлөх зам талбай байхгүй, зөөвөрлөх тээврийн хэрэгслийн асуудлын улмаас, ялангуяа өвлийн хүйтэнд зузаан хувцастай хүүхдээ зөөж хүргэж чадахгүйн улмаас цэцэрлэгээс хүүхдүүдээ гаргах асуудал түгээмэл байна. Тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэх асуудлууд хангалттай бус [27, 28], цаашид багшаар бэлтгэгдэж буй бүх оюутнуудад “Тэгш хамруулан сургах боловсрол” агуулгаар сонгон суралцах хичээлийг заавал эзэмшүүлэх шаардлагатай байна [29].

5. Сургууль завсардалт

Монгол Улсын хувьд Нийслэлийн Хүүхэд, Гэр бүлийн Хөгжлийн Газрын авч үзсэнээр бол “сургууль завсардалт гэдэг нь хичээлийн жилийн явц дундуур сургуулиа орхисон суурь боловсрол заавал эзэмших насны 7-16 нас буюу 1-9 анги хүртэлх хүүхдийг сургууль завсардсан хүүхэд” гэж авч үздэг байна [30]. Боловсролын яамны авч үзэж буйгаар бол “6-14 насны сургуульд суралцаагүй буюу суралцаж байгаад сургуулиас завсардсан болон сургуульд огт суралцаагүй

хүүхэд” гэж тус тус тайлбарлажээ. Эдгээр тодорхойлолтуудаас үүдэн сургууль завсардалтын талаарх хэмжүүрүүд ялгаатай, судалгааны тайлан мэдээллүүд хоорондоо зөрүүтэй байдаг байна [22]. Жишээлбэл, сургууль завсардалтын талаарх статистик мэдээллийг нэг эх сурвалжаас авах гэтэл албан ёсны тоон мэдээлэл байхгүй байсан тул олон эрх сурвалжаас тоон мэдээллийг цуглуулсныг дор нэгтгэн харуулав (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Ерөнхий боловсролын сургууль завсардалтын байдал, хувиар, 1988-2018 он

Хичээлийн жил	1988/1989	1991/92	1992/93	1993/94	1994/95	1995/96	1996/97	1997/98	1998/99
	4.4	8.1	8.8	6.2	4.3	3.5	3.8	3.4	3.4
Хичээлийн жил	1999/2000	2000/01	2001/02	2002/03	2003/04	2004/05	2005/06	2006/07	2007/08
	2.9	2.8	2.7	2.2	2.2	1.9	1.6	2.2	1.6
Хичээлийн жил	2008/09	2009/10	2010/11	2011/12	2012/13	2013/14	2014/15	2015/16	2016/17
	0.9	0.6	0.8	0.6	0.5	0.4	0.2	0.1	0.08
Хичээлийн жил	2017/18								
	0.06								

Эх сурвалж: [3, 21, 31] болон Үндэсний статистикийн хороо, 2018

Хүснэгтээс харахад сургууль завсардалтын түвшин 1990 оны Монгол Улсын улс төр, нийгэм-эдийн засгийн шинэчлэлтийн үед эрс нэмэгдэж, түүнээс хойш эрс буурсан байна. Гэхдээ сургууль завсардалтын талаарх статистик тоон үзүүлэлтийг харвал эрс буурсан мэт харагдаж байгаа боловч бусад олон улсын байгууллага, судлаачдын зүгээс өөр байр суурийг илтгэж харуулсан байдаг байна.

Сургууль завсардалтын үндсэн шалтгаанууд

Боловсрол, шинжлэх ухааны яамны статистик мэдээллийг илүү тодруулбал, 2015-2018 оны хичээлийн 3 жилийн хугацаанд сургууль завсардсан нийт сурагчдын дийлэнх шалтгааны 30 гаруй хувь нь өвчний улмаас, 10 гаруй хувь нь амьдралын гачигдлаас болсон гэж тэмдэглэжээ (Үндэсний статистикийн хороо, 2018). Үлдсэн нь сургууль сурах дургүй, ажил эрхэлсэн, дийлэнх олонх буюу 30 хол давсан хувийг бусад шалтгаанаар ерөнхийлөн тоймлосон байна. Үүнийг илүү дэлгэрэнгүй тайлбарлахын тулд олон улсын байгууллага, судлаачдын судалгаатай танилцаж дараах байдлаар тоймлолоо. Үүнд:

Ядуурал ба амьдралын гачигдал

2005 оны байдлаар сургуулийн насны олон хүүхдүүд гэр бүлдээ туслах, хоол, амь зуулгаа залгахын тулд ачаа зөөх, тамхи, чихэр ширхэглэж зарах,

машин угаах, телевизийн хөтөлбөр зарах, автобусны кондуктор хийх гэж сургууль завсардаж байсан [21]. Үүний дараа буюу 10 жилийн дараагаар хүүхдүүд гудамжинд гарч ажил хийх нь багассан хэдий ч ядуурал тогтвортой буурахгүй тэр дундаа захын хорооллын өрх, өрх толгойлсон эмэгтэйчүүд ядууралд нэрвэгдэж байна. 2016 оны хүн амын ядуурлын судалгаагаар Улаанбаатар хотод ядуурлын түвшин 24.8 хувь ба нийт хүн амын 1/3 нь шилжин ирэн төдийгүй илүү ядууралд өртөмтгий байгаа гэж тайлагнажээ. Эдгээр ядуу өрхүүд хүүхдэдээ сургуулийн дүрэмт хувцас, хичээлийн хэрэглэгдэхүүн, хуримтлалын мөнгө, баяр ёслол, ном дэвтрийн мөнгө зэрэг бусад зардлыг төлж чадахгүйн улмаас хүүхдээ сургуульд сургаж чадахгүйд хүрч байна [12]. Нөгөөтээгүүр боловсролын түвшин доогуур буюу бага боловсролтой эцэг эхчүүд илүү их ядууралд өртөж, магадгүй өдрийн нэг долларын орлоготой өрхөд төрсөн хүүхэд 4 дахин илүү сургууль завсардалтад өртөх эрсдэлтэй гэж Pastore (2012.p17.) сонирхолтой нотолгоо дэвшүүлсэн байна [32].

Шилжилт хөдөлгөөн ба нүүдэлчин хэв маяг

Монгол Улсын 1990 оны шилжилтийн үе нь ажилгүйдэл, ядуурлыг хэт бий болгосонтойгоор алслагдсан бүс нутгийн иргэд хот суурин газрыг бараадаж амьдрах ахуйгаа дээшлүүлэх гэж нүүдэллэж эхэлсэн [33]. Хөдөө орон нутгаас нийслэлд ирж буй шилжилт жилээс жилд нэмэгдэж байгаа. Үүнтэй улбаатай нийслэл дэх ерөнхий боловсролын сургуулиудын суудлын тоо ихсэж, харин хөдөө орон нутгийн сургуулиудын тоо багасч, улмаар мэргэжлийн багшийн далд хомс үүссэн байна. 2007-2017 онд 184 сургуулиуд шинээр ашиглалтад орсон ч 3 ээлжээр хичээллэж буй сургуулиудын тоо байсаар байгаа [12]. Тодруулбал, шилжин ирэгсэд иргэний бүртгэлээ хийж амжихгүй эсвэл хийлгээгүйн улмаас хотын сургуулиуд харьяалалгүй хүүхдүүдийг хүлээн авахгүй байсны улмаас сургууль завсардсан хүүхдүүд хотын хүүхдүүдээс 3 дахин их байсныг Pastore (2012) судалгаанд дурдсан байна [32]. Нөгөөтээгүүр Монголчууд нүүдлийн ёс заншилтай ба нийт хүн амын 40 гаруй хувь нь нүүдэлчин ахуй соёлтой, мал маллаж, жилийн дөрвөн улирал бэлчээр дагаж амьдардаг хэв маяг сургууль завсардалтад ихээхэн нөлөөлсөн байна [3, 21, 31, 34, 35]. Өөрөөр хэлбэл, Монголын өвөл их хүйтэн ба -40 градус хүртэл хүйтэн байдаг ба малчин үүнийг даван туулахын тулд нөмөр нөөлөг, бэлчээртэй газар бараадахын тулд байнга

нүүдэллэж, тиймээс эцэг эхчүүд сумын төв рүү хүүхдүүдээ 35-50 км зайд явганаар, машинаар, морин тэрэг зэргээр тээвэрлэн, олон цагаар хүргэж өгдөг байна. Эдгээр байдлаас болж зарим эцэг эхчүүд хүүхдээ сургуульд зөөхөөс төвөгшөөх, хүүхдүүд хүйтнээс хашрах, даарах, эсвэл бүр дулаан хувцас байхгүй, эсвэл мал маллах хүн хүч дутмагийг нөхөх гэж хүүхдүүдээ сургуулиас завсардуулж байна. Мөн 6 наснаас эхэлж 1-р ангид элсэн суралцахтай холбогдуулан эцэг эхчүүд хүүхдээ дотуур байранд ганцаар нь суулгах, эсвэл аав нь малаа маллаж, ээж нь хүүхдээ даган сумын төв рүү нүүх, магадгүй гэр бүл салах, эсвэл хүүхдээ хамаатан, найз нөхдийндөө суулгах, эсвэл 7, 8 нас хүртэл нь сургуульд элсэхийг нь хойшлуулах гэсэн сонголтууд гарч ирсэнтэй холбоотой хүүхдүүд сургуулиас завсардаж байна [10, 12]. Гэхдээ зайлшгүй нөхцөл байдалд эцэг, эхийн хүсэлтээр 6 наснаас нь сургуульд элсүүлэх боломжгүй хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэнэ гэж 2016 онд Боловсролын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан байдаг. Мөн дотуур байрны багтаамж хангалтгүй улмаас хүсэлт гаргасан малчны хүүхдүүд дотуур байранд бүрэн хамрагдаж чаддаггүй хичээлээс завсардахад хүрдэг байна. Тухайлбал, 2017-2018 оны хичээлийн жилд малчны 27.945 хүүхэд хүсэлт гаргаснаас 25.705 хүүхэд дотуур байранд амьдарсан ба малчны хүүхдийн дотуур байрны хамрагдалт 92.0 хувьтай байна.

Дотуур байрны нөхцөл

2017-2018 оны хичээлийн жилд улсын хэмжээнд нийт 532 (522 төрийн, 10 хувийн) дотуур байр ажиллаж байгаа ба үүний дийлэнх буюу 516 дотуур байр нь хөдөөд байрладаг байна. Дотуур байранд нийт 35,196 суралцагчид амьдарч байна (Үндэсний статистикийн хороо, 2018). Өөрөөр хэлбэл, алслагдсан хөдөө орон нутгийн, малчдын хүүхдүүдийг боловсролд хамруулахад эдгээр сумын төв, баг дээр сургуулиудыг дагасан дотуур байр чухал үүрэг гүйцэтгэж байгаа юм. Харамсалтай нь ерөнхий боловсролын сургуулиудын байгууламжууд хуучирсан, ихэнхдээ эвдэрсэн, засвар шинэчлэлтийн төсөв бүрэн хангалтгүй байгаа ба тэр дундаа дотуур байрны байгууламж нь маш хүйтэн тул шинэчлэн засварлах, дулаалах шаардлагатай байгаа юм [34]. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Боловсролын үнэлгээний төв, НҮБ-ын хамтарсан судалгааны тайланд дотуур байрны эрүүл ахуйн байдал маш муу, ундны ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмж муу, үүнээс улбаалж дотуур байрны сурагчдын хувийн

ариун цэвэр хангалтгүй ба эдгээр нөхцөлүүд нь сурагчдаас гадна багш, ажилчдын эрүүл мэндэд ноцтой сөргөөр нөлөөлж буйг цохон тэмдэглэжээ [12]. Тодруулбал, хөдөөгийн сургуулиудын дотуур байрны эрүүл мэндийн шаардлага хангахгүй байгаа нь сурагчдыг сургуулиас завсардах мөн сурлагын үзүүлэлтэд сөргөөр нөлөөлж, олон эцэг эхчүүд хүүхдээ зохих ариун цэврийн байгууламжгүй сургуульд явуулахыг хүсэхгүй байгааг олж харжээ. Үүнээс гадна дотуур байранд амьдарч буй хүүхдүүдийн хоорондын харилцаа муу, бие биенээ дээрэлхэх байдал их байдаг [31, 36] ба гадаад төрх, хувцаслалт, амьжиргааны түвшин, сурлагын байдлаас хамаарч, нэр хоч авах, нэр төрөө гутаалгах асуудалд ордог байна [10]. Мөн дотуур байранд амьдарч буй нэгж хүүхдийн тоонд ноогдуулсан хувьсах зардлын төсөв хүрдэггүйгээс хоолны чанарын асуудал гардаг ба зарим малчид хүүхдүүдээ зөөхөд хэцүү тул сургахын тулд сумын төв, төв суурин газарт айлд орхих, эсвэл сургуулийн дотуур байранд амьдруулдаг байна [1, 21]. Гэтэл дотуур байранд хүүхдүүд эцэг эхээ санаж, даарах, өлсөх гэх мэт олон бэрхшээлтэй тулгарсаны улмаас сургуульд сурч чадахгүй сургуулиа орхиход хүрдэг талаар судалгаануудад дурдсан байна.

Үндэстний цөөнх

Монгол Улсад 16 үндэстэн ястнаас бүрдэх ба голлох ба 95 хувь нь Халх үндэстэн. Дараа нь Казак үндэстэн жагсдаг ба 4 орчим хувийг эзэлдэг. Голлох үндэстний цөөнх болсон Казак үндэстэн нь монгол орны баруун хэсгээр буюу Баян-Өлгий болон Ховд аймгуудад ихэнхдээ амьдардаг юм. Яагаад Казак үндэстнийг чухалчилж авч үзэж байна гэвэл тэд Казак-Монгол гэсэн хосолмол хэлтэй, ёс заншлын хувьд нэлээд ялгаатай бөгөөд улмаар Казак хүүхдүүд хичээлээ ойлгохгүйн улмаас сургууль завсарддаг байна [34, 37, 38]. Мөн Баян-Өлгий аймагт сургууль завсардалт улсын дунджаас 3 дахин их байна [12]. Иймд боловсролын яам онцгой анхаарч тэдэнд зориулсан тусгай сурах бичиг, хөтөлбөр боловсруулж ажилладаг. Үүнээс гадна насанд хүрэгчдийн боловсролын хөтөлбөрийг радио, хэвлэмэл материал ашиглан, хөдөө орон нутагт ажилладаг явуулын багшаар дамжуулан ууланд цагаачлан амьдардаг Тува үндэстэнд боловсрол олгодог байна. Гэхдээ эдгээр хөтөлбөрүүд нь ихэвчлэн олон улсын хандивлагч байгууллагуудын тусламжтай хэрэгждэг ба санхүүжилт зогсвол боловсрол олгох үйл явц тасалддаг байна [12].

Хүйсийн байдал

Ерөнхий боловсрол эзэмшигч нийт суралцагчдын хүйсийн харьцааны индекс 2017-2018 оны хичээлийн жилийн байдлаар 1.00 байгаа хэдий ч бага ангид (100 эр, 96 эм), дунд ангид (100 эр, 98 эм), ахлах ангид (100 эр, 119 эм) тус тус харьцаатай байна [12]. Сургууль завсардалтад хөвгүүд охидоос илүү ертөмтгий байна [31, 32, 36]. Тэд ихэвчлэн мал маллах, алт, нүүрс ухах, мөнгө олох зорилготой сургуулиас завсардаж байна. Жишээ нь, 15 настай Отгонмөрөн малчин хүү 7 настайгаасаа сургуулиас гарч мал малласан байна. Учир нь тэднийг 300 хонь, үхэр, адуутай. Харин түүний эгч нь сургуульд явдаг байна [39]. Боловсрол эзэмшээгүй хөвгүүдийн тоо охидоос хоёр дахин их байна [32]. Харин ямар нэгэн бие өвдөх, ээждээ хоол хийж туслах, дүү нараа харах, эсвэл хүчирхийлэл дарамтад өртөх, эсвэл жирэмсэн болох шалтгаанаар охид ихэвчлэн сургууль завсардаж байна [21].

Суралцахуйн бэрхшээл

Суралцахуйн бэрхшээлээс болж хүүхдүүд хичээлээ ойлгохгүй, улмаар хичээлээс хоцрох, хичээлдээ дургүй болох, өөрийгөө буруушаах, аажмаар багш, үе тэнгийнхнээс өөрийгөө тусгаарлах замаар хичээлээс завсардаж байна [40]. Суралцахуйн бэрхшээл гэдэг нь оюун ухааны хомсдол биш, эрхтэн системийн хувьд хэвийн тэгсэн хирнээ уншиж, бичих, ярих, тооцоолох гэх мэт чадварууд дутагдаад байгаа тохиолдол юм [22]. Ийм суралцахуйн бэрхшээл нь АНУ-ын хүн амынх нь бараг 50 хувийг эзэлж, сургуулийн нэг ангийн 20 хүүхдийн 3 нь ийм бэрхшээлтэй тулгардаг байна [41]. Боловсролын их сургуулийн Тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэх тэнхим, Японы Нагоя их сургуулийн багш судлаачдын хамтарсан “Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдүүдийг дэмжих” төслийн хүрээнд Монгол дахь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн төлөв байдлыг тогтоох зорилгоор орон нутгийн 380 багш нараас асуулгын аргаар авсан туршилт судалгааны үр дүнд нийт хүүхдүүдийг бараг 7-10 орчим хувь нь суралцахуйн бэрхшээлтэй байж магадгүй гэсэн дүгнэлтийг гаргасан байна [42].

6. Сурагчдын сурлагын амжилт

“Бүх шатны боловсролын үйлчилгээний чанар, үр дүнг үнэлэх боломжтой болгож, стандартад суурилсан боловсролын тогтолцоог бүрдүүлнэ” гэж Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр (Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолын хавсралт)-т тусгажээ. Үүний дагуу боловсролын чанарын үнэлгээний тогтолцоог бий болгох, үнэлэх арга зүйг шинэчлэхтэй

холбогдуулан сургуулийн өмнөх боловсрол болон бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөр, үнэлгээний зарчим, судлах арга зүйн талаар нэлээдгүй ажлууд хийгдсэн байна.

Сургуулийн өмнөх боловсрол

Сургуулийн өмнөх боловсролын стандартыг 2003, 2011, 2015 онд тус тус шинэчилсэн бөгөөд түүнийг хэмжих шалгуур үзүүлэлтүүдэд концепцийн томоохон өөрчлөлтүүд орсон байдаг байна (Хүснэгт 13).

Хүснэгт 13. СӨБ-ын сургалтын стандарт, шалгуур үзүүлэлтүүд, 2003-2015 он

Стандартууд	Шалгуур үзүүлэлтүүд
Сургуулийн өмнөх боловсролын стандарт (2003)	Үйлчилгээний чанар, агуулга, арга зүй, үнэлгээ, хүүхдийн хөгжлийн орчинд тавигдах шаардлага, хөгжлийн ай, агуулга болон эзэмшсэн байх чадвар
Бага насны хүүхдийн хөгжлийн стандарт (2011)	Хүүхдийн цогц хөгжил: Бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжил, хүүхдийн төрмөл болон олдмол хөгжлийг хамтад нь хөгжүүлэх, насанд хүрэгчдийн дэмжлэг
Цөм хөтөлбөр (2015)	Хүүхдийн эзэмшсэн чадамжаар үнэлэх, нарийвчилсан бүтэцтэй ажиглалтын хуудас бөглөх, чөлөөт ажиглалт хийх, хувийн хавтас бүрдүүлэх

Эх сурвалж: БСШУСЯ, БХ, & UNESCO. (2019.p.228)

Боловсролын үнэлгээний төв нь 2015 оноос эхлэн жил бүр сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжлийн улсын дундаж, норм, нормативыг тогтоох, хүүхэд бүрийн хөгжлийн гарааг үнэлэх, ахиц амжилтыг тодорхойлох, улмаар сургалтын үйл ажиллагааг оновчтой зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор СӨБ-ын цөм хөтөлбөрт суурилсан нарийвчилсан бүтэцтэй 3 хүртэлх насны (29 асуулттай) болон 3-6 нас хүртэлх (115 асуулттай) ажиглалтын хуудас ашиглан санамсаргүй түүврийн аргаар нийт хүүхдүүдийн 10 хүртэлх хувийг хамруулан судалж, үнэлж байна [12]. 2018 онд 1332 цэцэрлэгийн 6348 бүлгийн нийт 22968 хүүхдийг (5231- 3 хүртэлх насны, 17737-3-6 насны, 51.5 хувь нь Улаанбаатар, 48.5 хувь нь Хөдөө) хамруулжээ. Уг судалгааны тайлангийн талаарх албан ёсны мэдээлэл одоогоор олон нийтэд тавигдаагүй байна.

2015 онд Бага насны хүүхдийн суралцах орчны мониторингийн аргачлал (Early Childhood Environment Monitoring Instrument/ECEMI)-ын дагуу Дэлхийн банк цэцэрлэгүүдийн чанарыг нийслэл болон 8 аймгийн төрийн болон хувийн, мөн гэр цэцэрлэгүүдээс түүвэрлэн нийт 327 бүлгийн хүүхдүүдийг хамруулан судалжээ. Судалгаагаар төрийн өмчийн цэцэрлэгүүдээс хөдөө орон нутгийн цэцэрлэгүүд, аймгийн төвийн цэцэрлэгүүдээс сумын төвийн цэцэрлэгүүд, Улаанбаатар хотын гэр хорооллын хувийн цэцэрлэгүүд гэр хорооллын бус цэцэрлэгүүдээс үйлчилгээний чанар, хүртээмж ялгаатай ба бага зэрэг дэд үзүүлэлтүүдээр (Орон зай, харилцаа, сургалт зохион байгуулалт, үйл ажиллагаа, унших бичихэд бэлтгэх

орчин, математик) хоцрогдолтой ба гэр цэцэрлэгүүд хүнд нөхцөлд ажиллаж байгаа ба чанарын үнэлгээнд ердийн цэцэрлэгүүдийнхээс харьцангуй бага оноо авсан байна (WB, 2016). Өөрөөр хэлбэл, хөдөө, орон нутгийн, амьжиргааны түвшин багатай өрх, үндэсний цөөнхийн сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн танин мэдэхүй, хэл яриа, нийгэм сэтгэл зүйн чадвар төвлөрсөн суурин газраас доогуур байна. Мөн хотын хүүхдүүдээс хөдөөний хүүхдүүдийн сургуульд бэлтгэгдсэн байдал хоцрогдолтой ба улсын хэмжээнд 5 настай хүүхдүүдийн сургуульд бэлтгэгдсэн байдал хангалтгүй байна [11]. Үүнд тоглоом, материал хэрэгслийн хангамж, бүлгийн өрөөний зохион байгуулалт хангалтгүй зэрэг асуудлууд нөлөөлсөн байна.

Бага, дунд боловсрол

Бага, дунд боловсролын цогц чадамжид (2004 оноос хойш) суурилсан шинэ стандартууд, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон 2013 оны “Зөв Монгол хүүхэд” үндэсний сургалтын хөтөлбөр (Засгийн газрын 2013 оны 295 дугаар тогтоолын хавсралт), Цөм хөтөлбөр (Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн А/302 тоот тушаалын нэгдүгээр хавсралт)-үүд боловсруулагдаж (жич: 2004-2018 оны хугацаанд сургалтын төлөвлөгөө 21 удаагийн шийдвэрээр өөрчлөгдсөн), сурагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийг үнэлэх журмуудад (1998, 2010, 2013, 2018) нэлээдгүй өөрчлөлтүүд орсон байна. Сүүлд 2018 оны Ерөнхий боловсролын суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний шинэчилсэн журмын дагуу (Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Сайдын 2018 оны А/425 дугаар тушаал) суралцагчийг оношлох, явцын, үр дүнгийн гэсэн 3 үнэлгээгээр үнэлж, тодорхой шалгуурт суурилсан 8 түвшингээр үнэлэх загварыг хэрэгжүүлж байна.

“Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон боловсролын чанарын үнэлгээний журам”-д заасны дагуу 2013 оноос хойш Боловсролын үнэлгээний төв чанарын үнэлгээний судалгааг үндэсний хэмжээнд нийт суралцагчдын 10 хувьтай тэнцэх ЕБС-ийн 5, 9, 12 ангийн сурагчдаас авч эхэлсэн байна [12]. Чанарын үнэлгээний судалгааны зорилго нь суралцагчийн мэдлэг, чадвар, хандлага тэдгээрийн хэрэглээний чадварыг бодитой үнэлж, үндэсний хэмжээнд бага, суурь, бүрэн дунд боловсролын хөтөлбөрийн хэрэгжилт, түүний чанарыг тодорхойлоход оршдог. Боловсролын чанарын үнэлгээний судалгааны арга, аргачлалыг боловсруулахдаа олон улсын зөвлөх үйлчилгээ болон

дотоодын судлаачдын тусламжтайгаар засан сайжруулж ирсээр байна. Тухайлбал, Боловсролын үнэлгээний төв нь 3 жилийн туршид Кембриджийн олон улсын шалгалтын төвөөс сэдэв даалгавар боловсруулах, шалгалтын материал асах, үнэлэх, тайлагнах ажил дээр зөвлөх үйлчилгээг авсан байна. Мөн боловсролын чанарт нөлөөлж буй хүчин зүйлийг илрүүлэх зорилгоор суралцагч, эцэг эх, багш, сургуулийн удирдлагуудаас онлайнаар 2016 онд PISA, TIMSS судалгаанд ашиглагддаг асуумжуудаас Унгар Улсын Боловсрол судлалын докторантурын сургуультай хамтарч монгол орны нөхцөлд буулгасан асуултууд асуумж судалгаа авч судалсан байдаг [43, 44, 45]. Үүнээс өмнө олон улсад ашиглагдаж буй аргачлалаар зарим судалгаануудыг явуулсан байдаг байна. Үүнд: 5-р анги- Бага боловсролын математик, унших чадварын үндэсний үнэлгээ (2008), 4, 8-р анги-TIMSS, PIRLS олон улсын туршилт судалгаа (2011), 7, 10-р анги- Бага, суурь боловсролын стандартын хэрэгжилтийг тогтоох хөндлөнгийн шалгалт (2012) зэрэг болно [12].

Судалгаануудын дүнгээс харахад 2008 онд математикийн шалгалтын гүйцэтгэлийн дундаж 45.4 хувь, 2011 онд 38.8 хувь, 2012 онд 39.1 хувь болж буурсан байна. 2016-2018 оны хооронд сурлагын амжилтын түвшин бага боловсрол- 52.6-41.7 хувь буюу буурсан, суурь боловсрол-40.3-37.1 хувь буюу буурсан, бүрэн дунд боловсрол-34.7-39.9 хувь буюу бага зэрэг дээшилсэн тус тус үзүүлэлттэй байна. Дэлгэрүүлбэл, 2018 оны шалгалтын гүйцэтгэлийн дундаж оноог хүснэгт 14-ээс үзнэ үү.

Хүснэгт 14. Шалгалтын гүйцэтгэлийн дундамж үзүүлэлт, 2018 он, хувиар

Тестүүд	5-р анги	9-р анги	12-р анги
Математик			27.5
Монгол хэл		26.1	53.2
Байгаль шинжлэл	41.2	49.4	
Байгалийн ухаан	37.6		
Нийгмийн ухаан	46.4	33.9	
Гадаад хэл		38.0	46.0
Сонгох агуулга			32.8

Эх сурвалж: БСШУСЯ, БХ, & UNESCO. (2019.p.234.)


Өөрөөр хэлбэл, сүүлийн жилүүдэд хийгдсэн боловсролын чанарын үнэлгээний тайлангуудаас харахад сурагчдын мэдлэг, чадвар сул, ахиц дэвшил гараагүй 60 хувиас доогуур, өөрөөр хэлбэл бага оноотой хүүхдүүдийн эзлэх хувь өндөр, тэр дундаа дунд, ахлах ангийн сурлагын амжилтын үзүүлэлтүүд бага боловсролынхоос доогуур, алслагдсан хөдөө орон нутгийн, малчдын, дотуур байранд амьдарч буй, үндэсний цөөнхийн хүүхдүүдийн сурлагын чанар төвийн

хүүхдүүдээс доогуур байсаар байна. Мөн Казах, Тува, хилийн чанадад амьдарч буй монгол хүүхдүүдийн эх хэлний асуудлууд хичээл сурлагад муугаар нөлөөлж байна [10, 12]. Эдгээр боловсролын чанарын сул, ялгаатай байдалд сургалтын хөтөлбөрийн байнгын шинэчлэлттэй холбоотойгоор багшийн үнэлгээний арга зүй дутмаг, мэдлэгт суурилсан, чадварыг үнэлэхэд чиглэгдэхгүй, явцын үнэлгээг сургалтад оновчтой хэрэглэж чадахгүй байгаа байдал, суралцагчдын эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэх ном, гарын авлага хомс, сургалтын хэрэглэгдэхүүн, сурах бичгийн хангалтгүй байдал зэрэг асуудлууд маш хүчтэй нөлөөлсөн байна [12]. Мөн хөдөө орон нутгаас нийслэлд шилжин ирэгсдийн тоо өсөн нэмэгдэж буйтай холбоотойгоор нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудын ачаалал ихсэж бүлэг дүүргэлт 40-50 болсон, харин алслагдсан бүс нутаг дахь сургуулиудад суралцах сурагчдын тоо эрс багассанаар мэргэжлийн багшийн далд хомсдол үүссэн байдал сурлагын амжилтыг гажуудуулж байна. Өөрөөр хэлбэл, шинэ сургууль барих ажлыг хүн амын өсөлт, эрэлттэй уялдуулж бариагүйгээс үүдэлтэй зарим сургуулиуд хүчин чадлаасаа доогуур, зарим нь 2, бүр 3 ээлжээр хичээллэж байгаа нь сурлагын амжилтад сөргөөр нөлөөлсөн байна [11, 46].

Дүгнэлт

1990 оны Монгол Улсын улс төр, нийгэм-эдийн засгийн өөрчлөлт, шинэчлэлт нь боловсролын салбарт төдийгүй нийгэмд хүчтэй нөлөөлж, ажилгүйдэл, ядуурал, эрсдэлт, эмзэг бүлгийн хүүхдүүдийг бий болгосон байна [10, 12, 47, 48]. Иймд боловсролын салбарын тэгш байдал алдагдаж, улмаар сурлагын амжилт эрс буурч, боловсролын чанарын асуудал хүчтэй тавигдаж, өнөөдрийн боловсролын тогтолцоог үнэлж, дүгнэх хэрэгцээ гарсан байна. Дээрх байдлыг судлаачийн зүгээс дараах байдлаар загварчлав (Загвар, 3-аас харна уу).

3. Shapes. Framework in education of Mongolia from 1990-2020 year, Sansarmaa, 2020



Монгол Улсын одоо хэрэгжиж буй боловсролын тогтолцооны нөхцөл байдлаас харахад, өөрөөр хэлбэл, боловсролын чанарыг олон улсад нэвтэрсэн арга, аргачлалаар хэмжихэд судалгааны үндэс суурь болсон зорилтод бүлгийн сурагчдад хөдөө орон нутгийн алслагдсан сум, дүүргийн, малчдын, хөгжлийн бэрхшээлтэй, үндэсний цөөнх, дотуур байранд амьдарч буй хүүхдүүдийг хамруулан авч үзэж болохыг олж харлаа. Тэдгээр хүүхдүүдийг хэрхэн цэцэрлэг, сургуульд бүрэн хамруулах, сурлагын чанарыг яаж дээшлүүлэх талаар дорвитой ажил хийгдэхгүй байгаа ба шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлсийг илрүүлж, судалгааны үр дүнд суурилсан үйл ажиллагааны хөтөлбөр, бодлогын шинэчлэлт хийгдэхгүй байна. Шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлийг илүү дэлгэрэнгүй тодорхойлж, тэр дундаа нэг талаас хувь хүний хөгжлийн талаас, нөгөө талаас Монгол орны нөхцөлд нийгэм-эдийн засгийн ямар хүчин зүйл нөлөөлж буйг, магадгүй улс үндэсний ёс заншил нөлөөлж болохыг судалж тогтоох нь чухал юм [43, 44, 45]. Үүнээс гадна боловсролын талаарх нарийвчилсан судалгааны тайлан мэдээллүүд хомс, мэдээллийн эх сурвалж, судалгааны тайлангууд албан ёсоор

олон нийтэд мэдээлэгдэхгүй байна. Тухайлбал, сургууль завсардалт, сурлагын чанарын судалгааны тайлангуудын мэдээллүүд хоорондоо зөрүүтэй ба хаагдмал байна. Үүнээс гадна сурагчдын танин мэдэхүйн чадварыг дээшлүүлсэн, боловсролын салбарт хүчтэй хөрөнгө оруулалт хийж чадаж байгаа улс орнуудын эдийн засаг хурдацтай хөгждөг болохыг дээрх судалгаануудын тайлан мэдээллээс олж харлаа. Тэр дундаа хүүхдийг аль болох бага насанд нь анхаарч, нийгэм-сэтгэл зүйн асуудлыг шийдвэрлэх, тэдний эцэг, эх, гэр бүлд дэмжлэг, туслалцаа, төсөл, хөтөлбөр арга хэмжээнүүдийг хийж чадвал ирээдүйд нийгэмд үзүүлэх нөлөө нь эерэг байх, төсвийн зардлыг бууруулахад ихээхэн ач холбогдолтой байдаг байна [15, 16, 17, 49].

Талархал

Энэхүү онолын судалгааны тойм хийхэд эрдэмтэн судлаачид, зөвлөх багш, тэр дундаа Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам болон Боловсролын үнэлгээний төвийн хамт олондоо талархсанаа илэрхийлье.

Ашигласан хэвлэл

- [1]. Steiner-Khamsi, G & Stolpe, I. (2006) . Educational Import in Mongolia: A Historical Perspective. In G. Steiner-Khamsi & I. Stolpe (Eds.) , *Educational Import in Mongolia: Local Encounters with Global Forces* (pp. 1–23) . New York: Palgrave Macmillan.
- [2]. Steiner-Khamsi, G & Stolpe, I (2008) . Introduction: Unwrapping the Post Socialist Education Reform Package. In G. Steiner-Khamsi & I. Stolpe (Eds.) , *NGOs React. Globalization and Education Reform in the Caucasus. Central Asia and Mongolia* (pp. 1–43) . Bloomfield, CT: Kumarian Press.
- [3]. ADB (2008) . *Mongolia: Education Sector Reform Project (Financed by the Asian Development Fund)*. ADB Asian Development Bank: Technical Assistance Consultant’s Report & MECS Ministry of Education, Culture, and Science.
- [4]. Aassve, A., & Altankhuyag, G. (2002) . Changing Patterns of Mongolian Fertility at a Time of Social and Economic Transition. *Studies in Family Planning*, 33(2), 165–172. Retrieved from <http://www.jstor.org/stable/3181170>
- [5]. Weidman & Yoder. (2010) . Policy and Practice in Education Reform in Mongolia and Uzbekistan during the First Two Decades of the Post-Soviet Era. *Excellence in Higher Education*, 1, 57–68. doi:10.5195/ehe.2010.16. Retrieved from <http://www.researchgate.net/publication/50316722>
- [6]. Sukhbaatar, B (2014) . Study on parental involvement preparation at the preserves Institution in Mongolia. *School Community Journal*, 24(2), 189–218. Retrieved from <http://files.eric.ed.gov/fulltext/EJ1048610.pdf>
- [7]. YCX (2020). *Статистикийн мэдээллийн нэгдсэн сан*. Retrieved from <https://www.1212.mn/sonirkholtoi/>
- [8]. Caroleo, F. E., Gianneli, G. C., & Pastore, F. (2010) . Vulnerability and Discrimination among Women, Children and Ethnic Minorities, *International Journal of Manpower*, 31(2), 101–108. doi: 10.1108/01437721011042223

- [9]. WB (26, May, 2020). *Mongolia poverty update*. Retrieved from <https://www.worldbank.org/en/country/mongolia/publication/mongolia-poverty-update>
- [10]. БСШУЯ, АДВ, & ЯБЯС (2019). *Боловсролын салбарын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө 2021-2030*. Монгол Улс, Улаанбаатар хот.
- [11]. БСШУСЯ, СРЕ, & ОУСБХБ (2020). *Алсын хараа 2050: Боловсролын салбарт эрх тэгш байдал, үр ашиг, үр дүнг нэмэгдүүлэх нь*, Монгол Улс, Улаанбаатар хот.
- [12]. БСШУСЯ, БХ, & UNESCO (2019). *Монгол Улсын Боловсролын суурь мэдээллийн тайлан*. Монгол Улс, Улаанбаатар хот.
- [13]. OECD (2020). *How's Life? 2020: Measuring Well-being-Highlights*. Paris. Retrieved from <https://www.oecd.org/sdd/How-is-Life-2020-Highlights.pdf>
- [14]. OECD (2013). *PISA 2012 results: Excellence through equity: Giving every student the chance to succeed (Volume II)*. Paris: OECD.
- [15]. Hanushek, E. A., & Woessmann, L. (2010). *The High Cost of Low Educational Performance: The Long-run Economic Impact Of Improving PISA Outcomes*. OECD. Paris.
- [16]. Heckman, J. J., & Masterov, D. V. (2007). The Productivity Argument for Investing in Young Children. *National Bureau of Economic Research, 13016*. NBER Working Papers.
- [17]. Heckman (2008). *The Case for Investing in Disadvantaged Young Children*. Retrieved from <http://heckmanequation.org/content/resource/case-investing-disadvantaged-young-children>
- [18]. Leaders, Th. (12, March, 2018). *Equity in education: What it is and Why it matters*. Thinking Maps.com website.
- [19]. OECD (2008). *Ten step to Equity in Education*. Policy Brief.
- [20]. WB (2016). *Монгол Улсын сургуулийн өмнөх боловсрол: Үйлчилгээний хүртээмж, чанар ба хүүхдийн хөгжлийн үр дүн: Хоёр дахь хэвлэл: Тайлан: 113752*. Монгол Улс: Улаанбаатар хот.
- [21]. Rosario, M., Battsetseg, B., Bolormaa, Ts., Dorjnamjin, B., Tumendelger, S., Tsetsenbileg, Ts., & Enkhbold, D. (2005) . *Study report of the The Mongolia drop out study*. Ulaanbaatar, Mongolia: Mongolia Education Alliance.
- [22]. Save the Children, & IRIM (2018). *Монгол Улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь: хэрэгцээ тодорхойлох судалгааны тайлан*. Монгол Улс, Улаанбаатар хот.
- [23]. ХНХЯ & JICA (2019). *Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа, мэдээллийн лавлах*. Монгол Улс, Улаанбаатар хот.
- [24]. Одгэрэл, Д. (2020.05.28). Зөвхөн эмчийн оношоор тусгай сургуульд сургаж буй нь өрөөсгөл. *Unuudur.mn*, Монгол Улс, Улаанбаатар хот.
- [25]. Сарантуяа, Д. (2018). Монгол Улсын тэгш хамруулах боловсролын хөгжлийн асуудалд. In МУБИС (Eds), *“Тусгай хэрэгцээт боловсролын багш, онол практикийн асуудлууд” эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл* (p.98-103). Монгол Улс, Улаанбаатар.
- [26]. Sansarmaa (2018). Dropout of disadvantaged students in school system (Case of Mongolia). In МУБИС (Eds), *“Тусгай хэрэгцээт боловсролын багш, онол практикийн асуудлууд” эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл* (p.104-111). Монгол Улс, Улаанбаатар хот.
- [27]. Баттуяа, Ц. (2013) “Тусгай хэрэгцээт боловсролын нарийн мэргэшсэн багш бэлтгэх хэрэгцээ шаардлага”, In Х.Сансармаа (Eds), *“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлж буй сэргээн засах тусламж, үйлчилгээнд тулгамдаж буй*

асуудал, түүнийг шийдвэрлэх нь “ сэдэвт эрдэм шинжилгээний онол, практикийн хурлын илтгэлүүдийн эмхэтгэл (р.22-33). Монгол Улс, Улаанбаатар хот.

[28]. Батцэнгэл.Г & Байгалмаа.Ч. (2018). Тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэж буй байдал асуудал, шийдэл. In МУБИС (Eds), “Тусгай хэрэгцээт боловсролын багш, онол практикийн асуудлууд” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл (р.3-11). Монгол Улс, Улаанбаатар хот.

[29]. Батцэнгэл, Г. (2020). *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтын сэтгэл зүйн үндэс*. Монгол Улс, Улаанбаатар хот.

[30]. НХГБХГ (2014). *Сургууль завсардалтын судалгаа*. Монгол Улс: Улаанбаатар хот.

[31]. Steiner-Khamsi. G, & Gerelmaa, A. (2007) . *Mongolia Country Case Study. Background Paper Prepared for the EFA Global Monitoring Report 2007*. Paris: UNESCO EFA GMR.

[32]. Pastore, F. (2012) . *"I Wish I Had 100 Dollars a Month ..." - The Intergenerational Transfer of Poverty in Mongolia*. Santa Maria Capua Vetere (CE), Italy.

[33]. CHIP (2005). *Children on the Move, Rural-Urban Migration and Access to Education in Mongolia*. Ulaanbaatar: Save the Children and National University of Mongolia.

[34]. Tony, R. (2008) . *Mongolia: Education Sector Reform Project (Financed by the Asian Development Fund)*. ADB Asian Development Bank: Technical Assistance Consultant's Report & MECS Ministry of Education, Culture, and Science.

[35]. Walters, B., Marshall, R., & Nixson, F. (2012) . Consistent and Transparent? The Problem of Longitudinal Poverty Records. *Development & Change*, 43(4), 899–918. doi:

10.1111/j.1467-7660.2012.01785.x

[36]. Steiner-Khamsi.G, & Gerelmaa, A. (2009) . Quality and Equity in the Mongolian Education Sector. *Prospects*, 38(3), 409–414. doi: 10.1007/s11125-008-9079-5

[37]. Sandra, H. S. (2005) . *Education of Kazakh children: A Situation Analysis Save the children*. Ulaanbaatar: UK Save the children.: Report summary: Education of Kazakh children.

[38]. Wei-chieh, Ts. (2011) . Ethnic Riots and Violence in the Mongol Empire: A Comparative Perspective. *Mongolian Studies*, 33, 83–107.

[39]. Cengel, K. (3, Jan, 2018). *In a changing Mongolia, higher stakes for out-of-school heding boys*. Mongolia; Ulaanbaatar.

[40]. Баяраа, Д. (2016.11.24). Суралцахуйн бэрхшээл чухам юунаас шалтгаалдгийг шинжлэх ухаан яг таг тогтоогүй байгаа. *Өдрийн сонин*. Монгол Улс: Улаанбаатар хот.

[41]. Энхбат.Б, & Болормаа, Д. (2019). *Суралцахуйн бэрхшээл ба суралцагчдын ялгаатай байдал*. Монгол Улс: Улаанбаатар хот. Retrieved from <http://teacher.itpd.mn/read.aspx?content=7a3a3644-3323-4f6d-bbba-46c073326a9a>

[42]. Баяраа, Д. (2016.11.24). Суралцахуйн бэрхшээл чухам юунаас шалтгаалдгийг шинжлэх ухаан яг таг тогтоогүй байгаа. *Өдрийн сонин*. Монгол Улс: Улаанбаатар хот.

[43]. Sansarmaa, Kh. (2017). *The relationship between socio-economic background and test performance: The case of Mongolia*. 15th Conference on Educational Assessment 6-8 April 2017 Conference Abstract Book. p.41. Hungary, Szeged.

http://publicatio.bibl.u-szeged.hu/11179/1/PEK_2017_ABSZTRAKTKOTET.pdf

- [44]. Sansarmaa, Kh & Jozsef, F.B. (2017). The link between socio-economic background and test performance in the case of Mongolian students. *HuCER 2017 Conference Abstract book*, p.183. Hungary, Budapest. http://hera.org.hu/wp-content/uploads/2017/05/HERA_abstract2017.pdf
- [45]. Sansarma, Kh. (2018b). The relationship between socio-economic background and Mongolian students' achievement. *Management & Innovation scientific journal: ICIED 2018: International Conference on Innovation and Entrepreneurship Development*, 2(008), 168-171.
- [46]. World Education Forum (2020). *Dakar Framework for Action Education for All: Meeting our Collective Commitments*. Dakar, Senegal.
- [47]. Suprunova, L.L. (2007) . Education in Mongolia. The difficulties and achievements of the period of transition. *Russian Education and Society*, 49(1), 78–97.
doi: 10.2753/RES1060-9393490106
- [48]. EEC. (2008) . *Rural education and development project: Mongolian national assessment of primary education mathematics and reading*. Ulaanbaatar, Mongolia: EEC Education Evaluation Center of Mongolia, MECS and World Bank.
- [49]. Hanushek, E. A., & Woessmann, L. (2009). Do better schools lead to more growth? *Cognitive skills, economic outcomes, and causation*, 14633. NBER.

ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛД ЦАХИМ ХИЧЭЭЛИЙГ АШИГЛАСАН НЬ

Д. Алтансүх¹

¹ЕБ-ийн 29 сургуулийн Газарзүй багш

“Ялгаа хийгээд ялгаварлал хоорондын зай ихэссэн нь”

Хураангуй

Боловсролын хууль дахь дүрэм журмын дагуу сурагчдад эрх тэгш, хүртээмжтэй боловсролыг хүртээхэд сургалтын эрхэм зорилго оршдог. Дэлхий даяар айдас түгшүүр дагуулж буй шинэ коронавирус буюу Covid-19-ийн нөлөөгөөр улс орнууд өөрсдийн хилийг хааж, зорчих хөдөлгөөнийг хязгаарлан хөл хорио тогтоогоод байна. Манай улсын хувьд ч байж болох бүхий л арга хэмжээгээр урьдчилан сэргийлж байгаа билээ. Олон нийтийг хамарсан сургалт, арга хэмжээг хориглох гэх мэт урьдчилан сэргийлэх аргууд бидэнд цөөнгүй бэрхшээл, сорилтуудыг бий болгоод байна. Үүний нэг нь алсын зайн сургалт буюу цахим сургалт юм. Олон улсад аль хэдийн нэвтрээд сургалтын хөтөлбөрийн нэг хэсэг болчихсон энэ сургалтын загвар Монголд төдийлөн амжилт олохгүй байгааг оюутан сурагч, эцэг эх, багш нарын санал гомдлоос харж болно. Үүний нэг тод жишээ нь ТХБ буюу тусгай хэрэгцээт боловсрол эзэмшүүлдэг сургуулиудын сурагчдын хувьд энэ цахим сургалт нь ямар ч үр дүнгүй, тусгаарласан, ялгаварласан зүйл болж дууссан. Тусгай хэрэгцээт боловсрол эзэмшүүлдэг сургуулиудын хувьд хичээлийн агуулга арга зүй хувьд Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн агуулгаас хөнгөвчилсөн хэлбэрээр зохион байгуулагддаг. Иймээс цахим хичээл нь хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын сурах эрх үүрэг зөрчигдсөн, агуулга арга зүйн хувьд хэт хүнд тохиромжгүй мөн хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын хувьд цахим хичээлийн талаарх ерөнхий ойлголт бага, цахим хичээлийг хүлээж авах чадвар чадамж нь сул зэрэг олон асуудлууд дагуулсан хичээлүүд болж өнгөрсөн.

Түлхүүр үгс: Боловсрол, ялгаатай байдал, цахим хичээл, сэтгэлзүй, ТХБ.

Судалгааны шинэлэг тал: Тусгай хэрэгцээт боловсрол эзэмшүүлдэг сургуулиудын хүндрэл бэрхшээлийг харгалзан үзэж 29-р сургууль, 63-р сургуулийн сурагчдаас цахим хичээлийн ойлголт, хүлээж авсан байдал, хэрэглээний талаар судалж үзэх үүднээс сурагчид, багш нарыг оролцуулан асуулга арга болон түүврийн аргаар судалсан. Мөн цахим хичээлийн давуу болон сул талын талаар харуулсан нь давуу тал хэмээн үзэж байна.

Судалгааны Ажлын Зорилго

Хөл хорионы үед сургалтын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлсэн нь багш, сурагч, эцэг эхийн хувьд аль алины хувьд гэнэтийн байсан, техник болон сэтгэлзүйн талаасаа ч бэлэн биш байсан иймээс нийгмийн сэтгэлзүй талаас

хэрхэн хүлээж авч байгаа болон цахим хичээлийг ТХБ-д ашиглах нь хэр оновчтой юм, ХБХ-үүд цахим хичээлийг хүлээн авч чадаж байна уу, хэр үр дүн гарч байгаа. Мөн цахим хичээлийн онцлог давуу тал, хүртээмж, сул талыг гаргаж өгөх, цаашид хэрхэн шийдвэрлэх арга замыг илрүүлэхийг зорилго чиглэл болгосон.

Судалгааны Ажлын Зорилт

- Тандалтын судалгааг авах
- Судалгааны дагуу гол асуудлыг дэвшүүлэх
- Сэдвийн хүрээнд гадаад дотоодын сайт, ном зохиолоос цахим хичээлийн талаарх мэдээлэл цуглуулах боловсруулах

Ашигласан Судалгааны Арга

- Ажиглалтын арга
- Ярилцлагын арга (ганцаарчилсан болон бүлгийн)
- Түүврийн арга
- Асуулгын арга

Сэдвийг Сонгосон Үндэслэл

Хөгжиж буй орнуудад цахим хичээлийн хэрэглээ өндөр байдаг. Гэтэл манай орны хувьд Өнөөгийн нийгэм, өнөөгийн энэ цаг үед СЭТГЭЛЗҮЙН талаас ЦАХИМ ХИЧЭЭЛ гэдэг ойлголтыг хүлээж авах, ашиглаж дадах нь маш сул байна. Хэдийгээр Дэлхий даяар айдас түгшүүр дагуулж буй шинэ коронавирус буюу Covid-19-ийн нөлөөгөөр манай орон ч өөрсдийн хилийг хааж, зорчих хөдөлгөөнийг хязгаарлан хөл хорио тогтоож цахим сургалтаар хичээл сургалтын үйл ажиллагааг үргэлжлүүлсэн. Сургалтын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх засгийн шийдвэр “сонголт гэхээсээ илүүтэй”, аюулгүй байдал-боловсрол хоёроо аль алийг нь харгалзаж рационал тооцоогоор дэнсэлсэн “гаргалгаа” байлаа. Монгол улсын Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тухай хуулийн 4-р бүлэг, 14-р, 15-р зүйлд тус тус заасны дагуу ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ОНЦЛОГ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГАД НИЙЦСЭН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛЖ, ТОХИРОХ ХЭРЭГЛЭГДЭХҮҮНЭЭР ХАНГАЖ дэмжлэг туслалцаа үзүүлэх МӨН Монгол улсын боловсролын тухай хуулийн 1-р бүлгийн 5-р зүйлд иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, НИЙГМИЙН ГАРАЛ БАЙДАЛ, ХӨРӨНГӨ ЧИНЭЭ зэргээр ялгаварлан гадуурхахгүй байх эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж нөхцөлөөр хангах, Монгол улсын Боловсролын

тухай хуулийн 5.1.2 Монгол Улсад Боловсрол нь хүмүүнлэг, ардчилсан, тасралтгүй, бүх нийтэд ХҮРТЭЭМЖТЭЙ байх гэж тус тус заасан байдаг ба эдгээр хуулийн заалтууд хөндөгдсөн бүх нийтийг хамарч чадаагүй, үр дүн тааруу, сурагчдын сонирхол татахуйц бус, нийгэмд хүлээж авах сэтгэлзүй үгүй байсан, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд агуулга, арга зүй хувьд тохиромжгүй. Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг нийгмээс хэт тусгаарласан үйлдэл болсон зэрэг олон арван санал шүүмж гарч байсан учир тус сэвдийг сонгон авсан.

Судалгааны Ажлын Онолын Хэсэг

Хүний нийгмийн хөгжил, технологийн дэвшилтэй уялдан мэдээллийн хэмжээ асар их болж тэр хэрээр сургалтын процесс шинэчлэгдэн шинэ зуунтай золгоод байна. 20-р зууны дунд үед уламжлалт сургалт буюу нүүр нүүрээ харсан сургалт зонхилж байсан бол орчин үед электрон сургалт, хосолсон сургалт илүү өргөн хүрээнд ашиглагдаж байна. Мэдээлэл холбооны технологийн асар хурдацтай хөгжил нь сургалтын арга хэлбэр, заах арга зүй шинэчлэхэд хамгийн гол түлхэц болсон гэж үздэг.

Сургалтын арга зүйн мэдээлэлжсэн эрин зуунд суралцах улам амар хялбар болж байгаа гэдэгтэй та санал нийлэх бизээ. Мэдээлэл харилцааны технологи, электрон сургалт, интернет болон вебэд суурилсан сургалт, онлайн сургалт гэх мэт. Цахим сургалт гэдэг нь нэг үгээр хэлбэл МХХТ-д суурилсан сургалт юм. Цахим сургалтын материалыг боловсруулах нь танхимын сургалтын материал боловсруулахаас үнэтэй, цаг хугацаа, хүн хүч, хөдөлмөр их шаарддаг. Харин боловсруулсны дараа цахим сургалтыг явуулах нь ангид сургалтыг явуулахаас олон талаараа давуутай байдаг.

.....Хүний харах мэдрэхүйгээрээ хүлээж авсан мэдээлэл сонсох мэдрэхүйгээр хүлээн авсан мэдээллээс илүү үнэмшилтэй байдгийн зэрэгцээ бат тогтож, удаан мартагддаг тул сургалтад МХХТ-ийг тэр дундаа мультимедиа технологийг ашиглах нь хийсвэр ухагдахуунууд болон төсөөлж, харахад төвөгтэй зүйлсийг бодит юм шиг харагдуулж амьдруулдгаараа хичээлийг ойлгомжтой, илүү сонирхолтой болгоод зогсохгүй онолын хэсгийг заах хугацааг багасгаж суралцагчдын дадлага хийх цагийг нэмэгдүүлдэг. Мөн хоёр Цахим сургалт буюу E – Learning –ны талаар олон маш олон тодорхойлолт, үзэл баримтлал байдаг. Тухайлбал: Цахим сургалт нь интернет ба сургалтын нийлбэр цогц юм.

Хөгжиж буй орнууд цахим хичээлийн хэрэглээ өндөр байна. Онлайн сургалтыг сонгож буй суралцагсдын 68% нь суралцах арга барил эзэмшсэн мэргэжилтнүүд буюу насны дундаж 32 байна.

Судалгааны Ажлын Гол Хэсэг

Дэлхий даяар айдас түгшүүр дагуулж буй шинэ коронавирус буюу Covid-19-ийн нөлөөгөөр дэлхийн улс орнууд өөрсдийн хилийг хааж, зорчих хөдөлгөөнийг хязгаарлан хөл хорио тогтоогоод байна. Манай улсын хувьд хүн ам цөөн төдийгүй БНХАУ-тай шууд хиллэдэг учраас халдвар тархах өндөр эрсдэлтэй орноор нэрлэгдэж, байж болох бүхий л арга хэмжээгээр урьдчилан сэргийлж байгаа билээ. Олон нийтийг хамарсан сургалт, арга хэмжээг хориглох гэх мэт урьдчилан сэргийлэх аргууд бидэнд цөөнгүй бэрхшээл, сорилтуудыг бий болгоод буй. Үүний нэг нь алсын зайн сургалт буюу цахим сургалт юм. Олон улсад аль хэдийн нэвтрээд сургалтын хөтөлбөрийн нэг хэсэг болчихсон энэ сургалтын загвар Монголд төдийлөн амжилт олохгүй байгааг оюутан сурагч, эцэг эх, багш нарын санал гомдлоос харж болно. Манай улсын хувьд нийт хүн амын ихэнх хувийг малчин өрх айлууд, амьдралын боломж бололцоо сул тааруу айл, өрх гэрүүд эзэлдэг иймээс оюутан сурагчид, эцэг эх, багш нарт тулгарч буй асуудлуудаас ихэнх хувийг нь интернеттэй холбоотой, зурагт, багш нарын явуулж буй хичээлийн материал хангалтгүй, ойлгомжгүй, хурдан, сонирхол татахуйц бус байсан зэрэг асуудлууд гарч байна.

Бид дэлхийн шинэ нээлтүүдтэй хөл зэрэгцэн алхаж, технологийн нээлтээс хоцролгүй амьдарч байгаа энэ үед бусад зүйлсийг ч гэсэн орхигдуулалгүй суралцах нь чухал билээ. Аливаа улс үндэстний тэгш бус байдлыг арилгах гол гарц нь боловсрол байдаг хэмээн дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч, улмаар нийгэмд тулгарч буй олон асуудлыг шийдвэрлэх гарц хэмээн үздэг. Иймээс цахим сургалт, алсын зайны сургалт гэдэг нь суралцагчаас бие даасан байдал, хичээл зүтгэл их шаарддаг учир сурагчид аливаа бэрхшээлээс боломжийг олж харах нь чухал юм.


Цахим сургалтын томъёолол нь компьютерт суурилсан сургалт , Вебд суурилсан сургалт , виртуал сургалт , TV , радиогийн сургалт зэргийг агуулах сургалтын нэг шинэ хэлбэр бөгөөд үйлчилгээний өргөн цар хүрээг агуулсан байдаг.Цахим сургалт гэдэг нь нэг үгээр хэлбэл МЭДЭЭЛ ХАРИЛЦАА

ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИ-д суурилсан сургалт юм. БНХАУ-ын бага, дунд ангийн сурагчид видео хостингийн Youku сайтаар дамжуулан хичээлээ зааж, тус улсын боловсролын хамгийн том хувийн компани болох New Oriental Group, англи хэлний сургалтын VIP Kid платформоо онцгой нөхцөлд нийцүүлэн үнэ төлбөргүй ашиглуулж, хичээлүүдээ цахимд байрлуулсан байна. Энэ нь ч үр дүнтэй байгаа аж. Ер нь бол сургууль болгон өөрийн гэсэн аппликейшн, эсвэл өөрсдийн тусгай сайттай байдаг. Түүгээрээ орж онлайн хичээлд хамрагддаг. Гэтэл манай улсад энэ нөхцөлд хэрэглэх платформ битгий хэл, цахим хичээлийн стандарт, арга зүйн, журам ч гэж алга. Өнөөдөр зааж буй цахим хичээлийн арга барил таван жилийн өмнөхөөс сайжраагүй байгааг энгийн интернэтийн хайлтаар мэдэх боломжтой. Хэдийгээр сурагчид теле хичээлд хамрагдаж байгаа боловч багш нарын заах арга барил, хөтөлбөр нь танхимын сургалтын хэв маягтай, хичээлээ бодит бус орчинд хүлээн авч буй суралцагчийн сонирхлыг огт татахгүй, үр өгөөжийн хувьд харьцангуй сул байна. Манай орны хувьд энэ онд Улсын хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн 640 мянга гаруй сурагч теле хичээлээ 18 сувгаар дамжуулан үзсэн бөгөөд. Цахимаар сургалт явуулахад суралцагчаас хариуцлага, сурах зорилгоо ухамсарласан байдал зэрэг хувийн чадвар, сахилга бат ихээхэн шаарддаг.


Тусгай Сурууглийн Багш Нарын Жишээн Дээр

Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг тусгай сургуулиудаас хүндрэл бэрхшээлийг тооцож үзсэний үндсэн дээр Сүхбаатар дүүргийн 29-р сургууль, Хан-Уул дүүргийн 63 сургуулийг сонгон авч асуулгын аргыг ашиглан судалгаа авч боловсруулан дүгнэсэн.

1. Судалгаанд хамрагдсан багш нарын нас болон ажилласан жилийг авч үзвэл. Доорх асуулгын хүрээнд нийслэлийн тусгай хэрэгцээт боловсрол эзэмшүүлдэг 29-р сургууль, 63-р сургуулийн 27 багшаас судалгааг авч боловсруулан дүгнэж үзсэн. Тус асуулгын хувьд сонгосон сургуулийн нас болон ажилласан жил, мэргэжил зэргийг харгалзан үзэж түүврийн аргаар багш нараа сонгож судалгааг авч боловсруулан дүгнэсэн.



2. Доорх асуулгын хүрээнд нийслэлийн тусгай хэрэгцээт боловсрол эзэмшүүлдэг 29-р сургууль, 63-р сургуулийн 27 багшаас судалгааг авч боловсруулан дүгнэж үзэхэд судалгаанд хамрагдсан багш нарын 48% нь цахим хичээл заахад, бэлтгэхэд бэлэн байсан гэсэн хариулт өгсөн бол үлдсэн 41% хувь нь цахим хичээл бэлтгэх, заахад бэлэн бус буюу үгүй гэж хариулсан байна. Үүнээс үзэхэд багш нарын хувьд цахим хичээл заахад, цахим хичээлийн талаарх ерөнхий ойлголт сул буюу бэлэн бус байгааг харуулж байна.



3. Мөн доорх асуулгын хувьд багш нарын ихэнх хувь буюу 70% нь цахим хичээлийн талаарх ерөнхий ойлголт, мэдээ мэдээлэл, мэдлэг дутуу байсан нь харагдаж байна. Багш нар нь хичээл сургалтын үйл ажиллагаандаа ppt-буюу PowerPoint Presentations хааяа бага хэмжээгээр ашиглаж хичээл заадаг түүнээс

өөр цахим хичээлийн талаарх ерөнхий ойлголтгүй байна. Мөн сэтгэлзүйн хувьд болон хичээл заахад бэлэн бус байгаа нь харагдаж байна.



4. Доорх асуулгын хувьд судалгаанд хамрагдсан багш нарын 67% нь цахим хичээлийн үр дүн тааруу буюу дунд болсон гэж дүгнэсэн. Багш нарын ур чадвар, арга барил нэгэн хэв маягт баригдсан мөн нийгмийн сэтгэлзүй нь цахим хичээлийг хүлээж авах зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан үр дүнгүй болсон гэж дүгнэж байна.



5. Судалгаанд хамрагдсан багш нарын хувьд 29-р сургууль болон 63-р сургуулийн багш нарын ажилласан жил болон мэргэжил зэргийг харгалзан судлагдахуун бүрээс 1-с 2-р багшийг сонгон авсан учир бүх мэргэжлийн багш нарын төлөөлөл тус судалгаанд хамрагдсан юм. Судалгаанаас үзэхэд цахим сургалтыг явуулахад судлагдахуун бүрт хэрэглэх боломжтой гэдэг нь харагдаж байгаа учир ихээхэн

давуу талтай юм. Цаашид багш нараа чадваржуулаад, цахим хичээлийн талаарх ерөнхий ойлголт, мэдээ мэдээллийг багш нар, эцэг эхчүүд, сурагчдад сайн хүргэж чадваас ихээхэн үр дүн гарах боломжтой нь харагдаж байна.



6. Цахим сургалт нь багш нараас ихээхэн ачаалал, мэдээ мэдээлэл, ур чадвар шаардаж байдаг нь доорх судалгааны үр дүнгээс харагдаж байгаа юм. Иймээс багш нартаа цахим хичээлийн талаар ихээхэн ойлголт мэдлэг, чадвар эзэмшүүлж мөн багш бүр өөрсдийн гэсэн цахим хичээлийн сантай болж хойшид өргөжүүлэн хөгжүүлж чадвал үр дүн төдий чинээ өндөр байх нь харагдаж байна.



7. Таны бодлоор цахим хичээлийн давуу талууд юу юу байсан вэ? Гэсэн нээлттэй асуулгын хүрээнд багш нарын хувьд цахим хичээлийг сурагчид гэртээ дуртай цагтай үзэх боломжтой, ойлгоогүй зүйлээ нөхөж үзэх боломжтой, сурагчдыг бие даах чадварт суралцуулдаг, багш нар өөрийн цахим хичээлийн сантай болоход тус дэм болсон, бусад багш нараас туршлага судлах, өвчин халдварт өвчнөөс

урьдчилан сэргийлэх, эцэг эхчүүд хүүхэдтэйгээ харилцах харилцаа илүү ихэссэн, осол гэмтэл багассан гэх мэт давуу талуудыг нэрлэж байсан.

8. Харин багш нарын хувьд Таны бодлоор цахим хичээлийн сул талууд юу юу байсан вэ? гэсэн нээлттэй асуулгад хичээлийн агуулга нь хүүхэд бүрт хүрч боловсроход дутагдалтай, сурагчдын оролцоо ирц хянах, анхаарах боломжгүй, амьд харилцаа байхгүй учир хүүхэд бүрт тохирсон арга хэрэглэх боломжгүй, амьдралын хэв маяг, чадавхаас шалтгаалан хүүхэд бүр интернэт цахим орчинд орох нөхцөл бүрдээгүй, цахим хичээлийн хугацаа бага тусгай хэрэгцээт боловсролын хувьд агуулга хэт хүнд, хүүхэд бүр ойлгох боломжгүй, цахим хичээлийн хурдан явагддаг сурагчид гүйцэж тэмдэглэж авч чададгүй, багш нарын ур чадвар, арга барил өөр өөр учраас хичээл бүрийн чанар өөр өөр, бага цагт их агуулга багтаасан хурдан ярьдаг, хүүхэд бүрт хүрэх хүртээмж бага хичээл хийж байгаа байдалд хяналт тавих боломжгүй зэрэг олон сул талууд байгааг мөн дурдаж байсан.


Тусгай Сургуулийн Сурагчдын Жишээн Дээр

Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг тусгай сургуулиас хүндрэл бэрхшээлийг тооцож үзсэний үндсэн дээр Сүхбаатар дүүргийн 29-р сургуулийн 11,12 анги, Хан-Уул дүүргийн 63 сургуулийн 9-р ангийн сурагчдыг сонгон авч асуулга аргыг ашиглан судалгаа авч боловсруулан дүгнэсэн.

1. Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын хувьд цахим хичээлийн талаарх ерөнхий ойлголт маш сул, муу байсан нь доорх судалгаанаас харагдаж байна. Эдгээр сурагчид цахим хичээлийн талаар ойлголтгүй мөн хичээлийн агуулга хэт хүнд байсан учир цахим хичээлийг хүлээж авах сэтгэлзүй боломж нөхцөл байгаагүй нь харагдаж байна.



2. Судалгаанд хамрагдсан сурагчдын хувьд цахим хичээлийг бүрэн үзэж чадаагүй гэсэн хариулт өгсөн байна. Сурагчдын хувьд гэртээ олуулаа учир дүү нар бас хичээлээ үзэх гэдэг, мөн утас цахим орчин бүрдээгүй, интернет дата байхгүй байсан гэх олон асуудлууд байсан учир хичээлээ бүрэн үзэж чадаагүй байна.



3. Судалгаанд оролцсон сурагчдын хувьд тус асуулгын хүрээнд цахим хичээлээ бүрэн ойлгож чадахгүй байсан гэсэн хариулт өгсөн байна. Учир нь хичээлийн агуулга цар хүрээ их том байсан, багш нар маш хурдан ярьж байсан, мөн дохионы хэлний багш нар маш жижиг харагдаж байсан дохионы хэлээ ч сайн ойлгохгүй байсан гэсэн хариултууд өгсөн байна. Иймээс цахим сургалт нь хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын хувьд агуулга арга зүйн хувьд ч, багш нарын заах арга


барил хувь ч, ашигласан хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж хувьд хэт тохиромжгүй нь **харагдаж** байна.



4. Доорх асуулгад хөгжлийн бэрхшээлтэй сурагчид гэлтгүй ерөнхий боловсролын сургуулийн сурагчид гүйцэж ойлгож, тэмдэглэж авах боломжгүй гэсэн хариулт өгсөн байсан. Иймээс хойшид цахим сургалт, хичээл явуулахад хичээлийн хурд болон сурагчдад багахан хэмжээний бодох бичих, тэмдэглэх хугацааг өгч байх шаардлагатай нь харагдаж байсан.



6. Доорх асуултад сурагчдын 84% нь уламжлалт буюу танхимын сургалт нь ойлгомжтой хялбар байдаг гэсэн хариулт өгсөн нь цахим хичээлийн үр дүнг илтгэн харуулж байна. Гэхдээ дэлхий нийтийн хөгжлийн энэ цаг үед цахим сургалтыг багш нар өөрийн хичээл сургалтад түлхүү хэрэглэж сурагчид болон багш нар, эцэг эхчүүдэд цахим хичээлийн талаарх ойлголтыг өгч байх нь зүйн хэрэг юм.



7. Тухайн асуулгад оролцсон сурагчдын ихэнх хувь нь цахим хичээл ямар ч үр дүнгүй болсон гэсэн үнэлгээг өгч байна. Хагас дутуу үзсэн, хагас дутуу ойлгосон, ямар хичээл дээр ямар сэдвийн тухай үзсэн зэргийг бичиж тэмдэглэж аваагүй, хичээлээ ойлгоогүй учир сурагчид хэр үр дүнтэй болсныг мэдэхгүй буюу эргэлзэж байгаа гэсэн хариулт өгсөн байна. Мэдэхгүй нь мянган үгний таглаа гэдгийн адил ойлгоогүй, үзээгүй, хараагүй учир үр дүнгүй болсон нь харагдаж байна.



8. Та цахим хичээл үзэхэд ямар хүндрэл бэрхшээлүүд гарч байсан вэ? Гэсэн нээлттэй асуулгад хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын төлөөлөл болсон 50 сурагчид үргэлж маш олон хүндрэл бэрхшээлүүд тулгарч байсан үүнд ойлгохгүй зүйлээ багшаасаа шууд асуух боломжгүй, зурагт хараад ойлгохгүй байсан, багшийн яриа хурдан, дохионы багш нар жижиг харагдахгүй, дохиогоо бас сайн ойлгохгүй байсан, утас датагүй буюу интернет байхгүй, хурдан ойлгомжгүй, ер нь

хичээлээ ойлгохгүй байсан зэрэг олон асуудлууд гарч тулгарч байсан гэж хариулж байгаа нь тус цахим хичээл минь тусгай хэрэгцээт боловсрол буюу хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад тохиромжгүй агуулга аргагүйн хувьд том, мөн сурагчдын бие, сэтгэлзүйд тохиромжгүй байгаа нь харагдаж байна.

9. Таны бодлоор цахим хичээлийн давуу талууд юу юу байсан вэ? Гэсэн асуулгад гэртээ байж гарч орохгүй аюултай халдварт өвчнөөс өөрийгөө сэргийлж чадсан мөн нөхөж үзэж, ухрааж үзэж байсан нь бас дохионы хэлээр дохиж байгаа нь давуу байсан гэхдээ дохионы хэл маш жижиг байсан гэж дүгнэсэн байна.

10. Таны бодлоор цахим хичээлийн сул талууд юу юу байсан вэ? Нээлттэй асуултад сурагчид багш нарын яриа маш хурдан ойлгомжгүй байсан хугацаа нь бага ойлгомжгүй, дохио маш жижиг байсан дохиогоо олигтой ч ойлгоогүй гэсэн хариултауд өгсөн байгаа нь. Ер нь цахим сургалт нь хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад тохиромжгүй байсан нь харагдаж байна.

Мөн тус сэдвийн хүрээнд түүврийн арга ашиглан цахим хичээл сургалтын онцлог давуу талууд болон сул талыг тодорхойлж үзсэн. Үүнд:

Цахим хичээлийн онцлог давуу талууд:

- ✓ Орон зайнаас үл хамааран хаанаас ч холбогдох боломжтой.
- ✓ Ихэнх хичээлүүдийг өөрийн боломжтой цагтаа, шөнө ч үзэж судлах боломжтой.
- ✓ Олон дахин давтаж үзэх боломжтой.
- ✓ Өөрсдөө үргэлжлүүлэн судлах, өөрийгөө хөгжүүлэх эрэл хайгуул хийх, олсон материалаа багцлан хүргэх, эмхтгэх зэрэг чадвар эзэмших.
- ✓ Хэрэгцээтэй олон аппликейшн, программ, платформуудыг зөв ашиглаж сурна.
- ✓ Мэдээллийн сонголт хийх чадварыг хөгжүүлдэг. Суралцах зүйлээ суралцагч өөрөө удирдана. Ингэснээр өөрт илүү таатай, нийцтэй аргаараа суралцах боломж нэмэгдэнэ.
- ✓ Эдийн засагт хэмнэлттэй. Танхимын сургалтад очих унааны зардал, нэмүү өртөг шингэсэн цайны газрын хоол, хувцасны элэгдэлт зэрэг цөөнгүй хэмнэлт гарах боломжтой.

- ✓ Байгальд ээлтэй. Цахим сургалт нь уламжлалт сургалттай харьцуулахад эрчим хүчийг 90% хэмнэж, агаарт тарах Co2-г 80% бууруулдаг аж. Уламжлалт сургалтад хэрэглэгдэх цаас, сургууль хүргэх машины утаа, гадуур идэх гялгар ууттай хоол хүнс зэрэг байгальд хортой олон хүчин зүйлсээс зайлсхийдэг.
- ✓ Теле хичээлээр багш нар ч арга туршлагаа солилцох боломж олдсон. Залуу багш эндээс маш их юм сурч мэдэх боломж нээгдсэн.
- ✓ Гэхдээ телевизээр зааж байгаа хурдыг нь бага ангийн хүүхэд гүйцэхгүй юм. Бусдаар бол гэрээсээ хичээллээд байвал ханиад томуу хүрэхгүй амар байсан.
- ✓ Сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдэд дохионы хэлээр давхар зааж байгаа нь ч их сайн санагддаг.
- ✓ Хүүхэдтэйгээ ойлголцох, эцэг эхчүүд хамтарч ажиллаж, хүүхдэдээ цаг гаргадаг болсон.

Цахим сургалтын сул тал:

- ✓ ХҮРТЭЭМЖ буюу бүх сурагчдад хүрч чадсан үү? Амьдрал дээр үгүй.
- ✓ БАГШ НАРЫН БЭЛТГЭЛ ХАНГАМЖ та бэлэн байсан уу?
- ✓ НИЙГМИЙН ХҮЛЭЭЖ АВАХ СЭТГЭЛ ЗҮЙ- нийгэмд цахим хичээл гэдэг ойлголт байсан уу? Хэр ойлголттой байсан вэ?
- ✓ Интернетийн хурд, технологийн дутмаг байдал.
- ✓ Багшаас тэр даруй асуулт асууж, харилцан ярилцах боломж хязгаарлагдмал.
- ✓ Багаар, хамтран ажиллах боломж хязгаарлагдмал.
- ✓ Лаборатори, дадлага, дасгалын аргаар үзэх хичээлүүдийг цахимаар авах боломж тун бага. Хөгжим, бүжиг, биеийн тамирын хичээлүүдийг онлайнаар үзэхэд үр дүн муутай.
- ✓ Амьд харилцаа үүсэхгүйгээс шалтгаалан багш сурагчдыг мэдрэх, түүнд нийцүүлэн “сургах” арга зүй хязгаарлагддаг.

- ✓ Бага ангийн сурагчид хичээлийн хурдыг гүйцэхгүй. Тэр дундаа монгол хэлний хичээлийг хурдыг нь гүйцэхгүй, ойлгохгүй байна гэдэг санал, шүүмжлэл их гарч байна.
- ✓ Хэдийгээр багш, эцэг, эхчүүдийн зүгээс хангалттай анхаарч байгаа ч хүүхдүүдийн хүлээн авах чадвар, ойлголт танхимын сургалтыг гүйцэхгүй байгаа.
- ✓ Теле хичээлийн хувьд зааж буй багш нарын арга туршлага, хэрэглэгдэхүүн хүүхдэд ойлгомжтой. Гэхдээ сул тал нь сурагчдад бодох хугацаа өгөхгүй, тэмдэглэж авч гүйцэхгүй зэрэг бэрхшээл тулгарч байгаа.
- ✓ Эцэг эхчүүдээс санал авахад хичээл хэтэрхий хурдан явагдаж байгаа учраас тэмдэглэж авахад бэрхшээлтэй, зарим малчдад телевиз байхгүй учраас хүүхдүүд нь хичээлээ үзээгүй байдаг.
- ✓ Сурагчдын төлөөлөл: Минийхээр теле хичээл үр дүнгүй байгаа. Яагаад гэвэл 40 минутад орох ёстой хичээлийг 20-хон минутад заадаг. Маш хурдан учраас тэмдэглэж авахад ч хүндрэлтэй. Дээрээс нь эргэлзсэн ойлгоогүй зүйлээ лавлаж асуух боломжгүй. Мөн бүх хичээлээ тасралтгүй үзэж чадахгүй.
- ✓ Нэг хичээлийг хамгийн ихдээ 20 минутад багтаан зааж байна.Энэ хугацаанд зөвхөн мэдлэг өгөөд л дуусдаг. Хүүхдүүдийг чадваржуулах, шинэ хичээлийг бататгах хугацаа алга. Хамгийн гол нь хичээлүүдийг хэт хөнгөн, “илэх” төдий зааж болохгүй.
- ✓ Эцэг, эхчүүд хүүхдээ теле хичээл хийж буй, эсэхийг хянаж, гэрийн даалгаврын хамт зургийг нь дарж, багшид тэмдэглүүлнэ. Тэгэх бүрт асуудал мундахгүй ээ. Интернетгүй айл ч бий. Аав, ээж нь ажилтай, хүүхэд харах хүнгүй хөдөө явуулсан, айлд байлгаж буй нь ч цөөнгүй. Ийм шалтгаантай нь даалгавраа багшдаа “үзүүлж” чадахгүй.
- ✓ Телевизээр хичээл зааж буй багш нарын тухайд камертай харилцаж сураагүй л байх. Гэхдээ өөр тийшээ хараад, хичээл заахаар нэг л үр өгөөжгүй.АМЬД БУС
- ✓ Нийгэмд тэгш бус байдал маш их бий болгосон. Боломжтой айлууд энэ үеэр хүүхдээ сургаад, тасраад явна. Боломжгүй айлын хүүхэд хичээлээс хоцроод, муу сурдаг нэртэй үлдэнэ. Энэ бол бүгдэд хамаатай юм шиг

харагдагч тэгш бус байдал, боломжтой, боломжгүйн ялгааг улам гүнзгийрүүлж байна.

- ✓ Боловсрол гэдэг амьд харилцаан дээр үндэслэдэг. Багш суралцагчийнхаа царай төрх, үзүүлж буй нүүрний хувирал, биеийн хэлэмж, харцнаас хичээлээ ойлгож байна уу, үгүй юу гэдгийг шууд хараад мэднэ. Мөн суралцагчид нэг нэгнээсээ суралцах, нийгэмд дасан зохицох, өөрийгөө илэрхийлэх гээд тал бүрийн харилцаанд оролцдог. Гэтэл цахимаар энэ бүхнийг нь мэдрэх, мэдэх боломжгүй.
- ✓ Дэлхийн улс оронд онлайн сургалт бага багаар хэрэгжиж байсан ч, манай орны хувьд үүнд бэлэн биш байсан.
- ✓ Зарим сургуулийн хичээлд хамрагдалт 60 хувьтай байхад зарим сургууль 80 хувьтай хамрагдаж байна. Зарим хүүхдүүдтэйгээ утсаар ч холбогдож чадахгүй байна. Арай гэж аав, ээжтэй нь холбогдож асуухаар адуугаа аваад оторт гарсан, хониндоо явсан гэдэг.
- ✓ Багш нарын ачаалал хэд дахин нэмэгдсэн. Маш их нэмэгдсэн. Багш 24 цагаар тасралтгүй мэдлэг олгох хэрэгцээ гарч байна. Хүүхдүүд ойлгоогүй зүйлээ асуух гэх мэт. Технологи ашигласан сургалт нь уламжлалт сургалттай харьцуулахад маш их бэлтгэл 80 %- ийн бэлтгэл шаарддаг болохыг өгүүлсэн байдаг.

Дүгнэлт

Багш хүн тухайн хичээлийг стандартын дагуу өөрийн төлөвлөсөн хичээлээ хүргэхийн тулд уламжлалт буюу танхимын сургалт, цахим буюу компьютер, телевиз-д суурилсан хичээл зохион байгуулдаг. Тус сэдвийн хүрээнд сурагчдын хүндрэл бэрхшээлийг харгалзан үзэж Сүхбаатар дүүргийн 29-р сургууль, Хан- Уул дүүргийн 63-р сургуулийг сонгон авч багш нар, сурагчдыг оролцуулан асуулгын аргыг ашиглан судалгаа авч боловсруулсан. Судалгаанаас үзэхэд сонсголгүй сурагчдын хувьд дохионы багш хэт жоохон дохио харагдахгүй мөн маш хурдан явагдаж байсан учир цахим хичээлийг ойлгоогүй гэсэн хариулт өгсөн бол 63 сургуулийн сурагчдын хувьд ч мөн адил хичээл зааж байгаа багш нар хэт хурдан ярьж хурдан өнгөрч байсан учир ойлгож авч чадаагүй гэсэн хариултууд өгч байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад хэт тохиромжгүй, хөгжлийн

бэрхшээлтэй сурагчдыг нийгмээс хэт тусгаарласан, эдгээр хүүхдүүдийн эрхийг хэт зөрчсөн үйлдэл болсон гэж дүгнэж байна.

Судалгаанд хамрагдсан сурагчдын хувьд цахим хичээлээ ойлгоогүй, хэт хурдан ойлгомжгүй байсан гэж дүгнэсэн нь хичээлийн агуулгын хувьд, арга зүй хувьд хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад тохиромжгүй юмаа гэдгийг харуулж байгаа юм. Тус цахим хичээлүүд нь хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад хэт тохиромжгүй хичээлийн агуулга арга зүй хувьд ч хэт хүнд байсан. Иймээс хойшид тусгай хэрэгцээт боловсролын сурагчдад тохирсон цахим хичээлийн стандарт арга зүйг боловсруулах, цахим хичээлийн талаарх мэдлэг мэдээлэл сайн хүргэх, багш нарын хувьд ч өөрсдийн мэргэжил чиглэлийн дагуу цахим хичээлийн сантай болох өөрийн хичээлд цахим хичээлийг түлхүү ашиглаж байх шаардлагатай байна.

ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

Бид нарын үүрэг нь гол гарах, гэвч гүүр болон завь байхгүй бол гол гарах боломжгүй юм. Иймээс гүүр болон завьний асуудал шийдвэрлээгүй үед гол гарах боломжгүй болдог. Иймд өмнөө тулгарсан асуудлаа шийдвэрлээгүй үед өгсөн үүргийг биелүүлэх боломжгүй болно гэж. /Мао ze dong.1934/ хэлсэн байдаг. Манай орны хувьд Сургалтын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх засгийн шийдвэр “сонголт гэхээсээ илүүтэй”, аюулгүй байдал-боловсрол хоёроо аль алийг нь авч үлдэх “гаргалгаа” байлаа. Энэ хөл хорионы шийдвэр багш, сурагч, эцэг эхийн аль алины хувьд гэнэтийн байсан, техник болон сэтгэлзүйн талаасаа ч бэлэн биш байв. Тусгай хэрэгцээт боловсрол эзэмшүүлдэг сургуулиудын хувьд хичээлийн агуулга арга зүй хувьд Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн агуулгаас хөнгөвчилсэн хэлбэрээр зохион байгуулагддаг. Иймээс цахим хичээл нь хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын сурах эрх үүрэг зөрчигдсэн, агуулга арга зүйн хувьд хэт тохиромжгүй мөн хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын хувьд цахим хичээлийн талаарх ерөнхий ойлголт сул, хүлээж авах чадвар чадамж нь сул зэрэг олон асуудлууд зөрчигдсэн хичээл болж өнгөрсөн. Иймээс хойшид төр засаг, боловсролын эрх бүхий байгууллага, сургууль цэцэрлэгүүд цахим хичээлийн талаарх өөрсдийн ойлголт, мэдлэгээ дээшлүүлж ажиллах шаардлага тулгарч байна. Үүнд:

1. Их дээд сургууль, ЕБС, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш бүр өөрийн гэсэн цахим хичээлийн сантай болох аль болох цахим

- хичээлийг уламжлалт танхимын сургалттай хослуулан ашиглах, хэрэглэх, дадах.
2. Боловсролын байгууллагаас цахим хичээлийн сантай, сайттай болох хичээл мэргэжил бүр дээр цахим хичээлүүд бэлтгэн байршуулах. Олон нийтэд мэдээлэх.
 3. Цахим хичээлийн онцлог давуу тал, ашиглах боломж хэрэгцээ шаардлагыг олон нийтэд сурталчилан таниулах. Мэдлэгийг өгөх хүртээх нөхцөл бүрдүүлэх.
 4. Нийгэмд боловсролын тэгш бус байдал үүсгэхээс сэргийлж, амьдралын түвшин, амьжиргааг үл харгалзан ашиглах боломжийг бүрдүүлэхэд анхаарах.
 5. Цахим хичээл бэлтгэх арга зүй, арга барил, мэдлэг, заах багш нарыг бэлтгэн сургах. Техник технологи, арга зүйг их дээд сургууль, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарт хүргүүлэх, сургаж бэлтгэх.
 6. Цахим хичээл бэлтгэх, хүргэх, заах орчин нөхцөлийг бүрдүүлж, Шинэ эрин зууны дэвшилтэт технологиор сургууль цэцэрлэгийг хангаж өгөх.
 7. Сурагч, эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан цахим хичээлийн гарын авлага бэлтгэх, дэлхий нийтэд өргөн ашиглаж байгаа цахим сургалтын аргыг ашигласны онцлог давуу талыг мэдүүлэх таниулах.

Номзүй:

- [1]. Пүрэвдорж.ч, Багшлахуйн менежмент, УБ.
- [2]. Ичинхорлоо.Ш, Багшийн ном, УБ. 2006
- [3]. Дэмбэрэл.Ц, Ирээдүй, өөрчлөлт, хандлага, УБ.Ган принт ХХК
- [4]. Махмут Ачыл, Хүүхдэд өөртөө итгэх итгэлийг хайрын хэлээр төлөвшүүлэх, УБ, Эмпати төв
- [5]. www.google.mn
- [6]. www.baidu.com
- [7]. www.cnki.net

Хавсралт:

Багш нараас авсан нээлттэй судалгааны асуулга.

Судалгааны зорилго: Багш нарын цахим хичээлийн талаарх ерөнхий ойлголт, мэдлэг мэдээлэл, хэрхэн хүлээж авсан, хэрхэн дүгнэж байгааг илрүүлэхэд оршино.

Нас:.....

Мэргэжил:.....

Ажилласан жил:.....

1. Та цахим хичээл бэлтгэхэд, заахад бэлэн байсан уу?

A. Тийм B. Үгүй C. Мэдэхгүй

2. Та цахим сургалтын талаар өмнө нь ямар нэгэн мэдээ мэдээлэл, мэдлэгтэй байсан уу?

A. Сайн мэддэг байсан B. Мэдээ мэдээлэл, мэдлэг дутмаг байсан

C. Бусад

3. Таны бодлоор цахим хичээлүүд хэр үр дүнтэй байсан вэ?

A. Сайн B. Дунд C. Муу D. Мэдэхгүй e. Бусад

4. Таны мэргэжлийн хичээлийг цахим сургалтаар явуулахад хэр тохиромжтой байсан вэ?

A. Тохиромжтой B. Тохиромжгүй C. Мэдэхгүй

5. Цахим хичээл бэлдэх, уламжлалт танхимын сургалт 2-ийн аль нь ачаалал их шаарддаг вэ?

A. Цахим хичээл B. Танхимын сургалт C. Аль аль

6. Таны бодлоор цахим хичээлийн давуу талууд юу юу байсан вэ?

.....

7. Таны бодлоор цахим хичээлийн сул талууд юу юу байсан вэ?

.....

Сурагчдаас авсан нээлттэй судалгааны асуулга.

Судалгааны зорилго: Сурагчид цахим хичээлийг хэрхэн хүлээж авсан, хэрхэн дүгнэж байгаа болон цахим хичээлийн онцлог давуу тал, сул талуудыг илрүүлэхэд оршино.

Анги:

1.Та өмнө нь цахим хичээлийн талаар хэр их ойлголт, мэдээлэлтэй байсан вэ?

А. Хангалттай сайн В. Сайн мэдэхгүй байсан С. Мэдэхгүй

2. Та цахим хичээлүүдээ бүрэн үзэж чадсан уу?

А. Тийм В. Үгүй С. Заримдаа

3. Та цахим хичээлүүдээ бүрэн ойлгож байсан уу?

А. Тийм В. Үгүй С. Хааяа

4. Та цахим хичээлүүдээс ямар ямар хичээлийг сайн ойлгож байсан вэ?

.....

5. Та цахим хичээлүүдийн хурдыг нь гүйцэж, ойлгож, тэмдэглэж авч чадаж байсан уу?

А. Тийм В. Үгүй С. Заримдаа

6. Таны бодлоор танхимын уламжлалт сургалт болон онлайн цахим сургалт 2-ийн аль нь ойлгомжтой, хялбар байдаг вэ?

А. Уламжлалт танхимын сургалт В. Онлайн буюу цахим сургалт

7. Таны бодлоор цахим сургалт хэр үр дүнтэй болсон вэ?

А. Үр дүнгүй болсон В. Үр дүнтэй болсон С. Мэдэхгүй

8. Та цахим хичээл үзэхэд ямар хүндрэл бэрхшээлүүд гарч байсан вэ?

.....

9. Таны бодлоор цахим хичээлийн давуу талууд юу юу байсан вэ?

.....

10. Таны бодлоор цахим хичээлийн сул талууд юу юу байсан вэ?

.....

КАУФМАНЫ ХҮҮХДИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХОЁРДУГААР СОРИЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

(СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ЖИШЭЭН ДЭЭР)

МУБИС-ийн Сэтгэл судлалын докторант Ламжавын Соёлмаа¹

¹Дохионы хэлний хэлмэрч орчуулагчдын холбооны тэргүүн

Хураангуй

Манай улсын хэмжээнд сонсголын бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгодог цорын ганц сургууль нь нийслэл хотдоо байрладаг. Хөдөө орон нутгийн сурагчид байрлах дотуур байртай 29-р сургууль нь “Аман ярианд сургах арга зүй”-гээр 1964 онд үүссэн цагаасаа эхлэн сургалтаа явуулж ирсэн. 2010 оноос дэлхий даяар албан ёсоор эрчимтэйгээр “Хос хэл, хос соёлын арга зүй”-ээр сонсголгүй хүүхдэд боловсрол олгож байна. Бид “Хос хэл, соёлын арга зүйг бага боловсролд нэвтрүүлэх, эрт оролцооны хөтөлбөр боловсруулах” төслийн хүрээнд хос хэлний арга зүйгээр бага боловсрол эзэмшиж буй сонсголгүй сурагчдад 2016 онд сэтгэл зүйн стандарт сорилоор оюун ухааныг үнэлэх шаардлага зүй ёсоор урган гарсан. Сонсголгүй хүүхдээс үгэн бус хэлбэрээр авдаг, хамгийн зохимжтой сэтгэл зүйн сорил нь Кауфманы Хүүхдийн үнэлгээний хоёрдугаар сорил байв. Уг сорилоор сонсголгүй хүүхдийн эх хэл дохионы хэлээ эзэмшсэн цаг хугацаа нь танин мэдэхүйн хөгжилд нөлөөлдөг болох нь харагдсан. Балчир наснаасаа дохионы хэл сурсан хүүхдүүд оюун ухаан, танин мэдэхүйн хувьд дэлхийн түвшинтэй харьцуулахад дээгүүр болон дундаж үзүүлэлттэй байв. Эх хэлээ сурах нас, эх хэлээрээ боловсрол эзэмшихтэй холбоотой чухал асуудлыг хөндөхийг бид зорьсон юм.

Түлхүүр үг: хос хэл-хос соёлын арга зүй, сэтгэл зүйн сорил, үнэлгээ, оюун ухаан, танин мэдэхүй, монгол дохионы хэл

Удиртгал

Балчир буюу бага насандаа сонсголгүй хүүхдийн “Бамбарууш” цэцэрлэг, (2006-2012), нийслэлийн 186-р цэцэрлэгт (2012 оноос хойш) хамрагдаж, сонсголгүй багшаар эх хэл монгол дохионы хэлээ заалгаж, сургуулийн өмнөх боловсрол эзэмшин 2014 онд 29-р сургуульд элсэн орсон 12 сурагчдад 2014-2016 онд “Хос хэл, хос соёлын арга зүйгээр бага боловсрол эзэмшүүлэх” хөтөлбөрийг Дохионы хэлний хэлмэрч орчуулагчдын холбоо АНУ-ын Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн. Хос хэл нь нэгдүгээрт монгол дохионы хэл, хоёрдугаарт монгол хэлний бичгийн хэл болно. Хос соёл нь монгол ахуй соёл болон сонсголгүй хүний ахуй соёл болно.

Аман ярианд сургах арга нь олон улсад Oral education гэдгээр нэрлэгддэг. Манай зарим багш, согог зүйч, тус сургуулийн удирдлага нийгэмд удаа дараа андуу

ташаа мэдээлэл өгсөөр ирсэн: “Бид хос хэлний арга зүй буюу аман болон бичгийн хэлээр боловсрол эзэмшүүлж байна.” Энэ мэдэгдэл нь тухайн мэргэжилтнүүдийн сонсголгүй хүүхдийн боловсролын талаарх нь мэдлэг, мэдээлэл дутмаг, боловсролын дэвшилтэт арга зүйн талаар ойлголтыг харуулж буй хэрэг юм.

2017 онд Монголын багш, эцэг эхчүүдийн холбооны хийсэн судалгаагаар 29-р сургуулийн багш нарын монгол дохионы хэлний ур чадвар хангалтгүй, сурагчдаасаа дохионы хэлээ сурдаг гэсэн дүгнэлт гарсан байдаг.

Дохионы хэлний чадваргүй, эсвэл дохионы хэлний тааруу чадвартай багш нараар заалган эзэмшиж буй боловсрол нь авиа дуудлага зөв дуудах, огт сонсож байгаагүй үгээ хэлж сурах явдал юм. Мөн танин мэдэхүйн хөгжлийг удаашруулж буйн тод илрэл нь “Сонсголгүй хүүхдүүд сурах чадваргүй, ойлголтын түвшин сул” гэсэн пайз зүүж, хялбаршуулсан хөтөлбөрөөр хичээллэж байгаагаас тодорхой харагдана. Монгол төдийгүй олон улсад 10 жил аман ярианд сурах аргаар суралцсан сонсголгүй сурагчид хүний хамгийн энгийн яриаг уруулаас уншиж ойлгох чадвар дөнгөж 20 хүрэхгүй хувьтай байдаг. Мөн тэдний унших, бичих чадвар бага боловсролын түвшинд байдаг гэсэн судалгаа бий. Мөн өнөөдрийг хүртэл сургалтын арга зүйгээ өөрчлөхийг тус сургуулийн төгсөгчид болон сурагчид шаардсаар байгаа нь сонсголгүй хүүхдийн боловсролд “Боловсрол эзэмшүүлэх хэл, боловсролын арга зүйн шинэчлэл шаардлагатай болохыг харуулдаг.

Үндсэн хэсэг

Сонсголгүй хүүхдийн 90 гаруй хувь нь сонсголгүй хүний онцлог, ахуй соёл, дохионы хэлний мэдлэггүй сонсголтой эцэг эхэд төрдөг байна. Сонсголгүй хүүхдээ хүлээн зөвшөөрч, дохионы хэл сурч, хүүхдэдээ дохионы хэл эзэмшүүлэхийн оронд сонсгол алдагдлыг “эмчлэх” анагаахын тулд боломжит бүхий л эмчилгээг хийлгэдэг. Эцэг эхчүүд сонсголгүй хүүхэдтэй болсон сэтгэл зүйн хямралын үеэ давах хүртэл 3-5 жил зарцуулдаг бөгөөд эцэст нь хүүхдээ хүлээн зөвшөөрөх үед хүүхдийн хэл сурах хамгийн таатай үе нь өнгөрсөн байх нь олонтаа.

Манай улсад хөгжлийн бэрхшээлтэй тэр тусмаа сонсголын бэрхшээлтэй хүүхдийг эрт оношлох, илрүүлэх, эрт оролцооны цогц хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлага

байсаар байна. Энэ тогтолцоо бүрдвэл эцэг эхэд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сонсголгүй хүүхдийн 6 сараас эхлэн эцэг эхийн хамт эрт оролцооны хөтөлбөрт хамруулах боломжтой бөгөөд хүүхэд нялх үеэсээ дохионы хэлээ сурах боломж бүрдэх юм.

Сонсголгүй хүүхэд төрсөн цагаасаа эх хэл дохионы хэлээ сурах болон хос хэлээр боловсрол эзэмших ач холбогдлын илрүүлэх зорилгоор Хос хэл-хос соёлын төсөлд хамрагдаж, бага боловсрол эзэмшиж буй 12 хүүхдийг эцэг эхийн зөвшөөрлөөр сэтгэл судлалын стандарт сорилд хамруулсан.

Пиерсон компаниас Кауфманы Хүүхдийн үнэлгээний хоёрдугаар сорилыг орчуулах, ашиглах албан ёсны эрхийг бид худалдан авсан бөгөөд уг сорилын Луриагийн онолд суурилсан үгэн бус хэмжээс бүхий шалгуураар үнэлгээ хийж судлав. Сорилын үйл ажиллагааг заавар, стандартын дагуу удирдан явуулсан бөгөөд сорилын явцад сонсголгүй хүүхэдтэй харилцахдаа монгол дохионы хэл, дүрслэл-зангаа, пантамимо ашигласан.

Сорилын дүгнэлтээр балчир наснаасаа монгол дохионы хэл сурсан сонсголгүй хүүхдийн үзүүлэлт дэлхийн жишигтэй харьцуулахад, дундаж, дунджаас доогуур үзүүлэлттэй гарав. Харин дохионы хэлээ хожуу сурсан хүүхдүүдийн хувьд дэлхийн жишгээс доогуур үзүүлэлттэй гарсан. Эх хэлээ балчир наснаасаа сурсан сонсголгүй хүүхэд оюун ухааны хоцрогдолгүй, хомсдолгүй, дэлхий даяарх ижил насны хүүхдүүдийн түвшинд байгааг уг судалгааны дүгнэлт илэрхийлсэн юм.

Тэдгээр сурагчдаас 2019-2020 хичээлийн жилд 2 хүүхэд Ерөнхий боловсролын сургуульд дохионы хэлний хэлмэрчийн үйлчилгээгээр тэгш хамран суралцаж байна. Хос хэл, соёлын арга зүйгээр СӨБ болон бага боловсрол эзэмшсэн сонсголгүй хүүхэд дунд ангиас эхлэн хүртээмжтэй үйлчилгээний тусламжтайгаар ЕБС-д сурах боломжтойг харуулж байна гэж үзлээ.

Хүүхдийн үнэлгээний сорилын танилцуулга

Хүүхдийн оюун ухааны сорил (Wechsler Intelligence Scale for Children) болон хэд хэдэн хувилбар нь (WISC – III) сонсголгүй хүүхдийн оюун ухааны сорилоор Хойд Америкт өргөнөөр ашиглагддаг. Ер нь сонсголгүй хүүхдийн оюун ухааны чадварыг шалгахад хамгийн түгээмэл хэрэглэгддэг сорил юм. Клиникийн үүднээс тус сорилыг сонсгол алдагдлын нөлөөг оюун ухааны хоцрогдлын нөлөөнөөс ялгах зорилгоор ашигладаг.

Ихэнх сонсголгүй хүүхдүүд хэлний хөгжлийн хоцрогдолд орохоос гадна амьдарч буй ахуй соёлтой холбоотой танин мэдэхүйн ур чадвар, мэдлэг эзэмшихэд хоцрогдолд ордог. Гэхдээ мэргэжилтнүүд энэхүү хоцрогдол нь оюуны чадварын хоцрогдол бус эх хэлээ сурах боломжгүйн улмаас үүддэг болохыг илэрхийлдэг. Хүний хэл ярианы хөгжил, боловсролын амжилт зэргээр үнэлдэг уламжлалт сорилууд нь сонсголгүй хүүхдүүдийг оюуны хоцрогдолтой хэмээн тодорхойлдог. Харин хэл ярианы үзүүлэлтийг хасч, зөвхөн танин мэдэхүйн ур чадварыг хэмжих аргаар судалвал сонсголгүй хүүхдүүд оюуны дундаж ур чадвартай харагддаг. (Branden, 1994; Vernon, 1967) Тиймээс Векслерийн хүүхдийн оюун ухааны тодорхойлох сорилыг тааруу сурлага, хэл ярианы хоцрогдол нь сонсгол алдагдлаас үүдсэн болохоос бус оюун ухааны хоцрогдол биш гэдгийг тодорхойлоход хэрэглэдэг.

Өөр нэгэн судалгаагаар Кауфманы хүүхдийн үнэлгээний хоёрдугаар сорил (K-ABC II)-ийн үгэн бус хэмжээсээр сонсголгүй хүүхдийг судалсан байна. Сонсголгүй хүүхдийн сургуулийн 49 сурагчдаас K-ABC II сорил авахдаа 1 бүлгээс Америк дохионы хэл, пантамимо, дохио-зангаагаар зааварлаж, нөгөө бүлгээс зөвхөн пантамимо, дохио зангаагаар зааварласан байна. Хоёр бүлгийн Үгэн бус K-ABC II оноо онцын ялгаа гараагүй байна. Мөн аль аль нь K-ABC II стандарт нормд ялгаа гараагүй байна. Харин K-ABC II стандарт нормын Орон зайн санах ойн шалгуурт хоёр бүлэг хоёулаа доогуур үзүүлэлттэй байв. Кауфманы хүүхдийн үнэлгээний сорил (K-ABC) ба Векслерийн хүүхдийн оюун ухааныг судлах шинэчилсэн тест (WISC-R)-ийн хооронд нэн чухал харилцан хамааралтай болох нь тогтоогджээ. Тестийн дараах дүн шинжилгээнээс үзэхэд Үгэн бус K-ABC II сорил дээр их доогуур оноо авсан хүүхдүүд WISC-R Гүйцэтгэлийн шалгуурт мөн доогуур оноо авсан байна. Энэхүү судалгаа нь K-ABC II тестийг сонсголгүй хүүхдийг шалгахад хэрэглэх нь зохистой болохыг тодорхойлжээ.

Диаграмм: Кауфманы Хүүхдийн үнэлгээний хоёрдугаар сорил (KABC-II)-ын бүтэц, зохион байгуулалт (7-оос дээш нас)

Хүснэгт 1: 7-18 настан

	Үндсэн сорилууд		Нэмэлт дэд сорилууд
	Дараалсан/ Gsm	Тоо санах	Гарын хөдөлгөөн
	Үгийн дараалал		
Байнгын/Gv	Шоо тоолох /13-18/		Шоо тоолох /7-12/
	Хэсүүлч нохой		Гестальт холбоо

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

MPI/FCI		Гурвалжин дүрснүүд /7-12/	Гурвалжин дүрснүүд /13-18/
	Сурах/Glr	Атлангийн биет	Хойшилсон Атлангийн биет
		Зүйрлэл	Хойшилсон Зүйрлэл
	Төлөвлөх/Gf	Загвар ижилсүүлэх	
		Түүх гүйцээх	
	Мэдлэг/Gc	Онъсого	Илэрхийлэх үгсийн сан
Үгэн мэдлэг			

Анхааруулга: Хаалтанд байгаа дугаарууд насны тоог илэрхийлнэ.

Хүснэгт 2: КАВС-II-ын Үгэн бус хэмжээс

3-4 настан Гарын хөдөлгөөн Төсөөлөн бодох Царай таних Гурвалжин дүрснүүд	5 настан Гарын хөдөлгөөн Төсөөлөн бодох Царай таних Загвар нийлүүлэх Гурвалжин дүрснүүд	6 настан Гарын хөдөлгөөн Төсөөлөн бодох Загвар нийлүүлэх Түүх гүйцээх Гурвалжин дүрснүүд	7-18 настан Гарын хөдөлгөөн Шоо тоолох Гурвалжин дүрснүүд Загвар нийлүүлэх Түүх гүйцээх
---	---	---	---

Хэмжээс дэхь оноо өгөлт, дэлхийн жишиг хэмжээс нь индексээр тодорхойлогдоно. Бүх индексүүд стандарт онооны систем болох 100-аар, стандарт гажилт 15-аар илэрхийлэгдэнэ.

Дэд сорилууд

КАВС-II-ын 18 цөм сорилууд нь үндсэн болон дэд гэсэн хоёр төрөлтэй. Дэд сорилууд нь бүх хэмжээс, дэлхийн жишиг хэмжээсийн индекс зэргийг гаргадаг бөгөөд Луриагийн загварыг хэрэглэж байхад нас тус бүрт 5 болон 8 цөм дэд сорилууд байдаг. СНС загвараар бол нас бүрт нэмэлт хоёр цөм дэд сорилууд (Мэдлэг/Gc) байна. Зарим насны зарим цөм дэд сорилууд бусад насныханд нэмэлт дэд сорил байж болно.

Нэмэлт дэд сорилууд танин мэдэхүйн үйл ажиллагааг хэмжих, үйл явцын алдаа доголдлыг тодорхойлон илүү өргөн хүрээтэй суурийг бий болгохын тулд КАВС-II-р хэмжигдэн илүү өргөн хүрээг хамарч чаддаг. Тэдгээр нь шалгагчийн сонголтоор зохион байгуулагдана. Энэ олон төрлийн нэмэлт дэд сорил болгон нас тус бүр дээр өөрчлөгдөж болно. СНС загварт цөм дэд сорилуудын нас тус бүрийн Мэдлэг/Gc хоёр дэд сорилууд нь Луриагийн загварт хэрэглэгдээд ирэхээрээ нэмэлт сорил болж байдаг.

Нэмэлт дэд сорилууд дээр олж авч буй оноонууд нь Үгэн бус хэмжээсээс бусад КАВС-II-ын хэмжээсүүдэд тухайн хүүхдийн оноо болж ордоггүй бөгөөд энэ үед

цөм дэд сорилоор орлуулж хийгдэх ёстой. Хойшилсон ой санамжтай хавсран хэрэглэгддэг анхны сурах явцыг харьцуулахад хойшилсон Атлантын биет, хойшилсон зүйрлэл дэд сорил зэргүүдийг давхар авахыг шаарддаг.

Цөм болон нэмэлтээс үл хамааран бүх дэд сорилуудын оноо нь онооны 10-тын утгаар, 3-ын стандарт хуваарилалтаар хэмжигдэнэ. Бүх цөм дэд сорилууд болон нэг нэмэлт дэд сорилууд бүтэн КАВС-II стандартчиллын жишигт бүхлээрээ оноогдоно.

Загвар сонгох нь

Шалгагч үнэлгээг зөв гаргахын тулд 3-18 насныхан тус бүрийн одоогийн түвшинд дэлхийн жишгийн хоёр онооны алийг ашиглан дүгнэлт гаргаж байгаагаа тодорхойлох, хувь хүний ерөнхий танин мэдэх чадварын талаас нь кристалл чадвар тогтонги оюун ухааны чадвар зэргийг нь шийдэхийн тулд тухайн хүүхэд эсвэл хүнээ шалгахаас өмнө Луриа эсвэл СНС загварын алиныг ашиглахаа сонгох ёстой.

Зохиогчид өөрсдийн гарын авлагад тодорхой заасанчлан бүх сорилуудын үндсэн зорилгыг чандлан дагах бөгөөд Gc-ын хэмжилт нь Gc хэмжүүрээрээ дамжуулан тухайн хүний чадварын түвшинг гаргаж ирээгүй бол уг хүний оюун ухаан, танин мэдэх чадварыг хэмжиж гаргах гэсэн зорилгоосоо татгалзах хэрэгтэй болно. Энэхүү зарчим нь КАВС-II сорилыг ашиглахад дэлхийн жишиг бүхий оноог сонгосноор дараагийн алхмыг хийхэд голлох нөлөөлөл болно.

СНС загвар нь шалгагчийн шаардлагатай кристалл чадвар тогтонги оюун ухаан нь хөдлөнги оюун ухааны үзүүлэлт (FCI)-ийн хүчинтэй байдлаар тохиролцож болно гэж найдвараас бусад тохиолдолд ерөнхийдөө сонголтын загвар болж чадна. Тэдгээр тохиолдолд Луриад суурилсан дэлхийн жишиг индекс (MPI)-г илүү хэрэглэж болно. СНС загварыг Луриагийн загвараас илүүд үздэг учир нь зохиогчид Мэдлэг/Gc нь ерөнхийдөө танин мэдэхүйн үүрэгт чухал нөлөөл үзүүлдэг гэдэгт илүү итгэдэг.

Луриагийн загвар (MPI) хязгаарлагдмал ч илүү хэрэглэгдэх дараах тохиолдлууд байна. Үүнд:

- хос хэлтэй хүүхэд
- голлох бус соёлын нөхцөл байдал нь мэдлэгийн чадвар, хэл яриа хөгжих хөгжилд нөлөөлж болохуйц хүүхэд

- илэрхийлэх, хүлээж авах эсвэл хүлээж авах-илэрхийлэх холимог эсэхээс үл хамаараад мэддэг, ойлгодог хэлний эмх замбараагүй нөхцөл байдалтай хүүхэд

Түүнчлэн Луриагийн боловсруулах арга барилыг хатуу чандлан дагаж мөрдөхөө илэрхийлж цуглуулсан мэдлэгээ дэлхийн жишгийн танин мэдэхүйн онооноос (туслалцаа үзүүлэхийг хүсэх шалтгаанаас үл хамааран) гадуур байх ёстой гэж үзэх шалгагч Луриа-д суурилсан хэрэгсэл шиг анхдагч К-ABC-тай ижил арга барилаар КАВС-II-г ашиглаж болох юм.

Энэхүү зөвлөмжийн багц нь онолын хувьд нэг загвар нь нөгөөгөөсөө давуу байдаг гэж үздэг гэсэн үг биш бөгөөд хоёр онол нь хоёулаа КАВС-II-ын суурь ижил тэгш чухал үүргийг гүйцэтгэнэ. СНС психометр загвар нь Луриагийн мэдрэл сэтгэл судлалын асуудал шийдвэрлэхэд хүүхдийн мэдээлэл боловсруулах үйл явцыг онцлон гаргадаг шиг тусгайлсан танин мэдэхүйн чадварыг илүү нээхийг хичээдэг. Эдгээр аргууд нь хүүхэд аливаа шинээр үүссэн асуудлыг хэрхэн хүлээн авч, шийдвэрлэж байгааг ойлгоход дөхөм болдог, учир нь онол тус бүрийн хэмжүүр болгон хоёр нэртэй байдаг.

Сэтгэл судлаачдын боловсруулж буй хэмжүүрийг тайлбарлах арга зам нь тухайн онолын давуу байдлаас ихээхэн хамаарах болно. Луриагийн үйл ажиллагааны нэгжийн системээс илүү СНС-ын танин мэдэхүйн чадварын арга барилыг илүү тохиромжтой гэж үздэг шалгагч нар СНС өргөн хэмжээний ур чадварын давуу байдлуудыг КАВС-II оноогоор тайлбарлаж болох ба тухайлбал хэл ярианы бэрхшээлтэй хүүхдүүдэд илүү танин мэдэхүйн үйл ажиллагааг дэлхийн жишиг хэмжүүрээр үнэлэн MPI аргаар тайлагнах аргыг сонгоно. Луриагийн загварыг хэрэглэдэг шалгагч нар гурван функционал нэгж талаас оноог илүү тайлбарладаг ба билэг авьяаст бага насны болон өсвөр насны хүүхдүүдэд зориулан FCI-аар тайлбарлахаас татгалзах нь зүйтэй. Хүүхдийн онооны профайлыг тайлбарлах шалгагчийн хандлага нь тэдний дэлхийн жишиг оноог тайлбарлахтай холбогдуулан гаргасан шийдвэрээс илүү бага ач холбогдолтой байх бөгөөд энэ нь лавлах, суурь хүчин зүйлд илүү суурилсан байх ёстой.

Сорилын материал

Сорил тус бүрийн хэрэгсэл нь гарын авлагад дурдсан сорилын онолын суурь, техникийн мэдээлэл шиг бүх насныханд зориулсан КАВС-II-ыг тайлбарлах, оноо

өгөх, сорил авах зэрэгт шаардлагатай дараах материалуудыг багтаасан байна.

Секунд хэмжигч үүнд багтахгүй ч зарим дэд сорил авахад хэрэглэгдэнэ. Үүнд:

- Дөрвөн дэд сорилын ном
- Үгийн дарааллын карт, хавтас карт
- Хэсүүлч нохойн товхимол, нохойн баримал
- Шоо тоолох хэрэглэгдэх шоонууд
- Гурвалжингууд (хуванцар ба хөөсөн гурвалжингууд)
- Түүх гүйцээх өдөөгч товхимол, картнууд
- Тэмдэглэх маягт

Сорил авах цаг

Цөм дэд сорил авахаар болоход тухайн хүүхдийн наснаас хамаараад (Хүснэгт 1.3) шалгагч нар ойролцоогоор 25-60 минут (Луриа загвар), 30-75 минут (СНС загвар)-г онооны профайлыг олж авахын тулд зарцуулж байна. Эдгээр тооцооллыг үндэсний стандартчиллын үед бодит дэд сорил авах цагт үндэслэн дараачийн зүйлсийг гаргахад тохируулан гаргасан болно.

Бүтэн өргөтгөсөн цуврал сорилын авахаар сонгосон шалгагч нар кристалл чадвар тогтонги оюун ухаан чадварыг хэмжих хэмжилтийг оруулаад бүх үндсэн болон нэмэлт дэд сорилууд нь 3 болон 4 настангуудад нэг цаг дотор, 5 болон 6 настангуудад 90 минут, 7 болон 8 настангуудад 100 минут зарцуулахыг мэдсэн байх хэрэгтэй. Хэдийгээр нэмэлт дэд сорил авахаар сонгосон шалгагч нар тухайн бага насны хийгээд өсвөр насны хүүхдээс авах боломжтой бүх дэд сорилуудыг аваад байх шаардлагагүй ч лавлах зорилгоор тухайн хүүхдэд тохирсон нэгийг хамааруулах ёстой. Түүнчлэн Луриагийн загварыг сонгосон шалгагч нар тухайн хүүхдийн нөхцөл байдал хийгээд хамааралтай мэдээлэл нь тухайн хүүхдийн тухайлсан танин мэдэхүйн чадварт нөлөөлөхгүй хэмжилтийг үзүүлж байгаа тохиолдолд Мэдлэг/Гс-ийн алиныг ч сорилоор авахгүй байх нь зүйтэй.

Хүснэгт 3 Сорилын тайлбар

Хэмжээс/Дэд сорил	Нас			Тодорхойлолт
	Цөм	Нэмэлт	Үгэн бус	
Дараалсан/Gsm	4-18	3		
Тоо санах	3-18			Хүүхэд шалгагчийн хэлсний дагуу өгөгдсөн 2-9 дугаарын тоонуудыг ижил дараалалд оруулна. 7-н тооны оронд

				ашиглагдах 10-ын тооноос бусад тоонууд ганц тоо, нэг үетэй байна.
Үгийн дараалал				Хүүхэд шалгагчийн зааврын дагуу өргөн хэрэглээний зүйлсийн нэрийг хэлэх үед хүрэх бөгөөд өдөөгч болон хариу үйлдлийн хооронд хамгийн хүнд зүйлсэд хүндрэлтэй даалгаварууд (өнгө нэрлэх) мөн байна.
Гарын хөдөлгөөн		4-18	3-18	Хүүхэд шалгагчийн ширээн дээр тавьж үзүүлж байгаа нударга, гарын алга, гарын хажуу талуудын дарааллыг дууриана.
Зэрэгцээ/Gv				
Шоо тоолох	13-18	5-12	7-18	Хүүхэд олон төрлийн зурагтай шоо, дүрснүүдийн яг дугаарын дагуу тоолно. Дүрснүүдээс зарим нэгийг нуух, харагдах байдлаас далд тавьсан байж болно.
Төсөөлөн бодох	3-6		3-6	Хүүхэд 4 болон 5 зураг бүхий багц зургийг үзээд тухайн зүйлсэд хамааралгүй зургийг таних ёстой. Зарим зүйлс нь утга бүхий өгүүлэмжтэй, зарим нь хийсвэр утга бүхий байна.
Царай таних	3-4	5	3-5	Хүүхэд нэг болон хоёр нүүр царай бүхий зургийг сайн нарийвчлан харах, хэсэг бүлэг хүмүүсийн зураг, өөр өөр тавилттай зураг зэргээс зөв нүүр царайг сонгоно.
Загвар шалтгаалах нь	5-6			Төлөвлөлт/Gf үнэлгээ хэсгээс харна уу
Хэсүүлч нохой	6-18			Хүүхэд элдэв саад (хад чулуу, өвс ургамал) бүхий шатрын хөлөг шиг самбар дээрх тоглоомон нохойг ясандаа хурдан очих арга замыг олно.
Түүх гүйцээх нь		6		Төлөвлөлт/Gf үнэлгээ хэсгээс харна уу
Гурвалжин дүрснүүд	3-12	13-18	3-18	Ихэнх зүйлсийн хувьд хүүхэд хийсвэр загвар бүхий

				зурагтай хэд хэдэн ижил төрлийн хөөсөн гурвалжин дүрснүүдийг (нэг тал нь цэнхэр, нөгөө тал нь шар) нийлүүлнэ. Хялбар зүйлсийн хувьд хүүхэд тавиур дээр үзүүлсэн эсвэл шалгагч зааварчилгаа өгсний дагуу өгөгдсөн нүдэнд өнгө өнгийн хуванцар дүрснүүдийг эвлүүлэн нийлүүлнэ.
Гештальт холбоо		3-18		Хүүхэд өөрийн оюун ухаанаараа өгөгдсөн зүйлс, нэрсийг өөрийн дүрслэлээрээ нэрлэх, дүрсэлж хоосон зайг нөхнө.
Төлөвлөлт/Gf (зөвхөн 7-18 насныхан)				
Загвар нийлүүлэх нь	7-18		5-18	Хүүхдэд өдөөгч багц бүхий шугаман болон логик загварыг үзүүлэх ч нэг өдөөгч нь орхигдсон байна. Хүүхэд тараагдсан хуудасны доод хэсэгт байрлах 4-6 сонголт бүхий иж бүрдлээс зөв өдөөгчийг сонгох замаар загварыг гүйцээж болно. Ихэнх өдөөгч нар нь хийсвэр, геометрийн дүрс байх ч зарим хялбар зүйлс утга бүхий зураг агуулсан байж болно.
Түүх гүйцээх нь	7-18		6-18	Хүүхдэд үлгэр бүхий хэсэг зургийг үзүүлэх ч зарим зураг орхигдсон байх болно. Тухайн хүүхдэд уг багц зургийг өгч тухайн үлгэрийг гүйцээхийн тулд зөвхөн орхигдсон нэг зургийг зохих зөв байршилд байршуулна.
Сурах/Glr				
Атлангийн биет	3-18			Шалгагч хүүхдэд загас, ургамал, дун хясааны төрөл бүрийн зураг үзүүлж утгагүй нэрсийг зааж өгнө. Хүүхэд нэрийг сонсоод тухайн (багц зураг дотроос) зургийг зааснаар сурснаа харуулна.

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Зүйрлэл	4-18			Шалгагч хүүхдэд үг болон утгачилсан тусгайлсан зүйрлэл (зураг)-ийг заана. Хүүхэд холбогдох зүйрлэлээр бүтсэн тухайн хэллэг, өгүүлбэрийг чангаар уншина.
Хугацаа хойшилсон Атлангийн биет		5-18		Ойролцоогоор 15-25 минутын өмнө сурсан Атлангийн биетүүд болох загас, ургамал, дун хясааны утгагүй нэрийг санаснаараа эргэн санах буюу хосолсон холбоог илэрхийлнэ
Хугацаа хойшилсон зүйрлэл		5-18		15-25 минутын өмнө үзсэн зүйрлэлийн уншилтын үед сурсан хосолсон холбоог эргэн санаж буйг илэрхийлнэ.
Мэдлэг/Гс (зөвхөн СНС загварт)				
Ойлгомжтой үгийн сан	3-6	7-18		Хүүхэд зурагт үзүүлсэн зүйлсийн нэрсийг хэлнэ.
Онъсого	3-18			Шалгагч бодит болон хийсвэр үгэн утга бүхий илэрхийлэлийн хэд хэдэн хэллэгийг хэлэх ба хүүхэд түүнийг заах (эхний зүйлс) буй нэрлэнэ (дараагийн зүйлс).
Үгэн мэдлэг	7-18	3-6		Хүүхэд зургаан иж бүрдэл бүхий зургаас бүгийн сангийн үгд тохирох утгатай эсвэл ерөнхий мэдлэгт тохирсон хариу бүхий зөвхөн нэгийг нь сонгох болно.

Хүснэгт 4: Тооцоолсон дундаж сорил авах цагууд

	Нас					
	3	4	5	6	7-12	13-18
Луриа загвар (MPI)						
Цөм дэд сорилын дугаар	5	7	7	8	8	8
Дундаж цаг (минутаар)	25-30	30-35	35-40	45-50	55-60	50-55
СНС загвар (FCI)						
Цөм дэд сорилын дугаар	7	9	9	10	10	10
Дундаж цаг (минутаар)	30-35	40-45	45-50	55-60	70-75	65-70
Үгэн бус хэмжээс (NVI)						
Цөм дэд сорилын дугаар	4	5	5	5	5	5
Дундаж цаг (минутаар)	20	20	30	30	40	40

Судалгааны зорилго зорилт шинэлэг байдал

Сэтгэхүйн үйл явц, ерөнхий танин мэдэхүйн чадварын бүрэн гүйцэд хэмжилтээр авч үзвэл КАВС-II нь сургуулийн өмнөх болон ахлах сургуулийн хоорондох бүх шатны сэтгэл судлалын, клиникийн, психоболовсролын болон мэдрэл сэтгэл судлалын үнэлгээнд зохих нэмэр оруулж байдаг. Үүгээр клиникийн болон боловсролын дүн шинжилгээ, боловсролын төлөвлөлт, эмчилгээний төлөвлөгөө, хуваарилах шийдвэрт зохицуулагдах мэдээллийг олж авч болно.

Кауфманы хүүхдийн үнэлгээний хоёрдугаар сорилоор хос хэл-хос соёлын арга зүйгээр СӨБ ба бага боловсрол эзэмшсэн сонсголгүй хүүхдүүдийг үнэлэх зорилготой байсан. Уг сорилын Луриагийн онолд үндэслэсэн үгэн бус сорил нь сонсголгүй, хос хэлтэй (дохионы болон бичгийн) сурагчдыг үнэлэхэд тохиромжтой байсан. Сонсголын бэрхшээлтэй сурагчдаас сэтгэл зүйн стандарт сорилоор, монгол дохионы хэлээр сорил авсан нь шинэлэг тал байсан.

Судалгааны үр дүн

Хос хэлтэй сонсголгүй хүүхдүүд дохионы хэлээр чөлөөтэй харилцахаас гадна өөртөө итгэлтэй бие даасан байдалтай байв. Эдгээр хүүхдүүдийн гэр бүлийнхэнтэйгээ дохионы хэлээр чөлөөтэй харилцаж өөрсдийгөө илэрхийлдэг байдал нь тэднийг сэтгэл зүйн хувьд илүү тогтвортой болгосон нь харагдаж байлаа. Эцэг эхчүүдийн хувьд хүүхдүүдээ цэцэрлэгт хамрагдах хугацаанд “Эцэг эхчүүдэд зориулсан дохионы хэлний сургалт, сэтгэл зүйн бүлгийн зөвлөгөө”-нд идэвхтэй оролцож байсан. Энэ нь хүүхэдтэйгээ монгол дохионы хэлээр харилцаж ойлголцоход илүү дөхөмтэй байв.

Кауфманы хүүхдийн үнэлгээний хоёрдугаар сорилоор “хос хэл-хос соёлын арга зүйн төсөлд хамрагдсан туршилтын бүлэг”-ийн хүүхдийг Луриагийн онолын загвараар үнэлж хүүхэд тус бүрийн дэлхийн жишиг оноог тогтоов. МУБИС-ийн Сэтгэл судлалын тэнхимийн сэтгэл судлалын докторанд Л.Соёлмаа, удирдагч багш Г.Батцэнгэл (Доктор, Ph.D., Дэд проф, МУБИС-ийн Тусгай хэрэгцээт боловсролын тэнхимийн эрхлэгч)-ийн удирдлага дор 2015-2016 онд уг сорилыг тухайн үед 29-р сургуульд суралцаж байсан 2-р ангийн сурагчдаас авсан.

Сорилд хамрагдсан хүүхдийн анхаарал ба ачаалал даах чадвар нэмэгдсэн нь удаа дараагийн сорилын явц, үнэлгээнээс харагдаж байв.

Уг сорилд хамрагдсан 12 хүүхдийн 5 эмэгтэй, 7 эрэгтэй хүүхэд байна. 10 сонсголгүй, 1 сул сонсголтой, 1 давхар бэрхшээлтэй хүүхэд байв. Насны хувьд

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

8-14 насны хүүхдүүд бөгөөд эх хэлээ сурч эхэлсэн нас нь 2-8 насны хооронд байна. Нийт хүүхдийн 2 нь дэлхийн түвшний оноонд дундаж, 2 нь дунджаас доогуур, 8 нь доогуур үзүүлэлттэй байсан.


Судалгааны нэгдсэн дүгнэлтийг дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт 5: Сорилын нэгдсэн дүгнэлт

Хүүхдийн код	Нас	Хүйс	Монгол дохионы хэл сурч эхэлсэн нас	Сонсгол алдагдал	Стандарт оноо	95% Баталгаат интервал	Түвшний тодорхойлолт (Монголоор)	Түвшний тодорхойлолт (Англиар)
01-Г	9	Эр	2	сонсголгүй	74	87-99	Дундаж	Average Range
02-Н	9	Эм	5	сонсголгүй	48	43-65	Доогуур	Lower Extreme Range
03-Х	10	Эр	2	сонсголгүй	52	47-59	Доогуур	Lower Extreme Range
04-С	10	Эм	6	сонсголгүй	46	41-53	Доогуур	Lower Extreme Range
05-Д	9	Эр	6	сонсголгүй	84	78-90	Дундаж	Average Range
06-А	9	Эм	5	сонсголгүй	72	67-79	Дундажаас доогуур	Below Average Range
07-Бм	11	Эр	Тодорхойгүй	Сул сонсголтой	60	55-67	Доогуур	Lower Extreme Range
08-Му	8	Эр	4	сонсголгүй	55	57-62	Доогуур	Lower Extreme Range
09-Ү	8	Эр	4	сонсголгүй	63	58-70	Доогуур	Lower Extreme Range
10-Т	9	Эр	2	сонсголгүй	72	68-80	Дундажаас доогуур	Below Average Range
11-З	8	Эм	4	сонсголгүй	64	59-71	Доогуур	Lower Extreme Range
12-Ц	14	Эм	8	Сонсгаа	61	56-68	Доогуур	Lower Extreme Range

Сорилын тэмдэглэлийн жишиг загварыг нэг хүүхдийн жишээн дээр дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт 6: Үнэлгээний индексийн график 7-18 нас



хугацаанд уг төсөлд хамрагдаагүй хяналтын бүлэг ба бусад хүүхдүүдийг судлах боломжгүй байв. Төсөлд хамрагдсан ангиас бусад анги “Аман ярианд сургах” арга зүйг хэрэглэдэг байсан. Харин төсөлд хамрагдсан хүүхдэд хүрч буй ашиг тус нь илэрхий харагдаж байсан.

Ашигласан ном

Alan S. Kaufman, Elizabeth O. Lichtenberger, Elaine Fletcher-Janzen, Nadeen L. Kaufman “Essentials of the K-ABC assessment” 2005 John Wiley and Sons Ink.

Jeffery P. Braden and Joseph M. Hahhah “Assessment of hearing impaired and deaf children with the WISC-II”

Larry James Porter, Edward Aaron Kirby January 1986 Effects of two instructional sets on the validity of the Kaufman assessment battery for children—nonverbal scale with a group of severely hearing impaired children

WISC WISC-III Clinical Use and Interpretation Scientist- Practitioner Perspective. 1998 Academic Press.

Хавсралт 1

Кауфманы хүүхдийн үнэлгээний сорил (K-ABC) товч танилцуулга

Кауфманы хүүхдийн үнэлгээний сорил (K-ABC) 1970 оны сүүлч 1980-аад онд боловсруулагдаж, IQ – г голлож байсан Векслер, Бинегийн гол нөлөөллийн үед 1983 онд хэвлэгдсэн ба зөвхөн IQ бус арьс өнгөний ялгаатай байдлыг эсэргүйцэн, үндэсний цөөнхийн онцлогыг тусгасан байна.

Векслерийн сорилын үнэлгээний 15-16 үзүүлэлт нь Африк гаралтай Америк хүүхдүүдээс цагаан арьст хүүхдүүдэд илүү таатай байдаг бол Кауфманы хүүхдийн үнэлгээний сорил (K-ABC)-д энэхүү ялгааг бүрэн хассан байдаг. K-ABC –д Тест авахад соёлын ялгааны нөлөөллийг багасгасан тул үндэсний цөөнхийн бүлэг, латин америк, уугуул нутгийн индиан хүүхдийн үнэлгээний дүгнэлтийн оноо бусад уламжлалт тестийн онооноос өндөр гардагаараа давуу талтай.

K-ABC Анхны 8 тест дээр шинээр 10 тестийг нэмж Кауфманы хүүхдийн үнэлгээний хоёрдугаар сорил (K-ABC II)-ыг боловсруулав. K-ABC II сорилыг боловсруулах болсон зорилго нь

Нэгдүгээрт онолын суурийг бататгах. Үүнд KABC II сорилын ур чадварын хэмжигдэхүүнийг хэд хэдэн онолоор тайлбарлах шаардлага гарч ирсэн. Анхны Кауфманы хүүхдийн үнэлгээний сорилын хувилбарт байсан Луриагийн онолд суурилсан үнэлгээний тайлбарыг багтаасан ба Каттел Хорн Карены (CHC) онолд суурилсан үнэлгээний тайлбарыг багтаасан.

Хоёрдугаарт хэд хэдэн ур чадварын хэмжигдэхүүнийг нэмсэн. Үүнд АНУ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын хууль (IDEA) –ийн шинэчилсэн

зааварчилгаатай уялдах, түгээмэл чадвараас илүү тусгай чадваруудыг онцлох, эмгэгийн үйл явцыг тодорхойлж, хөндлөнгийн оролцоог ихэсгэсэн.

Гуравдугаарт, клиник ач холбогдлыг ихэсгэсэн. Энэ нь 3-18 насны хүүхдийн шалгахдаа бага насны хүүхдийн суурь чадвар, өсвөр үеийнхэний өндөр ур чадварыг бататгажээ. Ерөнхий танин мэдэхүйн ур чадвараас гадна хадгалагдсан ур чадвар (Gc) нь онцлох шалгуур байдаг. Чанарын шалгуур үзүүлэлтүүд (QIs) нэмэгдсэн нь шалгах явцдаа тест бүрт клиник ажиглалт хийх боломжийг шалгагчид олгодоогоороо онцлогтой.

Дөрөвдүгээрт үндэсний цөөнхийн хүүхдүүдийг шударгаар үнэлдэгээрээ онцлогтой. Үг ба баримт мэдлэгийг шаардлагатай тохиолдолд хасахыг шалгагчид зөвшөөрдөг. Тестийн зааврыг ойлгохгүйгээс хүүхдийн гүйцэтгэл дэх нөлөөллийг арилгасан. Зааврыг хялбарчилж, үгэн бус хэмжигдэхүүнийг нэмсэн.

Тавдугаарт, сургуулийн өмнөх насныхыг үнэн зөвөөр дүгнэдэг. Тоглоом шиг тестийн өгөгдлүүдтэй, тест удирдах, үнэлэх үйл явцыг хялбарчилсэн, үгэн зааврыг багасгасан, хоцрогдолтой хүүхдийг хөгжүүлэх боломж олгодог.

Хавсралт 2

Кауфманы үнэлгээний сорил 2 дах хэвлэлийн танилцуулга, ерөнхий тойм

Кауфманы хүүхдийн үнэлгээний хоёрдугаар сорил (KABC-II) нь 3-18 насны хүүхэд болон өсвөр насны хүүхдийн танин мэдэх чадвар, явцыг ганцаарчлан хэмжихэд зориулж тусгайлан боловсруулсан сорил юм. Энэхүү сорил нь сургуулийн өмнөх болон дунд сургуулийн бүх түвшний хүүхдүүдэд сэтгэл зүйн, клиникийн, сурган сэтгэл зүйн, мэдрэл сэтгэл зүйн үнэлгээ хийхэд ихээхэн чухал хувь нэмэр болдог. Кауфманы хүүхдийн үнэлгээний хоёрдугаар сорил (KABC-II) нь өргөн хүрээний онолын бааз суурьт үндэслэн, олон насны цар хүрээг хамарсан, нэмэлт онооны тогтолцоо бий болгосон дэвшилттэйгээр боловсруулагдсан байна.

Кауфманы хүүхдийн үнэлгээний хоёрдугаар сорил (KABC-II)-ын онцлог шинжүүд нь дараах танин мэдэхүйн үнэлгээний тусгайлсан аргуудыг багтааснаараа ач холбогдолтой юм. Үүнд:

- Дараалсан хийгээд байнгын үйл явц, сурах арга барил, шалтгаан, боловсролын хийгээд сэтгэл зүйн асуудалтай хүүхдүүдийг судлахтай холбоотой **кристалл чадвар тогтонги оюун ухааны** чадварыг хэмждэг
- Үнэлгээнд угсаатны хийгээд соёлын бүлгүүдийн хоорондын ялгааг бууруулах, өөр өөр амьдралын түвшинтэй бага насны болон өсвөр насны хүүхдүүдийн үнэлгээн дэхь тогтвортой байдлыг хангах зэрэг чадваруудыг хэмждэг
- Мөн Каттел-Хорн-Каррол (CHC)-ын психометрийн өргөн хийгээд нарийвчилсан чадварын загвар, Луриагийн үйл явц дахь мэдрэл сэтгэл судлалын онол гэх хоёр орчин цагийн онолын загварууд дээр суурилан хэрэглэгддэг сорил юм. Дэд сорилуудын дан багцыг ашигласнаар Кауфманы хүүхдийн үнэлгээний хоёрдугаар сорил (KABC-II) нь өөр боловч нарийвчилсан хоёр өөр чиг хандлагаар тайлбарлагддаг.
- Нэмж хэлэхэд энэхүү Кауфманы хүүхдийн үнэлгээний хоёрдугаар сорил (KABC-II)-ийн хос онолын суурь нь тухайн сэтгэл зүйчид суралцсан мэдлэг нь хүүхдийн чадварын гол үзүүлэлт бус тул үүнгүйгээр хүүхдийн үнэлгээг

гаргах боломжийг олгодог. Энэ нь Англи хэлийг хоёрдогч хэлээр сурж байгаа болон хэлний хүнд ба хөнгөн бэрхшээлтэй эвсэл аутизмтай хүүхдийг үнэлэхэд чухал юм.

- Кауфманы хүүхдийн үнэлгээний хоёрдугаар сорил (КАВС-II) анхны хувилбар сорил шиг (K-ABC) шиг хэлний бэрхшээлтэй, Англи хэлний мэдлэг хязгаарлагдмал, хангалтгүй, ярих чадвар сул, сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийг зөвөөр үнэлэх боломжийг олгохын тулд пантомимд зориулагдсан дэд сорилуудаас бүрдсэн, автоматаар хариулагддаг үгэн бус хэмжүүрийг ашигладаг.
- Мөн Кауфманы хүүхдийн үнэлгээний хоёрдугаар сорил (КАВС-II) нь үндсэн болон дэд сорилын цагийг ашигтай байдлаар зарцуулах системээр зохион байгуулагдсан бөгөөд үндсэн ба дэд сорилын багц нь бүх хэмжээс болон дэлхийн жишиг хэмжээст тохирсон оноог олгодог. Дэд сорил нь чадваруудын дараагийн алхамуудыг судлах, үндсэн цувралаар хэмжигдэх үйл явцыг судлана.
- Кауфманы хүүхдийн үнэлгээний хоёрдугаар сорил (КАВС-II) -ын хувь дэд сорил болон дэлхийн жишиг хэмжээс нь нийт хүн ам, тухайлбал насныхаа түвшний эсвэл гоц хүүхдүүдийг ч бүрэн хамардаг.
- Кауфманы хүүхдийн үнэлгээний хоёрдугаар сорил (КАВС-II)-ын маягтууд нь сорил тус бүрт зориулсан Чанарын үзүүлэлтийг агуулсан байх ба тайлбаруудтай холбогдох тусгайлсан сорилд оролцогчийн зан байдлыг ажиглан дүгнэх боломжийг шалгагчид олгоно.

Онолын хоёр загвар

КАВС-II нь хос онолын суурь дээр бүтээгдсэн бөгөөд үүнд 3 шоо эсвэл үйл ажиллагааны нэгжийг агуулсан Луриа (1966b, 1970, 1973)-ын мэдрэл сэтгэл судлалын загвар ба өргөн хийгээд нарийвчилсан танин мэдэхүйн чадваруудын шаталсан зохион байгуулалт бүхий Каттелл-Хорн-Карролл (СНС)-ын загвар болно. Эсрэгээрээ К-ABC нь дараалсан болон байнгын үйл явц хоорондын онцлог гэх дан ганц онолын суурьтай байсан.

Луриагийн загварын талаас тайлбарлахад КАВС-II нь сэтгэхүйн үйл явцад илүү анхаарах, олж авсан мэдлэгийг тодотгох, Сэтгэхүйн үйл явцын индекс (MPI) гэх дэлхий нийтийн хэмжээсээр хэмжигдэнэ. Анхны К-ABC шиг КАВС-II нь дараалсан болон байнгын үйл явцын үнэлгээг чухалчилан авч үзнэ. Эдгээр хоёр сэтгэхүйн үйл явцын дарааллаар явахаас гадна КАВС-II Луриа загвар нь сурах болон төлөвлөх чадварын хэмжээсийг мөн агуулна. Энэхүү Луриа онол нь олж авсан мэдлэг (хэлний мэдлэг эсвэл ерөнхий мэдлэг гэх мэт)-ийг сэтгэхүйн үйл явцаас гадна гэж үздэг.

СНС-н загварын талаас харах юм бол КАВС-II нь Луриагийн загварын бүхийл хэмжээсүүдийг агуулах хэдий ч өөрөөр тайлбарлагддаг. Жишээлбэл, Луриагийн чиг хандлагаар байнгын үйл явцыг хэмжих хэмжээс нь СНС-ын харах үйл явцын чадварыг (Gv) хэмжихэд ажиглагддаг. КАВС-II-т орсон СНС загвар нь нэгэн нэмэлт хэмжээсийг агуулдаг нь Луриагийн загварт байдаггүй Мэдлэг/Gc хэмжээс болно. СНС загвар дахь бүх хэмжээсийг зохицуулснаар дэлхийн жишиг хэмжээс нь хөдлөнги оюун ухааны индекс (FCI) болно.

Хэдийгээр КАВС-II нь шалгагчид Луриа эсвэл СНС-ын аль дуртай загвараа сонгох боломжийг олгодог ч шалгагч нар бага насны болон өсвөр насны хүүхдийг

шалгаж эхлэхээсээ өмнө алийг нь ашиглахаа сонгосон байхыг шаарддаг. Ийнхүү сонголт хийх талаарх зааварчилгааг дараагийн бүлгүүдэд өгүүлэх болно.
 Диаграмм 1.1 КАВС-II-ын хэмжээсийн хос онолын суурь ба дэлхийн жишиг хэмжээс

Луриагийн загвар	СНС загвар	КАВС-II-ын хэмжээсийн нэр
<ul style="list-style-type: none"> • дараалсан • байнгын явц • сурах чадвар • төлөвлөх чадвар 	<ul style="list-style-type: none"> • богино хугацааны санах ой (Gsm) • харах явц (Gv) • үрт хугацааны хадгалалт ба сэргээлт (Glr) • шингэн шалтгаалах нь (Gf) • Кристалл тогтонги оюун ухаан чадвар (Gc) 	<ul style="list-style-type: none"> • дараалсан/GSm • Байнгын /Gv • сурах / Glr • төлөвлөх / Gf • мэдлэг / Gc
КАВС-II-ын дэлхийн жишиг хэмжээсийн нэр	Сэтгэхүйн үйл явцын индекс (MPI)	Хөдлөнги оюун ухааны индекс (FCI)

Хавсралт 3

Нэр томъёоны тайлбар

Crystalized Ability - кристалл чадвар, тогтонги оюун ухаан

Fluid- Crystallized index - хөдлөнги оюун ухааны индекс

Тайлбар

Сэтгэл зүйч Р. Кэттелийн оюун ухааны онолоор оюун ухааныг **хөдлөнги** оюун ухаан, **кристалл** –тогтонги оюун ухаан гэж 2 хуваадаг.

Хөдлөнги оюун ухаан нь гүйцэтгэх үйлд хамаардаг.

Харин Тогтонги **Кристалл оюун ухаан** нь хуримтлуулсан мэдлэгийн гүн гүнзгий байдал, хэмжээ, үгийн нөөцөөр тодорхойлогддог, энэ оюун ухаан нь өтөл нас эхэлтэл үргэлжилж байдаг.

Кристалл оюун ухаан нь хөдлөнги оюун ухааны " кристалл " хэлбэр биш- энэ бол ялгаатай өөр өөр үйл ажиллагаа.

Кристалл оюун ухаан нь хөдлөнги оюун ухааны түвшнээс шалтгаалдаг учир нь хөдлөнги оюун ухаан өндөр хүн хурдан сурдаг, тэр хэмжээгээр хурдан туршлага буюу кристалл оюун ухаан хуримтлуулж, улмаар үүнийг нь IQ тест баталж өгдөг.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ СУРАГЧДЫН ИХ ДЭЭД СУРГУУЛЬД СУРАЛЦАХ СОНИРХОЛ, НӨЛӨӨЛӨХ ЗАРИМ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН СУДАЛГАА

Г. Энхжин
Б. Гүнсэнхорол

Хураангуй

Өндөр хөгжилтэй орнуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэд дээд боловсрол эзэмших боломжтой ч тулгарч буй асуудлууд байсаар байна. Харин хөгжиж буй орнуудад энэ нь одоо л яригдаж эхэлж буй сэдэв юм. 2019-2020 оны хичээлийн жилд нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 25.6% нь их дээд сургуульд хамрагдсан байна. Энэ нь тэгш хамрагдан суралцах бодлого нь их дээд боловсролын хувьд үл хэрэгжиж байгааг харуулж байна. Тиймээс бид энэхүү судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн их дээд сургуульд суралцах сонирхолд нөлөөлж буй зарим хүчин зүйлсийг тодорхойлох зорилгоор хийв.

Энэхүү судалгааг зорилтот бүлгээс буюу тусгай хэрэгцээт сургуульд суралцагч 40-н сурагчаас тусгайлан бэлдсэн 2 бүлэг 6 асуултын дагуу авж дескриптив статистикийг тоон хувьсагчийн хувьд дундаж, стандарт хазайлтаар тооцсон, категори хувьсагчийг давтамж, хувиар илэрхийлсэн. Категори хувьсагчдын ялгааг пирсоны хи квадрат тест, хоёр бүлгийн дунджийн ялгааг үл хамааралт хоёр бүлгийн сдеюдент Т тестээр үнэлэв.

Судалгааны үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын сурах сонирхолд их дээд сургуулийн сургалтын хөтөлбөр, оюутнуудын хандлага хүрээлэл, багш нарын хандлага ур чадвар нөлөөлж байсан. Их дээд сургуульд сурах сонирхолд одоо суралцаж буй сургуулиудын боловсон хүчин, суралцах орчин, тусгай хэрэгцээт ном сурах бичгийн хүрэлцээ гэх мэт хүчин зүйлс нөлөөлж байна. Мөн нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 57.5% нь их дээд сургуулиудыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан тохижуулсан нь суралцахад тохиромжтой гэж үзжээ.

Түлхүүр үг: хөгжлийн бэрхшээлтэй суралцагч, суралцах сонирхол, нөлөөлөгч хүчин зүйл, боловсрол

Үндэслэл

Дэлхий даяар нийт хүн амын 15% нь хөгжлийн бэрхшээлтэй, 2 - 4% нь бие даан амьдрах чадваргүй байна (World bank, 2020). Дэлхий дахинд 2018-2019 онд 3-21 насны 7.9 сая хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд боловсролын үйлчилгээнд хамрагдсан нь нийт суралцагчдын 14%-ийг эзэлж байна. (National Center for Education Statistic, 2020)

Манай улсад 2019 оны дүнгээр 107075 хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа нь хүн амын 3.2%-ийг эзэлж байна. (NSO, 2020) 2019-2020 оны хичээлийн жилд тусгай хэрэгцээт дунд сургуулийг 312 суралцагч төгссөн, үүнээс 2020 оны байдлаар 80 суралцагч их дээд сургуульд магистр болон баклаварын зэргээр

суралцаж байгаа нь төгсөгчдийн 25.6% нь их дээд сургуульд элсэн суралцсаныг харуулж байна. (БСШУЯ, 2020)

Гэрэлтуяа, Цэвэгмид нарын “Тэгш хамруулан сургах боловсролын бодлого, хэрэгжилт” судалгааны дүнгээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хандах сургууль, багш, сурагчид олон нийтийн хандлага өөрчлөгдөж, ялгаварлан гадуурхахгүй энгийн сургуульд үе тэнгийн найз нөхөдтэйгээ хамт сурахыг хүлээн зөвшөөрч дэмждэг болсон гэж үзсэн боловч их дээд сургуульд суралцах боломжийг тодорхой тусгаагүй байна. (Б. Гэрэлтуяа Ц.Цэвэгмид, 2019). Лаундан Ароны судалгаагаар улсаас тусгай хэрэгцээт суралцагчдын суралцах үйл явцыг дэмжин, бусад хүүхдүүдтэй адил суралцах нөхцөл бололцоог хангах хэрэгтэй, их сургуулиуд тусгай хэрэгцээт суралцагчдад зориулан хөтөлбөр боловсруулах нь нэн чухал гэж үзжээ. (Laudan Aron and Pamela Loprest , 2012)

АНУ-ын Пенн мужийн их сургууль, Өмнөд Каролинагийн их сургууль, Юта мужийн их сургууль их сургуулиудын судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын их дээд сургууль хамрагдалтын тоо өмнөх үеүдтэй харьцуулбал нэмэгдсэн ч сурлагын амжилт чанарын хувьд бусад суралцагчтай харьцуулахад бага гарчээ. Тиймээс тусгай хэрэгцээт суралцагчдын бие даан суралцах чадварыг багаас нь хөгжүүлэх шаардлагатай байна. (Allison R. Fleming, 2017) Доктор Камал Ламичаннийн Непал, Филиппин улсад хийсэн судалгаанаас харахад хөгжлийн бэрхшээлтэй иргэд олон жил суралцах тусам байнгын эсвэл удирдах албан тушаалын ажил эрхлэх хандлагатай байсан. Гэсэн хэдий ч бие махбодийн бэрхшээлтэй хүмүүс нь хараа болон сонсголын бэрхшээлтэй хүмүүстэй харьцуулахад ажилд орох нь бага байгааг ажигласан. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэд хөдөлмөр эрхлэхэд боловсролоос гадна ажиллах газрын хандлага, хөдөлмөр эрхлэх боломжийг хангаж өгсөн байдал нөлөөлж байна гэж үзжээ. (Lamichhane, 2015) Непал улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролд тулгамдаж буй асуудал судалгаанаас харахад сургуулийн хүртээмж бага, багш ажиллах хүчин хомс, хөтөлбөрийн хувьд асуудалтай, мөн хараагүй иргэдэд зориулсан бариед үсэгтэй ном сурах бичиг хангалтгүй гэх зэрэг зарим хүчин зүйлийг дурдсан. Мөн хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад сурахад нөлөөлөх гол хүчин зүйл бол гэр бүлийн дэмжлэг, тусламж хэмээн дүгнэжээ. (Lamichhane, Disability and Barriers to Education, 2015) Анне М. Хоккутийн суралцагч нарын сурлагын амжилт ба түүнд нөлөөлөгч зарим хүчин зүйлс дээр

хийсэн судалгааны үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын сурлагын амжилтад сурах хөтөлбөр, орчин нөхцөл гэх мэт хүчин зүйлс нь нөлөөлөлгүй гарсан. Хөгжлийн бэрхшээлтэй сурагчийн сурлагын амжилтанд тухайн суралцагчийн хичээл зүтгэл, хичээлээ хэр удаан давтгаг зэрэг хүчин зүйлс нь нөлөөлж байна гэж үзсэн. (Ph.d, 1996)

Манай улсад хийгдсэн хараа сонсгол хэл ярианы бэрхшээлтэй иргэдэд үзүүлж буй нийгмийн үйлчилгээ болон түүний орчны хүртээмжийг үнэлэх судалгааны үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд гол үйлчилгээ үзүүлдэг төрийн яамд, дүүрэг, нийгмийн даатгал хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсүүд, эрүүл мэнд, боловсролын салбарын байгууллагууд орчны хүртээмжгүй цаашид сайжруулах арга хэмжээ авах шаардлагатай гэж үзжээ. Монгол улсын 21 аймгийн 9 дүүргээс асуумж судалгаа авч нийгмийн хамгааллын салбарт хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй ажиллах боловсон хүчний хэрэгцээг тодорхойлоход хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажиллаж буй хүмүүсийн хувьд энэ талаарх тодорхой мэргэшээгүй нийгмийн ажилтнууд энэ ажлыг хийж байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй харилцах мэргэжилтэн бэлдэх шаардлагыг харахад 94% нь шаардлагатай гэж үзжээ. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 88% нь боломж олдвол тусгай мэргэжил эзэмшихэд бэлэн байна. (Ц. Болормаа Б. Хурцэцэг Ц.Хашчулуун, 2014) Тиймээс бид хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын их дээд суралцах сонирхол, түүнд нөлөөлөх зарим хүчин зүйлсийг тодорхойлохыг зорилгоо.

Судалгааны зорилт

1. Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын их дээд сургуульд суралцах сонирхолын түвшинг тодорхойлох
2. Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын их дээд сургуульд суралцах сонирхолд сургуулийн орчин, дэмжлэг болон бусад хүчин зүйлийн нөлөөллийг үнэлэх

Судалгааны таамаглал

1. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын 80% нь их дээд сургуульд суралцах сонирхолтой байна
2. Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын суралцах сонирхол зарим хүчин зүйлс хооронд ач холбогдол бүхий хамааралтай байна.

Судалгааны Арга Зүй

Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын их дээд сургуульд суралцах сонирхол, түүнд нөлөөлөх зарим хүчин зүйлсийн хамаарлыг судлахдаа аналитик судалгааны загвараар 2020.10 – 11 сарын хооронд тусгай хэрэгцээт сургуулиудыг түшиглэн явуулна. Судалгааны түүвэр хүн амыг зорилтод түүврийн аргаар судалгаанд оруулах ба хасах шалгуурыг баримталж бүрдүүлнэ. Судалгаанд сургуульд тогтвортой суралцаж буй хөгжлийн бэрхшээл тогтоогдсон, 10 – 12-р ангийн сурагчдыг хамруулна. Түүвэрт тусгай хэрэгцээт 116, 29, 63-р сургуулийн дунд болон ахлах ангийн сурагчдаас хараа, сонсгол, оюун ухааны бэрхшээлтэй тусгай хэрэгцээт суралцагчдыг хамруулсан. Судалгааны мэдээ материалыг асуумжийн аргаар цуглуулсан. Асуумжийн хуудас нь 2 бүлэг 6 тооны асуулттай. Судалгааны асуумжийн нэгдүгээр бүлэгт хамааран хувьсагч болох их сургуульд суралцах сонирхлыг судалгаанд оролцогчоор тодорхойлуулсан. Асуумжийн хоёрдугаар хэсэгт үл хамаарах хувьсагч буюу нөлөөлөх хүчин зүйлсийг тодруулсан. Тухайлбал, сургалтын хөтөлбөр, багшийн ур чадвар, суралцах орчин нөхцөлийг хангасан байдал, оюутнуудын хандлага хүрээлэл зэрэг нөлөөлөх хүчин зүйлсийг хэмжсэн. Судалгааны үр дүнг IBM SPSS 26.0 програмыг ашиглан статистик боловсруулалт хийсэн. Дескриптив статистикийг тоон хувьсагчийн хувьд дундаж, стандарт хазайлтаар тооцсон, категори хувьсагчийнг давтамж, хувиар илэрхийлсэн. Категори хувьсагчдын ялгааг пирсоны хи квадрат тест, хоёр бүлгийн дунджийн ялгааг үл хамааралт хоёр бүлгийн сдюдент Т тестээр үнэлсэн. Р утга 0.05-аас бага тохиолдолд статистик ач холбогдол бүхий ялгаатай байна.

Судалгааны Ажлын Үр Дүн

Судалгаанд хөгжлийн бэрхшээл оношлогдсон 13 – 20 насны 40 суралцагчийг хамруулсан. Судалгаанд оролцогчдын дундаж нас 15.7 ± 1.62 , 67.5 хувь нь эрэгтэй, сурагчдын 60 хувь их дээд суралцах сонирхолгүй байна. Их дээд сургуульд суралцах сонирхол нас хүйсээр статистик ач холбогдол бүхий ялгаагүй байна.

Хүснэгт 1 Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн мэдээлэл

	Их дээд сургуульд суралцах сонирхол						
	Тийм		Үгүй		р утга	Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь		Тоо	Хувь
Хүйс					0.53		

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Эрэгтэй	12	75.0	15	62.5		27	67.5
Эмэгтэй	4	25.0	9	37.5		13	32.5
Нас	15.81	1.83	15.67	1.49	0.78	15.73	1.62

Сурагчдын их дээд сургуульд суралцах сонирхол нь их дээд сургуулийн сургалтын хөтөлбөр, багшийн ур чадвар ба хандлага хүрээлэл статистик ач холбогдол бүхий ялгаатай байна ($p = 0.035$, $p = 0.048$, $p = 0.05$). Тухайлбал, их дээд суралцах сонирхолгүй сурагчдын 78.9 хувь нь сургалтын хөтөлбөр чухал гэж үзсэн буюу сургалтын хөтөлбөрийн чанар хангалтгүй учир их дээд сургуульд суралцах сонирхолгүй байна.

Хүснэгт 2 Сурагчдын их дээд сургуульд суралцах сонирхол ба зарим нөлөөлөх хүчин зүйл

Үзүүлэлт	Их дээд сургуульд суралцах сонирхол						
	Тийм		Үгүй		p утга	Нийт	
	тоо	хувь	тоо	хувь		тоо	хувь
Сургалтын хөтөлбөр чухал							
Үгүй	5	35.7	4	21.1	0.035*	9	27.3
Тийм	9	64.3	15	78.9		24	72.7
Орчин, Нөхцөл							
Үгүй	3	23.1	3	15.8	0.060	6	18.8
Тийм	10	76.9	16	84.2		26	81.3
Оюутнуудын хандлага, хүрээлэх							
Үгүй	3	21.4	3	13.6	0.050*	6	16.7
Тийм	11	78.6	19	86.4		30	83.3
Багшийн ур чадвар							
Үгүй	2	14.3	3	16.7	0.048*	5	15.6
Тийм	12	85.7	15	83.3		27	84.4

Сурагчдын их дээд сургуульд суралцах сонирхолд суралцаж буй сургуулийн боловсон хүчин хүрэлцээгүй, суралцах орчин, ном сурах бичгийн хангалтгүй байдал нь статистик ач холбогдол бүхий нөлөө үзүүлдэг байна. Жишээлбэл, их дээд сургууль суралцах сонирхол бага бүлгийн оролцогчдын 87.5 хувь нь одоо сурч буй сургуулийн боловсон хүчин хүрэлцээгүй, 95.8 хувьд суралцах орчинг бүрдүүлж өгөөгүй байна

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Хүснэгт 3 Сурагчдын их дээд сургуульд суралцах сонирхол ба сургуулийн орчин

Үзүүлэлт	Их дээд сургуульд суралцах сонирхол				p утга	Нийт	
	Тийм		Үгүй			Тоо	Хувь
	Тоо	Хувь	Тоо	Хувь			
Боловсон хүчин хүрэлцээгүй эсэх							
Тийм	10	62.5	21	87.5	0.046*	31	77.5
Үгүй	6	37.5	3	12.5		9	22.5
Суралцах орчинг бүрдүүлж өгөөгүй							
Тийм	11	68.8	23	95.8	0.016*	34	85.0
Үгүй	5	31.3	1	4.2		6	15.0
Тусгай хэрэгцээт ном сурах бичиг хангалтгүй							
Тийм	12	75.0	13	54.2	0.048*	25	62.5
Үгүй	4	25.0	11	45.8		15	37.5
Тохирох шалгалтын системгүй							
Тийм	8	50.0	16	66.7	0.047*	24	60.0
Үгүй	8	50.0	8	33.3		16	40.0

Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын 57.5 хувь нь их дээд сургуулиудын тусгай хэрэгцээт оюутнуудад зориулсан орчинг сайжруулснаар сурагчдын сонирхлыг дэмжих боломжтой гэж үзэж байна.

Хүснэгт 4. Сурагчдын их дээд сургуульд суралцах сонирхол ба шийдвэрлэх аргачлал

Үзүүлэлт	Их дээд сургуульд суралцах сонирхол				p утга	Нийт	
	Тийм		Үгүй			Тоо	Хувь
	Тоо	Хувь	Тоо	Хувь			
Шийдвэрлэх арга						0.89	
Их дээд сургууль байгуулах	7	43.8	10	41.7		17	42.5
Орчин бүрдүүлэх	9	56.3	14	58.3		23	57.5

Судалгаанд оролцсон сурагчдын их дээд сургуульд суралцах сонирхолгүй байх эрсдлийг боловсон хүчний хэрэгцээгүй байдал 4.2, суралцах орчинг бүрдүүлж өгөөгүй байх нь 10.5, тусгай хэрэгцээт ном сурах бичиг өгөөгүй байх нь 2.5, тохирох үнэлгээний системгүй байх нь 2.0 дахин нэмэгдүүлж байна.

Хүснэгт 5 Сурагчдын их дээд сургуульд суралцах сонирхолд нөлөөлөх зарим хүчин зүйлийн эрсдэлийн үнэлгээ

Үзүүлэлт	OR	95 % ИИ		P утга
		Доод	Дээд	
Боловсон хүчин хүрэлцээгүй эсэх				
Тийм	4.2	1.2	10.1	0.12
Үгүй	1			
Суралцах орчинг бүрдүүлж өгөөгүй				
Тийм	10.5	1.04	50.5	0.04
Үгүй	1			
Тусгай хэрэгцээт ном сурах бичиг хангалтгүй				
Тийм	2.5	1.3	10.5	0.18
Үгүй	1			
Тохирох шалгалтын системгүй				
Тийм	2.5	0.53	7.3	0.29
Үгүй	1			

Дүгнэлт

Урьд өмнө хийгдэж байсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгаануудаас харахад манай улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй орчин, нөхцөл байхгүй гэж үзсэн. Тиймдээ ч бид хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын их дээд сургууль сурах сонирхолд нөлөөлөгч зарим хүчин зүйлсийг сонгон авч судалгаа авахад дараах үр дүнгүүд гарч байна:

Сурагчдын их дээд сургуульд сурах сонирхолд нь нас болон хүйс нь статистик ач холбогдолгүй буюу хамааралгүй гарч байна. Сурагчдын их дээд сургуульд суралцах сонирхолд их дээд сургуулийн сургалтын хөтөлбөр, оюутнуудын хандлага хүрээлэл, багшийн ур чадвар нөлөөлж байна гэж гарсан. Өөрөөр хэлбэл их дээд сургуульд сурах сонирхолгүй сурагчдын 78.9% нь сургалтын хөтөлбөр хангалтгүй улмаас, 86.4% нь оюутнуудын хандлага хүрээллээс болж их дээд сургуульд сурах сонирхолгүй байна гэж үзлээ.

Мөн сурагчдын их дээд сургуульд суралцах сонирхолд одоо сурч буй сургуулийн боловсон хүч хүрэлцээгүй, ном сурах бичиг хангалтгүй, суралцах орчин нөхцөл, тохирсон шалгалтын системийг бүрдүүлж өгөөгүй байдал нь нөлөөлж байгаа нь судалгаагаар дэмжигдсэн. Судалгаанд хамрагдсан сурагчдын 57.5% нь их дээд

сургуулийг тохижуулж өгсөн нь илүү суралцахад тохиромжтой гэж үзжээ. Их дээд сургуулиудын суралцах орчин тохижуулж өгөөгүй байдал нь суралцагчдын сурах сонирхлыг 10.5, боловсон хүчин хүрэлцээгүй байдал 4.2 дахин бууруулж байна.

Ном Зүй

1. Allison R. Fleming, A. J. (2017). *College Students with Disabilities: The Relationship Between Student Characteristics, the Academic Environment, and Performance. Postsecondary Education and Disability*, 13.
2. Lamichhane, D. K. (2015). *Disability and Barriers to Education. Disability, Education and Employment in Developing Countries* , 212-245.
3. Lamichhane, D. K. (2015). *Disability and the Role of Education in Jobs: Case Studies from Nepal and the Philippines. Disability, Education and Employment in Developing Countries* , 38-66.
4. Laudan Aron and Pamela Loprest . (2012). *Disability and the Education System. The Future of Children*, 97-122.
5. National Center for Education Statistic. (2020, May). Retrieved from National Center for Education Statistic:
https://nces.ed.gov/programs/coe/indicator_cgg.asp#:~:text=In%202018%E2%80%93319%2C%20the%20number,percent%20had%20specific%20learning%20disabilities.
6. NSO. (2020, 1 30). Retrieved from 1212.mn:
https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NS0_3900_004V1
7. Ph.d, A. M. (1996). *Effectiveness of Special Education: Is Placement the Critical Factor? The Future of Children*, 77-102.
8. World bank. (2020, october 01). Retrieved from worldbank.org:
<https://www.worldbank.org/en/topic/disability#:~:text=Results-,One%20billion%20people%2C%20or%2015%25%20of%20the%20world's%20population%2C,million%20people%2C%20experience%20significant%20disabilities.>
9. Б.Гэрэлтуяа Ц.Цэвэгмид. (2019). *Тэгш хамруулан сургах боловсролын бодлого, хэрэгжилт. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дээд боловсрол олгох болон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажиллах боловсон хүчнийг бэлтгэх талаар туршлага солилцох олон улсын зөвлөгөөн* (р. 4). Улаанбаатар: МҮИС.
10. Батдулам О.Мөнхтуул Ц.Мөнхнасан . (2019). *Хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэдэд үзүүлж буй нийгмийн үйлчилгээ болон түүний орчны хүртээмжийг үнэлэх*. 23-33.
11. БСШУЯ. (2020, 9 29). Retrieved from <https://www.meds.gov.mn/>:
<https://www.meds.gov.mn/?cat=197>
12. Ц.Болормаа Б.Хурцэцэг Ц.Хашчулуун. (2014). *Нийгмийн хамгааллын салбарт хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй ажиллаж буй боловсон хүчний хэрэгцээг тодорхойлох*. 38-45.

ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ҮГ ЯРИА- УТГЫН ОЙН ХӨГЖЛИЙН СУДАЛГАА

Илтгэгчийн нэр, хаяг: Дорж овогтой Хорлоо¹

¹Тэгш эрх тэгш боломж төрийн бус байгууллагын Тэргүүн, ахмад багш

Хураангуй

- 1960-д онд Жан Пиажэ /1896- 1980/ хүүхэд 7-11 насандаа тодорхой үйлдлийн шат эхлэх үед оюун ухааны хөгжилд гурван чиглэлээр өөрчлөлт гардаг гэж үзжээ. Үүнд:
 - Юмсын тогтвортой байдлыг хадгалах чанарыг олж мэдэх.
 - Ангилан бүлэглэх чадвар хөгжих.
 - Ургуулан шилжүүлэх төсөөлөл хөгжих үе
 Үүний үндсэн дээр “Хүний хөгжил боловсролтой салшгүй холбоотой” гэх дүгнэлтэд хүрчээ. Үүний учир би удиртгал хэсэгт зорилтот бүлгийн хүүхдийн боловсролд хамрагдалтын тоог түүврийн аргаар товчлон орууллаа.
- Ой тогтоолтыг зориудын ба зориудын бус гэж ангилахаас гадна хэлбэрийн хувьд дүрслэх ой, үг яриа утгын ой гэж авч үздэг. Үг яриа, утгын ойд дохионы систем чухал үүрэгтэй байдаг бөгөөд энэ төрлийн ой тогтоолт амьтанд байдаггүй. Харааны бэрхшээлтэй сурагчдын ойн хөгжлийн төвшинг Боловсролын Хүрээлэнгээс гаргасан аргачлалын дагуу явуулсан учир нь сургуульд хамрагдсаны дараа хүүхэд хэрхэн хөгждөг, ямар үр дүн үзүүлдэг вэ? гэсэн сонирхлын дагуу судалгааг хийсэн билээ.

Түлхүүр үг: хүүхэд судлал, танин мэдэхүйн хөгжил, үнэн зөв мэдээлэл, дүгнэлт бодитой байх

Удиртгал

Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдийн хөгжлийг тодорхойлоход шинжлэх ухааны үндэстэй судалгаа зайлшгүй хэрэгтэй билээ. Олон улсын болон төрийн бус байгууллагууд өөрсдийн төсөл хөтөлбөрийн хүрээнд төрөл бүрийн судалгаа хийж ирсэн байдаг. Ер нь хөгжлийн бэрхшээлтэй хүн амын тоо, түүний дотор харааны бэрхшээлтэй хүүхдийн тоо баримтыг тодруулах зорилгоор 2010, 2020 оны хүн ам, орон сууцны улсын тооллогын дүн мэдээнээс түүвэрлэн тоо баримтыг цуглуулсан болно. Энэ тоо баримтаас хэд хэдэн зүйлийг ажигласан нь 2020 онд харааны бэрхшээлтэй хүүхдийн тоо 1666-р цөөн гарсан бөгөөд шинээр үйлдлийн чадвар алдалтыг тодорхойлжээ.

Түүврийг хүснэгтээр №1-ээр үзүүлэхэд

№	Хөгжлийн бэрхшээлтэй хүн ам					
	2010 он	Тоо	хувиар	2020 он	Тоо	Хувиар
1.	Хөгжлийн бэрхшээл	108171	-----	Хөгжлийн бэрхшээл	106363	Суурин хүн амын 3.3%
Үүнээс						

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

2.	харааны бэрхшээл	16161	15.4%		харааны бэрхшээл	12762	12% /3.1/	
3.	хүйс, нас	тоо	эр	эм	нас	тоо	эр	эм
	0-4	366	179	187	0-4	104	61	43
4.	5-9	601	301	300	5-9	368	193	175
5.	10-14	905	471	434	10-14	407	231	176
6.	15-19	1100	585	515	15-19	427	255	172
7.	Нийт	2972	1536	1436	Нийт	1306	740	566

Тайлбар: Харааны бэрхшээлийн эзлэх хувийг хөгжлийн бэрхшээлтэй нийт хүн амтай харьцуулан тооцжээ. (ҮСХ-2010, 2020 хуудас 23,67)

Монгол Улсын нийт 10, түүнээс дээш насны хүн амын 92.5% нь ямар нэг төвшний боловсрол эзэмшсэн байхад хөгжлийн бэрхшээлтэй 10, түүнээс дээш насны боловсролтой хүн амын хувь түүнээс 14.5 пунктээр бага, боловсролын төвшинг аваад үзэхэд бүрэн дунд боловсрол эзэмшсэн хүн амын тоо өндөр буюу 30 орчим хувь байв. Харааны бэрхшээлтэй 3087-19.1% нь бүрэн дунд боловсролтой, 10301 буюу 63.7% нь бүрэн дундаас дээш боловсролтой, 1682- 10.4% нь бичиг үсэг мэддэг, 1091–6.8% бичиг үсэг мэддэггүй².

(Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэм, эдийн засгийн шинж байдал ҮСХ -2010 оны тайлангаас²)

2020 оны тооллогоор

Нийт үйлдлийн чадварын хүндрэлтэй хүмүүсийн 15.5 хувь нь боловсролгүй, 84.5 хувь нь ямар нэгэн түвшний боловсролтой байна. Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүмүүсийг боловсролын түвшнээр харвал 25.0 хувь нь бүрэн дунд, 14.7 хувь нь суурь, 10.7 хувь нь бага боловсролтой байгаа нь хамгийн өндөр хувь байна. Хүндрэлийн давхардлаар авч үзвэл 5 болон 6 хүндрэлтэй хүмүүсийн хувьд бага боловсрол өндөр хувийг эзэлж байна. Үйлдлийн хүндрэлийг 18-с дээш насанд НҮБ-ын Вашингтон бүлгийн аргачлалаар богино багц асуултаар тодруулдаг. Богино багц асуулга нь харах, сонсох, алхах, өөртөө анхаарал тавих, харилцах, ой тогтоолт/санах/ гэсэн 6 багц үйл ажиллагааны хүндрэлийг тодорхойлжээ.

Боловсролын хувьд онцлох зүйл нь хот, хөдөөгийн оршин суугчдын хувьд ялгаа ажиглагдаж байна. Хотын бичиг үсэг мэддэггүй хүн амын эзлэх хувь 0.7 хувь байхад хөдөөгийнх 2.4 хувь буюу 1.7 пунктээр зөрүүтэй байна. Энэ үзүүлэлтэд оюун ухааны бэрхшээлийн улмаас бичиг үсэг сурах боломжгүй хүн байгааг харгалзан үзэх учиртай.

Хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй иргэд 33.9 хувь буюу 36106 хүн байна. (2020 он. Улсын тооллого. 8-р бүлэг-125-р хуудас³)

Судалгааны зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролд хамрагдалтын тоонд түүвэр хийх, хүүхдийн үг яриа, утгын ойн хөгжлийг илрүүлэх зорилготой явуулсан судалгааны үр дүнг таниулахад энэхүү судалгааны зорилго оршино. **Судалгааны зорилт**

- Түүвэр судалгаа хийх материалтай танилцах, тоон судалгаанаас түүвэр хийх
- Хийгдсэн судалгаанд анализ хийж, шинэчлэх
- Эрдэм шинжилгээний хурлын удирдамжид тохируулан илтгэлээ бэлтгэх

Шинэлэг байдал

Энэ судалгааг үг яриа утгын ойд тулгуурлан явуулсныг хэрэгцээт хүмүүст нь таниулахаар зорьсон бөгөөд боловсролын чиглэлийг сонгож, бичиж байгаа учир нь харааны бэрхшээлтэй суралцагсад хичээл сургалтад хамрагдах үедээ хэрхэн хөгжих боломжтойг илрүүлэх зорилгоор энэхүү судалгааг шинэчлэн хийж, танилцуулж байна. *Туршилт судалгаатай холбогдуулан ой тогтоолтын тухай товч өгүүлье.*

Хүртэж хүлээн авсан зүйлээ тогтоон хадгалж, сэргээн санах процессыг ой гэнэ. Хүн өсөж хөгжихдөө жилээс жилд улам ихийг үзэж, мэдэж, түүнийгээ ой ухаандаа тогтоож, хадгалах хэрэгтэй болдог. И.М. Сеченов: “Хэрэв хүнд ой гэдэг гайхам сонин үзэгдэл байгаагүй бол нярай хүүхдийн байдалд мөнхөд байх болно гэж хэлжээ. Тогтоогдож байгаа зүйл ойлгогдсоны үндсэн дээр утгачилсан ой тогтоолт явагдана. Ой тогтоолт бол нөхцөлт рефлекс бөгөөд ой тогтоолтын физиологи үндсийг И.П.Павлов анх тайлбарласан бөгөөд ойн физиологи үндэс нь урьд өмнө хүртэж мэдэрсэн зүйлийг тогтоох, сэргээн санах, мартаж зэрэг олон үзэгдлийн нууцыг шинжлэх ухааны үндэстэй тайлах нөхцөлийг бүрдүүлжээ⁴. Ой ухаан нь сэтгэцийн бүх үйл ажиллагааны үндсэн нөхцөл бөгөөд хөгжүүлэх олон арга байдаг билээ. (Сэтгэл зүйн зугаатай өгүүллүүд” Ч.Түмэндэлгэр, Л.Уранцэцэг⁴)

Өөрийн зүгээс 1995, 2012 онд хараагүй, сул хараатай сурагчдын дунд үг яриа- утгын ойн туршилт судалгааг явуулж, үр дүнг тооцсон. Сул хараатай, хараагүй, үлдэгдэл хараатай 2-9-р ангийн сурагчдын дунд 5 цуврал туршилтын I, II цувралыг амаар

уламжлан, III, IV, V цувралыг тэмдэгт хэрэгслийн тусламжтай явуулсан. Энэхүү илтгэлд товчлоод I, IV, V цувралыг танилцуулж байна.

Туршилт судалгааны хэрэглэгдэхүүн, арга зүй, математик боловсруулалт

Судалгааны материалыг дараах аргаар математик боловсруулалт хийж, үнэнд ойртож байгаа эсэхийг нягтлан үзсэн. Судалгаанд хамрагдсан хүүхэд нэг бүрийн зөв тогтоож, сэргээн санасан элементүүдийн (үг, дүрс, зураг) нийлбэр болгон хүүхдийн тооны харьцаагаар арифметикийн дунджийг бодож гаргалаа.

Σ - нийлбэр

X_i - хүүхэд нэг бүрийн зөв тогтоосон элементийн (үг, дүрс, зураг) тоо.

X- арифметикийн дундаж,

n- хүүхдийн тоо


(I цуврал туршилт)

Хүүхдүүд хоорондоо утгын холбоотой 10 үгийг сонсголоороо ойлгож, тогтоох даалгавар гүйцэтгүүлсэн. Тухайн даалгавар нь амаар уламжлан, утгачлан тогтоох зорилготой байсан. Харааны бэрхшээлтэй 9-17 насны сурагчдын I цуврал туршилтын хүснэгт ба графикаас ажиглахад хүүхдийн нас ахих тусам алдааны тоо багасч, математик дундаж өндөр байлаа. Тухайлбал: 14-17 насныхныг нэрлэж болно. 11 насны 4 сурагчаас 3 сурагч нь брайлиар унших бичих чадвар нилээн доогуур дүнтэй, ар гэрээс нь туслах боломж бага, бүгд дотуур байранд амьдардаг, амьдралын боломжоосоо шалтгаалж сургуулиас 1-2 жил завсардсан хүүхдүүд байлаа. Энэ нь сургалтын явцад ажиглагдсан. Утгын холбоотой үгийг сонгохдоо ихэвчлэн бодит зүйлийн нэрийг сонгосон боловч зүүд-нойр, дуулах-сонсох гэсэн 2 холбоо үгийг сонгож оруулсан нь эдгээр үгийн утгыг хэрхэн хүлээж авахыг ажиглах зорилготой байв. Судалгааны дүнгээс үзэхэд сурагчдын 38% нь (худаг-ховоо) холбоо үгийг, 17% нь хийсвэр утгатай үгийг тус тус сэргээн санахад хэцүү байжээ. Энэ нь сурагчдын үгийн нөөцтэй холбоотойгоос гадна нийгмийн дунд оролцох боломжоос шалтгаалсан байх үндэстэй. Сурагчдын хэрэгцээ болоогүй, тэднээс хөндий байдаг зарим үгийг тухайлбал: зураг-будаг холбоо үгийг “зураг-хөгжим” гэсэн холбоогоор өөрсдийн амьдралтай ойролцоо үгээр, худаг-ховоо гэсэн холбоо үгийг худаг-ус гэж сэргээн санах.

Хүснэгт № 2

	Нас	Математик дундаж	Квадрат хазайлт	Дундаж алдаа
1.	9 нас	7.3	1.2	-
2.	10 нас	8.2	1.4	0.6
3.	11 нас	7.5	1.5	1.1
4.	12 нас	6.3	0.8	0.5
5.	13 нас	7.1	0.5	0.4
6.	14 нас	7.5	0.8	0.4
7.	15 нас	5.2	0.8	0.4
8.	16 нас	9.5	0.5	0.3
9.	17 нас	8.8	0.8	0.4

Диаграмм № 1



(IV цуврал туршилт)

Энэ цуврал сорилд иж бүрдэл зургуудыг хэд хэдэн ерөнхий нэрэнд багтааж, хэсгүүдэд ангилж тогтоох даалгаврыг өгсөн. Бүлэглэн ангилах ба эмхлэн цэгцлэх сэтгэхүйн үйлдэл хийгдэх ёстой байв. Эд юмсын онцгой, ерөнхий шинж холбоо хамаарлыг тогтоох, тухайн зурагт хамаарагдаж болох бүх зүйлийн тухай урьд өмнө бий болсон ойлголт төсөөлөл ойд сэргээгдэнэ. Ямар нэг юмс үзэгдлийг гол ерөнхий шинжээр нь төрөл, зүйл, ангид хамааруулах сэтгэхүйн үйлдлийг бүлэглэн ангилах үйлдэл гэнэ. Жишээ нь: үзэг-хичээлийн хэрэглэл, онгоц-тээврийн хэрэгсэл гэх мэт. Судалгаанд 5 бүлэгт ангилж болохуйц 17 зураг, аль ч бүлэгт орохгүй нэг зураг, бүгд 18 зургийг ашигласан.

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

- а. Хувцас-малгай, цамц, дээл, оймс, бээлий
- б. Хичээлийн хэрэглэл-ном, үзэг
- в.Тээврийн хэрэгсэл- машин, онгоц, морин тэрэг
- г. Хүнсний ногоо- лууван, сонгино, байцаа
- д. Амьтан- туулай, баавгай, үнэг, гахай
- е. Байшин


IV цуврал судалгаанд боловсруулсан арга зүйн дагуу 5 ангилалд дүгнэж үзэхэд дараах үнэлгээ харагдаж байна. Дунд ангийн сурагчид (6-8 дугаар анги) даалгаврыг нэг минутын хугацаанд гүйцэтгэхээр өгөв. 1-5 ангийнханд хугацаа харгалзахгүй байхаар даалгаврыг өгөв. Судалгааны явцаас ажиглахад 6 хүүхэд ангиллаа хийгээгүй. 8-9 үгийг 4 хүүхэд тогтоож сэргээн санасан боловч тодорхой дэс дараатай хэлж чадаагүй. Цуврал сорилд оролцсон сурагчдын үр дүнгийнх нь дагуу дээд, дунд, доод түвшинд ангилж үзэхэд сурагчдын 47% нь дээд ангилалд, 20% нь доод ангилалд хамаарч байна. Доод түвшинд хамрагдсан сурагчдыг зөв тогтоож сэргээн санасан элементийн байдлаар дүгнэж үзэхэд 9 настай 2 хүүхэд ангиллаа хийгээгүй, 6 үг тогтоосон.

Цуврал судалгааг Дорнод аймгийн Хэрлэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 9-13 насны сурагчдынхтай харьцуулан тооцсон. Энд зөвхөн IV цувралын үр дүнг танилцуулж байна.

Хүснэгт № 4

Нас	Тусгай сургууль	Е.Б. сургууль
9 нас	6.1	6.6
10 нас	5.6	6.2
11 нас	6.5	7.2
12 нас	7.3	7.4
13 нас	7.1	7.5

Диаграмм №2



(V цуврал туршилт)

V цуврал ойн таних үйл, тэмтрэх чадварыг судлахаар тулгуур 9 дүрсийг 25 дүрсийн дотроос зөв таньж олох даалгавар өгөгдсөн. Хүн аливаа юмыг таньж тогтоох 2 үндсэн хэлбэр байдаг.

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

1. Бодит байдалд тулгуурлан төсөөлж, таньж тогтоох
2. Тухайн эд юмстай харилцаа үүсгэж таньж тогтоох


Харааны бэрхшээлтэй сурагчид 2-р хэлбэр буюу эд юмстай харилцаа үүсгэж тогтоох нь давамгайлах шинж ажиглагдсан. Учир нь харааны мэдрэхүйн алдагдлаас өөрийн эрхгүй тэмтэрч мэдрэх шаардлагатай болдог.

Сурагчдад ойн таних үйл, тэмтрэх чадварыг илрүүлэх зорилготой үндсэн дүрсийг тэмтрүүлж, таниулах хоёр хэлбэрээр:


а.хэвлэмэл хэлбэрээр

б.тэмтэрч таниулахад зориулж товойлгон бэлтгэсэн. Тэмтэрч таних зураг нь ямар ч хүмүүс хараад таньж болохоор есөн дүрсийг сонгоод, холимог 25 дүрс нь багасгасан хэмжээгээр харагдаж байгаа боловч А4 цаасны хэмжээгээр хийгдсэн.

Зураг 1. Үндсэн 9 дүрс



Зураг 2. Холимог 25 дүрс



Судалгааны явцаас ажиглахад ихэнх сурагчид тэмтрэх явцдаа үндсэн 9 дүрсээ таних зорилгоор ямар нэг зүйлтэй харьцуулан хэлж байлаа. жишээ нь бөмбөг шиг бөөрөнхий,

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

пуужин шиг, байшин шиг, “г” үсэг шиг гэх мэт. Нийтлэг тохиолдсон алдаа бол ижил төстэй дүрсийг хооронд нь андуурах тохиолдол байсан.

Энэ цувралын үр дүнг хүснэгт ба диаграммаар үзүүлбэл:

Хүснэгт № 3

	Нас	Математик дундаж
1.	9 нас	6.3
2.	10 нас	5.6
3.	11 нас	6.5
4.	12 нас	7.3
5.	13 нас	7.3
6.	14 нас	7.5
7.	15 нас	8.0
8.	16 нас	7.0
9.	17 нас	8.5

V цуврал судалгаанд 8-9 дүрс таньсан 14 сурагч, 5-7 дүрс таньсан 18 сурагч, түүнээс доош цөөн дүрс таньсан зөвхөн 2 сурагч байгаа нь сурагчдын ойн таних үйлийн хөгжил хэвийн байна гэж үзэв. Тусгай сургуулийн судалгаанд оролцсон сурагчдын хүрээнд 3 ангиллаар дүгнэхэд ажиллах шаардлагатай түвшинд 10 насны 2 хүүхэд байв.


Хүснэгт №4

НАС	9	10	11	12	13	14	15	16	17	БҮГД
АНГИЛАЛ										
Дээд түвшин	1	-	1	2	1	2	2	2	3	14
Хэвийн түвшин	2	4	3	2	2	2	-	3	-	18
Ажиллах шаардлагатай	-	2							-	2
Бүгд	3	6	4	4	3	4	2	5	3	34

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Дүгнэлт

1. “Хөгжлийн бэрхшээл судлал ба инноваци-2020” гэж гарчигласан нь шинэлэг байсан гэж хувийн зүгээс үзэж байгаа. Учир нь үнэхээр судалгаа, инновацид тулгуурлах нь зорилтот бүлгийн иргэдийн хөгжлийг дэмжих гарц билээ. Хөгжлийн гарцын тулгуур нь бүх төвшний боловсрол бөгөөд суралцагчдыг тусгай хэрэгсэл, өвөрмөц арга зүйгээр дамжуулан мэдээллийн технологийн хөгжил давамгайлсан эрин үед дасан зохицох чадвартай иргэн төлөвшүүлэх билээ. Хараагүй хүн сурч хөгжиж чаддагийг амьдралаараа харуулсан олон хүн бидний дунд амьдарч байна.
2. 2019-2020 оны хичээлийн жилд 116-р тусгай сургуульд 129 хүүхэд суралцаж байна. Диаграмаас харахад жилээс жилд элссэн хүүхдийн тоо нэмэгдсэн байна.



Хүүхэд тоглох, энгийн ажил хөдөлмөр хийх, сурах, харилцах зэрэг үйлээр дамжин хөгжиж төлөвшдөг. Сурагч болсон цагаас эхлэн уншиж, бичиж сурах, дунд ба ахлах ангидаа бие даан мэдээлэл олж авах, аливаа зүйлсийн учир зүйг нарийн тодорхой ойлгож мэдэхэд мэдээллийн олон хэлбэрийг ашиглах хэрэгцээ тохиолдоно.

Талархал

Энэхүү судалгааг явуулахад сэтгэл судлал, судалгааны талаас зөвлөж, арга зүйг боловсруулахад туслалцаа үзүүлсэн Боловсролын Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан агсан Д.Дашхүү багш, ЭШ ажилтан, одоо НҮБ-ын ажилтан Т.Цэндсүрэн, Дорнод аймгийн Хэрлэн сумын ерөнхий боловсролын дунд сургуулийн бага ангийн багш нарт талархлаа илэрхийлье.

Ашигласан бүтээл

- Батдэлгэр, Ж. (2011) Бага насны хүүхдийн сэтгэл судлал
- Батдэлгэр, Ж. Мягмар, О. Цэндсүрэн Т, Дашхүү,Д . (1996) Хүүхдийн оюун ухааны хөгжлийг судлах сорил (хуудас 12-14)
- Сэтгэл зүйн зугаатай өгүүллүүд” Ч.Түмэндэлгэр, Л.Уранцэцэг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэм, эдийн засгийн шинж байдал ҮСХ -2010 оны тайлангаас
- 2020 оны Монгол Улсын Хүн ам, орон сууцны тооллогын тайлангаас
- Имайл хаяг: sagaasara.blog.com

Энэ үр дүн бол зөвхөн нэг удаагийн судалгаа бөгөөд хойшид олон төрлийн судалгааг харьцуулан хийх боломжтой бөгөөд, судалгаа хийх орчин, цаг хугацааг зохицуулан , арга зүйгээ боловсруулан ажиллавал судалгааны сонирхолтой үр дүн хүлээж байх болно.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ СУРАЛЦАГЧИД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ДАДЛАГАД ГАРАХАД ТУЛГАРДАГ БЭРХШЭЭЛҮҮДИЙГ ТОДОРХОЙЛЖ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМУУДЫГ ДЭВШҮҮЛЭХ

МУИС “Боловсрол судлал” хөтөлбөрийн доктрант Э.Бямбадаш¹
¹Дархан-Уул аймаг дахь Политехник коллеж

Хураангуй

“Бүх шатны боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох, мэргэжил эзэмших нөхцөлийг бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж, дэмжлэг туслалцаа үзүүлэх”

Судалгааг төвийн бүсийн МБСБ-ууд, Дархан-Уул аймаг дахь Политехник коллежид суралцдаг хөгжлийн бэрхшээлтэй 4 суралцагч, 3 ажил олгогчоос урьдчилан бэлтгэсэн асуултын дагуу фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага хийж мэдээллийг цуглуулсан.

Судалгааны үр дүнгээс харахад төвийн бүсийн МБСБ-д суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид сургалтын төлөвлөгөөний дагуу үйлдвэрлэлийн дадлагад ихэвчлэн сургуульдаа, цөөн хэсэг ААН байгууллагад гардаг. Суралцагч ААН байгууллага дээр үйлдвэрлэлийн дадлагад гарахыг эрмэлздэг ч ажил олгогч тэднийг хэрхэн, яаж дадлага хийлгэх болон ажлын гүйцэтгэлд хугацаа их зарцуулдаг зэргээс хамаарч хамтран ажиллах тал дээр дутмаг байдаг.

Ангийн болон үйлдвэрлэлийн дадлага удирдсан багш, нийгмийн түншлэлийн ажилтан нар ажил олгогчидтой хамтран, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн хөгжлийн бэрхшээл болон нас, бие, сэтгэхүйн онцлогт тохируулан үйлдвэрлэлийн дадлагыг зохион байгуулах нь илүү үр дүнтэй байна.

Түлхүүр үг: МБСБ, нийгмийн түншлэл, хөгжлийн бэрхшээлтэй суралцагч, үйлдвэрлэлийн дадлага

Сэдвийн үндэслэл

1. “Бүх шатны боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох, мэргэжил эзэмших нөхцөлийг бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж, дэмжлэг туслалцаа үзүүлэх”
2. 2019-2020 оны хичээлийн жилд МБСБ-д нийт 654 хөгжлийн бэрхшээлтэй суралцагч суралцаж байгаагаас хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалтын орчинг бүрдүүлсэн Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн Мэргэжлийн боловсрол ур чадвар олгох сургуульд 134 суралцагч суралцаж байна.
3. Төвийн бүсийн МБСБ-д суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын 91 хувь нь үйлдвэрлэлийн дадлагыг сургууль дээрээ гүйцэтгэдэг байна.

Ойлголт, тодорхойлолт

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1-д зааснаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хамааруулна.

Албан ёсны статистикийн мэдээлэл буюу нийгмийн зарим үзүүлэлтийн жилийн мэдээнд эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссоор хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлогдсон хүнийг хамруулж байна. Тухайн иргэнд ямар байдлаар илэрч байгаагаас хамаарч харааны, ярианы, сонсголын, хөдөлгөөний, сэтгэцийн, бусад гэсэн 6 ангиллаар авч үзэж байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудлаар хамтран ажиллах нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллага, ажил олгогч, ажилтан, үйлдвэрчний эвлэл, мэргэжлийн холбоо, аж ахуйн нэгж, байгууллага, суралцагч, эцэг, эх зэрэг сонирхогч этгээд нийгмийн түншлэлийг бүрдүүлж, зөвлөлийн хэлбэрээр ажилладаг байна.

Судалгааны ажлын зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид үйлдвэрлэлийн дадлагад гарахад тулгардаг хүндрэл бэрхшээлүүдийг судалж, шийдвэрлэх арга замуудыг туршилтын үр дүн болон ОУ-н туршлагаас үндэслэн санал дэвшүүлэх

Судалгааны ажлын зорилт

1. 2015-2020 оны Төвийн бүсийн МБСБ-ын хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын тоо, үйлдвэрлэлийн дадлагад гарсан газруудын мэдээллийг судлах
2. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч, иргэнийг үйлдвэрлэлийн орчинд дадлагажуулах олон улсын туршлагыг судлах
3. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид дадлагад гарахад нөлөөлдөг хүндрэл бэрхшээлийг судалж, сайжруулах арга замыг турших
4. Туршилт үр дүн болон ОУ-н туршлагаас үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын үйлдвэрлэлийн дадлагын чанарыг сайжруулах саналыг дэвшүүлэх

Мэдээлэл цуглуулах арга

- ✓ Баримт бичгийн судалгаа
- ✓ Ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлага

Судалгааны хамрах хүрээ

Төвийн бүсийн МБСБ-ууд, Дархан-Уул аймаг дахь Политехник коллежид суралцдаг хөгжлийн бэрхшээлтэй 4 суралцагч, 3 ажил олгогчоос урьдчилан бэлтгэсэн асуултын дагуу фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага хийж мэдээллийг цуглуулсан.

Сэдвийн судлагдсан байдал

Манай улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжихэд чиглэгдсэн олон тооны судалгаа хийгдсэн байдаг ч дийлэнх нь бодлогын шинжтэй судалгаа хийгдэж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сүүлийн үеийн тоо баримтыг гаргах, тэдгээрийг сургах, эрүүл мэндэд анхаарах, ажил эрхлэлтийг дэмжихийн тулд ямар арга хэмжээнүүдийг авах, төрөөс ямар бодлого хэрэгжүүлэх шаардлагатай вэ? гэсэн асуултанд хариу олоход чиглэгдсэн байдаг. Мөн их дээд сургууль, коллеж болон ЕБС-ийн багш нарын сурган заах арга зүйн судалгаандаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад хэрхэн хичээлийг үр дүнтэй зохион байгуулах талаарх судалгаанууд зонхилдог.

Эдгээрийг дурдвал:


- Тахир дутуу иргэдийн нэг удаагийн бүртгэл, түүвэр судалгаа, 2004
- Хөдөлмөрийн зах зээл дэх тахир дутуу иргэдийн оролцоо, 2004
- “Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгай данс”-нд хийсэн мониторингийн тайлан, 2007
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд” ХАОСТ-ын сэдэвчилсэн судалгаа, 2010
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа 2013
- Монгол ажилчдын хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандах хандлага 2015
- Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад сургалт явуулахад тулгамдаж буй асуудал, 2019

Судалгааны хэсэг

Судалгаа 1: 2015-2020 оны Төвийн бүсийн МБСБ-ын хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын тоо, үйлдвэрлэлийн дадлагад гарсан газруудын мэдээлэл


“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Зураг 1. Төвийн бүсийн МБСБ-ын хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид /тоогоор/



“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Зураг 1. Төвийн бүсийн МБСБ-ын хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын үйлдвэрлэлийн дадлагад гарсан хэлбэр /Хувиар/



Хүснэгт 2. Дархан-Уул аймаг дахь Политехник коллежид суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид /төрөл, тоогоор/

№	Нэр	2015-2016	2016-2017	2017-2018	2018-2019	2019-2020	2020-2021
1	Сонсгол	4	8	3	0	0	1
2	Сэтгэц	1	2	1	0	2	2
3	Хэл яриа	2	5	5	3	2	2
4	Хөдөлгөөн	4	5	3	3	4	2
5	Хараа	7	5	4	1	0	0
6	Бусад	5	4	2	0	0	1
	Бүгд	23	29	18	7	8	8

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Хүснэгт 3. Дархан-Уул аймаг дахь ПК-д суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид /мэргэжлээр, тоогоор/

№	Нэр	2015-2016	2016-2017	2017-2018	2018-2019	2019-2020	2019-2021
1	Оёмол бүтээгдэхүүний оёдолчин	7	9	5	3	1	1
2	Сантехник	1	2	2	1	1	1
3	Автомашинны засварчин	3	3	2	0	1	1
4	Тогооч	6	8	5	2	1	1
5	Гагнуурчин	2		1		1	1
6	Үсчин	4	6	2	1	1	1
7	Цахим тоног төхөөрөмж үйлчилгээний ажилтан	-	-	-		2	1
8	Цахилгаан		1	1			
	Бүгд	23	29	18	7	8	7

Хүснэгт 4. Дархан-Уул аймаг дахь ПК-ийн хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид үйлдвэрлэлийн дадлагад гарсан байдал /дүнд эзлэх хувиар /

№	Нэр	2016-2017		2017-2018		2018-2019		2019-2020		2020-2021	
		Сургууль	ААН	Сургууль	ААН	Сургууль	ААН	Сургууль	ААН	Сургууль	ААН
1	Оёмол бүтээгдэхүүний оёдолчин	83	17	80	20	100		100		100	
2	Сантехник	100		100		100		100			

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

3	Автомашины засварчин	100		100				100			
4	Тогооч	83	17	100		67	33	100			
5	Гагнуурчин			100				100		100	
6	Үсчин	100		100		100					
7	Цахилгаан	100		100							
8	Цахим тоног төхөөрөмж үйлчилгээний ажилтан								100		100

Хүснэгт 5. 2019-2020 онд Дархан-Уул аймаг дахь ПК-д суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид

№	Нэр	Хөгжлийн бэрхшээлийн төрөл	Анги	Дадлагад гарсан газар
1	Суралцагч 1	Сонсгол	Оёмол бүтээгдэхүүний оёдолчин 1а	
2	Суралцагч 2	Сэтгэц	Сантехник 1а	
3	Суралцагч 3	Хэл яриа	Автомашины засварчин 1а	
4	Суралцагч 4	Сэтгэц	Тогооч 2а	Дархан ПК
5	Суралцагч 6	Хавсарсан	Гагнуур 2а	Дархан ПК
6	Суралцагч 5	Хөдөлгөөн	Гагнуурчин 3а	Дархан ПК
7	Суралцагч 7	Хөдөлгөөн	Цахим тоног төхөөрөмж үйлчилгээний ажилтан 3а	“Уран дизайн” студи

Судалгаа 1-ийн дүгнэлт

Судалгааны үр дүнгээс харахад төвийн бүсийн МБСБ-ын мэргэжлүүдийн чиглэлээс хамаараад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын тоо харилцан адилгүй байна. Жишээ нь Дархан-Уул аймаг дахь УУЭХПК-д суралцдаг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын тоо нь Дархан-Уул аймаг дахь Политехник коллежоос харьцангуй бага байна. Хөгжлийн

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

бэрхшээлтэй суралцагчдыг суралцаж байгаа ангиас нь харахад үйлчилгээний салбарын ангиудад илүү их суралцаж байна.

Төвийн бүсийн МБСБ-ын хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын үйлдвэрлэлийн дадлагад гарсан хэлбэрээс харахад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын 91 хувь нь сургууль, 9 хувь нь ААН байгууллагад дадлага хийдэг байна.

Дархан-Уул аймаг дахь ПК-ийн 2015-2020 онд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг тоон үзүүлэлтийг харахад 2016 онд хамгийн их 29, 2018 онд хамгийн бага 7 хөгжлийн бэрхшээлтэй суралцагч суралцаж байсан байна. Хөгжлийн бэрхшээлийн төрлөөр харахад хөдөлгөөний бэрхшээлтэй суралцагч дийлэнх, сэтгэцийн бэрхшээлтэй суралцагч харьцангуй бага байна.

2016-2021 онд 37 хөгжлийн бэрхшээлтэй суралцагч Дархан-Уул аймаг дахь Политехник коллежид суралцаж 93% сургуульд, 7% ААН байгууллагад үйлдвэрлэлийн дадлагад гарсан байна.

2016-2017 онд хэл ярианы бэрхшээлтэй 1 суралцагч оёмол бүтээгдэхүүний оёдолчин мэргэжлээр, хөдөлгөөний бэрхшээлтэй 1 суралцагч тогооч мэргэжлээр, 2017-2018 онд сонсголын бэрхшээлтэй 1 суралцагч оёмол бүтээгдэхүүний оёдолчин мэргэжлээр, 2019-2020, 2020-2021 онуудад хөдөлгөөний бэрхшээлтэй 1 суралцагч цахим тоног төхөөрөмж үйлчилгээний ажилтан мэргэжлээр тус тус үйлдвэрлэлийн дадлагад гарсан байна.

2020 оны 9 сард хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын дадлагад гарсан мэдээллээс харахад гагнуурчин мэргэжлээр суралцдаг тулгуур эрхтний болон сонсголын бэрхшээлтэй 2 суралцагч сургуульд, цахим тоног төхөөрөмж үйлчилгээний ажилтан мэргэжлээр суралцдаг хөдөлгөөний бэрхшээлтэй 1 суралцагч 2019-2020 онд дадлага хийсэн газраа дахин дадлагад гарсан байна.

Судалгаа 2: Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч, иргэнийг үйлдвэрлэлийн орчинд дадлагажуулах олон улсын туршлага

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Улс орнууд	Туршлага
Канад	Мэргэжлийн сургууль коллежид хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад үйлчлэх албыг ажиллуулдаг. Тухайн албаны мэргэжилтэнгүүд хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон ААН байгууллага 2-г холбож ажилладаг.
Герман	Томоохон ААН байгууллагуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дагуулан тэдгээрийг ажил хөдөлмөрт бэлтгэх үүрэгтэй мэргэжилтэн ажиллаж байдаг.
Англи	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байран дахь тэгш бус байдал ялгаварлан гадуурхалтанд өртөхөөс сэргийлж бүх шатны ажилчдад сургалт зохион байгуулдаг.
Швед	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг үйлдвэрлэлийн орчинд дадлагажуулах, ажиллуулах, мэргэшүүлэх нөхцөл бололцоогоор хангасан ААН байгууллагад эдийн засгийн дэмжлэг үзүүлдэг.

Эх үүсвэр: Олон улсын хөдөлмөрийн байгууллага үр чадвар хөдөлмөр эрхлэлтийн газар

“Мэргэжлийн сургалтанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хангах нь практик гарын авлага” 2015

Судалгаа 3: Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг дадлагад гарахад тулгардаг хүндрэл бэрхшээлийг судлах

Асуулт 1. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч үйлдвэрлэлийн дадлагад гарахад ажил олгогч болон тухайн хүүхдэд ямар бэрхшээл тулгардаг вэ?			
Ажил олгогч 2019 он		Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч 2019 он	
1	Үйлдвэрлэлийн дадлагад гарч байгаа суралцагчтай сайн ойлголцдоггүй	1	Үйлдвэрлэлийн дадлагад гаргаж байгаа ААН байгууллага мэргэжлийн чиглэлээр ажил хийлгэдэггүй
2	Хамтран ажиллахад цаг их зарцуулдаг.	2	Тухайн ААН байгууллагын хамт олон дургүй байх шиг санагддаг

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

3	Үйлдвэрлэлийн дадлагад гарч байгаа суралцагчийн ажлын бүтээмж бага	3	Үйлдвэрлэлийн дадлагаас өөр цэвэрлэгээ үйлчилгээ хийлгэдэг
4	Суралцагч ажлын ачаалал даах чадваргүй	4	Маш их даалгавар өгдөг
Асуулт 2. Дадлага хийхэд тулгарч байгаа бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэж болох вэ?			
1	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг хариуцаж дадлага хийлгэсэн үед байгууллагаас нэмэлт цалин урамшуулал олговол сайн байна.	1	Үйлдвэрлэлийн дадлага хийлгэх хугацаанд хамт ажилладаг ажилчид бидэнтэй сайхан харилцаж, тусалж дэмжиж ажиллах
2	Багш нар тухайн хөгжлийн бэрхшээлтэй суралцагчтай хэрхэн ажиллах заавар өгөх	2	Бидэнд дадлагын ажлыг ойлгомжтой тайлбарлаж өгдөг байх
3	Үйлдвэрлэлийн дадлагад ямар даалгавар ажил өгч хийлгэж болох талаар чиг өгөх	3	

Судалгааны ажлын туршилтын хэсэг: Олон улсын туршлага болон, фокус бүлгийн ярилцлагын үр дүнд үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн үйлдвэрлэлийн дадлагад гарахад тулгарч байгаа бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд сургуулийн нийгмийн түншлэлийн ажилтан, дадлага удирдсан болон ангийн багш нар хамтарч туршилтын ажлын төлөвлөгөөний дагуу судалгааны туршилт зохион байгууллаа.

Туршилтын ажлын төлөвлөгөө

№	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн
1	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчидтай бүлгийн фокус ярилцлага хийх	2019-11-04	Анги удирдсан багш

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

2	ААН байгууллагуудын төлөөлөлтэй ганцаарчилсан фокус ярилцлага хийх	2019 оны 11 сарын эхний 7 хоног	Нийгмийн түншлэлийн ажилтан
3	Үйлдвэрлэлийн дадлагын явцад гарсан хүндрэл бэрхшээлүүдийг нэгтгэж, сайжруулах арга замыг судлах	2019 оны 11 сарын 2-р долоо хоног	Ангийн болон дадлага удирдсан багш, Нийгмийн түншлэлийн ажилтан
4	Суралцагч, ААН байгууллагыг сонгох	2020 оны 09 сар эхний 7 хоног	Ангийн болон дадлага удирдсан багш, Нийгмийн түншлэлийн ажилтан
5	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн дадлага ажлын дэвтрийг суралцагчийн онцлогт тохируулан нарийн боловсруулах	2020 оны 09 сар эхний 7 хоног	Дадлага удирдсан багш
6	ААН байгууллагын ажилчдад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчтай хэрхэн ажиллах талаар зөвлөгөө өгөх	2020 оны 09 сар эхний 7 хоног	Анги удирдсан багш
7	Үйлдвэрлэлийн дадлагын хичээлийг эргэх	2020-09-14, 17, 22, 24, 30 2020-10-02, 07, 12, 15	Дадлага удирдсан багш
8	ААН байгууллагын төлөөлөлтэй уулзаж ярилцлага хийх	2020-10-15	Нийгмийн түншлэлийн ажилтан
10	Туршилтын ажлыг дүгнэх	2020-10 сар	Ангийн болон дадлага удирдсан багш, Нийгмийн түншлэлийн ажилтан

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Туршилтанд суралцагчийг төлөөлж Цахим тоног төхөөрөмж үйлчилгээний ажилтан 2а ангийн суралцагч О.Энхзул, ААН байгуулагыг төлөөлж Компьютерийн үйлчилгээний “Уран дизайн” студи дадлага удирдагч Э.Содцэцэг нар оролцсон. Туршилт 2019 оны 11 сараас 2020 оны 10 сарын 20 хүртэл үргэлжилсэн.

Туршилтын үр дүнд гарсан өөрчлөлт	
Ажил олгогч 2020 он	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч 2020 он
Дадлагад гарч байгаа суралцагчтайгаа ойлголцдог болсон.	Дадлага хийлгэж байгаа хүний өгсөн даалгавар нь ойлгомжтой байсан
Дадлага хийхдээ өмнөхөөсөө дуртай идэвхитэй болсон байсан.	Хамт ажиллаж байгаа ах эгч нар гоё эелдэг харьцдаг.
Өөрийн түвшинд тохирсон даалгавар гүйцэтгэсэн тул ажлын бүтээмж сайжирсан	Өдөр бүр шинэ шинэ зүйл туршиж дадлага хийсэн

Дүгнэлт

Судалгааны үр дүнгээс харахад төвийн бүсийн МБСБ-д суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид сургалтын төлөвлөгөөний дагуу үйлдвэрлэлийн дадлагад ихэвчлэн сургуульдаа, цөөн хэсэг ААН байгууллагад гардаг. Суралцагч ААН байгууллага дээр үйлдвэрлэлийн дадлагад гарахыг эрмэлздэг ч ажил олгогч тэднийг хэрхэн, яаж дадлага хийлгэх болон ажлын гүйцэтгэлд хугацаа их зарцуулдаг зэргээс хамаарч хамтран ажиллах тал дээр дутмаг байдаг.

Ангийн болон үйлдвэрлэлийн дадлага удирдсан багш, нийгмийн түншлэлийн ажилтан нар ажил олгогчидтой хамтран, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн хөгжлийн бэрхшээл болон нас, бие, сэтгэхүйн онцлогт тохируулан үйлдвэрлэлийн дадлагыг зохион байгуулах нь илүү үр дүнтэй байна.

Дэвшүүлж буй санал

1. Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, онцлогт тохируулан үйлдвэрлэлийн дадлагаар гүйцэтгэх ажлыг нарийн төлөвлөж, ажил олгогчдод суралцагчийн гүйцэтгэх даалгаврыг тодорхой бэлдэж өгөх
2. Хамт олны уур амьсгалыг сайжруулж хөгжлийн бэрхшээлтэй суралцагчтай эерэг сэтгэгдэл төрүүлж дэмжиж ажиллах тал дээр анхаарах
3. Дадлага удирдсан ажилтанд илүү цагийн цалин хөлс урамшуулал олгох

Ном зүй

- ✓ Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль
- ✓ Боловсролын тухай хууль
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль
2016 он
- ✓ Хөдөлмөрийн тухай хууль 1999 он
- ✓ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль 2011 он
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль,
14 дүгээр зүйл: Сурч боловсрох эрх, 14. 1. 3
- ✓ Мэргэжлийн болон техникийн боловсролыг
хөгжүүлэх үндэсний хөтөлбөр 2016-2021
- ✓ Үндэсний статистикийн хорооны тайлан, 2017
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц (артикл
24.2)
- ✓ МБСБ-ын тухай хууль 20.2.4
- ✓ НХХЯ, АХБ Хөдөлмөрийн зах зээл дэх тахир дутуу иргэдийн оролцоо, (2004)
- ✓ АЙВУУН ТББ Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой иргэдийн хөдөлмөр
эрхлэлтийг дэмжих тусгай данс”-нд хийсэн мониторингийн тайлан, (2007)
- ✓ ҮСХ Хөгжлийн бэрхшээлтэй иргэд” ХАОСТ-ын сэдэвчилсэн судалгаа, 2010
- ✓ М.Мөнхнаран “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн
судалгаа” УБ 2013
- ✓ Б.Баярмаа “Монгол ажилчдын хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандах
хандлагын судалгаа” УБ 2015

- ✓ Ж.Цэгмид “Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад сургалт явуулахад тулгамдаж буй асууда”, 2019он
- ✓ Олон улсын хөдөлмөрийн байгууллага үр чадвар хөдөлмөр эрхлэлтийн газар “Мэргэжлийн сургалтанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хангах нь практик гарын авлага” 2015
- ✓ Sheid T.(2005). Stigma as a barrier to employment: Mental disability and the Americans with Disabilities Act. International Journal of Law and Psychiatry, 28, 670-690
- ✓ Ozawa, A., & Yeada, J. (2006).Employer attitudes toward employing person with psychiatric disabilities in Japan.Journal of Vocational Rehabilitation, 26, 105-113.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙГ ПАРА СПОРТОД ТАТАН ОРОЛЦУУЛАХ БОЛОМЖИЙГ СУДАЛСАН ДҮН

Ж.Загас¹

¹ХААИС-ийн ББХТ ахлах багш, Доктор (Ph.D), пара волейболын ОУХМ

ABSTRACT: One of the manifestations of parade sports in Mongolia is the fact that Mongolian psychiatrists have participated in the Paralympics Summer Games in 2008, and they have shown that people with disabilities can be as successful as a healthy person. It has been increasing the national pride and increasing interest in the sport of disabled persons, thereby promoting the support of the people and the government to their paratroopers.

Хураангуй.

“Paralympic Games” гэдэг нэр нь грекийн үгсийн санд байдаг угтвар үг болох “para” буюу “зэрэгцээ” гэсэн утга санаатай үгнээс улбаатай. Аль ч нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал эгэл жирийн хүмүүсийн адил зэрэгцээ оршдог тул эдгээр хүмүүсийг нийгэмшүүлэх, өөрсдийнх нь дуу хоолойг спортын агуу баяр болох, Паралимпийн наадмаар дамжуулан дэлхий нийтэд хүргэх, бэрхшээл зовлонг хамтдаа даван туулах, эвлэлдэн нэгдэх, наадам зохион байгуулж улс орон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эх орондоо сайхан амьдрах нөхцөл боломжийг бий болгож, хийсэн бүтээсэн зүйлээ, паралимпийн өв хөрөнгө болох хүмүүнлэгийн үнэт зүйлийг бусад орнуудад үлгэр жишээ болгох гэсэн олон талын ач холбогдолтой юм. Бид энэхүү өгүүллээрээ дэлхийн болон монгол улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өнөөгийн байдал, тэдний спортоор хэрхэн хичээллэж ямар амжилтууд гаргаж байгаа талаар илрүүлэн бичлээ.

Түлхүүр Үг: паралимпийн хөдөлгөөн, спортын төрөл, ангилал, онцлог.

Оршил

Паралимпийн хөдөлгөөн нь 1880 оноос эхэлсэн түүхтэй боловч, 1945 оноос эхлэн нуруу нугасны гэмтэлтэй өвчтөнүүдийг системтэй эмчилж энэхүү эмчилгээ, нөхөн сэргээх үйл явц нь Паралимпийн хөдөлгөөнийг жинхэнэ утгаараа хөгжих үндэс суурийг тавьсан гэж судлаачид үздэг.

Дэлхийн II дугаар дайны дараа Германы мэс засалч Людвиг Гютман спортоор дамжуулан тахир дутуу болсон өвчтөний сэтгэл санааг түргэн хугацаанд өргөх, физиологийн нөхөн сэргээлт, сэтгэл зүйн болон хувь хүнийг өөрийгөө нийгэмд

хүлээн зөвшөөрүүлэхэд биеийн тамир, спорт нь маш их ач холбогдолтой гэдгийг нотолжээ. Англи улсын Сток Мандевиллийн хотын эмнэлэгт дайны дараа тахир дутуу болсон цэрэг дайчдыг нөхөн сэргээх үйл явцад биеийн тамир, спортыг хавсарга байдлаар ашигласан нь удалгүй спортын хөдөлгөөн болон өрнөж хөгжлийн бэрхшээлтэй тамирчдын спортод гаргах дээд амжилтыг харах боломжийг нээж өгсөн. Паралимпийн наадмыг 1948 оны 7 дугаар сарын 29-нд Англи улсад зохион байгуулсан. Наадмын анхны оролцогчид болох 16 саажилттай эрэгтэй, эмэгтэй ахмад цэрэг дайчид байт харвааны төрлөөр өрсөлдсөн түүхтэй.

Ром хотод 1960 онд анх зохион байгуулагдсан зуны анхны наадамд 23 орны 400 тамирчин оролцсон бол 2012 оны Паралимпийн XIV дүгээр наадамд, 164 орны 4237 тамирчин спортын 21 төрлөөр, 503 багц медалийн төлөө өрсөлдөж, дэлхийн рекордыг 251 удаа, Паралимпийн наадмын рекорд амжилтыг 314 удаа эвдсэн түүхэн наадам болсон. Паралимпийн наадам гэдэг албан ёсны нэрийг Сөүлийн Паралимпийн наадмаас хойш олон улсад хэрэглэж эхэлсэн юм.

1988 онд ОУПХ- (ИОС), ОУПХ- (ИРС)-оос албан ёсоор Олимпийн наадмыг хүлээн авсан орон, Паралимпийн наадмыг мөн зохион явуулах эрх олгодог болсон байна.

Судалгааны зорилго, зорилт, шинэлэг байдал, ач холбогдол

Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өнөөгийн байдал, тэдгээрийн спортоор хичээллэж байгаа судалгаа, уралдаан тэмцээнд хамрагдаж байгаа талаар судалгааны материал тун ховор, мэдээ мэдээлэл төдий байдаг. Тийм учраас бид энэхүү өгүүллээрээ Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон пара спортын тамирчдын өнөөгийн статистик тоо баримтыг эмх цэгцтэй, шинжлэх ухааны үндэслэлтэй гарган нийтийн хүртээл болгох зорилго тавилаа. Энэхүү зорилгын хүрээнд мэдээллийн хоёрдогч эх сурвалжийн материалыг ашиглан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн статистик тоо, тэдгээрийн спортын төрлүүдээр хичээллэн ямар амжилтууд гаргасан талаар илрүүлэн бичих зорилтуудыг тавьсан болно.

Бидний энэхүү өгүүлэл нь энэ чиглэлээр хийгдсэн цөөн тооны ажлуудын нэг болсноороо шинэлэг бөгөөд эмх цэгцтэй, үндэслэлтэй тоо баримтыг олны хүртээл болгон түгээж байгаагаараа ач холбогдолтой юм.

Судалгааны хэрэглэгдэхүүн, арга зүй

Энэхүү өгүүллийн хүрээний судалгааны үйл явцын туршид хоёрдогч эх сурвалжийн мэдээллийг ашиглан судалгаа шинжилгээнд өргөн хэрэглэгддэг шинжлэх ухааны танин мэдэхүйн ажиглалт, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх зэрэг ерөнхий арга зүйг ашиглан явууллаа. Судалгааны объект нь олон улсын болон Монгол улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн статистик тоо баримтууд болно.

Судалгааны үр дүн, шүүн хэлэлцэхүй

Дэлхийн 170 гаруй оронд Олимпийн хороо болох Үндэсний Олимп, Тусгай Олимпийн хороод идэвхтэй үйл ажиллагаа явуулж, зуны болон өвлийн Паралимпийн арга хэмжээг тогтмол зохион байгуулж байна.

1968 оны 7 дугаар сарын 20-нд Чикаго хотын Парк дүүргийн цэргийн талбайд Кенеди сангаас Олон улсын анхны Тусгай олимпийн зуны наадмыг зохион байгуулсан. Тус наадамд АНУ-ын 26 муж болон Канад улсын 1000 гаруй оюуны бэрхшээлтэй тамирчид оролцон, хөнгөн атлетик, хоккей, усан спортын төрлүүдээр өрсөлдсөн.

Тусгай Олимп нь спортын уралдаан тэмцээнээр дамжуулж, оюуны бэрхшээлтэй хүмүүст урам дэм өгөх, бие бялдрыг хөгжүүлэх, тэднийг бидний нэгэн адил эгэл нэгэн иргэн гэдгийг олон нийт, нийгэмд таниулах зорилготой, Олон улсын байгууллага юм.

Тусгай олимп нь оюуны бэрхшээлтэй болон насанд хүрэгчдэд зориулсан зуны болон өвлийн олимпийг 2 жил тутам ээлжлэн зохион байгуулдаг. Монгол улсад Тусгай олимпийг спортоор сүүлийн 2 олимп дараалан амжилттай оролцож байна.

Тусгай олимпийн тэмцээнд оюуны бэрхшээлтэй яг хүний асрамжид байдаг, ялангуяа харгалзагч хүн хамгийн гол үүрэг гүйцэтгэдэг.

Тусгай олимпийн төрөлд ордог хүүхдүүд нь бүгд оюун санааны бэрхшээлтэй байдаг болохоор өөрийн үзэл бодол юу хүсч байгаагаа үгээр хэлж чадахгүй нь хамгийн хүнд байдаг.

Дэлхий дээр нэг тэрбум гаруй хүн ямар нэгэн хөгжлийн бэрхшээлтэй, үүнээс бараг 200 сая хүн үйлдлийн бэрхшээлтэй бөгөөд нийгмээс тусгаарлагдсан, хязгаарлагдмал орчинд амьдарч байна. Энэ тоон дээр хөгжлийн бэрхшээлтэй

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

иргэнийг гэр бүлийн асран хамгаалагч гишүүдийн тоог нэмбэл ойролцоогоор 2 сая хүн хөгжлийн бэрхшээлээс үүдсэн асуудалтай амьдарч байна. Дэлхийн хүн ам өсөхийн хирээр хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо ч улам бүр нэмэгдэж байна. Нөгөө талаас ядуурал, байгалийн гамшиг, тогтворгүй байдал, осол гэмтэл, эмнэлгийн байгууллагын үйл ажиллагаанд гарсан алдаа дутагдлаас хүн хөгжлийн бэрхшээлтэй болох тохиолдол өссөөр байгааг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээ, тайлан харуулж байна. НҮБ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийг чиглүүлэх дэвшилтэт бодлого, хөтөлбөрт Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Дэлхийн банкны групп хамтарч, хөгжлийн бэрхшээлийн талаарх “Дэлхийн тайлан”-г боловсруулсан. Энэхүү олон улсын гэрээ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, хөгжлийн асуудлыг бэхжүүлж өгсөн. Хөгжлийн бэрхшээл нь нийгмийн орчин хөгжлийн түвшингээс хамаарч үргэлж өөрчлөгдөн хувьсаж байдаг ойлголт юм.

Дэлхийн эрүүл мэндийн судалгаагаар ойролцоогоор 785 сая хүн (15.6 %), Дэлхийн өвчний ачааллын *Global Burden of Disease* судалгаагаар 975 сая хүн (19.4 %) нь 15 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй амьдарч байна. Тэдгээрийн 110 сая хүн (2.2 %) үйлдлийн хувьд бэрхшээлтэй, харин 190 сая хүн (3.8 %) нь “хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй” байна гэж тогтоожээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгаа, (сая хүн) тивүүдээр 2018 он

№	ХБ ангилал	Австрали	Ази	Америк	Африк	Европ
1	Харааны бэрхшээл	0.4	182.2	28.0	49.4	27.4
2	Хэл ярианы бэрхшээл	1.6	89	29.3	25.5	4.6
3	Сонсголын бэрхшээл	2.5	212.4	32.4	78.3	32.4
4	Оюуны бэрхшээл	1.8	21.4	13.8	23.5	9.5
5	Тулгуур эрхтэний бэрхшээл	1.1	145	19.5	40.0	6.1
НИЙТ		7.4	650	123	216.7	80

Эх сурвалж: Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тайлан, 2018.

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Монголын Тусгай Олимпийн хороо нь 2013 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр Олон Улсын Олимпийн хороонд гишүүнээр элсэж, 2013 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр Монгол улсад нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага болсон.

Монголын Тусгай Олимпийн Хороо нь Олон Улсын Олимпийн Хорооны зорилгыг эрхэмлэн дээдэлж, цаашид Монгол улсад оюуны бэрхшээлтэй хүмүүсийг спортоор хөгжүүлж, тэдний нуугдмал чадавхийг хөгжүүлэн, эрүүл бие бялдартай, аз жаргалтай, өөртөө итгэлтэй, урам зоригтой тамирчин болоход нь бүхий л боломжоор дэмжлэг үзүүлэх зорилготой юм.



2018 оны байдлаар манай улсын нийт хүн амын 3.0 хувь буюу 105.7 мянга орчим нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаагаас 56 хувь нь эрэгтэйчүүд, 44 хувь нь эмэгтэйчүүд, 35.5 хувь нь төрөлхийн, 64.5 хувь нь олдмол (ахуйн болон үйлдвэрлэлийн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан иргэд) байна. Хөдөлмөрийн насны (42-45 нас) хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 20.7 хувь нь хөдөлмөр эрхэлж байна.

Хүйс	2014	2015	2016	2017	2018
Нийт	99,573.	101,730.	100,993.	103,630.	105,730.
Эрэгтэй	54,864.	56,434.	55,758.	57,310.	59,691.
Эмэгтэй	44,709.	45,296.	45,235.	46,320.	46,039.

Эх сурвалж: Монголын статистикийн үндэсний хороо, 2018 он.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгаа, насны ангиллаар болон төрлөөр

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”



Монголын Паралимпийн хороо (ОУПОХ)-нд гишүүнээр элсүүлэх, тэдгээр байгууллагуудын гишүүн болсноор гаргаж байгаа шийдвэрүүдийг Монгол улсад явуулж байгаа үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах, дэмжлэг туслалцаа авах зэрэг олон ажил хийж ирсэн билээ.

Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бие, оюун ухаан, сэтгэл санааг нийгэмшүүлэх төрийн бодлогыг дэмжих зорилгоор байгуулагдсан холбоодыг дурдвал:

1. Пара байт харваан холбоо
2. Пара буудлагын холбоо
3. Пара хөнгөн атлетикийн холбоо
4. Пара жүдогийн холбоо
5. Пара цанын холбоо
6. Пара волейболын холбоо
7. Пауэрлифтингийн холбоо
8. Пара ширээний теннисний холбоо анх байгуулагдсан юм.

Эдгээр холбоод тус тусынхаа спортын төрлөөр хот, улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах, цаашид хүүхэд, өсвөр нас, залуучууд гэсэн ангиллаар хот, улс, олон улсын тэмцээнийг зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг өргөн хамруулах, тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, улмаар спортын өндөр амжилт гаргах нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Энэ дагуу эрүүл тамирчдынхаа нэгэн адил хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс улс орныхоо нэр сүрийг өндөрт өргөх авъяаслаг тамирчдыг төрүүлэх зорилго тавьж ажилласан юм.

Тэдгээр холбоодын нэг зорилт нь Монголын бүх ард түмний X дугаар спартакиадад анх удаа хөгжлийн бэрхшээлтэй тамирчдыг бэлтгэж оролцуулах ажил байсан бөгөөд энэ арга хэмжээг амжилттай зохион байгуулсны үр дүнд Монголын хот, хөдөөгийн 100 гаруй тамирчид 69 медалийн төлөө өрсөлдсөн наадам болсон.

Харин 2003 оноос хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын арга хэмжээг зохион байгуулахад төрийн захиргааны бүх шатны байгууллагууд шууд оролцож санхүүжилтийн арга хэмжээг улсын төсөвт тусгайлан тусгах эхлэл тавигдсан.

Түүнчлэн 2004 оноос зарим спортын төрлөөр улсын шигшээ багийг бий болгосноор, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд пара спортыг хөгжүүлэх, биеийн

тамир, спортоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хичээллүүлэх чухал алхам тавьсан гэж дүгнэж болно.

1995-2003 оны хооронд төрийн бус 33 байгууллага байсан ба тэдгээр нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд спортын олон арга хэмжээ явуулах, аймаг, нийслэл, халамжийн газар, ивээн тэтгэгч байгууллагын туслалцаатайгаар хурал, зөвлөгөөн, уулзалтуудыг зохион байгуулж ирсэн юм.

“Дэлхийг тойрох” аялал уриан дор 1995 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортыг сурталчлах зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй иргэн Б.Баярмагнай, Э.Энхбаяр нар Монгол улсын хойд хилийн төмөр замын Сүхбаатар өртөөнөөс урд хилийн Замын-Үүд хүртэл дугуйн аялал зохиосон нь Параспортын байгууллагын санаачилж дэмжсэн ажлын нэг байсан юм.

Энэ санаачилга нь хөгжлийн бэрхшээлтэй хүний тэсвэр, тэвчээрийг гайхан бишрүүлсэн төдийгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортыг сурталчилсан анхны том арга хэмжээ болсон юм.

1999 оны 9 дүгээр сард болсон Тахир дутуу иргэдийн Ази тивийн VII дугаар наадамд Монгол улсын баг тамирчид анх амжилттай оролцсон билээ. Энэ наадамд Пара тамирчид спортын 3 төрлөөр (*хөнгөн атлетик, байт харваа, буудлага*) оролцож, хөнгөн атлетикийн төрөлд алтан медаль 1, мөнгөн медаль 2 авсан нь хөнгөн атлетикийн түүхэнд байгаагүй амжилт байсан юм.

Энэхүү Азийн тоглолтоор буудлагын тамирчин П.Төмөрбаатар дэд мастерын болзол биелүүлж, байт харвааны тамирчин Д.Баатаржав шагналт IV дүгээр байр эзэлсэн юм. Үүгээрээ Монголын хөгжлийн бэрхшээлтэй тамирчид жирийн тамирчдаас дутахааргүй амжилтанд хүрэх итгэлийг төрүүлсэн гэж дүгнэж болно.

Азийн тоглолтын үеэр Монголын Паралимпийн Хороог Азийн “Песпик”-ийн холбоонд албан ёсоор гишүүнээр элсүүлсэн байна. Паралимпийн Хорооны ажлын үр дүн, манай Пара спортын тамирчдын амжилтаас дурдвал:

- 2000 онд Олон улсын Паралимпийн Хорооны гишүүн байгууллага болсон.
- 2003 онд Биеийн тамир спортын тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортыг дэмжсэн заалт оруулсан юм.

- Монголын Паралимпийн тамирчид Австрали улсын Сидней 2000 зохион байгуулагдсан, Зуны Паралимпийн XI дүгээр наадмаас эхлэн Паралимпийн наадамд анх оролцож эхэлсэн.
- 2008 оны Зуны Паралимпийн XIII дугаар наадамд манай улсын тамирчид (байт харваа, буудлага, жүдо бөх) төрлөөр 4 тамирчин, нийт 13 хүний бүрэлдэхүүнтэй оролцож, байт харвааны төрлөөр Д.Баатаржав алтан медаль хүртэж, Монгол улс 147 орноос Дэлхийн чансаагаар 51 дүгээр байрыг эзлэн пара спортын тамирчдын амжилтын түүхийн шинэ хуудсыг нээсэн юм.
- 2010 оны Гуанжуо Азийн Паралимпийн спортын 10 дугаар наадамд спортын 6 төрлөөр 25 тамирчин, нийт 37 хүний бүрэлдэхүүнтэй оролцож байсан.
- 2014 онд Азийн наадам Инчөон 2014 спортын 9 төрлөөр 61 тамирчин нийт 118 хүний бүрэлдэхүүнтэй баг оролцсон юм.
- 2016 онд Азийн Паралимпийн наадамд спортын 11 төрлөөр 160 гаруй хүний бүрэлдэхүүнтэй оролцсон.

Паралимпийн Зуны наадмаас гадна Өвлийн наадмуудад Монгол улсын баг тамирчид амжилттай оролцож ирсэн. Өвлийн спортын төрлөөр гүйлтийн цаны тамирчид 2006 онд Итали улсад зохиогдсон Турины Паралимпийн наадамд анх оролцож эхэлсэн.

Энэ нь Монгол улсын Паралимпийн тамирчдын чадвар жилээс жилд өсөж, өвөл, зуны пара спортыг сонирхогчдын тоо улам их болж байгаатай холбоотой бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэд эрүүл хүний нэгэн адил спортын төрлүүдээр хичээллэх боломж нэмэгдсэнийг харуулж байна.

Дүгнэлт

Судалгааны үр дүнгээс дараах дүгнэлтүүдийг гаргаж байна. Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн статистик судалгааг сайжруулах, түүнийг олны хүртээл болгох талаар холбогдох байгууллага, холбоод тодорхой арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл байх үндсэн нөхцөл нь хөдөлгөөн биеийн тамир спорт гэдгийг олон нийтэд сурталчлах нөлөөллийн ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, холбоод зохион байгуулах шаардлагатай байна.
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд, паралимпийн хөдөлгөөнийг дэлгэрүүлэх, спортын аль нэг төрлөөр хичээллэх, паралимпийн спортын тэмцээн уралдаанд оролцуулах явдал чухал байна.
4. Пара спортын холбоодын ангиллыг бэрхшээлээр нь менежментийн хүрээнд хувааж хамтарч ажиллах, бие биеээ ойлгох, дэмжиж туслах, хамт олонд түшиглэсэн сэргээн засах төвүүдийг олноор бий болгох ажлуудыг нийтийн хүртээл болгох судалгааны ажлуудыг эхлүүлэх шаардлагатай байгаа нь ажиглагдав.
5. Хөгжлийн бэрхшээлийн ангиллаас хамааран тамирчдын оролцох паралимп, тэмцээн өөр өөр байдаг учраас хараа, сонсголын бэрхшээлтэйгээс бусдыг хөдөлгөөний бэрхшээлтэй гэж нэрлэвэл зохистой юм гэсэн дүгнэлт хийж байна.

Санал

Хөгжингүй орнуудын туршлагаас харахад хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тамирчдад зориулсан спорт комплекс, сургалтын төвүүдтэй байдаг бөгөөд тийм ч учраас тамирчид амжилт гаргах үндсэн нөхцөл бүрдэж байдаг байна. Үүний адил манай улс ордонтой болж, тамирчид болон ХБИргэд ордонд ирж аль нэг гэмтлээ засах, харин тамирчид нь тэмцээн, олимпд оролцох бэлтгэлээ хангадаг байх нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нийгмийн сайн сайхны үйлс, харин тамирчдад тэмцээн, олимпд амжилт гаргах үндсэн тулгуур хүчин зүйл болох юм гэсэн шинэ саналыг дэвшүүлж байна.

Зохиогчийн тухай

Жамбаа овогтой Загас нь 1987 онд УБДС-ийг Биеийн тамир-Цэрэгжилтын багш, хос мэргэжлээр төгссөн. 2002 онд МУБИС “Өсвөрийн волейболчдын бие бялдрын түвшинг Азийн орны өсвөрийн волейболчидтой харьцуулсан судалгаа”сэдвээр Боловсрол судлалын магистрийн зэргийг хамгаалсан. 2010 онд МУБИС-ийн докторантурт орж суралцсан. 2018 оноос МУЭИС-ийн докторант. 2020 онд МУЭИС ийг “Монголын Паралимпийн байгууллагын хөгжлийн судалгаа”сэдвээр Бизнесийн удирдлагын доктор Ph.D-ын зэрэг хамгаалсан.

АШИГЛАСАН НОМ СУРАХ БИЧИГ

1. Оюунбат Н, Загас Ж. Паралимпийн спорт. УБ. 2015.10-12 тал
2. Бордох. Д , Спортын менежмент. УБ. 2001. 16-18 тал
3. Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагын тайлан 2009, 2010, 2015. 4-11 тал
4. World report on Disability. Work and employment. 2018. Pp 3-4
5. UNESCO. Education in disability. 2018 Pp 14-15.
6. История “ Паралимпийского спорта” (2011), Москва.
7. <https://www.statista.com/statistics/815903/paralympics-number-athletes/>
8. <https://www.paralympic.org/athletics/rankings>

**ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ БОЛОВСРОЛ, ХЭРЭГЖҮҮЛЭХ
ХЭЛБЭР, БАГШ МЭРГЭЖИЛТНИЙ АСУУДЛЫГ СУДАЛСАН НЬ**

(гадны улсын жишээн дээр)

Г.Батцэнгэл¹

Б.Золзаяа²

^{1,2}МУБИС, Тусгай хэрэгцээт боловсролын тэнхим

Удиртгал

Дэлхий дахинд 93 сая орчим хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна гэж 2013 онд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх дэлхийн тайланд тэмдэглэсэн. НҮБ-ын ерөнхий ассамблейгаас баталсан Хүүхдийн Эрхийн Конвенцид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нь тусгай халамж болон ижил тэгш харьцааг хүлээн авах эрхтэй, боловсрол хүний үндсэн эрх, хүүхэд бүр өөрийн онцлогт тохирсон орчноор хангагдах эрхтэй гэж заасан. “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай” НҮБ-ын конвенцид хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хүлээн зөвшөөрч, тэгш хамруулан сургах боловсролын тогтолцоог бий болгох талаар тодорхой тэмдэглэсэн. 2012 онд БНСУ-ын Инчеон хотод баталсан Ази, Номхон далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх “Эрхийг бодит болгоё” стратегийн хоёрдугаарт, бага дунд боловсролд хамрагдалтын тоог нэмэгдүүлэхийг тэргүүлэх зорилт болгосон.

Монгол улс олон улсын конвенц, болон дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд сүүлийн жилүүдэд бодлого, хууль эрх зүйн орчин болон хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нилээд ахиц өөрчлөлтийг хийж байгаа бөгөөд 2019 онд БСШУС-ын сайдын “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ЕБС-д тэгш хамруулан сургах” А/292 тоот тушаал батлагдсан. Тушаалыг сургуулийн амьдрал практикт хэрэгжүүлэхэд гол үүргийг тусгай хэрэгцээт боловсролын багш, мэргэжилтэн гүйцэтгэх бөгөөд түүний үүрэг, үйл ажиллагаа, зохион байгуулалтын хэлбэрийг тодорхойлох нь чухал бөгөөд бид энэ талаарх гадаад орны туршлагаас судалж үзлээ.

Түлхүүр үг: Тэгш хамруулан сургах боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тусгай анги, дэмжлэгийн ажилтан

Зорилго

Монгол улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ЕБС-д тэгш хамруулан сургах үзэл санааг хэрэгжүүлэх зохион байгуулалтын хэлбэр, багш мэргэжилтний үүрэг, оролцоо, ажиллах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох

Зорилт

- Тэгш хамруулан сургах боловсролын (цаашид ТХСБ) талаарх гадаад орны бодлого, хууль эрх зүйн орчин, үйл, ажиллагааг судлах, өөрийн орны нөхцөл байдалтай харьцуулах
- ТХСБ-ыг хэрэгжүүлэх боловсролын үйлчилгээний хэлбэр, багш, мэргэжилтний үүрэг хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох

Судалгааны арга зүй

Зарим улс орнуудын болон Монгол улс дахь тэгш хамруулан сургах боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудал, холбогдох баримт бичгийг судалж, Монгол улс дахь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамруулж буй өнөөгийн байдлын талаар багштай ярилцах.

Судалгааны тойм

I. Зарим улс орны тэгш хамруулан сургах боловсролыг хэрэгжүүлж буй байдал

1. Англи улс дахь тэгш хамруулан сургах боловсрол

Англид “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд” гэсэн хэллэгээс илүү “Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхэд (Children with Special Educational Needs : SEN)” гэсэн ойлголтыг хэрэглэдэг байна. Энэ нь анагаахын оношинд суурилсан хөгжлийн бэрхшээлээс өөр ойлголт бөгөөд хүүхэд бүрт шаардлагатай хэрэгцээ, түүнд тохирсон боловсролын үйлчилгээг илэрхийлсэн нэр томъёо юм. Дээрх “Хувь хүн бүрийн боловсролын хэрэгцээ” гэсэн ойлголтыг 1978 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын судалгааны хорооноос гаргасан “Варнокийн тайлан”-д тэмдэглэсэнээр “Боловсролын тусгай хэрэгцээ, Special Educational Needs:SEN” хэмээх үзэл санаа дэлгэрч эхэлсэн. Үүнээс өмнө Англид тусгай хэрэгцээт боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлийг анагаахын үүднээс тулгуур хөдөлгөөний бэрхшээл, хараагүй, сонсголгүй, сул хараатай, сул сонсголтой, хүнд өвчтэй, чихрийн шижин, боловсролын хоцрогдол, хэл ярианы бэрхшээл гэх мэт ангилалд хуваан тодорхойлж байжээ. Хэдийгээр хөгжлийн бэрхшээлийг зөвхөн хувь хүний хүчин зүйл гэж үзсэн хэдий ч хүүхэд бүрт шаардагдах боловсролыг олгож чадахгүй байна хөгжлийн бэрхшээлтэй, бэрхшээлгүй гэж анагаах ухаан, эмгэг

судлалын үүднээс оношлох бус харин суралцахад үүсч буй саад, бэрхшээлийг авч үзэх шаардлагатай гэсэн боловсролын шинэ үзэл хандлагыг гаргаж ирсэн байна. 1995 онд “Хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхалтыг хориглох хууль”, 1996 онд “Боловсролын тухай хууль”-д “Ердийн хэлбэрийн сургуульд, боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийг сургах үүрэгтэй” талаар зааж өгсөн. 2001 оны “Боловсролын тусгай хэрэгцээ ба Хөгжлийн бэрхшээлийн хууль” –д бүх хүүхэд ердийн сургуульд боловсрол эзэмших шаардлагыг бэхжүүлэх, ТХСБ-ыг эрчимтэй хэрэгжүүлэхэд анхаарч 1996 оны “Боловсролын тухай хууль”-ийг шинэчлэн улмаар “Хүүхдэд боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатайг нотолсон “онош, шийдвэр” байгаа, байхгүйг үл харгалзан бүх хүүхэд ЕБС-д суралцана” гэж заажээ. Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийг ЕБС-д сургахын тулд Засгийн газраас олон төрлийн арга хэмжээг авсан байна. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй болон боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхэд нь ЕБС дахь “Анги, нэгж, /Unit/” эсвэл “Боловсролын тусгай хэрэгцээт анги, /SEN Unit/” буюу “Тусгай ангид” ихэвчлэн суралцаж байна. Гэвч ЕБС-д суралцдаг хэдий ч эцэг эхийн хүсэлт болон хүүхдийн бодит нөхцөл байдалд үндэслэн “Тусгай сургууль”-д шилжин суралцдаг жишээ цөөнгүй. Мөн ЕБС–ийн багш, сурган хүмүүжүүлэгч нь боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхэдтэй ажиллах мэдлэг чадвар дутагдалтай учир тусгай сургуулийн мэргэжлийн багш, мэргэжилтнээс зөвлөгөө, дэмжлэг авч ажиллаж байна. Дээрх байдалд үндэслэн зарим бүс нутагт “Боловсролын тосгон” гэсэн шинэ загварыг эхлүүлжээ. Энэ нь ердийн хэлбэрийн ЕБС, тусгай сургууль нэг дор байх бөгөөд хүүхэд багаасаа, хүн бүр ялгаатай гэдгийг ойлгож хамтран суралцах, багш, мэргэжилтнүүд хамтран ажиллах боломжийг бүрдүүлсэн байна.

2. Итали улс дахь тэгш хамруулан сургах боловсрол

Итали улсад 1970 оноос эхлэн цэцэрлэгээс их сургууль хүртэлх боловсролын бүх түвшинд ТХСБ-ыг хэрэгжүүлж байна. Үүнээс өмнө хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролыг ялгаатай авч үздэг байжээ. Тухайлбал ЕБС-ийн тусгай ангид оюун ухаан, хөдөлгөөний бэрхшээл, сул хараатай, сул сонсголтой хүүхдийг, тусгай сургуульд оюун ухаан, хөдөлгөөний бэрхшээлтэй, бүрэн хараагүй, бүрэн сонсголгүй хүүхдийг хамруулж байсан. 1969 онд өрнөсөн "Халуун намар" ардчиллын

хөдөлгөөнд сэтгэцийн эмгэгтэй иргэдэд зориулсан байгууламжуудыг нураах, сургуулиудыг ардчилах зэрэг хөдөлгөөн Италийг бүхэлд нь хамарч, боловсролын бодлого, эрх зүйг 1970-аад оноос аажмаар шинэчлэн найруулсан. Энэ хуулиар хүүхэд өөрийн амьдарч буй бүс нутагтаа ЕБС-д хөнгөнөөс хүнд хэлбэрийн бэрхшээлтэй бүх хүүхэд элсэн суралцах боломжтой болсон. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд элсэн суралцах боломжтой сургалтын байгууллагуудыг авч үзвэл “ЕБС”, “Тусгай сургууль”, “ЕБС дахь тусгай анги” юм.

2008 онд Европын тусгай хэрэгцээт боловсролын байгууллага"-аас гарсан статистик мэдээгээр Италийн ЕБС-ийн энгийн ангид 170000 /99,6%/, тусгай ангид 0, тусгай сургуульд 693 суралцагч /0,4%/ байна. Мөн статистик мэдээнээс харахад харааны бэрхшээлийн 2, сонсголын 7 буюу нийт 9 тусгай сургууль байна. 1975 онд сенатч Франка Фалкучи тэргүүтэй Комисс нь тайланд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг бүрэн нэгтгэх сургуулийн шинэ шаардлага"-г боловсруулан гаргаж, суралцах чадварыг үнэлэхдээ уламжлалт хандлагыг халж, сурагч өөрийн чадварыг бүрэн илэрхийлэх, хөгжүүлэхэд бодит аргуудыг ашиглаж, эзэмшсэн мэдлэгийг үнэлэх хэрэгтэй. Энгийн сургуулиуд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нийгэмшүүлэх, хөгжүүлэхэд, харилцааны ур чадвар олгоход чиглэсэн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ёстой бөгөөд сургуулийн үүрэг бол хүүхдийг соёлтой нийгэмшсэн иргэн болгон өсөх явдал. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургалтын үйл ажиллагаанаас гадна үлдэхээс сэргийлж нэг анги бүлгийг зөвхөн анги удирдсан багш хариуцахаас гадна дэмжлэгийн ажилтан, туслах багшийн орон тоог бий болгох хэрэгтэйг заажээ. Үүнтэй холбогдуулан Орон нутгийн засаг захиргаа, сургууль, олон нийтийн эрүүл мэндийн байгууллагууд хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хүртээмжтэй боловсрол олгох хөтөлбөр боловсруулна гэж заажээ. Тухайлбал хүүхдүүд зөвхөн сургууль доторх төдийгүй сургуулийн гаднах үйл ажиллагаанд хүртээмжтэй оролцох, сургууль нь төрөлжсөн төвүүдтэй хамтран ажиллах замаар сургалтын хэрэглэгдэхүүн, туслах тоног төхөөрөмжийг бүрдүүлэх боломжтой. Үүнээс гадна улсаас дэмжлэгийн ажилтанг, хотын захиргаанаас туслах багшийг, аймаг мужаас харааны болон сонсголын бэрхшээлтэй хүүхдэд туслах ажилтнаар хангах үүргийг хүлээнэ. Туслах багш нарын хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд

ганцаарчилсан дэмжлэг өгөхөөс гадна, анги удирдсан багшийн хамт ангийг хамтдаа удирдан зохион байгуулах, бусад багш нартай хамтран ганцаарчилсан дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулах үүрэгтэй. Туслах багшаар боловсролын мэргэжилтэн бус халамжийн ажилтан ажиллана. Туслах багш нь олон хэлбэртэй бөгөөд тулгуур эрхтний, оюун ухааны бэрхшээлтэй хүүхдэд туслах багшийг хотын захиргаанаас, сонсголын бэрхшээлтэй хүүхдэд харилцаа холбооны ажилтан, харааны бэрхшээлтэй хүүхдэд туслах багшийг аймаг, мужийн ажилтан ажиллана гэх мэтээр зааж өгсөн байна.

3. Австрали улс дахь тэгш хамруулан сургах боловсрол

Австрали улс 2005 онд гаргасан “Боловсрол дахь хөгжлийн бэрхшээлийн стандарт” журамд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нь бусад хүүхдүүдтэй адил сургалтын байгууллагад элсэн суралцах эрхтэйг заасан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах сургалтын байгууллагыг “Тусгай сургууль”, “ЕБС дахь Дэмжлэгийн анги”, “ЕБС-ийн анги” гэсэн хэлбэрт хуваажээ. Хүүхэд болон эцэг эхийн хүсэлт, хүүхдийн бэрхшээлийн нөхцөл байдлаас хамаарч дээрх байгууллагуудад элсэн суралцах боломжтой бөгөөд заавал бэрхшээлийг тодорхойлсон оношийн бичигтэй байх шаардлагагүй. Учир нь тусгай хэрэгцээт боловсролын мэргэжилтэн хүүхдийн нөхцөл байдал, суралцах үйл явцыг ажиглан бусад хүүхдүүдийн адил үр дүнтэй суралцах боломжгүй гэж үзвэл тухайн хүүхдийг “Боловсролын тусгай дэмжлэг шаардлагатай” хэмээн үзэж шаардлагатай, тохирсон арга хэмжээг авч эхэлдэг байна. Хэрэв хүүхэд ЕБС-д суралцаж байгаа бол тухайн бүс нутгийн боловсрол хариуцсан байгууллагаас “Тусгай мэргэжилтэн” томилон ажиллуулдаг байна. Жишээлбэл, харааны, сонсголын бэрхшээл, аутизмын хүрээний эмгэгтэй суралцагчийн хувьд тухайн суралцагч, түүний эцэг эх, ажиллаж буй багшид дэмжлэг өгөх зорилгоор сургалт семинар хийх, тусгай боловсролын мэргэжилтэн зочин багшаар ирж ажиллан, анги удирдсан багштай хамтран ажиллаж, хичээлийн хөтөлбөр, үнэлгээнд дэмжлэг, зөвлөгөө өгдөг байна. 2013 оны байдлаар ЕБС-д нийт 1600 “Дэмжлэгийн анги”-д дэмжлэгийн 1911 багш мэргэжлийн зөвлөгөө өгч ажиллаж байна.

4. Франц улс дахь тэгш хамруулан сургах боловсрол

2005 онд баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, боломж, тэгш байдал, оролцоо, иргэний харьяаллын тухай хууль”-д Хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран хүүхэд бүр өөрийн гэрт хамгийн ойр ЕБС-д суралцах эрхтэйг тусгасан. Энэ хуулийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ЕБС-д элсэн суралцаж байгаа боловч цөөнгүй хүүхэд “Тусгай анги”-ийн хэлбэрээр сургалтын үйлчилгээг авч байна. 2009 оны статистик мэдээгээр бага боловсролын түвшинд 120000 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, үүнээс ойролцоогоор 41000 хүүхэд тусгай ангид, дунд боловсролын түвшинд 67000 хүүхэд, үүнээс 17000 хүүхэд тусгай ангид суралцаж байна. Мөн дээрх хуулиар тэгш хамруулан сургах боловсролыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд сургууль бүрт үгчилбэл “Сургууль дахь үйл ажиллагаанд туслах ажилтан” буюу AVS (auxiliaires de vie scolaire) орон тоог тодорхойлж сургууль дээр байх хугацаанд дэмжих ажилтан ажиллуулах шаардлагатайг заажээ. 2010 онд дунд сургуулийн түвшинд “Тусгай анги”-ийг “Тэгш хамруулан сургах харьяа нэгж” болгон нэрлэж үйл ажиллагааг илүү үр дүнтэй болгохоор зорьсон. 2011 оноос ЕБС-д суралцагчдыг дэмжих зорилгоор “Ганцаарчилсан сургалтын туслах” буюу AVS-i (Auxiliaire de Vie Scolaire Individuel), “Бүлгийн үед дэхь боловсролын туслах” AVS-co (Auxiliaire de Vie Scolaire Collectif), мөн “Боловсролын туслах” буюу ASCO-г (Assistants de scolarisation) ажиллуулах болсон байна.

5. Америк дахь тэгш хамруулан сургах боловсрол

Америкийн ТХСБ-ын талаарх сүүлийн үеийн шинэчлэл, чиг хандлагаас авч үзвэл, 1965 оны “Бага, дунд боловсролын тухай хууль”-ийг 2015 онд шинэчлэн боловсруулж “Хүүхэд бүрийг амжилтад хүргэх боловсролын тухай хууль, (Every Student Succeeds Act)” –ийг боловсруулсан. Энэ хуулиар (1) Санхүүгийн хувьд эмзэг бүлгийн хүүхдүүд, (2) арьс өнгө, үндэсний цөөнхийн, (3) хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, (4) англи хэл мэдэхгүй хүүхдүүдийг боловсролоос ялгаварлан гадуурхахгүй байх, боловсролд тэгш хамруулна гэж заасан. Мөн хуулиар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бага, дунд шатны боловсролд элсэн суралцуулж, чанартай боловсрол олгохыг тусгасан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нь боловсролд үнэ төлбөргүй хамрагдах, “Хамгийн бага хязгаарлалттай орчин”-д суралцах, бусад хүүхдүүдийн хамт суралцах боломжоор хангагдах ёстой. Тиймээс

хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 95% нь “ЕБС” (regular school) -д” суралцаж байгаа бол үлдсэн 5% нь “Тусгай сургууль (special school) , ”Гэр, эмнэлэг”, “Засан хүмүүжүүлэх газар” зэрэгт суралцаж байна. Мөн Америкт ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг (IEP) боловсруулахдаа хүүхэд ердийн ангид хэдэн цаг (хэдэн хувь) суралцах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн тусгай сургалтыг цагийг тогтоохыг заасан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсролын тухай хуулийн 300.34-т ЕБС-д сургуульд суралцаж буй хүүхдийн боловсролын чанар, хүртээмжийг сайжруулахад зөвхөн боловсролын байгууллага бус бусад холбогдох байгууллагууд хамтран оролцож үйлчилгээ үзүүлэх шаардлагатайг тэмдэглээд тэдгээрийн үүрэг, оролцоог нь зааж өгсөн байна. Боловсролын бус байгууллагын үйлчилгээг “Нэмэлт үйлчилгээ” гэх бөгөөд үүнд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай боловсролыг дэмжих унаа тээвэр, хэл засал, сонсгол дэмжих үйлчилгээ, орчуулга, сэтгэл засал, хөдөлгөөн засал, хөдөлмөр засал, хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэлт, үнэлгээ, сэргээн засал гэх мэт зөвлөх үйлчилгээнүүд, шилжилт хөдөлгөөн дэмжсэн үйлчилгээ, оношлогоо, үнэлгээ хийх зорилготой эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг хүүхдийн хөгжлийн, дэмжлэгийн үйлчилгээнүүдийг оруулжээ. Мөн нэмэлт үйлчилгээнд сургууль дээр үзүүлдэг эрүүл мэнд, нийгмийн ажлын, эцэг эхэд зөвлөгөө өгөх үйлчилгээ багтдаг байна.

6. Япон улс дахь тэгш хамруулан сургах боловсрол

Япон улс нь ЕБС дахь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дараах хэлбэрийн боловсролын үйлчилгээнд хамруулж байна. Хүүхэд тохирох үйлчилгээг сонгоно.

1. Тусгай сургууль
2. Ердийн хэлбэрийн ЕБС-ийн анги
3. Ердийн хэлбэрийн ЕБС дахь “Тусгай анги”

Бага, дунд сургуульд байх бөгөөд нэг ангид хамгийн ихдээ 8 суралцагч байна. Дараах бэрхшээлтэй хүүхдийг хамруулж байна.

- Сул хараатай
- Сул сонсголтой

- Оюуны бэрхшээл
 - Тулгуур эрхтний бэрхшээлтэй
 - Бие эрхтний бэрхшээлтэй
 - Бусад
4. Ердийн хэлбэрийн ЕБС дахь “Нөөц анги”

“Нөөц анги” нь бага, дунд сургуульд үйл ажиллагаагаа явуулах бөгөөд нэг ангид хамгийн ихдээ 13 суралцагч байна. Дараах бэрхшээлтэй хүүхдийг хамруулж байна.

- Сул хараатай
- Сул сонсголтой
- Хэл ярианы бэрхшээлтэй
- Аутизмын хүрээний эмгэгтэй
- Сэтгэцийн эмгэгтэй
- Суралцахуйн бэрхшээл
- Анхаарлын дутмагшил -хэт хөдөлгөөнтөх эмгэг
- Бусад

Янз бүрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тохирох боловсролын үйлчилгээнд хамрагдаж сургалтын үйл ажиллагаанд бүрэн дүүрэн оролцоход нь дараах хэлбэрийн хүний нөөцөөр дэмжиж байна.

а. “Тусгай хэрэгцээт боловсролын ажилтан”

Японы Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухааны яам, бага болон дунд шатны бүх сургууль “Тусгай хэрэгцээт боловсролын ажилтан”-тай байхыг зөвшөөрч гүйцэтгэх үүргийг “ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн анги хоорондын шилжилт хөдөлгөөн, хувцаслалт, хооллолт гэх мэт өөртөө үйлчлэх үйл ажиллагааг дэмжих, хүүхдийн аюулгүй байдлыг хангах, суралцах үйл ажиллагааг дэмжих буюу самбарт дахь зүйлийг уншиж өгөх, багшийн хэлснийг давтан хэлэх, хичээлийн хэрэглэгдэхүүнийг хэрэглэх, биеийн тамирын хичээлийн явцад дэмжлэг үзүүлэн ажиллана” гэж зааж өгсөн байна.

б. Тусгай хэрэгцээт боловсролын зохицуулагч

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Бага, дунд боловсролын хуулинд “Бүх сургуульд тусгай хэрэгцээт боловсролын зохицуулагч авч ажиллуулах боломжтой”- г зааж өгсөн байна. Тусгай хэрэгцээт боловсролын зохицуулагч нь сургуулийн зөвлөл, сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, удирдах, мөн холбогдох байгууллага, сургуультай холбоо тогтоох, зохицуулах, эцэг эхтэй зөвлөлдөх үүрэг гүйцэтгэнэ. Мөн анги удирдсан багш нарт зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх, мэргэжлийн байгууллага, мэргэжилтэнтэй холбогдон ажиллаж ганцаарчилсан сургалтын хөтөлбөрийг сайжруулахад хамтран ажиллах зэрэг үүрэг гүйцэтгэн ажиллахыг заажээ.

7. Орос улс дахь тэгш хамруулан сургах боловсрол

ОХУ, 2012 онд НҮБ-ын “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн конвенци” - д нэгдэж, хөгжлийн бэрхшээлтэй хүнд ижил тэгш боломж олгох, ялгаварлан гадуурхахгүйгээр боловсрол эзэмших эрхийг хангах, боловсролын бүх түвшинд тэгш хамруулан сургах боловсролын үзэл санааг хөгжүүлэх үүргийг хүлээн авч, 2012оны 12-р сарын 29 нд “ОХУ-ын боловсролын тухай” № 273 тоот холбооны улсын хуулийг баталж, 2013 оны 1-р сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.

Боловсролын тухай хууль “ Тэгш хамруулан сургах боловсрол” (инклюзивное обучение) нэр томъёог ...боловсрол эзэмших хувийн боломж, боловсролын өвөрмөц, янз бүрийн хэрэгцээг нь харгалзан бүх суралцагсдад боловсрол эзэмших тэгш, хүртээмжтэй орчноор хангах” гэж тодорхойлсон. ТХСБ-ыг дараах хэлбэрийн боловсролын үйлчилгээгээр хэрэгжүүлж байна. Үүнд:

- ЕБС-д бусад хүүхдүүдтэй хамт, нэг ангид (инклюзивное обучение)
- ЕБС-ийн дэргэдэх тусгай анги болон бүлэгт (интегрированное обучение)
- Боловсролын тусгай байгууллагад: тусгай цэцэрлэг, тусгай сургуульд (дифференцированное обучение)

Хүснэгт 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх боловсролын үйлчилгээний хэлбэр, ажиллах багш, мэргэжилтэн

Улс	Сургалтын байгууллага	Ажиллаж буй мэргэжилтэн, ажилтан
Англи	Ердийн хэлбэрийн ЕБС Тусгай сургууль	Тусгай сургуулийн мэргэжилтэнтэй хамтран ажилладаг

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

	Тусгай анги	
Итали	Ердийн хэлбэрийн ЕБС Тусгай сургууль Тусгай анги	Дэмжлэгийн ажилтан Туслах ажилтан Туслах багш
Австрали	Ердийн хэлбэрийн ЕБС Тусгай сургууль Дэмжлэгийн анги	Тусгай хэрэгцээт боловсролын мэргэжилтэн
Франц	Ердийн хэлбэрийн ЕБС Тусгай анги	Туслах ажилтан Ганцаарчилсан, боловсролын туслах Бүлгийн, боловсролын туслах Боловсролын туслах
Америк	Ердийн хэлбэрийн ЕБС Тусгай дэмжлэгийн сургууль Гэрийн, эмнэлэг	Хэл засалч Хөдөлгөөн засалч Хөдөлмөр засалч Сэтгэл засалч Мэргэжлийн нийгмийн ажилтан Сэргээн засах зөвөлгөө Орчуулагч гэх мэт
Япон	Ердийн хэлбэрийн ЕБС Тусгай сургууль Нөөц анги	Тусгай хэрэгцээт боловсролын ажилтан Тусгай хэрэгцээт боловсролын зохицуулагч
Орос	Ердийн хэлбэрийн ЕБС Тусгай анги Тусгай сургууль	Багш Туслах ажилтан Тусгай боловсролын багш

II. Монгол улс дахь тэгш хамруулан сургах боловсролыг хэрэгжүүлж байдал

а. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын нөхцөл байдал

Монгол улс 1990 онд НҮБ-ын “Хүүхдийн Эрхийн Конвенци”-д, 2009 онд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” конвенцид тус тус нэгдэн орсноор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох орчин, нөхцөлийг хүүхэд бүрийн онцлогт тохируулан бүрдүүлэх үүргийг Монгол улсын Засгийн газар хүлээн авсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад чиглэсэн Монгол улс дахь хууль, эрх зүйн зохицуулалтаас авч үзвэл:

1. 1992 он, Монгол улсын Үндсэн хууль
2. 2002 он, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль
3. 2002 он, Боловсролын тухай хууль
4. 2002 он, Бага, дунд боловсролын тухай хууль
5. 2003 он, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах хөтөлбөр
6. 2005 он, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль
7. 2016 он, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль
8. 2019 он, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ЕБС-д тэгш хамран сургах журам, БСШУС-ын сайдын тушаал зэрэг болно.

Манай улсад 2019 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 107 мянган иргэнээс 11606 нь хүүхэд байна. ЕБС-д 6053 хүүхэд сурч байгаагаас 1751 нь УБ хотын 6 тусгай сургуульд суралцаж байна. ЕБС-д суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсролын чанартай үйлчилгээг үзүүлэхийн тулд 2018 онд ЭМ, ХНХ, БСШУС-ын сайдын хамтарсан тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар”-ыг баталсан бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хүүхдийг хүлээж авсан сургууль “Дэмжлэгийн баг” байгуулж ажиллана гэж заасан. “Дэмжлэгийн багийн” бүрэлдэхүүнд, сургуулийн удирдлага, нийгмийн ажилтан, сургуулийн эмч, анги удирдсан багш, бусад хичээл заах багш ажиллаж байна. Энэхүү дэмжлэгийн баг нь шаардлагатай хүүхдэд “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө” боловсруулах, төлөвлөгөөг засаж сайжруулахаас гадна хүүхдийн өвөрмөц хэрэгцээнд нийцсэн тохирох хэрэглэгдэхүүн байгаа эсэхэд хяналт тавина. Сургууль өөрийн дотоод нөөц бололцоогоор шийдвэрлэх боломжгүй тохиолдолд боловсролын байгууллага, эрүүл мэнд, халамжийн мэргэжилтэн, орон нутгийн байгууллага, хамт олонтой хамтран ажиллаж шийдвэрлэнэ” гэсэн байна.

б. ЕБС-ийн багш нартай хийсэн ярилцлага, үр дүн

Манай улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах үйл ажиллагааг үр ашигтай хэрэгжүүлэхээр олон ажил хийж байгаа боловч бодит байдалд сургалтын орчин, олон нийтийн хандлага, багш боловсон хүчний мэдлэг, чадвар бүрэн хангагдаагүй хэвээр байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

боловсролд тэгш хамруулахад гол үүрэг хүлээх багш нарын ойлголт, тулгамдаж буй асуудлын талаар ярилцлага авсан бөгөөд энэхүү судалгааны ажилд зарим мэдээллийн үр дүнг оруулсан. Судалгаанд Улаанбаатар хотын ЕБС-ийн 150 багшийг хамруулсан.




График 1. Та өөрийн, ХБХ-ийн боловсролын талаарх мэдлэгээ хэрхэн дүгнэж байна вэ?

Судалгаанд оролцсон нийт багшийн 68 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын талаарх мэдлэгээ “Муу” гэж дүгнэсэн бол 9.3 хувь “Сайн” гэсэн хариу өгсөн нь ЕБС дахь багшийн ойлголт мэдлэг хангалтгүй байгааг харуулж байгаа бөгөөд тэдэнд энэ талаарх сургалт, семинар, мэргэжилтний зөвлөгөө, хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай байна.




График 2. Та ХБХ-ийн боловсролын талаар сургалтад хамрагдаж байсан уу?

Багш нар, ХБХ болон тэгш хамруулан сургах боловсрол, тусгай хэрэгцээт боловсролтой холбогдолтой сургалт, семинарт хамрагдах нь цөөн байгаа нь эдгээр хүүхдүүдэд тохирсон боловсролын үйлчилгээг үзүүлэхэд хүндрэл учруулж байна.



График 3. ХБХ-тэй ажиллахад тулгарч буй асуудал юу вэ?

ЕБС-т ажиллаж буй багш нар сургалт, семинарт хамрагдах нь цөөн учир хүүхэдтэй ажиллах арга зүйг оновчтой сонгох, ажиллахад хүндрэл гарч байна гэж судалгаанд хамрагдагсдын 62.6 хувь хариулсан. Мөн шаардлагатай үед хэнээс мэргэжлийн зөвлөгөө авахаа мэддэггүй, сургалтын үйл ажиллагааг явуулахад нэмэлт хэрэглэгдэхүүн дутагдаж байна гэж хариулжээ.



График 4. ХБХ-тэй ажиллахад танд ямар тусламж, дэмжлэг шаардлагатай байна вэ?

Судалгаанаас харахад, багш нарт ХБХ-ийн боловсролын талаарх мэдлэгээс гадна шаардлагатай үед хамтран ажиллах мэргэжилтэн мөн нэг бүлэг дэх хүүхдийн тоо олон тул дэмжин туслах багш, туслах ажилтан хэрэгтэй байгааг тэмдэглэжээ.

Манай улсын хувьд сүүлийн жилүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн хэлбэрийн сургуульд тэгш хамруулан сургахаар олон ажлыг хийж байгаа боловч бодит байдалд бүрэн хэрэгжүүлж чадахгүй байна. Үүний гол шалтгаан нь багш боловсон хүчний мэдлэг, чадвар, хүртээмжгүй орчин гэж холбогдох

байгууллагуудын хийсэн судалгаа болон багш нартай хийсэн ярилцлага, судалгааны зарим тайлангийн үр дүнгээс харагдаж байна. Жишээлбэл, 2015- 2019 онд хэрэгжүүлсэн ЖАЙКА ОУБ-ын “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн судалгааны тайланд туршилтын сургуулиудад хийсэн үр дүнгээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хүлээж авахад бэлэн биш шалтгааныг асуухад сургалтын материал, хэрэглэгдэхүүн хангалттай бус, багш нарын арга зүй, ур чадвар хангалтгүй, “Ачаалал ихтэй” гэсэн хариултыг дийлэнх багш өгсөн байна. Харин тусгай сургуулийн багш нар ердийн сургуулийн багш нартай хамтран ажиллаж, зөвлөгөө өгсний дараа багш нарын хандлага, заах арга зүй ихээр өөрчлөгдсөн, багш нарт мэргэжлийн дэмжлэг, тусламж шаардлагатай талаар тэмдэглэсэн байна. Мөн 2018 онд IRIM судалгааны хүрээлэнгээс гарсан “Монгол улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь” судалгааны тайлангийн ЕБС-ийн багш нарыг хамруулсан судалгааны дүнгээр “Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллахад, ажиллах арга зүй, тусгай хэрэгцээтэй хүүхдийн хөгжлийн онцлогт тохируулан заах ур чадвар хангалтгүй” байгаа нь ЕБС-д эдгээр хүүхдүүдийг сургахад саад, бэрхшээл болж байна гэж судалгаанд оролцогчдын 91% нь хариулсан байна. Мөн энэ судалгааны ажлын хүрээнд хийсэн ярилцлагын үр дүнгээс мөн харахад ЕБС-ийн багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад бэлэн бус, сургалтын орчин, хэрэглэгдэхүүний хувьд ч тохиромжтой бус бүрэн шийдээгүй байна. Үүнээс гадна анги удирдсан багш, хичээл удирдаж буй багшийн ачаалал их байгаа нь хүүхэд бүрт шаардлагатай заавар, арга зүйг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй буюу мэргэжилтний дэмжлэг, зөвлөгөө, нэмэлт ажилтан шаардлагатай байгааг харуулж байна. Багшид учирч буй дээрх саад бэрхшээлээс шалтгаалан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд өөрийн онцлог, хэрэгцээнд нийцсэн сургалт, дэмжлэгийн үйлчилгээг авч чадахгүй хоёрдогч саад бэрхшээлтэй тулгарч байна.

Дүгнэлт

Улс орон бүр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хандах хандлагаа өөрчлөн, боловсролд тэгш хамруулан сургахыг зорьж, улмаар өөрийн орны онцлог

тохируулан сургалтын хөтөлбөр, орчин, хэрэглэгдэхүүн, заах арга зүй, багшлах боловсон хүчнийг янз бүрийн хувилбартайгаар боловсруулан хэрэгжүүлж байна.

Монгол улс Олон улсын байгууллагын санхүүгийн дэмжлэг тусламжтайгаар тэгш хамруулан сургах боловсролыг хэрэгжүүлэх туршилтыг (Хөвсгөл аймаг, УБ хот) хийж өөрийн оронд тохирсон загварыг боловсруулан хэрэгжүүлсэн сайн эхлэл байгаа хэдий ч хүртээмж хангалттай бус байна.

Тэгш хамруулан сургах боловсролын үзэл санааг хэрэгжүүлэх гол хүч болсон багш боловсон хүчний ойлголт мэдлэг сул байгааг анхаарч энэ тал дээр ажиллах шаардлагатай байна.

Санал, зөвлөмж

- ✓ ЕБС-ийн багш, ажилтанд сургалт, семинарыг тасралтгүй явуулж байх
- ✓ Багш боловсролоос төгсөж буй багш бүр “Тэгш хамруулан сургах боловсролын” агуулгыг судалсан байх
- ✓ ЕБС-д бэрхшээлийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн дэмжлэгийн ажилтан, туслах багшийн орон тоог бий болгох
- ✓ Тусгай сургууль болон ердийн хэлбэрийн сургуулийн багш нар хамтран ажиллах
- ✓ Нэг ангид суралцах хүүхдийн тоо болон бэрхшээлийн түвшинг харгалзан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоог тодорхой болгох, хэрэгжүүлэх
- ✓ Сургалтын орчин, сургалтын нэмэлт хэрэглэгдэхүүн материалыг сургууль бүр бэлтгэж, хангадаг байх

Ашигласан материал

1. 障害のある児童生徒の就学形態に関する国際比較調査報告書, 2010年
2. 諸外国における特別支援教育の状況について, 2019年9月25日
3. 日本の特別支援教育の状況について, 2019年9月25日

4. 諸外国における障害のある子どもの教育, 国立特別支援教育総合研究所ジャーナル,第6号 2017年3月
5. 特別支援教育コーディネーターガイド, 福岡県教育委員会, 2018年10月
6. 特別支援教育支援員のためのサポートマニュアル, 茨城県教育委員会, 2012年
7. [Федеральный закон от 29 декабря 2012 г. N 273-ФЗ "Об образовании в Российской Федерации"](#)
8. IRIM, “Монгол улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь” хэрэгцээ тодорхойлох судалгааны тайлан, 2018
9. ЖАЙКА, “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн судалгааны тайлан, 2019.07

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛ БА ИННОВАЦИ

Д.Батмөнх

Хураангуй:

Монгол Улсад 2020 оны байдлаар 102 мянга гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэд амьдарч байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 50% нь ерөнхий боловсролын сургуульд элсэн ордог хэдий ч 14% нь төгсдөг. Уг шалтгаан нь сургуулийн орчин нөхцөл, сурах бичгийн хүрэлцээгүй байдал, анги танхим ширээ сандлын хүрэлцээгүй байдал, эцэг эхийн анхаарал халамжгүй байдал, багш сурган хүмүүжүүлэгчийн ур чадвар, мэдлэг боловсролгүй байдал, бусад хүүхдүүдийн ялгаварлан гадуурхалт зэрэг шалтгааныг судалгаагаар тогтоосон.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ялгаварлан гадуурхалаас ангид байлгаж, сэтгэл зүй болон бие махбодийн өсөн хөгжих, төлөвших, хувь хүн болгох зорилгоор тусгай хэрэгцээтэй сургуулийн хангамж, багш нарын ур чадвар, асрамж халамжийн үйлчилгээг сайжруулах, сургалтын орчин нөхцөл, сургуулийн гарц, шатыг стандартын дагуу болгох зэрэг арга хэмжээг авснаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийг хамгаална.

Тусгай хэрэгцээт сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургахдаа тухайн хүүхдийн сул талд тулгуурлан сургалтын арга барилыг чиглүүлж, хүүхдийн нас, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр ангилан мэргэжлийн багшаар сургалтын үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх.

Түлхүүр үг:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүн- Махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хэлнэ.
2. Боловсрол эзэмших эрх- Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дүгээр зүйлийн 16.7-д зааснаар сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх төрлийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно.
3. Тэгш, хүртээмжтэй байх- Хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран хуульд заасан заавал олгох боловсролыг эзэмшихийг хэлнэ.
4. Ялгаварлан гадуурхалт- Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т зааснаар хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно.

1.1. Сэдэв сонгосон үндэслэл

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ялгаварлан гадуурхалт, сурч боловсрох эрх нь хэрхэн зөрчигдөж байдаг талаар судалгаа хийж эдгээрээс ангид байлгаж, сэтгэл зүй болон бие махбодийн өсөн хөгжих, төлөвших, хувь хүн болгох зорилгоор тусгай хэрэгцээтэй сургуулийн хангамж, багш нарын ур чадвар, асрамж халамжийн үйлчилгээг сайжруулах, сургалтын орчин нөхцөл, сургуулийн гарц, шатыг стандартын дагуу болгох зэрэг арга хэмжээ хэрхэн авагддаг талаар судлах.

Тусгай хэрэгцээт сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургахдаа тухайн хүүхдийн сул талд тулгуурлан сургалтын арга барилыг чиглүүлж, хүүхдийн нас, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр ангилан мэргэжлийн багшаар сургалтын үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх шаардлага үүссэн учир энэхүү сэдвийг сонгосон.

1.2. Судалгааны ажлын зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн суурь боловсролын өнөөгийн байдал, хөгжлийн бэрхшээлийн боловсрол эзэмших эрх зөрчигдөж буйг судалж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тэгш хүртээмжтэй боловсрол эзэмших бололцоог олгох тэдгээрийн сурах эрхийг хамгаалах талаар санал дүгнэлт гаргаж шийдвэрлэх зорилготой.

1.3. Сэдвийн судлагдсан байдал

Save the children, IRIM “Монгол улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь” УБ2018 онд судалгаа, Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагуудын the universal periodic review-д өргөн барих УБ2010 онд хийсэн судалгаа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Жайка олон улсын хамтын ажиллагааны байгууллага “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлог, үйл ажиллагаа” УБ2017 онд судалсан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хууль, эрх зүйн орчин, стандартын хэрэгжилтийн өнөөгийн байдал” УБ2019 онд судалсан байна. World Health Organization, The World Bank

“Хөгжлийн бэрхшээлийн талаарх дэлхийн тайлан”, Сонгихайрхан дүүргийн статистикийн хэлтэс “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд-2018 онд судлагдсан байна.

1.4. Судалгааны ажлын зорилт

1. Хөгжлийн бэрхшээлийн ойлголт, төрөл
2. Монгол Улс дахь боловсролын ойлголт, тогтолцоо, бүрдэл
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн суурь боловсрол эзэмшиж байгаа байдал
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн суурь боловсрол эзэмшихэд тулгарч буй асуудал

1.5. Судалгааны хэрэглэгдэхүүн, арга зүй

Энэхүү сэдвийг судлахдаа нийслэлийн тусгай хэрэгцээт найман сургуулийн багш ажилчид, сургалтын менежерүүдээс ярилцлага, анкетын аргаар судалгааг хийж гүйцэтгэсэн. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоон болон чанарын судалгааг статистикийн ерөнхий хорооноос авч шинжлэн судалсан болно.

1.6. Шинэлэг байдал, ач холбогдол:

Энэхүү илтгэлийг бичсэнээр нийгэмд өөрсдийн эрхийг зөрчигдөж буй талаар илэрхийлж чадахгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг хамгаалах, хангах ач холбогдолтой юм.

2.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын ойлголт

Хөгжлийн бэрхшээлтэй /тусгай хэрэгцээтэй/ хүн гэж махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хэлнэ.

Тахир дутуу гэж өвчин, гэмтэл буюу оюун ухааны хомсдлын улмаас амьдралын үйл ажиллагаа нь хязгаарлагдмал болсон ба түүнд нийгэмшлийн хамгаалалт зайлшгүй шаардлагатай байгаа болон бие организмын чиг үүрэг нь үлэмж сарниж, эрүүл мэнд нь муудсан этгээд.

Хөгжлийн бэрхшээлийг эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс тогтоох ба 2 шаттай:

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

1. Комиссын бүрэлдэхүүнд аймаг, дүүргийн эмнэлгийн эмч мэргэжилтэн оролцуулсан 7-9 хүнээс бүрдэх ба дотор, мэдрэл, мэс заслын эмч, нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч, нийгмийн даатгалын хэлтсийн магадлагч эмч, нийгмийн халамж үйлчилгээний байгууллага, ажил олгогчийн төлөөлөл, даатгалуулагч, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.
2. Төв комиссын бүрэлдэхүүнд нийгмийн даатгалын байгууллагын магадлагч эмч, эрүүл мэндийг асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөлийн шинжээч эмч нар, ажил олгогчийн төлөөлөн 15 хүнтэй байна.

Хөгжлийн бэрхшээлийн төрөл:

- Төрөлхийн хөгжлийн бэрхшээл- тухайн хүнд удамшлын шинжтэйгээр бий болсон хөгжлийн бэрхшээлийг төрөлхийн хөгжлийн бэрхшээл.
- Олдмол хөгжлийн бэрхшээл- амьдралын явцад бий болсон хөгжлийн бэрхшээлийг олдмол хөгжлийн бэрхшээл.

Хөдөлмөрийн чадвар алдалтын төрөл:

1. Хөдөлмөрийн чадвар бүрэн алдсан: 70-аас дээш хувиар алдсан
2. Хөдөлмөрийн чадвараа хагас алдсан: 50-69 хувиар алдсан

Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр:

- ✚ Харааны хөгжлийн бэрхшээл
- ✚ Хэл ярианы хөгжлийн бэрхшээл
- ✚ Сонсголын хөгжлийн бэрхшээл
- ✚ Хөдөлгөөний хөгжлийн бэрхшээл
- ✚ Сэтгэц оюуны хөгжлийн бэрхшээл
- ✚ Хавсарсан хөгжлийн бэрхшээл

Хүснэгт 1. Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүний 2015-2019 оны статистик, мэдээлэл:

№	2015	2016	2017	2018	2019
---	------	------	------	------	------

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Бүгд	101,730	100,993	103,630	105,565	107,075
Харааны	10,925	11,001	11,071	11,534	11,690
Ярианы	4,491	4,367	4,228	4,299	4,086
Сонсголын	8,406	8,560	8,5504	8,445	8,885
Хөдөлгөөний	20,110	20,1277	20,688	21,614	21,545
Оюун ухааны хомсдолтой					
Сэтгэцийн	18,433	18,359	19,733	20,321	20,728
Хавсарсан	7,912	8,052	7,842	7,288	7,334
Бусад	31,453	30,527	31,514	32,064	33,107

2.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суурь боловсрол эзэмшиж буй байдал, тулгамдаж буй асуудал

Хүснэгт 2. Монгол Улс дахь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 2017 оны статистик, мэдээлэл:

Насны бүлэг	Хүний тоо	Төрөлхийн	Олдмол
Бүгд	103,630	44,384	59,246
0-14	8,835	6,656	2,179
15-17	2,618	1,759	859

Профессор Стефее В Хокинг хөгжлийн бэрхшээлийн талаарх дэлхийн тайланд хэлэхдээ “...Хөгжлийн бэрхшээл нь амжилтад хүрэхэд саад болох ёсгүй. Би амьдралынхаа ихэнх үеийг хөдөлгөөн, мэдрэлийн өвчтэйгээр өнгөрүүлсэн боловч энэ нь намайг сансрын, физикийн салбарт амжилт олж, амьдралдаа аз жаргалтай байхад минь саад болоогүй юм.

Хөгжлийн бэрхшээлийн талаарх дэлхийн тайланг уншихад миний өөрийн туршлагатай маш их холбоотой байлаа. Би дээд зэрэглэлийн эмнэлгийн тусламж авч байсан. Намайг тав тухтай ажиллаж амьдрахад боломж олгодог хувийн туслагч нарын багт би их итгэж найддаг. Тэд миний гэр, ажлын орчныг надад хүртээмжтэйгээр тохируулж өгсөн. Компьютерийн мэргэжилтнүүд надад

харилцааны туслах систем болон ярихад мэдрэгч төхөөрөмжийг хийж өгснөөр би лекц уншиж, бичиг баримт үйлдэж, янз бүрийн хүмүүстэй харилцаж байна.

Би олон талаар маш их азтай хүн. Физикийн ухааны онолын салбарт гаргасан миний амжилт намайг үнэ цэнэтэй амьдрахад тусалсан. Дэлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ихэнх нь өдөр бүр амьд үлдэх, бүтээлч хөдөлмөр эрхлэх, хувийнхаа үүргийг гүйцэтгэхэд маш хүнд цаг хугацааг өнгөрөөдөг нь тодорхой.

Хөгжлийн бэрхшээлийн талаарх дэлхийн анхны тайланг би сайшааж байна. Энэхүү тайлан нь хөгжлийн бэрхшээлийн болон хувь хүн, нийгмийн үр нөлөөний талаарх бидний ойлголтонд гол хувь нэмрээ оруулна ...” гэж бичсэн байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч, боловсрох эрхийн хэрэгжилт нь нийгэмд тулгамдсан буй асуудал юм.

Монгол Улсад боловсролын тогтолцоо нь албан болон албан бус, насан туршийн боловсрол гэж ангилна.

- Албан боловсрол- Боловсролын албан ёсны байгууллагаар дамжуулж, сургалцагчийн ерөнхий болон мэргэжлийн зохих түвшний боловсрол эзэмших хэрэгцээг хангадаг боловсролын зохих байгуулагдсан үйл ажиллагаа.
- Албан бус боловсрол- Боловсролын албан ёсны байгууллагаар дамжуулж, суралцагчийн ерөнхий болон мэргэжлийн зохих түвшний боловсрол эзэмших хэрэгцээг хангадаг боловсролын зохион байгуулагдсан үйл ажиллагаа.
- Насан туршийн боловсрол- бүх насны иргэд боловсролын албан болон албан бус хэлбэрээр ёс суртахуун, гоо зүй, иргэн, гэр бүл, шинжлэх ухааны боловсролыг тасралтгүй эзэмших үйл ажиллагааг ойлгоно.

Боловсролын түвшинээр нь сургуулийн өмнөх болон бага, дунд, дээд боловсролоос бүрдэнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч, боловсрох эрхийг Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгэм хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Боловсролын тухай хууль гэх мэт хууль тогтоомжоор зохицуулсан боловч хэрэгжилт нь муу байна.

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ерөнхий боловсролд тэгш, хүртээмжтэй хангагдах, боловсрол эзэмшихдээ ямар нэгэн байдлаар ялгаварлан гадуурхал, суралцах орчин, нөхцөлөөр хангагдах эрх хангагдаж байгаа өнөөгийн байдал.

Монгол Улсын иргэн сурч боловсрох эрхтэй. Монгол Улсын Үндсэн хуульд заасан нь хүний ялгаатай байдлыг харгалзахгүйгээр бүх иргэнд сурч боловсрох эрх тэгш үйлчлэх болохын илэрхийлсэн.

Save the Children болон IRIM-ын 2018 онд хийсэн “Монгол Улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь” судалгааны тайланд Улаанбаатар хотын Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргийн 8 тусгай хэрэгцээт ерөнхий боловсролын сургуульд судалгаа хийсэн.

Хүснэгт 3. Тусгай хэрэгцээт хүүхдийн боловсролд хамрагдаж чадахгүй байгаа шалтгааныг багш нараас судалгаа авахад дараах үр дүн гарч байна.


№	Шалтгаан	Тоо	Хувь
1	Ар гэрийн санхүүгийн боломжгүй байдал, эцэг эхийн анхаарал халамж сул, оролцоо дэмжлэг хангалтгүй байдал	208	92.9
2	Сургуулийн дэд бүтэц, анги танхимын хүрэлцээгүй байдал, сургалтын материалын хүрэлцээгүй байдал	112	50.0
3	Хөгжлийн бэрхшээлийн онцлог, эрүүл мэндийн байдал	102	45.5
4	Багшийн мэдлэг ойлголт, ур чадвар, аргазүйн дутмаг байдал	41	18.3
5	Алслагдмал байдал, сургуулиас хол, хүргэж өгөх авах хүн байхгүй, шилжилт хөдөлгөөн	41	18.3
6	Эцэг эхийн боловсрол, мэдээлэл дутмаг байдал	40	17.9
7	Бусад хүмүүсийн хүлээн авах байдал, гадуурхал, бэрхшээлээс ичих байдал	38	17.0
8	Хүүхдийн өөрийн сурах сонирхолгүй байдал, сургууль завсардалт	23	10.3
9	Оношилгоо, үнэлгээ, судалгаа дутмаг, сургалтын хөтөлбөр тохиромжгүй	19	8.5
10	Нас хэтэрсэн болон бусад шалтгаан	12	5.4

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

График 1. Таны бодлоор тэгш хамруулан сургах боловсрол аль нь вэ? (Багш нараас авсан судалгаа)



График 2. Таны бодлоор дараах ТХХ-ийг ЕБС-д тэгш хамруулан сургах боломжтой юу? (Багш нараас авсан судалгаа)




Багш, менежерээс авсан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ЕБС-д тэгш хамруулах боломжтой эсэх судалгаагаар хөгжлийн бэрхшээлээр өөр дүн гарч байгаа боловч

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

дийлэнх нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ЕБС-д тэгш, хүртээмжтэй хамруулан сургах боломжгүй гэсэн дүгнэлт гарч байна. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхаж байна.

График 3. Та ТХХ-ийн талаарх өөрийн мэдлэг чадвараа үнэлнэ үү. (Багш нараас авсан судалгаа)



Багш нараас авсан тусгай хэрэгцээт хүүхдийн талаарх өөрийн мэдлэг чадвараа үнэлэх судалгаанаас авахад судалгаанд оролцогчдын дийлэнх нь мэдлэг чадвар хангалтгүй, муу байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 4. ТХХ-д боловсрол олгоход тулгарч буй бэрхшээл

№	Тулгарч байгаа бэрхшээл	Тоо	Хувь
1	ТХХ-ийг сургах, тэгш хамруулах аргачлал, аргазүйн, модуль, хөтөлбөр	182	81.3
2	ТХХ-тэй ажиллаж багш нарын мэдлэг, чадвар, туршлага сул	157	70.1
3	ТХХ-ийн талаарх хөгжлийн бэрхшээлгүй хүүхдүүдийн эцэг эхийн ойлголт	141	62.9
4	ТХХ-тэй ажиллах багш, ажилтнуудын хандлага сөрөг	139	62.1
5	ТХХ-ийг сургах сургалтын материал, хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж сул	113	50.4

6	ТХХ-ийн сургалтын ажилтныг үнэлэх системтэй арга хэмжээ дутмаг	103	46
7	Сургуулийн удирдлагын ТХХ-ийг сургуульд хүлээн авах сонирхол бага	93	41.5
8	ТХХ-тэй ажиллаж буй багш нарыг ажлын байранд дээр сургадаггүй	90	40.2
9	ТХСБ-ыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдээгүй	34	15.2
10	ТХХ-ийг сургах, сургуульд хүлээн авах дэд бүтэц байхгүй	33	14.7

2.3. Судалгааны үр дүн, шүүн хэлэлцэхүй

Тусгай хэрэгцээт хүүхдийг сургууль завсардахад нөлөөлж байгаа хоёр дахь хүчин зүйлд боловсролын орчин, сургуулийн дэд бүтэцтэй холбоотой бэрхшээл байна.

Судалгаанд хамрагдсан хоёр багш тутмын нэг нь ЕБС-д тусгай хэрэгцээт хүүхдийн онцлог, хэрэгцээнд нийцсэн сургалтын материал, хичээлийн хэрэглэгдэхүүн ихээхэн дутагдалтай, анги дүүргэлт өндөр, хичээлийн танхим, ширээ сандал хүрэлцээгүй байгаа нь ТХХ-ийн сургуульд хамрагдалтад нөлөөлж байна.

Чингэлтэй дүүргийн 37-р сургуульд 29 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, 39-р сургуульд 12 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, Баянзүрх дүүргийн 127-р сургуульд 39 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, 79-р сургуульд 16 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, Сонгинохайрхан дүүргийн 65-р сургуульд 45 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, 9-р 51 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байна.

Монгол Улсын иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангана гэж заасан боловч бодит байдал дээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй байх, тэгш боломж, нөхцөлөөр хангагдахгүй байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Монгол Улсад Монгол 2017 оны байдлаар 11,453 хүүхэд байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 50 хувь нь сургууль, цэцэрлэгт сурдаг боловч ердөө 14 хувь нь төгсдөг. Үүнээс харахад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч, боловсрол тэгш, хүртээмжтэй авах эрх зөрчигдөж байна.

Дүгнэлт

Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэж гэр бүл, соёл, улс төр, нийгмийн харилцаанд бүрэн дүүрэн оролцож чадахгүй хүнийг хэлнэ. Хөгжлийн бэрхшээлтэй хүн нь сэтгэцийн өвчтэй, нийгэмд аюултай хүн биш төрөлхийн болон олдмол буюу осол гэмтлийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон этгээд гэтэл нийгэмд тэднийг ялгаварлан гадуурхаж байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрх зөрчигдөж байна. Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 50% нь сургуульд сурдаг боловч 14% нь төгсдөг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тэгш хүртээмжтэй сурч боловсрох эрх сургуулийн орчин нөхцөл, дэд бүтэц, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тохирсон сурах бичгийн дутагдал, сургагч багш нарын ур чадваргүй байдал, анги танхимын дүүргэлт гэх мэт тодорхой шалтгаанаар үүдэлтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийг төрийн зүгээс анхаарал хандуулах шаардлагатай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлийн төрөл, наснаас үл хамаарч нэг ангид боловсрол эзэмшүүлж байгаа нь хүүхдийг ялгаварлан гадуурхаж, боловсролыг тэгш хүртээмжтэй эзэмших, авах эрхийг зөрчиж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тусгай сургуульд тэдэнд зориулсан сурах бичиг, энэ чиглэлээр бэлтгэгдсэн сурган хүмүүжүүлэгчээр боловсрол олгох хэрэгтэй.

Нийслэлийн 8 сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурч байгаа бөгөөд сургуулийн гарц, хаалга нь стандарт нөхцөлийг зөрчиж, сурах орчин нөхцөлөөр хангагдахгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол эзэмшихэд тэд нарт зориулсан сургалтын материал, ном сурах бичиг хангалтгүй байна.

Судлаачийн зүгээс дараах шинэ санааг гаргаж байна:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн ерөнхий боловсролын сургуульд суралцуулах, ингэхдээ нэг ангид сургахыг хориглох

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан сурах материалаар бүрэн хангуулах
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан зориулалтын шат, хаалга үүдтэй болгох
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургагч багшийн ур чадвар, мэдлэгийг сайжруулах

Ашигласан Материал

Монгол улсын хууль, эрх зүйн акт:

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 2016 он
3. Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль 1999 он
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгэм хамгааллын тухай хууль 2005 он
5. Хүүхдийн эрхийн тухай хууль 2016 он
6. Боловсролын тухай хууль 2002 он

Ном, сурах бичиг:

1. Save the children, IRIM “Монгол улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь” УБ2018 он
2. Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагуудын the universal periodic review-д өргөн барих УБ2010 он
3. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Жайка олон улсын хамтын ажиллагааны байгууллага “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлог, үйл ажиллагаа” УБ2017 он
4. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Засгийн газрын хэрэгжүүлэнч агентлаг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хууль, эрх зүйн орчин, стандартын хэрэгжилтийн өнөөгийн байдал” УБ2019 он
5. World Health Organization, The World Bank “Хөгжлийн бэрхшээлийн талаарх дэлхийн тайлан”
6. Сонгихайрхан дүүргийн статистикийн хэлтэс “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд-2018 УБ2018
7. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сурч боловсрох эрхийг хэрхэн хангаж буй талаарх мэдээлэл

ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛ ШААРДЛАГАТАЙ ХҮҮХДИЙГ БОЛОВСРОЛД ТЭГШ ХАМРУУЛАХ ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЭХ НЬ /ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЖИШЭЭН ДЭЭР/

Д.Баасансүрэн¹

¹Хөвсгөл аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын Насан туршийн боловсролын мэргэжилтэн

Хураангуй

Тэгш хамруулан сургах гэдэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамран сургах тойргийн сургуульд, тухайн насны бүлэгт бусад суралцагчдын хамт суралцуулахдаа ялгаатай байдлыг харгалзан үзэж ялгаварлан гадуурхалтгүй соёлыг төлөвшүүлэх явдал юм.

Энэ нь бүх хүүхэд хамтдаа амжилттай суралцахад учрах саад тотгорыг даван туулахын тулд орон нутгийн бодлого, дэмжлэгийн тогтолцоо, хичээлийн агуулга, заах арга, хандлага-арга зүй зэрэг үйл ажиллагаандаа тодруулга, тохируулга, өөрчлөлт хийж хэрхэн шийдвэрлэсэн байдлыг Хөвсгөл аймгийн жишээн дээр тулгуурлан авч үзсэн болно.

Түлхүүр үг

Дэмжлэгийн зөвлөл, Дэмжлэгийн баг, Тохирох хэрэглэгдэхүүн, Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, Түгээмэл загвар

Оршил

Хөвсгөл аймаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын шийдвэрээр хөгжлийн бэрхшээлтэй нь тогтоогдсон 512 хүүхэд байгаа бөгөөд 69% нь боловсролын үйлчилгээнд хамрагдаж байна. Аймгийн сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлийг 2018 онд аймгийн засаг даргын захирамжаар байгуулж 3 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна. Зөвлөл нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулахад тохиолдох саад бэрхшээлийг төр захиргааны байгууллага, орон нутгийн болон сургуулийн удирдлага, багш, эцэг эх, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын оролцоотойгоор шийдвэрлэхийг зорьж ажилладгаараа онцлог юм.

Судалгааны зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах орон нутгийн дэмжлэгийн тогтолцоо бүрдүүлж буй туршлага үр дүнг судлах

Судалгааны зорилт

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулахтай холбоотой эрх зүйн орчны судалгаа хийх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах Хөвсгөл аймгийн дэмжлэгийн тогтолцоог судлах
- Дэмжлэгийн зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнг судлах

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулахтай холбоотой эрх зүйн орчин

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийнд сурч боловсрох эрхийг заасан нь;

14 дүгээр зүйл. Сурч боловсрох эрх

14.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн бусад иргэний хамт сурч боловсрох, мэргэжил эзэмших эрхтэй бөгөөд энэхүү эрхийг нь хангах чиглэлээр төрөөс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

14.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт нийцүүлэн авьяас билэг, бүтээлч чанар, оюуны болон бие бялдрын чадварыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөр, орчныг бий болгох;

14.1.2.хувь хүний чадамж болон өөрийгөө үнэлэх үнэлэмжийг хөгжүүлж, хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх явдлыг бэхжүүлэх;

14.1.3.бүх шатны боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох, мэргэжил эзэмших нөхцөлийг бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж, дэмжлэг туслалцаа үзүүлэх;

14.1.4.хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн сургалтын хөтөлбөр, стандартыг боловсруулах.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульд элсэх зохицуулалт

Хүүхдийн сургуульд элсүүлэхэд баг, хорооны засаг дарга, хамран сургах тойргийн сургуулийн захирал, эцэг эх үүрэг хүлээнэ.

Үүрэг хүлээсэн эдгээр албан тушаалтан, иргэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуульд элсүүлэх үйл явцыг хэрхэн зохион байгуулах талаар ХНХ-ын сайд, БСШУС-ын сайд, ЭМ-ийн сайдын 2018 оны хамтарсан А/304, А/699, А/460 тушаал “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд цогц дэмжлэг үзүүлэх заавар”, БСШУС-ын сайдын 2018 оны А/155 дугаар тушаалаар батлагдсан Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах загвар, БСШУС-н сайдын 2019 оны А\292 тоот тушаал “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах” журмаар нарийвчилсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуульд элсүүлэхэд “Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөл” чухал үүрэгтэй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах Хөвсгөл аймгийн туршлага:

Хөвсгөл аймгийн засаг даргын 2018 оны А/247 дугаар захирамжаар Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн багийн бүрэлдэхүүн, ажиллах журам, үйл ажиллагааны чиглэлийг баталсан.

Дэмжлэгийн зөвлөлийн бүрэлдэхүүн:

Дарга:

Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд:

Боловсрол, соёл урлагийн газрын хэлтсийн дарга

АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Боловсрол, соёл, урлагийн газрын Сургуулийн өмнөх

боловсрол хариуцсан мэргэжилтэн

БСУГ-ын Бага боловсрол хариуцсан мэргэжилтэн

БСУГ-ын төсөв, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн

Хүүхдийн харьяалагдах сумын засаг дарга

Хүүхдийн оршин суугаа багийн засаг дарга

Тухайн хамран сургах тойргийн сургуулийн захирал /хамран сургах тойргийн дагуу /

Тухайн хамран сургах тойргийн цэцэрлэгийн эрхлэгч, багш

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын нарийн бичгийн дарга

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын эмч

Нарийн бичгийн дарга: Боловсрол, соёл, урлагийн газрын Насан туршийн боловсролын мэргэжилтэн

Зөвлөлийн үйл ажиллагаа:

Сум бүрт амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын шийдвэрээр хөгжлийн бэрхшээлтэй нь тогтоогдсон хүүхдийн тоо, мэдээллийг гарган сургуульд хамруулах ажлыг төлөвлөн, зохион байгуулж ажиллана.

Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн өргөтгөсөн хурлыг жилд 2 удаа зохион байгуулж хүүхдийн харьяалагдах багийн засаг дарга, сургуулийн удирдлагууд хүлээн авах багш, эцэг эх асран хамгаалагч, хүүхэд зэргийг биечлэн оролцуулна. 6-н настай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн, ар гэрийн амьдрал, суралцахад нь шаардлагатай тохирох хэрэглэгдэхүүн, шийдвэрлэх боломж зэргийг судалж сургуульд элсүүлэх, хүлээн авах бэлтгэлийг хангах талаар сургуулийн удирдлага, эцэг эх асран хамгаалагчтай хэлэлцэж хурлын шийдвэрийн маягтад тэмдэглэнэ. Энэхүү шийдвэрийн маягыг нь хамран сургах тойргийн сургууль дээрх

дэмжлэгийн багт хүргүүлэх бөгөөд тухайн хүүхдийн тохирох хэрэглэгдэхүүний зөвлөмж болно.

Сургууль дээрх дэмжлэгийн баг байгуулах

Дэмжлэгийн багийн бүрэлдэхүүнд:

- ✧ Сургуулийн удирдлагын төлөөлөл
- ✧ Нийгмийн ажилтан
- ✧ Сургуулийн эмч
- ✧ Тусгай дэмжлэгийн төвийн багш
- ✧ АУБ багш
- ✧ Мэргэжлийн багш нар байж болно

Сургуулийн дэмжлэгийн багийн үүрэг

- ✧ Суралцагчдаас тусгай дэмжлэг шаардлагатай хүүхдийг эрт илрүүлэх
- ✧ Тусгай дэмжлэг шаардлагатай хүүхдүүдийн бодит байдлыг судалж мэдэх
- ✧ Эцэг эх, асран хамгаалагчийн хүсэлт болон аймгийн дэмжлэгийн зөвлөл, салбар комиссын шийдвэрийг үндэслэн тусгай дэмжлэг шаардлагатай хүүхэд зориулсан Ганцаарчилсан сургалт, дэмжлэгийн төлөвлөгөөг боловсруулах
- ✧ Тухайн хүүхдэд зориулсан тусгай л дэмжлэг болон Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний талаар сургуулийн нийт багш ажилтнуудад ойлгуулах ажлыг зохион байгуулах
- ✧ Орон нутгийн төрийн болон ТББ, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх талаар санаачлагатай ажиллах

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн шийдвэрийн дагуу тухайн хүүхдийг хүлээж авсан сургуулийн захирал тушаалаар “Дэмжлэгийн баг” байгуулна. Дэмжлэгийн баг дэмжлэг шаардлагатай хүүхдийн тооноос хамаарч 11-15 хүний бүрэлдэхүүнтэй байж болно. Хөвсгөл аймаг нь 35 сургуультай бөгөөд үүний 68% нь буюу 24 сургуульд “Дэмжлэгийн баг” байгуулан ажиллаж байна. “Дэмжлэгийн баг”-ийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг нь тухайн

хүүхдийн хөгжих, сурахад шаардлагатай сургалтын хөтөлбөр /ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах, ерөнхий болон засан сайжруулах хичээлийн агуулгыг тодорхойлох/, хүүхдийн хэрэгцээнд суурилсан ялгаатай хичээл, судлагдахууныг сонгон судлах асуудлыг сургуулийн зөвлөлд оруулах, тохирох хэрэглэгдэхүүнийг бэлтгэх, багш, эцэг эх, асран хамгаалагчид иргэд олон нийтэд сургалт зохион байгуулах, багшийн арга зүйг тасралтгүй хөгжүүлэх, эцэг эх, асран хамгаалагчийн эерэг хандлага, нөлөөллийг дэмжих, хүүхдийн аюулгүй, саадгүй, хүндрэл бэрхшээлгүй сурч, хөгжих сургалтын орчинг бүрдүүлэхэд оршино.


Дэмжлэгийн баг нь шаардлагатай хүүхдэд “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө” боловсруулахаас гадна хүүхдийн өвөрмөц хэрэгцээнд нийцсэн тохирох хэрэглэгдэхүүн байгаа эсэхэд хяналт тавина. Тус баг нь улиралд нэг удаа хуралдаж, Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг засаж сайжруулах болон хүүхдэд гарч байгаа ахиц амжилт багшийн ажлын үр дүнг үнэлэн сургуулийн захиргаанд мэдээлэх бөгөөд энэ нь багшийн урамшуулал нэмэгдэл хөлс тооцох үндэслэл болохуйцаар удирдлага зохион байгуулалтыг ханган ажиллаж байгаа нь 2021 оны 1 дүгээр сараас хэрэгжиж эхлэх А/296 дугаар тушаалтай нийцэж байна. /2020 онд БСШУС-н яамны сайд А/296 тушаалаар “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш, туслах багшид нэмэгдэл хөлс олгох заавар” /

Үйл ажиллагааны үр дүнг Боловсролын хэлтэс/Боловсрол, соёл, урлагийн газарт тайлагнана. Ердийн сургалтын хөтөлбөрт нийцэхгүй сурагчид Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулан сургадаг. “Дэмжлэгийн баг”, хүүхдийн асран хамгаалагч зэрэг холбогдох хүмүүс хамтран Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулснаар тухайн хүүхдийн хэрэгцээг зөв тодорхойлж, урт хугацаанд дэмжлэг үзүүлэх боломж бүрдэж байна.

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Үр дүн


1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульд элсэлтийн хувь өссөн



2. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж буй хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын тоо өссөн



3. Багш нарын хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах хандлага эерэгээр өөрчлөгдсөн / “Дэмжлэгийн баг”-ийг үлгэр жишээ ажиллуулж буй 3-н сургуулийн багш нараас авсан судалгааны дүн /



Дүгнэлт

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн дэмжлэг үзүүлэх орон нутгийн болон сургуулийн тогтолцоог бүрдүүлэн ажилласнаар хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах боломжтой болох нь харагдсан.
2. Хүүхэд бүрийн онцлог, ялгаатай хэрэгцээнд тохируулан сургууль эцэг эхийн хамтын оролцоотойгоор тодорхой зорилтын хүрээнд ойлголтоо нэгтгэн ажиллаж чаддаг болсон нь тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд боловсролын үйлчилгээг тэгш хүртээмжтэй үзүүлэхэд СУРГУУЛЬ БҮХЛЭЭРЭЭ АЖИЛЛАХ дэмжлэгийн тогтолцоог бүрдүүлэх боломжтой болох нь ажиглагдсан.
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүрийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн боловсролын үйлчилгээг үе тэнгийнхэн дотор нь үзүүлэхийн тулд багш нар тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхэдтэй ажиллах арга зүйд суралцах явдал чухал байна.
4. Сургуулийн дэмжлэгийн тогтолцоог бүрдүүлэн ажилласнаар удирдлага, багш, ажилчид, анги хамт олон, эцэг эхчүүд хүүхэд бүрийн ялгаатай хэрэгцээ, сурахад тохиолдох саад тотгорыг багасгаж байгаа нь ялгаварлан гадуурхалтгүй, тэгш хамруулан сургах соёл төлөвших эхлэл тавигдаж байна.

Талархал

Сургуульд хамрагдалтыг дэмжих аймгийн дэмжлэгийн зөвлөл, сургуулийн дэмжлэгийн баг нь бусад аймагт хэрэгжээгүй байгаа шинэ үйл ажиллагаа юм. Энэ үйл ажиллагааг туршин хэрэгжүүлэхэд тусалж дэмжсэн орон нутаг, байгууллагын удирдлагууд болон хамтран ажилласан бүх хүмүүстээ талархал илэрхийлье.

Хүүхэд бүхэн аз жаргалтай байх болтугай.

**ТӨРИЙН ӨМЧИЙН ИХ, ДЭЭД СУРГУУЛЬД
ТУЛГУУР ЭРХТНИЙ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ОЮУТАН
СУРАЛЦАХ БОЛОМЖИЙГ ҮНЭЛЭХ НЬ**

¹ Д.Мөнх-Учрал, ² Б.Түвшинбаатар, ³ Т.Оюун-Эрдэнэ

¹ Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль

² Арьс Өвчин Судлалын Үндэсний Төв

³ Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв

Хураангуй

Монгол улсын хэмжээнд нийт 105.730 хөгжлийн бэрхшээлтэй иргэн (ХБИ) амьдарч байгаа нь хүн амын 3.2 хувийг эзэлж байна. Монгол улс 2008 онд ХБИ-ийн эрхийн тухай конвенцыг баталж, ХБ-тэй иргэдэд хүртээмжтэй барилгын орчин бүрдүүлэх чиглэлээр хэд хэдэн стандартуудыг баталсан. Гэвч тус стандартуудын хэрэгжилт туйлын хангалтгүйн дээр энэ чиглэлээр хийсэн судалгаа эрдэм шинжилгээний ажил ховор байдаг.

Зорилго: Төрийн өмчийн их, дээд сургуулиудад тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй (ХБ) оюутан суралцах боломжийг үнэлэх

Аргазүй: Судалгаанд Улаанбаатар хотын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчийн 13 их, дээд сургуулийн 30 барилгын орчинд үнэлгээ хийсэн.

Их, дээд сургуулиуд ХБ-тэй оюутанд зориулсан автомашины зогсоолгүй (93.3 хувь), зогсоолоос барилга руу нэвтрэх тэгш гадаргуутай замгүй (36.7 хувь), барилгын төв үүдэнд налуу замгүй (83.3 хувь), стандарт бус буюу хэт огцом налуу зам (16.7 хувь) байршуулсан байна.

Их, дээд сургуулиуд давхар хооронд зорчих лифт төлөвлөөгүй (90 хувь), ариун цэврийн өрөө ХБ-тэй оюутан үйлчлүүлэх нэмэлт тоноглол байршуулаагүй (эмэгтэй 96.7 хувь, эрэгтэй 83.3 хувь), лекц, семинарын өрөөний зарим стандарт үзүүлэлтүүд ХБ-тэй оюутанд хүртээмжгүй байна.

Түлхүүр үг: Тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээл, хүртээмжтэй орчин

Үндэслэл

Дэлхий дахинд 1 тэрбум гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэн амьдардаг бөгөөд үүнээс Ази Номхон Далайн бүсэд 650 сая орчим буюу 10 хүн тутмын 1 нь хөгжлийн бэрхшээлтэй амьдарч байна. Монгол улсын хэмжээнд нийт 105.730 хөгжлийн бэрхшээлтэй иргэн (ХБИ) амьдарч байгаа нь хүн амын 3.2 хувийг эзэлж байна.

Монгол улс ХБИ-ийн эрхийг хангах, тэгш боломжийг бүрдүүлэх зорилгоор 2008 онд ХБИ-ийн эрхийн тухай конвенцыг баталж, 2009 онд НҮБ-д албан ёсоор бүртгүүлснээр энэхүү конвенц Монгол улсад хэрэгжих болсон. Гэвч холбогдох бусад

хууль, эрхзүйн баримт бичгийг конвенцын үзэл санаа, агуулгатай нийцүүлэх ажлыг орхигдуулсны улмаас конвенцын хэрэгжилт туйлын хангалтгүй байна.

Монгол улс 2004 онд ХБИ-дэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль (БД 31-101-04), 2009 онд Иргэний барилгын төлөвлөлтөд ХБХ-ий шаардлагыг тооцсон орон зай орчин (MNS 6055:2009) зэрэг стандартыг баталж их, дээд сургуулиудад ХБИ-нд хүртээмжтэй орчин бүрдүүлэх талаар тодорхой заалтуудыг тусгасан байдаг. Гэвч төрийн өмчийн их дээд сургуулиудын орчинд тус стандарт (нормаль)-ын хэрэгжилт хангалтгүйн дээр ХБИ-д их, дээд сургуульд суралцах боломж хязгаарлагдмал байна.

Судалгааны зорилго

Төрийн өмчийн их, дээд сургуулиудад тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй (ХБ) оюутан суралцах боломжийг үнэлэх

Судалгааны зорилт

1. Төрийн өмчийн их, дээд сургуулиудын тулгуур эрхтний ХБ-тэй оюутанд хүртээмжтэй барилгын гадаад орчинд үнэлгээ хийх
2. Төрийн өмчийн их, дээд сургуулиудын тулгуур эрхтний ХБ-тэй оюутанд хүртээмжтэй барилгын дотоод орчинд үнэлгээ хийх

Шинэлэг тал, практик ач холбогдол

Төрийн өмчийн их, дээд сургуулиудын тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй оюутанд зориулсан барилгын гадаад болон дотоод орчинд үнэлгээ хийж шинжлэх ухааны үндэслэлтэй нотолгоо бүрдүүлж буйгаараа ач холбогдолтой.

Судалгааны хэрэглэгдэхүүн ба аргазүй

Судалгааны загвар: Агшингийн судалгаа

Төрийн өмчийн их, дээд сургуулиудад тулгуур эрхтний ХБ-тэй оюутан суралцах боломжийг үнэлэхэд Улаанбаатар хотын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчийн их, дээд сургуулийн (n=16) орчинд үнэлгээ хийхээр төлөвлөсөн.

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Судалгаанд хамрагдах түүврийн нэгжийг сонгохдоо **нэлэнхүй** түүвэр ашигласан бөгөөд үнэлгээ хийх боломжтой (n=13) сургууль тус бүрээс хичээлийн төв байр (n=1), салбар сургууль (n=2) сонгож нийт 30 барилгын орчинд үнэлгээ хийсэн.

Хүснэгт 1. Үнэлгээ хийсэн их, дээд сургуулиуд

№	Сургууль	Төв	Салбар
1	АШУҮИС	1	2
2	СЭЗИС	1	-
3	МУИС	1	2
4	СУИС	1	2
5	ДХИС	1	2
6	БХИС	1	2
7	УБИС	1	-
№	Сургууль	Төв	Салбар
8	ШУТИС	1	2
9	КУДС	1	-
10	ТДС	1	-
11	ХААИС	1	2
12	ХУИС	1	1
13	МУБИС	1	2

Мэдээ материал цуглуулсан арга

Төрийн өмчийн их, дээд сургуулиудад тулгуур эрхтний ХБ-тэй оюутан суралцах боломжийг үнэлэхэд 7 бүлэг 94 асуулт бүхий үнэлгээний хуудас ашигласан. Үнэлгээний хуудсыг дараах стандарт (нормаль)-д тулгуурлан боловсруулсан.

1. Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газар. “ХБИ-дэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль (БД 31-101-04)” УБ 2004 он,
2. Стандартчилал хэмжил зүйн газар. Монгол улсын стандарт. “Иргэний болон үйлдвэрлэлийн барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай орчин” MNS 6055: 2009
3. Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам. Монгол улсын барилгын дүрэм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох дүрэм. (БД 31-112-11) УБ 2011 он

Хэмжилт хийсэн багаж

Тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй оюутанд зориулсан төрийн өмчийн их, дээд сургуулиудын орчин дахь хэмжилтийг дараах багаж ашиглан хийсэн.


1. Малайз улсад 2011 онд үйлдвэрлэсэн талбайн урт, өргөн, өндөр, эзлэхүүн м2 лазер хэмжигч BOSCH багажийг ашиглан хэмжилт хийсэн.
2. БНХАУ-д 2011 онд үйлдвэрлэсэн талбайн гадаргуугийн налуу, өнцгийн лазер хэмжигч LAISAI LS 165 багажуудыг тус тус ашигласан.

Судалгааны мэдээллийг Spss 22.0 програмыг ашиглаж боловсруулалт хийсэн.

Судалгааны үр дүн


Судалгаанд БСШУСЯ-ны харьяа төрийн өмчийн 13 их, дээд сургуулийн 30 барилгын орчинд үнэлгээ хийсэн. Үүнээс төв сургууль 14, салбар сургууль 16 байсан ба барилгын 26.7 хувь нь их, дээд сургуулийн зориулалтгүй байсан.

Их, дээд сургуулиудын барилгын гадна талбайд ХБ-тэй оюутанд зориулсан автомашины зогсоолгүй (93.3 хувь), тэмдэглээ байршуулаагүй, зогсоолоос сургуулийн барилгад нэвтрэх чиглэлд тэгш гадаргуутай замгүй (36.7 хувь) байсан.



Зураг 1. Төв хаалганд налуу зам байршуулсан байдал

Их, дээд сургуулиудын 16.7 хувь нь стандарт бус буюу хэт огцом налуу замтай, 83.3 хувь нь огт налуу замгүй байгаа нь тулгуур эрхтний ХБ-тэй оюутан бие даан сургуулийн барилгад нэвтрэх боломж хязгаарлагдмал байгааг харуулж байна.




Зураг 2. Төв хаалганы өргөн, бариулын өндөр, босгоны стандарт

Төв хаалганы өргөнд тэргэнцрийн орон зайг тооцсон эсэхийг үнэлэхэд 80 хувь нь стандарт (800 мм өргөн), 20 хувь нь стандарт бус (800 мм бага) байна. Төв хаалганы бариулын өндөр 70 хувь стандарт (900-1065 мм өндөр), 30 хувь нь стандарт бус, төв хаалганы босгоны өндөр 33.3 хувь нь стандарт (шалтай нэг түвшинд), 66.7 хувь нь стандарт бус байгаа нь тулгуур эрхтний ХБ-тэй их, дээд сургуулийн барилгад бие даан нэвтрэх боломж хязгаарлагдмал байгааг харуулж байна.


Хүлээлгийн өрөөнд тулгуур эрхтний ХБ-тэй оюутны орон зайг тооцсон байдлыг үнэлэхэд хүлээлгийн өрөөний талбай 80 хувь нь стандарт (1000 мм^2), 80 хувь нь сургуулийн бүтэц, үйл ажиллагааны тухай мэдээллийг стандартын дагуу байршуулсан (900 мм өндөр, 90 хувь нь хүлээлгийн өрөөнд тэргэнцрийн орон зайн бүсчлэлийг тооцсон (1500 мм диаметр) зэрэг давуу талууд ажиглагдсан.

Үнэлгээнд оролцсон их, дээд сургуулиудын 100 хувь нь 2 ба түүнээс дээш давхар байсан ба давхар хооронд зорчих шатны бариулын өндөр 60 хувь нь стандарт бус (800 мм өндөр), шатны ирмэгийн налуу стандарт бус (30 хувь) байсан. Мөн үүнээс гадна лавлагаа мэдээлэл (63.3 хувь), хувцасны өлгүүрийн (73.3 хувь) өндөр стандарт бус (800 мм өндөр) байгаа нь тулгуур эрхтний ХБ-тэй оюутанд хүртээмжгүй байгааг харуулж байна.




Зураг 3. Давхар хооронд зорчих лифт, өргүүр төлөвлөсөн байдал

Их, дээд сургуулиудын 10 хувь нь давхар хооронд зорчих лифт төлөвлөсөн бол 90 хувь нь огт лифтгүй байсан ба лифтний хаалганы өргөн стандарт бус, хянах самбар, бариулын өндөр тохиромжгүй (950 мм өндөр), тасалгаанд ХБ-тэй хүний орон зайг (1400 мм урт, 1350 мм өргөн) тооцоогүй байгаагаас харахад тулгуур эрхтний ХБ-тэй оюутан их, дээд сургуулийн 2 ба түүнээс дээш давхарт гарах боломж хязгаарлагдмал байгааг харуулж байна.




Зураг 4. Ариун цэврийн өрөний стандарт

Их, дээд сургуулиудын ариун цэврийн өрөөний талбайн хэмжээ 93.3 хувь стандарт (2000 мм урт, 2000 мм өргөн), тэргэнцрийн орон зайг тооцсон байдлаар нь авч үзвэл ариун цэврийн өрөөнд 33.3 хувь нь, бие засах тасалгаанд 86.7 хувь нь стандарт бус буюу тэргэнцрийн орон зайг (1500 диаметр) тооцоогүй, ариун цэврийн өрөөний суултуурт нэмэлт тоноглол байршуулаагүй (93.4 хувь), усны татуурга ХБИ-нд хүртээмжгүй (83.3), дуудах товч байршуулаагүй (100 хувь), гар угаах тосгуур хэт өндөр (73.3 хувь) байгаагаас харахад тулгуур эрхтний ХБ-тэй оюутан их, дээд сургуулиудын ариун цэвэр ба эрүүл ахуйн зориулалттай өрөөг бие даан ашиглах боломж хязгаарлагдмал байгааг харуулж байна.



Зураг 5. Ариун цэврийн өрөөний эрэгтэй суултуурт нэмэлт тоноглол байршуулсан байдал

Их, дээд сургуулиуд эмэгтэй суултуурт 100 хувь стандарт нэмэлт тоноглол (Хэвтээ 650 мм, босоо 800 мм) байршуулаагүй байсан бол эрэгтэй тосгуурт 16.7 хувь нь стандарт нэмэлт тоноглол (Нэмэлт тоноглол 800 мм өндөрт) байршуулсан байна.



Зураг 6. Лекцийн өрөөнд тэргэнцрийн орон зайг тооцсон байдал

Их, дээд сургуулиудын 96.7 хувь лекцийн талбайг стандартын дагуу төлөвлөсөн бөгөөд лекцийн өрөөний гадна (56.7 хувь), лекцийн өрөөнд (70 хувь) тэргэнцрийн орон зайг тооцсон байна.

Их, дээд сургуулиудын лекц, семинарын өрөөг тулгуур эрхтний ХБ-тэй хүртээмжтэй төлөвлөсөн эсэхийг үнэлэхэд хаалганы өргөн (Лекц 73.3, Дад 76.7 %), хаалганы бариулын өндөр (Лекц 80, Дад 66.6%), хаалганы босго (Лекц 36.7, Дад 46.7 %), ширээний өндөр (Лекц 96.7, Дад 80%), залгуурын өндөр (Лекц 70, Дад 46.7 %) стандарт буюу ХБ-тэй оюутанд хүртээмжтэй байсан.

Харин лекцийн өрөөний цонхны өндөр (Лекц 46.7, Дад 33.3% хувь), цонхны хөшигний татуурга (Лекц 56.7, 46.7%), гэрлийн унтраалганы өдөр (Лекц 63.3, Дад 43.3 %) стандарт бус буюу тулгуур эрхтний ХБ-тэй оюутан хүртээмжгүй төлөвлөсөн байна.

Дүгнэлт

1. Их, дээд сургуулиуд ХБ-тэй оюутанд зориулсан автомашины зогсоолгүй (93.3 хувь), зогсоолоос барилга руу нэвтрэх тэгш гадаргуутай замгүй (36.7 хувь), барилгын төв үүдэнд налуу замгүй (83.3 хувь), стандарт бус буюу хэт огцом налуу зам (16.7 хувь) байршуулсан байна.

2. Их, дээд сургуулиуд давхар хооронд зорчих лифт төлөвлөөгүй (90 хувь), ариун цэврийн өрөө ХБ-тэй оюутан үйлчлүүлэх нэмэлт тоноглол байршуулаагүй (эмэгтэй 96.7 хувь, эрэгтэй 83.3 хувь), лекц, семинарын өрөөний зарим стандарт үзүүлэлтүүд ХБ-тэй оюутанд хүртээмжгүй байна.

Номзүй

1. Д.Мөнх-Учрал, О.Чимэдсүрэн. Ц.Эрдэнэсамбуу. Тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тэгш хамрагдах боломж. Улаанбаатар: 2012. х.7
2. Монгол улс. Төрийн мэдээлэл. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль. Улаанбаатар: Засгийн газрын дэргэдэх хэвлэх үйлдвэр. 2011.
3. Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газар. Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх норм дүрэм. БНБД 30-01-01. Улаанбаатар: 2000
4. Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газар. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль. БД 31-101-04 Улаанбаатар: 2004.

**ОЮУНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ТУСГАЙ
СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧДЫН ТАНИН МЭДЭХҮЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТИЙГ СУДАЛСАН ЛОНГИТЮД
СУДАЛГААНЫ ТОЙМ ҮР ДҮН**

Ж.Нямцэцэг¹, Б.Туяа¹, Г.Уянга¹, Ж.Лхагватогтох¹, Р.Нэнсэндэн², Д.Цогзолмаа³

¹ Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв

² Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

³ ШУТИС, Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль

Удиртгал

Манай улсын хувьд Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх тогтолцооны загвар” батлагдсан бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудалд иж бүрэн хандах, хөгжлийг дэмжих ажлууд эрчимжиж байна.

Хүүхдийн хоол хүнсний асуудал нь зөвхөн эрүүл мэндийн төдийгүй оюун ухааны хөгжилд чухал үүрэгтэй. Шим тэжээлийн бодис сэтгэн бодох үйл ажиллагаанд нөлөө үзүүлдэг талаар гадны судалгаа цөөнгүй хийгдсэн байдаг.

Манай орны хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хийсэн сэтгэл зүйн шинжилгээний лонгитюд судалгаа тун хомс байгаа бөгөөд ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн танин мэдэх үйл ажиллагаанд шим тэжээл хэрхэн нөлөөлж байгааг судлан харуулах нь цаашид хүүхдийн хөгжлийг дэмжих ажлыг төлөвлөхөд чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Судалгааны зорилго

Оюуны хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын нас, бие махбодийн онцлогт тохирсон шим тэжээл хүүхдийн танин мэдэхүйн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгааг илрүүлэхэд чиглэнэ.

Судалгааны түүвэр

БСШУЯамны 2017-2018 оны хичээлийн жилийн албан ёсны статистикийн мэдээллээр Ерөнхий боловсролын 25-р тусгай сургуульд 208 суралцагч, 70-р тусгай сургуульд 299 суралцагч тус тус суралцаж байна.

Сургууль тус бүрээс 60, нийт 120 суралцагч судалгаанд хамрагдсан бөгөөд эх олонлогийн 20.1- 28.8 хувийг хамруулсан ($n > 15$) тул төлөөлөх чадвартай гэж үзэж байна.

Хүснэгт 6. Судалгааны түүвэр

	Нас	Хүйс	Онош
--	-----	------	------

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

	6-11 нас	11-15	16, дээш	эр	эм	Оюуны бэрхшээлгүй, саажилт	F70	F71	F72
Туршилтын бүлэг	16	42	2	31	29	22	14	21	3
Хяналтын бүлэг	23	32	5	37	23	31	13	15	1
Нийт тоо	39	74	7	68	52	53	27	36	5
Хувь	32,5	61,6	5,9	56,6	43,4	44,2	22,5	18	4,2

Судалгааны арга:

Хүүхдийн сэтгэл зүйн шинжилгээнд дараах аргуудыг хэрэглэв.

Хүснэгт 7. Судалгаанд хэрэглэсэн аргачлал

Судлах зүйл	Хэрэглэсэн аргачлал
Ядралт, идэвх	Люшерийн өнгө ялгах сорил, компьютерийн хувилбар
Оюун ухааны хөгжлийн түвшин	Оюун ухааны түвшинг тогтоох аргачлал (WISC, WAIS)
Ой тогтоолт	Үг цээжлэх сорил
Сэтгэхүй	Утгын хувьд холбоогүй дүрс хасах сорил
Оюуны ажиллах чадварын хурд, анхаарал	Крепелины аргаар тоо бодох сорил

Судалгааны мэдээллийг ганцаарчилсан байдлаар цуглуулсан ба бидний судалгаандаа хэрэглэсэн аргууд нь манай орны эмнэл зүйн практикт түгээмэл хэрэглэгдэж буй аргууд болно.

Судалгааны үе шат

Судалгааг 2018 оноос 2020 он хүртэл, 2 үе шаттай явуулсан бөгөөд эхний шатанд судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн танин мэдэхүйн үйл ажиллагааны түвшинг мэргэжлийн арга аргачлалаар үнэлэх, дараачийн шатанд хүүхдийн танин мэдэхүйн үйл ажиллагаанд гарсан хөдлөл зүйг хянах судалгаа явуулсан болно.

Хүснэгт 8. Судалгааны үе шат

Үе шат	Судалгаа явуулсан хугацаа	Судалгаанд хамрагдагч
--------	---------------------------	-----------------------

Танин мэдэхүйн хөгжлийн үнэлгээ хийх шат	2018 оны 11 сараас 2019 оны 5 сар хүртэл	25, 70 дугаар сургуульд суралцагч нийт 120 хүүхэд
Танин мэдэхүйн үйл ажиллагааны хөдлөл зүйг илрүүлэх шат	2019 оны 11 сараас 2020 оны 1 сар	25, 70 дугаар сургуульд суралцагч нийт 107 хүүхэд

Танин мэдэхүйн хөгжлийн түвшинг үнэлэх сэтгэл зүйн шинжилгээг СЭМҮТ-ийн эмгэг сэтгэл судлаач, сэтгэцийн эмч нар хамтран хийж гүйцэтгэв.

Танин мэдэхүйн хөгжлийн үнэлгээ хийсэн судалгааны үзүүлэлт

Сэтгэл зүйн шинжилгээний өгөгдөл дээр судалгааны асуулгын найдвартай байдлыг шалгаж үзэхэд 0.761 буюу найдвартай байдлын хувьд ач холбогдолтой гэсэн үр дүн гарч байна.

1. Оюун ухааны хөгжлийн түвшин

Шинжилгээнд хамрагдсан нийт хүүхдүүдийн 17,5 хувьд оюун ухааны ерөнхий түвшинг тогтоох боломжгүй байв. Учир нь хүүхэд сонсгол, хэл ярианы хөгжил, саажилтын улмаас сорилын даалгаврыг бүрэн биелүүлэх боломжгүй байна.

Оюун ухааны түвшин тогтоох сорилд хамрагдсан 99 хүүхдийн 25,2 хувь нь оюун ухааны хөгжил хэвийн, 21,3 хувь нь завсрын хоцрогдол, 26,2 хувь нь хөнгөн зэргийн, 27,3 хувь нь хүндэвтэр хомсдолтой гэсэн үзүүлэлт илрэв.

Оюуны хөгжлийн бэрхшээлтэй гэсэн оноштой шинжилгээнд хамрагдсан хүүхдүүдийн оюун ухааны хөгжлийн түвшинг мэргэжлийн аргачлалаар судлан үзэхэд 45,4 хувьд оюуны хөгжлийн бэрхшээл илэрсэнгүй. Харин 27,3 хувь нь хөнгөн, 27,3 хувь нь хүндэвтэр зэргийн хомсдолтой байв. Тархины саа саажилттай хүүхдүүдийн хувьд 50 хувь нь оюун ухааны хомсдолгүй хэвийн, 27,5 хувь нь хөнгөн зэргийн оюуны хомсдол хавсарсан, 22,5 хувь нь оюуны хүндэвтэр хомсдол хавсарсан үзүүлэлт илрэв.

Оюун ухааны үзүүлэлтийг хэлэхүйн (VIQ) болон хэлэхүйн бус оюун ухаан (NIQ) гэж авч үздэг. Эхний судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн дундаж үзүүлэлтийг харуулбал:

Хүснэгт 4. Туршилтын болон хяналтын бүлгийн харьцуулсан үзүүлэлт, оюун ухаан

	Бүлэг	IQ	VIQ	NIQ
1	Туршилтын бүлэг	63,25	68	65,6
2	Хяналтын бүлэг	71,6	80,78	62,06
3	Нийт	67,2	74,07	63,91

2. Ой тогтоолтын байдал

Шинжилгээнд хамрагдсан хүүхдүүдийн ой тогтоолтын дундаж үзүүлэлт 1,51 байна. Тодруулбал, үг цээжлэх сорилоор давталт бүр дээр дунджаар 1-2 үг тогтоодог байна.

Оюун ухааны үзүүлэлт болон ой тогтоолтын хоорондын хамаарал $r=0,383$ байна. Тодруулбал, оюуны хөгжлийн ерөнхий үзүүлэлт өндөр байх тусам ой тогтоолт сайн байх хандлагатай.

3. Оюуны ажиллах чадварын хурд, анхаарал

Шинжилгээнд хамрагдсан хүүхдүүдийн хувьд Крепелины аргаар хялбар тоо нэмэх сорилоор 15 сек тутамд дунджаар 0-3 үйлдэл гүйцэтгэж байгаа бөгөөд оюуны хөгжлийн түвшингээс хамааран ялгаа илэрдэг байна.

Анхаарлын алдаа гаргаж буй эсэхийг судлан үзэхэд 60.0 хувьд анхаарал жигд, 21,7 хувьд анхаарал харьцангуй тогтвортой, 19.3 хувьд анхаарал тогтворгүй гэсэн үзүүлэлт илрэв.

4. Сэтгэхүй

Утгын хувьд холбоогүй дүрс хасах сорилын хүүхдэд зориулсан хувилбараар сэтгэхүйн хөгжлийг судлан үзэв. Уг хувилбар нь оюуны хомсдолын үед болон танин мэдэхүйн чадварууд алдагдалтай үед хэрэглэж болдог, түүнчлэн тоон болон чанарын шинжилгээ хийдгээрээ давуу талтай юм.

Шинжилгээнд хамрагдсан хүүхдүүд сэтгэхүйг судлах даалгавруудаас дунджаар 6,1-ийг зөв гүйцэтгэсэн байна.

Оюун ухааны хөгжлийн түвшин тус бүрт судлуулагчийн зөв гүйцэтгэсэн даалгаврын дундаж үзүүлэлтийг харуулбал:

Хүснэгт 5. Сэтгэхүйн даалгаврыг гүйцэтгэсэн байдал, оношоор

	Зөв гүйцэтгэсэн даалгаврын дундаж/оноо	Нэг бүлэг даалгаварт зөв гүйцэтгэсэн дундаж тоо
хүндэвтэр	1,95	0,3
хөнгөн	4,48	0,6
завсрын	8,25	1,48
хэвийн	10,8	1,5

Зөв гүйцэтгэсэн даалгаврын дундаж буюу хүүхдийн оноог оюуны хөгжлийн түвшингээр тогтоох нь оношийн ач холбогдолтой үзүүлэлт болж байна.

Харьцуулсан судалгааны үзүүлэлт

Эхний шатны судалгаанд хамрагдсан нийт 120 хүүхдээс нэг жилийн дараа хийсэн давтан шинжилгээнд 107 хүүхэд хамрагдсан байна. Давтан шинжилгээнд хамрагдаагүй 13 сурагчийн хувьд сургууль төгссөн, сургуулиас шилжсэн, удаан хугацааны турш өвчтэй байсан шалтгаантай байв.

Оюун ухааны үзүүлэлтэд гарсан өөрчлөлт

Оюун ухааны давтан шинжилгээнд туршилтын бүлгийн 48, хяналтын бүлгийн 43 хүүхэд хамрагдсан байна.

Давтан шинжилгээгээр туршилтын бүлэгт ерөнхий оюун ухааны үзүүлэлт хүүхдүүдийн 10,04 хувьд, хяналтын бүлгийн хүүхдүүдийн 4,65 хувьд өссөн байна.

Хүснэгт 9. Оюун ухааны харьцуулсан үзүүлэлт

IQ	Туршилтын бүлэг		Хяналтын бүлэг	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Өссөн	5	10,04	2	4,65
Буурсан	4	8,33	6	13,95
Хэвэндээ	39	81,25	35	81,39
N	48	100	43	100
Эхний болон давтан шинжилгээний зөрүү	0,19		-0,44	
P Sig. (2-tailed)	0,001		0,001	
Pearson Correlation	.942**		.982**	

Туршилтын бүлэгт оюун ухааны үзүүлэлт буурсан 4 хүүхдийн 3 нь эмэгтэй, 2 нь саа саажилт гэсэн оноштой, харин хяналтын бүлэгт оюун ухааны үзүүлэлт буурсан 6 хүүхдийн 4 нь саа саажилт гэсэн оноштой байна. Эдгээр нь цөөн тохиолдол дээр яригдаж байгаа учраас оюун ухааны түвшин буурахад нөлөөлсөн хүчин зүйлийн талаар дүгнэлт гаргах боломжгүй юм.

Танин мэдэхүйн үйл ажиллагаанд гарсан хөдлөл зүй

Танин мэдэхүйн үйл ажиллагаанд ой тогтоолт, оюуны ажиллах чадварын хурд болон сэтгэхүйн үзүүлэлтүүдийг нэгтгэн харуулав.

Ой тогтоолтын харьцуулсан үзүүлэлт

Туршилтын бүлгийн хүүхдүүдийн 41,7 хувьд ой тогтоолт сайжирсан үзүүлэлт илэрч байна. Ингэхдээ даалгаврын гүйцэтгэл дунджаар 2,35 нэгжээр өссөн

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

байна. Хяналтын бүлгийн хүүхдүүдийн 30 хувьд ой тогтоолт сайжирсан гэсэн үзүүлэлт илрэв.

Хүснэгт 10. Ой тогтоолтын харьцуулсан үзүүлэлт

Ой тогтоолт	Туршилтын бүлэг		Хяналтын бүлэг	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Өссөн	25 (2,35)	41,7	18 (2,74)	30
Буурсан	7 (-0,38)	11,7	8 (-1,6)	13,3
Хэвэндээ	28	46,7	34	56,7
Эхний болон давтан шинжилгээний зөрүү	0,93		0,66	
P Sig. (2-tailed)	0,001		0,001	
Эхний болон давтан шинжилгээний хоорондын хамаарал	0,612**		0,518**	

Туршилтын бүлгийн хүүхдүүдийн дунд ой тогтоолт буурсан болон даалгаврын гүйцэтгэлийн дундаж үзүүлэлт яльгүй бага байна.

Оюуны ажиллах чадварын хурд

Оюуны ажиллах чадварын хурд гэдэг нь нэг хэвийн үйл ажиллагааг ядралгүйгээр тодорхой хугацааны турш амжилттай хийж гүйцэтгэх чадвартай холбоотой ойлголт юм.

Туршилтын бүлгийн хүүхдүүдийн 45 хувьд оюуны ажиллах чадварын хурд сайжирсан. Ингэхдээ дунджаар 1,97 нэгжээр өссөн буюу 15 сек тутамд 1-2 тоо өмнөхөөс илүү бодож байна. Хяналтын бүлгийн хүүхдүүдийн 23,3 хувьд оюуны ажиллах чадварын хурд удааширсан, гэхдээ дунджаар -0,96 үйлдлээр багассан, 16,7 хувьд сайжирсан бол 60 хувьд хэвэндээ байсан байна.

Хүснэгт 11. Оюуны ажиллах чадварын хурд

Оюуны ажиллах чадварын хурд	Туршилтын бүлэг		Хяналтын бүлэг	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Өссөн	27 (1,97)	45	10 (0,67)	16,7
Буурсан	5 (-0,7)	8,3	14 (-0,96)	23,3
Хэвэндээ	28	46,7	36	60
Эхний болон давтан шинжилгээний зөрүү	0,82		-0,11	
P Sig. (2-tailed)	0,001		0,001	
Эхний болон давтан шинжилгээний хоорондын хамаарал	0,716**		0,864**	

Нийт үзүүлэлтээр харьцуулан авч үзвэл туршилтын бүлгийн хүүхдүүдийн гүйцэтгэл 0,82 нэгжээр сайжирсан бол хяналтын бүлгийн хүүхдүүдийн хувьд 0,11 нэгжээр буурсан байна.

Сэтгэхүйн харьцуулсан үзүүлэлт

Сэтгэхүй гэдэг нь юмс үзэгдлийн хоорондын мөн чанар, зүй тогтлыг нээн илрүүлэх танин мэдэхүйн процесс юм.

Сэтгэхүйн түвшин туршилтын бүлгийн хүүхдүүдийн 38,3 хувьд, хяналтын бүлгийн хүүхдүүдийн 23,3 хувьд өссөн үзүүлэлт илэрч байна. Даалгаврын гүйцэтгэлийн дундаж утга туршилтын бүлэгт, хяналтын бүлгээс 3,19 нэгжээр илүү байгаа юм.

Хүснэгт 12. Сэтгэхүйн харьцуулсан үзүүлэлт

Сэтгэхүй	Туршилтын бүлэг		Хяналтын бүлэг	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Өссөн	23 (7,04)	38,3	14 (3,85)	23,3
Буурсан	8 (-2,37)	13,3	15 (-5,93)	25
Хэвэндээ	29	48,3	31	51,7
Эхний болон давтан шинжилгээний зөрүү	2,38		-0,58	
P Sig. (2-tailed)	0,001		0,01	
Эхний болон давтан шинжилгээний хоорондын хамаарал	0,827**		0,921**	

Нийт үзүүлэлтээр авч үзвэл туршилтын бүлгийн хүүхдүүдийн гүйцэтгэл 2,38 нэгжээр өссөн байгаа бол, хяналтын бүлэгт 0,58 нэгжээр буурсан байна.

Судалгааны ажлын үр дүн

1. Оюун ухааны түвшин тогтоох сорилд хамрагдсан хүүхдүүдийн 25,2 хувь нь оюун ухааны хөгжил хэвийн, 21,3 хувь нь завсрын хоцрогдол, 26,2 хувь нь хөнгөн зэргийн, 27,3 хувь нь хүндэвтэр хомсдолтой гэсэн үзүүлэлт илрэв. Туршилтын бүлгийн хүүхдүүдийн IQ онооны дундаж 63.25, хяналтын бүлгийн хүүхдүүдийн дундаж үзүүлэлт 71,6 байна. Оюун ухааны үзүүлэлтэд тухайн үеийн сэтгэл санааны байдал, ядралт, идэвхийн байдал нөлөөлдөггүй байна.

2. Шинжилгээнд хамрагдсан нийт хүүхдүүдийн хувьд ой тогтоолтын даалгаврын дундаж гүйцэтгэл 1,5 байна. Энэ үзүүлэлт туршилтын бүлэгт 1.6, хяналтын бүлэгт 1.42 байв.
3. Оюуны ажиллах чадварын хурдыг судлах тестээр даалгаврын дундаж гүйцэтгэл 15 сек тутамд 1.01 байна.
4. Давтан шинжилгээгээр туршилтын бүлэгт ерөнхий оюун ухааны үзүүлэлт хүүхдүүдийн 10,04 хувьд, хяналтын бүлгийн хүүхдүүдийн 4,65 хувьд өссөн байна. Эхний ба давтан шинжилгээний нийт үзүүлэлтийг харьцуулан авч үзэхэд туршилтын бүлэгт 0,19 нэгжээр нэмэгдсэн, хяналтын бүлэгт 0,44 нэгжээр буурсан байна. Туршилтын бүлэгт оюун ухааны үзүүлэлт буурсан 4 хүүхдийн 3 нь эмэгтэй, 2 нь саа саажилт гэсэн оноштой, харин хяналтын бүлэгт оюун ухааны үзүүлэлт буурсан 6 хүүхдийн 4 нь саа саажилт гэсэн оноштой байна.
5. Туршилтын бүлгийн хүүхдүүдийн 41,7 хувьд ой тогтоолт сайжирсан, даалгаврын гүйцэтгэл дунджаар 2,35 нэгжээр өссөн байна.
6. Туршилтын бүлгийн хүүхдүүдийн 45 хувьд оюуны ажиллах чадварын хурд сайжирсан. Ингэхдээ дунджаар 1,97 нэгжээр өссөн буюу 15 сек тутамд 1-2 тоо өмнөхөөс илүү бодож байна. Хяналтын бүлгийн хүүхдүүдийн 10 хувьд өмнөхөөс сайжирсан үзүүлэлт илрэв. Эхний болон давтан шинжилгээний нийт үзүүлэлтийг харьцуулан үзэхэд туршилтын бүлэг 0,82 нэгжээр нэмэгдэж, хяналтын бүлэгт 0,11 нэгжээр буурчээ.
7. Сэтгэхүйн түвшин туршилтын бүлгийн хүүхдүүдийн 38,3 хувьд, хяналтын бүлгийн хүүхдүүдийн 23,3 хувьд өссөн үзүүлэлт илэрч байна. Даалгаврын гүйцэтгэлийн дундаж утга туршилтын бүлэгт 3,19 нэгжээр илүү байгаа юм. Эхний болон давтан шинжилгээний нийт үзүүлэлтээр авч үзвэл туршилтын бүлгийн хүүхдүүдийн гүйцэтгэл 2,38 нэгжээр өссөн байгаа бол, хяналтын бүлэгт 0,58 нэгжээр буурсан байна.

ДҮГНЭЛТ

1. Оюуны хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын нас, бие махбодийн онцлогт тохирсон шим тэжээл хүүхдийн танин мэдэхүйн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгааг илрүүлэх зорилго бүхий сэтгэл зүйн лонгитюд судалгаа хийв. Оюун ухааны хөгжил туршилтын бүлгийн хүүхдүүдийн 10 хувьд, даалгаврын гүйцэтгэл 0,19 нэгжээр; ой тогтоолт 41,7 хувьд, даалгаврын гүйцэтгэл 1,6 нэгжээр; оюуны

ажиллах чадварын хурд 45 хувьд, даалгаврын гүйцэтгэл 0,82 нэгжээр; сэтгэхүй 38,3 хувьд, даалгаврын гүйцэтгэл 2,38 нэгжээр тус тус өссөн байна.

2. Хүүхдийн оюун ухаан, ой тогтоолт, оюуны ажиллах чадварын хурд, сэтгэхүйн хөгжилд шим тэжээлийн хэрэглээ сайнаар нөлөөлж байгаа бөгөөд, цаашид боловсролын байгууллага, эцэг эх, асран хамгаалагчдын зүгээс хүүхдийн шим тэжээлийн зохистой хэрэглээнд анхаарах нь хүүхдийн хөгжлийг дэмжих нэг үзүүлэлт болно.

Ашигласан материал:

1. Н.Орёл, Д.Цогзолмаа. Эмгэг сэтгэл судлал, сэтгэц – физиологийн зарим үндсэн шинжилгээг эмнэл зүйн практикт хэрэглэх арга зүй. УБ.,2006
2. Сарантуяа Г. Сэтгэл судлалын шинжлэх ухааны судалгааны аргууд. УБ, 2015
3. СЭМҮТ, Сэтгэл зүйн оношилгооны баг. Утгын хувьд холбоогүй дүрс олох сорил. УБ.,2017
4. СЭМҮТ, Сэтгэл зүйн оношилгооны баг. Хүүхдийн оюун ухааныг судлах сорил. УБ.,2016
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль. УБ, 2016
6. World report on Disability. 2011. WHO, WB

**ЦАХИМ БОЛОН УЛАМЖЛАЛТ СУРГАЛТЫГ ХОСЛУУЛАН
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ОЮУТНУУДЫН СУРАЛЦАХ
БОЛОМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ
INCREASING LEARNING OPPORTUNITIES FOR STUDENTS WITH
DISABILITIES BY COMBINING E-LEARNING AND TRADITIONAL
TRAINING**

Ц.Цэвэгмид¹ Р.Нурбек²

¹Боловсролын хүрээлэн

²Санхүү эдийн засгийн их сургууль

Хураангуй

Манай улсад 2019 оны байдлаар 107 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаагийн 11606 нь хүүхэд байна. Ерөнхий боловсролын сургуульд 6053 хүүхэд сурдгаас 1751 нь зургаан тусгай сургуульд суралцдаг. Сургуулийн өмнөх боловсрол буюу цэцэрлэгт 1076 хүүхэд суралцдагаас 179 нь 10, 186 дугаар тусгай цэцэрлэгт суралцдаг. Харин их, дээд сургуульд 620 орчим хөгжлийн бэрхшээлтэй оюутан суралцаж байна. Боловсролын салбарт хүний эрхэд суурилсан сурч боловсрох эрхийн талаарх төрийн зүгээс зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээний заалтад бүх нийтийн боловсрол эзэмших эрхийг хангахад чиглэсэн холбогдох хууль тогтоомжийг хянан үзэх, тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхэд, оюутан суралцагчдыг боловсролын гадна үлдээхгүйгээр чанартай боловсролд тэгш хамруулах боломжийг цахим болон уламжлалт сургалтаар нэмэгдүүлэх боломжтойг энэхүү өгүүллээрээ онцолж байна.

Summary

As of 2019, there are 107,000 people with disabilities in Mongolia, of which 11,606 are children. There are 6,053 children in secondary schools, of which 1,751 attend six special schools. There are 1,076 children in pre-school education or kindergartens, of which 179 attend two special kindergartens, 10 and 186. There are about 620 students with disabilities studying at universities and colleges.

In the field of education, the government should review the relevant laws and regulations aimed at ensuring the right to universal education in the provisions of the human rights-based right to education, and increase access to quality education through e-learning and traditional education. This article emphasizes the possibility.

Тэгш хамруулан сургах боловсрол нь суралцагчдын харилцан адилгүй байдал, ялгаатай хэрэгцээ, хэл соёл, нийгмийн гарал, эдийн засгийн хүчин зүйлсээс үл хамааран хүн бүрийн мэдлэг чадвараа дээшлүүлэх, боловсрол эзэмших тэгш боломж болон эрхийг хангахад чиглэсэн үйл явц юм. Бүх нийтийн

боловсролын зорилтуудад хүрэхийн тулд тэгш хамруулан сургах боловсрол нэн чухал болохыг дэлхий нийт онцолж байна.

1960 онд ЮНЕСКО-гоос баталсан “Боловсролын салбарт ялгаварлан гадуурхахын эсрэг тэмцэх тухай конвенц” нь тэгш хамруулах боловсролын гол тулгуур бөгөөд боловсролын салбарт үл ялгаварлал, тэгш хандлага, тэгш боломж гэсэн зарчмуудыг эрхэмлэдэг. Монгол улс 1964 онд уг конвенцид нэгдэн орсон юм. 1948 оны НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон 1989 оны НҮБ-ийн Хүүхдийн эрхийн конвенцид ялгаварлан гадуурхалыг хориглож хүүхэд бүр боловсрол эзэмших эрхтэйг заасан байдаг. 1993 оны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох НҮБ-ын стандарт дүрэмд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд тэгш боломж олгохыг дэмжиж, 1994 оны ЮНЕСКО-гийн Саламанкагийн мэдэгдэлд **“Сургуулиуд хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгмийн гарал, сэтгэлийн хөдөлгөөн, хэл яриа болон бусад нөхцөл байдлыг үл харгалзан”** хүүхэд бүрийг авч сургах ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй ба авьяаслаг хүүхдүүд, хараа хяналтгүй ба ажил, хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд, алслагдсан ба нүүдэлчин өрхийн хүүхдүүд, хэл, соёл ба үндэсний цөөнхийн хүүхдүүд болон бусад ялгаварлан гадуурхагдсан бүлгийн хүүхдүүд бүгд сургуульд хамрагдах ёстой гэж тэмдэглэсэн байдаг. Тэгш хамруулах боловсрол нь бүх хүүхэд, залуучууд болон насанд хүрэгчдийн сурах хэрэгцээг хангахад чиглэгдсэн бөгөөд энэхүү үзэл баримтлал нь 1990 оны Бүх нийтийн боловсролын дэлхийн бага хурал болон Тусгай хэрэгцээт боловсролын асуудлаарх Саламанкагийн мэдэгдлийн суурь болж Дакарын боловсролын форумар дахин баталгаажсан юм. Монгол Улс Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг Улсын Их Хурлаас 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр батлан хөгжлийн бэрхшээлтэй хүнд тулгамдаж байгаа нийтийн тээвэр, зам, орон сууц, тэдний онцлог хэрэгцээ шаардлагад нийцүүлсэн олон асуудлыг сайжруулах арга хэмжээг хуульчлан, эрх орцныг бүрдүүлж өгсөн. Дээрх хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 14 дүгээр зүйлийн 14.5, 39 дүгээр зүйлийн 39.1.3 дэх заалт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 21 тоот тогтоолд заасны дагуу **“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, оролцоог нэмэгдүүлэх, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”**-ийн төслийг НҮБ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүний

эрхийг хамгаалах хорооны 11-р уулзалтын хүрээнд гаргасан Ерөнхий зөвлөмжийн заалтуудыг үндэслэн боловсруулж, 2016-2020 онд хэрэгжүүлэн ажиллаж байна.

Манай улсад 2019 оны байдлаар 107 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаагийн 11606 нь хүүхэд байна. Ерөнхий боловсролын сургуульд 6053 хүүхэд сурдгаас 1751 нь зургаан тусгай сургуульд суралцдаг. Сургуулийн өмнөх боловсрол буюу цэцэрлэгт 1076 хүүхэд суралцдагаас 179 нь 10, 186 гэсэн хоёр тусгай цэцэрлэгт суралцдаг. Харин их, дээд сургуульд **620 орчим хөгжлийн бэрхшээлтэй оюутан** суралцаж байна. Боловсрол, Шинжлэх Ухааны Яам (БШУЯ) 2023 он хүртэл тооцоолж үзэхэд Монгол Улсын 0-18 насны бүх хүүхдийн нэг орчим хувийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эзэлдэг гэсэн тооцоолол гаргасан. Энэ нь хүн ам өсөхийн хэрээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ч нэмэгдэнэ гэсэн үг. Зарим хүн тусгай сургууль байх ёстой, зарим нь хэрэггүй гэж үзэж байгаа ч дэлхий нийт тусгаарлаж болохгүй ээ, хамт хөгжих ёстой гэж зөвлөж байна. БШУЯ тусгай сургуулиудын тоог нэмэх бус хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг бусад хүүхдүүдтэйгээ цуг сурч, хөгжих боломжоор хангахаар ажиллаж байна. Сүүлийн хоёр жилийн хугацаанд гаргасан эрх зүйн баримт бичиг бүгд тэгш хамран сургах үзэл баримтлалд нийцсэн, удирдлага, зохион байгуулалтыг зөвлөмжилсөн байна.

БШУЯ-д 2020 оны гуравдугаар сарын 31-нд “Тусгай хэрэгцээт боловсролын хэлтэс” байгуулагдсан. Бүх шатны боловсролын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй иргэний сурч, боловсрол эзэмших эрхийг бүрэн хангах, тусгай хэрэгцээт боловсролд шаардлагатай байгаа ном, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний стандартыг тогтоож, хангамжийг сайжруулах үндсэн үүрэг хүлээж ажиллаж байна.

Боловсролын хүрээлэнд 2019 оны 11 дүгээр сард БСШУС-ын сайдын тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжил, боловсрол, арга зүйн сектор байгуулагдсан. Тус секторын дэргэд Тусгай хэрэгцээт боловсролыг дэмжих төв ажиллаж байна. Боловсролын хүрээлэнгийн сектор болон төвийн үйл ажиллагаа нь цэцэрлэг, ЕБС-д тэгш хамран суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжих, сурах онцлог, хэрэгцээг судалгаанд суурилсан онол, арга зүйд тулгуурлан хөгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багшийг чадавхжуулах, хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчдад

зөвлөгөө өгөх, зөвлөн туслах дэмжлэгийн тогтолцоог бий болгоход анхаарч ажиллаж байна.

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиудад “Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрх” “Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох нөхцөл”-ийг хангах, “Ажил олоход хүндрэлтэй иргэн”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд аж ахуйн нэгж, байгууллага, иргэний оролцоо, эрх, үүрэг” “Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүний хөдөлмөр” эрхлэлтийг дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлж өгснөөрөө бодлого, эрх зүйн орчны шинэчлэлийг хийсэн ажил болсон. Эдгээр хуулиудын хэрэгжилтийг хангах, дэмжлэг үзүүлэн ажиллах аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн оролцоо маш сул, төрийн захиргаа болон боловсролын байгууллагуудын хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээнд нийцсэн ном, сурах бичиг, тусгай хэрэглээний сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслийг худалдан авах зардал, цогц орчин, суралцах нөхцөл бүрдүүлэх үүрэг хариуцлага өнөөдөр хүнд байгааг судлаач миний бие олон жишээгээр нотлон харуулж болохоор байна.

Боловсролын салбарт хүний эрхэд суурилсан сурч боловсрох эрхийн талаарх төрийн зүгээс зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээний заалтад бүх нийтийн боловсрол эзэмших эрхийг хангахад чиглэсэн холбогдох хууль тогтоомжийг хянан үзэх, тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхэд, оюутан суралцагчдыг боловсролын гадна үлдээхгүйгээр чанартай боловсролд тэгш хамруулахыг чухалчилж байна.

- Хүүхэд бүр боловсролын үйлчилгээнд тэгш хамрагдах эрхийг хангах,
- Чадвар, тусгай хэрэгцээ зэргээс үл хамааран сурагч, оюутан бүрийн сурч боловсрох эрхийг хангах
- Эрүүл мэндийн шалтгаанаар сургуульд сурах боломжгүй хүүхдүүдэд суралцах цогц орчин бүрдүүлэх,
- Дохионы хэлний багш нарыг хүрэлцээтэй болгох
- Тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах багш нарыг мэргэшүүлэх, чадавхжуулах боломжийг нэмэгдүүлэхийг БШУЯ, түүний харьяа мэргэжлийн байгууллагуудын хамтын үйл ажиллагаагаар хэрэгжүүлж ажиллаж байна.

Хувь судлаачийн хувьд цахим сургалт болон уламжлалт сургалтын аргыг хослуулан хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудын суралцах боломжийг нэмэгдүүлэх гарц, шийдлүүдийг ч анхааралдаа авах, судлах зайлшгүй шаардлагатай гэж үздэг. Үүнд:



Хөгжлийн бэрхшээлтэй болон тусгай хэрэгцээ шаардлагатай оюутан суралцагчдад боловсролын байгууллагын зүгээс сонголттой, олон төрлийн хөтөлбөр, арга зүй, сургалтын орчны дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Боловсролын салбарт дээрх дэмжлэг

үзүүлэх хөтөлбөр, үйлчилгээний хүрээнд

- ① Боловсролын нэмэлт дэмжлэг,
- ② Хөгжлийн бэрхшээлтэй оюутан, сурагчдад үзүүлэх тусгай дэмжлэг,
- ③ Хөгжлийн бэрхшээлтэй оюутан, сурагчдын хөтөлбөрийг бүх оюутан суралцагчид, сургуулиудыг багтаан хамруулах боломжтой.

Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй болон суралцахад хүндрэлтэй, зан төлөвийн хувьд тусгай дэмжлэг шаардлагатай суралцагчдыг хамруулах өргөн хүрээний хөтөлбөр санаачлага юм. Хөгжлийн бэрхшээлтэй оюутан сурагчид боловсролын хөтөлбөрт хамрагдах, их дээд сургуульд элсэн ороход хязгаарлалт байх учиргүй. Хөгжлийн бэрхшээл гэдэг ойлголтод тэдний хөгжих, сурах онцлогийг дэмжих үйл ажиллагааг сургууль, боловсролын байгууллагуудын сурган хүмүүжүүлэгчдийн (багш, зааварлагч, сургагч, захиргааны удирдах ажилтнууд гэх мэт) хөгжлийн бэрхшээлтэй бүлэгт хандах хариуцлага, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх юм. Хөгжиж буй орны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох болоод ажил хөдөлмөр эрхлэх боломж нь ижил насны эрүүл иргэдээс бага байхын зэрэгцээ ихэвчлэн амьдралын түвшин доогуур байдаг. Монгол орны хувьд ч байдал ийм байна. Үүнтэй уялдан БШУЯ дунд болон дээд боловсролын байгууллагын аль алинд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөгжүүлэх цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг чухалчилж байна.

Дээд боловсролын системд ур чадварыг хөгжүүлэх санаачилга нь хөгжлийн бэрхшээлтэй бүлгийн итгэл үнэмшлийг нэмэгдүүлэн, сурч боловсрон

цаашид цалин хөлстэй ажил хөдөлмөр эрхлэхэд чиглэдэг. Гэсэн хэдий ч дээд боловсролын байгууллагад санхүүгийн саад бэрхшээл, нөөцийн хязгаарлагдмал байдал тулгарч байна. Монголын дээд боловсролын байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад дэмжлэг үзүүлэхийн тулд зөвлөгөө үйлчилгээ үзүүлэхийг чухалчилж байна. Үүний тулд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан сургалтын арга замыг оновчтой сонгох зөвлөгөө шаардлагатай болно. Энэхүү зөвлөгөө зөвлөмжийг Оюутны ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ба зөвлөх нэгжээр дамжуулан олгох нь зүйтэй бөгөөд ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй оюутан суралцагчидтай ажиллахад мэргэшсэн дэмжигч багш (support teacher) болон шилжилт хариуцсан мэргэжилтэн (transition officer) энэ чиглэлийн зөвлөгөөг олгох ёстой.

Ямар оюутнуудад туслалцаа шаардлагатай вэ?



Анхаарвал зохих оюутан суралцагчид:

- ✓ Сонсголын бэрхшээлтэй
- ✓ Харааны бэрхшээлтэй
- ✓ Оюун ухааны бэрхшээлтэй
- ✓ Биеийн хөгжлийн болон хүнд архаг өвчин, эмчилгээний нөхцөлтэй
- ✓ Хэл ярианы бэрхшээлтэй.

Хөгжлийн бэрхшээлтэй оюутан, суралцагчдад

- ❖ элсэлтийн нэмэлт дэмжлэг,
- ❖ сургалтын материалын туслалцаа,
- ❖ суралцах болон цаг зохицуулалтын стратеги,
- ❖ сургалтын ганцаарчилсан дэмжлэг шаардлагатай байдаг.

бэрхшээлтэй болон суралцахад хүндрэлтэй, тусгай дэмжлэг шаардлагатай оюутнуудад шууд болон явцын дэмжлэг үзүүлдэг.

- Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ)-ын хэвлэл, гарын авлага, ном товхимол зэргийг орчуулан хэвлэж ашиглахад ОУХБ болон бусад донор байгууллагын дэмжлэг авах гэх мэт.

Судлаачийн зүгээс дэвшүүлж буй гол санаа

“Цахим болон уламжлалт сургалтыг хослуулан хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудын суралцах боломжийг нэмэгдүүлэх гарц, шийдлүүдийг нэмэгдүүлэх...”

Учир нь “Аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгал эхэлсэн эсэх дээр эрдэмтэн мэргэжилтнүүдийн санал хоёр хуваагддаг. Нэг хэсэг нь технологийн үсрэнгүй хөгжлөөр өдөөгдсөн энэхүү хувьсгалыг компьютерийн үеийн буюу гуравдугаар хувьсгалын үргэлжлэл гэж үздэг бол нөгөө хэсэг нь хүн төрөлхтний өмнө цоо шинэ түүхийн хуудас нээгдэж байгааг хэлдэг. Өмнөх гурван хувьсгалтай харьцуулбал өргөн цар хүрээг хамарч, маш хурдацтай тархаж байгаа, мөн эдийн засаг, бизнес, нийгмийн салбаруудад төдийгүй хувь хүний амьдралд ч урьд хожид үзэгдээгүй олон суурь шилжилтийг бий болгож байгаагаас харахад аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгал эхэлсэнд бат итгэлтэй байгаагаа” Дэлхийн эдийн засгийн чуулганыг үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал Клаус Шваб **“Аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгал”** номондоо онцлон тэмдэглэжээ.

Мөн XVIII зууны хоёрдугаар хагасаас эхлэн аж үйлдвэрийн хэд хэдэн хувьсгал цувран өрнөсөн нь хүний хүчийг техникээр орлуулсан шинжтэй байсан. Харин одоо хүний оюун ухааныг техникээр орлуулах аж үйлдвэрийн шинэ хувьсгал ирлээ. Эл хувьсгалыг хөдөлгөөнт интернет, бичил боловч илүү чадалтай мэдрэгчүүд, хиймэл оюун ухаанд суурилсан хямд төсөр технологийн дэвшлээр ерөнхийд нь тодорхойлж болох ч энэ нь таны бодсоноос ч илүү өргөн хүрээг хамарна. Учир нь шинэ хувьсгалаас мэндэлсэн технологиуд болон инновацууд нэг нэгнээ өдөөн улам гүнзгийрүүлэн хөгжүүлдэг онцлогтой бөгөөд тэр хөгжил хаа хүрэхийг таашгүй. Аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгал хүн төрөлхтөнд асар их шинэ боломжийг авчрах ч яг ижил хэмжээний асуудал, эрсдэлийг ч мөн дагуулна. Түүнд бэлэн биш байна гээд зугтаж зайлах боломжгүй. Аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгал эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хүн

төрөлхтөнд нүүрлээд буй хүндхэн сорилтуудыг даван туулахад тусална. Гагцхүү энэ хувьсгалын сөрөг тал, тэр тусмаа тэгш бус байдал, хөдөлмөрийн зах зээлд үзүүлэх нөлөөг удирдан залж, инновацын тархалтыг хяналтаас алдах эрсдэлээс хамгаалах нь чухал гэдгийг зохиогч сануулжээ. Судлаачид мөн адил дээрх зохиогчийн үзэж буйтай санал нэгтэй байна. Учир нь энэхүү аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгалын нөлөөнд боловсролын салбар ч өртөж, цахим орчинд суралцах, судалгаа хийх, ажиллах боломж бүрдэж эхэлсэн. Үүний тод жишээ бол дэлхий нийтийг хамарсан COVID-19 цар тахал юм. Цар тахлын нөлөөгөөр дэлхий нийтэд бүх сургууль, сургалтын төвүүдийн үйл ажиллагаа зогсонги байдалд орж, цахим сургалт, теле хичээлийн хэлбэрт шилжээд байгаа билээ. Бид хөгжлийн бэрхшээлтэй иргэний танхимын болон цахим хэлбэр хосолсон сургалтаар мэргэжлийн болон дээд боловсрол эзэмших боломжийг илүү ихээр нэмэгдүүлэх дараах боломжууд байна гэж үзэж байна.

- Бүх шатны боловсролын байгууллагуудад орчны болон сургалтын заах арга зүйг хүртээмжтэй болгоход чиглэгдсэн арга хэмжээг авах(Цахим болон уламжлалт сургалт хослуулах);
- Мэргэжлийн хамтарсан багаар их, дээд сургууль, коллеж, ерөнхий боловсролын сургуулийн суралцагч, цэцэрлэгт хүмүүжиж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, оюутнуудад тохирох цахим хэрэглэгдэхүүн, цахим сургалтын орчныг бүрдүүлэн гэрээр суралцах боломжийг давхар бүрдүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, оюутан залууст боловсрол эзэмших сурах олон төрлийн аргачлалыг хүлээн зөвшөөрөх;
- Их, дээд сургуулийн багш нар, тусгай хэрэгцээт боловсролын багш нар, дохионы хэлмэрч-орчуулагч, сэтгэл зүйч, IT-ийн инженерүүдийн хамтарсан багаар цахим контент, цахим болон теле хичээлүүдийг хөгжүүлэх;
- Сургалтад ашиглагдаж буй ном, сурах бичгийг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын онцлог хэрэгцээнд нийцүүлэн хүртээмжтэй хэлбэрээр түгээх /аудио, видео, DVD, брайль, дохионы хэлээр бэлтгэсэн контент, хичээлүүд, дүрс зурган өгүүлэмжтэй цахим сургалтын талбарыг уламжлалт сургалттай хослуулан хөгжүүлэх/;

- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад ээлтэй жишиг номын сан байгуулах(Цахим болон уламжлалт сургалт хослуулах);
- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан цахим болон уламжлалт сургалтаар бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалтын зардлын хэмжээ, олгох тэтгэлэг зэргийг төрийн бодлоготой уялдуулан баталгаажуулж, элсэгчдэд суралцах боломжийг нээж өгөх;
- Сургуулийн бүх барилга, зам, талбай, нийтийн бие засах газар, тээврийн үйл ажиллагааг Монгол Улсын болон олон улсын стандарттай нийцүүлэн бодитой хийж, хэрэгжүүлэх;

Ингэснээр дээд боловсролын байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн хэрэгцээ, сонирхол, мэргэжлийн онцлогийг харгалзан цахим болон танхимын хүртээмжтэй, зориулалтын суралцах, хөгжих орчинг бүрдүүлэх, төгсөгчдийг ажлын байраар хангахад ажил олгогчтой хамтран ажиллах боломжуудыг илүү сайн нэмэгдүүлэх, юм.

Ашигласан ном зүй

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын Байгууллага (ЮНЕСКО)-ын Монголын Үндэсний Комисс <http://www.unesco.mn/p/48>
2. УИХ, Хөдөлмөрийн тухай хууль
3. УИХ, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль /Шинэчилсэн найруулга/
4. УИХ, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль
5. ҮСХ, Тодорхойлолт “Хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэж бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг хэлнэ. <https://www.1212.mn>
6. МУЗГ, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, оролцоог нэмэгдүүлэх, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр 2016-2020
7. БШУЯ, АХБ, ДБШТ. Сургалтын үйл ажиллагааг хөдөлмөрийн зах зээлийн судалгаатай уялдуулах гарын авлага-2016
8. Дэлхийн эдийн засгийн чуулганыг үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал Клаус Шваб "Аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгал" ном УБ 2020.

9. “Зууны мэдээ” сонин 2020.9.21 ДАВАА № 182 (6407) БШУЯ-ны Тусгай хэрэгцээт боловсролын хэлтсийн мэргэжилтэн Б.Гэрэлтуяа
10. Р.Нурбек, Д.Болормаа, Д.Анхтуяа. **“Расширение возможностей электронного обучения для студентов с ограниченными возможностями”** Министерство науки и высшего образования РФ, ФГБОУ ВО «Тувинский государственный университет» Тува, 2020.

**ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛ ШААРДЛАГАТАЙ
ХҮҮХДҮҮДИЙН СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮНИЙГ
БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ**

Н.Баярмаа¹, Х.Сайнсанаа², С.Өнөрсайхан³

¹Монголын үндэсний Эрдэмийн их сургууль

² Монгол улсын их сургууль

³Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

Хураангуй

Манай улс хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ийн конвенцын 8 дугаар зүйлийг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгмийн нэг гишүүн байж, бусдын адил сурч, боловсорч, хөдөлмөр эрхлэх, эрүүл амьдрах бүрэн эрхтэйг нийгэмд ойлгуулж, тэдний нийгэмд эзлэх байр суурийг бүхий л давхаргад бий болгох, хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголтыг нэмэгдүүлэх, тэдний амьдралд бие даах чадварт суралцуулах үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна. Хүүхэд бүрийн бэрхшээл тус бүрт тохируулан хүүхдүүдийн сэтгэл зүйн онцлогийг харгалзан үзэж сургалтын хэрэглэгдэхүүнийг санаачилж түүнд түшиглэн сургалт явуулж, боловсролд хамрагдаж чадахгүй байгаа хүүхдүүдийг бүрэн гүйцэд хамруулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн амьдрах чадварыг дээшлүүлэх шаардлагатай байна. Иймээс бид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэтгэл зүйн онцлог, боловсролд хамрагдаж чадахгүй байгаа шалтгааныг судлах, сургалтаар хэрхэн төлөвшиж, ахиж байгааг нь харьцуулан судлах, үр дүнг тооцох зорилгоор энэхүү судалгааг гүйцэтгэв. Судалгааг нийт 6 сарын хугацаанд зохион байгуулсан бөгөөд аутизмтай 10, хавсарсан бэрхшээлтэй 4, нийт 14 хүүхдийг хамруулан “тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдүүдийн сургалтын хэрэглэгдэхүүн”-ийг хэрэглүүлэн харьцуулан жиших, ажиглах, нэгтхэн дүнгнэх, задлан шинжлэх, асуудал дэвшүүлж томъёолох зэрэг судалгааны аргуудыг хэрэглэн чадварыг нь үнэлсэн. Сургалтын үр дүнд хүүхдүүд өнгө ялгах, тоо тоолох, үсээ сүлжих, үдээсээ тайлах, үдэх, цаг тоолол таних, их бага дүрс таних, шүр хэлхэх зэрэг чадваруудыг эзэмшиж сурсан нь бидний боловсруулсан сургалтын хэрэглэгдэхүүн хүүхдүүдийг боловсрол эзэмшүүлэхэд шаардлагатай сургалтын хэрэгсэл болж чадахыг харуулснаас гадна хүүхдүүдийг бие даах, бусдад гадуурхагдах, өөртөө гутрах зэрэг олон эрсдэлээс сэргийлж чадаж байна.

Түлхүүр үг: Хөгжлийн бэрхшээл, боловсрол, өнгө ялгах, үдээс үдэх, тоо тоолох, үс сүлжих, дүрс таних чадвар

Удиртгал

Өнөөдөр дэлхий нийтийн хандлага болон Монгол улсын төрийн бодлого боловсролын тусгай хэрэгцээт хүүхдүүдийн гердийн сургуульд тэгш хамруулах зарчим баримталдаг [1]. Өөрөөр хэлбэл, хүүхдийг тусгай хэрэгцээт, хөгжлийн бэрхшээл зэрэг ямар нэгэн ялгаатай байдлаар ялгаварлалгүйгээр боловсролд тэгш

хамруулахыг зорьдог билээ. Хөгжлийн бэрхшээлтэй, тусгай хэрэгцээ шаардлагатай байгаа хүүхэд нь бусдын адил хүсэл мөрөөдөлтэй, тэмүүлэлтэй, аливаа зүйлийг сурч мэдэх тодорхой чадамжтай байдаг гэдгийг олон нийт ойлгож, хандлагаа өөрчилж, тэдэнд боломж олгосон цагт хүүхэд бүр ялгаварлан гадуурхалтгүй орчинд сурч, хөгжих боломжтой [2,3]. Бид бүхэн хөгжлийн бэрхшээлийг зөвхөн анагаах ухааны талаас нь тодорхойлдог байсан бол өнөө үед нийгмийн бүтэцтэй нь хамт авч үздэг болжээ. Суралцах бэрхшээлийн шалтгааныг “Танин мэдэхүйн тэнцвэргүй байдал”-тайнь холбон тайлбарладаг. Танин мэдэхүйд анхаарлаа хандуулах чадвар, харсан зүйл болон бусдын хэлснийг цээжилж тогтоох чадвар (Ой тогтоолт), хэлбэр дүрс, байрлалыг ялган таних чадвар (Харааны танин мэдэхүй), дуу чимээг сонсож ялгах чадвар (Сонсголын танин мэдэхүй) зэрэг олон чадварууд багтах ба эд бүгд суралцахуйн үндэс суурь болдог. Эдгээр чадвар тэнцвэртэй хөгжсөн бол хүүхэд сурахад асуудал үүсэхгүй [4].

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны 2016-2020 оны мөрийн хөтөлбөр, Боловсролын тухай багц хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд адил тэгш боломж олгох, нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах, сурч боловсрох, ажил хөдөлмөр эрхлэх зэрэг эрх ашгийг нь хамгаалах чиглэлээр олон улсын гэрээ, эрх зүйн баримт бичгүүдийг удирдлага болгон бүхий түвшинд бодлогын зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна [5]. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүр хэрэгцээндээ нийцсэн боловсролын үйлчилгээ, хөгжлийн дэмжлэг хүртэх эрхтэй. Бид өмнө нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах хөтөлбөрийг хэрэгжүүлснээр тэдний сурч боловсрох орчныг сайжруулахад чиглэсэн техник тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүний шууд хөрөнгө оруулалт нэмэгдүүлэхэд анхаарч ирсэн билээ. Харин өнөөдөр багш, удирдах ажилтнуудын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үнэлэх, хөгжлийн дэмжлэг үзүүлэх чадварыг бэхжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, ялангуяа оюуны бэрхшээлтэй хүүхдүүдэд чанартай боловсрол олгох шаардлага бидэнд тулгараад байна [6]. Иймд тусгай хэрэгцээт боловсролын үйлчилгээг өнөөгийн хөгжлийн шаардлагад нийцүүлэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хязгаарлагдмал чадавхи боломжийг ойлгож, хүндэтгэх, эрт илрүүлэх, оношлох, тэдний онцлог хэрэгцээнд тулгуурласан үйлчилгээг сайжруулах замаар дэмжин хөгжүүлэх, нийгмийн

сэтгэлзүйг төлөвшүүлэх, нийгмийн харилцаанд бие даан оролцох боломжийг нь нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага бидний өмнө тулгамдсан олон асуудлын нэг болоод байна [7,8]. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон хүмүүс нь амьдарч буй орчиндоо бусдын адил бүх шатны боловсролын үйлчилгээнд тэгш, чанартай хамрагдах боломжийг бүрдүүлэх, тэдний эрүүл мэнд, сэргээн засах тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг тулгамдаж буй олон асуудлуудыг шийдвэрлэхэд тус болох зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэтгэлзүйн онцлог, боловсролд хамрагдаж чадахгүй байгаа шалтгааныг судлах, сургалтаар хэрхэн төлөвшиж, ахиж байгааг нь харьцуулан судлах, үр дүнг тооцох зорилгоор энэхүү судалгааг гүйцэтгэв.

Зорилго, Зорилт

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэтгэл зүйн онцлогийг судлан, амьдралд бие дааж өдөр тутамдаа хийж гүйцэтгэх үйлдлийг зааж сургах зорилгоор дараах зорилтуудыг тавьж ажиллав. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэтгэл зүйн онцлог, боловсролд хамрагдаж чадахгүй байгаа шалтгааныг судлах.
- Сургалтаар хэрхэн төлөвшиж, ахиц дэвшлийг харьцуулан судлах, үр дүнг тооцох.

Материал, Арга Зүй

Судалгааг 2020 онд 6 сарын хугацаатайгаар зохион байгуулсан бөгөөд судалгаанд нийт 14 хүүхдийг хамруулан өөрсдийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нас, хүйс, онцлогт тохируулан боловсруулсан сургалтын хэрэгсэлүүд (Зураг 1)-ийг ашиглан гүйцэтгэв.





Зураг 1. Сургалтын хэрэгсэл буюу эсгий номнууд

Эсгий номнууд нь хүүхдийн эрүүл мэндэд харшлахгүй эко материалаар хийгдсэн бөгөөд өнгө хүүхдийн анхаарлыг татахуйц тод, хурц бөгөөд хүүхэд өөрийн өмсөх хувцас, цүнх гэх мэт зүйлийн товч цахилгааныг татаж, нээх үйлдлийг гүйцэтгэж сурах нь гарын жижиг булчин хөгжүүлэх болон бусдын тусламжгүй хувцсаа өмсөж, тайлах эхний алхамыг гүйцэтгэж сурахад нөлөөлж болно. Ан амьтны дүрс, геометрийн дүрс эвлүүлэх, үүл, бороо зэргийг таньж, мэдэх, өнгө ялгах, тоо хасч, нэмэх үйлдлийг хийж сурах зэрэг нь оюун ухааныг хөгжүүлэхээс гадна гарын хурууны жижиг булчинг хөгжүүлэх сайн талуудтай юм. Эсгийгээр хийж бүтээсэн ном буюу сургалтын хэрэгслийн давуу талууд:

- Эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй
- Хүүхдийн сэтгэхүйд нийцсэн, сонирхол татахуйц
- Биеийн хөдөлгөөн оюуны чадамж, хараа, ой тогтоолт сайжруулах
- Бие дааж амьдрах чадвар суух
- Цаашид боловсрол эзэмших талын хүндрэл бэрхшээл багасах
- Хүүхдийн сэтгэл санаа дээшилж, урам зориг, итгэл үнэмшил төрөх
- Хүүхдүүдийн бэрхшээл тус бүрт тохируулж, өөрчилж болдог
- Эрүүл мэндийн бусад дадал хэвшил эзэмшүүлэх олон төрлөөр бүтээж болно
- Халдварт болон халдварт бус өвчлөл, гар угаах арга зэрэг хүссэн төрөл загвараар бүтээж болдог олон давуу талуудтай хэрэглэгдэхүүн юм.


Энэхүү судалгаанд харьцуулан жиших, ажиглах, нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх, асуудал дэвшүүлж томъёолох зэрэг судалгааны аргуудыг хэрэглэн дараах төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн болно (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдүүдийг сургах туршилтын ажлын төлөвлөгөө


№	Үзүүлэлтүүд	Хугацаа	Хаана
1	Өнгө ялгах чадвар	6 сар	Гэрт /явуулын сургалт/
2	Дүрс эвлүүлэх	6 сар	Гэрт/явуулын сургалт/
3	Гутал үдэх	6 сар	Гэрт/явуулын сургалт
4	Хувцас /цахилгаан, товч, тайлах/	6 сар	Гэрт/явуулын сургалт
5	Тоо нүдлэх	6 сар	Гэрт/явуулын сургалт
6	Цаг тоолол	6 сар	Гэрт/явуулын сургалт
7	Үсээ сүлжих, самнах	6 сар	Гэрт/явуулын сургалт
8	Нисэх, хөвөх, авто замын тухай мэдлэг	6 сар	Гэрт/явуулын сургалт
9	Байгалийн үзэгдэлийн тухай мэдлэг	6 сар	Гэрт/явуулын сургалт
10	Амьтаны дүрс эдлүүлж сурах	6 сар	Гэрт/явуулын сургалт

Үр дүн

Судалгаанд аутизмтай 10, хавсарсан бэрхшээлтэй 4, нийт 14 хүүхэд хамрагдсан бөгөөд 4-6 настай 8 хүүхэд, 7-9 настай 4 хүүхэд, 10-12 настай 2 хүүхэд хамрагдлаа(Зураг 1, 2).




Зураг 1. Судалгаанд хамрагдсан хүүхдүүд, насны ангиллаар




Зураг 2. Судалгаанд хамрагдсан хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлээр

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийг хүйсээр авч үзвэл эмэгтэй 8, эрэгтэй 6 хүүхэд байсан (Зураг 3).



Зураг 3. Судалгаанд хамрагдсан хүүхдүүд, хүйсээр

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн боловсролд хамрагдаж чадахгүй байгаа шалтгаан нь зөөх хүргэх хүнгүй 5, ам бүл олон 3, сурч чадахгүй гэж үзсэн 2, санхүүгийн боломжгүй 4 хүүхэд байлаа (Зураг 4).



Зураг 4. Боловсролд хамрагдаж чадаагүй шалтгаан

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн өнгө ялгах, дүрс эвлүүлэх, үдээс үдэх, хувцасны цахилгаан, товчийг тайлах, товчлох, тоо нүдлэх, цаг тоолох, үсээ сүлжих, самнах зэрэг чадваруудыг өөрсдийн боловсруулсан “тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдүүдийн сургалтын хэрэглэгдэхүүн” болох эсгийн номуудыг хэрэглүүлэн 6 сарын дараа үнэлэхэд маш сайн ахиц гарсан байв (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Сургалтын үр дүн

Үзүүлэлт	Өнгө ялгах чадвар	Дүрс эвлүүлэх	Үдээс үдэх	Хувцас /цахилгаан, товч, тайлах/	Тоо нүдлэх	Цаг тоолол	Үсээ сүлжих, самнах
Сургалтын өмнө, хүүхдийн тоо	3	4	2	5	4	4	1
Сургалтын дараа, хүүхдийн тоо	14	14	12	9	14	10	13
Гарсан ахиц, хүүхдийн тоо	11	10	12	9	10	10	13

Дүгнэлт

1. Шинэ зууны үндсэн зорилт бол хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах асуудал бөгөөд тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдүүдийн

бэрхшээл тус бүрт тохируулсан сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулж хэрэглэх нь тэдний бие дааж, бусдын туслалцаагүй өдөр бүр хийж чадах чадварт суралцуулах, тэдний алдагдсан чадамжийг сэргээх, хөгжүүлэхэд нэн чухал шаардлагатай болохыг харуулж байна.

2. Сургалтын үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд өнгө ялгах, тоо тоолох, үсээ сүлжих, үдээсээ тайлах, үдэх, цаг тоолол таних, их бага дүрс таних, шүр хэлхэх зэрэг чадвартай болов.
3. Хүүхэд хоолоо идэх, хувцсаа өөрөө өмсөх, болохгүй гэхээр больж, босоод аягаа аваад ир гэх мэт үйлдлийг биелүүлэх нь хөгжлийн бэрхшээлтэй ялангуяа аутизмтай хүүхдүүдийн хувьд асуудал болж хувирдаг бөгөөд аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдүүдэд нийгэмд биеэ авч явах чадвар сул, дийлэнх нь харилцаанд орж чадахгүй тул наад захын үйлдлийг нэг бүрчлэн заах сургалтыг гэрээр явуулын сургалт хэлбэрээр өгөх нь илүү тохиромжтой байна.
4. Судалгаанаас үзэхэд манай эцэг эхчүүд бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд хамруулах тал дээр хангалтгүй, сурах чадваргүй гэсэн буруу үзэл бодолтойгоос боловсролд хамруулахгүй байгаа тул төрийн болон төрийн бус байгууллага, өрх хорооны нийгмийн ажилтнуудыг сургалт арга зүйгээр хангаж ажиллах шаардлагатай байна.

Талархал

Бидний судалгаанд сэтгэл санаа үнэтэй сургамж, санаа бодол хэлж, бидний ажилд туслан, хамтран ажилласан судалгаанд хамрагдсан хүүхдүүд, тэдний асран хамгаалагч нар, МҮЭИС-ийн эрдэмтэн багш нар, ДАШУИС-ийн багш Х.Амаржаргал, “Ач” АУИС –ийн багш Д.Дүүриймаа, СБД-ийн 6-р хорооны ӨЭМТ-ийн эмч, сувилагч нар, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сэргээн засах үндэсний төвийн багш, номын санч нар, “Оюу Номин” ТББ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асрамж, сувиллын хамт олон, “Тод-Эйч” хүүхдийн өсөлтийн эмнэлэг, “Алтан бийр” уран зургийн дэлгүүрийн худалдагч Б. Хорлоо, жолооч Д.Отгонсайхан, 69-р сургуулийн 9Б ангийн сурагч О.Насан-Өлзий нартаа чин сэтгэлийн талархал илэрхийлэе.

Ном зүй

1. “Хүүхдийн эрх”, Улаанбаатар, 2010
2. Е.А.Аркин, “Сургуулийн өмнөх хүмүүжлийн асуудлууд” 1953, 113х
3. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхцөл байдлын талаарх зураглал”, Улаанбаатар, 2005
4. “Хүүхэд бүрийн онцлогт хэрэглээнд нийцүүлэн сургалтын үйл ажиллагаа явуулах нь”, Улаанбаатар, 2008
5. “Эрдэм боловсролтой Монгол хүн”, Боловсрол шинжлэх ухааны чанарын шинэчлэлийн хөтөлбөр-2012-2016 он, Улаанбаатар, 2012
6. “Бага насны хүүхдэд тусгай боловсролын үйлчилгээ үзүүлэхэд ашиглах гарын авлага”, Улаанбаатар, 2008
7. “Бага насны хүүхдийг хөгжүүлэх алхам алхамаар”, Улаанбаатар, 1990
8. Н.Норжинхорлоо, “Сургах тоглоом”, Улаанбаатар, 2006

**БОЛОВСРОЛЫН САЛБАРААС ТУСГАЙ СУРГУУЛЬ-ХӨГЖЛИЙН
БЭРХШЭЭЛТЭЙ СУРАГЧИД РУУ ЧИГЛЭСЭН ТӨСӨЛ,
ХӨТӨЛБӨРҮҮДИЙН СУДАЛГАА БА БЭРХШЭЭЛ-ШИЙДВЭРЛЭХ
АРГА ЗАМ**

Монгол Улсын боловсролын их сургууль

Нийгэм Хүмүүнлэгийн Ухааны Сургууль

Хураангуй

Аль ч улс орны боловсролын салбар тухайн улс орны ирээдүйг тодорхойлдог чухал салбар байдаг. Сүүлийн 10 жилийн дунджаар зарим улс орнуудын боловсролын салбартаа оруулж буй хөрөнгө оруулалтыг, төсөвт эзлэх хувиар тодорхойлжээ. Болгар 10.77%, Чех 9.67%, Унгар 9.82%, Япон 9.51%, АНУ 14.71% Монгол 14.7% (*Боловсролын салбарын санхүүжилт, хөрөнгө оруулалтын судалгаа, 2019.*)-аар Монгол улс бусад улс орнуудтай харьцуулахад төсвийн эзлэх хувь харьцангуй өндөр байна. Боловсролын салбарын нийт төсвийн 46% нь ерөнхий боловсролд, 23% нь СӨБ-д, 9% нь дээд боловсролд, 4% нь ТМБС-д, харин 18% нь салбарын менежментэд зарцуулагддаг. (*Боловсролын салбарын санхүүжилт, хөрөнгө оруулалтын судалгаа. хуудас 22.*) Боловсролын салбарын хөрөнгө оруулалтад дүн шинжилгээ хийдэг шинжээч нарын зүгээс энэ асуудал нь үр дүнгүй, тэгш бус зарцуулалтын асуудал гэж үздэг.

Ялангуяа боловсролын салбарт суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын асуудал бол зайлшгүй хөндөгдөх шаардлагатай, мөн төдийлөн их дурдагддаггүй асуудал байгаа юм. Иймээс МУ-ын хэмжээнд ойрын 5-6 жилийн хугацаанд “хүүхэд” болоод “хөгжлийн бэрхшээлтэй” иргэд рүү чиглэсэн хичнээн төсөл, хөтөлбөр хэрэгжиж байгаа талаар судлах замаар боловсролын салбараар дамжигдан хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийг судлах хэрэгцээ-шаардлага гарч байгаа юм. Боловсролын салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдээс “тусгай сургууль болоод хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын тулгамдаж буй асуудал”-ыг судлахад 1. Хүүхэд рүү чиглэсэн 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд рүү чиглэсэн гэх 2 чиглэлийг сонгон авсан. Энэ төсөл, хөтөлбөрүүдээс хичнээн хувь нь тусгай сургууль болоод хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын орчин нөхцөлийг сайжруулах талаар тусгагдсаныг судална. Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын сургуулийн орчинд хэрэгжсэн төсөл, хөтөлбөрүүдийг судалж, үр дүн-хэрэгжилтийг судлах замаар цаашид эдгээр сурагчдыг дэмжих-орчин нөхцлийг сайжруулах ямар үйл ажиллагаа хэрэгжвэл зохистой, шийдвэрлэх арга зам зэргийг тодорхойлоход өөрийн шинэлэг санааг дэвшүүлжээ.

Түлхүүр үг: Төсөл, хөтөлбөр, тусгай сургууль, хөгжлийн бэрхшээл, хүүхэд

Удиртгал

Хүүхэд сурч боловсрох, эрүүл аюулгүй орчинд амьдрах, хамтран суралцах, сургууль, гэр бүл, олон нийттэй харилцах орчин гэх мэт хүүхэд байгаа газар бүр хүүхдийн эрх адил тэгш хэрэгжих эрхтэй. Тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй

сурагчдын сурах орчин нөхцөлийн асуудал төдийлэн бага дурдагддаг, тэдгээр хүүхдийн асуудал нь массыг хамарсан шинж чанартай байгаа нь цаашид хөгжиж, өөрийгөө нийгмийн чухал гишүүн гэж үзэх хандлагыг бууруулж байгаа нь учир дутагдалтай гэж үзэж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах орчин, нөхцөлийн асуудал нь ердийн сурагчдыг бодвол харьцангуй тусгай арга зүй-аргачлалыг ашиглаж явуулах хэрэгтэй бөгөөд цаашид сурагчийн нас, сэтгэхүйн онцлогыг харгалзаж үзэх нь чухал юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болоод хүүхэд рүү чиглэсэн 36 төсөл хөтөлбөрийг судлах замаар тусгай сургууль болоод хөгжлийн бэрхшээлтэй сурагчид руу чиглэсэн төсөл хөтөлбөрийг судалсан. Нийт төсөл, хөтөлбөрийн 11,1% нь л хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлыг хөндсөн байгаа юм. Иймээс тусгай сургуулиуд дээр хэрэгжсэн төсөл, хөтөлбөрүүдийг судлах замаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн асуудлыг сайжруулах тал дээр ямар төсөл хөтөлбөрүүд хэрэгжсэнийг судлах болно.

Зорилго

Манай улсын хэмжээнд хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдээс боловсролын салбар, тэр дундаа тусгай сургууль, хөгжлийн бэрхшээлтэй сурагчид руу чиглэсэн төсөл-хөтөлбөрүүдийг сонгон авч хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын сургуулийн орчин дахь тулгамдаж буй асуудлыг нарийвчлан судалж, дүгнэх зорилготой.

Зорилт

- Эх баримт бичгийн судалгаа хийх
- Судалгааны төлөвлөгөө, аргазүйг боловсруулах
- Судалгааны ажлыг зохион байгуулж, үр дүнг боловсруулан дүгнэх
- Судалгааны ажилд үндэслэсэн санал дэвшүүлэх

Онолын судалгаа

1. Хүүхдийн эрхийн конвенц-д 18 насанд хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ гэж тодорхойлсон байдаг.
2. “Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт бие махбод, сэтгэл мэдрэл, оюун санаа, мэдрэхүйн байнгын согогтой бөгөөд уг согог нь янз бүрийн саад тотгортой нийлсний улмаас бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад учруулахуйц болсон хүнийг багтааж ойлгоно”

3. Ерөнхий боловсролын тусгай сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сэргээн засах, чийрэгжүүлэх, бие даалгах үйлчилгээ үзүүлж, бага, суурь, бүрэн дунд боловсрол, мэргэжил эзэмшүүлэх сургалтын байгууллага мөн.
4. Төсөл гэдэг нь ажил хэргийг хэрхэн гүйцэтгэх тухай урьдчилан тооцоолж, төлөвлөсөн төлөвлөгөө гэсэн утгатай бол хөтөлбөр үгийн утга нь “дагаж мөрдлөг болговол зохих юм” гэсэн утгатай.

Судалгааны арга зүй

1. Эх баримт бичгийн судалгааны арга

МУ-ын хэмжээнд 2012 оноос хойш хэрэгжсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэд болоод хүүхэд рүү чиглэсэн 34 төсөл хөтөлбөрт эх баримт бичгийн судалгаа хийсэн. Хүснэгт1-т нийт хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүдээс ААН-байгууллага болон БШУЯ-тай хамтарсан гэсэн 2 чиглэлийг тодорхойлон авлаа. Боловсролын салбараас хэрэгжсэн нийт төсөл, хөтөлбөрийг тодруулах замаар тусгай хэрэгцээт сурагчдын асуудлыг тусган харуулах зорилготой юм.

№	Төслийн нэр /хэрэгжсэн хугацаа/	Хэрэгжүүлсэн газар	
		ААН, байгууллага	БШУЯ болон /хамтарсан/
1	Хүүхдэд ээлтэй-Улаанбаатар (2015)	✓	
2	Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөр (2012-2015)	✓	
3	Хүүхэд ээлтэй орон нутаг хөтөлбөрийн хүрээнд Хөвсгөл аймагт /НҮБХС-тай хамтран ажилласан./ (2015-2016)	✓	
4	“Хүүхдэд ээлтэй- Баянгол” дүүрэг хөтөлбөр()	✓	
5	Хүүхдэд ээлтэй “Хан-Уул” дүүрэг хөтөлбөр (2017-2018)	✓	
6	“Хүүхдэд ээлтэй-Өвөрхангай” хөтөлбөр (2016-2017)	✓	
7	“Хүүхдэд ээлтэй-Алтай” дэд хөтөлбөр (2018-2019)		✓
8	“Хүний эрхэд ээлтэй сургууль” (2005-2019) хөтөлбөр	✓	
9	“Хүүхдэд ээлтэй -Баянзүрх дүүрэг “ хөтөлбөр		✓
10	Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр (2018-2019)	✓	
11	“Хүүхдэд ээлтэй орон нутаг” хөтөлбөр Завхан аймагт (2017-2021)		✓
12	Сургууль-дотуур байрны хүүхдэд ээлтэй ус, ариун цэврийн байгууламжийг бий болгох” төсөл (2018-2019)		✓

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

13	Хүүхдэд ээлтэй–Орон нутаг” 2020 Налайх дүүрэг /НҮБХС-тай хамтран ажилласан/ (2017-2020)	✓	
14	Хүүхдэд ээлтэй дотуур байр” хөтөлбөрийн хүрээн дэх аян (2016-2017)		✓
15	Хүүхдэд ээлтэй –Чингэлтэй (2016-2018)	✓	
16	“Монголд буй Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг зогсооё” (2019.12-2020.12)	✓	
17	“Орон нутгийн хүүхэд хамгаалал” төсөл (2018)	✓	
18	“Монгол улсад хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” төсөл (2015-2018)	✓	
19	"Хүүхэд хамгаалагч" төсөл (2019 оноос)	✓	
20	Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” төсөл (2018-2022)	✓	
21	Хүүхдийн эсрэг хүчирхийллийг зогсооё” хүүхэд хамгаалал, нөлөөллийн төсөл (2017)	✓	
22	Монголын Пара Бочигийн Холбооноос хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг спортоор дамжуулан идэвхжүүлэн дэмжих төсөл (2019)	✓	
23	Хараагүй болон харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулж ‘брайл’ сурах бичиг хэвлүүлэх” төсөл (2017-2018)	✓	
24	“Хүйсэд суурилсан хүчирхийллээс сэргийлэхэд өсвөр насны хөвгүүдийн оролцоог дээшлүүлэх” (хүчирхийлэлгүй нийгэм) төсөл (2017)	✓	
25	“Харааны бэрхшээлтэй болон хараагүй хүүхдүүдэд сургуулийн орчны баримжаа олгох анги байгуулах” төсөл (2016)	✓	
26	Хүүхэд хамгаалагч төсөл (2019)	✓	
27	“School police” төсөл		✓
28	Боловсролын чанарын шинэчлэлийн бодлого-“Хүүхдэд ээлтэй сургууль хөтөлбөр” (2019)		✓
29	Хүүхдийн эрх-хүүхдийн хөгжил төсөл /2-р шат/ (2014-2018)	✓	
30	Хүүхдэд ээлтэй орон нутаг (2018) НҮБ	✓	
31	Хүүхэд хамгааллын жишиг сургууль” туршилтын хөтөлбөр		✓
32	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангаж, үйлчилгээ үзүүлэх төсөл (2018-2022)	✓	
33	Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл		✓

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

34	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, оролцоог нэмэгдүүлэх, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр (2017-2020)		✓
35	"Алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдийн бага боловсролын үр дүнг сайжруулах нь" төсөл (2012-2016)		✓
36	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангаж, үйлчилгээ үзүүлэх төсөл /Азийн хөгжлийн банк/		✓
Нийт төсөл, хөтөлбөр-36		24	12

Хүснэгт 1. Хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой төсөл, хөтөлбөрүүд




График1. БШУЯ болон БШУЯ-тай хамтарсан төсөл 13 байна. Энэ нь нийт төслийн 36%-тай тэнцэж байна .

БШУЯ-наас хэрэгжсэн төсөл, хөтөлбөрүүдээс хөгжлийн бэрхшээлтэй сурагчид руу чиглэсэн, чиглээгүй гэсэн 2 ангиллыг хүснэгт 2 харуулна. Үүнээс боловсролын салбарын зүгээс тусгай сургуулиудын сурагчид руу чиглэсэн хичнээн төсөл, хөтөлбөрүүдийн тоог тодорхойлж, нарийвчлан судалсан.

№	Төслийн нэр	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд /сурагчид/ руу чиглээгүй	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, /сурагчид/ руу чиглэсэн	
			Хөгжлийн бэрхшээлтэй сурагчид руу чиглэсэн /сургууль/	Ерөнхий хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд рүү чиглэсэн /баг, хороо, НТБТ гэх мэтээр/

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

1	“Хүүхдэд ээлтэй-Алтай” дэд хөтөлбөр (2018-2019)	✓		
2	“Хүүхдэд ээлтэй-Баянзүрх дүүрэг” хөтөлбөр	✓		
3	“Хүүхдэд ээлтэй орон нутаг” хөтөлбөр Завхан аймагт (2017-2021)	✓		
4	Сургууль-дотуур байрны хүүхдэд ээлтэй ус, ариун цэврийн байгууламжийг бий болгох” төсөл (2018-2019)	✓		
5	Хүүхдэд ээлтэй дотуур байр” хөтөлбөрийн хүрээн дэх аян (2016-2017)	✓		
6	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангаж, үйлчилгээ үзүүлэх /Азийн хөгжлийн банк/	✓		
7	“School police” төсөл оныг олох		✓	
8	Боловсролын чанарын шинэчлэлийн бодлого-“Хүүхдэд ээлтэй сургууль хөтөлбөр” (2019)		✓	
9	Хүүхэд хамгааллын жишиг сургууль” туршилтын хөтөлбөр	✓		
10	Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл оныг олох jaica		✓	
11	"Алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдийн бага боловсролын үр дүнг сайжруулах нь" төсөл (2012-2016)			✓
12	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, оролцоог нэмэгдүүлэх, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр (2017-2020)		✓	
Нийт-12		7	5	
			4	1

Хүснэгт 2. БШУЯ болон БШУЯ-тай хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн ангилал



БШУЯ-ны зүгээс сургуулиар дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд рүү чиглэсэн хичнээн төсөл, хөтөлбөр байгааг судаллаа. Сургуулиар дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй сурагчид

руу чиглэсэн нийт 4 төсөл, хөтөлбөр байгаа бөгөөд нийт төсөл, хөтөлбөрийн 8%-ийг эзэлж байгаа юм.

График2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлыг тусгаасан төсөл 41%-ийг эзэлж байна.

Эх баримт бичгийн судалгааны үр дүн

Нийт төсөл, хөтөлбөрүүдээс БШУЯ-ны зүгээс тусгай сургуулиуд, сурагчид руу чиглэсэн 4 төсөл, хөтөлбөр байгаа юм. Хүснэгт 3-т харуулсанаар тус төсөл, хөтөлбөрүүд нь сурагчийн болоод сургуулийн орчинд хийсэн үйл ажиллагааг товч, тодорхой илэрхийлсэн.

№	Төсөл, хөтөлбөрүүдийн нэр	Төсөл, хөтөлбөрөөр дамжуулан хийсэн үйл
1	“School police” төсөл оныг олох	1. Сургуулийн гадаад орчин 2. Сурагчийн аюулгүй байдал руу чиглэсэн төсөл, хөтөлбөр
2	Боловсролын чанарын шинэчлэлийн бодлого-“Хүүхдэд ээлтэй сургууль хөтөлбөр” (2019)	1. Сургалт зохион байгуулсан.
3	Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл оныг олох /JICA, БШУЯ/	1. Сургалтын хэрэглэгдэхүүнийг хангах чиглэл 2. Цөөн тооны багш чадавхижуулж байсан 3. Сургалт, семинарын үйл ажиллагаа зохион байгуулсан
4	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, оролцоог	1. Оношилгоо хийх арга зүйг боловсруулж турших. 2. Тусгай хэрэгцээт боловсон хүчин бэлтгэх

нэмэгдүүлэх, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр (2017-2020)	
--	--

Хүснэгт 3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд рүү чиглэсэн төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаа

Хүснэгт 3. – Төсөл хөтөлбөрийг нэгтгэвэл:

1. Сурагчийн материаллаг орчин
2. Сургалтын хэрэглэгдэхүүн
3. Багш, хүн хүчний нөөцийг чадавхижуулах
4. Сурагчийн оношлогоо хийх зэрэгт голчлон анхаарсан нь харагдаж байна

2.Ярилцлагын арга

Энэ ярилцлагын хүрээнд Нийслэлийн тусгай ЕБС-ийн сургалтын менежерүүдээс бэлтгэсэн асуултуудын хүрээнд ярилцсан. Тус сургуулиудын сургалтын менежерүүдээс эхний шатны ярилцлагыг авсан болно. Нийслэлийн хэмжээнд тусгай ЕБС-ийн 6 сургууль байдаг бөгөөд нийт 6000 гаруй суралцагчид боловсролын үйлчилгээ үзүүлж байгаа юм. Сургалтын менежерүүдийн ихэнх нь “энэ төсөл, хөтөлбөрүүдийн талаар тодорхой мэдээлэл байхгүй, хийгдсэн ажлыг санахгүй байна” гэх зэрэг зэрэг бусад шалтгаанаар мэдээлэл өгөхөөс татгалзсан. ЕБСийн харааны бэрхшээлтэй сурагчдын 116 болоод сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй сурагчдын 29-р сургуулиудын сургалтын менежер, багш нартай бэлтгэсэн асуултын хүрээнд ярилцлага */хавсралт хэсэгт оруулав/* хийсэн. Ингэхдээ тус 4 төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааны хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдлыг судалсан. Ярилцлагын аргыг тус сургуулиудад хэрэгжсэн төслүүдийн хэрэгжилт, үр дүн, үйл ажиллагааны талаар мэдээлэл авсан ба тус сургуулиуд дээр тулгарч буй хүндрэл бэрхшээл, бэрхшээлийг даван туулж буй арга туршлагыг тодруулсан болно.

Ярилцлагын аргын үр дүн

№	Төсөл, хөтөлбөрүүдийн нэр	Төсөл, хөтөлбөрөөр дамжуулан хийсэн үйл	
		А сургууль/119-р сургууль/	Б сургууль/29-р сургууль/
1	“School police” төсөл оныг олох	Сургуулийн гадаад орчинд хүүхдүүдийг аливаа зүйлээ дээрэмдүүлэх, авто тээврийн ослоос болмгоомжлох зорилготой өдөрт 3 эцэг, эх сургуулийн орчин тойронд хичээлийн цаг дуустал ажиглалт хийдэг.	

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

2	Боловсролын чанарын шинэчлэлийн бодлого-“Хүүхдэд ээлтэй сургууль хөтөлбөр” (2019)	Дохионы хэлний сургалт зохион байгуулсан.	Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад үе тэнгийнхний дунд тэгш хамруулах боломжтой гэдгийг ойлгуулах зорилготой сургалт, семинарын үйл ажиллагаа зохион байгуулалгдсан. Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүүхдүүдэд танхим байгуулсан
3	Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл оныг олох /JICA, БШУЯ/	Брайл сурах бичиг хэвлүүлсэн. Сургалт, семинарын үйл ажиллагаа зохион байгуулсан	Унгар луу цөөн тооны багш чадавхижуулж байсан “Үлгэрийн орноор аялая, үгэн баялагаа хөгжүүлье” бичил анги тохижуулах төсөл
4	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, оролцоог нэмэгдүүлэх, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр (2017-2020)	Тусгай хэрэгцээт боловсон хүчний сургалт	

Хүснэгт. 4 Тус сургуулиудад хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажил

Асуулт 2

Төсөл хөтөлбөрийн үр дүнгийн хувьд бол сайн үр дүнтэй байсан ба ялангуяа 29-р сургуульд “Боловсролын чанарын шинэчлэл” хөтөлбөр үр дүнгээ өгсөн. Одоо ч хүүхдүүд маань байгуулсан танхимд орж хичээл, сургалт семинарын үйл ажиллагаа явуулах дуртай. Ном унших хүсэл нь улам бүр нэмэгдсэн.

(29-р сургуулийн сургалтын менежер)

Төсөл, хөтөлбөрүүд ерөнхийдөө их сайн хэрэгжсэн, мэдээж нарийн төлөвлөгөөтэй үйл ажиллагаа учраас үр дүнгийн хувьд сайн байсан.

(116-р сургуулийн сургалтын менежер)

Асуулт 3

Техник-технологийн асуудал, брайл сурах бичгийн болон энгийн сурах бичгийн хангалт маш хэрэгцээтэй байна. Учир нь хүүхэд бүр түрээсийн сурах бичиг түрээслэх амьдралын бололцоо байхгүй юм. Мөн боловсон хүчний асуудал дээр маш муу харааны мэргэжлийн согог зүйч, сэтгэл зүйч огт байхгүй зэрэг нь сурагчдын оношлогоо алдаатай хийгдэх мөн сурагчдын сэтгэл зүй асуудал орхигдож байна. 36 багшийн 3 нь л тусгай хэрэгцээт боловсролын багш нар юм.

(116-р сургуулийн сургалтын менежер)

Дунд, ахлах ангийн тусгай хөтөлбөр сургалтын тусгай хэрэглэгдэхүүн болон телевизор, чанга яригч, анги нийтийн сонсголын төхөөрөмж зэрэг нь хичээл сургалтын ажиллагаа явуулахад нэн шаарлагатай байдаг зүйлсүүд юм. Мөн боловсон хүчний хэрэгцээ шаардлага, нилээдгүй байна. 72 багшийн 6 нь тусгай хэрэгцээт боловсролын багш бөгөөд мэргэжлийн хэл засалч нэн шаардлагатай байгаа юм..

(29-р сургуулийн сургалтын менежер болоод ахмад багш нар)

Асуулт 4.

Багш нарт харааны бэрхшээлтэй сурагчдад зориулсан хичээлийн хэрэглэгдэхүүн огт байхгүй учраас өөрсдийн гар доорх материал ашиглан сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэдэг. Мөн хичээл сургалтын үйл ажиллагаанд сурах бичгийн хангалт муу учраас энэ нь хүндрэлтэй байдаг. Мөн урлаг, спортын стандарт заал, танхим байхгүй учраас нилээдгүй хүндрэлтэй байдаг. Сургуульд лифт байхгүй учраас эрэгтэй багш нар харааны бэрхшээлтэй сурагчдын үдийн хоолны цаг болоод хичээлийн бусад танхим руу зөөх үйл ажиллагааг гардан хариуцдаг.

(116-р сургуулийн сургалтын менежер)

Сургуулийн бүх хана цуурсан байдалтай байгаа, их бороо цас орсон үед дээврээс ус гоожих гэх мэт асуудлууд байдаг. Мөн их чимээ шуугиантай хотын хүн ам төвлөрөл, утаа ихтэй газар байлгах нь хүүхдэд хортой бөгөөд дэлхийн улс орнуудын жишгээр тусгай сургуулиуд хотын захдаа цэвэр агаарт нам гүм газар байдаг туршлагаас бид суралцах хэрэгтэй байна. Машины хөдөлгөөн ихтэй учраас сурагчдын аюулгүй орчны байдал хүнд байдаг учраас, эцэг эхчүүд

байнгын хараа хяналттай байдаг. 1-р ангийн сурагчид анх орохдоо “ээж, аав” гэдэг үгээ ч мэддэггүй нь багш нарт хүндрэлтэй байдаг. Иймээс бэлтгэл анги байлгах нь зүйтэй ба багш нар аль болох өөрсдийн ур чадвараа гаргаж хичээлээ бэлтгэдэг.

(29-р сургуулийн сургалтын менежер ба багш нар)

Дүгнэлт

Энэхүү эрдэм шинжилгээний өгүүллээрээ нийт 36 төсөл хөтөлбөрийг судлан авч үзлээ. Аливаа төсөл, хөтөлбөр үйл ажиллагааны ерөнхий загвар, чиглэл, онцгой хэрэгцээ шаардлагыг хангахад чиглэгдсэн байдаг. Иймээс хөгжлийн бэрхшээлтэй болон хүүхэд рүү чиглэсэн 36 төсөл, хөтөлбөрийг эх баримт судалгааны үндсэн дээр шинжилсэн. Шинжилгээний эцсийн гол зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй болоод, хүүхэд рүү чиглэсэн төсөл хөтөлбөрөөс БШУЯ болон БШУЯ-тай хамтарсан төсөл, хөтөлбөрийн хувийг тодорхойлох мөн сургалтын байгууллагаар дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын сурах орчин нөхцөлийн асуудлыг тодруулахыг гол зорилгоо болгосон. Үүний үндсэн дээр

- a) БШУЯ ба БШУЯ-тай хамтарсан
- b) Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын асуудлыг хөндсөн
- c) Тусгай сургуулиар дамжуулан үйл ажиллагаагаа явуулсан эсэх ерөнхий 3 шалгуураар 4 төсөл, хөтөлбөрийг сонгон авч судалсан.

“School police” төсөл, Боловсролын чанарын шинэчлэлийн бодлого-“Хүүхдэд ээлтэй сургууль хөтөлбөр” (2019), Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл оныг олох /JICA, БШУЯ/, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, оролцоог нэмэгдүүлэх, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр (2017-2020) зэрэг болно. Эдгээр төсөл, хөтөлбөр нь үйл ажиллагааны үр дүнгийн талаар 116 болон 29-р сургуулиудын холбогдох албан тушаалтантай ярицлагын арга ашиглан үр дүн хэрэгжилтийн талаар судлахад үйл ажиллагаа-үр өгөөжийн хувьд сайн байсан. Иймээс цаашид ямар чиглэлийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлбэл зохистой байгаа талаар нэмэлт асуулт бэлтгэж сургуулийн орчин дах хэрэгцээ-шаардлага, бэрхшээлийг тодруулсан юм.

ЕБС-ийн 116 болон 29- р сургуулиудын хамгийн гол тулгамдаад байгаа бэрхшээл нь

- ✓ Сургалтын хэрэглэгдэхүүн /сурах бичгийн хүрэлцээ, хэрэглэгдэхүүн хомс/
- ✓ Сургуулийн орчин /лифт, дээвэр, хана, урлаг-спорт заал, дотуур байр/
- ✓ Боловсон хүчний хэрэгцээ шаардлага /мэргэжлийн боловсон хүчний хангалт аль аль сургуульд 20% ч хүрэхгүй үзүүлэлттэй, сэтгэл зүйч, мэргэжлийн согог зүйч, хэл засалч гэх мэт байхгүй/
- ✓ Сургуулийн орчин нөхцөлийн эрүүл, аюулгүйн баталгаа маш бага /сургууль орчмын зай талбай бага, хүн амын хэт төвлөрөлт, авто тээврийн хэрэгсэл их, сургуулийн барилгын байгууламжийн асуудал/ зэрэг ерөнхий бэрхшээлүүд ихээхэн тулгарч байна.

Санал, зөвлөмж:

1. Сургалтын хэрэглэгдэхүүний асуудал дээр сурагчийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон сурах бичгийн бүрэлдэхүүн гаргаж харааны болон сонсголын бэрхшээлтэй сурагчдад зориулсан олон улсын жишиг хөтөлбөрийн загвар гаргаж хэрэгжүүлэх
2. Сургуулийн материаллаг орчны асуудлыг стандартын дагуу орчин нөхцөлийг хангах төсөл хэрэгжүүлэх
3. Боловсон хүчний хэрэгцээ шаардлага маш их байгаа бөгөөд өнөөгийн байдлаар МУ-ын хамгийн эрэлттэй 5 мэргэжилд тусгай хэрэгцээт боловсролын багш нар багтаж байна. Иймээс боловсон хүчин бэлтгэх их дээд сургуулиудын мэргэжлийн ангийг зохих хэмжээгээр нэмэгдүүлэх, ажлын байраар хангах баталгаа олгох, тус мэргэжлээр тэтгэлэгтэй элсэн суралцуулах, одоо ажиллаж байгаа багш нарт ур чадварыг дээшлүүлэх сургалт тогтмол зохион байгуулах, багшийн мэргэжлээр төгсөж буй ямар ч оюутанд дохионы хэл болоод хөгжлийн бэрхшээлтэй сурагчидтай ажиллах арга зүйн хичээл “заавал судлах” хичээлийн агуулгад тусгах, гадаадын улс орнуудтай боловсон хүчний туршлага солилцох, тусгай сургуулиудын ажиллах хүчний нөөцөд онцгой анхаарал хандуулах зүй ёсны шаардлага байгаа нь харагдаж байна
4. Тусгай хэрэгцээт сургуулиудын хэт төвлөрсөн газар байлгахаас зайлсхийж, аль болох агаарын чанар сайн, нам гүм орчин нөхцөлд сургаж, хотоос

зайдуу байлгах ба багш ажилчдыг байрлаж ажиллах боломжийг олгох. Олон улсын туршлагыг судалж, хэрэгжүүлэх гэх мэт санал зөвлөмжийг гаргаж байна

5. Сурагчдын хөгжлийн бэрхшээл оношлогоо нь дан болон нэгдмэл байна. 2-3 төрлийн бэрхшээлтэй хүүхдүүд нилээдгүй суралцдаг. Иймээс сурагчдыг дан болон нэгдмэл шинжээр нь дотор нь ахин ангилах хэрэгтэй. Ингэснээр сургалт илүү үр дүнтэй болно.
6. Эдгээр асуудлуудад онцгой анхаарал хандуулж, сургуулийн хэмжээний, нийслэл дүүргийн хэмжээний, улсын хэмжээний тодорхой зорилтот төсөл-хөтөлбөрүүдийг олноор хэрэгжүүлбэл маш их ач холбогдолтой юм

Талархал

Энэхүү эрдэм шинжилгээний хурлыг заан чиглүүлсэн МУБИС-ийн Боловсрол судлалын тэнхимийн Х.Хишигмана/ph.d/ багшдаа заавар зөвлөгөө өгсөнд гүнээ талархаж байна. Мөн судалгааны ярилцлагыг чин сэтгэлээсээ уриалгахан хүлээн авч ярилцлага өгсөн 116 болон 29-р сургуулийн сургалтын менежер Урнаа болон Өнөрзүд ба бусад багш нартаа талархал илэрхийлье.

Ашигласан материал

1. Хүүхдийн эрхийн конвенци.,1989
2. Хүний эрхийг иргэний боловсролоор сургах нь., Amnesty International, 2018
3. НҮБ-ын хүний эрхийн боловсрол, сургалтын тунхаглал /хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр/“хүний эрхийн соёлыг бэхжүүлэх нь симпозиумд зориулж гаргав” .,2018
4. Хүүхдийн эрхэд ээлтэй сургууль болох нь.,2012 /сургуулиудад зориулсан удирдамж/
5. Нийслэлийн ИТХТ-ийн тогтоол /Хөтөлбөр батлах тухай 2015.11.20/
6. Хөвсгөл аймгийн Хүүхдийн VII чуулганы тайлан /“Хүүхдэд ээлтэй орон нутаг-Хүүхдийн оролцоо”- сэдвийн хүрээнд/
7. Хүүхдэд ээлтэй-Баянгол хөтөлбөрийн хүрээнд “Хүүхдэд ээлтэй сургууль шалгаруулах журам”
8. Өвөрхангай аймгийн ИТХТ-ийн тогтоол/2017.07.03/

9. Хүүхдэд ээлтэй-Алтай дэд хөтөлбөр батлах тухай, Говь-Алтай аймгийн ИТХТ-ийн тогтоол /2018.04.23/
10. Хүний эрхэд ээлтэй сургууль болох нь /сургуулиудад зориулсан удирдамж/
11. Нийлэлийн Баянзүрх дүүргийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр
12. Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр 2018-2019 /үйл ажиллагааны төлөвлөгөө/
13. Гэр бүл, хүүхэд залуучуудын салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга /2016 оны жилийн эцсийн байдлаар/
14. “Хүүхдэд ээлтэй-дотуур байр” аян 2016-2017 оны хичээлийн жилийн тайлан /Дэлхийн Зөн Монгол, Дундговь аймгийн хамтарсан тайлан/
15. Гэр бүл, залуучуудийн хөгжлийн хэлтсийн эхний хагас жилийн тайлан, 2018
16. БСШУСЯ-ны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт., 2019
17. Хүүхдийн эрх-хөгжил төсөл II шат., 2018

Цахим эх сурвалж

1. <https://worldvision.mn/>
2. <https://www.savethechildren.mn/>
3. <https://police.gov.mn/a/4998>
4. <https://www.montsame.mn/mn/read/171044>
5. <https://mongolia.embassy.gov.au/ulnbmongolian/DAPinMongolian.html>
6. <http://www.fcy.gov.mn/CHILDPROTECTION>
7. <https://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/013/index.html>
8. <https://www.ncle.mn/news/pdf/26/>
9. <https://www.adb.org/sites/default/files/project-document/177428/48076-001-mon-pds-mn.pdf>

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН БОЛОВСРОЛЫН ЗАРИМ АСУУДАЛ, ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭХ НЬ

Мөнхбат Мөнхзул

Оршил

Хүн бүр л аз жаргалтай, сайн сайхан амьдралыг хүсдэг боловч энэ нь амьдрал дунд бий болсон олдмол болон төрөлхийн байдлаас болж хязгаарлагдах тохиолдол байдаг. Энэ бол хөгжлийн бэрхшээл хэмээх нэр томъёонд хамаарагдах иргэд. Монгол улсын хэмжээнд 107,075 иргэн уг бүлэгт хамаарагдаж байна.

Монгол Улсын Үндсэн хуулинд *“хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно”, “Монгол улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”* хэмээн тунхагласан. Гэвч энэ нь бодит байдалтай хэр нийцдэг бол гэсэн бодол өөрийн эрхгүй төрнө.

Хөгжлийн бэрхшээлийг хэрхэн ойлгох ёстой вэ?

Энэ нь хувь хүндээ биш, нийгэмдээ гэж үздэг “Хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар” -ын ойлголт манай улсад нийтлэг болоогүй байгаа нь нийгэмд уг иргэдийг сул дорой, өвчтөн, нийгмийн халамж л хүртэж амьдардаг гэсэн ойлголт давамгайлсны улмаас тэдний оролцоо бодит байдал дээр хангагдаж чадахгүй байсаар байна.

Иймээс Монгол Улсын иргэн бүр эрх тэгш байж, эрхээ эдэлж, нийгэмд оролцох оролцоо нь хангагдаасай хэмээн хүсч, нийгэм дэх “хөгжлийн бэрхшээлтэй иргэн” гэх ойлголтыг өөрчилж, энэ салбарт хувь нэмрээ оруулах алхам болно хэмээн итгэж энэхүү илтгэлээ бичлээ.

Судалгааны зорилго

Нийгэм дэх хөгжлийн бэрхшээлтэй гэх боловсролын салбарт тулгамдсан асуудлыг судлан, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг тодорхойлоход оршино.

Зорилт: Зорилгод хүрэхийн тулд:

- ХБ иргэдийн сурч боловсрох эрхийн талаар хууль тогтоомжид тусгагдсан байдал, түүний хэрэгжилт

- Хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцад тулгамдсан асуудлыг тодорхойлон дүгнэж, шийдвэрлэх арга замыг тодорхойлох явдал юм.

Жич: Хөгжлийн бэрхшээл бол бэрхшээл биш, нийгмийнх гэж үздэг боловч нийгэмд уг нэр томъёо хэрэглэгдэж хэвшсэн тул энэ нэр томъёог ашиглахад хүрсэн болно./цаашид “ХБИ” гэх/

Үндсэн хэсэг

Энэхүү илтгэлд аливаа суурь ойлголт, нийгмийн институтын тайлбар, хууль, эрх зүйн орчинд тусгагдсан байдал зэргийг нэг бүрчлэн тайлбарлах шаардлагагүй хэмээн үзсэн бөгөөд гагцхүү судалгааны зорилгын хүрээнд дараах нэр томъёог тайлбарлах нь зүйтэй.

Хөгжлийн бэрхшээл

Энэхүү нэр томъёоны тайлбарыг тодруулан авч үзвэл “...**махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хамруулна**” гэж заасан байх бөгөөд Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссоор “*хөгжлийн бэрхшээлтэй*” гэж тодорхойлогдсон хүнийг албан ёсны статистикийн мэдээлэлд хамруулдаг.

2019 оны Үндэсний статистикийн хорооны судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй нийт иргэдийн 43% нь төрөлхийн, **57.% нь олдмол** байгаагаас үзэхэд олдмол байдлаар уг бүлэгт хамаарагдах эрсдэл өндөр байгаа нь манай улсын нийт хүн амын өвчлөл, нас баралтын шалтгааны нэг нь **осол болж байгаатай холбоотой** байна.

Хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр нь авч үзвэл:

- Хөдөлгөөний 20%
- Ярианы 4%
- Харааны 11%
- Сонсголын 8%
- Сэтгэцийн 19%
- Хавсарсан 7%
- Бусад 31%

Эдгээр иргэдэд төрийн зүгээс нийгмийн даатгалын шимтгэл төлсөн эсэхээс нь үл хамааран **нийгмийн хамгаалалд** тодорхой үндэслэл, зохицуулалтын дагуу

бүх нийтийг хамруулах зарчимтайгаар ажилладаг. Өөрөөр хэлбэл: Энэ нь эрсдэлээс өөрийгөө хамгаалах чадвар бүхий болон бусдын туслалцаа шаардлагатай байгаа иргэдэд үзүүлж байгаа эдийн /тэтгэвэр, тэтгэмж олгох / болон сэтгэл санааны тусламж, дэмжлэг үзүүлэх, асран халамжлах, туслалцаа авах нөхцөлийг бүрдүүлдэг юм.

Ялангуяа хүн хөгшрөх, хүүхэд төрөх зэрэгт тэдгээрийг асрамжлан хамгаалах, ажиллаж, амьдрах чадварыг нь сэргээх, халамжлах нь аль ч төрийн хэрэгжүүлэх үүргийн нэг бөгөөд энэ нь нийгмийн хамгааллын хүрээг зөвхөн хөдөлмөрийн чадвараа алдсан болон асрамж тэтгэмж шаардлагатай тохиолдолд үзүүлэх туслалцаа төдийгөөр хязгаарлаж болохгүй юм. Харин ч тэдний хөгжлийн асуудал илүү яригдах ёстой.

Хөгжлийн асуудал...

Хүн гэгч байгалиасаа аливаа зүйл рүү хүсэн тэмүүлж, өсөн хөгжиж байхаар бүтээгдсэн байдаг бөгөөд дээрх бэрхшээлээс болж энэ байдал нь үгүй болох боломжгүй, харин ч бидний оюун ухаан, бие махбодь, сэтгэл зүй ямагт энэ зүйлийг шаардаж байдаг. Тэгвэл бодит байдалд ХБИ Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөгөө бүрэн дүүрэн, баталгаатай эдэлж чадаж байна уу?

Хүний эрхийн төлөөх хөдөлгөөнийг дагалдан хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар үүсэн бий болсон бөгөөд ХБИ улс, эх орныхоо нийгэм, эдийн засгийн амьдралд идэвхтэй оролцоход нийгэм өөрөө тэдэнд бэрхшээл болж байна. Эдгээр саадыг арилгах үүрэг нь нийгэмд байгаа ба үүнийг арилгах үйл явцад ХБИ гол үүргийг гүйцэтгэх ёстой.

Гэтэл ХБИ-ийн талаарх сөрөг ойлголт нийгэмд байгаагийн улмаас тэднийг ялгаварлан гадуурхах асуудлууд өдөр тутам гарсаар байгаа нь тэдний хөгжих эрх, нийгэмд оролцох оролцоо хангагдаж чадахгүйд хүрч байна. Бодит байдалд тэдний эрх бүрэн дүүрэн хангагдаж чадаж байна уу?

Оролцоо гэдэг нь агуулгын хувьд өргөн ойлголт ба ХБИ-Энгийн иргэдтэй нэг цаг хугацаанд нэг зүйлийг хийж, туршлага солилцох тухай юм. Учир нь оролцоо нь хүний амьдралын зайлшгүй нэг хэсэг. ХБИ, энгийн иргэд хамтарч аливаа зүйлийг хамтарч хийхдээ аль аль талын оролцоог бүрэн хангаж байдаг.

Иймд тэтгэмж авдаг нийгмийн хамгааллын тогтолцооноос илүүтэй тэдний хөгжлийн асуудлыг ярих ёстой учир тэдний боловсролын асуудлыг мөн нэн тэргүүнд тавих ёстой.

Сурч боловсрох эрх:

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд иргэн бүрийн баталгаатай эдлэх эрх, эрх чөлөөг баталгаажуулсан байдаг бөгөөд “16.7/ Сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн боловсролыг төлбөргүй олгоно...” хэмээн заасан.

Үүний дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын сурч боловсрох эрхийн асуудал хэрхэн зохицуулагдаж байгааг авч үзье. Үүнд:

Нэг. Хууль

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого
3. Боловсролын тухай хууль
4. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
5. Бага, дунд боловсролын тухай хууль
6. Дээд боловсролын тухай хууль
7. Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль
8. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль

Хоёр. Монгол Улсын их хурал болон Засгийн газрын тогтоол

1. УИХ-ын 2013 оны 19 дүгээр тогтоол
2. Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоол
3. Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоол
4. УИХ-ын 2015 оны 12 дугаар тогтоол
5. Засгийн газрын 2017 оны 62 дугаар тогтоол
6. УИХ-ын 2017 оны 46 дугаар тогтоол
7. УИХ-ын 2017 оны 24 дүгээр тогтоол

Гурав. Сайдын тушаал

1. БСШУСС-ын Тусгай сургууль, цэцэрлэгийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2017 оны 05 сарын 11-ний өдрийн А/195 дугаар тушаал
2. БСШУСС-ын Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2017 оны 05 сарын 11-ний өдрийн А/196 дугаар тушаал

Боловсролын тухай багц хуулийн 2013, 2016 оны нэмэлт, өөрчлөлтөөр дор дурдсан асуудлууд шинээр тусгагджээ. Үүнд:

- Ерөнхий боловсролын тусгай сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сэргээн засах, чийрэгжүүлэх, бие даалгах үйлчилгээ үзүүлэхээр болсон.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сэргээн засах, чийрэгжүүлэх эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэх чиглэлээр мэргэшсэн эмч, сувилагч, туслах багш, сэргээн засалч, сэтгэл зүйч ажиллахаар болсон.
- Ерөнхий боловсролын тусгай сургууль нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд шилжихээр болсон.
- Ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тооноос хамаарч тусгай мэргэжлийн багш, сэтгэл зүйч, сувилагч, сэргээн засалч, нийгмийн ажилтан ажиллуулж болно.
- Ерөнхий боловсролын тусгай сургууль нь сэргээн засалтын кабинет, танхимтай байхаар тус тус зохицуулсан байна.

Эдгээрээс гадна эхэнд дурдах ёстой чухал бичиг баримт бол 1960 онд НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагаас баталсан “БОЛОВСРОЛЫН ТАЛААР АЛАГЧЛАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ КОНВЕНЦ”.

Уг конвенцод Монгол улс нэгдсэн орсон бөгөөд нэгдэн орсон улс бүр үүрэг хүлээдэг. Энэ Конвенцоор дэлхий нийт хүлээн зөвшөөрч, тунхагласан гол зүйл бол “Хүний эрхийн түгээмэл тунхаглалд алагчлахгүй байх явдлыг гаргаж үл болох зарчмыг баримталж, хүн бүр боловсрол эзэмших эрхтэй гэж тунхагласныг санан, боловсролын талаар алагчлах нь энэ тунхаглалд дурдсан эрхийг зөрчиж байгааг анхаарч, НҮБ-ын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага нь дүрэмдээ заасан ёсоор хүний эрхийг хаана ч сахин хамгаалах, боловсрол олгох тэгш эрхээр бүх нийтийг хангахын тулд ... боловсролын талаар аливаа алагчлалтыг арилгах төдийгүй, энэ талаар бүх нийтийн тэгш боллоцоо, тэгш харьцаатай байх явдлыг явдлыг хөхүүлэн дамжих ёстойг анхаарч ...” энэхүү Конвенцийг баталсан явдал. Иймд Монгол Улсын хувьд ч Конвенцид оролцогч улсын хувьд Конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлж, дотоодын хууль тогтоомждоо тусган хэрэгжүүлэх ёстой юм.

Монгол Улсын Боловсролын тухай хуульд заасны дагуу манай улсын боловсролын тогтолцоо нь албан ба албан бус боловсролын нэгдэл байх ба сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол, дээд боловсролоос бүрддэг.

Боловсролын тухай хуулийн 4 дүгээр зүйлд “Монгол Улсын боловсролын зорилго нь иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахьдаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино” гэж заасан.

Энэ хуулийн зорилго нь: энгийн хүүхдийн тухайд үйлчилж байдаг буюу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тухайд энэ нь төдийлөн хангагдахгүй байна. 2002 онд батлагдсан уг хуулийн 90-ээс дээш зүйл, заалтад 19 удаа нэмэлт, өөрчлөлт оруулахдаа 1 заалтыг 6 удаа өөрчлөлт оруулсан нь энэ салбарын хууль тогтворгүй байгаа нь анхаарал татсан чухал асуудал гэдгийг тодорхой харуулж байна. Үүнээс шалтгаалан яаран дүгнэлт хийхгүйн тулд 2016 онд батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд тухайн иргэдийн сурч боловсрох эрх хэрхэн хангагдах ёстойг авч үзье.

Тус хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 **“хөгжлийн бэрхшээлтэй хүн бусад иргэний хамт сурч боловсрох, мэргэжил эзэмших эрхтэй бөгөөд энэхүү эрхийг нь хангах чиглэлээр төрөөс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.”** хэмээн заасан. Үүнээс нь голлох заалтыг дурдвал 14.1.1 **“хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт нийцүүлэн авьяас билэг, бүтээлч чанар, оюуны болон бие бялдрын чадварыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөр, орчныг бий болгох”, “бүх шатны боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох, мэргэжил эзэмших нөхцөлийг бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж, дэмжлэг тусалцаа үзүүлэх”, “хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн сургалтын хөтөлбөр стандартыг боловсруулах”** хэмээн хуулиндаа тусгажээ.


Төр хөгжлийн бэрхшээлтэй иргэнийхээ сурч боловсрох, мэргэжил эзэмших эрхийг хангаж, дээрх хуульд заасан арга хэмжээнийхээ дагуу хэрхэн ажиллаж байгааг сургуулийн өмнөх боловсрол болон бага дунд боловсролын асуудлаар голчлон үзэх болно.

А. Сургуулийн өмнөх боловсрол:

Улсын хэмжээнд 2010/2011 оны хичээлийн жилд нийт 839 цэцэрлэг үйл ажиллагаагаа явуулж байсан бол 2019/2020 оны хичээлийн жилд **1439** болж 600 /71,5%/-аар нэмэгдсэн бөгөөд **хамрагдсан хүүхдийн тоог авч үзвэл** 2010/2011 оны хичээлийн жилд 157,2 мянга байсан бол 2019/2020 оны хичээлийн жилд **263,3 мянга болж 106,2 мянга /67,5%/-аар өссөн байна.**

Үндэсний статистикийн хорооны 2019 оны тайлан, мэдээгээр улсын хэмжээнд 0-16 насны **10,857 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд** байгаа бөгөөд үүнээс СӨБ-д хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийт тоог харвал жил бүр тодорхой тоогоор ихсэж, буурсан хэлбэлзэл байгааг олж харж болох ба 2018/2019 оны хичээлийн жилд **1087** хүүхэд хамрагдсан нь өмнөх оны буюу 2017/2018 оны хичээлийн жилээс огцом буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 8. СӨБ-д хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, 2010-2019 он



СӨБ-д хамрагдах ёстой 2000 гаруй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгаа хэдий ч 2019/2020 оны хичээлийн жилд 1076 хүүхэд СӨБ-д хамрагдаж байгаагаас 179 нь л **10, 186 гэсэн тусгай цэцэрлэгт** суралцаж байна. Гэхдээ энэхүү тоон үзүүлэлт нь ҮСХ, Боловсролын удирдлага, мэдээллийн системээс “захиргааны маягт” -аар гаргасан тоо. Иймд энэ статистик мэдээ зөрүүтэй байх магадлалтай.

Жишээлбэл, захиргааны маягтын тоон дээр хэд нь дауны хам шинжтэй, хэд нь аутизмын хүрээний эмгэгтэй гэдэг нь тодорхой гардаггүй бөгөөд зөвхөн хараа, сонсгол, оюуны бэрхшээл, хөдөлгөөн тулах эрхтний бэрхшээл, хэл ярианы бэрхшээл, бусад гэсэн ангиллын дагуу тоон мэдээлэл гардаг.

СӨБ-ын тухай хуулийн 2016 оны “халамжийн цэцэрлэг “хэмээх нэр томъёог нэмсэн ба энэ нь “нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.1-д заасан хоёр наснаас сургуульд элсэх хүртэл насны хүүхдийг асрах, хамгаалах, хөгжүүлэх цогц үйл ажиллагаа бүхий сургалтын байгууллагыг” хэмээн тодорхойлжээ.

Үүнээс гадна 2015 онд “Хүүхэд харах үйлчилгээний тухай” хуулийг баталсан бөгөөд 2017 оноос хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Уг хуулийн 3 дугаар зүйлд хүүхэд харах үйлчилгээ нь “... **2 наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд асран халамжлах, хамгаалах, хооллох, тоглуулах, амраах үйл ажиллагаа**” бөгөөд уг хуулийн 5.2-т “**хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нас харгалзахгүйгээр хүүхэд харах үйлчилгээнд хамруулж болно**” гэж тусгажээ.

Ийнхүү хууль нь хүүхэд бүрийг ямар ч шатны боловсролд эрх тэгш хамруулах зорилготой хэдий ч СӨБ-д хамрагдах ёстой хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 50 гаруй хувь нь хамрагдаж чадахгүй буюу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цэцэрлэгийн хүртээмж хангалтгүй /*өнөөдрийн байдлаар Улсын гээдэх 2 нас хүртэлх хүүхэд өсгөн хүмүүжүүлэх газар сувиллын, асрамжийн үүрэгтэй 3 хүрэхгүй тооны цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байгаа бол 1990 оноос өмнөх үед 3 хүртэлх насны хүүхдийн ясли 40 гаруй байсан.*/, хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, боловсролд тэгш хамруулах боломж бүрдүүлэх, энгийн түвшинд өсөж хөгжих боломж хязгаарлагдмал байгаа нь нотлогдоно.


Б. Бага, дунд боловсролын тухай

Өнөөдрийн байдлаар нийслэлд улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг **тусгай сургалттай** 6 сургууль байгаагийн 4 /25, 55, 63, 70/ нь оюуны бэрхшээлтэй, 29 дүгээр сургууль сонсголын бэрхшээлтэй, 116 дугаар сургууль харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд тусгай хэрэгцээт боловсролын дагуу боловсрол эзэмшүүлж байгаа. *Үүнээс гадна мөн хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсролын үйлчилгээний гадна орхигдох эрсдэлтэй байгааг ч мартаж болохгүй.*

2019/2020 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд нийт 646,8 мянган хүүхэд суралцаж байна. Үүнийг 2010/2011 оны тоон үзүүлэлттэй харьцуулахад 119,7 мянгаар өссөн үзүүлэлттэй байгаа юм.

Үүнээс ЕБС-д суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тоог дараах графикт тодорхой харуулсан байна.

Зураг 21. ЕБС-д суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, 2010-2019 он



Үүнээс 2010/2011 оны хичээлийн жилд ЕБС- нийт **18,298** хүүхэд элсэн суралцаж байсан бол 2019/2020 оны хичээлийн жилд **6,053** болж илтэд буурсан үзүүлэлт байгааг харж болно.

Ийнхүү илтэд буурсны шалтгаан юу вэ?

Нэгдүгээрт, Сургуулийн хүртээмжийн асуудал. Үүнд олон шалтгаан байх ч нэг жишээг дурдая.

Бага, дунд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлд “ерөнхий боловсролын сургуульд суралцах хөгжлийн бэрхшээлтэй хүний насны зөрүүг боловсрол, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно.”

Сурч боловсрох эрхийг хүн бүрт адил тэгш хүртэх эрхтэй учир 1964 онд хараа, сонсголын бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамруулах үүднээс тусгай сургалтын 29 дүгээр сургууль байгуулагдсан нь тусгай хэрэгцээт хүүхдүүдэд боловсрол эзэмшүүлэх эхлэл болсон бөгөөд 1967 онд тусгай сургалттай 25 дугаар сургууль байгуулагдсан нь оюуны бэрхшээлтэй хүүхдэд зориулагдсан хөтөлбөрөөр боловсролын үйлчилгээнд хамруулах нөхцөлийг бүрдүүлсэн. Гэвч 1990 оноос хойш энгийн хүүхдээс тусгаарлан боловсрол эзэмшүүлж байсныг үгүйсгэж, боловсролд тэгш хамруулах, нийгэмшүүлэх зорилгоор ердийн сургалттай сургуульд суралцах боломж нээгдсэн гэж үздэг.

Ердийн сургуульд сурах орчин бүрдэж буй хэдий ч сургуулийн орох хаалганы шатнаас эхлэн бэрхшээлийг өдөр бүр, цаг, минут тутамд даван туулах шаардлагатай, хүүхэд томрох тусам халшран зугтаах, нийгмээс тусгаарлагдах шалтгаан болсоор байна.

Мөн хуулиар хүүхдийн ХБ онцлогийг харгалзахгүйгээр насны зөрүүг тогтоож өгөх тухай заах нь улиран сурах хүүхдүүдтэй дүйцүүлэн хүүхдүүд дунд ялгаварлан гадуурхалтыг бий болгох сөрөг үр дагавартай төдийгүй боловсрол тэгш хамрагдах эрхийг харин ч зөрчиж байгаа явдал бөгөөд бидэнд тулгамдсан асуудлын нэг болж байна.

Бие эрхтний согогтой хэдий ч оюуны хөгжлийн хувьд энгийн хүүхдийн түвшинд байдаг. Зарим тохиолдолд илүү ч сурах боломжтой. Хөгжлийн бэрхшээлтэй ч үе тэнгийн хүүхдүүдээс хоцрохгүйг хичээн суралцах хүүхдэд суралцах орчин нөхцөл бүрдээгүйгээс үүсэх хүндрэлтэй асуудлыг даван туулах гэж хичээх явдлыг дэмжин туслах ёстой атал насны зөрүүтэй, хоцрогдолтой сурагч гэж ялгамжтай

хандах нь тэдний эрхийг зөрчсөн, ялгаварлан гадуурхалтыг бий болгосон үйлдэл болж буй тул хэрэгжүүлэхэд хүндрэлтэй хуулийн заалт гэдгийг харуулж байна.

Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэгт: НҮБ-ийн ХБ хүний эрхийн хороо 2015 оны 05 сарын 13-нд Монгол Улсын Засгийн газар дүгнэлт, зөвлөмжөө хүргүүлсэн бөгөөд зөвлөмжид ХБ хүүхдийн боловсрол эзэмших эрхэд онцгой анхаарал хандуулах тухай дурдсан.

-сургууль цэцэрлэгийн орчныг ХБ хүүхдэд ээлтэй хэлбэрээр засан тохижуулах, сургалтын бааз, хэрэглэгдэхүүнээр хангах ажлыг бодлогын түвшинд зохион байгуулж хэрэгжүүлэх;

-ХБ хүүхдийг ердийн сургууль, цэцэрлэгт сурч хүмүүжихэд зориулсан сургалтын тусгай хөтөлбөр боловсруулах, шаардлагатай сургалтын материал, хэрэглэгдэхүүнийг бэлтгэж хэрэгжүүлэх;

-ХБХ багшлах боловсон хүчний чадварыг дээшлүүлэх, тэдний хөдөлмөрийн нөхцөл, цалин, урамшууллыг боловсронгуй болгох, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд онцгой анхаарах хэмээн зөвлөмждөө дурджээ.

Хоёрдугаарт, сургалтын чанарын асуудал.

Жишээ 1: Үүнд нэгэн жишээг дурдвал 2017 онд олон нийтийн анхаарлыг татсан яриа, сонсголын бэрхшээлтэй хүүхдийн тусгай 29-р сургуулийн асуудал.

2017 онд тус сургуульд суралцаж буй 15 эрэгтэй сурагчид хичээл хаялт зохион байгуулж байсан ба хүүхдүүдийн гол шаардлага нь хичээлийг дохионы хэлээр заах, тэдний сурч боловсрох эрхийг эрхэмлэн хүндэтгэх байсан юм.

Тухайн үед гарсан “Чимээгүй хашхираан” нэвтрүүлэг болон бусад телевизийн мэдээгээр сургуульд нуугдсан далд зүйлсийг ил болгосон юм. Үүнд:

- Багш нар нь хичээлээ дохионы хэлээр заадаггүй учраас хүүхдүүд хичээлээ ойлгохгүй, бичиг үсэг мэдэхгүй, уншиж, бичиж чадахгүй, зүгээр л хуулан бичдэг.
- Үүнээс гадна эрэгтэй багш нар нь эрэгтэй сурагчдыг байнга зодолж дарамталдаг, эмэгтэй сурагчдад бэлгийн дарамт үзүүлдэг.
- Багш нар ёс зүйгүй, ажлын байрандаа архи уудаг, хогийн савнаас хэрэглэсэн бэлгэвч гарч ирсэн зэрэг ноцтой асуудлыг дэлгэсэн.

Эдгээр ноцтой асуудал тус сургуульд байдгийг нотолсон 29-р сургуулийн ахлах ангийн сурагчаас авсан ярилцлагыг medee.mn сайтын сэтгүүлч Уранцэцэг нийтэлсэн.

Ийнхүү олон нийтэд ил болсон дээрх сэтгүүлчийн нийтлэлээс үүдэн тус сургуулийн багш нар 2017 оны 04 сарын 04-ний өдөр хэвлэлийн бага хурал зарлаж, тухайн medee.mn сайтын ярилцлага нийтэлсэн сэтгүүлчийг шүүхэд өгч байгаагаа мэдэгдсэн үйл явдал болсон юм. Уг хурлаар тус сургуулийг төлөөлж ирсэн багш нар бэлгийн дарамт, ёс зүйгүй юм байхгүй, ийм зүйлс огт болдоггүй гэх тайлбарыг хэлж байв.

Харин 2017 оны 04 сарын 07-ны өдөр Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас мөн хэвлэлийн бага хурал зарлаж, сурагчдын тавьсан шаардлага бодитойг хэлж, дохионы хэлээр хичээлээ заадаггүй, багш нарын 56% нь дохионы хэлний чадваргүй гэх дүгнэлт гарснаа хэлсэн боловч бусад ноцтой асуудлыг **“нотлогдоогүй, гэхдээ ажлын хэсэг үргэлжлүүлж ажиллана, шалгана”** гэж хариулж байв.

Ийгл телевизийн сэтгүүлчийг 7 хоногийн дараа мөн л лавлаж асуухад: **“ажлын хэсэг цаашдаа ажиллахгүй”** гэх хариултыг яамны зүгээс өгөв.

Жишээ 2: 2019 оны 10 сарын 25-ны мэдээллээр 51 дүгээр сургууль 1 дүгээр ангийн аутизмтай хүүхдийг сургаж чадахгүй гэсэн тохиолдол гарсан. Энэ явдал нь хүүхдийг ялгаварлан гадуурхаж, сурч боловсрох эрхийг нь зөрчсөн ноцтой үйлдэл юм. Гэтэл энэ хэргийг хаасан.

Гэтэл эдгээрээс гадна бид өөр хичнээн ХБ хүүхдийн сурч боловсрох эрх нь зөрчигдөж байгааг бид мэдэхгүй.

Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлд боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн хөдөлмөрийн онцлогт тохирсон, ХБ суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байх тухай заасан ч сургууль гэлтгүй эргэн тойрны барилга байгууламжийн шат, орчин нөхцөл ХБ суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцээгүй нь хүндрэлтэй хэвээр.

Жил бүр суралцаж буй хүүхдүүдийн тоо буурч, ялангуяа эдгээр хүүхдүүд анги дэвших тутам сургуульд суралцах нь багасч байгаа нь ичиж зовох, нийгмийн амьдралд чөлөөтэй оролцохоос айж эмээх гэх мэт шалтгаан ч бас бий. Өөрөөр

хэлбэл, нийгэм эдгээр хүүхдүүд ийм нөхцөл байдалд орох бэрхшээлийг нь үүсгэж байна гэсэн үг юм.

Бодитой өөрчлөлт хийгдэхгүй, өнөөх л сургалт хэвээр байсаар байгаа нь манай улсын боловсролын талаарх бодлого иргэндээ хэр үйлчилж, хэрхэн ач холбогдол өгч байгааг харуулж байна.

Иймд хуулийн зохицуулалтыг өөрчлөн найруулж, ХБ хүүхдийн сурах орчин нөхцөлийг бусад хөгжингүй орны түвшинд хангах нь боловсрол тэгш хамруулах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх энгийн хүүхдийн түвшинд өөрийгөө ямар нэгэн хэмжээгээр ХБ гэдгээ мэдрэхгүй өсөх хандлага төлөвшүүлэх, мөн ХБ-ийг зөв оношлон тодорхойлох, суралцах идэвх сонирхолтой хүүхдийг хөгжлийн бэрхшээлээс үл хамааран дэмжин хөгжүүлэх шаардлагатай байна.

Жишээ 2: 2019 оны 10 сарын 25-ны мэдээллээр 51 дүгээр сургууль 1 дүгээр ангийн аутизмтай хүүхдийг сургаж чадахгүй гэсэн тохиолдол гарсан нь хүүхдийг ялгаварлан гадуурхаж, сурч боловсрох эрхийг нь зөрчсөн ноцтой үйлдэл юм. Гэтэл энэ хэргийг хаасан.

Ийм учраас Тусгай хэрэгцээт боловсролыг хүртээмжтэй, чанартай олгох, мөн цэцэрлэг, ЕБС-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургах асуудал шийдвэрлэх зохистой чухал асуудлуудын нэг мөнөөс мөн. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулинд зааснаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг **“ялгаварлан гадуурхаж, доромжилж, тохуурхсан бол хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хүндэтгэх, ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалтад 14 хоногоос доошгүй хугацаагаар хамруулна”**, *“хуулийг зөрчсөн буруутай этгээдийн үйлдэл, эс үйлдэхүй гэмт хэргийн шинжтэй бол Эрүүгийн хууль, зөрчлийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.”* хэмээн заасан хэдий ч бодит байдалд хэрэгжихгүй байгаа учраас үүнийг дагаад нийгмийн сөрөг хандлага ч байсаар байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сургуульд сурах эрмэлзэл байвч төр, нийгмийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, түүний хэрэгжилт, саадгүй, чөлөөтэй зорчих гудамж, талбай, зам, нийтийн тээвэр, барилга байгууламж, сургалтын материаллаг орчин хангалтгүй, боловсрол олж буй байгууллага, багш нарын чадваргүй, ХБ хүүхдийг ялгаварлан гадуурхсан явдал хүний эрхийг эхэнд тавьдаг гэх өнөөдрийн нийгэмд байсаар байгаа нь тэдний суралцах эрхийг

хязгаарлаж, нийгэмд боловсролгүй, “үл үзэгдэгч” байдлаар амьдрах нөхцөлийг бүрдүүлж байна.

2019 оны эхний 3 сарын байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 11.000 гаруй залуучуудын 25% нь л бүх шатны боловсролд хамрагдаж, тусгай сургалттай 6 сургуульд 1531 хүүхэд, 2 тусгай цэцэрлэгт 172 хүүхэд суралцаж байна гэсэн тоо баримт байна. Үүнээс олон төрлийн бэрхшээлтэй хүүхдүүд 1 ангид сурч, 2 багш л хичээл зааж байгаа нь тун хангалтгүй үзүүлэлт.

Бусад улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсор эрх хэрхэн хангагддаг талаар товчхон авч үзье.

✓ АНУ-ын Дээд шүүхээс ялгаварлан гадуурхалт байх ёсгүй бөгөөд боловсролыг бүх иргэдэд адил тэгш хэлбэрээр олгож байх нь Засгийн газрын үндсэн үүрэг гэж үзсэн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний боловсролын тухай хуулиар тэдний өвөрмөц хэрэгцээг хангах, цаашид боловсрол эзэмшихэд нь бэлтгэх, олон нийтийн боловсролыг үнэ төлбөргүй олгох эрхээ эдлэх боломжийг олгодог. Уг хууль нь 4 хэсгээс бүрдэх бөгөөд Эхний А хэсэг үндсэн хэсгийг зохицуулах ба Б хэсэг нь 3-21 насны хүүхдүүдэд зориулсан боловсролын туслалцаа үзүүлэх тухай удирдамжийг боловсруулсан, С хэсэгт 3 хүртэлх насны хүүхдийн хөгжилд анхаарч, хүүхдийн хөгжлийг төрөөс дэмжих, санхүүжүүлэх тухай зохицуулсан, Д хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролыг сайжруулахад чиглэсэн үндэсний үйл ажиллагааг дэмжсэн, хөгжлийн бэрхшээлтэй оюутанд олгодог буцалтгүй тусламжийг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эерэг үр дүн үзүүлж байгаа төсөл хөтөлбөрийг дэмжихэд чиглэсэн байдаг байна.

✓ ХБНГУ Үндсэн хуульдаа “**нэг ч хүн хөгжлийн бэрхшээлтэйн улмаас эмзэглэх ёсгүй**” тухай тусгаж өгсөн. ХБИ нь дээд болон мэргэжлийн боловсролыг эзэмших эрхээр бусад хүмүүсийн нэгэн адил хангагдсан ба ихэнх дээд сургууль үнэ төлбөргүй байдаг. ХБИ-ний сурах үйл явц, үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор тусгай тусламж авах эрхээр хангасан ба түүнд зарцуулагдах зардлыг холбооны муж улсын нийгмийн албад хариуцдаг байна. Мэргэжлийн сургалтын тухай хуулиар ХБИ-д зориулсан мэргэжлийн сургалтын талаар зохицуулсан ба мэргэжлийн сургалтад хамрагдсан хүмүүс нь мэргэшүүлэх сургалтад хамрагдах бөгөөд сургалтын агуулга нь хөдөлмөрийн зах зээлд хүлээн зөвшөөрөгдсөн ерөнхий байдал, хөгжилд

анхаарсан байх тухай заасан. ХБХ суралцах явцад хувийн туслагч тодорхой хугацаанд үйлчилж, тусламж үзүүлэх бөгөөд энэ нь дадлагын ажил бичих, ном, сурах бичиг олох, дадлага хийх, хараагүй оюутанд хичээлийн материалыг уншиж сонгох, сонсголгүйд нь хичээлийг нь тэмдэглэж өгөх, өөрөө явах, хөдлөх боломжгүйд нь сургуульдаа явахад нь тусалдаг байна.

✓ Жишээлбэл, Иракийн сургалтын хөтөлбөрийг илүү оролцоотой болгоход Олон улсын хөдөлмөрийн байгууллага, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс тусалцаа үзүүлсэн бөгөөд тэр үед нийт элсэгчдэд анхан шатны боловсролтой байх ёстой гэсэн шаардлагыг хянаж үзсэн байна. Гэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүн бүр уг шаардлагыг хангаж чаддаггүй. Ийнхүү үүний оронд унших, бичих шаардлага нэмж оруулсан нь хөгжлийн бэрхшээлтэй олон хүн хамрагдах боломжийг нээж өгсөн байдаг.

Монгол Улсын хувьд сургуулийн хүртээмжгүй байдал, сургалтын чанар хангалтгүй байгаагийн бас нэг суурь шалтгаан багшлах боловсон хүчингийн асуудлыг хөндөхөд хүрч байгаа. Багшлах боловсон хүчин хангалтгүй, чадваргүй байгаа нь сургалт чанаргүй, сургалт чанаргүй учраас ХБ хүүхдийн сурч боловсрох эрх зөрчигдөн нийгэмд оролцоогүй л байх нөхцөл байдалд л байлгана.

Багшлах боловсон хүчин:

Тусгай хэрэгцээт боловсролын тэр дундаа дефектологич буюу согог зүйч мэргэжлийн багш нарыг 1960-аад оны дунд үеэс 1990-ээд оны эхэн үе хүртэл гадаадад зохион байгуулалттайгаар бэлтгэж байсан. Тухайлбал, Унгарын Будапештын Эмнэлэг, сурганы дээд сургууль, мөн хуучнаар Оросын Ленинград, Москва, Эрхүүгийн багшийн дээд сургуулиудад хараа, сонсгол, хэл, яриа, оюун ухааны бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах чиглэлээр 100 гаруй багш бэлтгэж, тусгай хэрэгцээт боловсролын сургууль, цэцэрлэгийг мэргэжлийн багш, боловсон хүчнээр ханган ирсэн түүх бий. Гэвч өнөөдрийн байдлаар дээрх багш, сурган хүмүүжүүлэгч нарын дийлэнх нь тэтгэвэрт гарсан бөгөөд энэ салбарын хүний нөөцийн бодлого алдагдсан гэж хэлж болно.

Түүнчлэн тусгай сургуульд ажиллаж байгаа согог зүйч мэргэжлийн багш нарын мэргэжил, мэдлэгийг гадаад дотоодын сургуулиудад сургаж, хөгжүүлэх тогтолцоо бүрэн орхигдсоор ирсэн гэдгийг Ерөнхийлөгч Х.Баттулга онцлон тэмдэглэсэн байдаг. Тиймээс хөгжлийн бэрхшээлийн төрөл, онцлог байдлаас

хамаарч, тэд нарт тохирсон сургалтын арга барилаар хичээлийг заах, тухайн сургалтын байгууллагын орчныг хүртээмжтэй байдлаар бүрдүүлэх, ажиллах багш боловсон хүчнийг бэлтгэх, мэргэшүүлэх асуудал чухал байгаа юм.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 2017 оны “Мэдээллийн лавлах”-д Хөгжлийн бэрхшээлтэй ерөнхий боловсролын сургуульд суралцагчийн сурах үйл явцын чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээг дурджээ. Үүнд:

- Үдийн хоолтой болсон талаар
- Сурах бичгийн шинэчлэл хийж, сургалтын хэрэглэгдэхүүнтэй болсон талаар
- Сургуульд хамрагдаж чадахгүй байгаа хүүхдийг дэмжих чиглэлээр
- Тусгай хэрэгцээт боловсролын багшлах боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах чиглэлээр
- Сургалтын орчинг сайжруулан дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээг дурдсан байгаа боловч бодит байдалд үр дүн нь харагдахгүй байгаа нь асуудал.

Сайхан бичсэн тайлангаас илүү эдгээр хүүхдүүдийн оюун ухаан, зүрх сэтгэлд нь өөрийн гэсэн үнэ цэнэ, итгэл, хүсэл эрмэлзлийг бий болгож чадах боловсролын тогтолцоо, нийгмийн оюун санааны өөрчлөлт шаардлагатай байна.

Дүгнэлт

Хүн бүр адил, тэгш эрхтэй гэдгийг Монгол улсын Үндсэн хуулинд тусгасан байдаг. Олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг ч бидэнд бий. Үүнийг бусад салбарын хууль тогтоомжууд мөн адил гол зарчмаа болгох ёстой. Хууль гэгч нь эрхээ эдлэх, үүргээ хэрэгжүүлэх, нийгмийг сайн сайхан байдлыг хангах боломжийг олгодог тул энэ зарчим маш чухал.

Монгол улсад одоогоор хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загварын ойлголт нийтлэг болоогүйн улмаас тухайн иргэдийг сул дорой гэсэн ойлголт давамгайлж, бодит байдал дээр сурч боловсрох эрх хангагдаж чадахгүй байна.

Нийгмийн хамгааллын тэтгэвэр, тэтгэмж авдаг тогтолцооноос илүүтэй тэдний хөгжлийн асуудал яригдах ёстой. Хөгжлийн асуудал яригдах ёстой бол боловсролын асуудал нэн тэргүүнд.

Уг салбарын талаарх дээрх зүйлсийг дүгнэн үзэхэд нэг удаагийн шинжтэй, одоогийн нөхцөл байдалд ямар байгаа талаар мэдэгдэх судалгаа байхгүй зэрэг

асуудлууд байна. Гэхдээ ганцхан төрийн байгууллагад даатгаад орхиж болохгүй, эдгээр иргэдийн оролцоог хангахад хүн бүрийн оролцоо, хамтын ажиллагаа маш чухал юм. Ялангуяа нийгмийн сөрөг ойлголтыг өөрчлөхөд хамтын ажиллагаа шаардлагатай байна.

Нийгэмд хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 20 хувийг эзэлж байгаагаас үзэхэд эл асуудал боловсролтой шууд холбоотой. Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, дээд боловсролыг тэгш хүртээмжтэй, чанартай олгож, чадвартай иргэнийг бэлдэхгүй байгаа улмаас эдгээр иргэд нийгэмд сул дорой, идэвхгүй гэсэн ойлголт байсаар л байна.

Өнөөдөр бид өөрсдийн үнэ цэнээ мэддэг, зорилготой, тэмүүлэлтэй, үүнийхээ төлөө амьдарч чадах чадвартай иргэнийг бэлдэж чадаж байна уу? Дээрх судалгаа, нөхцөл байдлаас харахад эсрэгээр нь...

Асуудал байгаа бол шийдэл нь зайлшгүй байх хэрэгтэй. Иймд дээр дурдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд юу хийх ёстой вэ? Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролыг дэмжсэн, тусгай хэрэгцээт боловсролыг олгох, боловсролд тэгш хамруулах зохицуулалтуудыг нарийн тусгасан бие даасан хуультай болох;

Учир нь энэ талаарх нарийн зохицуулалт байхгүйн улмаас энэ салбар өнгөрсөн 30 жилийн хугацаанд урсгалаараа явж ирсэн. Иймд нарийн зохицуулсан бие даасан хууль батлагдсанаар энэ салбарт онцгой анхаарал хандуулах шаардлагатайг ойлгуулж, салбарын талаас ч нийгмийн талаасаа ч үр дүн, өөрчлөлтийг авчрах чухал ач холбогдолтой.

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг бусад хүүхдүүдтэй энгийн сургуульд тэгш хамруулан сургах ажлыг идэвхжүүлэх;

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/292 дугаар тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах” журмыг баталсан. Үүний хэрэгжилтийн явц ямар байгааг ойлгоё гэвэл аутизмтай хүүхдийг ялгаварлан гадуурхсан хэрэг үүнийг нотолно. Боловсролын байгууллага ямар ч нөхцөл байдалд хүүхдийн эрх ашгийг л хүндэлж хамгаалах ёстой. Иймээс уг асуудал сайдын гаргасан тушаал, журмаар зохицуулагдах энгийн нэг асуудал биш. Иймд дээр дурдсан бие даасан хууль байх шаардлагатай байгааг харж

байна. Мэдээж хуулийн процессыг нь илүү нарийвчилсан журам байх нь асуудал биш. Жишээ нь: одоогийн байдлаар Нийслэлд 6 тусгай сургууль, зарим бус нутаг болон сургуулиудын хүчин чармайлтаар хэд хэдэн ЕБС-д нээгдсэн тусгай анги, албан бус сургалтууд л хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол эзэмших газар болж байна. Иймд энэ үйл ажиллагааг цаашид төрийн болон төрийн бус байгууллагууд, ЕБС-иудын оролцоотойгоор эрчимжүүлэх шаардлагатай байна. Энэ нь хүүхдүүдийн зан төлөвшилд сайнаар нөлөөлөх үр дүнтэй арга юм.

3. Тусгай хэрэгцээт боловсролыг олгох, тэгш хамруулан сургах боловсон хүчнийг бэлтгэх, сургуулийн орчин, хэрэглэгдэхүүнээр хангах төсвийг нэмэгдүүлэх;

Дээрх жишээ баримтуудаас харахад чанартай боловсрол эзэмшиж, амьдарч чадахгүй байгаа хүүхдүүдийн төлөө энэ салбарын төсвийг нэмэгдүүлэх ёстой.

- Багш нарын чадварыг гадаад, дотоодод дээшлүүлэх ажлыг эрчимжүүлэх;
 - Энэ салбарт бэлтгэгдэж буй ирээдүйн боловсон хүчнийг чанартай, шат дараалалтай сайн бэлтгэх ;
 - Төсвийн зарцуулалтыг үр дүнтэй, нарийн хуваарилан, олон нийтэд шилэн болгох, үүнийг хянах механизмыг Сангийн яам хариуцан тайлагнадаг байх;
4. Хөгжлийн бэрхшээлийн талаарх нийгмийн ойлголтыг өөрчлөх ажлыг эрчимжүүлэх, энэ талаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулан оролцуулж, санаа бодлыг нь сонсон, асуудлын гарцыг хамтдаа шийдвэрлэх байнгын /улирал тутам/ хэлэлцүүлэг, олон нийтийн ажлуудыг зохион байгуулдаг болох;
 5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг зөрчсөн хэргийг хаах биш, үнэн зөвөөр, шударгаар шийдвэрлэхийн тулд Прокурорын байгууллага хэргийг үнэн, зөв шийдвэрлэж байгаа эсэхэд хатуу хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

Эдгээрээс гадна хийх олон зүйлс бий боловч нэн тэргүүнд чанартай, хүртээмжтэй, үр өгөөжтэй боловсролыг олгон үнэ цэнээ мэддэг, зорилго тэмүүлэлтэй иргэдийг бэлдэж чадвал энэ *бэрхшээл гэгч нь бэрхшээл огт биш* гэдгийг ойлгох цаг ирнэ.

Хөгжлийн төлөө хамтдаа өөрчлөө...

Ном зүй:

Хууль, конвенц:

1. Үндсэн хууль
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц
4. Боловсролын талаар алагчлахтай тэмцэх тухай

Ном, гарын авлага:

1. Ц.Давхарбаяр, Д.Эрдэнэчимэг Нийгмийн хамгааллын эрх зүйн гарын авлага, УБ 2013 он
2. Дэлхийн банк, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Хөгжлийн бэрхшээлийн талаарх дэлхийн тайлан
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн лавлах, УБ 2017 он
4. Мэргэжлийн сургалтад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хангах нь: Практик гарын авлага, Женев хот, 2013 он
5. Боловсролын салбарын танилцуулга-2019
6. Зөрчлийн тухай хууль болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ялгаварлан гардуурхсан заалт буй эсэхэд үнэлгээ хийх, бусад орны хууль тогтоомжийн талаар харьцуулсан судалгаа, 2018 он

Цахим нийтлэл:

1. <https://president.mn/7929/>
2. https://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/013/news/general/15122_2.html
3. <http://www.mlsp.gov.mn/uploads/news/files/ab2651e843027240b1d120d5ef7746df2ada1b57.pdf>
4. <https://www.youtube.com/watch?v=3uoRbLtLrrk&feature=youtu.be&fbclid=IwAR07jXeJluaWcDpWHUuzojctYrcmUS-sEeBNXNUTJHoYz0QE77LJnqDjbQs>
5. http://network.mn/post/32345?fbclid=IwAR2Mc98XWIW8k_o-tlBJJ3422rijPAqvNKsJ9mNLfxPUq1yGPP0qY4SUiQg
6. http://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_3300_014V1

7. <https://www.meds.gov.mn/?p=6590>
8. The individuals with Disabilities Education Act (IDEA)
<http://www.apa.org/advocacy/education/idea/index.aspx>
9. <https://www.youtube.com/watch?v=zwoWu0FQs98>
10. <https://www.youtube.com/watch?v=DeNeJNrsLSE>

МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБОО ТЕХНОЛОГИЙГ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНД ХЭРЭГЛЭХ НЬ

Ц.Нямаа¹

¹МУИС, НШУС-ын докторант

Хураангуй

XXI зууны Монголын боловсролын зорилго нь хүний хөгжил, амьдралын чанарыг баталгаажуулах, хэрэгцээ сонирхлыг нээлттэй тасралтгүй чөлөөт хэлбэрээр хангаж чадах хүмүүнлэг ардчилсан тогтолцоог бүрдүүлэн монгол уламжлал, зан заншилтай “Дэлхийн иргэн” хөгжих, үр ашигтай үйлчилгээ үзүүлэх замаар Монгол улсыг тогтвортой хөгжүүлэн, үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдлыг баталгаатай хангахад чиглэж байна.

Шинэ эрин үед боловсрол мэдээлэлжсэн, дизайнлаг хэлбэрээр сургалтын хөтөлбөрийн агуулгыг дүрслэн бэлтгэж, хүртээмжтэйгээр хүргэх, тэдний мэдлэг, чадварт тулгуурлан бүтээх явцыг үндэслэн чанартай, үр бүтээлтэй явуулах зорилтууд тулгарч байна. Үүнийг өнөөгийн нийгэмд хэнд, яаж хүргэхээс шалтгаалж, мэдээлэл харилцаа холбоо, технологийн суурь мэдлэгийг ашиглаж олдмол хөгжлийн бэрхшээлтэй/авто тээврийн, ажлын байрны, ахуйн осол г.м/ хүн онлайнаар/цахим/ хөгжих боломжтой.

Түлхүүр үг: МХХТ/Мэдээлэл харилцаа холбоо, технологи/, олдмол хөгжлийн бэрхшээл, онлайн сургалт

Үндэслэл

Хүний нийгмийн хөгжил, технологийн дэвшилтэй уялдан мэдээллийн хэмжээ асар их болж тэр хэрээр сургалтын үйлчилгээ өөрчлөгдөн мөн мэдээлэл холбооны технологийн асар хурдацтай хөгжил нь сургалтын арга хэлбэр, заах арга зүй шинэчилэгдэж цахим сургалтын хувьд маш их эрдэмтэд судалсаар ирсэн. Харин олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэнд мэдээлэл, харилцаа холбооны технологийг хэрхэн хэрэглэж, цахим сургалтыг нэвтрүүлэх талаас судлагдсан тэмдэглэл дурдагдсангүй. Тиймээс судалж эхлэсэн юм.

Олдмол хөгжлийн бэрхшээлтэй/авто тээврийн, ажлын байрны, ахуйн осол/ иргэн хөгжих боломжуудыг эрж хайн, үүнд тулгамдаж байгаа асуудлууд юу болох, үүнээс гарах арга зам юу вэ гэдэгт анхаарлаа хандуулах шаардлага зайлшгүй гарч ирж байна.

Мэдээлэл, харилцаа холбоо технологийг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хэрэглэх нь:

Мэдээллийг бий болгох, хадгалах, боловсруулах, түгээх болон солилцоход ашиглаж байгаа үйлчилгээ, хэрэглээ, бүтээгдэхүүнийг хамтад нь мэдээлэл,

харилцаа холбооны технологи-МХХТ (information & communication technology-ICT) гэж нэрлэдэг. Үүнтэй холбоотойгоор Монгол улс цахим засгийн тухай хууль, цахим мэдээллийн аюулгүй байдлын хууль, харилцаа холбооны тухай хууль, “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого 2025” /Засгийн газрын 2017 оны 47 дугаар тогтоол/ • Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх зарим арга хэмжээний тухай /Засгийн газрын 2018 оны 259 дүгээр тогтоол/ бодлогын баримт бичгүүдэд заасанаар хэрэгжүүлсээр байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хэлнэ. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 2016, дөрөвдүгээр бүлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүний сурах эрх, **14.1.4.хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн сургалтын хөтөлбөр, стандартыг боловсруулах гэсэн** заалт нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажил, гэр бусад хаанаас ч сурах боломжийг зайн, электрон, онлайн сургалтыг/Диаграм №01/ ашиглан хөгжүүлэх боломжтой.

Диаграм №01. Сургалтын хөгжлийн үе шат




Зайн сургалт гэдэг нь цаг хугацаа, орон зайн хүчин зүйлийг даван туулж, суралцагчид мэдлэг, ур чадвар, чадамжийг эзэмшүүлэх сургалт юм. Тийм ч учраас Мэдээлэл, харилцаа холбооны технологийг олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хэрэглэх нь өөрийн хувь хүний хөгжилд зайлшгүй шаардлагатай сургалтын хэлбэр юм.

Электрон сургалт нь суралцагчид агуулга хвргэхдээ бүх төрлийн электрон дамжуулах төхөөрөмж, түүний дотор интернет, интранет, экстранет, хиймэл дагуулын систем, аудио, видео систем, интерактив телевиз ба CD-ROM зэргийг ашиглаж **технологид суурилсан сургалт** болдог.

Электрон сургалтыг зайн сургалтад хэрэглэж байгаа туршлага дэлхийн олон оронд байдаг бөгөөд зайн сургалт нь тухайн цаг үеийнхээ хамгийн дэвшилтэт технологийг ашигладаг онцлогтой./Диаграм №02/

Диаграм №02. Электрон сургалтаас онлайн сургалт



Онлайн сургалт нь вэбэд, интернэтед тодорхой хаягтайгаар вэб сайт байдлаар байрласан орон зай, цаг хугацаанаас үл хамааран суралцаж болох сургалтын нэгэн өвөрмөц хэлбэр юм. /Цариагаа харах/

Онлайн сургалтыг нэвтрүүлснээр хөгжлийн бэрхшээлтэй хүний гүйцэтгэл, цаг хугацааны зарцуулалтыг хэмнэх боломжтой. XXI-р зуунд дэлхийн өнцөг булан бүрээс, бүх төрлийн хөдөлгөөнт болон суурин төхөөрөмжөөр холбогдон онлайн сургалт хийх, сургалт явуулах нь үр ашигтай шийдэл болжээ./Цахим сургалтын програм: cout, Vidyo Desktop, ooVoo, Skype, Meetme, IChat, WebEx Meeting Center, AT&T Connect, Zoom, Go to meeting, TrueConf, Handouts, WeChat /


Судалгаагаар авч үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Дэлхийн тайланд/2017-2018/ боловсролд тулгарч буй саад бэрхшээлийг гаргасан. Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд хамруулахад тогтолцоо болон сургуулиудад өөрчлөлт хийх шаардлагатай байдаг.

2. Боловсролын тогтолцоонд хичээлийн хөтөлбөр, багшийн арга зүй, үнэлгээ болон шалгалтын хэв загварт өөрчлөлт оруулж, сурагч төвтэй хандлагыг хүлээн авах хэрэгтэй гэж тусгасан байгаа нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудлыг оруулаагүй нийтлэг яригдсан гэж авч үзээд цаашид тусд нь өөрийн эрүүл мэнд, хувь хүн гэх мэт асуудлаар хөгжүүлэх боломжийг судалсан болно.

Монгол улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо 2020 оны байдлаар нийт 107075/2019он/ иргэн байгаагаас өмнөх оныхтой харьцуулахад 1,3 хувь өссөн байгаагаас төрөлхийн 43 хувь, 57 хувь нь олдмол байна./График №01/

График №01. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн.2019-2020




Улаанбаатар хотод нийт 34860 иргэн байгаагаас 15489 төрөлхийн, 19371 олдмол, хөдөлмөр эрхэлдэг хөгжлийн бэрхшээлтэй 3717 иргэн байна./График №02/

График №02. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн. УБ, 2019-2020



Улаанбаатар хотод нийт 34860 иргэн байгаагаас 19371 буюу 56 хувь олдмол хөгжлийн бэрхшээлтэй түүнээс 44 хувь нь ердийн өвчин, 4 хувь нь мэргэжлээс шалтгаалсан өвчин, 3 хувь нь зам тээврийн осол, 2 хувь нь үйлдвэрийн осол, 3 хувь нь ахуйн ослоор олдмол хөгжлийн бэрхшээлтэйгээс нийт олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэний 19,2 хувь нь хөдөлмөр эрхэлдэг хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна./График №03/


График №03. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн. УБ, 2019-2020



Цахимаар авсан судалгаагаар нийт 27 хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс 74 хувь нь эмэгтэй, 26 хувь нь эрэгтэй хамрагдсанаас 93 хувь нь олдмол, 7 хувь нь төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд оролцсон байна.

Та юунаас шалтгаалж хөгжлийн бэрхшээлтэй болсон бэ гэсэн асуултад 19-45 насны иргэд оролцсоноос 33-44 насны нийт 44 хувь хамрагдсанаас 20 хувь нь зам тээврийн ослоос шалтгаалж олдмол хөгжлийн бэрхшээлтэй болсон байна./График №04/

График №04. Хөгжлийн бэрхшээлтэй болсон шалтгаан. УБ




Та сургалтад хамрагдсан уу гэхэд 85 хувь нь үгүй гэж харин цаашид ямар сургалтын төвд сургалтад хамрагдахад ямар бэрхшээл байна гэхэд 70 хувь нөхцөл бололцоо байхгүй, 100 хувь нь явж сургалтад хамрагдах боломжгүй гэсэн саналуудыг давхардсан тоогоор хариулсан бөгөөд та онлайн сургалтад хамрагдахад ашиглагддаг програмыг хэр сайн мэддэг вэ гэсэн асуултанд давхардсан тоогоор 81,5 хувь нь zoom, wechat, skype, handouts хэрэглэдэг гэсэн нь ажиглалтын явцад ажил мэргэжлээс шалтгаалж ашигладаг нь харагдаж байна./График №05/

График №05. Цахим програм мэддэг эсэх.



Та ямар сургалтад хамрагдахыг хүсэж байна вэ гэсэн асуултад давхардсан тоогоор word, excel програмын сургалтад хамрагдахыг санал болгосон байгаа нь мэдээллийн технологийн сургалтад хамрагдах олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа нь судалгаанаас харагдаж байна. /График №06/

График №06. Сургалтанд хамрагдах эсэх



Дүгнэлт

Боловсролыг хүн өөрөө бага наснаас суралцаж, боловсруулж хөгжүүлсэнээр ухамсартайгаар хийж байгаа танин мэдэх үйл ажиллагаа, цаашлаад сурч боловсрох, хөгжих эрхээ эдлэхэд нь төр, нийгмийн зүгээс дэмжлэг үзүүлж байгаа дэс дараалалтай үйлчилгээ, түүний үр дүнд боловсрол эзэмших боломж нээлттэй байгаа нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгаанаас харагдаж байна.

Судалгааны явцад хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс судалгааг авахад судалгаанд оролцогч иргэн мэдээллээ худал бичих, хоосон орхих тохиолдлууд маш их тулгарсан. Тиймээс цахимаар судалгааг хийсэн болно. Нийт оролцогчийн 74 хувь нь эмэгтэй оролцсон нь эмэгтэйчүүдийн дуу хоолой, болох тулгуур судалгааны нэг болсон. Мөнх 93 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэд хамрагдсан нь гол зорилгод хүрэх алхам хийгдсэн.

Судалгаанд хөгжлийн бэрхшээлтэй болсон шалтгааныг тодруулахад 20 хувь нь зам тээврийн ослоос шалтгаалж олдмол хөгжлийн бэрхшээлтэй болсон түүнээс үүдээд сургалтад хамрагдах боломжгүй, цаашлаад гэрээсээ өөрийгөө хөгжүүлэхэд анхаарах бөгөөд онлайнаар мэдээллийн технологи болон хувь хүний хөгжлийн сургалтуудыг авахыг хүсэж байгаа нь хариа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих байгууллагууд анхааралдаа авах цаг үе ирсэн.

Ашигласан материал

1. Нийгмийн халамжийн хууль, тогтоомжийн гарын авлага, 2015 он
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуул, 2016 он

3. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар <http://www.hudulmur-halamj.gov.mn/>
4. Хөдөлмөр, нийгэм хамгааллын институт <http://rilsp.gov.mn/tasudalгаа.php>
5. Хөдөлмөр, нийгэм хамгааллын статистик
6. www.1212.mn
7. www.nso.mn
8. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар судалгаа <http://www.gadpwd.gov.mn/uploads/files/%D0%9C%D1%8D%D0%B4%D1%8D%D1%8D3.pdf>
9. Цахим програм хангамжийн судалгаа <https://lead.style/c/1v4i2jCk5SXDf5LY4DsE>
10. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа <http://rilsp.gov.mn/2019/upload/2019/pdf/HBI%20Final.pdf>
11. Олон улсын тайлан https://apps.who.int/iris/bitstream/handle/10665/70670/WHO_NMН_VIP_1_1.01_mon.pdf;jsessionid=36363A3F24847AE9B9EB542C6FC7841F?sequence=61

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД БОЛОН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛГҮЙ ИРГЭДИЙН ЯЛГААТАЙ БАЙДАЛ

Ханаагийн Цэвээнжав¹

¹Статистикч, Үндэсний статистикийн хороо

Энэхүү судалгааны ажилд дурьдагдах санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачийн байр суурийг илэрхийлэх бөгөөд ажилладаг байгууллагын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй

Хураангуй

Манай улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон хөгжлийн бэрхшээлгүй иргэд хэр ялгаатай байгааг судалсан судалгаа хомс байна. Тиймээс энэхүү судалгааг Монгол Улсын Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын үр дүнг ашиглан хийлээ. Монгол Улсад байгаа 106 мянга гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллийг хамруулсан энэхүү тооллогын үр дүнг ашиглан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон хөгжлийн бэрхшээлгүй иргэдийн боловсролд эцэг, эхийн боловсролын түвшин хэрхэн нөлөөлж байгаа эсэх, түүнчлэн боловсрол нь эдгээр хоёр бүлгийн хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтэд хэрхэн нөлөөлж байгааг тооцооноороо чухал ач холбогдолтой судалгаа болов.

Судалгаанаас дараах үр дүн гарлаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүний ээж нь боловсролгүй эсвэл бүрэн дундаас доош боловсролтой бол хүүхдийн сургуульд суралцахад сөрөг нөлөөтэй байна. Харин дээд боловсролтой бол эерэг нөлөөтэй гарсан байна. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүний ээж нь дээд боловсролтой бол хүүхэд нь сургуульд суралцах жил нэмэгдэж байна. Эдгээр үр дүн нь статистикийн нэг хувийн түвшинд ач холбогдолтой байна. Харин хөгжлийн бэрхшээлгүй хүний ээж нь дундаас дээш түвшний боловсролтой мөн аав нь бага боловсролоос дээш түвшний боловсролтой бол хөгжлийн бэрхшээлгүй хүүхэд сургуульд суралцах жил нэмэгдэж байна. Энэ нь мөн статистикийн нэг хувийн түвшинд ач холбогдолтой буюу ач холбогдлын түвшин өндөр байна.

Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлт нь хөгжлийн бэрхшээлгүй иргэдийн хөдөлмөр эрхлэлтээс ихээхэн ялгаатай байна. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй иргэний сургуульд сурсан жил нэг жилээр нэмэгдэхэд хөдөлмөр эрхлэлт нь 2 нэгжээр нэмэгдэж байна. Харин хөгжлийн бэрхшээлгүй хүний сургуульд сурсан жил нэг жилээр нэмэгдэхэд тэдний хөдөлмөр эрхлэлт 7 нэгжээр нэмэгдэж байна. Эдгээр нь статистикийн нэг хувийн түвшинд ач холбогдолтой үр дүн байна.

Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн нь ямар нэг мэргэжил эзэмшсэн бол тэдний хөдөлмөр эрхлэлтэд эерэг нөлөөтэй байна. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ямар нэг мэргэжил эзэмшсэн бол тэдний хөдөлмөр эрхлэлт 15.9 нэгжээр нэмэгдэж байна. Энэ нь статистикийн 1 хувийн түвшинд ач холбогдолтой байна.

Халамж, хөдөлмөр эрхлэлт 2 нь сөрөг хамааралтай байна. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй иргэн халамж авдаг бол хөдөлмөр эрхлэлт нь 7 нэгжээр бага байна. Харин хөгжлийн бэрхшээлгүй иргэнийх 3 нэгжээр бага байна.

Түлхүүр үг: Хөгжлийн бэрхшээл, ялгаатай байдал, боловсрол, аав ээжийн боловсрол, хөдөлмөр эрхлэлт, халамж

1. Удиртгал

“Хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хамруулна (УИХ, 2016). Хөгжлийн бэрхшээлийн хэлбэрийг харааны, хэл ярианы, сонсголын, хөдөлгөөний, сэтгэц оюуны, бусад (эдгээрээс бусад болон хавсарсан) гэсэн 6 ангиллаар авч үзэж байна. (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Жайка олон улсын хамтын ажиллагааны байгууллага, 2017).

Монгол Улсын “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай” хууль, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”, НҮБ-ын “Тогтвортой хөгжлийн зорилт 2030”, Ази Номхон далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг бодит болгоё” Инчеоны стратеги 2012-2022 зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүний бүрэн оролцоог хангасан, ая тухтай, хүний эрхэд тулгуурласан нийгмийг цогцлон бүрдүүлэх асуудлаарх үйл ажиллагааны хэрэгжилтийг хангахад хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх дэлгэрэнгүй, үнэн бодит тоо мэдээлэл зайлшгүй шаардлагатай байдаг. Иймээс НҮБ-ын тооллогын зарчим зөвлөмжид хөгжлийн бэрхшээлийн асуудлыг үндсэн үзүүлэлтээр оруулахыг зөвлөмж болгосон байдаг. Харин энэхүү тооллогын мэдээлэлд үндэслэн, хөгжлийн бэрхшээлтэй хүнд тулгарч буй асуудалд хийсэн судалгаа, шинжилгээ хомс байна.

Тулгамдсан асуудал

НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилго 2030-ийн Зорилт 8.5-д 2030 он гэхэд эрэгтэй, эмэгтэй бүх хүн, түүний дотор залуу болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бүрэн, бүтээмжтэй ажил, зохистой хөдөлмөр эрхлүүлж, адил үнэ цэнэтэй ажилд адилхан цалин хөлс олгох гэжээ. Түүнчлэн Зорилт 8.6-д 2020 он гэхэд ажил эрхэлдэггүй, боловсрол эсвэл сургалтад хамрагдаагүй залуучуудын эзлэх хувийг үлэмж хэмжээгээр бууруулах гэж заасан байна. Харин талаар хийсэн судалгаа, шинжилгээ байхгүй байна. Тиймээс бид бодит мэдээлэлд

түшиглэсэн судалгааг хийж, ямар хүчин зүйлс яаж хэрхэн нөлөөлж байгааг тооцох шаардлагатай.

Судалгааны асуулт

- Хөгжлийн бэрхшээлтэй болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сургуульд суралцах жил хэр ялгаатай байна вэ?
- Хөгжлийн бэрхшээлтэй болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сургуульд суралцахад аав, ээжийн боловсролын түвшин хэрхэн нөлөөлж байна вэ?
- Хөгжлийн бэрхшээлтэй болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол нь тэдгээрийн хөдөлмөр эрхлэлтэд хэрхэн ялгаатай нөлөөлж байна вэ?
- Хөгжлийн бэрхшээлтэй болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтэд бусад хүчин зүйлс хэрхэн ялгаатай нөлөөлж байна вэ?

Судалгааны зорилго

Энэхүү судалгааны зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй болон хөгжлийн бэрхшээлгүй иргэдийн сургуульд суралцах жилд аав, ээжийн боловсролын түвшин хэрхэн нөлөөлдөг эсэх, тэдгээрийн боловсрол нь хөдөлмөр эрхлэлтэд хэрхэн нөлөөлдөг эсэх, мөн хөдөлмөр эрхлэлтэд бусад хүчин зүйлс хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох зорилготой.

Судалгааны ач холбогдол

Энэхүү судалгаа нь судлаач миний судалснаар Монгол Улсад анх удаа хийгдэж байгаагаараа ач холбогдолтой.

Судалгааны шинэлэг байдал

Энэхүү судалгааг Монгол Улсын Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын үр дүнг ашиглан хийснээрээ ач холбогдолтой. Түүнчлэн Linear Probit Model (LPM), Probit Model, Logit Model зэрэг моделийг ашигласан. Мөн quasi-experiment арга буюу 2 шатат хамгийн бага квадратын арга (Two-Stage Least Square=2SLS)-ыг Монгол Улсын мэдээлэлд түшиглэн хийснээрээ шинэлэг боллоо.

Судалгааны ажлын бүтэц

Энэхүү судалгаа Удиртгал, Өгөгдөл болон эмпирик судалгааны арга зүй, Өгөгдлийн боловсруулалт, шинжилгээний үр дүн, Дүгнэлт, Ашигласан материал гэсэн хэсгээс бүрдэнэ.

2. Өгөгдөл болон эмпирик судалгааны арга зүй

Өгөгдлийн эх үүсвэр

Энэхүү судалгаанд Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны “Хүн ам, орон сууцны 2020 оны тооллого”-ын мэдээллийг ашигласан. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогод Монгол улсын 3,296,866 иргэн, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй 106,363 иргэд тоологдсон байна. Энэхүү судалгаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нас, хүйс, иргэний харьяалал, үндэс угсаа, шашин, суурьшил, боловсрол, бичиг үсгийн мэдлэг, өрх, гэр бүлийн байдал, гар утас, интернет хэрэглэгчид, үйлдлийн чадварын хүндрэл, эдийн засгийн идэвх зэрэг мэдээллийг ашиглав.

Судалгааны хамрах хүрээ

Энэхүү судалгаанд Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны “Хүн ам, орон сууцны 2020 оны тооллого”-ын мэдээллийг ашигласан. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогод Монгол улсын 3,296,866 иргэн, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй 106,363 иргэд тоологдсон байна. Энэхүү судалгаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нас, хүйс, иргэний харьяалал, үндэс угсаа, шашин, суурьшил, боловсрол, бичиг үсгийн мэдлэг, өрх, гэр бүлийн байдал, гар утас, интернет хэрэглэгчид, үйлдлийн чадварын хүндрэл, эдийн засгийн идэвх зэрэг мэдээллийг ашиглав.

“Хүн ам, орон сууцны 2020 оны тооллого”-ын мэдээлэлд үндэслэн 15-65 насны хүн ам, үүнээс зөвхөн Монгол улсын харьяат, түүнчлэн одоо суралцаж байгаа болон тэтгэвэрт гарсан хүн амыг хамруулаагүй. Түүнчлэн 2SLS моделд эцэг, эхийн боловсролын түвшнийг хамруулж тооцсон бөгөөд энэхүү моделд зөвхөн эцэг, эхтэйгээ хамтран амьдардаг иргэдийн боловсролыг авсан.

Хувьсагчдын тодорхойлолт Хамааран хувьсагч

Энэхүү судалгааны хамааран хувьсагч нь хөдөлмөр эрхлэлт. Энэхүү хувьсагч нь binary бөгөөд хэрэв хөдөлмөр эрхэлдэг бол 1, эрхэлдэггүй бол 0 гэсэн утгыг авах юм.

Үл хамаарах хувьсагч

Энэхүү судалгаа нь боловсрол хөдөлмөр эрхлэлтэд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох зорилготой. Тиймээс судалгаанд ашигласан үл хамаарах хувьсагчдыг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 1. Судалгаанд ашигласан хувьсагчдын тодорхойлолт

Хувьсагч	Тодорхойлолт
Хамааран хувьсагч	
emp	Хэрэв хөдөлмөр эрхэлдэг бол 1, бусад 0
Үл хамаарах хувьсагчид	
edu	Сургуульд сурсан жил
age	Нас
agesq	Насны квадрат
male	Хэрэв эрэгтэй бол 1, эмэгтэй бол 0
urban	Хэрэв хотод амьдардаг бол 1, хөдөө бол 0
married	Хэрэв гэрлэж байсан бол 1, бусад 0
size	Ам бүлэн тоо
pro	Хэрэв мэргэжил эзэмшсэн бол 1, бусад 0
welfare	Хэрэв халамжид хамрагддаг бол 1, бусад 0
disability	Хэрэв хөгжлийн бэрхшээлтэй бол 1, бусад 0
haraa	Хэрэв харааны бэрхшээлтэй бол 1, бусад 0
yaria	Хэрэв ярианы бэрхшээлтэй бол 1, бусад 0
sonsgol	Хэрэв сонсголын бэрхшээлтэй бол 1, бусад 0
hodolgoon	Хэрэв хөдөлгөөний бэрхшээлтэй бол 1, бусад 0
setgets	Хэрэв сэтгэцийн бэрхшээлтэй бол 1, бусад 0
busad	Хэрэв бусад төрлийн бэрхшээлтэй бол 1, бусад 0
Ээжийн боловсролын түвшин	
edum0	Хэрэв ээж боловсролгүй бол 1, бусад 0
edum1	Хэрэв ээж багаас бүрэн дунд боловсролтой бол 1, бусад 0
edum2	Хэрэв ээж техникийн болон мэргэжлийн боловсролтой бол 1, бусад 0

edum3	Хэрэв ээж тусгай мэргэжлийн дунд боловсролтой бол 1, бусад 0
edum4	Хэрэв ээж дээд боловсролтой бол 1, бусад 0
Аавын боловсролын түвшин	
eduf0	Хэрэв аав боловсролгүй бол 1, бусад 0
eduf1	Хэрэв аав багаас бүрэн дунд боловсролтой бол 1, бусад 0
eduf2	Хэрэв аав техникийн болон мэргэжлийн боловсролтой бол 1, бусад 0
eduf3	Хэрэв аав тусгай мэргэжлийн дунд боловсролтой бол 1, бусад 0
eduf4	Хэрэв аав дээд боловсролтой бол 1, бусад 0

Хувьсагчдын хураангуй статистик

Хүснэгт 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хураангуй статистик

Variable	Obs	Mean	Std. Dev.	Min	Max
employee	15,844	0.246	0.431	0	1
edu	15,844	6.267	5.088	0	20
age	15,844	32.944	10.040	15	65
agesq	15,844	1186.108	736.425	225	4225
male	15,844	0.557	0.497	0	1
urban	15,844	0.747	0.435	0	1
married	15,844	0.164	0.370	0	1
size	15,844	4.514	2.048	2	20
pro	15,844	0.240	0.427	0	1
welfare	15,844	0.706	0.455	0	1
disability	15,844	1.000	0.000	1	1
haraa	15,844	0.077	0.266	0	1
yaria	15,844	0.044	0.206	0	1
sonsgol	15,844	0.075	0.263	0	1
hodolgoon	15,844	0.169	0.374	0	1
setgets	15,844	0.4144787	0.492647	0	1
busad	15,844	0.2203989	0.414529	0	1
edum0	15,844	0.021	0.142	0	1
edum1	15,844	0.446	0.497	0	1
edum2	15,844	0.041	0.197	0	1
edum3	15,844	0.071	0.257	0	1
edum4	15,844	0.087	0.282	0	1

eduf0	15,844	0.008	0.092	0	1
eduf1	15,844	0.299	0.458	0	1
eduf2	15,844	0.029	0.168	0	1
eduf3	15,844	0.031	0.174	0	1
eduf4	15,844	0.041	0.198	0	1

Хүснэгт 3. Хөгжлийн бэрхшээлгүй иргэдийн хураангуй статистик

Variable	Obs	Mean	Std. Dev.	Min	Max
employee	261,624	0.719	0.450	0	1
edu	261,624	11.391	3.007	0	20
age	261,624	28.247	7.785	15	65
agesq	261,624	858.478	536.317	225	4225
male	261,624	0.560	0.496	0	1
urban	261,624	0.799	0.401	0	1
married	261,624	0.256	0.436	0	1
size	261,624	5.029	2.092	2	22
pro	261,624	0.581	0.493	0	1
welfare	261,624	0.134	0.341	0	1
edu0	261,624	0.015	0.120	0	1
edu1	261,624	0.470	0.499	0	1
edu2	261,624	0.061	0.240	0	1
edu3	261,624	0.000	0.000	0	0
edu4	261,624	0.454	0.498	0	1
edum0	261,624	0.009	0.096	0	1
edum1	261,624	0.482	0.500	0	1
edum2	261,624	0.053	0.223	0	1
edum3	261,624	0.091	0.288	0	1
edum4	261,624	0.173	0.378	0	1
eduf0	261,624	0.007	0.085	0	1
eduf1	261,624	0.385	0.487	0	1
eduf2	261,624	0.044	0.206	0	1
eduf3	261,624	0.046	0.209	0	1
eduf4	261,624	0.091	0.287	0	1

Эмпирик судалгааны арга зүй

Энэхүү судалгааны нь боловсрол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон хөгжлийн бэрхшээлгүй иргэдийн хөдөлмөр эрхлэлтэд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох зорилготой. Тиймээс судалгаанд Linear Probit Model (LPM), Probit Model, Logit Model зэрэг моделийг эхлээд ашиглана. Түүнчлэн 2 шатат хамгийн бага квадратын арга (Two-Stage Least Square=2SLS)-ыг ашиглана. Учир нь боловсрол хувьсагч нь судалгаанд хамрагдаагүй зарим хувьсагчтай хамааралтай байж болох юм. Тухайлбал, тухайн хүн боловсролгүй хэрнээ ур чадвартай, идэвхтэй, хүсэл тэмүүлэлтэй болоод ажил эрхэлдэг байж болно. Харин бид тэрхүү чадвар, идэвх, хүсэл тэмүүлэл гэдэг хувьсагчийг хамруулж чадахгүй учраас энэхүү боловсрол хувьсагч маань үлдэгдэл хувьсагчтай хамааралтай болж (endogenous problem), энэхүү судалгааны үр дүнг хүлээн зөвшөөрөхөд асуудалтай болох юм (omitted variable bias). Тиймээс бид энэхүү хамруулж чадахгүй хувьсагчдад нөлөөлж болохуйц, тооцож гаргаж чадахуйц хувьсагчдыг судлагдсан байдлын тоймоос (David, 2001) гаргаж авлаа. Дэвид (2001) эцэг, эхийн боловсрол нь хүүхдийн боловсролд нөлөөлөх боловч, эдгээр хамруулж чадахгүй байгаа хувьсагчтай хамааралгүй гэж үзсэн. Тиймээс бид энэхүү судалгааны omitted variable bias алга болгохын тулд аав, ээжийн боловсролын түвшинг (instruments) ашигласан.

Энэхүү судалгааг дараах байдлаар загварчлав.

Үндсэн тэгшитгэл:

$$Emp = \beta_0 + \beta_1 Edu_i + X_i' \beta_2 + \varepsilon_i$$

Instruments Z_i : Аав, ээжийн боловсролын түвшин

$$Cov(Z_i, \varepsilon_i) = 0$$

Эхний шат:

$$Edu_i = \alpha_0 + \alpha_1 Z_i + X_i' \alpha_2 + \epsilon_i$$

2 дахь шат:

$$Emp = \beta_0 + \beta_1 \widehat{Edu}_i + X_i' \beta_2 + \theta_i$$

Үүнд:

E_{it} - Хөдөлмөр эрхлэлт

Edu_i - Сургуульд сурсан жил

Z_i - Аав, ээжийн боловсролын түвшин

X'_i - Нас, насны квадрат, хүйс, суурьшил, гэрлэж байсан эсэх, ам бүлийн тоо, мэргэжил эзэмшиж байсан эсэх, халамжид хамрагддаг эсэх, хөгжлийн бэрхшээлтэй эсэх

ε_i - Үлдэгдэл хувьсагч

ϵ_i - Үлдэгдэл хувьсагч

θ_i - Үлдэгдэл хувьсагч

3. Өгөгдлийн боловсруулалт, шинжилгээний үр дүн

Боловсролын хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлөх нөлөө, LPM, Probit, Logit моделин үр дүн

Энэхүү 3 моделин үр дүнгээс харахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол нь хөдөлмөр эрхлэлтэд эерэг нөлөөтэй харагдаж байна. Өөрөөр хэлбэл, сургуульд сурсан хугацаа нэмэгдэх тусам хөдөлмөр эрхлэх боломж нь нэмэгдэж байна. Энэ нь статистикийн нэг хувийн түвшинд ач холбогдолтой байна.

Хүснэгт 4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж буй хүчин зүйлс, LPM, Probit, Logit моделин үр дүн

	LPM	Probit	Logit
edu	0.0128*** (0.0008)	0.0530*** (0.0031)	0.0925*** (0.0055)
age	0.00632*** (0.0018)	0.0304*** (0.0075)	0.0508*** (0.0131)
agesq	-0.000127*** (0.0000)	-0.000560*** (0.0001)	-0.000949*** (0.0002)
male	0.0192*** (0.0063)	0.0816*** (0.0239)	0.137*** (0.0414)
urban	-0.193*** (0.0080)	-0.733*** (0.0288)	-1.263*** (0.0505)
married	0.0234** (0.0104)	0.113*** (0.0350)	0.190*** (0.0599)

size	-0.00469*** (0.0016)	-0.0175*** (0.0060)	-0.0302*** (0.0105)
pro	0.192*** (0.0099)	0.546*** (0.0298)	0.912*** (0.0509)
welfare	-0.0815*** (0.0075)	-0.279*** (0.0252)	-0.478*** (0.0433)
haraa	Тийм	Тийм	Тийм
yaria	Тийм	Тийм	Тийм
sonsgol	Тийм	Тийм	Тийм
hodolgoon	Тийм	Тийм	Тийм
setgets	Тийм	Тийм	Тийм
busad	Тийм	Тийм	Тийм
N	15844	15844	15844

Доорх хүснэгтээс харахад хөгжлийн бэрхшээлгүй иргэдэд энэхүү эерэг нөлөөлөл мөн адилхан байна. Тухайлбал, LPM, Probit, Logit моделин үр дүнгээс харахад хөгжлийн бэрхшээлгүй иргэдийн боловсрол нь хөдөлмөр эрхлэлтэд эерэг нөлөөтэй байна. Өөрөөр хэлбэл, сургуульд сурсан хугацаа нэмэгдэх тусам хөдөлмөр эрхлэх боломж нь нэмэгдэж байна. Энэ нь статистикийн нэг хувийн түвшинд ач холбогдолтой байна.

Харин хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харьцуулахад, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сургуульд сурсан жил нэмэгдэхэд хөдөлмөр эрхлэх боломж нь хөгжлийн бэрхшээлгүй иргэдээс өндөр байна.

Хүснэгт 5. Хөгжлийн бэрхшээлгүй иргэдийн хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж буй хүчин зүйлс, LPM, Probit, Logit моделин үр дүн

	(1) LPM	(2) Probit	(3) Logit
edu	0.0164*** (0.000364)	0.0500*** (0.00109)	0.0831*** (0.00181)
age	-0.0142*** (0.000668)	-0.0409*** (0.00198)	-0.0710*** (0.00329)
agesq	0.000143*** (0.00000961)	0.000409*** (0.0000281)	0.000718*** (0.0000466)
male	0.0541*** (0.00178)	0.170*** (0.00565)	0.282*** (0.00953)
urban	-0.0789*** (0.00223)	-0.252*** (0.00751)	-0.437*** (0.0130)
married	-0.00209 (0.00220)	-0.00761 (0.00689)	-0.0167 (0.0116)
size	-0.00968*** (0.000426)	-0.0296*** (0.00128)	-0.0496*** (0.00214)
pro	0.169*** (0.00215)	0.505*** (0.00637)	0.854*** (0.0107)
welfare	-0.0509*** (0.00270)	-0.152*** (0.00787)	-0.250*** (0.0131)
N	261624	261624	261624

Аав, ээжийн боловсролын түвшин хүүхдийн боловсролын түвшинд нөлөөлж буй нөлөөлөл

Аав, ээжийн боловсролын түвшин хүүхдийн боловсролын түвшинд хэрхэн нөлөөлж байгааг харахад сонирхолтой үр дүн гарлаа. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүний ээж нь боловсролгүй эсвэл бүрэн дундаас доош боловсролтой бол хүүхдийн сургуульд суралцахад сөрөг нөлөөтэй байна. Энэ нь статистикийн нэг хувийн түвшинд ач холбогдолтой гарчээ. Харин дээд боловсролтой бол эерэг нөлөөтэй гарсан байна. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүний ээж нь дээд боловсролтой бол хүүхэд нь сургуульд суралцах жил нэмэгдэж байна. Энэ нь статистикийн нэг хувийн түвшинд ач холбогдолтой байна.

Хүснэгт 6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол аав ээжийн боловсролын түвшин нөлөөлж буй байдал, LPM, Probit Model, Logit Model-ын үр дүн

	LPM	Probit	Logit
edum0	-1.892*** (0.2150)	-0.675*** (0.0869)	-1.160*** (0.1530)
edum1	-0.292*** (0.0924)	-0.0301 (0.0345)	-0.0472 (0.0584)
edum2	0.292 (0.1780)	0.0805 (0.0674)	0.151 (0.1140)
edum3	0.372*** (0.1440)	0.0464 (0.0539)	0.0836 (0.0914)
edum4	1.113*** (0.1340)	0.209*** (0.0548)	0.350*** (0.0945)
eduf0	0.0805 (0.3990)	-0.0795 (0.1360)	-0.104 (0.2290)
eduf1	0.125 (0.0830)	-0.00489 (0.0309)	-0.019 (0.0525)
eduf2	-0.0351 (0.1950)	-0.0785 (0.0736)	-0.141 (0.1270)
eduf3	0.391** (0.1980)	-0.0106 (0.0748)	0.00928 (0.1270)
eduf4	0.682*** (0.1690)	0.089 (0.0689)	0.135 (0.1180)
age	-0.0218 (0.0196)	0.00602 (0.0075)	0.0107 (0.0128)
agesq	0.000078 (0.0003)	-0.0000765 (0.0001)	-0.000138 (0.0002)
male	-0.0726 (0.0631)	0.0659*** (0.0240)	0.114*** (0.0408)
urban	2.133*** (0.0748)	0.448*** (0.0272)	0.742*** (0.0463)
married	1.767*** (0.0843)	0.890*** (0.0481)	1.597*** (0.0895)
size	0.0583*** (0.0160)	0.0206*** (0.0064)	0.0371*** (0.0107)
pro	4.472*** (0.0738)	1.127*** (0.0379)	1.972*** (0.0716)
welfare	-1.123*** (0.0679)	-0.426*** (0.0279)	-0.737*** (0.0482)
haraa	-0.977	-4.552***	-13.99***

	(0.6850)	(0.1510)	(0.2580)
yarla	-3.525***	-5.502***	-15.62***
	(0.6940)	(0.1500)	(0.2550)
sonsgol	-1.981***	-4.974***	-14.74***
	(0.6870)	(0.1490)	(0.2520)
hodolgoon	-1.200*	-4.689***	-14.25***
	(0.6810)	(0.1460)	(0.2480)
setgets	-3.942***	-5.523***	-15.64***
	(0.6800)	(0.1440)	(0.2440)
busad	-1.430**	-4.844***	-14.52***
	(0.6810)	(0.1440)	(0.2440)
N	15844	15844	15844

Харин хөгжлийн бэрхшээлгүй хүний аав, ээжийн боловсролын түвшин хүүхдийн боловсролын түвшинд хэрхэн нөлөөлж байгааг харахад тун сонирхолтой үр дүн гарлаа.

Тухайлбал, хөгжлийн бэрхшээлгүй хүний ээж, аав нь боловсролгүй бол хүүхдийн боловсролд сөрөг нөлөөтэй байна. Өөрөөр хэлбэл, аав ээж нь боловсролгүй, мөн ээж нь дундаас доош түвшний боловсролтой бол хүүхдийн сургуульд сурах жил багасаж байна. Энэ нь статистикийн нэг хувийн түвшинд ач холбогдолтой байна.

Харин ээж нь дундаас дээш түвшний боловсролтой мөн аав нь бага боловсролоос дээш түвшний боловсролтой бол хөгжлийн бэрхшээлгүй хүүхдийн боловсролд эерэг нөлөөтэй байна. Өөрөөр хэлбэл, ээж нь дундаас дээш түвшний боловсролтой мөн аав нь бага боловсролоос дээш түвшний боловсролтой бол хөгжлийн бэрхшээлгүй хүүхэд сургуульд суралцах жил нэмэгдэж байна. Энэ нь мөн статистикийн нэг хувийн түвшинд ач холбогдолтой буюу ач холбогдлын түвшин өндөр байна.

Хүснэгт 7. Хөгжлийн бэрхшээлгүй иргэдийн боловсрол аав ээжийн боловсролын түвшин нөлөөлж буй байдал, LPM, Probit Model, Logit Model-ын үр дүн

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

	(1) LPM	(2) Probit	(3) Logit
edum0	-1.931*** (0.0789)	-0.781*** (0.0410)	-1.584*** (0.0868)
edum1	-0.271*** (0.0159)	-0.0167 (0.0225)	-0.0491 (0.0540)
edum2	0.00541 (0.0231)	0.0895** (0.0418)	0.217** (0.104)
edum3	0.430*** (0.0186)	0.217*** (0.0393)	0.558*** (0.103)
edum4	0.892*** (0.0160)	0.340*** (0.0353)	0.902*** (0.0957)
eduf0	-0.784*** (0.0848)	-0.456*** (0.0467)	-0.851*** (0.0985)
eduf1	0.197*** (0.0117)	0.136*** (0.0176)	0.316*** (0.0417)
eduf2	0.275*** (0.0210)	0.224*** (0.0443)	0.502*** (0.112)
eduf3	0.522*** (0.0187)	0.314*** (0.0548)	0.804*** (0.147)
eduf4	0.712*** (0.0140)	0.216*** (0.0417)	0.587*** (0.114)
age	0.0918*** (0.00421)	-0.0128** (0.00500)	-0.0446*** (0.0119)
agesq	-0.00154*** (0.0000625)	0.0000682 (0.0000715)	0.000324* (0.000171)
male	-0.905*** (0.00936)	-0.134*** (0.0157)	-0.280*** (0.0379)
urban	1.162*** (0.0149)	0.434*** (0.0162)	0.990*** (0.0388)
married	0.270*** (0.0116)	0.325*** (0.0239)	0.829*** (0.0611)
size	-0.0343*** (0.00238)	-0.00618* (0.00375)	-0.0107 (0.00907)
pro	2.762*** (0.0102)	0.737*** (0.0181)	1.877*** (0.0511)
welfare	-0.267*** (0.0152)	-0.342*** (0.0173)	-0.792*** (0.0395)
N	261624	261624	261624

Боловсролын хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлөх нөлөө, 2SLS моделин үр дүн

Энэхүү үр дүн нь тухайн хүүхдүүдийн боловсролд аав ээжийн боловсрол нөлөөлснийг тооцсоны дараах хөдөлмөр эрхлэлтийг тооцож гаргасан үр дүн юм. Энэхүү 2 шатат тооцооллыг хийсний дараа дараах үр дүн гарлаа.

Хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй хүний хүний боловсрол нь тэдгээрийн хөдөлмөр эрхлэлтэд эерэг нөлөөтэй байна.

Гэвч судалгааны үр дүнгээс хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлт нь хөгжлийн бэрхшээлгүй иргэдийн хөдөлмөр эрхлэлтээс ихээхэн ялгаатай байна. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй иргэний сургуульд сурсан жил нэг жилээр нэмэгдэхэд хөдөлмөр эрхлэлт нь 2 нэгжээр нэмэгдэж байна. Харин хөгжлийн бэрхшээлгүй хүний сургуульд сурсан жил нэг жилээр нэмэгдэхэд тэдний хөдөлмөр эрхлэлт 7 нэгжээр нэмэгдэж байна. Эдгээр нь статистикийн нэг хувийн түвшинд ач холбогдолтой үр дүн байна.

Харин нас нэмэгдэх тусам хөгжлийн бэрхшээлтэй иргэд хөдөлмөр эрхлэх боломжтой болж байхад хөгжлийн бэрхшээлгүй иргэдэд энэ нь эсрэгээрээ нөлөөлдөг байна.

Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн нь ямар нэг мэргэжил эзэмшсэн бол тэдний хөдөлмөр эрхлэлтэд эерэг нөлөөтэй байна. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ямар нэг мэргэжил эзэмшсэн бол тэдний хөдөлмөр эрхлэлт 15.9 нэгжээр нэмэгдэж байна. Энэ нь статистикийн 1 хувийн түвшинд ач холбогдолтой байна.

Халамж, хөдөлмөр эрхлэлт 2 нь сөрөг хамааралтай байна. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй иргэн халамж авдаг бол хөдөлмөр эрхлэлт нь 7 нэгжээр бага байна. Харин хөгжлийн бэрхшээлгүй иргэнийх 3 нэгжээр бага байна.

Хүснэгт 8. Боловсролын хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж буй нөлөөлөл, 2SLS моделин үр дүн

	Хөгжлийн бэрхшээлтэй 2SLS	Хөгжлийн бэрхшээлгүй 2SLS
edu	0.0200*** (0.0061)	0.0766*** (0.0016)
age	0.00643*** (0.0018)	-0.0210*** (0.0007)
agesq	-0.000127*** (0.0000)	0.000260*** (0.0000)
male	0.0198*** (0.0063)	0.110*** (0.0023)
urban	-0.210***	-0.168***

	(0.0162)	(0.0034)
married	0.0107	-0.0187***
	(0.0149)	(0.0024)
size	-0.00514***	-0.00766***
	(0.0016)	(0.0005)
pro	0.159***	-0.00757
	(0.0294)	(0.0050)
welfare	-0.0735***	-0.0335***
	(0.0100)	(0.0029)
haraa	Тийм	Үгүй
yaria	Тийм	Үгүй
sonsgol	Тийм	Үгүй
hodolgoon	Тийм	Үгүй
setgets	Тийм	Үгүй
busad	Тийм	Үгүй
N	15844	261624

4. Дүгнэлт

Энэхүү судалгааг Монгол Улсын Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын үр дүнг ашиглан хийлээ. Монгол Улсад байгаа 106 мянга гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллийг хамруулсан энэхүү тооллогын үр дүнг ашиглан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон хөгжлийн бэрхшээлгүй иргэдийн боловсролд эцэг, эхийн боловсролын түвшин хэрхэн нөлөөлж байгаа эсэх, түүнчлэн боловсрол нь эдгээр хоёр бүлгийн хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтэд хэрхэн нөлөөлж байгааг тооцсноороо чухал ач холбогдолтой судалгаа болов.

Судалгааны үр дүнгээс харахад хэрэв ээж, аав нь боловсролгүй бол хүүхдийн боловсролд сөрөг нөлөөтэй байна. Өөрөөр хэлбэл, аав ээж нь боловсролгүй бол хүүхдийн сургуульд суралцах жил багасаж байна.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүний ээж нь боловсролгүй эсвэл бүрэн дундаас доош боловсролтой бол хүүхдийн сургуульд суралцахад сөрөг нөлөөтэй байна. Энэ нь статистикийн нэг хувийн түвшинд ач холбогдолтой гарчээ. Харин дээд боловсролтой бол эерэг нөлөөтэй гарсан байна. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүний ээж нь дээд боловсролтой бол хүүхэд нь сургуульд суралцах жил нэмэгдэж байна. Энэ нь статистикийн нэг хувийн түвшинд ач холбогдолтой байна.

Харин хөгжлийн бэрхшээлгүй хүний ээж нь дундаас дээш түвшний боловсролтой мөн аав нь бага боловсролоос дээш түвшний боловсролтой бол хөгжлийн бэрхшээлгүй хүүхэд сургуульд суралцах жил нэмэгдэж байна. Энэ нь мөн статистикийн нэг хувийн түвшинд ач холбогдолтой буюу ач холбогдлын түвшин өндөр байна.

Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлт нь хөгжлийн бэрхшээлгүй иргэдийн хөдөлмөр эрхлэлтээс ихээхэн ялгаатай байна. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй иргэний сургуульд сурсан жил нэг жилээр нэмэгдэхэд хөдөлмөр эрхлэлт нь 2 нэгжээр нэмэгдэж байна. Харин хөгжлийн бэрхшээлгүй хүний сургуульд сурсан жил нэг жилээр нэмэгдэхэд тэдний хөдөлмөр эрхлэлт 7 нэгжээр нэмэгдэж байна. Эдгээр нь статистикийн нэг хувийн түвшинд ач холбогдолтой үр дүн байна.

Харин нас нэмэгдэх тусам хөгжлийн бэрхшээлтэй иргэд хөдөлмөр эрхлэх боломжтой болж байхад хөгжлийн бэрхшээлгүй иргэдэд энэ нь эсрэгээрээ нөлөөлдөг байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн нь ямар нэг мэргэжил эзэмшсэн бол тэдний хөдөлмөр эрхлэлтэд эерэг нөлөөтэй байна. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ямар нэг мэргэжил эзэмшсэн бол тэдний хөдөлмөр эрхлэлт 15.9 нэгжээр нэмэгдэж байна. Энэ нь статистикийн 1 хувийн түвшинд ач холбогдолтой байна.

Халамж, хөдөлмөр эрхлэлт 2 нь сөрөг хамааралтай байна. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй иргэн халамж авдаг бол хөдөлмөр эрхлэлт нь 7 нэгжээр бага байна. Харин хөгжлийн бэрхшээлгүй иргэнийх 3 нэгжээр бага байна.

Судалгааны хязгаарлалт

Энэхүү судалгаанд зөвхөн аав, ээжтэйгээ амьдардаг хүмүүсийн аав, ээжийн боловсролын түвшинг авч тооцсон. Учир нь бүх хүний аав, ээжийг хөөн олох мэдээллийн бааз дутмаг байсан болно. Түүнчлэн тооллогын мэдээлэлд цалингийн мэдээлэл байдаггүй учир авч буй цалин нь хэрхэн ялгаатай байгааг тооцоогүй. Цаашид цалингийн ялгаатай байгааг тооцвол мөн сонирхолтой үр дүн гарах болов уу.

Ашигласан материал

УИХ. (2016). *Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль*. Улаанбаатар.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Жайка олон улсын хамтын ажиллагааны байгууллага. (2017). *Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа*. Улаанбаатар. http://www.hudulmur-halamj.gov.mn/uploads/files/20180514_02.pdf.-ээс Гаргасан

David, C. (2001). *The Causal Effect of Education on Earnings*. Vol. 3 PART. 1.

2

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

ОЮУНЫ ЯЛГААТАЙ ЧАДВАРТАЙ ХҮНИЙГ АЖИЛД ДАДЛАГАЖУУЛАГЧ БУЮУ ЖООБ КООЧЫН АЖЛЫН ТУРШЛАГААС

П. Мөнхчимэг¹

¹ХБХЭЭХолбоо “Ногоон гархан” урлангийн багш

Хураангуй

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлог, хэрэгцээ, чадавхид үндэслэн тусгай ажлын байр бий болгох, тэдний боловсролын төвшин мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ядууралд өртөхөөс хамгаалах зайлшгүй шаардлага тулгараад байгаа хэдий ч бид Хөдөлмөрийн тухай хуулийн 111-р заалтыг тухай л ярьсаар ганц түүнийг биелүүлэхийн төлөө явсаар. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудалд төрийн бодлогын хэрэгжилтийг хангах, тэднийг өөртөө итгэлтэй, нийгмийн идэвхтэй гишүүн болгож хөгжүүлэх, бусдын адил амьдрах боломж нөхцөл, нийгэмд оролцох оролцоо, хөдөлмөр эрхлэхэд тулгардаг хүндрэл бэрхшээлийг олон улсад хэрхэн шийдвэрлэж бодлого, шийдвэр, тогтолцоондоо тусган ажиллаж байгааг судалсны үндсэн дээр Япон, Словак улсын туршлага Жооб кооч буюу ажлын дадлагажуулагч мэргэжилтний талаар мэдэж тэдэнтэй холбоо тогтоож Ажлын дадлагажуулагч буюу Жооб коочын систем арга замын талаар сургалтад хамрагдаж Оюуны ялгаатай чадвартай залуусыг дэмжлэгтэй ажлын байраар ханган, хүн бүрийн онцлог хэрэгцээнд тохирсон тохируулга хийж ажлын байранд дадлагажуулан ажиллаж байна. Жооб кооч буюу ажлын байрны дадлагажуулагчийн систем, тогтолцоог монгол нэвтрүүлсэнээр

- Оюуны ялгаатай чадвартай хүн хөдөлмөр эрхлэх боломж бүрдэнэ
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тогтвор, суурьшилтай хөдөлмөр эрхэлнэ
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн чанар, тоо үзүүлэлт нэмэгдэнэ
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хөдөлмөр эрхлэхийн өмнө, хөдөлмөрийн харилцаанд орсны дараа хэрхэн туслах, дэмжих, ажлын байрны тохируулга хийх талаар арга зүйтэй болно.
- Олон улсын туршлага судлаж, харилцаа холбоо тогтоож, хамтын ажиллагаа өрнүүлснээр Жооб коочийн тогтолцоо, системийн Монгол бий болгох нөхцөл бүрдэнэ

Түлхүүр үг: Ажлын дадлагажуулагч буюу Жооб кооч, Саори урлал, Ажлын байрны тохируулга

Оршил

Манай улсад 2017 оны байдлаар 103,6 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн /ХБИ/ байгаа нь нийт хүн амын 3,3 хувийг эзэлж байна. 92,5 хувь нь 15, түүнээс дээш насны иргэн. Үүнээс 21,1 хувь 19,974 хүн хөдөлмөр эрхэлж байна. 78,9 хувь 73,285 хүн хөдөлмөр эрхлээгүй байна. ХБХүмүүсийн хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгаанаас дурдвал Боловсролын төвшин доогуур дээд боловсрол, мэргэжил эзэмшилтийн хувь муу, цалин хөлс бага, дэд бүтцийн хүртээмж муу, ажлын

байрны тохируулга хийдэггүй, ажил олгогч нарын ойлголт хандлага муу, ажлын байр тогтворгүй, ажлын ачаалал даах чадваргүй, ажлын хурд, бүтээмж муу зэргээс үүдэлтэй. Ажиллаж буй ХБИ бэрхшээлийн хэлбэрээр үзвэл Хөдөлгөөний 21,9 Сонсголын 13,3 Харааны 8 Бусад 38,9 хувьтай байгаа нь Оюуны ялгаатай чадвартай /ОЯЧ/ хүн хөдөлмөрийн харилцаанд огт орохгүй байгааг харуулж байна. /ҮСХ ажиллах хүчний судалгаа 2017/

Кейс: Тусгай сургуулийн 9-р анги төгсөж байгаа нэгэн хүүгийн ээж хүүгийнхээ хонхны баярын үйл ажиллагаан дээр хэлсэн үгэндээ “Өнөөдөр миний хүүгийн сургууль төгсөж байгаа баярын өдөр гэхдээ үүнээс хойш миний хүү гэр гэдэг нэртэй шоронд насаараа хоригдож эхлэх өдөр болж байна гэж” нулимс туслуулан хэлсэн байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо /ХБХЭЭХ/2016 оноос эхлэн ОЯЧ хүний хөдөлмөр эрхлүүлэх чиглэлээр ажиллаж одоогоор 4 ОЯЧ хүнийг нээлттэй хөдөлмөрийн зах зээлд ажилд оруулж, 5 ОЯЧ хүнийг дэмжлэгтэй ажлын байраар /Саори урлал/ хангаж ажиллаж байна. Энэ хугацаанд ОЯЧ хүнийг нээлттэй хөдөлмөрийн зах зээлд хөдөлмөр эрхлүүлэх олон улсын туршлага судлан **Ажлын дадлагажуулагч буюу Жооб коочын** систем, ажлын талаар мэдэж Япон улсын “Емпвермент Окинава” ТББ, Словак улсын “Тененет” ТББ сургалтад хамрагдаж сурсан зүйл дээрээ үндэслэн ОЯЧ залуустай ажилласан нь ХБХүний тэр дундаа ОЯЧ хүн хөдөлмөр эрхлэх бүрэн боломжтой гагцхүү тэднийг анкет бөглүүлээд явуулах биш ажлын байран дээр нь дадлагажуулж, ажил олгогч нарт ойлгуулж тэдэнтэй нягт хамтын ажиллагаатай ажиллах нь ХБИ тогтвортой ажлын байртай байх нэг үндэс юм гэдгийг олж харсан.

Судалгааны ажил

Оюуны ялгаатай чадвартай залуусыг хөдөлмөрийн харилцаанд оруулах Жооб коочын хэрэгцээ шаардлага. Монгол улсад 6 тусгай сургууль үйл ажиллагаа явуулж байна үүний 4 нь оюуны ялгаатай чадвартай хүүхдүүд сурдаг.

№	Сургуулийн нэр	Бэрхшээлийн төрөл	Хүүхдийн тоо	Дэвшин суралцсан байдал	Хөдөлмөр эрхлэлт
1	55-тусгай сургууль	Оюуны ялгаатай чадвартай суралцагч	478	?	?

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

2	63- тусгай сургууль	Оюуны ялгаатай чадвартай суралцагч	215	?	?
3	70- тусгай сургууль	Оюуны ялгаатай чадвартай суралцагч	240	?	?
4	25- тусгай сургууль	Оюуны ялгаатай чадвартай суралцагч	250	?	?
5	116 тусгай сургууль	Хараа	112	?	?
6	29 тусгай сургууль	Сонсгол	184	?	?

ХБХЭЭХолбоо 2016-2019 онд хөдөлмөр бэлтгэсэн Оюуны ялгаатай чадвартай залуусын боловсрол эзэмшилт, дэвшин суралцаж мэргэжил эзэмшин, хөдөлмөр эрхэлсэн байдал.

№	Боловсролын эзэмшилт болон дэвшин суралцаж, хөдөлмөр эрхэлсэн байдал	ОЯЧ /30 /хүн
1	ЕБС төгссөн	1
2	Тусгай сургууль төгссөн	18
3	Сургуульд огт хамрагдаагүй	5
4	Дэвшин суралцсан /Сэргээн засах сургалт үйлдвэрлэлийн төв	1
5	Сургууль төгсөөд гэрээ байсан	29
6	Хөдөлмөр эрхэлсэн	0

Шийдвэрлэх санаа

Хөдөлмөр жуучлалын газар, хөдөлмөр халамж үйлчилгээний газарт ажиллаж байгаа ажилчид Жооб кооч сургалтад хамрагдсанаар хөгжлийн бэрхшээлтэй хүний анкет бөглүүлснээр ажлын байртай болгосон биш ажил олгогч, ажил хайгч, гэр бүлтэй ажиллаж тогтвортой ажлын байртай болгох Жооб коочоор ажиллах бүрэн боломжтой.

Төрийн болон төрийн бус байгууллага хамтын ажиллагаа сайжруулж гаднын орны туршлага судлан харилцаа, холбоо тогтоож, туршлага судлан Жооб коочын

системийг Монгол улсынхаа хөдөлмөрийн харилцаанд тохируулан туршиж үзээд үр дүнд үндэслэн нэвтрүүлэх.

Дүгнэлт

Жооб кооч систем Япон улсад 2002 онд Хөдөлмөрийн яамнаас эхлүүлснээс хойш Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зөвхөн тусгайлсан ажлын байранд ажиллах биш нийгэмдээ, нээлттэй хөдөлмөрийн зах зээлд тогтвор суурьшилтай ажиллаж эхэлсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн хөдөлмөр эрхлээд тохирох хөдөлмөрийн хөлс автал Жооб кооч туслалцаа үзүүлж ажиллахаас гадна гэр бүл, ажил олгогч, ажил хайгч, хөдөлмөрийн харилцааны бүх байгуулагатай хамтран ажилладаг учир хөгжлийн бэрхшээлтэй хүн тэр дундаа оюуны ялгаатай чадвартай хүний хөдөлмөр эрхлэлтийн тоо, чанар нэмэгдсэн байдаг.

ХБХЭЭХолбоо энэхүү арга аргачлал судлан бүтэн нэг жилийн турш Оюуны ялгаатай чадвартай хүнтэй ажиллаад өөрсдийн гэсэн туршлага хуримтлуулснаас гадна орон нутгийн салбарын болон төрийн, төрийн бусын 16 хүнд туршлагаа хуваалцан сургалт зохион байгуулсан нь цаашид Жооб коочын системийг эхлүүлэх үндэс болж байна.

Давуу тал

Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилд орох гэж анкет бөглөөд ажлын байран дээр очоод нэгээс хоёр сар ажиллах биш тогтвор суурьшилтай хөдөлмөр эрхлэх боломж бүрдэнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд авсан ажил олгогч болон байгууллагын хамт олон хөгжлийн бэрхшээлийн талаар зөв ойлголт хандлагатай болж тэднийг хүлээн зөвшөөрч хамтран ажилснаар тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэнэ.

Ашигласан материал

1. “Емповермент Окинава” ТББ Монгол улсад зохион байгуулсан сургалтын материал 2019.08.09-11
2. Словак улсын “Тененет” ТББ Монгол улсад зохион байгуулсан сургалтын материал 2019.11.15-20
3. Job accommodation network website
4. Job accommodation book 2019

Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн төвийн Мэргэжлийн боловсрол, ур чадвар олгох сургуулийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт ба боловсролын үр ашиг

Сандаг Цэрэндулам¹, Тогтохбат Мөнхбат¹

¹Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт

Хураангуй

Үндэслэл: Сэргээн засах сургалт үйлдвэрлэлийн төвийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал, ажилгүйдлийн шалтгаан, болон төгсөгчдийн боловсролын үр ашгийн хэмжээ хэр төвшинд байгааг тодорхойлох хэрэгцээ шаардлагын улмаас энэхүү судалгааг хийж гүйцэтгэлээ.

Үр дүн: СЗСҮТ-ийн сургалтын хэрэгцээт байдлын үнэлгээн дээр шинжлэхэд 64.7 хувь нь “маш сайн” гэж тодорхойлов. Мөн судалгаанд хамрагдсан ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийн 41.2 хувь нь байнгын ажлын байранд ажиллаж байгаа бөгөөд дийлэнх нь хувийн байгууллагуудад ажил хөдөлмөр эрхэлж байна. Харин өвчтэй бөгөөд, одоогоор ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй төгсөгчид 21.7 хувийг эзэлж байгаа бол, ялгаварлалд өртдөг төгсөгчид 14.0 хувийг эзэлж байна. Манай улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ялгаварлан үзэх байдал байсаар байгаа бөгөөд, бусадтай адил эрх тэгш, хөдөлмөр эрх хангагдахгүй байгааг энэ судалгаа харуулж байна. Боловсролын өгөөжийг сурсан жилээс хамаардаг гэж таамаглавал 17 ХБИ-ий хувьд сургуульд суралцсан нэмэлт нэг жил нь тэдгээрийн сарын цалинг, тэдгээрээс 1 жилээр бага сургуульд суралцсан ХБИ-тэй харьцуулахад дундаж цалинг дунджаар 13.4 хувиар нэмэгдүүлж байна. Харин боловсролын өгөөж, сурсан жил болон туршлагаас хамаардаг гэж таамаглавал 17 ХБИ-ий хувьд сургуульд суралцсан нэмэлт нэг жил нь тэдгээрийн сарын цалинг, тэдгээрээс 1 жилээр бага сургуульд суралцсан ХБИ-тэй харьцуулахад дундаж цалинг дунджаар 9.3 хувиар нэмэгдүүлж байгаа бол, туршлага нэмэгдэх тусам цалинг 0.6 хувиар өсгөж байна. Энэхүү тооцооллуудаас харахад СЗСҮТ-ийн МБУЧОС-ийн төгсөгчдийн боловсролын үр ашиг сурсан жилээс хамааран авч үзвэл үр ашигтай байна.

Түлхүүр үг

- ХБИ-Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
- БҮА-Боловсролын үр ашиг
- МБУЧОС-Мэргэжлийн боловсрол ур чадвар олгох сургууль

Удиртгал

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 17.1-д зааснаар Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилд орох, албан тушаал дэвших, цалин хөлс, нөхөн олговор авах, хөдөлмөр эрхлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд бусадтай адил тэгш хамрагдах эрхтэй, мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15.1-д зааснаар Бүх шатны сургалтын байгууллага болон мэргэжил олгох төв нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид амьдрах ухаан, мэргэжлийн ур чадварыг үр дүнтэй эзэмшүүлэх бөгөөд тухайн суралцагчийн онцлогт тохирсон хамгийн зохистой арга хэлбэрээр боловсрол олгох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд бие дааж амьдрах чадвар олгох, бүрэн болон бүрэн бус дунд боловсрол эзэмшсэн бол цаашид суралцах, эсхүл хөдөлмөр эрхлэх, мэргэжлээ сонгоход нь туслалцаа үзүүлэх, үүрэгтэй ажээ.

Монгол улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нийт мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв байдаг бөгөөд энэхүү судалгаандаа 7 төрлийн бэрхшээлийн хэлбэрийн иргэдэд зориулж, сургалт үйлчилгээ явуулдаг Сэргээн засах сургалт үйлдвэрлэлийн төвийг сонгон авлаа. Сүүлийн жилүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох, хөдөлмөрлөх эрх харьцангуй эрх тэгш болсон ч ажлын байран дээр гарах, ажлын байран дээр дасан зохицох, ажлын цагийн асуудал зэрэг хөндөгдөж болохуйц асуудлууд байсаар байна.

Монгол улсын хэмжээнд 2019 оны байдлаар 107075 хөгжлийн бэрхшээлтэй хүн байгаагийн 96906 хүн нь 16 ба түүнээс дээш насны иргэд байна. Харин 2018-2019 оны хичээлийн жилд улсын хэмжээнд мэргэжил болон техникийн боловсролын сургалтын байгууллагад нийт 555 хөгжлийн бэрхшээлтэй иргэд суралцаж байгаагийн 24.1 хувь, буюу 134 иргэн СЗСҮТ-д суралцаж байсан байна. Энэхүү статистик мэдээллээс харахад СЗСҮТ нь улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сургалт, үйлчилгээгээр нэлээдгүй том байгууллага гэдэг нь харагдаж байна. Тиймээс СЗСҮТ төвийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, ажил эрхлэлт, ажилгүйдэл зэрэг нөхцөл байдлуудыг тодорхойлох зорилгоор энэхүү судалгааг хийж гүйцэтгэлээ.

Судалгааны зорилго

Сэргээн засах сургалт үйлдвэрлэлийн төвийн мэргэжил, ур чадвар эзэмшсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт болон, хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгаан зэргийг тодорхойлох, сургалт үйлдвэрлэлийн төвийн боловсролын үр өгөөжийг хэмжих;

Судалгааны зорилт

1. Сэргээн засах сургалт үйлдвэрлэлийн төвийн төгсөгчдийн төлөв байдлыг тодорхойлох; /2018-2020 онуудын төгсөгчдийн тоон мэдээлэл дээр/
2. Сэргээн засах сургалт үйлдвэрлэлийн төгсөгчдийн ажил эрхлэлтийн талаарх нөхцөл байдлыг тодорхойлох; /2018-2020 онуудын төгсөгчдийн тоон мэдээлэл дээр /
3. Сэргээн засах сургалт үйлдвэрлэлийн төгсөгчдийн ажилгүй байгаа төгсөгчдийн төлөв байдлыг тодорхойлох; /2018-2020 онуудын төгсөгчдийн тоон мэдээлэл дээр /
4. Сэргээн засах сургалт үйлдвэрлэлийн төгсөгчдийн боловсролын үр ашгийг тодорхойлох; /2018-2020 онуудын төгсөгчдийн тоон мэдээлэл дээр /
5. Санал, зөвлөмж боловсруулах

Арга зүй, Аргачлал

Судалгааны мэдээлэл цуглуулалтыг гүйцэтгэхдээ тоон судалгааны анкетийн аргаар урьдчилан бэлтгэсэн асуулгын хуудсын дагуу 2018-2020 оны нийт 68 төгсөгчөөс судалгааг авсан.

Боловсролын үр ашгийг хэмжихдээ эконометрикийн шинжлэх ухааны суурь ухагдахуун болох регресс үнэлэх байдлаар чухал ач холбогдолтой коэффициентүүдийг тодорхойлсон. Статистик боловсруулалтыг STATA программ дээр нэг ба олон хувьсагчийн 2 төрлийн регресс үнэлсэн.

Сэргээн засах сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагч болон төгсөгчдийн өнөөгийн төлөв байдал

СЗСҮТ нь үндэсний хэмжээнд хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, ХБИ-ийн


эрэлт хэрэгцээнд нийцүүлэн мэргэжлийн боловсрол олгох сургалт явуулах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ явуулах, сэргээн засах хэрэгсэл, хиймэл эрхтэн үйлдвэрлэх зэрэг сэргээн засалтын тусламж, үйлчилгээг цогцоор нь чанартай, хүртээмжтэй хүргэх үүрэг бүхий байгууллага юм. ХБИ-дэд мэргэжлийн баримжаа олгох сургалтыг тус төвийн нэгж Мэргэжлийн боловсрол, ур чадвар олгох сургууль эрхлэн явуулдаг. Энэхүү сургууль нь 15-45 насны ХБИ-ийг 1-2,5 жилийн мэргэжлийн ангид суралцуулах боломжтой ба бусад мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүдээс ялгаатай нь боловсролын төвшин хамаарахгүй сургуулиас завсардсан болон суурь боловсролгүй ХБИ-д үндсэн 7 мэргэжлийн төрлөөр мэргэжлийн боловсрол, чиг баримжааг олгож байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн мэргэжлийн боловсрол олгож, тэдэнд харилцаа амьдрах ухаан, бизнес аж ахуй эрхлэх, англи хэл, биеийн тамир, эрүүл мэндийн болон мэргэжлийн технологийн хичээлүүдийг /20 хувь/ онол, /80 хувь/ дадлага/ хослуулан заадгаараа онцлогтой юм.

СЗСҮТ-д 2019 оны хагас жилийн байдлаар нийт 134 суралцагч суралцаж байсан бол, 2020 оны 10 сарын байдлаар 174 хүүхэд суралцаж байна. СЗСҮТ нь дараах 6 төрлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтдаа хамруулж, мэргэшлийн боловсролын зэрэг олгодог байна.

- Сонсголын бэрхшээл
- Тулгуур эрхтний бэрхшээл
- Сэтгэц оюуны бэрхшээл
- Хавсарсан бэрхшээл
- Хэл ярианы бэрхшээл
- Бусад бэрхшээл

График 13. СЗСҮТ-д 2020-2021 онуудад суралцаж буй оюутнууд
/бэрхшээлийн хэлбэрээр/

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”



СЗСҮТ-д 2020-2021 онуудад суралцаж буй нийт 174 оюутнуудын 37.8 хувийг бусад төрлийн хөгжлийн бэрхшээлтэй оюутнууд эзэлж байгаа бол, 24.7 хувийг тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй оюутнууд эзэлж байна. Харин 18.3 хувийг сонсголын бэрхшээлтэй оюутан, 10.9 хувийг хавсарсан бэрхшээлтэй оюутан, 6.8 хувийг сэтгэцийн бэрхшээлтэй оюутан, 1.1 хувийг хэл ярианы бэрхшээлтэй оюутнууд эзэлж байна.


СЗСҮТ-ийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой харилцаа, болон төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор 2018-2020 онуудад төгссөн нийт 68 төгсөгчөөс тоон судалгааны анкетийн аргаар урьдчилан бэлтгэсэн асуулгын хуудсын дагуу судалгааг авсан.

График 2. Судалгаанд хамрагдсан СЗСҮТ-ийн 2018-2020 онууд дэх төгсөгчид /ажил, мэргэжлээр/



Судалгаанд 4 төрлийн мэргэжлээр төгсөгчдийг хамруулсан бөгөөд 35.29 хувь нь хэвлэлийн график дизайн, 26.5 хувь нь оёмол бүтээгдэхүүний оёдолчин, 19.2 хувь нь гар утас засвар, телефон аппарат засварчин, 19.2 хувь нь талх нарийн боов, үйлдвэр технологийн ажилтан мэргэжлээр төгссөн хүмүүс эзэлж байна. Насны ангиллаар авч үзвэл 17-43 насны төгсөгчид хамрагдсан бөгөөд 17-25 насны залуучууд 52.9 хувийг эзэлж байна. Мөн судалгаанд хамрагдсан 68 төгсөгчөөс 66 нь сурч байх хугацаандаа үйлдвэрийн дадлага хийж байсан бөгөөд, ихэвчлэн хувийн байгууллагуудад дадлагаа хийж хамгаалсан байна.

График 3. СЗСҮТ-ийн дадлага болон сургалтын хэрэгцээт байдал /хариултын, хувилбараар/




СЗСҮТ-ийн дадлага болон сургалтын хэрэгцээт байдал дээр хийсэн шинжилгээнээс харахад нийт судалгаанд хамрагдсан хүмүүсийн 55.3 хувь буюу 36 хүн дадлагын хэрэгцээт байдал дээр маш сайн гэж хариулсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүний эрхийн тухай конвенцын 24 дүгээр зүйлийн 3-т зааснаар “Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, нийгмийн гишүүний хувьд боловсролд бүрэн дүүрэн тэгш оролцоход нь дэмжлэг үзүүлэх амьдралын болон нийгмийн хөгжлийн ур чадваруудыг эзэмших боломжийг олгоно” гэж заажээ. Судалгаанд хамрагдсан төгсөгчдийн 55.3 хувь нь маш сайн гэсэн үнэлэлт өгсөн байдлаас харахад СЗСҮТ нь төгсөгчдийг дадлагажуулах, мэргэжлийг үр дүнтэй эзэмшүүлэх тал дээр сайн анхаарч ажиллаж байгаа бөгөөд, энэхүү заалтын дагуу хөгжлийн бэрхшээлтэй,

нийгмийн гишүүнийг боловсрол эзэмших тал дээр бүрэн дүүрэн дэмжиж, ажиллаж байна.

Харин сургалтын хэрэгцээт байдал дээр судалгаанд хамрагсдын 64.6 хувь буюу 42 хүн маш сайн гэж хариулт өгсөн бол, 27.7 хувь нь сайн, 8.0 хувь нь дунд гэж хариулсан байна. Сургалтын агуулгын хувьд харилцаа амьдрах ухаан, бизнес аж ахуй эрхлэх, англи хэл, биеийн тамир, эрүүл мэндийн болон мэргэжлийн технологийн хичээлүүдийг /20 хувь/ онол, /80 хувь/ дадлага/ хослуулан заадгаараа онцлогтой юм. Мөн тус төв нь, үндэсний хэмжээнд хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, сэргээн засах хэрэгсэл, хиймэл эрхтэн үйлдвэрлэх зэрэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан бүх төрлийн тусламж үйлчилгээг хүргэж байгаа бөгөөд энэхүү үйлчилгээнүүдийг сургалтын үйл ажиллагаатай уялдуулж, хослуулснаар сургалтын хэрэгцээт байдал маш сайн гэж үнэлэгдсэн байх талтай.

График 4. Судалгаанд хамрагдсан СЗСҮТ-ийн 2018-2020 онууд дэх төгсөгчдийн мэргэжлээрээ төгссөн шалтгаан /хариултын,хувилбараар/




Судалгаанд хамрагдсан оюутнуудын 61.7 хувь нь энэхүү мэргэжилд дуртай сонирхолтой гэж хариулсан бөгөөд, энэхүү хувилбар нь бусад

хувилбаруудтай харьцуулахад нилээдгүй өндөр жинг эзэлж байна. Харин 23.6 хувь нь эцэг эх,гэр бүл, найз нөхөд санал болгосноор мэргэжлээ сонгож, суралцаж төгссөн байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс мэргэжлээ сонгож суралцахдаа, мэргэжлийн эрэлт болон тэтгэлэг болон санхүүгийн хөшүүргүүдийг харгалзан үзэж суралцах хандлага багатай буюу 7.4 хувийг эзэлж байна. Мөн судалгаанд хамрагдаж буй төгсөгчдийн дийлэнх нь мэргэжил эзэмшихээс гадна, нийгэмших, олон нийтийн харилцаанд оролцох сонирхолтой байдаг зэрэг нь судлаачийн өнцгөөс ажиглагдав.

Сэргээн засах сургалт үйлдвэрлэлийн төвийн төгсөгчдийн хөдөлмөрийн зах зээл дэх төлөв байдал


СЗСҮТ-ийн төгсөгчдийн ажил эрхлэлтийн төвшин 2019 оны байдлаар 43 хувьтай байгаа бөгөөд судалгаанд хамрагдсан хүмүүсийн хувьд ажил эрхлэлтийн төвшин 25 хувьтай байна. Ажил эрхэлж буй хүмүүсийн хувьд ихэвчлэн туслах ажилтан, цагийн ажилтан зэрэг албан тушаалууд дээр ажиллаж байна. Оёдолчны хувьд гэхэд л жижиг деталь оёх, цэвэрлэх, индүүдэх зэрэг туслах ажлууд дээр илүү ажиллах хандлагатай байгаа бөгөөд , хэвлэлийн дизайн мэргэжлээр төгссөн хүмүүсийн хувьд ахлах мэргэжилтэнд туслах, дэвтэрлэх, үдэх, хавтаслах зэрэг ажлууд дээр түлхүү ажиллах хандлагатай байна.

График 5. Судалгаанд хамрагдсан СЗСҮТ-ийн 2018-2020 онууд дэх төгсөгчдийн ажил эрхлэлтийн статус /хариултын,хувилбараар/




Судалгаанд хамрагдсан төгсөгчдийн 51.5 хувь одоогоор ямар нэг эрхэлсэн ажилгүй байгаа бөгөөд, 19.2 хувь нь ажил хөдөлмөр эрхэлж байгаа бол 7.4 хувь нь хувиараа бизнес эрхэлдэг хүмүүс байна. Мөн төрөөд хүүхдээ асарч байгаа буюу ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй төгсөгчид байгаа бөгөөд нийт судалгаанд хамрагдсан 4.5 хувийг эзэлж байна. Үргэлжлүүлэн суралцаж байгаа төгсөгчид нийт судалгаанд хамрагдсан төгсөгчдийн 17.7 хувийг эзэлж байгаа бөгөөд, энэхүү хувилбар дотор бүрэн дунд боловсрол эзэмшихээр дахин суралцаж байгаа хүмүүс ч хүртэл байгаагаараа онцлогтой юм.

График 6. Судалгаанд хамрагдсан СЗСҮТ-ийн 2018-2020 онууд дэх төгсөгчдийн ажил эрхлэлтийн хэлбэр /хариултын,хувилбараар/



Судалгаанд хамрагдсан ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийн 41.2 хувь нь байнгын ажлын байранд ажиллаж байгаа бөгөөд дийлэнх нь хувийн байгууллагуудад ажил хөдөлмөр эрхэлж байна. Мөн байнгын ажлын байранд ажиллаж байгаа хүмүүсийн хувьд 46.6 хувь нь долоо хоногт 31-40 цагийн ажил хөдөлмөр эрхэлж байна. ААНОАТ-ын хуулийн 19.8-д зааснаар “50-аас дээш хувиар хөдөлмөрийн чадвараа алдсан ХБИ-ий эзэлж байгаа хувь хэмжээгээр тооцон үзүүлэх албан татварын хөнгөлөлт эдэлнэ” гэж заасан байдаг. Харин энэхүү судалгаанд хамрагдсан ажил хөдөлмөр эрхэлж байгаа ажилчдын 33.3 хувь нь хүн амын орлогын татвар төлдөггүй бол 66.7 хувь нь ямар нэг байдлаар төлдөг байна.

График 7. Судалгаанд хамрагдсан СЗСҮТ-ийн 2018-2020 онууд дэх төгсөгчдийн ажил хайхгүй байгаа шалтгаан /хариултын,хувилбараар/



Судалгаанд хамрагдсан ажилгүй байгаа төгсөгчдийн ажил хайхгүй байгаа шалтгааныг хариултын хувилбараар дээрх графикт харууллаа. Шалтгаанаар нь авч үзвэл, бусад төрлийн шалтгаанаар ажил хайхгүй байгаа төгсөгчид 46.0 хувь буюу хамгийн өндөр хувийг эзэлж байна. Харин өвчтэй бөгөөд, одоогоор ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй төгсөгчид 21.7 хувийг эзэлж байгаа бол, ялгаварлалд өртдөг төгсөгчид 13.6 хувийг эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүний эрхийн тухай конвенцын 27 дүгээр зүйлийн 1-т зааснаар “Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бусадтай адил тэгш байх үндсэн дээр хөдөлмөр эрхлэх, тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд хүртээмжтэй, нээлттэй байгаа, оролцож болох хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөрлөх орчинд ажиллахаар чөлөөтэй сонгосон, эсхүл зөвшөөрлөө чөлөөтэй өгсөн нөхцөлд эрхэлж буй хөдөлмөрийнхөө үр шимээр амьжиргааны эх үүсвэрээ олох боломжтой байх хүний эрхийг хүлээн зөвшөөрнө гэж заажээ.” Манай улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ялгаварлан үзэх байдал байсаар байгаа бөгөөд, бусадтай адил тэгш хөдөлмөр эрх хангагдахгүй байгааг энэ судалгаа харуулж байна.

Сэргээн засах сургалт үйлдвэрлэлийн төвийн төгсөгчдийн боловсролын үр ашгийг тодорхойлох

Боловсролоос хувь хүний хүртэх үр ашгийг тодорхойлж, тооцох нь боловсролын нийт үр ашгийг зөв үнэлж, боловсролын талаар баримтлах бодлогыг тодорхойлоход чухал ач холбогдолтой. Боловсролын эдийн засаг болон, боловсролын шинжлэх ухаанд боловсролын үр ашгийг хувь хүний

орлого буюу цалин гэсэн үзүүлэлтээр хэмждэг. Цалингийн хэмжээ нь дараах хүчин зүйлүүдээс хамаарч, ялгаатай байж болно.

- ажиллагчдын хүйс,
- нас
- боловсрол,
- ажлын туршлага,

Цалинд нөлөөлж буй дээрх хүчин зүйлүүдээс боловсрол, болон ажлын туршлага гэсэн 2 хувьсагч дээр үндэслэн, БҮА-ийг 1973 онд боловсролын эдийн засагч Минсер АНУ-ын датан дээр үндэслэсэн.

Зураг 1. Минсерийн цалингийн тэгшитгэл

$$\ln w = f(s, x) = \ln w_0 + \rho s + \beta_1 x + \beta_2 x^2$$

Энэхүү судалгааны ажлаараа СЗСҮТ-ийг 2018-2020 онуудад төгссөн ажил хөдөлмөр эрхэлж буй 17 төгсөгчийн цалингийн хэмжээ болон, сурсан жил гэсэн 2 хувьсагч дээр үндэслэн, БҮА-ийн хэмжээг тооцоолохыг зорилоо. АХС- аас үзэхэд иргэдийн боловсролын түвшин дээшлэх тусам дундаж цалин өсөж байна. Гэхдээ энэ өсөлт хэр өндөр вэ? Бусад оронтой харьцуулахад, Монголын хөдөлмөрийн зах зээлийн өгөөж хэр вэ? Дэлхийн банкны судалгаагаар 2011 оны байдлаар Монголын боловсролын салбарын үр өгөөж нь бага боловсролын хувьд 13.7%, дунд боловсролын хувьд 4.2%, дээд боловсролын хувьд 10.1% байжээ. Эдгээр үзүүлэлт дэлхийн дунджийн хувьд 11.5%, 6.8%, 14.6% тус тус байгаа юм.

Цалингийн хэмжээ: Цалин гэсэн хувьсагчийг тухайн ажилчны нэг сард авсан цалингийн хэмжээнээс логарифм авч засварлав. *gen lnwage = log(wage)*

Сурсан жил: Сурсан жил гэсэн хувьсагчийг тухайн ажилчны СЗСҮТ-д явахаас өмнөх боловсролын төвшинд харгалзах суралцсан жил дээр, СЗСҮТ-д суралцсан жилийг нэмснээр тооцоолов.

Зураг 2. Сурсан жилээс хамаарах боловсролын өгөөж / Минсерийн цалингийн тэгшитгэл дээр/

Source	SS	df	MS	Number of obs	=	17
Model	1.56690609	1	1.56690609	F(1, 15)	=	11.11
Residual	2.11555257	15	.141036838	Prob > F	=	0.0045
Total	3.68245866	16	.230153666	R-squared	=	0.4255
				Adj R-squared	=	0.3872
				Root MSE	=	.37555

lnwage	Coef.	Std. Err.	t	P> t	[95% Conf. Interval]
Сурсанжил	.1346131	.0403861	3.33	0.005	.0485321 .2206941
_cons	11.42155	.5001245	22.84	0.000	10.35556 12.48754

1. $\ln wage = 11.4 + 0.1346$ сурсан_жил

17 хүний хувьд сургуульд суралцсан нэмэлт нэг жил нь тэдгээрийн сарын цалинг, тэдгээрээс 1 жилээр бага сургуульд суралцсан хүмүүстэй харьцуулахад дундаж цалинг дунджаар 13.4 хувиар нэмэгдүүлж байна.

Мөн цалингийн хэмжээ сурсан жилээс гадна хувь хүний чадвар туршлагаас хамаарч өөрчлөгдөх боломжтой тул регрессийн үнэлгээндээ туршлага гэсэн хувьсагчийг нэмж орууллаа.

Туршлага: Туршлага гэсэн хувьсагчийг сонгохдоо тухайн хүний наснаас сурсан жилийг хасаж, мөн 7-г хасаж засварлав. Хүн 7 нас хүртлээ ямар нэг туршлага хуримтлуулах боломжгүй тул, дунджаар 7 наснаас эхлэн боловсрол эзэмшинэ гэж таамаглав.

$$gen\ exp = \text{Нас} - \text{Сурсан жил} - 7$$

Зураг 3. Сурсан жил болон туршлагаас хамаарах боловсролын өгөөж / Минсерийн цалингийн тэгшитгэл дээр/

Source	SS	df	MS	Number of obs	=	17
Model	2.23795832	3	.745986106	F(3, 13)	=	6.71
Residual	1.44450034	13	.111115411	Prob > F	=	0.0056
Total	3.68245866	16	.230153666	R-squared	=	0.6077
				Adj R-squared	=	0.5172
				Root MSE	=	.33334

lnwage	Coef.	Std. Err.	t	P> t	[95% Conf. Interval]	
Сурсанжил	.0930664	.0416982	2.23	0.044	.0029828	.1831499
exp	-.1036514	.0433742	-2.39	0.033	-.1973557	-.0099471
exp ^{sq}	.0065076	.0031586	2.06	0.060	-.0003161	.0133312
_cons	12.11408	.535669	22.61	0.000	10.95684	13.27132

2. Ln wage=12.1+0.093сурсан_жил-0.103exp+0.006exp^{sq}

- 17 хүний хувьд нэмэлт нэг жилийн туршлага нь, тэдгээрээс 1 жилээр бага туршлагатай хүмүүстэй харьцуулахад дундаж цалинг дунджаар 10.3 хувиар бууруулж байна.
- 17 хүний хувьд сургуульд суралцсан нэмэлт нэг жил нь тэдгээрийн сарын цалинг, тэдгээрээс 1 жилээр бага сургуульд суралцсан хүмүүстэй харьцуулахад дундаж цалинг дунджаар 9.3 хувиар нэмэгдүүлж байна.
- 17 хүний хувьд туршлага нэмэгдэх тусам цалинг 0.6 хувиар өсгөж байна.

Дүгнэлт

2018-2019 оны хичээлийн жилд улсын хэмжээнд мэргэжил болон техникийн боловсролын сургалтын байгууллагад нийт 555 хөгжлийн бэрхшээлтэй иргэд суралцаж байгаагийн 24.1 хувь, буюу 134 иргэн СЗСҮТ-д суралцаж байна. СЗСҮТ-ийн сургалтын хэрэгцээт байдлын үнэлгээн дээр шинжлэхэд 64.7 хувь нь “маш сайн” гэж тодорхойлов. СЗСҮТ-ийн МБУЧОС нь мэргэжлийн боловсрол олгох, дадлагажуулах, дадлагын байранд зуучлах зэрэг олон талт байдлаар анхаарал хандуулан ажиллаж байна. Мөн судалгаанд хамрагдсан ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийн 41.2 хувь нь байнгын ажлын байранд ажиллаж байгаа бөгөөд дийлэнх нь хувийн байгууллагуудад ажил хөдөлмөр эрхэлж байна. Харин өвчтэй бөгөөд, одоогоор ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй төгсөгчид 21.7 хувийг эзэлж

байгаа бол, ялгаварлалд өртдөг төгсөгчид 13.6 хувийг эзэлж байна. Манай улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ялгаварлан үзэх байдал байсаар байгаа бөгөөд, бусадтай адил эрх тэгш, хөдөлмөр эрх хангагдахгүй байгааг энэ судалгаа харуулж байна. ХБИ-д хандаж буй сөрөг хандлагууд нь тэднийг боловсрол эзэмших, нийгэмших, цаашлаад хөдөлмөр эрхлэхэд хүртэл саад тотгор учруулж байна.

Боловсролын өгөөжийг сурсан жилээс хамаардаг гэж таамаглавал 17 ХБИ-ий хувьд сургуульд суралцсан нэмэлт нэг жил нь тэдгээрийн сарын цалинг, тэдгээрээс 1 жилээр бага сургуульд суралцсан ХБИ-тэй харьцуулахад дундаж цалинг дунджаар 13.4 хувиар нэмэгдүүлж байна. Харин боловсролын өгөөж, сурсан жил болон туршлагаас хамаардаг гэж таамаглавал 17 ХБИ-ий хувьд сургуульд суралцсан нэмэлт нэг жил нь тэдгээрийн сарын цалинг, тэдгээрээс 1 жилээр бага сургуульд суралцсан ХБИ-тэй харьцуулахад дундаж цалинг дунджаар 9.3 хувиар нэмэгдүүлж байгаа бол, туршлага нэмэгдэх тусам цалинг 0.6 хувиар өсгөж байна. Энэхүү тооцооллуудаас харахад СЗСҮТ-ийн МБУЧОС-ийн төгсөгчдийн боловсролын үр ашиг сурсан жилээс хамааран авч үзвэл үр ашигтай байна.

Шинэ санаа, зөвлөмж

- ХБИ боловсрол эзэмшсэнээрээ үр ашигтай байгаа тул ХБИ-ийг боловсрол эзэмшүүлэх нь зүйтэй. Цаашлаад боловсрол эзэмшүүлэх мэргэжлийн тоог нэмэх, СЗСҮТ-ийн сургалт үйл ажиллагаанд төрөөс дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна
- Тиймээс ХБИ-г төрөөс боловсрол эзэмших, боловсрол эзэмших явцад гарч буй хүндрэл бэрхшээлүүдийг танин мэдэж, анхаарч ажиллах шаардлагатай байна.
- Мөн хөдөлмөрийн зах зээл дээр гарч буй төгсөгчдийн ажил хайхгүй шалтгаан нь маш олон төрөл байгаа бөгөөд, бусад гэсэн шалтгааныг төгсөгчдийн 46.0 хувь нь сонгосон байна. Үүнээс үзэхэд төгсөгчдийн тал хувь хөдөлмөрийн зах зээлийн харилцааны талаарх мэдлэг мэдээлэл хомс байна. Иймд төгсөгчдийг ажлын байраар хангах, ХБИ-ий хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн хэмжээг урьдчилан тогтоох эрэлтийн барометрийн судалгаа хэрэгтэй байна.

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ХБИ-ий хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль болон, эдлэх хөнгөлөлт үйлчилгээний талаарх мэдлэг ойлголтуудыг хүргэж байх шаардлагатай байна.

Талархал

Уг судалгааг явуулахад дэмжин ажилласан Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал С.Баярбат, Мэргэжлийн боловсрол, ур чадвар олгох сургуулийн статистикч Н.Ундрал, болон сургалтын менежер П.Чимэддулам нартаа талархал илэрхийлье.

Ашигласан хэвлэл

1. <https://www.legalinfo.mn/law/details/11711>- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем
2. <http://mlsp.gov.mn/>- “Хөдөлмөр Нийгэм Хамгаалалын яам” /ХХҮЕГ/
3. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа” “ХНХЯ, Жайка ОУХАБ”
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүний эрхийн тухай конвенц /НҮБ, ХНХЯ/
5. <https://economics.ubc.ca/> Mincer, Jacob (1974) Schooling, Experience and Earnings, New York: National Bureau of Economic Research
6. <https://www.worldbank.org/> (Claudio & Patrinos, 2014)

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА

Б. Элбэгдорж¹

¹ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв

Хураангуй

2017 оны байдлаар 103360 ХБИ байдаг ба үүнээс хөдөлмөрийн насны 93259 байдаг ба 19974 буюу 40% нь ХБИ хөдөлмөр эрхэлж байна. 2009 онд хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан 25 ажилтан тутамд 1 ХБ байна гэж хуулчилсан ба энэ хуулийн биелэлт хэр байгааг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэн” гэж төрөлхийн болон удамшлын эмгэг өөрчлөлт, осол гэмтлийн улмаас бие эрхтэн, оюун ухаан, сэтгэц, тулах хөдлөх эрхтэн, мэдрэхүйн чадавх нь амьдрах, хөдөлмөрлөх боломж хязгаарлагдсан нь тогтоогдсон хүнийг хэлнэ. Ийм тодорхойлолтоор хүрээлэн буй орчинд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ойлгоод зогсохгүй ажил хийх чадваргүй гэж ойлгодог. Миний судалгаа нь ХБИ хөдөлмөр эрхлэлт бөгөөд энэ судалгаагаар дамжуулан “хөдөлмөрлөх боломж хязгаарлагдсан” гэсэн ойлголтыг эрс өөрчлөнө. Өөрөөр хэлбэл Монгол улсад байгаа ХБИ хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдлыг судлахыг зорилоо.

Судалгааны зорилго

Сонгогдсон аймаг, дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажил эрхлэлтийн төлөв байдлыг тодорхойлох явдал нь энэхүү судалгааны зорилго юм

Судалгааны зорилт

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажил эрхлэлтийн түвшин, хүйсээр ерөнхий хандлагыг тодорхойлох
- Хаана аль бүсэд ХБИ-ийн ажил эрхлэлт өндөр байгаа, аль хүйсийнхэнд ажил эрхлэлт илүү өндөр байгааг тодорхойлох
- Хөдөлмөрийн хуулийн 111.1д заасан хуулийн биелэлтийг тодорхойлох
- ХБИ ажил эрхлэлт хөгжлийн бэрхшээлийн төрлөөр, хүйс, бүс нутгаар харах

Судалгаанд хамрагдагсад

Монгол улсын нутаг дэвсгэр дээр байгаа ХБИ-ийн мэдээлэл 2017, 2016, 2015 мөн 2018 оны түүвэр судалгаа

он	Хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо
2017	19974
2016	19563
2015	19715

Судалгааны аргачлал

- 3 Судалгааг Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа хийж авсан бөгөөд Үндэсний статистикийн хороо болон мэдээллийн сангаас тоо мэдээллийг авсан.
- 4 2018 оны судалгааг хөдөлмөрийн хуулийн “111.1 д заасан хуулийн хэрэгжилтэн дээр хяналт тавих зорилгоор Монгол улсын ерөнхий сайд У.Хүрэлсүхийн санаачилгаар Монгол улсын нутаг дэвсгэр дээр байгаа Улсын болон хувийн хэвшлийн аж ахуй нэгжээс тоо мэдээлэл цуглуулсан.

“ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлт” судалгаа

Монгол улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн тогтолцоонд шилжин хүнлэг, ардчилсан нийгэм байгуулж эхэлсэн үеэс нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн тогтолцоо бүхэлдээ өөрчлөгдөн шинэ тогтолцоо нэвтэрч эхлэж байна. Шинэчлэлийн сөрөг үр дагавар хүндээр туссан нийгмийн бүлгийн нэг бол ХБИ юм. Нийгмийн энэ шинэ харилцаанд зохицуулан ХБИ-ийг нийгмийн амьдралд татан оролцуулах, тэдгээрийн хязгаарлагдмал боломжид тохирсон ажил хөдөлмөр эрхлүүлэхтэй холбоотой шинэ бодлого хэрэгжиж эхэлсний дүнд олон хууль, тогтоол, тушаал гаргаж ажиллаж байна. Эдгээр арга хэмжээнүүд нь Монгол улсын хувьд шинэ, анхлан хэрэгжүүлж байгаа юм. Иймээс алдсан асуудал, шийдвэрээ хүлээж байгаа олон зүйл монголын нийгмийн өмнө тулгамдаж байна.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн тухай 159 дугаар конвенцид хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажил олох, ажлын байраа хангах, ажлын байраа хадгалах, ахиж дэвших адил боломж олгох, тэгш хандах, тухайн ажил нь өөрийн сонголтод нийцэж, хувь хүний боломж чадварыг харгалзсан байх зэрэг нийтлэг хэм хэмжээг заасан байдаг.

Түүнчлэн тус конвенцид мэргэжлийн нөхөн сэргээлтэд хамруулах, хөдөлмөрийн зах зээлд нээлттэй оруулцах, хөдөлмөр эрхлэлт, нөхөн сэргээлтийн дэд бүтцийг бий болгох, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын цагыг богиносгох, тусгай зориулалтын тоног төхөөрөмжийг татвар, бусад төлбөрөөс чөлөөлөх, мэдээлэл хүргэх, тэднийг дэмжихэд чиглэсэн орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, багш

нарыг бэлтгэх, давтан сургах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг гишүүн орнууд зөвлөсөн. Конвенцийн дагуу монгол улсын засгийн газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг эдлүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх талаар холбогдох хууль тогтоомжид тусгасан. Тухайлбал:

1. Хөдөлмөрийн тухай хуульд 25, түүнээс дээш ажилчинттай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу ажилтны ажлын цагийг богинсгох, ээлжийн амралтыг уртасгах, аж ахуйн нэгжид хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажилуулах квот тогтоох, биелүүлээгүй тохиолдолд торгууль төлбөр ноогдуулах гэж заасан байдаг.


Хөгжлийн бэрхшээлтэй иргэд

График: Хөгжлийн бэрхшээлтэй иргэд



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо
Монгол Улсад 2017 оны байдлаар 103,6 мянга буюу нийт хүн амын 3.3 орчим хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 44,6 хувь нь эмэгтэй, 54 хувийг эрэгтэйчүүд, 2 хувь нь 16-аас доош насны хүүхэд байна. Тэдний 42 хувь нь төрөлхийн, 58 хувь нь олдмол шалтгааны улмаас хөгжлийн бэрхшээлтэй байна.

График: ХБИ бүсээр, 2015-2017



Эх сурвалж: ҮСХ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бүс нутгаар харахад Баруун бүсийн хувьд 2015 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 4407 хүн ажил эрхлэдэг байсан бол 2017 онд 3604 болж 1.2 дахин буурчээ. Хангайн бүсийн хувьд байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 4239 хүн ажил эрхлэдэг байсан бол 2017 онд 3619 болж 1.1 дахин буурчээ. Харин төвийн бүс хөгжлийн бэрхшээлтэй 3967 хүн ажил эрхлэдэг байсан бол 2017 онд 5812 болж 0.6 дахин нэмэгдсэн. 2015-2017 оны интервалыг харахад Баруун бүс, хангайн бүс, зүүн бүс, буурсан үзүүлэлтэй. Харин төвийн нэмэгдсэн байна. Харин улаанбаатарын хувьд 2015 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 5400 хүн ажил эрхлэдэг байсан бол 2017 онд 5337 болж 1.01 дахин буурчээ

Хөдөлмөр эрхлэлт

График: Хөдөлмөрийн насны ХБИ



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо задгай тоон мэдээлэл
 Дээрх графикаас ХБ иргэдийн хөдөлмөрийн насны хүн амыг харвал 2015 оны байдлаар 90456 ХБ иргэд хөдөлмөрийн насныхан байна. Харин 2017 онд 93259 болж буурсан. Өмнөх онтойгоо харьцуулахад 0.9 дахин өссөн үзүүлэлтэй байна
 График: ХБИ ажил эрхлэлт. (2015-2017)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо задгай тоон мэдээлэл
 Дээрх графикаас ХБ иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг харвал 2015 оны байдлаар 19715 ХБ иргэд хөдөлмөр эрхэлж, 2016 онд 19563 болж

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

буурсан. Өмнөх онтойгоо харьцуулахад 1 дахин буурсан үзүүлэлтэй байна. Харин 2017 онд 19974 болж өссөн ба энэ оныг задалж харвал:

Хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөр насны **19974** хүн хөдөлмөр эрхэлж байна. Харин хөдөлмөр эрхэлж буй тэтгэврийн насны хүн **3018** байгаа юм. Хөдөлмөр эрхэлдэггүй хөгжлийн бэрхшээлтэй хүн **73285** байна.

Хүснэгт: ХБИ ажил эрхлэлт, бэрхшээл

он	Хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо	Эмэгтэй	Хөгжлийн бэрхшээлийн төрөл					
			Төрөлхийн	Олдмол				
				Өвчнөөр		Осол гэмтлээр		
				Ердийн өвчин	Мэргэжлээс шалтгаалсан өвчин	Зам тээврийн осол	Үйлдвэрийн осол	Ахуйн осол
2017	19974	8395	6685	10705	817	359	238	1170
2016	19563	8252	6398	10879	799	281	209	997
2015	19715	8333	6141	10887	1074	382	268	963

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо задгай тоон мэдээлэл
Хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийг бэрхшээлийн төрлөөр харвал 2015 онд 19715 ХБИ ажил эрхлэлт байгаагаас 6685 төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 13289 олдмол бэрхшээлтэй иргэд ажил хийж байна. Олдмолийг задлавал: өвчнөөр 11522, осол гэмтлээр 1767 байна. Харин 2016 онд 19563 болж буурсан ба 6398 төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 13165 олдмол бэрхшээлтэй иргэд ажил хийж байна. Олдмолийг задлавал: өвчнөөр 11678, осол гэмтлээр 1487 байна. Өмнөх онтойгоо харьцуулахад ХБИ ажил эрхлэлт буурсан ба хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр хархад бэрхшээлийн төрөл буурсан үзүүлэлтэй байна. ХБ иргэдийн ажил эрхлэлтийн байдлыг бүс нутгаар харахад
2.2 График: ХБИ ажил эрхлэлт, бүс нутгаар 2015-2017



Эх сурвалж: ҮСХ задгай тоон мэдээ
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажил эрхлэлтийг бүс нутгаар харахад Баруун бүсийн хувьд 2015 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 4407 хүн ажил эрхлэдэг байсан бол 2017 онд 3604 болж 1.2 дахин буурчээ. Хангайн бүсийн хувьд байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 4239 хүн ажил эрхлэдэг байсан бол 2017 онд 3619 болж 1.1 дахин буурчээ. Харин төвийн бүс хөгжлийн бэрхшээлтэй 3967 хүн ажил эрхлэдэг байсан бол 2017 онд 5812 болж 0.6 дахин нэмэгдсэн. 2015-2017 оны интервалыг харахад Баруун бүс, хангайн бүс, зүүн бүс, буурсан үзүүлэлтэй. Харин төвийн нэмэгдсэн байна. Харин улаанбаатарын хувьд 2015 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 5400 хүн ажил эрхлэдэг байсан бол 2017 онд 5337 болж 1.01 дахин буурчээ

.Харин бүс нутгийг аймгаар задалж харвал 21 аймгийн засаг дарга тамгын газрын ажилчид түүндээ хөгжлийн бэрхшээлтэй ажилчин, шаардлагтай авах хэмжээ болон хуулийн биелэлтийг харахийг зорилоо. 21 аймгийг харьцуулан шинжилж үзвэл:

2.3 Шинжилгээ

Хүснэгт 1: Аймгийн сумдын ЗДТГ

Аймгийн нэр	Сумын тоо	Судалгаанд хамрагдсан сумын тоо	Нийт ажилтан	Ажиллаж буй ХБИ-ний тоо	Ажиллавал зохих ХБИ-ийн ажилтаны тоо	Хуулийн биелэлт
Архангай	18	6	161	9	7	100%
Баян-Өлгий	13	1	29	1	1	100%
Баянхонгор	20	9	261	12	10	100%

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Булган	16	9	278	9	11	81.8%
Говь-Алтай	18	0	0	0	0	0%
Говь-сүмбэр	3	1	31	1	1	100%
Дархан-Уул	4	1	89	1	3	33.3%
Дорноговь	13	6	163	9	6	100%
Дорнод	14	7	242	9	9	100%
Дундговь	15	5	103	7	4	100%
Завхан	23	1	54	1	2	50%
Орхон	2	2	313	12	12	100%
Өвөрхангай	19	7	204	4	8	50%
Өмнөговь	14	0	0	0	0	0%
Сүхбаатар	12	0	0	0	0	0%
Сэлэнгэ	17	0	0	0	0	0%
Төв	26	1	56	7	2	100%
Увс	19	16	458	31	18	100%
ховд	17	11	328	14	18	77.7%
Хөвсгөл	24	0	0	0	0	0%
хэнтий	17	4	125	4	4	100%

Эх сурвалж: Ерөнхий сайдын орон тооны бус зөвлөл Монгол улсын 21 аймгийн 365 сумдын ЗДТГ хамрагдлаа. Судалгаанд сэлэнгэ, сүхбаатар, өмнөговь, хөвсгөл, говь-Алтай гэсэн 5 аймгийн сумуудын тоо мэдээллээ ирүүлээгүй бөгөөд судалгааны ирцийг үнэлэхэд 72% гүйцэтгэлтэй байна. ховд аймгийг авч үзэхэд нийт 17 сумтай. 11 сумаас ЗДТГ мэдээлэл ирсэн ба нийт 328 ажилтантай. Үүнээс 14 ажилтан нь хөгжлийн бэрхшээлтэй. Хөдөлмөрийн хуулийн 111.1 зааснаар ховд аймаг нь 18 ХБ авах ёстойгоос 4 ХБ аваагүй нь харагдаж байна. хуулийн биелэлт 77.7%. Харин Хангайн бүсээс хөвсгөл аймгийг хэлэхийн бол сумуудынхаа тоо мэдээллийг ирүүлээгүй ба бусад судалгаануудыг харахад маш муу оролцсон. Төлөвлөгөөний биелэлт 0%. Төвийн бүсээс Дархан-Уул аймгийг авч үзэхэд Нийт 4 сумтай ба 1 сумаас мэдээлэл ирсэн ба Нийт 89 ажилтантай үүнээс 1 ажилтан нь хөгжлийн бэрхшээлтэй. Хуулийн биелэгжилт 25%. 21 аймгаас харахад хамгийн олон сумтай аймаг нь төв аймаг бөгөөд нийт 23 сумтайгаас 1 сумын СЗДТГ-ын тоо мэдээлэл ирсэн ба судалгаандаа идэвхгүй оролцсон. Харин судалгаанд идивхтэй оролцсон аймаг нь увс байсан бөгөөд нийт 19 сумтай ба 16 сумаас мэдээлэл ирж нийт 458 ажилтантай үүнээс 31 ажилтан нь ХБ ба энэ байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй ажилтан авах хэмжээ 18 бөгөөд одоогийн хэмжээгээс 13 хөгжлийн бэрхшээлтэй ажилтан илүү байна. Дээрх хүснэгтээс харахад 21 аймгийн СЗДТГ нь Хөдөлмөрийн хуулийн 111.1 д зааснаар тухайн байгууллага нь байгууллага нь 25


хүн тутамд 1 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна гэсэн заалтнаас үзэхэд хуулийн биелэлтэй 100% гүйцэтгэлтэй байна.

2.4 Хүснэгт: ХБИ хөдөлмөр эрхлэлт, хүйсээр

	2015		2016		2017	
	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй
БАНГАЙН БҮС	2560	1847	2652	1744	2051	1553
ХАНГАЙН БҮС	2389	1850	2484	1831	2213	1406
ЗҮҮН БҮС	1023	679	1227	681	989	613
ТӨВИЙН БҮС	2456	1511	2351	1463	4301	1511
УЛААНБААТАР	2954	2446	2597	2533	2891	2446


Эх сурвалж: ҮСХ задгай тоон мэдээ
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг хүйсээр харвал гурван оны интервалыг харахад эрэгтэй хүн ажил эрхлэлтийн байдал эмэгтэй хүнээс 1-1.5 дахин өндөр байгаа нь харагдаж байна. Эдгээр 4 бүсээс хөдөлмөр эрхлэлтийн байдал өндөр нь төвийн бүс бөгөөд хөдөлмөр эрхлэлтийн байдлыг хүйсээр харахад 2-3 дахин өндөр байна. Жишээ авбал 2017 оны байдлаар ХБИ хөдөлмөр эрхлэлт нь төвийн бүсэд 5813 ХБИ хөдөлмөр эрхэлж байгаагаас 4301 эрэгтэй, 1511 эмэгтэй байна.

Хөдөлмөр эрхлэлтийн дүн шинжилгээ
Хөдөлмөр эрхлэх боломжийн судалгаа



/ түүвэр судалгааны аргаар 150 хүн хамруулав/
Хөдөлмөрийн насны ажил эрхлэдгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэнээс судалгаа авсан ба судалгааг Судалгаанаас харахад ажил хийх бүрэн боломжтой ХБИ 8.8%, харин ажил хийх боломжгүй нь 35.5%, боломжийн 7,7% , тохирсон ажил хийх боломжтой 46% гэж хариулсан. Энэ үзүүлэлтээс харахад тохирсон ажил хийх боломжтой ХБИ хамгийн өндөр байгаа нь харагдаж байна.

2.6 График: Бэрхшээлийн үүсэл, ажил эрхлэлт (2015-2017)



Эх сурвалж: ҮСХ задгай тоон мэдээ 2015 оны байдлаар 19715 хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажил хийдэг ба төрөлхийн оноштой мөртлөө ажил эрхэлдэг 6146 хүн, олдмолоор ХБ болсон 13574 хүн ажил эрхэлдэг байна. Харин 2017 онд байдлаар 19974 хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажил хийдэг ба төрөлхийн оноштой мөртлөө ажил эрхэлдэг 6685 хүн, олдмолоор ХБ болсон 13289 хүн ажил эрхэлдэг байна. Өмнөх онтойгоо харьцуулахад төрөлхийн оноштой мөртлөө ажил эрхэлдэг хүн 1.08 дахин нэмэгдсэн, харин олдмол оноштой мөртлөө ажил эрхэлдэг 0.9 дахин буурсан үзүүлэлтэй байна. **Бүс нутгаар задалж харвал:**

2.7 График: хөдөлмөр эрхлэлт, бэрхшээлийн төрөл

	2015		2016		2017	
	олдмол	төрөлхийн	төрөлхийн	олдмол	олдмол	төрөлхийн
БАРУУН БҮС	2560	1847	1961	2435	2051	1553
ХАНГАЙН БҮС	2389	1850	1249	3066	2213	1406
ЗҮҮН БҮС	1023	679	643	1265	989	613
ТӨВИЙН БҮС	2456	1511	1278	2536	4301	1511
УЛААНБААТАР	2954	2446	1267	3863	3947	1390

Эх сурвалж: ҮСХ задгай тоон мэдээ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бэрхшээлийн үүслээр хөдөлмөр эрхлэлтийг бүс нутгаар харвал 2015 онд баруун бүсийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажил хийдэг ба төрөлхийн оноштой мөртлөө ажил эрхэлдэг 6146 хүн, олдмолоор ХБ болсон 13574 хүн ажил эрхэлдэг байна. Харин 2017 онд байдлаар 19974 хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажил хийдэг ба төрөлхийн оноштой мөртлөө ажил

эрхлэдэг 6685 хүн, олдмолоор ХБ болсон 13289 хүн ажил эрхэлдэг байна. Өмнөх онтойгоо харьцуулахад төрөлхийн оноштой мөртлөө ажил эрхлэдэг хүн 1.08 дахин нэмэгдсэн, харин олдмол оноштой мөртлөө ажил эрхлэдэг 0.9 дахин буурсан үзүүлэлтэй байна.

2.8 Хүснэгт: Олдмол оноштой мөртлөө ажил эрхэлдэг ХБИ задаргаа. 2017

	Хөгжлийн бэрхшээлийн төрөл					
	Төрөлхийн	Олдмол		Осол гэмтлээр		
		Өвчнөөр		Зам тээврийн осол	Үйлдвэрийн осол	Ахуйн осол
		Ердийн өвчин	МШӨ			
Баруун бүс	1358	2583	245	42	36	143
Хангайн бүс	1211	2399	191	113	51	274
зүүн бүс	548	891	47	55	19	142
төвийн бүс	1478	2133	102	46	15	193
Улаанбаатар	1546	2881	489	126	147	211

Эх сурвалж: ҮСХ задгай тоон мэдээ

Олдмол оноштой мөртлөө ажил эрхэлдэг ХБИ задалж харвал: Баруун бүсийн хувьд 2560 ХБИ ажил хийдэг ба үүнээс 2583 ердийн өвчин, МШӨ 245, зам тээврийн осолоор 42, үйлдвэрийн осолоор 36, ахуйн осолоор 143 хүн ажил эрхэлдэг. Харин төвийн бүсд 2560 ХБИ ажил хийдэг ба үүнээс 2583 ердийн өвчин, МШӨ 245, зам тээврийн осолоор 42, үйлдвэрийн осолоор 36, ахуйн осолоор 143 хүн ажил мэргэжлээс шалтгаалсан ХБИ ажил эрхэлдэг байна. Дээрх хүснэгтээс харахад зүүн бүсэд ажил мэргэжлээс шалтгаалсан осол гэмтэлтэй ХБИ ажил эрхлэлт нь нөгөө 3 бүсээс харьцангуй бага нь Зүүн бүс. Харин хамгийн их нь хангайн бүс байна

3 Тэтгэврийн насны ХБИ ажил эрхлэлтийн судалгаа



Эх сурвалж: ҮСХ задгай тоон мэдээ
 Дээрх графикаас тэтгэвэрийн насны ХБ иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг харвал 2015 оны байдлаар тэтгэвэрийн насны 2732 ХБ иргэд хөдөлмөр эрхэлж, 2016 онд 2727 болж буурсан. Өмнөх онтойгоо харьцуулахад 1 дахин өссөн үзүүлэлтэй байна. Харин 2017 онд 3018 болж өссөн ба энэ оныг задалж харвал: Хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөр насны **19974** хүн хөдөлмөр эрхэлж байна. Харин хөдөлмөр эрхэлж буй тэтгэвэрийн насны хүн **3018** байгаа юм. Хөдөлмөр эрхэлдэггүй хөгжлийн бэрхшээлтэй хүн **73285** байна.


3.1 Хүснэгт: тэтгэвэрийн ХБИ ажил эрхлэлт, бэрхшээл

он	Бүгд	Эмэгтэй	Хөгжлийн бэрхшээлийн төрөл					
			Төрөлхийн	Олдмол				
				Өвчнөөр		Осол гэмтлээр		
				Ердийн өвчин	МШӨ	Зам тээврийн осол	Үйлдвэрийн осол	Ахуйн осол
2015	2732	1586	929	1483	133	41	32	114
2016	2727	1428	840	1561	133	41	23	129
2017	3018	1712	963	1716	167	35	24	113

Эх сурвалж: ҮСХ задгай тоон мэдээ
 Хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийг бэрхшээлийн төрлөөр харвал 2015 онд 2732 ХБИ ажил эрхлэлт байгаагаас 929 төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 1803 олдмол бэрхшээлтэй иргэд ажил хийж байна. Олдмолийг задлавал: өвчнөөр 1616, осол гэмтлээр 188 байна. Харин 2016 онд 2727 болж өссөн ба 840 төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 1694 олдмол бэрхшээлтэй иргэд ажил хийж байна. Олдмолийг задлавал: өвчнөөр 188, осол гэмтлээр 152 байна. Өмнөх


онтойгоо харьцуулахад ХБИ ажил эрхлэлт өссөн ба хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр хархад бэрхшээлийн төрөл буурсан үзүүлэлтэй байна.

3.2 График: тэтгэвэрийн насны ХБИ ажил эрхлэлт, бүс нутгаар 2015-2017



Эх сурвалж: ҮСХ задгай тоон мэдээ
Тэтгэвэрийн насны Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажил эрхлэлтийг бүс нутгаар харахад Баруун бүсийн хувьд 2015 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 373 хүн ажил эрхлэдэг байсан бол 2017 онд 1255 болж 3.2 дахин өссөн. Хангайн бүсийн хувьд 2015 оны байдлаар тэтгэвэрийн насны хөгжлийн бэрхшээлтэй 444 хүн ажил эрхлэдэг байсан бол 2017 онд 916 болж 1.1 дахин өссөн. Харин төвийн бүс хөгжлийн бэрхшээлтэй 372 хүн ажил эрхлэдэг байсан бол 2017 онд 482 болж 1.29 дахин нэмэгдсэн. 2015-2017 оны интервалыг харахад Баруун бүс, хангайн бүс, зүүн бүс нэмэгдсэн үзүүлэлтэй. Харин төвийн бүс нэмэгдсэн байна. Харин улаанбаатарын хувьд 2015 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 1255 хүн ажил эрхлэдэг байсан бол 2017 онд 887 болж 1.41 дахин буурчээ.


3.3 График: Тэтгэвэрийн насны ХБИ ажил эрхлэлт хүйсээр



Эх сурвалж: ҮСХ задгай тоон мэдээ

Тэтгэвэрийн насны Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг хүйсээр харвал гурван оны интервалыг харахад эмэгтэй хүн ажил эрхлэлтийн байдал эрэгтэй хүнээс 1-1.3 дахин өндөр байгаа нь харагдаж байна. 2015 оны байдлаар тэтгэвэрийн насны эмэгтэй ХБИ 1586 байсан бол эрэгтэй ХБИ 1146 байна. Ерөнхийдөө гурван оныг харвал бүгд өсөх хандлагатай байна.

3.4 График: Тэтгэвэрийн насны ХБИ ажил эрхлэлт, төрөлхийн олдмол



Эх сурвалж: ҮСХ задгай тоон мэдээ 2015 оны байдлаар тэтгэвэрийн насны 2732 хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажил хийдэг ба төрөлхийн оноштой мөртлөө ажил эрхлэдэг 929 хүн, олдмолгоор ХБ болсон 1803 хүн ажил эрхэлдэг байна. Харин 2017 онд байдлаар тэтгэвэрийн насны 3018 хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажил хийдэг ба төрөлхийн оноштой мөртлөө ажил эрхлэдэг 963 хүн, олдмолгоор ХБ болсон 2055 хүн ажил эрхэлдэг байна. Өмнөх онтойгоо харьцуулахад төрөлхийн оноштой мөртлөө ажил эрхлэдэг хүн 1.03 дахин нэмэгдсэн, харин олдмол оноштой мөртлөө ажил эрхлэдэг 1.13 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

3.5 Бүс нутгаар задалж харвал:

	2015		2016	
	Төрөлхийн	Олдмол	Төрөлхийн	Олдмол
Баруун	98	275	94	497
Хангайн	104	340	110	343
Төвийн	72	300	235	280
Зүүн	57	231	313	774
Улаанбаатар	816	1255	303	741

Эх сурвалж: ҮСХ задгай тоон мэдээ

Тэтгэвэрийн насны Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бэрхшээлийн үүслээр хөдөлмөр эрхлэлтийг бүс нутгаар харвал 2015 онд баруун бүсийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажил хийдэг ба төрөлхийн оноштой мөртлөө ажил эрхлэдэг 98 хүн, олдмолоор ХБ болсон 275 хүн ажил эрхэлдэг байна. Харин 2016 оны байдлаар 581 тэтгэвэрийн насны хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажил хийдэг ба төрөлхийн оноштой мөртлөө ажил эрхлэдэг 94 хүн, олдмолоор ХБ болсон 497 хүн ажил эрхэлдэг байна. Өмнөх онтойгоо харьцуулахад төрөлхийн оноштой мөртлөө ажил эрхлэдэг хүн 1.04 дахин буурсан үзүүлэлтэй байна. Харин олдмол оноштой мөртлөө ажил эрхлэдэг 1.9 дахин нэмэгдсэн үзүүлэлтэй байна.

3.6 Хүснэгт: Олдмол оноштой мөртлөө ажил эрхэлдэг тэтгэвэрийн насны ХБИ задаргаа. 2017

	аймаг, нийслэлийн нэр	Бүгд	Эмэгтэй	Хөгжлийн бэрхшээлийн төрөл					
				Төрөлхийн	Олдмол				
					Өвчнөөр		Осол гэмтлээр		
					Ердийн өвчин	МШӨ	Зам тээврийн осол	Үйлдвэрийн осол	Ахуйн осол
Баруун бүс	373	186	98	259	9	1	0	6	0
Хангайн бүс	444	208	104	262	27	20	7	24	0
Төвийн бүс	372	207	72	248	37	6	2	7	0
Зүүн бүс	288	169	57	187	3	1	1	39	0
Улаанбаатар	1255	816	598	527	57	13	22	38	32

Эх сурвалж: ҮСХ задгай тоон мэдээ

Олдмол оноштой мөртлөө ажил эрхэлдэг тэтгэвэрийн насны ХБИ задалж харвал: Баруун бүсийн хувьд 373 тэтгэвэрийн насны ХБИ ажил хийдэг ба үүнээс 27 ердийн өвчин, МШӨ 20, зам тээврийн осолоор 7, үйлдвэрийн осолоор 24 ажил эрхэлдэг. Харин төвийн бүсд 372 ХБИ ажил хийдэг ба үүнээс 37 ердийн өвчин, МШӨ 6, зам тээврийн осолоор 2, үйлдвэрийн осолоор 7 хүн ажил мэргэжлээс шалтгаалсан ХБИ ажил эрхэлдэг байна. Дээрх хүснэгтээс харахад зүүн бүсэд ажил мэргэжлээс шалтгаалсан осол гэмтэлтэй ХБИ ажил эрхлэлт нь нөгөө 3 бүсээс харьцангуй бага нь Зүүн бүс. Харин хамгийн их нь хангайн, төвийн бүс байна.

Ажил олгогч ХБИ аваагүйн улмаас торгуулах мөнгөн дүн

Хөдөлмөрийн хуулийн 111 дүгээр заалтын дагуу төлбөрийн хэмжээг Монгол Улсын засгийн газар 2009 оны 26 дугаар тогтоолоор баталсан.

	Аж ахуй нэгж, байгууллагын ажиллагчдын тоо	50 хүртэлх ажиллагчтай	51-ээс дээш ажиллагчдтай
1	Улаанбаатар, Орхон Дархан	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээн 40%	50%
2	Бусад аймаг		30%

Эх сурвалж: ҮСХ задгай тоон мэдээ

Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 111.6 д аж ахуйн нэгж, байгууллага тогтоосон төлбөрийг 24 сар тасралтгүй төлсөн тохиолдолд дараагийн 12 сард ногдох төлбөрийг чөлөөлнө гэсэн байдаг. 2018 оны хөдөлмөрийн доод хэмжээ нь 240000 мянган төгрөг ба Улаанбаатар, Орхон, Дарханий бүсэд тухайн үйлдвэр 50 хүртэлх ажиллагчтай байвал 96000 мянган төгрөг, 51 ээс дээш ажиллагчдтай байвал 120000 мянган төгрөг, бусад аймаг 72000 мянган төгрөгийг сар тутамд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн санд” төвлөрүүлэнэ.

График: Монгол улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн сан



Эх сурвалж: ХБИ нэгдсэн сан

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

2012 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг авч ажилуулаагүйн улмаас улсад 291,4 сая төгрөг нэгдсэн санд аж ахуйн нэгжээс авсан. Харин 2017 оны байдлаар санд 545,7 сая төгрөгөөр нэмэгдсэн. Суурь онтойгоо харьцуулахад 1.8 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Харин төлбөрийн хэмжээг 2 бүсийн хувьд нэг нэг аймгаар авч үзэхийн бол нэмэгдсэн үзүүлэлтэй байна. 2017 оны торгуулийн мөнгийг задалж харвал:

Үндэсний статистикийн хорооноос 2017 оны мэдээгээр хөгжлийн бэрхшээлтэй хөдөлмөрийн насны 19974 хүн хөдөлмөр эрхэлж байна. Нийслэлийн Мэргэжлийн

ДД	Аймгийн нэр	Байгууллагын нэр	Нийт ажилтны тоо	Ажиллаж буй ХБИ-ний тоо	Ажиллавал зохих ажилтны тоо	ХБ ажилтан авч ажилуулаагүйн төлбөр /өөрөө бодож үзэхэд/
1	Архангай	Төрийн банк	98	2	4	288000
		Хотонт сумын соёлын төв	7	1	0	0
		Мэдээлэл Холбооны Сүлжээ төрийн өмчит ХХК	48	3	2	0
		ЭБЦТС төхк	102	4	4	0
		Хашаат сумын соёлын төв	6	1		0
		Хот тохижилт үйлчилгээний газар	28	2	1	0
	Орхон	Төрийн банк	81	1	3	240000
		Хүүхэд залуучуудын театр	41	2	1	0
		Зх-ний 186-р анги	627	7	25	2160000
		Нийтлэг үйлчилгээний алба	46	2	1	0
		Хот тохижилтын газар	232	5	9	480000
		Эрдэнэт ус дулаан түгээх сүлжээ ТӨХК	320	11	12	120000
		Эрдэнэт булганы цахилгаан түгээх сүлжээ	243	3	9	720000
		Эрдэнэт үйлдвэр	6200	41	248	24840000

хяналтын газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдалд шалгалт хийсэн. Шалгалтад 1281 аж ахуйн нэгж хамрагдсан. Эдгээрээс 487 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг зохих орон тоонд ажиллуулаагүй, ажлын

байрны төлбөрийг төлөөгүй байна. улсын байцаагч 734000000 төгрөгийн төлбөр тавьснаас 119 байгууллага 587 сая төгрөгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн санд төвлөрүүлсэн байна.

Жишээ болгож Архангай, Орхон аймгийн төрийн өмчит газруудаас санамсаргүй түүвэрлэн 8 аж ахуйн нэгж сонгон авч мөнгөн хөрөнгийг тооцож үзлээ.

Архангай аймгийн хувьд “Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1” д заасан хуулийг биелүүлээгүй учир 6 аж ахуйн нэгжээс нийт 288000 төгрөгийг Улсын нэгдсэн санд тушаах мөнгөний хэмжээ. Харин орхон аймгийн хувьд хөдөлмөрийн доод хэмжээг 50%-тай тэнцэх төлбөр авна гэж заасан ба нийт 8 аж ахуй нэгжээс нийт 6204000 төгрөгийг улсын санд төлөх болж байна. 2017 оны нэгдүгээр сарын 25-наас 2017 оны 10 дугаар сарын 01-ний хооронд хийсэн. Шалгалтад нийт 1,281 аж ахуйн нэгж хамрагдсанаас 131 аж ахуйн нэгж, байгууллага нь ажлын байрны төлбөрийг хуулийн дагуу төлж, 794 аж ахуйн нэгж байгууллага 1,908 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг зохих орон тоонд ажиллуулж байна.

Төрийн болон төсвийн байгууллагын дөнгөж 38 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг зохих орон тоонд ажиллуулж байна. Боловсрол, эрүүл мэндийн салбарын байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажилд авдаггүй мөртлөө, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд ч мөнгө төлдөггүй. Яагаад эдгээр иргэдийг авч ажиллуулдаггүй шалтгаанаа өндөр дээд мэргэжилтэй хүмүүсийг авч ажиллуулдаг, төсөвт мөнгө тусгагдаагүй учир хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд мөнгө төвлөрүүлдэггүй, Уг нь Засгийн газрын тогтоолоор хуульд бүгдийг зааж өгсөн.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр

д/д	Арга хэмжээ	2017 оны гүйцэтгэл		
		Хүн	хөрөнгө	хувь
1	Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ	672	44,362.0	81
2	Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах үйлчилгээ	171	7,020.0	13
3	Санхүүгийн дэмжлэг	898	2,053,310.0	98
4	Борлуулалтын дэмжлэг	515	93,914.5	50
5	Ажлын байрны түрээсийн хөнгөлөлт		67,543.5	68
6	Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт	2729	57,657.5	69
7	Хөдөлмөр эрхлэлтийн сургалт	584	144,636.0	83
8	Ажил олгогчийн урамшуурлал	213	81,792.0	36

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

9	Ажил олгогчид санхүүгийн дэмжлэг олгох		677,530.0	60
10	дүн	5782	3,227,764.0	78

Эх сурвалж: ХНХЯ, Жайка

ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дээшлүүлэх зорилгоор ХХҮГ-аас 71 сая төгрөг зарцуулсан баримт байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд 2007 онд 7.5 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн. Харин Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллаж амьдрах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор Улаанбаатар хотын дэд бүтэц, барилга байгууламж, нийтийн тээврийн зогсоол, автобусны үйлчилгээ, явган хүний зам гарц зэрэгт тодорхой стандартыг мөрдүүлэх, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлж, “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үнэмлэх олгох журам, үнэмлэхийн загвар”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам”, “Мэргэжлийн ур чадварын олон улсын тэмцээнд амжилттай оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүнд урамшуулал олгох журам”, “Хөтөч нохойг сургах, ашиглах журам”-ыг баталсан байна. Нийгмийн халамжийн тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж үйлчилгээнд 2017 онд давхардсан тоогоор 227,9 мянган иргэн хамрагдаж нийт 146,9 тэрбум төгрөгийг зарцуулсан бөгөөд Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн хүрээнд 2017 онд Тэтгэврийн даатгалын сангаас 67,9 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 183 тэрбум төгрөгийн, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 4578 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 23,6 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосон байна.

Дүгнэлт

Миний бие 2018 оны 10 сарын 01-ээс 10 сарын 15-ийг дуустал үйлдвэрлэлийн дадлагыг хийж дуусгалаа. Дадлага эхлэхэд өөртөө тавьж байсан зорилгуудаа бүрэн биелүүлсэн. Дадлага удирдсан хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны ажилтан болон хэлтсийн ажилтнуудын өгсөн үүрэг даалгаваруудыг цаг тухайд нь биелүүлж, ямар нэгэн мэдлэг чадвар өөртөө үлдээхийг эрмэлзсэн болно. ХНХЯ яамны газар, хэлтсүүдээс бусад байгууллага руу явуулсан албан бичиг болон түүний стандарттай танилцаж, албан бичгийг төлөвлөж сурсан. Мөн Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1д заасан хуулийн

хэрэгжилт, тайлан боловсруулах судалгааны ажлын тоон мэдээг нэгтгэн судалж, график хүснэгт хийж шинжилгээ хийсэн нь хичээл дээр судалсан мэдлэгээ баттагахад тусалсан. Ажлын байран дээр гараад ажилдаа идэвх санаачлагатай ажиллаж, үргэлж мэргэжлээ дээшлүүлж өөрийгөө хөгжүүлэн өсч дэвших болно. Дадлагын хугацаанд тус яамны явуулж буй үйл ажиллагаа нь миний эзэмшиж буй мэргэжилтэй хэрхэн холбогдож практик дээр ямар үүрэгтэй, хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай ур чадваруудыг эзэмшсэн.

Өнгөрсөн хугацаанд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай болон Хөдөлмөрийн тухай хуулийн хүрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийг шинэчлэн боловсруулж хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг, эхийг хамруулахаар хүрээг өргөжүүлсэн бөгөөд энэхүү хөтөлбөрт 2017 онд 5782 иргэн хамрагдаж 3,2 тэрбум төгрөг зарцуулж, 1144 байнгын, 171 түр ажлын байр бий болжээ. Хөтөлбөрийн үйл ажиллагааг зохион байгуулахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл, төрийн бус байгууллагуудыг оролцуулдаг болсон төдийгүй 2018 онд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-т зарцуулах хөрөнгийг 4.5 тэрбум болгон нэмэгдүүлснээр 6000 иргэн, аж ахуйн нэгж, ТББ-ыг хамруулж 1000-аас доошгүй байнгын, 200-гаас доошгүй түр ажлын байрыг бий болгож, хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт гээд бүхий л үе шатанд иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангаж байна.

Засгийн газраас ХБИ-д хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг хариуцсан хэрэгжүүлэгч агентлаг байгуулах саналыг танилцуулж Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлэх
3. Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг амьжиргааны баталгаажих түвшинд хүргэх асуудлыг хууль тогтоомжид тусган шийдвэрлэх
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх анхдагч мэдээллийн сан байгуулах, эрүүл мэндийн үзлэг зохион байгуулах шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэх
5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах зөвлөлийн бүрэлдэхүүнийг өргөжүүлж, бүх яамны Төрийн нарийн бичгийн дарга, зарим агентлагийн дарга, Нийслэлийн Засаг даргыг оруулах

6. Хүртээмжийн тухай хууль боловсруулж энэ онд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэхээр боллоо.

Яамдын дэд зөвлөлүүдийг:

1. Салбарын хэмжээнд Хөдөлмөрийн тухай хуулийн 111-р зүйлийн хэрэгжилтийн байдлыг судлан, хэрэгжилтийг хангах
2. Салбарын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд төрийн бус байгууллагын оролцоог хангаж, зарим ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэх
3. Салбарын харьяа байгууллагуудын дэд бүтцийн хүртээмжийн байдалд үнэлгээ хийж, энэ онд багтаан стандартад нийцүүлэх
4. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Говьсүмбэр, Өвөрхангай, Дархан-Уул, Говь-Алтай, Завхан аймаг дэд болон салбар зөвлөлөө яаралтай байгуулан, ажлаа тогтмолжуулах, БСШУСЯ, Эрүүл мэндийн яам хууль заасан үүргээ хэрэгжүүлэх талаар санаачилгатай ажиллахыг үүрэг болгох.

Ашигласан материал:

- <http://data.worldbank.org/sites/default/files/wdi - 2014- book.pdf>
- www.1212.mn-Үндэсний статистикийн хороо
- www.zasag.mn- Хөдөлмөр нийгмийн хамгааллын тоо
- Монгол Улсын ХБИ аж байдлын тайлан-2018 он
- Статистикийн эмхтгэл-Үндэсний статистикийн хороо, задгай тоо
- Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны хөдөлмөрийн дотоод журам 2018 он
- жайка олон улсын байгууллагын танилцуулга 2018 он
- ХБИ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль 2018 он
- Хөдөлмөрийн тухай хууль 2011 он
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: бодлого, үйл ажиллагаа
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын статисти-2017 он
- ХБХ эрхийн хэрэгжилт: олон улсын чиг хандлага- хурлын тэмдэглэл

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН СУРЧ БОЛОВСРОХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТЭД ЭЦЭГ, ЭХИЙНХ НЬ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ НӨЛӨӨЛӨХ НЬ

С.Мягмарсүрэн¹

¹МУИС, Хууль зүйн сургууль

Хураангуй

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар хүүхдээ сургахыг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид үүрэг болгосон бөгөөд дэмжлэг болох зорилгоор унааны зардлыг нь Нийгмийн халамжийн газраас жилд нэг удаа 200.000 төгрөг өгдөг нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлж байгаа хэлбэр юм. Гэвч хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн хөдөлмөрлөх эрхийг нь хангах талаас зохицуулалт байхгүй байгаа нь нийгэмд тулгамдаад байгаа нэг асуудал юм.

Төрөхийн хүндрэлээс шалтгаалан тархины саажилттай болж улмаар тулгуур эрхтэний хөгжлийн бэрхшээлтэй болсон намайг Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн оюутан болгох гэж эцэг, эх минь хичнээн олон ажлын саналаас татгалзаж, хичнээн удаа зэмлүүлэн байж ажиллаж, намайг сургуульд минь хүргэж өгсөн бол гэх бодлоос өнөөдрийн энэхүү сэдвийг хөндөхөд хүргэлээ.

Иймд, Хөдөлмөрийн тухай хуульд хөдөлмөр эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхэд хүүхдээ сургууль, цэцэрлэгт нь хүргэж өгөх, авах завсарлагыг нэмж өгөх хэлбэрээр хуульчилж өгөх шаардлагатай байна.

Тус хуулийн шинэчилсэн найруулгын 87.1-т: “ Төрүүлсэн, эсхүл үрчлэн авсан нэг нас хүрээгүй, нэг нас хүрсэн боловч эмнэлгийн магадлагаагаар зайлшгүй асаргаа шаардагдах хүүхэдтэй эх /ганц бие эцэг/-эд амрах, хооллох завсарлага...олгоно.” гэж зааснаас эмнэлгийн магадлагаагаар зайлшгүй асаргаа шаардагдах хүүхэд гэдэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамаарах ч тусгайлан сургууль, цэцэрлэгт хүргэх, авах цагийг нь хуульчилж өгөх нь хуулийн бодитой хэрэгжих нөхцөл болно хэмээн харж байна.

Түлхүүр үг: Хөдөлмөр эрхлэх эрх, сурч боловсрох эрх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эх , хөдөлмөрийн тухай хууль

Удиртгал

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.4, 17 дугаар зүйлийн 17.2-т “Монгол Улсын иргэн ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй”, “Хөдөлмөрлөх нь иргэдийн журамт үүрэг мөн” гэж тус тус хуульчилсан байдаг. Иргэд төрийн албанд эсхүл хувийн хэвшилд аль ч салбарт ялгалгүй хөдөлмөр эрхлэхдээ Үндсэн хуулиар баталгаажсан эрхүүдийг эдэлж оролцдоогоороо бүх салбарт хамаарах нийтлэг эрх юм.

Гэтэл өнөөгийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн хувьд Үндсэн хуулиар баталгаажсан эрхээ эдлэхэд бэрхшээл тулгардаг нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ боловсролтой нэгэн болгох уу, эсвэл хувийн карьерээ хөөж эдийн засгийн баталгаагаа бэхжүүлэн ажил хөдөлмөр эрхлэх үү гэдэг хүндхэн боловч зайлшгүй сонголт гарч ирдэг нь харамсалтай.

Хөдөлмөрийн тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд холбогдох зохицуулалт байх боловч хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй гэр бүлийн гишүүний хөдөлмөр эрхлэлтийн талаарх зохицуулалт байхгүй байгаа нь эрх зүйн хувьд хийдэлтэй байна гэж харж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд “сурч боловсрох эрх” бөгөөд 14.4-т: “Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсрол эзэмшүүлэх сургалтад хамруулах үүрэгтэй бөгөөд энэ үүргээ биелүүлэхэд нь боловсролын байгууллагын болон нийгмийн ажилтан холбогдох мэдээллээр хангах үүрэгтэй.” гэж заасан байдаг.

Харин Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцыг манай улс 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр соёрхон баталсан. Тус конвенцын 23 дугаар зүйлд “Орон байр болон гэр бүлийг хүндэтгэх” тухай зохицуулж өгсөн байдгаас 23.3-т: “Оролцогч улсууд нь гэр бүлийн харилцаанд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тэгш эрхийг хангана. Энэхүү эрхийг хэрэгжүүлэх болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нууцлах, орхих, үл тоомсорлох, хөндийрүүлэхээс урьдчилан сэргийлэхийн тулд оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон тэдний гэр бүлийн гишүүдийг эхнээсээ бүхий л

талын мэдээллээр хангаж, үйлчилгээ болон туслалцаа үзүүлнэ” гэж заасан байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүлд үзүүлэх туслалцаа, үйлчилгээг хангахуйц олон улсын конвенцыг Монгол улс соёрхон баталчихсан хэдий ч дотоодын хууль тогтоомждоо бодитойгоор тусгаж өгөөгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 10.1-т “ Монгол Улс олон улсын эрх зүйн нийтлэг хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна.”, 10.2-т “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.” гэж заасан байдаг. Монгол улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэхийг Үндсэн хуулийн хэмжээнд хуульчилсан явдал бол тус улсын олон улсын нэр хүндийг өндөрт өргөж, тэдгээрээс Монгол улстай харилцан ашигтай, тэгш эрхийн зарчмыг үндэслэн хамтран ажиллах итгэлийг баталгаажуулсан юм.

Иймд, хөгжлийн онцлог бүхий хүүхдийн сургуульд хамрагдах боломжийг амьдрал дээр хэрэгжих боломжтой байдлаар хуульчлах, тухайн хүүхдийн гэр бүлийн гишүүдийн хөдөлмөрлөх эрхлэх эрхийг нь хүртээмжтэйгээр хангах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Судалгааны зорилго

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хөдөлмөрийн тухай хуулийн долдугаар бүлэгт “Эмэгтэй хүний хөдөлмөр”-ийг зохицуулахдаа **Хүүхэд хөхүүлэх, асрах завсарлага нэмж олгох** тухай нарийвчлан тусгасан. Энэ зохицуулалтын нэгэн адил хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульд хамрагдах боломжийг амьдрал дээр хэрэгжих боломжтой байлгахын тулд хүүхдээ цэцэрлэг, сургуульд хүргэж өгч, авах цагийг эцэг, эхэд нь хуулийн хүрээнд зохицуулах боломжтой эсэхийг онолын үндэслэлтэйгээр судлахыг зорилоо.

Судалгааны зорилт

Судалгааны үндсэн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- Монгол Улсын хэмжээнд цэцэрлэг, сургуулийн насны хэдэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгааг тодорхойлох, түүнээс хэдэн хувь нь боловсролд хамрагдаж чадаж байгааг гаргаж ирэх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхэд холбогдох эрх зүйн хэм, хэмжээнүүдийг судлан үзэх, тухайлбал Хөдөлмөрийн тухай хуулийн хүрээнд авч үзэх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхэд хүүхдэдээ боловсрол олгохын тулд цэцэрлэг, сургуульд хүргэж өгч, авах цагийг нь холбогдох хуулийнх нь хүрээнд нь зохицуулалт оруулж ирэх тухай саналыг дэвшүүлэх

Судалгааны арга зүй


Судалгааны зорилгын хүрээнд ажиглалт, харьцуулалтын арга болон мэдээлэл цуглуулах аргуудыг ашиглан холбогдох хууль тогтоомжийн хүрээнд авч үзсэн.

Судалгааны үр дүн, шүүн хэлэлцэхүй

Улсын хэмжээнд 2018-2019 оны хичээлийн жилийн статистик мэдээллээр хөгжлийн бэрхшээлтэй 1087 хүүхэд цэцэрлэгт, 6518 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд тус тус суралцаж байна. Харин 2019-2020 оны буюу энэ хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд 6,053 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын “Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн статистик, тоо баримт 2019”-аас харахад 0-16 насны цэцэрлэг, сургуульд хамрагдах насны 10,857 хүүхэд байдгаас ердөө 7605 хүүхэд л сургууль, цэцэрлэгт хамрагдаж чадаж байгаа нь нийт суралцагчдын 0.9 хувийг эзэлж байна. 2019-2020 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд 6.1 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байгаа нь 2010-2011 оны хичээлийн жилээс 12.2 мянга (66.9 %)-иар буурсан байна. (Зураг 1-т)

Зураг 1. Ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, 2010-2019 он

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”



Боловсрол нь хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй гэр бүлийн ядуурлын гинжин холбоог таслах хамгийн чухал хүчин зүйл болдог. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй иргэд бусдын адил нийгэмд өөрийн хувь нэмрээ оруулж хөдөлмөрлөх түүний үндсэн дээр сайхан амьдрах, өөрийн эрх, ашиг сонирхлыг зөрчигдөхөөс сэргийлэх эрх зүйн мэдлэгийг олж авах гол хүчин зүйл нь боловсрол, эрдэм мэдлэг юм. Иймд боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн хувийн ялгаатай байдал, хэрэгцээнд нь тулгуурлан боловсрол эзэмшүүлэх, хуульчилсан эрхийг нь хамгаалах нь манай нийгмийн тулгамдаад байгаа асуудлын нэгд тооцогдож байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах эрхийг нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх зааварт тус тус хуульчилж өгсөн байдаг. Дээрх хуулиудын зохицуулалтыг судлан үзэхэд, хөгжлийн бэрхшээлтэй суралцагч гэх ойлголтыг оруулж, сургуулийн орчинд хэрхэн тэгш, хүртээмжтэй боловсрол олгох талаас нь түгээмэл авч үзсэн. Харин сургууль, цэцэрлэгтээ ирж, очих боломжийг хангах талаар ХБХЭТХ-н 26 дугаар зүйлийн 26.1.5-д: хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн цэцэрлэг, сургуульд ирж,

очих унааны зардлыг хөнгөлөх, эсхүл автобусаар үйлчлэх гэж хуульчилж өгсөн.

Гэвч өнөөдрийн амьдралд тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд цэцэрлэг, сургуульд хамрагдахад нэн тэргүүний асуудал бол гэр бүлийн амьжиргааны байдалтай салшгүй холбоотой бөгөөд тэдний гэр бүлийг дэмжин ажиллах хуулийн зохицуулалт хангалтгүй байна.

ХБХЭтХ-д боловсрол эзэмшүүлэх сургалтад хамруулах нь эцэг эхийн үүрэг хэмээн хуульчилж өгсөн байдгаас тухайн хүүхдийн эцэг, эхийн аль нэг эсвэл хоёулаа (тухайн хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээс шалтгаалан) хүүхдээ ядаж л сургууль, цэцэрлэгт нь хүргэж өгөх үүрэгтэй гэдэг нь харагдаж байна. Хуульдаа ийнхүү хуульчлахдаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн Үндсэн хуулиар баталгаажсан “хөдөлмөрлөх эрх”-ийг харгалзан үзээгүй нь хууль зүйн техник талаас хоорондоо уялдаа холбоогүй байдлыг бий болгосон байна.

Хөдөлмөрийн тухай хууль дах төсөөтэй зохицуулалт

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хөдөлмөрийн тухай хуулийн 103 дугаар зүйлд тухайн эмэгтэй ажилчин хүүхдээ хөхүүлэх, асрах завсарлага нэмж олгохоор хуульчилсан байна. Тус зохицуулалтыг хууль тогтоогч хүүхдийн хэвийн өсөлт, ээжийнх нь тогтвортойгоор ажиллах нөхцөлийг нь хангах талаас нь үзэл баримтлалаа боловсруулж хуульчилсан. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд мөн дээрх зохицуулалт агуулгын хувьд хэвээр тусгагдсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ сургууль, цэцэрлэгт нь хүргэж өгч, авах цагийг нь холбогдох хуульд нь ийм байдлаар хуульчлах боломжтой хэмээн үзэж байна.

Дүгнэлт

Хөдөлмөрийн тухай хуульд хөдөлмөр эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхэд хүүхдээ сургууль, цэцэрлэгт нь хүргэж өгөх, авах завсарлагыг нэмж өгөх хэлбэрээр хуульчилж өгснөөр сургууль, цэцэрлэгт хамрагдах хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нэмэгдэх боломжтой юм

Ном зүй

1. Г.Совд нар Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, УБ 2000 он
2. Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яам, “Жайка” Олон улсын хамтын ажиллагааны байгууллага, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа: Мэдээллийн лавлах, УБ, 2019 он
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар “Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн статистик, тоо баримт 2019”, УБ, 2020 он
4. Боловсрол, шинжлэх ухааны яам “Бага, дунд боловсролын салбарын 2019-2020 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийн товч танилцуулга”, УБ, 2020 он
5. Candace Kaye нар “Тусгай хэрэгцээт боловсролын үндэс”, УБ, 2018 он
6. Л.Баасан “Хөдөлмөрийн эрх зүй Ерөнхий анги”, УБ, 2000 он

Хууль, олон улсын конвенц

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Хөдөлмөрийн тухай хууль
3. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль
5. Боловсролын тухай хууль
6. Бага, дунд боловсролын тухай хууль
7. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр
8. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар
9. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭДТЭЙ ЭХЧҮҮДИЙН СЭТГЭЛ ГУТРАЛЫГ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛТАЙ ХОЛБОН СУДАЛСАН НЬ

Р.Энхчулуун¹
¹Марал-Элч сан

Хураангуй

Монгол улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эхчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудалыг судлах нь нийгмийн өмнө тулгамдсан асуудал бөгөөд өнөөгийн байдлаар 10,000 гаруй эхчүүд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ байнга асрах шаардлагын улмаас ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа бөгөөд энэ нь нийт монгол улсын хүн амын 3.85 хувь нь билээ

Энэхүү судалгааны зорилго нь энэ бүлгийн төлөөлөл болох 0,7 хувийг судлан урьдчилсан байдлаар тоон баримтанд дүн шинжилгээ хийхэд оршино. Тус зорилгын хүрээнд эхчүүдийн сэтгэцийн эрүүл мэндийн асуудлыг судлаж байсан судалгаануудтай танилцаж, судалгааны төлөвлөлт, судлагааны арга зэргээ тодорхойлж, зр дүнд тоон болон чанарын боловсруулалт хийж ажиллах, мөн дүгнэлт санал, зөвлөмж зэргийг дэвшүүлэх зорилтуудыг тавьсан билээ.

Судалгаандаа нас гэр бүлийн байдал өрх толгойлсон эсэх статусын ялгаатай байдал нь сэтгэцийн эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлс болдог эсэхийг судлахаас гадна хүнд хэлбэрийн бэрхшээлтэй хүүхдээ байнга асран ажил хөдөлмөр эрхлэхгүй байх нь өөр нэг нөлөөлөх хүчин зүйлс болдог байж болох юм гэсэн таамаглалыг дэвшүүлж ажилласан

Түлхүүр үг: сэтгэцийн эрүүл мэнд, байнгын асаргаатай хүүхэд, нийгмийн хамгаалал, амьжиргааны түвшин, эхчүүд

Үндэслэл

Монгол улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй орлого багатай айл өрхийн эмэгтэйчүүд болон өрх толгойлсон эмэгтэйчүүд, тэдний хүүхдүүдийн аж байдал өнөөдөр маш том тулгамдсан асуудал болсон. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүлүүдийн амьжиргааны түвшин, ажил эрхлэлт, өрхийн орлого өнөөдөр монгол улсад мөрдөгдөж буй хөдөлмөрийн хөлсний болон амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур байна. Эрх баригчид хэрэв энэ тал дээр анхааралтай хандаж ирсэнсэн бол хэдэн жилийн дотор шийдчихэж болох асуудал. Гэтэл удаа дараагийн их хурал олон засгийн газар хэд хэдэн удаа солигдсон ч энэ асуудалд анхаарал хандуулж дорвитой арга хэмжээ авсангүй өнөөг хүрлээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд төрүүлсэн эмэгтэйн амьжиргааны түвшний бууралт, ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа асуудал ядуурал нь тухайн хүний асуудал мэт боловч нь эцсийн бүлэгт нийгэм-эдийн засгийн асуудал болж таарна.

Энэ бүлгийн эмэгтэйчүүдийн амьдралын чанар буурч ядуурал ажилгүйдэлд өртөж байгаа нь энэ бүлэгт хамгийн их асуудал байна гэсэн үг. Эмэгтэй хүн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд төрүүлснээсээ эхлэн хүүхдээ байнга асрах шаардлагын улмаас ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй болж тухайн өрхийн орлого 50 хувь ба хэрэв эмэгтэй өрх толгойлсон ээж бол 100 хувь өрхийн орлого буурахад хүрдэг. Монгол улсын засгийн газраас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эхчүүдэд олгодог халамжийн тэтгэмж сард (2020 оны 4 сарын байдлаар) 123,000 төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амьжиргааг дэмжиж олгодог тэтгэмж 188,000 төгрөг нийтдээ 311,000 төгрөг байна. Энэ хэмжээний мөнгөөр тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүл ялангуяа өрх толгойлсон эхтэй гэр бүл амьжиргаагаа залгуулахад туйлын хүндрэлтэй. Ийм нөхцөлд тухайн гэр бүлийн хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, хоол хүнсний хангамжийн авах талаар ярихад хүнд юм. Өнөөгийн байдлаар улсын хэмжээнд байнгын асаргаатай хүүхдээ асардаг 10,000 гаруй эх байна. Эдгээр эхчүүдэд юу юунаас илүү өрхийн орлогоо нэмэгдүүлэх шаардлага нэн тэргүүнд тулгарч байна.

Эмэгтэйчүүд санхүүгийн хувьд бие даасан цагт өөрсдийнхөө амьдралыг хянан удирдах эрх мэдэл нь нэмэгддэг. Ингэснээр ядууралд өртсөн эмэгтэйчүүд тухайн нөхцөл байдлаас зугтах боломжтой болдог.

Хүүхдээ төрүүлсэн цагаасаа эхлэн хуучин ажлаа хийх мэргэжлээрээ ажиллах боломжгүй болсон эхчүүд маань хүүхдээ асрахын хажуугаар гэртээ өрхийн бичил бизнес, жижиг үйлдвэрлэл эрхлэх сонирхолтой, зарим эхчүүд маань гэртээ гар урлал хийх гэх мэтээр өрхийн орлогоо нэмэгдүүлэхээр хичээж байгаа боловч стартап бизнесийн мэдлэг сул зах зээлд өрсөлдөх чадвар дутмаг тул төдийлэн амжилт олж чадахгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд төрүүлсэн цагнаасаа эхлэн нийгмийн хамгааллын гадна үлддэг. Үүнд эрүүл мэнд нийгмийн даатгал төлөх боломжгүй болсноос эх эмнэлгийн тусламж авах гэнэт өвдөх зэрэгт хувийн хэвшилд хандах эсвэл огт үзүүлэлгүй олон жилээр явах зэргээр эрсдэлт байдалд ордог. НДШ төлдөггүйн улмаас тэтгэвэрт гарах, тэтгэвэр авах эрх үүсдэггүй.

Судалгааны арга

Энэхүү ажлаа шинж тэмдгийн 20 асуулгаар хэмжсэн бөгөөд сэтгэл гутралыг илрүүлэх ухамсаргүйгээр бөглөх проектив асуулгаар эхчүүдийн

сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг тодруулах бөгөөд статистик тоон боловсруулалтын тоон мэдээлэлд чанарын дүгнэлт гаргах замаар гүйцэтгэсэн. Эрүүл мэндийг тодорхойлогч хүчин зүйлсд нас хүйс гэх мэт хувь хүний биологийн үзүүлэлтүүд эрүүл мэндийн хүчин зүйлээс гадна мэргэжил, боловсролын түвшин, ажил эрхэлж буй эсэх, цалин хөлс өрхийн орлого амьжиргааны түвшин зэрэг нийгэм эдийн засгийн хүчин зүйлийн үзүүлэлтүүд нэн чухал нөлөөтэй болох нь харагдаж байна.

Сэтгэцийн эрүүл мэндийн тэгш бус байдалд ороход орлогын тэгш бус байдал болон нийгэм эдийн засгийн бусад тэгш бус байдлууд шууд нөлөөлөх нь зүйн хэрэг юм.

Судалгааны үр дүн

Судалгаанд оролцсон эхчүүдийн 42,7 хувь нь сэтгэл гутралын эмгэгтэй байгаа нь тогтоогдлоо.

Үүнээс 36,4 хувь нь хөнгөн хэлбэрийн депресстэй, 5,49 хувь нь дундаж түвшний депресстэй, 0,81 нь тодорхой түвшний депресстэй байна.

Ажил эрхэлдэггүй болон өрх толгойлсон эхчүүдийн депрессийн түвшин гэр бүлтэй болон ажил эрхэлдэг эхчүүдийнхээс илүү өндөр байна.

Судалгаанд оролцсон эхчүүдэд ядрах, сульдах, хоолны дуршил буурах, бухимдуу уцаартай болох, өөрийгөө дорд үзэх, уйтгарлах, зүрх дэлсэх, санаа зовох түгших ирээдүйд итгэлгүй болох шинж тэмдгүүд илэрч байна.

Судалгаанд оролцсон эхчүүдээс насны байдлаар авч үзвэл 18-25 насны 2,9 хувь, 26-35 насны 56,5 хувь, 35-45 насны 37,7 хувь, 45-аас дээш насны 3,1 хувь байна. 79,9 хувь нь гэр бүлтэй, 21,1 хувь нь өрх толгойлсон эх байна.


Нийт эхчүүдийн 75,4 хувь нь ажил эрхэлдэггүй ба 24,6 хувь нь ямар нэг байдлаар ажил хөдөлмөр эрхэлдэг байна. 18-25 насны ээжүүд дунд ажил хөдөлмөр эрхэлдэг хүн байхгүй байна. 26-35 насны эхчүүдийн 12,96 хувь нь, 35-45 насны эхчүүдийн 11,52 хувь нь ажил эрхэлдэг байна.

Хүнд хэлбэрийн бэрхшээлтэй хүүхдээ байнга асран ажил хөдөлмөр эрхлэхгүй байх, өрх толгойлсон ганц бие эх байх нь сэтгэцийн эрүүл мэндэд хүчин зүйлс болдог байж болох юм гэсэн таамаглал батлагдсан.

График 1. Эхчүүдийн депрессийн түвшин



График 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эхчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал



Дүгнэлт

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эхчүүдийн эдийн засгийн бие даасан байдал, чадавхийг эрс нэмэгдүүлэх хэрэгтэй байна.
2. Байнгын асаргаатай хүүхдээ асарч байгаа эхчүүдийн нийгмийн хамгааллыг эрс сайжруулах шаардлагатай байна
3. Байнгын асаргаатай хүүхдээ асардаг эхчүүдийн эрүүл мэнд НДШ-ийг төрөөс төлдөг болох арга хэмжээг зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Ном зүй

Эрдэнэбаяр Л. (2014) Сэтгэц судлал, Улаанбаатар

Бямбасүрэн С. (2019) Сэтгэцийн эмгэг судлал, Улаанбаатар

Цагаанхүү Г, Д. Ц. (2014). Мэдрэл судлал, Улаанбаатар.

Сэтгэцийн ба төрх үйлийн эмгэгүүдийн ангилал, эмнэлзүйн тодорхойлолт ба оношлолтын заавар. (2004). Өвчний олон улсын Х ангилал , Улаанбаатар.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАРГҮЙ ИРГЭД МӨН ҮҮ?

Б.Энхням

Хураангуй

2018 оны байдлаар дэлхийн хүн ам 7,7 тэр бум хүрсэн ба нэг тэр бум гаруй хүн буюу 8 хүн тутмын нэг нь хөгжлийн бэрхшээлтэй байна. Тухайлбал АНУ Австрали, Англи улсуудын тайланд тусгагдсанаар бие эрхтний бэрхшээлтэй хүн амд эзлэх хувь нь 18 хувь байгаа бөгөөд , дэлхийд хүн амын тоогоор дээгүүр эзэлдэг Энэтхэг улсын хувьд Камбож болон Непал улсын адилаар хүн амын 3 хувь хүртэл хүмүүс нь бие эрхтний бэрхшээлтэй байна гэж мэдээлжээ. Энэ нь зарим орнуудад мэдээлэл, тоон өгөгдөл дутмаг байгаагаас үзүүлэлт бодит байдлаас бага гарч байгаа бөгөөд бие эрхтний бэрхшээлтэй хүний тоо 1 тэрбумаас хол давсан байх магадлалтай ба цаашид ч бас нэмэгдэх хандлагатай байна. Тиймээс эдгээр иргэдийг бусдын адил нийгэмд эрх тэгш бүрэн бүрэн оролцох эрхийг нь хангах нь чухал юм.

Монгол улсын үндсэн хуулийн 16.2 т зааснаар Монгол улсын иргэн ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй гэж хуульчилсан байдаг ба үндсэн хуулийн дагуу хүн бүр хөдөлмөр эрхлэх эрхтэй. Гэтэл өнөөгийн нийгэмд бие эрхтний бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх боломж хангалттай биш байна.

Түлхүүр үг: Хөдөлмөрийн чадвар алдалт ба хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний нийгмийн оролцоо

Судалгаа хийх болсон шаардлага шалтгаан

Яагаад бие эрхтний бэрхшээлтэй иргэдийн 80-аас дээш хувь нь боловсролын төвшин болоод амьдралын чанар нь дундаас доогуур төвшинд байна.

Судалгааны зорилго

Энэхүү судалгааны зорилго нь Эмнэлэг Хөдөлмөр Магадлах комиссын хөдөлмөрийн чадвар алдалт болон хөдөлмөрийн чадвар алдалтын хувь нь тухайн иргэний сэтгэл зүйд болон амьдралын чанар болон гадаад орчинд

хэрхэн нөлөөлж байгаа талаарх бодит мэдээлэлтэй болж цаашид авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлох.

Судалгааны арга зүй

Бодит Кэйс

ХБИ –тэй фокус бүлгийн ярилцлагын арга


Хууль эрх зүй, бодлогын баримт бичгүүд уншиж судалсан

Иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллүүдтэй уулзаж ярилцсан

Ажил олгогч эзэдтэй уулзаж ярилцсан

Өнөөгийн байдал

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тодорхойлолт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульдаа “Хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие мах-бодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хэлнэ”



Бие эрхтний бэрхшээл + орчин = хөгжлийн бэрхшээл

гэж тодорхойлсон байдаг гэтэл бид ХБИ тоон судалгааг ЭХМК-оос авдаг комиссын шийдвэр ХБИ-г хөдөлмөрийн чадвар алдсан гэдгээр нь тодорхойлдог тул тоон судалгаа зөрөөтөөтэй гарах магадлал өндөр . Тоон судалгаа зөрөөтэй гарснаар цаашид авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа болон болдогт сөргөөр нөлөөлөөд зогсохгүй үр дүнгүй зардал болж хувирдаг.

Мөн ХБИ-н бухимдлыг төрүүлсээр байна. Монгол улс ХБИ тоон судалгааг гаргахдаа зөвхөн Төв ЭХМК -н нэгдсэн дүгнэлт болон тоон судалгааг хардаг. Энэ буруу гэсэн үг биш гэхдээ энэ комиссоор ороогүй ХБИ бас байдаг мөн түр хугацаанд өвдсөн хүн ХБИ гэж тодорхойлох нь зөв эсэх их эргэлзээтэй юм.

Case study 1: Иргэн Д 47 настай, 4-4-д заалтаар хугацаагүй 100% Хөдөлмөрийн чадвараа алдсан гэсэн дүгнэлттэй. Гэхдээ ажил хийдэг бас давхар асаргаанд байдаг. Гэтэл дарга нь эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын журмын 1,5,1 заалтыг үндэслээд чи хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан тул ажил хийх чадваргүй гэж үзээд ажлаас чөлөөлөх шийдвэр гаргах санал оруулсан. Гэтэл энэ хүн өөрөө өөрийнхөө хувийн асуудлаа шийдээд ажлаа гүйцэтгэл өндөр хийгээд явж байгаа. Цаашид ч ажлаа хийгээд явах хүсэлтэй байгаа.

Case study 2: Иргэн Н 40 настай хөдөлмөрийн чадвар алдалт 90% хугацаагүй. үндсэн мэргэжил нь авто засварчин осолд ороод 2 хөлөө тайруулаад гэртээ 4-5 жил байж байгаад өөрийн хоббигоо хөгжүүлэн одоо хөгжимчин болоод нийгмийн амьдралд идэвхтэй оролцоод өөрийн амьдралын чадамжаа дээшлүүлээд явж байгаа. Энэ хүний хувьд бол өөрөө өөртөө хөдөлмөрийн нөхөн сэргээлт хийж чадсан байна. Харин чадаагүй хэдэн хүн байгаа бол?

Case study 3: Иргэн Б 45 настай хөдөлмөрийн чадвар алдалт 100% хугацаагүй. Хүүхэд байхаас хараа нь бага багаар муудсаар хараагүй болсон. Байнгын ажилтай. ХАОАТатвараас чөлөөлөгдөх гээд хариа дүүргийнхээ татварын хэлтэс дээр очтол ЭХМК-н акт дээр нь төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй гэж бичигдээгүйн улмаас татвараас чөлөөлөгдөж чадаагүй. Энэ нь манай хууль тогтоомжууд хоорондоо уялдаа холбоогүй байгааг харуулж байна.

Судалгааны үр дүн:

Мөн бие эрхтний бэрхшээлтэй иргэдийг нийтэд нь хамруулаад хөдөлмөрийн чадвар алдалттай иргэн эсвэл хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэж дүгнэх нь тохиромжгүй бөгөөд нь эргээд сөрөг тал ихтэй байна. Судалгаанд нийт 80-н бие эрхтний бэрхшээлтэй иргэн хамрагдсанаас 65 % нь ажил хийж чадахгүй гэж боддог ба хүсэлгүй иргэд байсан.

Жишээ нь: ярилцлагын шатны санал асуулгад өөрийгөө ажил хийж чадахгүй гэж боддог, ажил хийснээс гэртээ байх нь илүү дээр гэж үздэг, туршиж үзээд бүтэлгүйтсэн, ажил олгогч эздийн буруу ойлголт, өөрсдийн боловсролын төвшин туу эдгээрээс болоод хөдөлмөр эрхлэлт доогуур байгааг олж харсан.

Дүгнэлт

1. БЗД нийт хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан (70%-100%) иргэд нийт 4226 иргэн байгаагаас 345 хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан иргэн ажил хөдөлмөр эрхэлж байна. Мөн БЗД –н хүн амтай ойролцоо дүүрэг болох СХД хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан 248 иргэн ажил хийж байна. Үүнээс үзэхэд хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан иргэд ч бас хөдөлмөр эрхэлж болж байгааг харуулж байна.
2. Хөдөлмөрийн чадвар алдалттай иргэн гэж тодорхойлох нь бие эрхтний бэрхшээлтэй иргэдийг нийгмийн зүгээс сөргөөр хүлээж авахад хүргээд байна. Энэ нь эргээд тэдгээр иргэдийн өөртөө итгэх итгэл болон амьдралын чанарт сөргөөр нөлөөлж байна
3. Аливаа хууль эрх зүйн акт , тогтоол шийдвэрүүдийн хоорондох зөрүү болон үр дагавар нь бие эрхтний бэрхшээлтэй иргэнд ямар бэрхшээл болж байгаа тухай бодит жишээн дээр олж харлаа.
4. Дээрх асуудлыг шийдвэрлэх арга замыг ICF ангиллаас эрэлхийлэх нь зүйтэй.

Ном зүй:

1. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам болон засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын гаргасан “Хөгжлийн бэрхшээл судлал нь салбар дундын шинжлэх ухаан “ сэдэвт ном.
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүний эрхийн тухай хууль
3. Монгол улсын үндсэн хууль
4. Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын дүрэм, журам
5. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, JICA klky улсын хамтын ажиллагааны байгууллага “ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал, Бодлого үйл ажиллагаа” мэдээллийн лавлах 2017.
6. International Classification of Functioning, Disability and Health (ICF)
7. НҮБ, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай конвенц.
8. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ТОХИРОХ АЖЛЫН БАЙРУУДЫГ ҮҮСГЭХЭД ХОРШООЛЛЫН ХӨДӨЛГӨӨНИЙГ АШИГЛАХ НЬ

Л.Дансранбавуу¹, Ж.Гантулга²

^{1,2} Докторант, Мандах Их Сургууль

Хураангуй

Дэлхий нийтээр улам бүр даяарчлагдаж, энэхүү даяарчлал нь улс орнуудад хөгжиж дэвших илүү их боломжийг олгож байна. Гэтэл, нөгөө талдаа өрсөлдөх чадвар багатай, хамтарч ажиллаж чадаагүй хүмүүс нь зөвхөн өөрийн улс дотроос ч бус, дэлхий нийтээс ирэх өрсөлдөөнд нэрвэгдэж мэдэх нөхцөл байдал үүслээ. Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд хамтарч хүчээ нэгтгэх нь жирийн иргэдтэй өрсөлдөх, тэднээс давж гарч илүү амжилттай амьдрах гол нөхцөл юм гэсэн урьдчилсан таамаглалын үндсэн дээр энэ судалгааг эхлүүлсэн.

Япон зэрэг өндөр хөгжилтэй улсуудад ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар авч хэрэгжүүлсэн аргад хоршооллын хөдөлгөөн ашиглагдсан, энэхүү судалгааны үр дүнд ХБИ-ийн дундах ажилгүйдлийн түвшнийг бууруулахад хоршоодын тоо шууд нөлөөлж байсан дүгнэлт зэргээс ХБИ-ийн дунд хоршооллын хөдөлгөөнийг эрчимжүүлэх замаар, тэдэнд тохирсон ажлын байруудыг үүсгэхэд өөрсдийнх нь оролцоотойгоор шийдэх, эдийн засаг, оюун санааны хамтын ажиллагааг дэмжих нь өнөөгийн нийгэмд тулгамдсан асуудал болоод байна гэж үзсэн.

Түлхүүр үгс: Хоршоо, хувь нийлүүлсэн хөрөнгө, гишүүн, ажилгүйдэл, хувьсагч

1. Оршил

Монгол Улсын бодит дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) зах зээлийн эдийн засагт шилжсэний дөнгөж дараахан буюу 1991 онд 8.7 хувиар, 1992 онд 9.3 хувиар, 1993 онд 3.2 хувиар унасан ч гэлээ түүнээс хойш 2009 он хүртэл 15 жил дараалан тогтмол өсөж ирсэн байдаг. Харин 2007 оны дунд үеэс эхэлсэн, дэлхий нийтийг хамарсан санхүүгийн хямрал нь АНУ-ын орон сууцны үнийн хэт хөөсрөлтийг хагалж, дэлхийн II дайнаас хойших сүүлийн 60 жилд тохиолдоогүйгээр улсуудын эдийн засгийг бууруулсан (Verick & Islam, 2010). Энэхүү хямрал нь Монгол Улсын нийт экспортын 80-90 хувийг дангаараа эзэлдэг эрдэс түүхий эдийн гадаад эрэлт болон дундаж үнийг огцом бууруулсны улмаас эдийн засгийн бодит өсөлтийг 2009 онд 1.3 хувиар буурчээ. Эдгээр 4 жилийг эс тооцвол 1991 оноос хойш 2019 он хүртэлх бусад 25 жилийн хугацаанд бодит

эдийн засаг 1.1-17.3 хувийн хооронд, дунджаар жилд 4.5 хувиар өсөж ирсэн байна.

Харин 1995-2011 оны хооронд буюу шилжилтийн эдийн засгийн үед 33.7-38.8 хувьтай байсан ядуурлын хамралтын хүрээ 2014 онд 21.6 хувь болж буурсан ч гэлээ 2018 оны байдлаар эргээд 28.4 хувь болж өслөө (ҮСГ, 2018). Аливаа улсын Засгийн Газрын хамгийн гол үүрэг бол нэг хүнд ноогдох бодит ДНБ, үндэсний орлогын хэмжээг өсгөхөд гол анхаарлаа хандуулж, төрийн бодлогоо боловсруулж, ард иргэдийнхээ амьжиргааны түвшнийг дээшлүүлэх явдал байдаг. Гэтэл 1991-2019 оны хооронд жил бүр дунджаар 4.7 хувиар өссөн ДНБ-ий бодит өсөлт иргэдийн амьдралд хүртээмжтэйгээр нөлөөлөхгүй байна. Нийгмийн баян, ядуу хэсгийн хоорондын ялгаа улам нэмэгдэж байгаагаас үүнийг харж болно. Тухайлбал, 2015 онд НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн хийсэн судалгаагаар Монгол Улсын хүн амын 21.6 хувь нь нэн ядуу, 42.0 хувь нь бага орлоготой, 36.1 хувь нь дундаж давхаргад хамаарч, зөвхөн 0.3 хувийг баячууд эзэлдэг гэсэн дүгнэлт гарчээ (Dolgion, Nyambayar, & Dolgorsuren, 2015).

Дээрх байдлаас харахад сүүлийн 30-аад жилийн төрийн бодлого нь баян ядуугийн ялгааг улам бүр ихэсгэх, нийт иргэдийн дундах ажил хөдөлмөр эрхлэх сонирхлыг бууруулах, халамжийг хавтгайруулан олгох буруу чиглэлээр явж ирлээ. Энэ бүх байдлыг засаж залруулах, иргэд, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй иргэд (ХБИ) нь бүх бурууг бусад руу, ялангуяа төрийн буруу бодлого руу өгөлгүйгээр, үг, үйлдлээ үнэ цэнэтэй болгох, өөрсдийнхөө санхүүгийн чадавхыг өөрсдөө дээшлүүлэх цорын ганц арга зам нь хамтарч ажиллах, дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн хоршооллын хөдөлгөөнийг ашиглах явдал юм гэсэн урьдчилсан таамаглалын үндсэн дээр энэхүү судалгааг хийлээ.

2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх нь

Сүүлийн жилүүдэд, ХБИ гэж хэн болохыг болон тэдэнд хүндрэлтэй байдаг асуудлуудыг илүүтэй таньж мэдэх, аж ахуйн нэгжүүд, хувь хүмүүс нь тэдэнд ээлтэй байдлаар үйлдлүүдээ хийх, өөрийн боломжоор бусдад туслах, тусламж шаардлагатай хүмүүст боломжийг нээж өгөх зэрэг ойлголтууд түгээмэл болж байна.

2016 онд батлагдсан Монгол Улсын “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль”-д “Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хэлнэ” гэж тодорхойлсон байдаг (УИХ, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, 2016).

Хуулийн дээрх тодорхойлолтоос харахад ХБИ-ийг бусадтай эн тэнцүү өрсөлдөх боломжоор ямар нэгэн байдлаар хязгаарлагдсан гэж үзэж байна. Гэхдээ ингэж өрсөлдөх нь огт боломжгүй гэсэн үг биш. Жирийн иргэдтэй эн тэнцүү өрсөлдөх, тэднээс илүү их баялгийг нийгэмдээ бүтээх, өөрсдийнхөө амьдралын нөхцөлийг сайжруулах, бусдад боломжийг нээж өгөх боломж нь ХБИ-д ч гэсэн байна. Ингэж амжилттай ажиллаж амьдрах нь ХБИ маань өөр хоорондоо хэрхэн хамтарч ажиллахаас эхэлнэ. Хамтарч ажилласнаараа тэд өөрсдийн бодит нөхцөл байдал, боломж, сайтар хийж чадах зүйлсээ зөв таньж мэдэх, нийгмийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцэх эрэлттэй бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох замаар бусдад хэрэгтэй байж чадна.

Мөн “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль”-д “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах, тохирох хэрэглэгдэхүүн бүхий ажлын байр бий болгохыг урамшуулах”, хөгжлийн бэрхшээлтэй иргэний сурч боловсрох нөхцөлийг хангах, мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх зэрэг олон зүйл заалт тусгагдсан боловч төдийлөн үр дүнгээ өгөхгүй байна.

Тиймээс эдгээр бүхий л эерэг зүйл заалтыг ажил хэрэг болгохын тулд Засгийн газар, орон нутгийн засаг захиргаа, төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд хуулийн зүйл заалтуудыг болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй хамтран ажиллахын давуу талуудыг илүү томруунаар таниулах, тэднийг уриалах, ХБИ-ийн зүгээс хариу боломжит туслалцааг үзүүлэх үүднээс эхний ээлжид ХБИ маань өөрсдөө хамтран ажиллаж, бодит үйлдэл хийж эхлэх шаардлага байна. Хамтран ажиллахдаа ашгийн бус хэлбэрээр буюу төрийн бус байгууллага(ТББ)-

ын хэлбэрээр ажиллах нь ХБИ-ийн амьдрал ахуйд төдийлөн тустай биш байгааг сүүлийн жилүүдэд бид харлаа. Тиймээс хамтын ажиллагааг ашгийн төлөөх зохион байгуулалтад оруулах буюу хоршооллын хөдөлгөөнийг ашиглах нь ТББ-ын зохион байгуулалтын хамтаар, зэрэгцээ байдлаар ажиллаж чадах үр дүнтэй шийдэл байж болох юм.

2.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийцтэй хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх аргууд

Улс орны эдийн засгийн өсөлтийг хангах, нэг хүнд ногдох үндэсний орлого, ДНБ-ий үйлдвэрлэлийг өсгөхөд эдийн засагт идэвхтэй оролцож байгаа хөдөлмөрийн оролцоог нэмэгдүүлэх нь чухал байдаг. Нэг ч гэсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд авсан, тэдэнд бие даан ажиллаж, хөдөлмөрлөх боломжийг олгосон, өөр хоорондоо хамтран бизнесийн үйл ажиллагаа эхлүүлсэн байдал нь нийт эдийн засагт сайнаар нөлөөлж, улс орны эдийн засгийн татварын бааз суурийг өргөтгөнө. Хүн бүр өөр өөрсдийнхөө үнэ цэнтэй байдлыг хүлээн зөвшөөрөх, нийгэмдээ өөрийн чадахаар хувь нэмрээ оруулах, бусдад хэрэгтэй байх гэсэн хүсэл мөрөөдөл, тэмүүлэл, хичээл зүтгэл, хамтын ажиллагаа нь нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд хүргэнэ.

Тогтвортой хөгжил гэдгийг (Dagsupta, 2007) одоо болон ирээдүй үеийнхний амьжиргааны дундаж түвшин ямар ч тохиолдолд буурахгүй байхыг хэлнэ гэж тодорхойлсон бол, хүртээмжтэй өсөлтийг (Ali & Son, 2007) нийгмийн гишүүд нь нийгмийн баялгаас тэгш хүртэх байдал гэж тодорхойлжээ. Өндөр хөгжилтэй улсуудын хөгжлийн түүхээс харахад экспортод чиглэсэн үйлдвэрлэл буюу бусад улсад хэрэгцээтэй байгаа бүтээгдэхүүнүүдийг ихээр үйлдвэрлэж, экспортлох байдлаар улсынхаа эдийн засгийг хурдтай өсгөсөн байдаг. Энэ бүхнээс харахад ажлын байр олноор үүсгэдэг, хөдөлмөр зарцуулалт ихтэй салбаруудад бий болгосон эдийн засгийн өсөлт нь нийгмийн хамгааллыг сайжруулах, хүн болгонд боломжийг тэгш олгох, иргэдийн амьжиргааг жигд дээшлүүлэх сайн талтай (Л.Дансранбавуу, Б.Сайнжаргал, & Г.Эрдэнэцогт, 2017). Сүүлийн жилүүдэд Монгол Улсын эдийн засгийн өсөлт нь уул уурхай, зам, барилга зэрэг хөдөлмөр зарцуулалт багатай, капитал ихээр ашигладаг салбаруудаас голлон хамаарч

байгаагаас эдийн засаг нь бодитойгоор өссөн ч үр дүнг нь хүн амын цөөнх нь хүртдэг буруу жишиг тогтоод байна.

Бид эдийн засгийн бодит өсөлтийг нийт иргэддээ, түүний дотор онцгой анхаарал тавьж дэмжих шаардлагатай ХБИ-д хүргэхийн тулд дэлхийн улсууд ямар арга замыг хэрэглэж байгааг сайтар судалж, түүнээс өнөөгийн Монгол улсын нөхцөлд хэрэглэж болохыг зөв тодорхойлж, ажил хэрэг болгох шаардлагатай байна.

Дэлхий нийтэд түгээмэл хэрэглэгддэг, ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хэд хэдэн загварууд байдаг. Эдгээр загваруудыг дотор нь ХБИ-ийг тодорхой орчинд байрлуулж ажиллуулах ажил, зарим шаардлагатай дэмжлэг туслалцааг үзүүлж ажиллуулах ажил, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлогт тохируулж өөрчилсөн ажлын байранд ажиллуулах ажил зэргээр ангилдаг. Гэхдээ эдгээр загварууд нь ХБИ-ийг тусгай орчинд бусад жирийн иргэдээс тусгаарлан ажиллуулах загварууд юм. Харин НҮБ-аас гаргасан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн талаарх конвенц”-ийн 27 дугаар заалтад “Энэхүү конвенцод нэгдсэн улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ бусад иргэдтэй адил тэгш хөдөлмөрлөх эрхийг хүлээн зөвшөөрөх, мөн хөдөлмөрийн зах зээлээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нээлттэй, хүртээмжтэй, оролцох боломжтой байлгах, өөрсдийн сонгосон ажил хөдөлмөрийг эрхлэн амьдрах боломжийг олгох ёстой...” гэж заасан байдаг (UN, 2008).

ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн талаар НҮБ-аас баримталж байгаа бодлого бол тэднийг аль болох хөдөлмөрийн ердийн нөхцөлд жирийн иргэдтэй хамт ажиллуулах, аль болох нийгмээс тусгаарлахгүйгээр ажил хөдөлмөр эрхлүүлэх, амьдрах чадвартай байлгахад чиглэж байна. Энэ арга үр дүнтэй болохыг олон олон судалгааны үр дүн нотолдог. Тухайлбал, ХБИ-ийг тусгай орчинд нийгмээс тусгаарлан ажиллуулах нь тэдний цалин хөлсийг ижил түвшний ажил хөдөлмөр эрхэлж байгаа жирийн иргэдээс бага байлгах, урт хугацаанд тэдний өрсөлдөх чадварыг бууруулахад хүргэдэг байна (Gottlieb, Myhill, & Blanck, 2010).


Дээрх бүхнээс харахад, ХБИ-ийг тодорхой нөхцөлд тусгаарлан ажиллуулах болон тэднийг жирийн иргэдийн дунд, эрх тэгш ажиллуулах нөхцөл бололцоог зэрэг, сонголттойгоор бий болгох шаардлага үүсэж байна. Бидний

хувьд, ХБИ өөрсдийн бие, сэтгэхүйн онцлогт тохирсон ажлын байрууд ямар байх тухай өөр хэнээс ч илүү мэднэ, тиймээс тэд өөрдсөндөө тохирох ажлын байруудыг үүсгэхэд дээд зэргийн оролцоотой байх хэрэгтэй гэж урьдчилсан таамаглалыг дэвшүүлсэн. Өөрөөр хэлбэл, тэдний хамтын ажиллагааг буюу хоршооллын хөдөлгөөнийг дээд зэргээр дэмжих, үүнд нь төр, хувийн хэвшлийн байгууллагууд боломжит бүхий л хэлбэрээр туслах нь ХБИ маань цаашид бие даан ажиллаж чадах, нийгэмдээ сайн бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгож, хувь нэмрээ оруулах, татварын суурийг өргөтгөхөд чухал ач холбогдолтой.

2.2. Хоршооллын хөдөлгөөн, түүний давуу талууд

Өнөө үед дэлхийн улсуудын хоорондох харилцаа холбоо, тээврийн хэрэгсэл, тэдний хүрэлцээ хангамж, технологи, хурд, хөгжил улам бүр нэмэгдэж байна. Дэлхий нийтэд маш олон чиглэлээр мэдээлэл дамжуулалт, технологи шилжилт явагдаж байгааг Томас Фридман бүх хүмүүст тэгш боломж бий, учир нь дэлхий бол хавтгай гэсэн алдарт зүйрлэлээ хэлсэн (Friedman, 2005). Даяарчлал нь хүн болгоны өмнө, аж ахуйн нэгж болгоны өмнө асар их боломжийг олгож байгаа ч гэсэн өрсөлдөөнийг дэлхийн энтэй болгож байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа шинээр эхэлсэн жижиг үйлдвэрийн өрсөлдөгчид нь зөвхөн Монгол Улсад байгаа үйлдвэрлэгчид биш БНХАУ, ОХУ болон бусад улсад ажиллаж байгаа үйлдвэрлэгчид болж байна. Иймээс бид үйлдвэрлэлийн цар хүрээгээ өргөтгөх, нэгж бүтээгдэхүүний дундаж зардлыг бууруулах, дангаараа бизнес эрхлэх боломжгүй ч гэсэн ямар нэгэн хамтын бизнест өөрийн санхүүгийн чадавхад тохируулан хөрөнгө оруулалт хийж, ногдол ашиг авах сонирхолтой ХБИ-дээ боломжийг олгох үүднээс хоршооны бизнес загварыг авч үзлээ.

Хоршооллын бизнесийн онолын үндэслэл нь эдийн засгийн “Цар хүрээний хэмнэлтийн онол”-д суурилдаг. Үйлдвэрлэлийн тоо хэмжээг өсгөж, нэгж бүтээгдэхүүний дундаж зардлыг бууруулснаар улс орон, аж ахуйн нэгжүүд ашгаа нэмэгдүүлэх, өрсөлдөх чадвараа сайжруулж болох талаарх онолын үндэслэлийг А.Смит, К.Маркс нарын судалгаануудад үндэслэн 1977 онд Ж.Панзар, Р.Виллиг нар анх гаргасан (Panzar & Willig, 1977).



Зураг 1. Эдийн засгийн цар хүрээний хэмнэлт (Эх сурвалж: www.wikipedia.org)

Жижиг зах зээлд зориулан цөөн тоогоор (дээрх графикийн Q цэг орчимд) үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нэгжийн дундаж зардал нь нэгжийн зардал хамгийн бага байх оновчтой хэмжээний ойролцоо (Q_2 цэг орчимд) үйлдвэрлэгдэж байгаа бүтээгдэхүүний нэгжийн өртгөөс өндөр байна. Өөрөөр хэлбэл, нэгжийн өртгийн хувьд өрсөлдөх тааруу гэсэн үг юм.

Ганц нэгээрээ, эсхүл цөөхүүлээ ямар нэгэн бизнесийг эхлүүлэх үед анхны хөрөнгө оруулалтаа бүрдүүлэхэд хүндрэлтэй байдаг. Энэхүү хөрөнгө оруулалтаа яаж ийгээд бүрдүүлээ гэхэд 1 хүнд ногдох эрсдэл хэт өндөр болдог байна. Тиймээс эрсдэлийг бууруулах, бага хэмжээний мөнгөөр хурдан хугацаанд бизнесээ эхлэх, эдийн засгийн цар хүрээний хэмнэлтэд хамтдаа хүрэх боломжийг олгодог хамтын бизнес-хоршоонд нэгдэх нь ашигтай гэсэн дүгнэлт гарна. Мэдлэг, хөрөнгө хүч, цаг хугацаагаа нэгтгэн хийдэг хоршооны бизнесийн 90-ээс дээш хувь нь амжилттай болдог бол дангаараа, цөөхүүлээ эхэлсэн бизнесийн 3-5 хувь нь л 5 жилийн дараа тэсэж үлддэг судалгааны үр дүн байдаг (Williams, 2007).

2016 онд Японы Засгийн газраас гаргасан статистик мэдээллээс харахад тус улсын 127 сая иргэний 3.5 сая орчим нь бие эрхтний хувьд хөгжлийн бэрхшээлтэй, 2.5 сая нь сэтгэцийн ямар нэгэн бэрхшээлтэй, 500 мянга нь сэтгэн бодох чадварын хувьд хөгжлийн бэрхшээлтэй байна. Энэ нь нийт хүн амын дотор 6.5 сая орчим хүнийг буюу 5.1 хувийг хамарч байна (Otake, 2006). 1960 онд Япон Улс “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль”-ийг баталж, компаниудыг ажиллах хүчнийхээ тодорхой хувьд ХБИ-ийг

ажиллуулахыг үүрэг болгосон байдаг. 2006 оны мэдээллээр Япон Улсад ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн нийт хувь дөнгөж 40.3 хувь байна (Kudo, 2010). 1919-1920-иод оны үед Япон Улсад хоршооллын хөдөлгөөнүүд үүсэж, бэрхшээлтэй асуудлуудаа хамтдаа шийдэх оролдлого гарч эхэлсэн. Тухайлбал, Токио хотын Киодо-Ша болон Осака хотын Киоэки-Ша зэрэг ажиллагсдын хоршоод 1920 онд, иргэдийн хамтарч байгуулсан “Токиогийн худалдан авагчдын нийгэмлэг” хоршоо 1919 онд, “Кобегийн хэрэглэгчдийн хоршоо” болон “Надагийн худалдан авагчдын нийгэмлэг” хоршоод 1921 онд тус тус байгуулагдаж жижиглэн худалдааны үйл ажиллагаа эрхэлж байв. Нада-Кобегийн хэрэглэгчийн хоршоо нь хоршоодын гишүүдийн дунд ХБИ-д туслах “Харилцан туслах нийгэмлэг” хоршоог 1983 онд үүсгэн байгуулсан нь улс даяар өргөн хэрэглэгдэх болсон (Suzuki, Saito, & Yamashita, 2010). Энэ бүхэн нь цаашид хөгжлийн бэрхшээлтэй иргэд хамтарч ажиллах, шаардлагатай нэгэндээ туслах, нийгмийн эрэлт хэрэгцээг хангаж, ашиг орлого олох чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох чиглэлээр улам бүр хөгжих үндэслэл болсон.

1978 онд байгуулагдсан “Сайтамагийн эмнэлэг”-ийн хоршоо нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургаж, ахмад настнуудын асрагчаар ажиллуулдаг гэдгээрээ онцлогтой. Ингэж бусдад тустай гэдгээ мэдрэх нь ХБИ-д амьдрах эрч хүч, бие даан ажиллах итгэлийг өгдөг байна (ICA, 2016). “Сайтамагийн эмнэлэг” хоршоо нь 2014 оны 3 дугаар сарын байдлаар 242.1 мянган гишүүнтэй, 2.2 мянган ажиллагсадтай томоохон байгууллага болжээ. ХБИ өөрсдөө энэхүү хоршооныхоо гишүүн болохын зэрэгцээ, өөрт тохирох ажлуудаа хийж хоршооныхоо ажилтан ч болдгоороо давуу талтай байна.

3. Монгол Улсын эдийн засгийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн нөхцөл байдал

Өнөөдөр өндөр хөгжилтэй байгаа улсууд эдийн засгаа өсгөхдөө зах зээлийн өрсөлдөөнт зарчмыг ашиглан хөгжиж ирсэн. 1980-аад оноос хөгжил нь саарч, 1990-ээд онд бүрэн задарсан социалист системийг алдаанд хүргэсэн үнийг төрөөс 100 хувь зохицуулдаг байсан, хүмүүсийн ажиллаж хөдөлмөрлөх санал санаачилгыг урамшуулах механизм хангалттай бус байсан зэрэг олон хүчин зүйл байдаг. Гэлээ гэхдээ энд хамгийн том хүчин зүйлийн нэг нь хувийн өмчийг хүлээн

зөвшөөрдөггүй явдал байлаа гэж зарим судлаачид үзсэн байдаг (Perry, 1995). Монгол Улс эдийн засгийн тулгуур хуулиудаа зах зээлийн эдийн засгийг ашиглан, өндөр хөгжилд хүрсэн улсуудын хуулиудын жишигт нийцүүлэн өөрчилж эхлээд байна. Эдийн засгаа өөрчилсөнтэй нэгэн адилаар ажлын байр үүсгэх, нэн ялангуяа ХБИ-дээ тогтвортой, сайн цалинтай ажлын байр үүсгэхийн тулд бид өндөр хөгжилтэй улсуудын өнгөрсөн түүхээс сайтар суралцах шаардлага үүсээд байна. Тухайлбал, Япон Улсын Ажил Эрхлэлтийг Дэмжих Олон Нийтийн Байгууллага(АЭДОНБ, Work Integration Social Enterprises)-ууд нь ХБИ-ийг хамтдаа ажиллах, хөгжих боломжтой ажлын байруудыг үүсгэхдээ хоршооллын хөдөлгөөнийг ашигладаг байна (Laratta & Nakagawa, 2016).

Үндэсний Статистикийн Газрын мэдээллээр 2018 оны жилийн эцэст Монгол Улсын ХБИ-ийн тоо 105.7 мянга байгаагаас 59.7 мянга нь эрэгтэйчүүд, 46.0 мянга нь эмэгтэйчүүд байна (ҮСГ, 2019). Тухайн онд Монгол Улсын хүн амын тоо 3.2 сая байсантай харьцуулахад ХБИ-ийн нийт хүн амд эзлэх хувь нь 3.3 хувь байна.

Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн 111 дүгээр зүйлийн 1 дэх заалтад “25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулна” гэж заасан байдаг (УИХ, 1999). Гэтэл, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яамны харьяа Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Судалгааны Институтээс 2019 онд хийсэн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа”-ны үр дүнгээс харахад дээрх хуулийн заалтын хэрэгжилт туйлын хангалтгүй байна.

Тухайлбал, 25-аас дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагуудын ХБИ-ийг ажиллуулах орон тоо 19.5 мянга байгаагаас 2018 онд 4.9 мянган хүн ажиллаж, 14.6 мянган хүн ажиллаагүй байна (ХНХСИ, 2019). Хуулийн энэхүү заалтыг биелүүлээгүйн улмаас торгууль төлж байгаа аж ахуйн нэгжүүд дараах шалтгаануудыг дурдсан байна. Үүнд, хамгийн том шалтгааныг 42.9 хувиар хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажилд орохоор огт ирж байгаагүй гэсэн шалтгаан, 25.7 хувиар ХБИ ажиллах боломжтой ажлын байр байхгүй, 20.0 хувиар ХБИ-ийн ур чадвар шаардлагад нийцэхгүй байсан, 8.6 хувиар ХБИ-ийг ажиллуулах

сонирхол байхгүй, 5.7 хувиар ажлын байрны тохируулга хийхэд хүндрэлтэй байсан гэх шалтгаанууд эзэлсэн байна (ХНХСИ, 2019).

Институтийн судалгааны үр дүнгээс харахад, ХБИ-ийн ажил хөдөлмөр эрхэлж, амьжиргааны түвшнээ дээшлүүлэх санал санаачилга хомс байгаагийн шалтгааныг тодруулах, үүнд төрөөс явуулж байгаа халамжийн бодлого нөлөөлж байгаа эсэхийг цаашид судлах шаардлагатай байна. Мөн аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран ХБИ ажиллах боломжтой ажлын байруудыг үүсгэх, ХБИ-ийн ур чадварыг дээшлүүлж, чадавхжуулах нийгмийн хэрэгцээ үүсжээ. Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яам, Жайка ОУБ-ын хамтарсан судалгаагаар, Монгол Улсад хөдөлмөрийн насны 93.3 мянган ХБИ байгаагийн 19 хувь л цалин хөлстэй хөдөлмөр эрхэлж, 80 гаруй хувь нь ажилгүй байна (ХНХЯ & JICA, 2017). ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, журмууд гардаг ч гэсэн төрийн зүгээс үзүүлэх санхүү мөнгөний хүндрэлээс шалтгаалан тунхаг хэлбэртэй хоцорч, ХБИ хохирсоор байна.

4. Судалгааны арга зүй

Уг судалгааны ажилд тодорхойлогдож буй загварт хэд хэдэн тайлбарлагч хувьсагчдыг сонгож авсан бөгөөд тоон өгөгдлийн олдоцтой байдлыг харгалзан 2009-2019 оны хоорондох хугацаан цуваан өгөгдлийг ашиглав. Жирийн болон ХБИ-ийн ажилгүйдлийн түвшин, бизнес регистрийн санд бүртгэлтэй хоршооны тоо, гишүүдийн тоо, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ зэрэг үзүүлэлтүүдийг ҮСХ-ны статистикийн мэдээллийн сангаас түүвэрлэн авч ашиглав (Хүснэгт 1). Ажилгүйдлийн түвшний тэгшитгэл нь дараах хоёр хэлбэртэй байна.

$$urate_t = \alpha_0 + \beta_1 ncooper_t + \beta_2 nmembers_t + \beta_4 sequity_t + e_t \quad [1]$$

$$uratepwd_t = \alpha_0 + \beta_1 ncooper_t + \beta_2 nmembers_t + \beta_4 sequity_t + e_t \quad [2]$$

Хүснэгт 1. Загварт ашигласан хувьсагчид

Хувьсагчид	Тайлбар	Хүлээгдэж буй таамаглал
Тайлбарлагдагч хувьсагч		
urate	Ажилгүйдлийн түвшин, хувиар	
urate_pwd		
Тайлбарлагч хувьсагчид		
n_cooper	Бизнес регистрийн санд бүртгэлтэй хоршооны тоо	-
n_members	Бизнес регистрийн санд бүртгэлтэй хоршооны гишүүдийн тоо	-
s_equity	Хоршооны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ	-

Эх сурвалж: ҮСХ-ны статистикийн мэдээллийн сан

Ажилгүйдлийн түвшний тэгшитгэлд ашиглагдах хувьсагчдын өөр хоорондын учир шалтгаан болдог эсэхийг Гранжер (Granger Causality Tests) тестээр, тогтвортой байдлыг ADF (Augmented Dickey-Fuller test) болон PP (Phillips-Perron test) тестүүдээр шалгасан ба шугаман регрессийн загварын үнэлгээг хийхэд Eviews 10.0 программын хамгийн бага квадратын арга (Least Squares Method)-г ашиглав.

5. Судалгааны үр дүн

Судалгааны бүлэгт Монгол Улсын жишээн дээр хоршооны тоо, гишүүдийн тоо, нийлүүлсэн хөрөнгө зэрэг үзүүлэлтүүд нь жирийн иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажилгүйдлийн түвшинд хэрхэн нөлөөлж байгааг эконометрик үнэлгээний аргуудыг ашиглан тайлбарлахыг зорилоо. Ихэнх хугацаан цувааны өгөгдөл нь тогтворгүй байдаг тул судалгаанд ашигласан өгөгдлүүдийг ADF болон PP тестүүдээр шалгав.

Хүснэгт 2. Нэгж язгуурын тестийн үр дүн

	H ₀ : нэгж язгуурын процесс					
	Fisher-ADF			Fisher-PP		
	Intercept	Trend&Intercept	None	Intercept	Trend&Intercept	None
urate	0.045**	0.3161	0.4036	0.0209**	0.0504*	0.3935
urate_pwd	0.0478**	0.5116	0.0104**	0.0014***	0.5116	0.0015***
n_cooper	0.558	0.0001***	1.0	0.0024***	0.0001***	0.9772
n_members	0.999	0.8979	0.9993	1.0	0.9999	0.9993
s_equity	0.7341	0.6033	0.9804	0.6306	0.7177	0.9804

Тэмдэглэл: Тэг таамаглалыг няцаах хамгийн бага магадлалыг үзүүлсэн бөгөөд (*), (**), (***) нь харгалзан 10, 5, 1 хувийн ач холбогдлын түвшинд ач холбогдолтой болохыг илэрхийлнэ.

Эх сурвалж: Судлаачдын тооцоо

Тухайлбал, urate нь тогтмол хувьсагч агуулсан, энгийн түвшиндээ /level/ тогтвортой болохыг 95 хувийн ач холбогдлын түвшинд хүлээн зөвшөөрч байгааг хүснэгт 2-с харж болно. Эдгээр тестүүдээр urate, urate_pwd, n_cooper зэрэг хувьсагчид нь тогтвортой гарсан хэдий ч n_members, s_equity зэрэг хувьсагчид энгийн түвшиндээ тогтворгүй байсан тул логарифм авах замаар үнэлгээнд ашиглав. Хувьсагчдын өөрчлөлт нь нэг нэгнийхээ учир шалтгаан болдог эсэхийг Гранжер тестээр шалгаж үр дүнг Хүснэгт 2-т харуулав.

Хүснэгт 2. Гранжерын учир шалтгааны тестийн үр дүн

Null Hypothesis:	Prob.
------------------	-------

URATE нь N_MEMBERS-н учир шалтгаан болохгүй байх	0.023**
N_MEMBERS нь URATE_PWD-н учир шалтгаан болохгүй байх	0.091*
URATE_PWD нь S_EQUITY-н учир шалтгаан болохгүй байх	0.039**
N_COOPER нь S_EQUITY-н учир шалтгаан болохгүй байх	0.08*
S_EQUITY нь N_MEMBERS-н учир шалтгаан болохгүй байх	0.055*

Тэмдэглэл: (*), (**) нь харгалзан 10, 5 хувийн ач холбогдлын түвшинд учир шалтгаан болохгүй байх гэсэн тэг таамаглал үнэн байх магадлалыг илэрхийлнэ.

Эх сурвалж: Судлаачдын тооцоо

Тестийн үр дүнгээс харахад жирийн иргэдийн ажилгүйдлийн түвшин (urate) болон хоршооны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ (s_equity) зэрэг үзүүлэлтүүдийн өөрчлөлт нь хоршооны гишүүдийн тоо (n_members)-ны өөрчлөлтийн учир шалтгаан болохуйц хамаарал оршин байгаа нь харагдаж байна. Харин хоршооны гишүүдийн тоо (n_members)-ны өөрчлөлт нь ХБИ-ийн ажилгүйдлийн түвшин (urate_pwd)-ий өөрчлөлтийн шалтгаан болж байна. Түүнчлэн ХБИ-ийн ажилгүйдлийн түвшин (urate_pwd)-ий өөрчлөлт нь хоршооны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ (s_equity)-ний өөрчлөлтийн учир шалтгаан болж байна.

6. Дүгнэлт, зөвлөмж

Хөгжиж байгаа ихэнх улсад, түүний дотор дөнгөж 1990 оноос зах зээлийн эдийн засагт шилжиж, капиталист эдийн засгийн талаарх хууль эрх зүйн зохицуулалтууд, иргэдийн ойлголтууд нь төдийлөн цэгцрээгүй байгаа Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрал ахуй туйлын хүнд байна. Нийт иргэдийн дундах ажилгүйдлийн түвшин 2017 онд 8.8 хувь, 2018 онд 7.8 хувь, 2019 онд 10.0 хувь болж өсөх хандлагатай байгаа өнөө үед хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажил хайж олох, амьдрал ахуйгаа бие даан авч явах боломж бага байна.

Судалгаанд ашигласан Гранжер тестийн үр дүнгээс харахад, жирийн хоршооны гишүүдийн тоо (n_members)-ны өөрчлөлт нь ХБИ-ийн ажилгүйдлийн түвшин (urate_pwd)-ий өөрчлөлтийн шалтгаан болж байна. Түүнчлэн ХБИ-ийн ажилгүйдлийн түвшин (urate_pwd)-ий өөрчлөлт нь хоршооны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ (s_equity)-ний өөрчлөлтийн учир шалтгаан болж байна.

Судалгаанд ашигласан тоон мэдээлэл хангалттай бус, нэн ялангуяа хоршооны гишүүдийн дотор ХБИ-ийн эзлэх хувь хэмжээ тодорхой бус гээд статистикын тоон өгөгдлийн дутагдалтай байдал нь судалгааг илүү өргөн түвшинд хийх боломжийг хязгаарлаж байна.

Цаашид ХБИ-ийн дунд үйл ажиллагааны эрсдэл багатай хоршооллын хөдөлгөөнийг эрчимжүүлэх, үүнд жирийн иргэдийг татан оролцуулах, төрийн бодлогыг жирийн болон ХБИ-ийн хамтын ажиллагааг дэмжихэд чиглүүлэх боломжтой нь судалгааны үр дүнгээс болон Япон зэрэг өндөр хөгжилтэй улсуудын өнгөрсөн түүхээс харагдаж байна.

Ном зүй

1. Ali, I., & Son, H. (2007). *Measuring Inclusive Growth*,. *ADB, Asian Development Review, Vol 24*.
2. Dagsupta, P. (2007). *Measuring Sustainable Development: Theory and Application*,. *ADB, Asian Development Review, Vol 24*.
3. Dolgion, A., Nyambayar, G., & Dolgorsuren, G. (2015). *Mainstreaming, acceleration and policy support (maps) for SDGs: gender baseline analysis against SDGs in Mongolia* . Ulaanbaatar: UNDP.
4. Friedman, L. (2005). *The World Is Flat*. New York: Farrar, Straus and Giroux.
5. Gottlieb, A., Myhill, W. N., & Blanck, P. (2010, January). *Employment of People with Disabilities*. New York, NY, USA.
6. ICA. (2016). *HIP Cooperative Members in Japan*. Brussels: International Cooperation Allaince.
7. Isaro, P., & Isard, W. (1965). *General social, political, and economic equilibrium for a system of regions*. *Papers of the Regional Science Association*.
8. Kehinde, A., Jubril, A., Felix, A., & Edun, F. (2012). *Foreign trade and economic growth in nigeria: An empirical analysis*. *American Academic and Scholarly Research Journal*, vol.4.no.5.
9. Kudo, T. (2010). *Japan's Employment Rate of Persons with Disabilities and Outcome of Employment Quota System*. *Japan Labor Review, vol 7*.
10. Laratta, R., & Nakagawa, S. (2016). *Work Integration Social Enterprises for People with Disabilities in Japan*. *Nonprofit Policy Forum | Volume 7: Issue 4*.
11. Otake, T. (2006, 8 27). *Is 'disability' still a dirty word in Japan?* Tokyo, Japan.
12. Panzar, J., & Willig, R. (1977). *Economies of Scale in Multi-Output Production*. *The Quarterly Journal of Economics, Volume 91, Issue 3.*, 481-493.
13. Perry, M. (1995). *Why Socialism Failed*. Atlanta: Foundation for Economic Education.
14. Sekine, Y. (2008). *The Rise of Poverty in Japan: The Emergence of Working Poor*. *Japan Labor Review, vol 5, no 4*, 49-66.
15. Suzuki, T., Saito, Y., & Yamashita, T. (2010). *A Brief Chronicle of the Modern Japanese Consumer Cooperative Movement* . Tokyo: Japanese Consumers' Co-operative Union .
16. UN. (2008). *Convention on the Rights of Persons with Disabilities*. New York and Geneva.
17. Verick, S., & Islam, I. (2010). *The Great Recession of 2008-2009: Causes, Consequences and Policy Responses*. *IZA Discussion Paper No. 4934*.
18. Williams. (2007). *The cooperative movement: Globalization from below*. Aldershot: Ashgate Publishing Limited.
19. Williams, I., & Enright, J. (2000). *Local Partnership, Clusters and SME Globalization*. *Conference for Ministers responsible for SMEs and Industry Ministers*. Milan, Italy.
20. World Bank. (2009). *What is Inclusive Growth?*. Washington: World Bank.
21. Л.Дансранбавуу, Б.Сайнжаргал, & Г.Эрдэнэцогт. (2017). *Орон нутгийн өсөлт, түүний боломжууд*. МУИС-ийн Орхон ИС.

22. УИХ. (1999, 5 14). Хөдөлмөрийн тухай хууль. Улаанбаатар, Монгол: Улсын Их Хурал.
23. УИХ. (2008). *Монгол Улсын мянганы хөгжлийн зорилгод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого*. Улаанбаатар: УИХ-ын тогтоол.
24. УИХ. (2016). *Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030*. Улаанбаатар: УИХ-ын тогтоол.
25. УИХ. (2016, 2 5). Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль. Улаанбаатар, Монгол.
26. ҮСГ. (2018). *Ядуурлын үндсэн үзүүлэлт, хот, хөдөө, бүс, суурьшлаар*. Улаанбаатар: Үндэсний Статистикын Газар.
27. ҮСГ. (2019). *Ажилгүйдлийн түвшин (хувиар), хүйс, насны бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдээр*. Улаанбаатар: Үндэсний Статистикын Газар.
28. ҮСГ. (2019). *Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, бүс, аймаг, нийслэлээр, хүйсээр*. Улаанбаатар: Үндэсний Статистикын Газар.
29. ХНХСИ. (2019). *Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Хөдөлмөр Эрхлэлтийн Судалгаа*. Улаанбаатар: Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Судалгааны Институт.
30. ХНХЯ, & JICA. (2017). *Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа*. Улаанбаатар: Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яам; Жайка Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага.

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТ БА НОРВЕГИ УЛСТАЙ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Д Ариунгэрэл¹, Б Уянга¹, Э.Балжинням¹, Г.Чанцалдулам¹, Г.Нямдулам¹

¹Мандах их сургууль

Хураангуй

Бид энэхүү судалгаандаа Монгол улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Ажил эрхлэлт ба өнөөгийн байдалд, статистик мэдээлэл, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж Норвеги улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харьцуулсан судалгаа хийж Монгол улс нь ОУ-ын түвшинд Хөгжлийн бэрхшээлтэй иргэддээ хууль эрх зүйн ямар зохицуулалт хийх, цаашдын чиг хандлагыг хэрхэн тодорхойлох талаар энэхүү судалгааны бичсэн болно.

НЭГ. МОНГОЛ БА НОРВЕГИ УЛСЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

1.2 НОРВЕГИ УЛСЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Хөгжлийн бэрхшээл гэдэг нь танин мэдэхүй, хэл шинжлэл, нийгмийн бэрхшээлтэй холбоотой хэд хэдэн өөр оношлогоо, нөхцөл байдлын хамтын нэр томъёо юм. Хөгжлийн бэрхшээл нь хөгжлийн бэрхшээл буюу хөгжлийн бэрхшээлийн тухай ерөнхий ойлголтонд багтдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өдөр тутмын амьдралдаа хэр сайн ажилладаг, тэдэнд тусламж, туслалцаа хэр их хэрэгтэй байдагтай холбоотой хувь хүний томоохон ялгаа байдаг.

Тодорхойлолт

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хөгжлийн бэрхшээлийг дараахь байдлаар тодорхойлдог. Хөгжлийн явцад илэрч буй ур чадвар, оюун ухааны ерөнхий түвшинд хувь нэмэр оруулах чадварыг дарангуйлах, ялангуяа танин мэдэхүйн, хэл шинжлэлийн, моторт, нийгмийн чадварын хөгжлийн хоцрогдсон буюу дутагдалтай байдал. Хөгжлийн бэрхшээл нь бусад сэтгэцийн болон соматик эмгэгүүдтэй эсвэл үүнгүйгээр тохиолдож болно. Тодорхойлолтонд багтахын тулд хүн дараахь зүйлийг хийх ёстой.

- хязгаарлалт нь 70-аас доош түвшинг хэлнэ.
- Стандарт үнэлгээний хуваарийн дагуу болон хамаатан садантайгаа ярилцлага хийхдээ нийгмийн төлөвшил, дасан зохицох чадварын хязгаарлалттай байх.
- 18 нас хүрэхээс өмнө гарч байсан эмгэг.

Хөгжлийн бэрхшээлийн янз бүрийн зэрэг байдаг. Тэдгээрийг дараах байдлаар тараана.

- Хөгжлийн бага зэргийн хөгжлийн бэрхшээл: IQ 50-69
- Хөгжлийн дунд зэргийн хөгжлийн бэрхшээл: IQ 35-49
- Хөгжлийн ноцтой хоцрогдол: IQ 20-34
- Хөгжлийн гүнзгий хөгжлийн бэрхшээл: IQ 20-оос доош

Хөгжлийн хоцрогдол хэр зэрэг хүнд байх тусам нэмэлт хүндрэл, архаг эмгэг үүсэх магадлал нэмэгддэг. Хөгжлийн бэрхшээлийн зэрэг, нэмэлт бэрхшээлээс хамааран тусламжийн хэрэгцээ ихээхэн ялгаатай байх болно. Зарим нь өдөр тутмын амьдралын үйл ажиллагаандаа өөрсдийгөө удирддаг бол зарим нь өдөр шөнөгүй тусламж, дэмжлэг шаарддаг.

Хөгжлийн бэрхшээл нь хэр нийтлэг байдаг вэ?

Норвегид хөгжлийн бэрхшээлтэй хичнээн хүн байдаг тухай янз бүрийн тоо баримт байдаг. Бид гурван тооцоог голчлон ялгаж үздэг.

- Мэргэжлийн эрүүл мэндийн үйлчилгээгээр ICD-10-ийг үндэслэн оношлогдсон хүмүүс. Акершус хотод 1980-85 онд төрсөн хүүхдүүдийн [тархвар судлалын судалгаагаар](#) хөгжлийн бэрхшээлтэй оношлогдсон хүүхдүүдийн өвчлөл 0.6% байна.
- Норвегийн Эрүүл мэндийн газарт хотын захиргаанаас мэдээлэх. Норвегийн Эрүүл мэндийн газар нь үндэсний хэмжээнд 21,000 орчим тогтвортой тогтвортой байгаа хотын захиргаанаас мэдээлсэн тоонуудтай ажилладаг. Энэ нь ойролцоогоор тохирч байна. Хүн амын

0.42. Бүртгэгдсэн хэргүүд нь хотын захиргаанд төрөөс үзүүлэх татаасыг өдөөж байна. Үүнийг "захиргааны оношлогоо" гэж нэрлэж болно.

- ICD-10-ийн шалгуур үзүүлэлт дээр үндэслэсэн статистик тооцоо. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хөгжлийн бэрхшээлийг хэрхэн ойлгож байгаагаас хамаарч хүн амын 1-3% -ийг бүрдүүлдэг гэсэн тооцоо байдаг. IQ түвшинд цорын ганц шалгуур болох хувь нь 2.27% байдаг боловч ДЭМБ-ын тодорхойлолтын дагуу IQ дангаараа хангалттай сайн шалгуур биш юм. Тиймээс Дэлхийн эрүүл мэндийн байгууллага нь нийт хүн амын 1.5% -ийн ICD-10-ийн тодорхойлолтыг үндэслэн ерөнхий өвчлөлтэй ажилладаг. Норвегид энэ нь ойролцоогоор тохирч байна. 2015 онд 75,000 хүн.

Хөгжлийн бэрхшээлийн шалтгаан юу вэ?

Хөгжлийн бэрхшээлийн шалтгааны талаар ярихдаа бид ихэвчлэн хоёр үндсэн бүлгийг ялгадаг.

- **Биопатологи** : Энд генетик ба олдмол байдлыг ялгаж салгаж болно. Генетикийн инженерчлэлийн аргуудын хөгжил нь илүү олон хүмүүст илүү оновчтой оношлогоо хийгдэж байгааг харуулж байна. [Дауны синдром](#) нь хөгжлийн бэрхшээлийг үүсгэдэг хромосомын согогуудаас хамгийн сайн мэддэг боловч олон оношлогоо нь хөгжлийн бэрхшээл нь хам шинжийн нэг хэсэг болох ховор нөхцөл / синдромыг хэлдэг.
- **Өвөрмөц бус**: Зарим тохиолдолд хөгжлийн хоцрогдол яагаад **үүссэнийг** бид мэдэхгүй бөгөөд мэдэгдэж буй оношлогоо, хам шинж үүнийг тайлбарлаж чадахгүй. Өвөрмөц бус шалтгаан нь хөгжлийн хөнгөн хөгжлийн бэрхшээлтэй үед хамгийн их тохиолддог.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дараахь үндсэн бүлэгт хувааж болно.

- Харааны бэрхшээлтэй хүмүүс
- Хөдөлгөөн багатай хүмүүс
- Сонсголын бэрхшээлтэй хүмүүс
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс

- Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс

Ажил, өдөр тутмын үйл ажиллагаа

Ажилд оролцох нь хувь хүний эдийн засаг, нийгэмд үнэ цэнэ бий болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд, бусад хүмүүсийн адил бие даасан, нийгмийн амьдрал, эзэмшсэн туршлагатай, эрүүл чийрэг байхын тулд хөдөлмөрийн амьдралд оролцох нь чухал юм.

Хууль ёсны эрх

Норвегид хувь хүмүүст ажил хийлгэх ерөнхий эрх байдаггүй боловч Үндсэн хуулинд төр "хөдөлмөрийн чадвартай хүн бүр ажил хөдөлмөр, аж үйлдвэрээр мөнгө олох боломжтой байх" нөхцлийг бүрдүүлнэ гэж заасан, эс тэгвээс төрийн байгууллагаас дэмжлэг авах эрхтэй ([Ловдата](#)).

Энгийн ажил NAV тусламж

Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхахаас хамгаалах Ажлын орчны тухай хууль нь хөгжлийн бэрхшээлийн улмаас ялгаварлан гадуурхахаас хамгаална (Ажлын орчны тухай хуулийн 13-р хэсэг). Нэмж дурдахад, хөгжлийн бэрхшээлийн улмаас ялгаварлан гадуурхахыг хориглосон тусдаа хуультай бөгөөд " Жөндөрийн тэгш байдал, ялгаварлан гадуурхах тухай хууль " гэж нэрлэдэг .

NAV-ийн хяналт шалгалт

Норвегийн Хөдөлмөр, Халамжийн Захиргаа (NAV) ажилд хамруулж ажиллах болно. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дотор үүнийг хүссэн хүн бүр, ажлын чадвар үнэлгээ авах боломжтой байх ёстой , NAV тухай хуулин § 14 дагуу .

NAV нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст энгийн хөдөлмөрийн амьдралд туслах хэд хэдэн хэрэгсэлтэй. Эдгээрийг хөдөлмөрийн зах зээлийн хэмжүүрийн талаархи журамд дэлгэрэнгүй тайлбарласан болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан NAV-ийн боломжит арга хэмжээний жишээ:

- Ажилд бэлтгэх

- Хамгаалах байртай эсвэл энгийн компанид байнгын ажил зохион байгуулдаг
- Байнгын зохион байгуулалттай ажлаас энгийн ажлын амьдралд дадлага хийхээр явах
- Цалингийн түр татаас
- Байнгын цалингийн татаас
- Багш
- Хяналт

Хөгжлийн бэрхшээлтэй цөөн хэдэн хүн тусламжгүйгээр энгийн ажил хийдэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ердийн ажлын байранд нэмэлт тусламжгүйгээр хамрагдах боломжтой байж болох боловч практик дээр энэ нь маш цөөхөн хүнд хамаатай юм. Технологийн хэрэглээ нэмэгдэж, цөөн тооны гарын авлагын даалгавар бүхий хөдөлмөрийн хатуу зах зээл нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нөхцөл байдлыг улам бүр хүндрүүлэхэд хувь нэмэр оруулах болно.

👤 Байнгын зохион байгуулалттай ажил VAT схем

VTA гэж юу вэ?

Хамгаалах байранд байнгын дасан зохицсон ажил нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон хөдөлмөрийн чадвар, хөдөлмөрийн чадвар буурсан бусад хүмүүсийг хөдөлмөрийн амьдралд хамруулах чухал арга хэмжээ юм. Энэхүү арга хэмжээний зорилтот бүлэг нь тахир дутуугийн 100 хувийн тэтгэвэртэй хүмүүс юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гол зорилтот бүлэг болох цорын ганц арга хэмжээ юм.

Байнга зохицсон ажлыг (VTA) [хөдөлмөрийн зах зээлийн хэмжүүрээр зохицуулдаг](#).

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст цөөн тооны VTA газар очдог

Сүүлийн жилүүдэд VTA байрны хэрэглээ нэмэгдэж байгаа хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээс бусад бүлгүүд эдгээр газруудын ихэнхийг авсан (Мелд. Санкт 45: 56) бөгөөд өнөөдөр үүнд сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийн 35 орчим хувь нь хамрагдаж байна (Рейнерцен 2012).

Ердийн үйл ажиллагаанд VTA (VTA-O)

VTA-O хэмээх ердийн үйл ажиллагаануудад байнгын зохион байгуулалттай ажил байдаг боловч үүнд хамрагдсан салбараас хамаагүй цөөн хүмүүс хамрагддаг (2010 онд ойролцоогоор 3%, Рейнерцен 2012).

Хотын өдөр өнжүүлэх

Өдрийн төв нь Эрүүл мэнд, халамж үйлчилгээний тухай хуулийн § 3-3-т үндэслэн хотын захиргааны байгууллагуудын урьдчилан сэргийлэх ажлын нэг хэсэг гэж үздэг. Өдрийн төвд байрлах газар бол хувь хүний эрх биш харин тухайн хүний хүсэлт гаргаж болох зүйл юм. Өдрийн төвийг ердийн ажил гэж үздэггүй.

Энэхүү саналын загвар нь хотын захиргаанаас хамаарч өөр өөр байх болно. Практик дээр хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрэгчдийн бараг тэн хагас нь өдрийн төвийн схемд байр суурь эзэлдэг (Reinertsen 2012). Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өдөр бүр асрахгүй байх хандлага ажиглагдаж байна.

Ажлын байран дахь тусламж

Хэрэв тусламж нь ажлын амьдралд хамаатай бол NAV нь үүнд туслалцаа үзүүлэх боломжтой. Чухал хязгаарлалт бол [Үндэсний даатгалын тухай хуулийн § 10-5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт](#) заасны дагуу тахир дутуугийн тэтгэвэр авч буй хүмүүст туслалцаа үзүүлэх хэрэгсэл (зарим тохиолдолд бусад тохиолдолд) ашиглах эрхгүй байх явдал юм.

ХОЁР. МОНГОЛ УЛС БА НОРВЕГИ УЛСЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

2.1 МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Манай нийгэмд тогтсон буруу хандлага ойлголтын нэг бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бусдын адил хөгжих, ажиллаж амьдрах чадамжтай хувь

хүн гэдэг талаас нь бус харин нийгмийн эмзэг бүлэг мэтээр өрөвдсөн, тэдний өмнөөс харамссан, хөөрхийлөлттэй нэгэн болгож хардагт учир байна. Харин бодит нөхцөл байдал тэдний төсөөллөөс тэс өөр гэж ойлгож болно. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэж нэрлэсэн эдгээр хүмүүс үнэн хэрэгтээ тэдэнд хандсан төрийн бодлого зохицуулалт байхгүйгээс болж тодорхой хэмжээгээр нийгмээс тусгаарлагдаж байгаа ч бусдын адил хөгжих, ажиллаж амьдрах бүрэн чадамжтай гэдгийг онцлох хэрэгтэй.

Ухаан санаа саруул, бусдын адил хүсэл мөрөөдөлтэй хэрнээ үйл хөдлөл, хэрэгцээ шаардлага харьцангуй өөр хүнийг Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэж энгийнээр ойлгож болно. Ийм хүмүүс маш олон. Манай улсын хэмжээгээр 10 мянган хөгжлийн бэрхшээлтэй, ижил төрлийн тулгамдсан асуудалтай хүмүүс бий. Эдгээр хүмүүсийн ажиллаж амьдрах, нийгэмших орчинг сайжруулахад ээлтэй орчинг бүрдүүлэх асуудал ус агаар мэт үгүйлэгдэж байна. Төр засаг, аймаг орон нутгаас баримтлаж байгаа бодлого үйл ажиллагааны чиглэлд хөгжлийн бэрхшээлтэй иргэд рүү хандсан ээлтэй орчинг бий болгох асуудлыг илүү тусган ажил хэрэг болгож чадвал хүнээ дээдэлсэн төр, төрөө дээдэлсэн иргэн бий болж хөгжил өөд хамт урагшлах боломж бүрдэх юм. Үүний тулд төрийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага бүр тусгай хэрэгцээт иргэддээ хүрч ажиллах, тэдэнд ээлтэй орчинг бүрдүүлэх асуудал чухал байна.



Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд 25-аас дээш ажилчинтай албан байгууллага хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг заавал ажиллуулах зохицуулалттай байдаг. Манай улсад албан ёсоор хөдөлмөр эрхэлдэг хэмээн бүртгүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 41 хувь нь хувиараа, 35 хувь нь

цалин хөлстэй ажиллагч, 20 хувь нь өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй ажиллаж, 1.6 хувь нь ажил олгогч, 0.3 хувь нь нөхөрлөл, хоршооны гишүүн байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу аж ахуйн нэгж хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлого өнгөрсөн онд 349 сая төгрөг байсан бол энэ оны эхний байдлаар 545 сая төгрөг төвлөрчээ. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай болон Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлдэг. Уг хөтөлбөрийн хүрээнд өнгөрсөн онд 2.3 тэрбум төгрөг зарцуулж, 1980 хүн ажлын байраар хангагдсан байна. Харин энэ онд 4.2 тэрбум төгрөг баталсан бөгөөд энэ оны эхний долоон сарын байдлаар 951 иргэнийг хамруулан, 1.6 тэрбум төгрөг зарцуулж, 827 ажлын байр бий болгосон байна.

Төрийн болон төсвийн байгууллагын дөнгөж 38 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг зохих орон тоонд ажиллуулж байна.

Нийт 1,281 аж ахуйн нэгж хамрагдсанаас 131 аж ахуйн нэгж, байгууллага нь ажлын байрны төлбөрийг хуулийн дагуу төлж, 794 аж ахуйн нэгж байгууллага 1,908 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг зохих орон тоонд ажиллуулж байна. Байгууллагууд нийт ажилчдынхаа 0.4-өөс доошгүй хувьд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажиллуулах ёстой.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 40.3-д "Төрийн захиргааны төв байгууллагууд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлж байгаа бодлого арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн харилцаанд тэгш оролцох боломжийг бүрдүүлэх асуудлыг тусгаж, хэрэгжүүлнэ" гэж заасан байдаг. Үүний дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийн санд төвлөрүүлсэн хөрөнгийг тэдний бие эрхтэн, хөгжлийн онцлогт нийцсэн тогтвортой орлого бүхий байнгын ажлын байрыг шинээр бий болгоход зарцуулах учиртай.

Байгууллага хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангадаг бол дараах урамшуулал, хөнгөлөлтөд хамрагдана.

Аж ахуйн нэгж, компаниуд 50%-иас дээш хөдөлмөрлөх чадвараа алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангаснаар "Хөдөлмөр

эрхлэлтийн сан"-гаас тодорхой хөнгөлөлт урамшууллыг хүртэнэ гэж Монгол улсын "Хөдөлмөрийн тухай хууль"-д заасан байдаг. "Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн сан"-д бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг 6 сараас доошгүй хугацаагаар ажиллуулж буй ажил олгогч нь тухайн "Хөдөлмөр эрхлэлтийн сан"-тай гэрээ байгуулдаг байна. Ингэснээр хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгосон эхний 6 сарын цалингийн 60%-ийг Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолтыг үндэслэн буцаан олгодог. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хуулийн дагуу хагас жилээс дээш хугацаагаар ажиллуулсан бол дээрх хувьтай тэнцэх хэмжээний мөнгө танай байгууллагын дансанд буцаж байршина гэсэн үг.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг 18 сараас дээш хугацаагаар ажиллуулж буй бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ буюу 144000 төгрөгийг 5-10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх мөнгийг "Хөдөлмөр эрхлэлтийн сан"-гаас танай компанид буцалтгүй тусламж болгон олгодог бөгөөд тухайн иргэнийг дадлагажуулах замаар ажлын байраар хангасан бол гаргасан зардлыг "Хөдөлмөр эрхлэлтийн сан"-гаас байгууллагад буцаан олгодог.

Мөн түүнчлэн аж ахуйн нэгж, хувь хүн ажлын байр шинээр бий болгосон бол "Хөдөлмөр эрхлэлтийн сан"-гаас хөнгөлөлттэй зээл авах эрхтэй болдог байна. Үүнд, Халамжийн байгууллагад бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулбал нэг хүний орон тоо тутамд нэг сая төгрөг зээлэх эрх үүснэ. Энэхүү зээлийг "Хөдөлмөр эрхлэлтийн сан"-гаар дамжуулан авах бөгөөд хүү нь 1 хувь байдаг. Хэрвээ авсан зээлээ хугацаанд нь буцаан төлбөл зээлийн хүүг "Хөдөлмөр эрхлэлтийн сан"-гаас буцаан олгох журам байдаг. Өөрөөр хэлбэл танай байгууллага хариуцлагатай ажиллаж чадвал хүүгүй зээлээр бизнесээ өргөжүүлж болох юм.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн тухай 159 дугаар конвенцид хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажил олох, ажлын байраа хадгалах, ахиж дэвших адил боломж олгох, тэгш хандах, тухайн ажил нь өөрийн сонголтод нийцэж, хувь хүний боломж чадварыг харгалзсан байх зэрэг нийтлэг хэм хэмжээг заасан байдаг.

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> • Хуулиа сахин биелүүлэх • Хөгжлийн бэрхшээлтэй иргэн тогтвортой ажилладаг • Нийгмийн хариуцлагаа ухамсарладаг • Хүний нөөцөө хангах • Татварын хөнгөлөлт чөлөөлөлт эдлэх • Мэргэжлийн ур чадвар ховор авьяас ашиглах 	<ul style="list-style-type: none"> • Ажлын байрны тохируулга хийх • Ажлын ачаалал даах чадвар муу • Хурд удаан • Бүтээмж бага • Мэргэжлийн ур чадвар хангалтгүй • Ар гэрийн асуудал их • Үүрэг хариуцлага муу • Тогтвортой удаан ажиллах хүсэлгүй

Хүснэгт 14 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах давуу болон сул тал

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах сонирхол бага байдаг шалтгаан

57.6% ХБИ ажиллах боломжтой ажлын байр байхгүй.

51.5% Ур чадвар шаардлагад нийцдэггүй.

36.4% Ажлын байрны тохируулга хийхэд хүндрэлтэй.

63.65 ХБИ ажилд орохоор хандаж байгаагүй.

2020 оны байдлаар нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо 107,075 байна. Үүнээс эрэгтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэний 61,095, эмэгтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэний тоо 45,980 байдалтай байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоог дотор нь тус тусаар авч үзвэл:




График 1 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоог доторх ангилал

“Ажил эрхэлдэг” хэмээн бүртгэгдсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажил эрхлэлтийн статусаар нь судлахад 41.7 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 35.7 хувь нь цалин хөлстэй ажиллагч, 20.1 хувь өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч, 1.6 хувь нь ажил олгогч, 0.3 хувь нь нөхөрлөл, хоршооны гишүүн байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь төсвийн, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагад буюу албан хэвшилд гэрээ байгуулан ажиллах боломж харьцангуй хязгаарлагдмал, эсрэгээр албан бус хэвшилд ажиллах эсвэл цалин хөлсгүйгээр өрхийн үйлдвэрлэл үйлчилгээнд оролцох байдал харьцангуй илүү байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ

- **Мэргэжлийн боловсрол, сургалт**

Монгол Улсын хэмжээнд 83 мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага үйл ажиллагаа явуулж, үүнээс төрийн өмчийн 50, төрийн бус өмчийн 33 байна.

Хөгжлийн бэрхшээлийн ангиллаар авч үзвэл харааны бэрхшээлтэй 223 суралцагч байгаа бөгөөд үүнээс эмэгтэй 119 суралцагч, ярианы бэрхшээлтэй 79, үүнээс эмэгтэй 42 суралцагч, сонсголын бэрхшээлтэй 111, үүнээс эмэгтэй 55 суралцагч, хөдөлгөөний бэрхшээлтэй 116, үүнээс эмэгтэй 63 суралцагч, сэтгэцийн бэрхшээлтэй 58, үүнээс эмэгтэй 33 суралцагч, бусад төрлийн бэрхшээлтэй суралцагч 86 байна.

1) Холбогдоххуультогтоомж

1. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль
2. Боловсролын тухай хууль
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хүрээнд:

Энэ хуулийн хүрээнд мэргэжлийн боловсрол, сургалтын агуулга, зорилго, бүтэц, түүний удирдлага, зохион байгуулалтыг тодорхойлж, иргэнд мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх, мэргэжлийн ур чадвар олгох, дээшлүүлэх сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгад нийцүүлэн зохион байгуулах, энэ үйл ажиллагаанд оролцогчийн эрх, үүрэгтэй холбогдсон харилцааг тусгасан байна. Тус мэргэжлийн боловсрол, сургалтын бүтэц, бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн боловсрол, сургалтын төвүүд хамаарна. Хүмүүжүүлэгчдийг чадваржуулах, мэргэжил дээшлүүлэх сургалтад тогтмол хамруулсан.

Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр

Монгол Улсын хөгжлийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, шаардлагад нийцсэн, иргэдийн хэрэгцээ, авъяас, сонирхолд тохирсон мэргэжлийн болон техникийн боловсролыг шинэчлэн хөгжүүлж, чанар, хүртээмж, үр өгөөжийг дээшлүүлэхэд хөтөлбөр чиглэж байгаа.

Энэхүү хөтөлбөрт мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын шинэчлэлийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодит механизм бүрдүүлж төлөвшүүлэх, үйлдвэрлэлийн хөгжлийн хэрэгцээтэй холбож төрөлжүүлэх, мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт, хөтөлбөрийг шинэчлэх, багш нарыг заах арга зүй болон мэргэшсэн инженер, техникийн ажилтны түвшинд чадваржуулах, сургалтын нөхцөлийг орчин үеийн шаардлагад нийцүүлэх, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах, иргэдийн хэрэгцээнд суурилсан үйлчилгээг нэвтрүүлэх, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх зэрэг асуудлыг тусгасан.

Тус хөтөлбөрт 2019 онд хэрэгжилтийн дунд хугацааны зорилтот түвшинд, 2021 онд зорилтот түвшинд хүрсэн эсэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээр төлөвлөсөн.

ХБИ хөдөлмөр эрхлэхэд тулгардаг хүндрэл, бэрхшээл

- Гадаад төрх, бие бялдрын хөгжил

- Ажлын туршлагагүй
- Дэд бүтцийн хүртээмжгүй байдал
- Ялгаварлан гадуурхалт сөрөг хандлагууд
- Ар гэрийн асуудал
- Боловсролын түвшин ажлын байрны шаардлагад нийцэхгүй

Ажил олгогчдод эерэг хандлагыг төлөвшүүлэх, татварын болон ХЭДС-гийн урамшууллыг сурталчлах, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх.

Мөн тохируулгатай ажлын байр бүрдүүлсэн тохиолдолд гаргасан зардалд татварын хөнгөлөлт үзүүлэх боломжийг судлах. Хуулийн тус заалтын хэрэгжилттэй холбоотой захиргааны тоон мэдээллийн загвараар хандлагыг улирал бүр гаргаж, хуулийн хэрэгжилтийн хяналтыг сайжруулах.

ХБИ ажиллуулах квотыг ХБИ ажиллах боломж, бололцоог харгалзан эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ялгаатай тогтоож болох боломжийг нарийвчлан судлах.

ХБИ-ийн бүртгэл, хөдөлмөр эрхлэх чадавхийг зөв тодорхойлсон мэдээллийн санг хөгжүүлэх, чадавхийг сайжруулсан сургалтыг зохион байгуулах.

ХБИ-ийг хөдөлмөрт зуучлах ажлыг эрчимжүүлэх, энэхүү ажилд мэргэжлийн холбоодын үйл ажиллагааг уялдуулах

Хөгжлийн бэрхшээлтэй нийт хүн ам	
Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүн ам	Олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүн ам

Олдмол хөгжлийн бэрхшээлтэй болох эрсдэл өндөр байгаа нь манай улсын нийт хүн амын өвчлөл, нас баралтын голлох шалтгааны нэг нь осол болж байгаатай холбоотой байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн амыг хөгжлийн бэрхшээлийн төрлөөр, насаар авч үзэхэд бага, залуу насныхны дунд төрөлхийн хөгжлийн бэрхшээлийн

тохиолдол өндөр байснаа нас ахихын хэрээр олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эзлэх хувь хандлага байна.

Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ

Дэлхийн ихэнх улс орнуудын хөгжлийн бэрхшээлийн статистикийн уламжлалт чиг хандлага хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоог тодорхойлоход чиглэгдэж байсан бол сүүлийн үед уг ойлголт нь өргөжин, тэдгээрийн нийгмийн харилцаанд оролцоход тулгарч буй өдөр тутмын хүндрэл, бэрхшээлийг илрүүлэх, шалтгааныг нарийвчлан судлах, хэрэгцээг тодорхойлох зэрэг хөгжлийн өргөн агуулгатай болж байна. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь бусдын адил нийгмийн харилцаанд эрх тэгш оролцож, сайн сайхан амьдрах ёстой гэсэн үзэл санаанд үндэслэн хөгжиж байна. Тогтвортой хөгжлийн зорилго 8 буюу “Тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, бүрэн, бүтээмжтэй ажил эрхлэлт, зохистой хөдөлмөрийг хөхүүлэн дэмжих”-д 2030 он гэхэд эрэгтэй, эмэгтэй бүх хүн, түүний дотор залуу болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бүрэн, бүтээмжтэй ажил, зохистой хөдөлмөр эрхлүүлж, адил үнэ цэнэтэй ажилд адилхан цалин хөлс олгох зорилтыг дэвшүүлсэн.

Энэхүү зорилтыг хангах чиглэлээр Үндэсний статистикийн хороо нь улирал тутам явуулдаг ажиллах хүчний судалгааны түүврийн дизайн, асуулгын бүтцийг өөрчилж, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажилгүйдлийн түвшин, дундаж цагийн хөлсний статистик мэдээллийг бий болгохоор ажиллаж байгаа болно.

2.2 НОРВЕГИ УЛСЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Норвегийн Хүүхэд, залуучууд, гэр бүлийн асуудал эрхэлсэн газар нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах нөхцлийн талаарх мэдлэг, судалгаа, статистик мэдээллийг цуглуулах, системчлэх үүрэгтэй. Энэхүү ажил нь Норвегийн CRPD-ийг дагаж мөрдөж байгааг хянахад онцгой ач холбогдолтой юм. Ингээд бид конвенцийн чухал зүйлүүдийн дагуу зарим гол үзүүлэлтүүдийг танилцуулж байна.


-----Гол санаа-----



Норвегичуудын ойролцоогоор нийт хүн амын 15-20-ыг нь хөгжлийн бэрхшээлтэй буюу тусгай хэрэгцээт хүмүүс эзэлдэг.



3 сурагчийн 2 нь ангиас гадуур тусгай боловсрол эзэмшдэг



2018 онд хөдөлмөрийн насны хүн амын ажил эрхлэлтийн түвшин ойролцоогоор 74% байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд ажил эрхлэлтийн түвшин 44% байна.

Норвегийн хэдэн иргэнд тусгай хэрэгцээ шаардлагатай бэ?

Судалгаа нь хүн амын дунд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эзлэх хувийг тооцоолоход байнга хэрэглэгддэг арга юм. Хүн амын төлөөллийн түүврээс хөгжлийн бэрхшээлтэй иргэн эсэхийг асууна. Норвеги нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй холбоотой асуултуудыг багтаасан хэд хэдэн судалгааг жил бүр явуулдаг. Ажиллах хүчний судалгаа нь эдгээрийн нэг юм. Энэхүү судалгаанд тахир дутуу болох тухай асуултанд хариулах замаар өөрөө тайлагнадаг. “Хөгжлийн бэрхшээл гэж бид таны өдөр тутмын амьдралд хязгаарлалт үүсгэж болзошгүй удаан хугацааны шинж чанартай бие махбодийн болон сэтгэцийн эрүүл мэндийн асуудлыг хэлнэ. Энэ нь жишээлбэл, хараа, сонсгол буурах, унших, бичихэд бэрхшээлтэй болох, хөдөлгөөний дутагдал, зүрх, уушигны асуудал, танин мэдэхүйн бэрхшээл, сэтгэцийн эмгэг, бусад зүйлийг хэлж болно. Таны бодлоор та тахир дутуу юу? ”гэж асуусан асуулга судалгаа авдаг байна.

Энэ графикт 2017 оны Норвегийн 16-66 насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын эзлэх хувийг харуулна.




График 2 норвегийн 16-66 насны хөгжлийн бэрхшээлтэй хүн ам

	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Total	17.3	16.9	17.2	16.1	17.2	16	15.2	16.6	15.4	16.6	18	17
Male	15.7	15.1	15.2	14.8	15.9	14.4	13.6	14.8	13.8	14.8	16	14.9
Female	18.9	18.8	19.2	17.5	18.7	17.7	16.9	18.4	17.2	18.5	20	19.3

Хүснэгт 15 норвегийн 16-66 насны хөгжлийн бэрхшээлтэй хүн ам /хувиар/

Ажиллах хүчний судалгаанд ашигласан тодорхойлолт нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоо жилээс жилд өөрчлөгддөг гэсэн үг боловч ерөнхийдөө хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийт хүн амын 15% -иас 18% -ийг эзэлдэг. 2017 онд Хөдөлмөрийн хүчний судалгаагаар хүн амын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эзлэх хувь 17% байсан нь ойролцоогоор 605 000 хүнтэй тэнцэж байна. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эзлэх хувь нь хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэйчүүдийнхээс өндөр байна. Ажиллах хүчний судалгааны дагуу хүйсийн ялгаа ойролцоогоор 4% байна.

Хандалт

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бие даан амьдрах, амьдралын бүхий л зүйлд бүрэн дүүрэн оролцохын тулд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусадтай

адил тэгш бие бялдрын орчин, тээвэрлэлт, мэдээлэл, харилцаа холбоо олж авах нь чухал юм (Конвенцийн 9-р зүйл. Тусгай хэрэгцээт хүмүүсийн эрх).




График 3 өнгөрсөн нэг жилийн хугацаанд хотын захиргаанд нийтийн тээврээр үйлчлүүлсэн иргэдийн хувь хэмжээ, тоо

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийтийн тээврийн хэрэгслийг нийт хүн амаас бага хэрэглэдэг. Хүмүүсийн дийлэнх нь, түүний дотор тусгай хэрэгцээт иргэд сүүлийн нэг жилийн хугацаанд нийтийн тээврээр үйлчлүүлсэн байна. Гэсэн хэдий ч тусгай хэрэгцээт иргэд нийтийн тээврээр үйлчлүүлдэг нь хүн амынхаас арай бага юм. 2015 онд тусгай хэрэгцээт иргэдийн 65 орчим хувь нь өнгөрсөн онд нийтийн тээврээр үйлчлүүлсэн гэж мэдэгдэж байсан. Нийт хүн ам, тусгай хэрэгцээт хүн амын аль алинд нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү нийтийн тээврийн хэрэгслээр үйлчлүүлдэг. (Эдгээр тоонууд нь нийтийн тээврийн хэрэгслийг хэр давтамжтай ашигладаг болохыг харуулахгүй бөгөөд зөвхөн өнгөрсөн нэг жилийн хугацаанд дор хаяж нэг удаа ашигласан болохыг тэмдэглэх нь зүйтэй.)

Хөгжлийн бэрхшээлийн янз бүрийн хэлбэрүүд байдаг. Хөдөлгөөн багатай хүмүүсийн дунд 58% нь өнгөрсөн жил нийтийн тээврээр үйлчлүүлсэн гэж хариулжээ. Өнгөрсөн жил сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 74% нь нийтийн тээврээр үйлчлүүлсэн нь нийт хүн амынхаас өндөр хувь юм.

Ажил эрхлэлт

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусадтай адил хөдөлмөрлөх эрхтэй. Үүнд ажилаа сонгох боломж нээлттэй, хүртээмжтэй, хүртээмжтэй хөдөлмөрийн зах зээл, ажлын орчинд ажиллах боломж орно.




График 4 Норвегийн иргэдийн ажил эрхлэлт




График 5 Ажил эрхлэлтийн түвшинг насны ангиллаар, 2018 он




График 6 2018 оны 15-66 насны цагийн ажилчид

насны бүлэг	2015	2016	2017	2018
15-24	40.6	35.3	33.9	35.9
25-39	52.9	56.4	52.3	53.2
40-54	47.6	49.2	48	51
55-59	43.9	47.5	44.2	42.9
60-66	30.4	28	29.2	26.9

Хүснэгт 16 хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ажиллах хүчний түвшин насны бүлгээр /хувиар/

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 44 хувь нь хөдөлмөр эрхэлж байна. 2018 онд хөдөлмөрийн насны хүн амын ажил эрхлэлтийн түвшин ойролцоогоор 74% байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд ажил эрхлэлтийн түвшин 44% байв. Статистик Норвеги долоо хоногт дор хаяж нэг цаг ажилладаг хүнийг ажилтай гэж тодорхойлдог. Өөрөөр хэлбэл, ажил эрхлэлтийн энэхүү тодорхойлолт нь маш өргөн хүрээтэй бөгөөд үүнд үндсэндээ хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүс, оюутнууд эсвэл тэтгэмж авахаас гадна цагийн ажил эрхэлдэг хүмүүс хоёулаа багтдаг.

Норвегийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин эдийн засгийн уур амьсгалаас үл хамааран бага хэвээр байгаа бөгөөд үүнийг сайжруулах ажлыг сүүлийн жилүүдэд эрчимжүүлжээ. ЭЗХАХБ-ын бусад орнуудтай харьцуулахад Норвеги муж дундаа оржээ.

Хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 41 хувь нь цагийн ажил хийдэг. Цагийн ажил нь нийт хүн амын тооноос илүү хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дунд түгээмэл байдаг. 2018 онд нийт хүн амын 24 орчим хувь нь цагийн ажил хийдэг байсан бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 41 орчим хувь нь мөн адил хамааралтай байв. Гэсэн хэдий ч ажлын цагийг богиносгох нь илүү олон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажилд орох боломжийг олгодог гэдгийг харгалзан үзэх нь чухал юм.


🚦 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрд оролцох оролцоо

2013 онд сонгуулийн ирцэд хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон нийт хүн амын хооронд ялгаа гараагүй байна. Бүх санал авах байрууд хүртээмжтэй байдаггүй тул энэ нь нааштай дүгнэлт юм.

Улс төр дэх сонирхол ба хуваагдал


Иргэдийн дунд явуулсан судалгаагаар (Difi 2015) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сонгуулиас гадуур дунджаар нийт хүн амаас илүү улс төрийн идэвхтэй байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 21% нь парламентын шийдвэрт нөлөөлөхийг идэвхтэй эрэлхийлж байгаа тухай мэдээлж байгаа бол нийт хүн амын 17% -д мөн адил хамаарна.

- УИХ-ын сонгуульд санал өгөхөөс бусад тохиолдолд та УИХ-ын шийдвэрт нөлөөлөх зүйл хийж байсан уу?



Дүгнэлт

Манай улс болон Норвеги улсын хүн амын харьцуулалт



Манай улсын нийт хүн амаас норвеги улсын нийт хүн ам нь 63%-иар их байгаа ба манай улсын хувьд нийт хүн амын 35%-ийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзлэж байгаа бол Норвеги улсын хувьд нийт хүн амын 11%-ийг нь эзлэж байна. Үүнээс үзэхэд манай улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эзлэх хувь Норвеги улсынхаас харьцангуй өндөр байгаа нь харагдаж байна.

Монгол улсын “Ажил эрхэлдэг” хэмээн бүртгэгдсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажил эрхлэлтийн статусаар нь судлахад 41.7 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 35.7 хувь нь цалин хөлстэй ажиллагч, 20.1 хувь өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч, 1.6 хувь нь ажил олгогч, 0.3 хувь нь нөхөрлөл, хоршооны гишүүн байна. Норвеги улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 44 хувь нь хөдөлмөр эрхэлж байна. 2018 онд хөдөлмөрийн насны хүн амын ажил эрхлэлтийн түвшин ойролцоогоор 74% байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд ажил эрхлэлтийн түвшин 44% байв. Статистик Норвеги долоо хоногт дор хаяж нэг цаг ажилладаг хүнийг ажилтай гэж тодорхойлдог. Өөрөөр хэлбэл, ажил эрхлэлтийн энэхүү

тодорхойлолт нь маш өргөн хүрээтэй бөгөөд үүнд үндсэндээ хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүс, оюутнууд эсвэл тэтгэмж авахаас гадна цагийн ажил эрхэлдэг хүмүүс хоёулаа багтдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь төсвийн, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагад буюу албан хэвшилд гэрээ байгуулан ажиллах боломж харьцангуй хязгаарлагдмал, эсрэгээр албан бус хэвшилд ажиллах эсвэл цалин хөлсгүйгээр өрхийн үйлдвэрлэл үйлчилгээнд оролцох байдал харьцангуй илүү байна.

Монгол улсын хувьд өгөх зөвлөмж :

- ХБИ ажиллуулах квотыг ХБИ ажиллах боломж, бололцоог харгалзан эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ялгаатай тогтоож болох боломжийг нарийвчлан судлах.
- ХБИ-ийн бүртгэл, хөдөлмөр эрхлэх чадавхийг зөв тодорхойлсон мэдээллийн санг хөгжүүлэх, чадавхийг сайжруулсан сургалтыг зохион байгуулах.
- ХБИ-ийг хөдөлмөрт зуучлах ажлыг эрчимжүүлэх, энэхүү ажилд мэргэжлийн холбоодын үйл ажиллагааг уялдуулах.



3

ХУУЛЬ, ЭРХ
ЗҮЙ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ТӨЛӨӨЛЛИЙГ ХАНГАХ АСУУДАЛ

Сүлдийн Номынбаясгалан¹

¹Монголын Криминологчдын холбооны ахлах судлаач

Хураангуй

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд “Бүх шатны сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй хүн саналаа бие даан, чөлөөтэй, нууцаар өгөх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Бүх шатны сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгаа нь хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид хүртээмжтэй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүн бүх шатны сонгуульд нэр дэвших, сонгогдох, төрийн аливаа албанд томилогдон ажиллахад нь улс төрийн нам, эвсэл, төрийн байгууллагууд дэмжих үүрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг сонгогдох эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаар улс төрийн нам, эвслүүд бодлого, мөрийн хөтөлбөртөө тусгана” гэж зохицуулсан байна. Энэ илтгэлийн сэдвийг “Монгол Улсын Их Хуралд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөөллийг хангах асуудал” гэж томъёолон, агуулгыг хөгжлийн бэрхшээлийн тэгш байдлаар хязгаарлав.

Түлхүүр үгс

Хөгжлийн бэрхшээлийн тэгш байдал, квот, үндсэн эрх, бүх шатны сонгууль, сонгох, сонгогдох эрх, сонгуулийн тогтолцоо, улс төрийн антропологи, Монгол Улсын олон улсын гэрээ.

I. Удиртгал

Хууль зүйн толь бичигт “*хөгжлийн бэрхшээл – тахир дутуу хүн*” гэдгийг өвчин, гэмтэл буюу оюун ухааны хомсдлын улмаас амьдралын үйл ажиллагаа нь хязгаарлагдмал болсон ба түүнд нийгэмшлийн хамгаалалт зайлшгүй шаардлагатай байгаа болон бие организмын чиг үүрэг нь үлэмж сарниж, эрүүл мэнд нь муудсан этгээд” гэж тайлбарлажээ (Нарангэрэл С., 2015). Харин засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичигт “Тэгш ба тэгш бус байдал нь үндсэндээ улс төрийн үзэл баримтлал бөгөөд сүүлийн үед тэгш байдлыг орлого дахин хуваарилалтын утгаар нь ойлгохоос илүү нийгмээс гадуурхах гэсэн соёлын агуулгаар нь тайлбарлах, албан ёсны тодорхойлолтоос нийгмийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх гэсэн санаагаар хэрэглэх нь илүү болсон байна. Хөгжлийн бэрхшээл, хүйсний баримжааны улмаас бий болж тогтсон нийгмийн хуваагдал, тэгш бус байдлыг арилгах гэсэн тодорхой

бүлгүүдийн тэмцлийн үр дүнд бий болов. Нийгмийн төрөл бүрийн бүлгүүдийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр тэдний хэрэгцээнд чиглэсэн бодлого явуулах, нийгмийн шударга ёсыг тогтоох тухай үзэл баримтлалыг тууштай баримтлах хандлага нэмэгдэж байна” гэж үзжээ (Даваадулам Ц., 2010). Түүнчлэн нийгмийн зарим үзүүлэлтийн статистик мэдээлэлд эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссоос хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлогдсон хүнийг хамааруулж байна (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Жайка, 2019).

Тэгвэл хууль зүйн үүднээс бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг “хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэж үндэсний болоод олон улсын эрх зүйн хэм хэмжээнд “**НИЙТЛЭГ**” байдлаар тодорхойлж байна. Энэ нь монист, дуалист онолуудын үүднээс хэм хэмжээг “**ТОГТООХ**” талаар олон улсын эрх зүй болон дотоодын хууль тогтоомж нь тусдаа бие даасан эрх зүйн хоёр өөр салбар мэт боловч тэдгээрийг хэрэгжүүлэх нөхцөлд өөр хоорондоо нягт уялдаатай гэдгийг харуулж байна (Сарангэрэл Ч., 2007).

Үндэсний статистикийн хорооны 2019 оны жилийн эцсийн мэдээгээр Монгол Улсад нийт 107,075 (**НИЙТ ХҮН АМЫН 3.3 ХУВЬ**) хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаагаас 34,860 нь нийслэл Улаанбаатар хотод амьдарч байна. Эдгээрээс сонгуулийн насанд хүрсэн буюу 18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэн 95,469 байгаа нь нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 89,2 (%) хувийг эзэлж байна. Тиймээс Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Сонгуулийн ерөнхий хороонд “. . . Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 6.3.6–д “сонгох, сонгогдох эрхээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлээгүй байх” нь ялгаварлан гадуурхах нэг хэлбэр болно гэж үзсэн. Эдгээр иргэдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх боломж, нөхцөлийг дээшлүүлэх зорилгоор Япон улсын туршлага дээр тулгуурлан хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн үйл ажиллагаанд оролцох эрхийг хангахад чиглэсэн” зөвлөмжийг (2020.05.25) хүргүүлсэн байна.

Иймд тухайн нийгмийнхээ бүтцийн тусгал болсон “**ТӨЛӨӨЛЛИЙН**” тухай ойлголтоор хууль тогтоох байгууллага нь зарим талаар “тухайн улс үндэстний толин тусгал” байх ёстой (Эндрю Рейнольдс, 2010) учраас Монгол Улсын Их Хуралд (цаашид “Улсын Их Хурал” гэх) хөгжлийн бэрхшээлтэй иргэн нэр дэвших

болон сонгогдоход (**төлөөллийн**) тодорхой тоог тогтоох зайлшгүй нийгмийн хэрэгцээ, шаардлага үүсээд байна (Номынбаясгалан С., 2020). Ийм учраас олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд “*хөгжлийн бэрхшээлтэй иргэд Улсын Их Хуралд нэр дэвших 5 хувийн квот хүссэн*” тухай нийтлэл цөөнгүй гарсан байна. Энэ илтгэлээр энэ асуудлын талаар хөндөхийг гол зорилгоо болгов. Энэхүү асуудлыг Улсын Их Хурлын сонгуулиудын дүнгийн нээлттэй өгөгдлийн сангийн мэдээлэлд үндэслэн авч үзэв. Учир нь хууль тогтоох дээд байгууллага дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөөллийн асуудал нь ардчиллын суурь зарчмууд, ялангуяа хүний эрх, эрх чөлөө, хөгжлийн бэрхшээлийн тэгш байдлыг тодорхойлоход ихээхэн чухал үзүүлэлтэд тооцогдож болох юм. Тиймээс илтгэлээ ийнхүү нэрлэсний учир энэ билээ.

II. Үндсэн асуудал

Монгол Улс 1992 оноос хойш нийт Улсын Их Хурлын найман удаагийн ээлжит сонгуулийг зохион байгуулсан бөгөөд 1992 оны сонгуульд сонгуулийн насны иргэдийн 95.6 (%) хувь нь сонгох эрхээ эдэлж байсан бол 10 жилийн дараа (буюу 2012 оны сонгуульд) 67.24 (%) хувь болж огцом буурсан байна. Харин 2016 оны Улсын Их Хурлын сонгуулийн ирц 74.35 (%) хувь болж өмнөх сонгуулиас бага зэрэг өссөн үзүүлэлттэй гарсан байна (Эрдэнэдалай Б., 2019). Тэгвэл цар тахлын үеийн буюу Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн хувьд сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн 2,003,969 сонгогчийн 73.65 (%) хувь буюу 1,475,895 нь саналаа өгч оролцсон боловч хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигч иргэн Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдоогүй (түүхэндээ нэг ч удаа сонгогдож) байгаагүй нь хөндөх ёстой асуудал болсныг харуулж байна.

Тиймээс Улсын Их Хурлын гэлтгүй орон нутгийн Хурлын сонгуульд оролцогчдын эрхийг “**тэгш**” хангахын тулд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал байдал, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно гэсэн заалтын шаардлагыг бүрэн хангасан байх ёстой (Совд Г., 1999). Энэ заалт тэгш эрхийн агуулгыг илэрхийлээд зогсохгүй, түүний гол баталгаа нь болж байна (Совд Г., Жамбалдорж О., 1993). Энэ заалтад бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл зэргийг тухайлан заагаагүй боловч тэгш эрхийн ерөнхий үзэл

баримтлалын хүрээнд эдгээр онцлог шинжээр нь хүнийг ялгаварлан гадуурхахыг хориглодог. Үүний үндсэн хуулийн үндэслэл нь “**тэгш байдал**” гэж үзээд тэгш байдлыг төрийн үйл ажиллагааны үндсэн зарчимтай холбон тайлбарлаж ирсэн байна (Энхбаатар Ч., 2016). Зарим улсад “**үндсэн хуулийн ялгаварлан гадуурхахыг хориглох зарчим**” (Сүнжид Д., 2012) гэж нэрлэх нь бий.

Ийнхүү “Тэгш байдлыг хангах нь эрх чөлөөг хангах зарчмаас эх үндэстэй учраас эрх, эрх чөлөөг хангасан цагт тэгш байдал хангагдана” гэж үздэг (Энхбаатар Ч., 2007). Тэгш эрхийг (хүн бүрт эрх тэгш хандах) хэрэгжүүлэхийн тулд тэгш байдлын (адил тэгш хүмүүст адил тэгш, адил тэгш бус хүмүүст адил бус хандах) зарчим хэрэгжих ёстойг харуулдаг (Агар-Эрдэнэ Г., 2013). Энэ нь тэгш байдал “**тэнцүү боломж**” олгодог гэж үзэж болох юм. Түүнчлэн тэгш байдлыг хангах зарчмыг хэрэгжүүлэх эрх зүйн шаардлагыг нийгмийн ерөнхий зарчмуудад ямар төвшинд тусгах бололцоотой бэ? Хүн бүрт тэгш эрх чөлөөг эдүүлэх зарчмыг бодит үнэн болгохын тулд нийгмийн бодит байдалд ямар нөхцөлүүд хангагдсан байх шаардлагатай бэ? гэсэн асуултуудад хэрхэн хариулах нь либерал ардчилал либертар ба нийгмийн чиглэлд хуваагдах шалтгаан нь болдог гэж үздэг.

Иймд үндсэн хуульд “**хөгжлийн бэрхшээл**” гэж шууд нэрлэн тусгагдаагүй боловч Монгол Улсын олон улсын гэрээнд (Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн конвенцод заасан эрх “**үндсэн эрх**”–ийн түвшинд хамгаалагдана гэсэн үг) тодорхойлсон хүний эрх, эрх чөлөөг хөгжлийн бэрхшээлтэй хүн “**бусдын нэгэн адил**” эдлэх, хамгаалуулах боломжтой. Энэ талаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судалгаанд “*Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар үндсэн хуулиар заагдсан хүний эрхийг дэлгэрүүлэн тайлбарласан нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх утгыг бүрэн дүүрэн илэрхийлж өгсөн байна*” гэсэн дүгнэлтийг хийсэн байна (Хууль зүйн судалгааны төв, 2018). Ийнхүү үндсэн хууль болоод олон улсын гэрээгээр баталгаажсан “*хүн бүр ялгаварлан гадуурхагдахгүй байх*” зарчмыг хэрэгжүүлэх нөхцөл журмыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид тусган хэрэгжүүлж байна. Үүнийг бас хөгжлийн бэрхшээлийн тэгш байдлыг хангах (**Disability Equality**) гэж нэрлэж болох юм. Улмаар Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн талаархи Монгол Улсын анхдугаар илтгэлд “*Үндэсний хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль*

тогтоомж, эрх зүйн актуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг алагчлан ялгаварласан заалт одоогоор байхгүй бөгөөд хуулийн хүрээнд тэгш хамгаалуулах боломж хуулиар нээлттэй байна” гэж тэмдэглэсэн байна (Хүний эрхийн үндэсний комисс, 2014).

Түүнчлэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай (4.1.2) хуульд ““хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхах” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын харилцаанд иргэний үндсэн эрх, эрх чөлөөг бусадтай адил тэгш эдлэх, нийгмийн баялгаас тэгш хүртэх, хөгжилд хувь нэмрээ оруулах, тохирох хэрэглэгдэхүүнээр хангагдах боломжийг үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхгүйг ойлгоно” хэмээн тайлбарласны зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй хүн “бүх шатны сонгуульд нэр дэвших, сонгогдоход нь улс төрийн нам, эвсэл, төрийн байгууллагууд дэмжих” үүрэгтэй гэсэн онцлог (30.3) зохицуулалт үйлчилж, тэдгээрийн улс төрийн үйл ажиллагаанд оролцох эрх хэрэгжих нөхцөлийг хангаж өгсөн байна. Энэ нь иргэний “**сонгох, сонгогдох**” эрхийн харилцааг сонгуулийн нэгдсэн хуулиар зохицуулан хөгжлийн бэрхшээлтэй хүн сонгуульд нэрээ дэвшүүлэх замаар төрийн үйл хэрэгт оролцох боломжийг “**жигд**” хангах хөшүүрэг болсон зохицуулалтыг бэхжүүлсэн байна. Ийнхүү Улсын Их Хурлын болон олон нутгийн Хурлын сонгуульд **хөгжлийн бэрхшээлтэй** иргэдийн сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийг хангах боломжийг бүрдүүлсэн гэж үзэж болох юм.

Гэвч үндсэн хууль болоод сонгуулийн тухай хуулиараа “Ялгаваргүйгээр төрийн байгууллагад, сонгуульд сонгох, сонгогдох эрхтэй, улс төрийн харилцаанд хүн бүр тэгш эрхтэй” хэмээн зохицуулсан байдаг боловч бодит байдалд тэгш хамрагдаж чадахгүй байгаагийн нэг жишээ нь “Улсын Их Хурлын сонгуульд сонгогдсон төлөөлөгчдийн дунд “хөгжлийн бэрхшээлтэй иргэн” байдаггүй. Эмэгтэй болон залуу төлөөлөгчдийн тоо хүн амын дунд эзлэх хувьтай харьцуулахад хангалтгүй бага” байна (Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн, 2017). Үүнээс гадна Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн талаархи Монгол Улсын анхдугаар илтгэлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “улс төр, нийгмийн амьдралд оролцох” асуудлыг зөвхөн сонгох эрхийн (**санал өгөх**) хүрээнд авч үзсэн нь учир дутагдалтай байна. Ийм хүмүүст тэгш байдал, тэнцүү боломжийг олгохын тулд зарим улс оронд хүн амд эзлэх хувь хэмжээгээр парламентын суудалд квот тогтоон хадгалсан байна.

Жишээлбэл, Руанда улс үндсэн хуулиараа шийдвэр гаргах түвшний байгууллагын 30 хувийг эмэгтэйчүүдэд, 80 гишүүнтэй Төлөөлөгчдийн танхимийнхаа 24 суудлыг эмэгтэйчүүдэд, гурван суудлыг залуучууд болон **хөгжлийн бэрхшээлтэй** иргэдэд хуваарилсан байна. Энэ нь улс төрийн намуудын хувьд өнөөг хүртэл хөгжлийн бэрхшээлийн тэгш байдлыг хангах талаар тодорхой зорилт бүхий бодлого үгүйлэгдэж байгааг харуулж байна.

Эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн хувьд:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн бүх шатны сонгуульд нэр дэвших, сонгогдоход нь улс төрийн нам, эвсэл, төрийн байгууллагууд дэмжих үүрэг бүхий зохицуулалтыг хэрэгжүүлэхийг оролддог боловч хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчийг бусад нэр дэвшигчийн адил өрсөлд гэсэн нийтлэг зарчим баримталж буй нь учир дутагдалтай байна. Энэ тухай Сонгуулийн менежментийн хувилбарууд хэмээх бүтээлд “хууль тогтоох байгууллагаас сонгуульд оролцох эрхтэй бүх сонгогчдын жинхэнэ оролцоог хангахад (Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгуулийн эрхийн тухай олон улсын (2002) хэм хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сонгуулийн үйл явцад ижил тэгш эрхтэй оролцуулахыг чухалчлан заасан) чиглэсэн үйлчилгээ явуулахыг улам бүр хурцаар шаардах болсон байна. Ийм оролцоог өргөжүүлэхэд чиглэсэн үйлчилгээ өндөр өртөгтэй байдаг учраас энэ асуудлыг хууль тогтоогчид “**төсвийн**” хязгаарлагдмал байдалтай уялдуулан авч үзэх хэрэгтэй” гэж үзсэн байна (Алан Уолл., 2010).

Түүнчлэн сонгуулийн зардлын зарим тайлангуудаас үзвэл, (i) Нам, эвслийн мөрийн хөтөлбөрийг таниулах, (ii) Нэр дэвшигчийг сурталчлах, (iii) Уулзалт, хурал цуглаан зохион байгуулах, (iv) Ажилтан, ухуулагч, шадар туслагчийн хөлс, урамшуулал, (v) Бичиг хэрэг, (vi) Шуудан холбоо, (vii) Шатахуун, унаа, (viii) Томилолтоос сонгуулийн зардал нийтлэг байдлаар бүрдэж, үүнд нэр дэвшигчийн “**хувийн онцлог**” байдалд холбогдох нэмэлт зардал тусгагдаж байгаагүй байна. Энэ байдлыг арилгах үүднээс хөгжлийн бэрхшээлтэй хүн бүх шатны сонгуульд нэр дэвших, сонгогдоход нь улс төрийн нам, эвсэл дэмжих үүрэг хүлээхийн зэрэгцээ, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг сонгогдох эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаар улс төрийн нам, эвслүүд бодлого, мөрийн хөтөлбөртөө тусгах тухай эрх зүйн зохицуулалтыг хөшүүргийг бүрдүүлсэн боловч энэ нь бодит амьдрал дээр хэрэгжиж чадахгүй байна. Цаашлаад сонгуулийн арга хэмжээ нь

аливаа ардчилсан төрийн үндсэн чиг үүрэг тул холбогдох сонгуулийн байгууллагуудын хувьд “**төрийн**” санхүүжилтийн үндсэн эх үүсвэртэй холбон үзэж байна.

Ийм учраас холбогдох сонгуулийн байгууллага бүх шатны сонгуульд нэр дэвшигчдийнхээ “**хувийн онцлог шинж**” байдалд тулгуурлан, түүний хөгжлийн бэрхшээлийн хэлбэрт нь тохирч нийцсэн байдлаар хандах шаардлагатай болсон байна. Ард түмнээс сонгогдон байгуулагдсан байгууллагад хүлээлгэсэн эрх мэдэл нь нэг талаас, сонгуулийн утга учрыг тодорхойлох тул Монгол Улсын Их Хурлыг төрийн дээд байгууллага гэж үзээд байгууллага дахь зан төлөв, харилцааны хэв шинжийн үүднээс авч үзвэл, аливаа байгууллагад зөвхөн дан ганц мэдлэг, мэргэжилтэй албан тушаалтан бус, харин бүх талаар хөгжсөн “**бие хүн**” хэрэгтэй гэж үздэг (Дамдинсүрэн Л., 2009). Өөрөөр хэлбэл, нийгмийн үйл ажиллагаанд идэвхтэй бүтээлч оролцдог ухамсарт хүн болох талаас нь авч үзсэн байна (Цэрэн Г., 2014). Тиймээс эмэгтэйчүүд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зэрэг “нийгмийн бүх бүлгийн төлөөлөл”-ийг шийдвэр гаргах түвшинд гарвал ямар ач холбогдолтой, нийгэмд ямар эерэг үр нөлөө үзүүлэх талаар хөндөх зайлшгүй хэрэгтэй болсныг харуулж байна.

Энэ талаар хийгдсэн зарим судалгааны үр дүнгээс аваад үзвэл:

Төлөөллийн эрх мэдлийн байгууллагын төлөөллийн тоог тогтоох, тооцох зарчмын талаархи лавлагаа хэмээх (2019) судалгаанд “*Парламентын гишүүдийн тоо нь тухайн улс орны нөхцөл байдал, хөгжлийн түвшингээс хамааран янз бүр байх ба парламентын гишүүдийн зохистой тоо хэмжээг тогтооход тухайн улсын парламентын түүхэн уламжлал, улс орны хэмжээ, хүн амын тоо, газар зүйн нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгжүүдийн тоо зэрэг нь нөлөөлөх хүчин зүйлүүд байж болно*” гэж тэмдэглэсэн байна (Монгол Улсын Их Хурлын тамгын газар, 2019). Түүнчлэн дэлхийн улс орнуудын хүн амын тоог парламентын гишүүдийн тоонд харьцуулсан байдал хэмээх судалгаанд “*Нийт 191 улс орныг хамруулж, тухайн улсын хүн амын тоог парламентын танхимын гишүүний тоод харьцуулахад: Парламентын 1 гишүүний төлөөлж буй хүн амын тоог авч үзвэл нийт улс орны 33 (%) хувь нь 20.000 – 40.000 хүртэл иргэнийг төлөөлөн ажиллаж байна гээд Монгол Улсын Их Хурлын нэг гишүүн нь 39.474 иргэнийг төлөөлдөг байна*” гэж тэмдэглэсэн байна (Монгол Улсын Их Хурлын тамгын газар, 2015). Мөн Монгол Улс дахь хөгжлийн

бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох арга замууд хэмээх (2019) судалгаанд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг зохицуулж байгаа 70 гаруй хууль тогтоомж үйлчилж байгаа хэдий ч Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэд ялгаварлан гадуурхалтад өртөж, энгийн хүнтэй адил амьдрах нөхцөл боломжоор хангагдаж чадахгүй байна. Энэ нь хууль тогтоомжийн зохицуулалт дутагдалтай байгаагаас бус харин хууль тогтоомжийн хэрэгжилт сул, санхүү, төсвийн дутагдалтай байдал нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд сөрөг нөлөө үзүүлж байна” гэж дүгнэсэн байна (Монгол Улсын Их Хурлын тамгын газар, 2019). Энэ утгаараа хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүх шатны сонгуульд нэр дэвшин сонгогдох боломжтой эсэхийг сонгуулийн тогтолцооны үүднээс аваад үзвэл, хууль зүйн хувьд нээлттэй хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй иргэн Улсын Их Хуралд гэлтгүй орон нутгийн Хуралд сонгогдох боломж ихээхэн хязгаарлагдмал байна гэсэн дүгнэлтийг цөөнгүй судлаачид хийсэн байдаг (Номынбаясгалан С., 2020).

III. Дүгнэлт

Монгол Улсын Их Хурлын гэлтгүй орон нутгийн Хурлын сонгуульд хөгжлийн бэрхшээлийн тэгш байдлыг хангах зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн санал болгосон квотын талаархи асуудлыг шийдвэрлэхгүй байсаар багагүй хугацааг өнгөрүүлээд байна. Дан ганц квотоор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн оролцоо, төлөөллийг хангах (**төлөөллөө нэмэгдүүлэх**) бололцоогүй. Гэвч квот нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгуульд өрсөлдөх боломжийг нэмэгдүүлэх чухал түлхэц хүчин зүйл болох юм. Энэхүү “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дэмжих квот” нь улс төрийн практикт тохиолдох хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлах, улс төрийн өрсөлдөөнд оруулахгүй байх явдлын эсрэг авч буй арга хэмжээнд тооцогдох болно.

Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бүх шатны сонгуульд нэр дэвших, сонгогдоход нь улс төрийн нам, эвсэл, төрийн байгууллагууд дэмжих төдийгүй сонгогдох эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаар улс төрийн нам, эвслүүд бодлого, мөрийн хөтөлбөртөө тусган улс төрийн үйл ажиллагаанд оролцох өргөн боломжийг хууль зүйн хувьд бүрдүүлсэн боловч энэ нь бодит амьдрал дээр үр дүнтэй хэрэгжихгүй байна. Энэ нь хууль тогтоомжийн зохицуулалт дутагдалтай

байгаагаас бус харин хэрэгжилт сул, санхүү төсвийн дутагдалтай байдал нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн үйл ажиллагаанд оролцох бололцоог хангахад чиглэсэн хууль тогтоомжийн хэрэгжилтэд сөрөг нөлөө үзүүлсэн байж болохыг үгүйсгэх аргагүй юм.

Эцэст нь тэмдэглэхэд, Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулиудын (2020 оны ээлжит сонгуулийн ирц, оролцооны) үр дүнгээс аваад үзвэл, эдгээр сонгуулиудыг мажоритар тогтолцоогоор зохион байгуулж ирсэн нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн оролцоо, сонгогдох боломжийг зарим талаараа хязгаарласан байж болохыг үгүйсгэх аргагүй. Тиймээс пропорционал (холимог) тогтолцоо, түүнд хамаарах хэлбэрүүд хөгжлийн бэрхшээлийн тэгш байдлыг хангахад илүү үр дүнтэй байж болох юм.

IV. Ном зүй

Жайка олон улсын хамтын ажиллагааны байгууллага, (2019). Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа, (хууд. 12). Улаанбаатар

Эндрю Рейнольдс, Бэн Райлли, Эндрю Эллис, (2010). Сонгуулийн тогтолцооны бүтэц зохион байгуулалт, (хууд. 14). Улаанбаатар

Эрдэнэдалай Б., (2019). Залуучуудын сонгуулийн ирц, оролцооны асуудал, Нээлттэй улс төр сэтгүүл, (хууд. 105–106). Улаанбаатар

Совд Г., (1999). Монгол Улсын Үндсэн хууль, Хүний эрх, (Харьцуулсан эрх зүй), (хууд. 118). Улаанбаатар

Совд Г., Жамбалдорж О., (1999). Монгол Улсын Үндсэн хуулийн нэр томъёоны дагалга, (хууд. 61). Улаанбаатар

Энхбаатар Ч., Амаржаргал П., ба бусад, (2016). Монгол Улсын 1992 оны үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ, (хууд. 46). Улаанбаатар

Сүнжид Д., (2012). ХБНГУ–ын Үндсэн хуулийн ялгаварлан гадуурхахыг хориглох зарчим, Эрх зүйн үзэл баримтлал: Шинэ хандлага, (Эрдэм шинжилгээний илтгэлийн эмхэтгэл), (хууд. 49). Улаанбаатар

Дамдинсүрэн Л., (2009). Байгууллага дахь зан төлөв, харилцаа, (хууд. 20–21). Улаанбаатар

Цэрэн Г., (2014). Байгууллагын зан төлөв, (хууд. 42). Улаанбаатар

Монгол Улсын Их Хурлын тамгын газар, (2019). Судалгааны эмхэтгэл, ХХIX боть, (хууд. 364). Улаанбаатар

Монгол Улсын Их Хурлын тамгын газар, (2015). Судалгааны эмхэтгэл, ХХ боть, (хууд. 198). Улаанбаатар

Монгол Улсын Их Хурлын тамгын газар, (2019). Судалгааны эмхэтгэл, ХХVIII боть, (хууд. 272). Улаанбаатар

Номынбаясгалан С., (2020). Цар тахал ба Иргэдийн сонгуулийн ирц, оролцооны асуудал, Шинэ толь сэтгүүл, №81, (хууд. 34–43)

**ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДАЛТЫГ ТОГТООХ ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

Б.Цэнд¹, М.Цэрэнбат²

¹СХД-ийн НДХ, ²АШУУИС-ийн БАС

Үндэслэл

Манай улс нь анх Оросын холбооны улсын туршлага дээр үндэслэж хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох эрх зүйн орчныг бий болгож байсан бөгөөд 1940-өөд онд Улсын төв эмнэлгийн дэргэд одоогийн эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс (ЭХМК) буюу эмнэлэг хөдөлмөрийн экспертизийн комисс байгуулагдсанаар эх сууриа тавьжээ.

1950-иад оны сүүлчээр БНМАУ-ын тэтгэврийн хууль гарсантай холбогдуулан эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм, өвчтөн хүмүүст хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох өвчний жагсаалтыг анх батлан гаргасан байна. 1974 онд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 403 дугаар тогтоолоор ЭХМК-ын дүрмийг дахин шинэчлэн баталж, ЭХМК-уудыг аймаг, хотын клиник болон нэгдсэн тусгай мэргэжлийн эмнэлэг, диспансеруудын дэргэд байгуулж байжээ.

Харин хамгийн сүүлд 2015 онд "Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм", "Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоох, хөдөлмөр зохицуулалт хийх заавар", 2017 онд "Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалт"-ыг тус тус шинэчлэн баталсан байна.

Иймд хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох эрх зүйн орчны өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхийн тулд бусад улс орнуудын туршлагыг судлах, эрх зүйн тогтолцоо ижил улсуудыг харьцуулан судлах шаардлагатай байна. Тухайлбал Оросын холбооны улсын хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримталж буй эрх зүйн зохицуулалтыг судалсан судалгаа хийгдээгүй байгаа нь бидний судалгааны ажлын үндэслэл болсон юм.

Зорилго

Хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах

Зорилт

- Монгол улстай эрх зүйн тогтолцоо ижил улсын хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох онцлогийг судлах;
- Тухайн улсын хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримталж буй ангилал, шалгуурыг судлах

Материал, арга зүй

Судалгааг харьцуулсан судалгааны аргаар хийж гүйцэтгэсэн.

Үр дүн

1919-1929 онд ЗСБНХУ хөдөлмөрийн чадвар алдалтыг эмнэлэг хяналтын комисс тогтоодог байсан бөгөөд 1929 оноос эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс (ЭХМК) үүсгэн байгуулагдаж хөгжлийн бэрхшээлтэй болсон иргэдийн зэрэг, шалтгаан мөн ажлын чадамжийг нөхөн сэргээх, эмчилгээ, халамж зэргийг тогтоодог болсон.

1995 онд эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нь эмнэлэг нийгмийн магадлах товчоо (ЭНМТ) болж өөрчлөгдсөн. Өвчлөл, хөгжлийн бэрхшээлийн бүтэц, түвшингээс хамааран холбооны товчоо болон төв товчоонууд нь ерөнхий, мэргэжлийн (сүрьеэ, сэтгэцийн эмгэг, мэргэжлээс шалтгаалсан, 18 нас хүрээгүй хүүхдийн), холимог гэж хуваагддаг.

70-90 мянган хүн амд нэг ЭНМТ байдаг бөгөөд жилдээ 1.8-2 мянган хүнд үйлчилдэг байна. ЭНМТ нь 8 хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд мэргэжлийн 3 эмч (дотрын эмч, мэдрэлийн эмч, мэс заслын эмч), магадлагч эмч, нарийн бичгийн даргаас гадна нийгмийн ажилтан, сэтгэл судлаач, сэргээн засалч эмч нь шинээр бүрэлдэхүүнд орсон байна.

Товчоо нь иргэнийг хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоож, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бүртгэлжүүлэх болон нөхөн сэргээлтийн чадавхийг тодорхойлох, нөхөн сэргээх арга хэмжээг боловсруулах гэсэн үндсэн хоёр чиглэлээр ажилладаг.

Өвчин, гэмтэл, согогийн улмаас үүдэлтэй хүний биеийн организмын хэвийн ажиллагааны алдагдлын илэрхийлэгдэх зэрэг нь 10-100 хувиар тогтоогдоно. Хүний бие организмын хэвийн ажиллагааны алдагдлыг илэрхийлэх 4 зэрэг байна. (I зэрэг 10-30%, II зэрэг 40-60%, III зэрэг 70-80%, IV зэрэг 90-100%)

18 болон түүнээс дээш настай хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг тодорхойлох шалгуур нь хүний үйл ажиллагааны үндсэн ангиллуудын нэг нь 2 эсвэл 3-р зэргийн хязгаарлагдмал болсон, мөн өвчин, эмгэгээс үүдэлтэй хүний бие организмын хэвийн ажиллагааны алдагдлын II болон түүнээс дээш зэргээр алдагдах (40-100 хувь) юм.

Мөн зөвхөн өвчин, эмгэгээс гадна өөртөө үйлчлэх чадвар, өөрөө явах хөдлөх чадвар, чиг баримжаа олох чадвар, харилцах чадвар, зан байдлаа хянах чадвар, суралцах чадвар, хөдөлмөрлөх чадвар зэрэг хүний үйл ажиллагааг харгалзан үзэж хувь тогтоодог байна.

Дүгнэлт

Харьцуулсан эрх зүйн судалгаанд хамрагдсан ОХУ-ын хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох эрх зүйн орчин манай улстай харьцуулахад илүү боловсронгуй болох нь бидний судалгаагаар тогтоогдлоо.

Хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримталж буй ангилал, шалгуурыг судлахад ОХУ-д хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоохдоо зөвхөн өвчин, эмгэгийн үе шатнаас гадна биеийн үйл ажиллагааны алдагдлыг харгалзан үздэг байна.

Зөвлөмж

Цаашид харьцуулсан судалгааг үргэлжлүүлэн улмаар Монгол улсын хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Ашигласан хэвлэл

[1] Баасандорж Б. Эмнэлэг-хөдөлмөрийн магадлалын ажлын өнөөгийн байдал, цаашдын зорилт. Монголын анагаах ухаан. 1990;1(73).

Нийгмийн даатгалын тухай хууль. Улаанбаатар. 1994.

[2] Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн эмхтгэл. Улаанбаатар: "Виндзор" хэвлэх үйлдвэр; 2016.

[3] Эмнэлэг хөдөлмөрийн магадлалтай холбоотой тушаал, шийдвэрийн эмхтгэл. Улаанбаатар. 2019.

[4] ОХУ-ын Хөдөлмөрийн яамны 2016.07.05-ны өдрийн №346 тоот тушаал

**ГАМШГИЙН ҮЕД НИЙГМИЙН ЭМЗЭГ БҮЛГИЙГ ХАМГААЛАХ
ТӨРИЙН БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

Ц.Ганчимэг¹

¹Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн
дэд профессор, дэд хурандаа

Хураангуй

Аливаа улс гүрэн нийгэм, эдийн засаг, улс төрөөс үл хамааран хүн байгаа нөхцөлд түүний мөн чанар, хүн гэсэн утгаар нь хамгаалах, амьдрах нөхцлийг хангах нь зүй ёсны асуудал байдаг.

Нийгмийн хөгжлийн үе шатыг дагаж өөр өөрийн онцлог бүхий нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлж ирсэн ба хөгжлийн эхэн үед хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон ахмадуудад, дайнд гавъяа үзүүлсэн дайчдад туслалцаа үзүүлэх хандлага давамгайлж байсан бол явцын дунд гэр бүлийн хүрээнд анхаарах чиглэл бий болсон байдаг.

Ямар ч улс оронд гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажлыг амжилттай хэрэгжүүлэхэд энэхүү үйл ажиллагаанд оролцогч төр, орон нутгийн захиргааны болон аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус олон нийтийн байгууллага, иргэд, олон улсын болон хандивлагч орнуудын оролцох эрх, үүрэг, харилцаа хамтын ажиллагааг нарийн зохицуулсан хууль, эрх зүйн баримт бичгийг батлан мөрдөж хэрэгжүүлдэг байх нь ихээхэн ач холбогдолтой.

Гамшгаас хамгаалах болон нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг хамгаалах тухай хууль тогтоомжууд нь бусад олон хуулийн адил Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцсэн байх шаардлагатай. Монгол Улсын Их Хурал 2003 онд анх удаа “Гамшгаас хамгаалах тухай хууль”-ийг баталж, мөрдөж эхэлснээр гамшгаас хамгаалах үйл ажиллагааны орчин шинэчлэгдэн, хүн амын аюулгүй орчинд амьдрах нөхцөл бололцоог хангахад чухал ач холбогдолтой эрх зүйн баримт бичиг болсон хэдий ч гамшгийн эрсдэлийг бууруулахын тулд нас, хүйс, хөгжлийн бэрхшээлээр ангилсан мэдээлэл, уламжлалт мэдлэгээр баяжуулсан хүртээмжтэй, шинэчлэгдсэн, өргөн хүрээтэй, шинжлэх ухаанд суурилсан, нийтэд зориулсан мэдээллийг нээлттэй солилцох, түгээх талаар шийдвэрийг эрх зүйн зохицуулалттайгаар гаргах нь нэн шаардлагатай юм.

Түлхүүр үг: Нийгмийн эмзэг бүлэг, төрийн бодлого, эрх зүйн зохицуулалт,

Оршил

Улс орон бүр өөр өөрийн эдийн засгийн хөгжил, амьдралын баталгаат түвшний үзүүлэлтээс хамаарч хүн оршин байх нөхцлийг үгүйсгэх болон түүнийг нь алдагдуулах нөхцөл шалтгааныг тогтоох, ингэхдээ өөр өөрийн онцлог байдлыг тусгасан ухагдахууныг гаргаж ирсэн байдаг. Ингэснээр нийгмээс хамааралтай эрсдэл гэсэн ойлголт бүрэлдэж уг эрсдэлд байгалийн жамаар үүсэх (өтлөх,

хөдөлмөрийн чадвар алдагдах, хүүхэд төрүүлэх, асран хамгаалалт, харгалзан дэмжилтийг шаардсан насанд хүрээгүй хүүхэд байх) эрсдэл, оршин буй нийгэм-эдийн засгийн харилцаанаас хамаарсан (ажилгүйдэл, хүн амын бодит орлогын хэмжээ буурч ядууралд нэрвэгдэх, эдгээрээс хамаарч хүн орчиндоо зохицох чадваргүй болох) эрсдэл гэж ангилагдаж байна. Эдгээр эрсдэлийг зөв тодорхойлж чадсанаар, улс орны нийгмийн хамгааллын тогтолцоо баталгаатай, оновчтой, зайлшгүй шаардлагатай байх нөхцөл бүрдэнэ.

Монгол улс нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхдээ нийгмийн хамгааллын үүрэг, хамрах хүрээг нэмэгдүүлж гамшгийн эрсдэлийн буюу байгалийн аюулт үзэгдэл, техникийн томоохон осол, гал түймэр, хүн, мал, амьтан, ургамалын гоц халдварт өвчний өргөн тархалт болон нийгмийн шалтгаантай хүчирхийллийн нөлөөгөөр хүмүүсийн эрүүл мэнд амь насанд аюул тохиолдож, тэдний эд хөрөнгө, эдийн засаг, хүрээлэн буй орчинд хохирол учирсан буюу учруулахуйц гамшгийн нөхцөл байдлын үед авах арга хэмжээг тодорхойлох, механизмыг бүрдүүлэх шаардлагатай болсон. Өөрөөр хэлбэл гамшгийн янз бүрийн үе шатанд болон тайван цагт гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, аврах хүч хэрэгсэл, удирдлагын шуурхай үйл ажиллагааг бүх түвшинд хангахдаа нийгмийн эмзэг бүлэгт тохирсон арга, хэрэгслийг тухайлан зохицуулах зайлшгүй шаардлага бий болсон.

Сүүлийн 20 жилд уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарал болон хүний зохисгүй үйл ажиллагааны нөлөөгөөр манай улсад ган, зуд, аянга, аадар бороо, хүчтэй шороон болон цасан шуурга, мөндөр, уруйн үер зэрэг байгаль, цаг агаарын аюулт үзэгдлийн тоо, төрөл нэмэгдэж, тэдгээрийн давтамж ойртон, үүний улмаас нийгэм, эдийн засагт учруулсан хохирлын хэмжээ 2 дахин нэмэгдсэн байна. Монгол орны агаарын хэмийн жилийн дундаж 2050 он гэхэд 2.1-3.0 хэмээр дулаарах урьдчилсан тооцооноос үзэхэд цаашид хүний эрүүл мэнд, амь нас эрсдэх, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд аюул, хохирол учруулах явдал мөн хэмжээгээр нэмэгдэх хандлагатай байна.

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд гамшгийн улмаас олон хүний амь нас үрэгдэж, хүн ам, олон нийт, улс орны аюулгүй байдал, сайн сайхан аж байдалд сөргөөр нөлөөлж, нийтдээ 700 гаруй мянган хүн амь насаа алдаж, 1.4 сая гаруй хүн, эмэгтэйчүүд, хүүхэд, эмзэг бүлгийн иргэд харилцан адилгүй гэмтэж бэртэн нэрвэгдэж, 23 орчим сая хүн орон гэргүй болсон байна.

Гамшгийн нөлөөллөөс үүсэх хор уршгийг хохирол багатай даван туулах асуудал нь гамшгаас хамгаалах чадавхиас ихээхэн хамаарах ба гамшгаас хамгаалах чадавхийг дэлхийн улс орнууд гамшгаас хамгаалах эрх зүйн зохицуулалт, гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоо, эдийн засаг, нийгэм, хүн амын эмзэг байдлын түвшин, эдгээрийн үнэлгээ, гамшгийн эмзэг байдлыг бууруулах арга хэмжээ, байгалийн болзошгүй аюулыг эртнээс сэрэмжлүүлэх хүчин чадал, мэргэжлийн боловсон хүчний хангамж, аврах ажлын багаж, техник хэрэгслийн хангалт, хүн амын гамшгаас хамгаалах боловсрол болон бараа, материалын нөөц бүрдүүлэлтийн боломжоор ойлгож байна.

Аливаа болзошгүй гамшигтай тэмцэх, аль болох хамгийн бага хохирол амсах нь гамшгийн удирдлагыг хэрхэн зөв оновчтой хэрэглэснээс шууд хамаардаг.

Гамшиг, онцгой байдлын үе дэх нийгмийн эмзэг бүлгийн асуудал сүүлийн үед өргөн хүрээнд яригдах болсон. Тиймээс эрсдэлийн шалтгааныг арилгах, эрсдэл тохиолдоход учирч болох хор уршгийг бууруулах нэг хүчин зүйл нь нийгмийн эмзэг бүлгийг тодорхойлж, гамшгийн үед тэдний эрхийг хамгаалах явдал юм.

Нийгмийн эмзэг бүлгийн хамгаалах чиглэлээрх төрийн бодлого, эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдлыг олон улсын болон үндэсний эрх зүйн зохицуулалтын хүрээнд авч үзье:

Гамшиг, онцгой байдлын үед нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, нийгмийн харилцаанд оролцуулах ажил нь гамшгийн байдлыг даван туулахад хэрэгтэй бөгөөд гамшгийн үеийн эзмэг бүлгийн иргэдийн хамгааллын үндсэн үйлчилгээг онцгой анхаарах шаардлагатай. Учир нь нийгмийн эмзэг бүлгийн иргэд асран хамгаалах, харгалзан дэмжих хүнгүй, өөрөө өөртөө туслах боломжгүй, хөдөлгөөн хязгаарлагдмал, хэлж ойлгуулах, тусламж хүсэх чадвар хомс байдгаас **эмзэг бүлэгт** багтдаг.

Гамшгийн үед хамгаалалтад авах шаардлагатай нийгмийн эмзэг бүлгийг хэрхэн тодорхойлж ирснийг судлан үзвэл 1998 онд баталсан Нийгмийн халамжийн тухай хуульд “Бие даан амьдрах чадваргүй, тэжээн тэтгэх төрөл садангүй, ганц бие ахмад настан, тахир дутуу хүн, бүтэн өнчин хүүхэд болон нэн ядуу амьдралтай ахмад настан, тахир дутуу хүн, олон хүүхэдтэй эх /эцэг/, нэн ядуу амьдралтай хүнийг ойлгоно” хэмээн заасан байна.

2012 онд шинэчилсэн найруулж баталсан Нийгмийн халамжийн тухай хуульд зааснаар “Нийгмийн халамж” гэж эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг хэлдэг ба гамшгийн үед өндөр настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийн аль аль нь нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа авах боломжтойг тусгаж өгсөн. Мөн түүнчлэн халамж хүртэх эрхтэй субъектыг дараах байдлаар тодорхойлсон байдаг.

Үүнд:

- Ахмад настан гэж ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүнийг;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэж Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүнийг;
- “Байнгын асаргаа шаардлагатай иргэн” гэж бусдын туслалцаагүйгээр өдөр тутмын үйлдлээ бие даан гүйцэтгэх чадваргүй, эсхүл оюуны хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй хүнийг;
- “Бүтэн өнчин хүүхэд” гэж эцэг, эх нь тогтоогдоогүй, эсхүл эцэг, эх нь хоёул нас барсан, сураггүй алга болсон, эрх зүйн чадамжгүй, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, түүнчлэн эцэг тодорхойгүйн улмаас эхтэйгээ амьдарч байгаад эх нь нас барсан, гэр бүл салсны улмаас асрамждаа авсан эх /эцэг/ нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийг;
- Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ гэж асран хамгаалах, харгалзан дэмжих төрөл, садангүй бөгөөд бие даан амьдрах чадваргүй, ганц бие, байнгын эмчилгээ, асаргаа шаардагдах ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүнчлэн хүнд нөхцөлд байгаа хүүхдийг байрлуулан хоол, хувцас, эмнэлэг, соёл, ахуй, сэтгэл зүй, асаргаа сувилахуйн үйлчилгээ үзүүлэх, тэдний амьдралын хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, хууль ёсны эрх ашгийг нь хууль тогтоомжид заасны дагуу хамгаалах үйл ажиллагааг;

- “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ” гэж иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор өрх, иргэнд дэмжлэг туслалцаа, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг тус тус ойлгохоор заасан.

Харин тэжээгчээ алдсан гэх ойлголтын хувьд нэг талаасаа гэр бүлийн гишүүн, тэжээгч нь нас барсан эсвэл шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу тухайн этгээдийг нас барсанд тооцсон байх явдал юм. Тэжээгч нас барсан гэх ойлголтонд иргэнийг сураггүй алга болсонд тооцох, иргэнийг нас барсанд тооцох гэсэн ойлголтууд гарч ирэх ба Монгол Улсын Иргэний хуулиар зохицуулсан байдаг. Тэжээгчээ алдсаны тэтгэвэрийг дараах этгээд авахаар зохицуулсан.

Үүнд:

- хууль ёсоор тэжээх өөр хүн байгаа эсэхийг харгалзахгүйгээр төрүүлсэн буюу үрчлэн авсан 19 нас хүрээгүй хүүхэд /үүнд эцгээ нас барснаас хойш мэндэлсэн, төрсөн хүүхэд нь хамаарна/;

- хууль ёсоор тэжээх өөр хүнгүй 19 нас хүрээгүй ач, зээ, төрсөн дүү;

- тэжээгчийн асрамжид байсан төрөлхийн тахир дутуу буюу 16 нас хүрээгүй байхдаа тахир дутуу болсон хүүхэд, ач, зээ, төрсөн ах, эгч, дүү;

- эрэгтэй нь 60, эмэгтэй нь 55 нас хүрсэн буюу эсхүл тахир дутуу болсон эцэг, эх, эхнэр, нөхөр, хууль ёсоор тэжээх өөр хүнгүй өвөг эцэг, эмэг эх, төрсөн ах, эгч, дүү;

- найман нас хүрээгүй хүүхэд, хууль ёсоор асрах хүнгүй төрсөн дүү, ач, зээг нь асарч ажил хийгээгүй байгаа эцэг, эх буюу нөхөр, эхнэрийн аль нэг /нас,хөдөлмөрийн чадварыг харгалзахгүйгээр/ .

Дараах иргэд гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн нэгэн адил тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй. Үүнд:

- өндөр насны, эсхүл тахир дутуугийн тэтгэвэр авч байгаад нас барсан, түүнчлэн нас барахын өмнөх саруудад хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан даатгуулагчийн гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд;

- дагавар хүүхэд нь тэжээгч байгаад нас барсан бол хойт эцэг, эх нь төрсөн эцэг, эхийн адил;

- төрсөн эцэг, эхээс шүүхийн шийдвэрээр тэтгэлэг авдаггүй хүүхэд хойт эцэг буюу эхийгээ нас барахад төрсөн хүүхдийн адил;

- даатгуулагч сураггүй алга болсон нь шүүхийн шийдвэрээр тогтоогдож, уг шийдвэр хүчинтэйд тооцогдсон тохиолдолд түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд.

Хүн амын насны бүтэц, дундаж насны хэтийн төлөвийг харгалзан иргэдийн нийгмийн хамгааллыг баталгаатай бүрдүүлэх нийгмийн шударга ёсыг дээдлэх, хувь хүний оролцоонд тулгуурласан тогтолцоонд шилжих зорилтыг иш үндэс болгон өндөр настан гэх ойлголтыг бий болгосон. Ахмад настан гэж 60, түүнээс дээш настай эрэгтэй, 55, түүнээс дээш настай эмэгтэй хамаарах ба тэдний эрхийг хуулиар хамгаалахаар заасан байдаг. Ингэхдээ ахмад настны эрхийг тусгайлан заасан боловч гамшгийн эрсдэлийн үед хэрхэн хамгаалуулах талаарх нарийвчилсан зохицуулалт байхгүй байна.

Харин Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1-д зааснаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хамааруулахаар заасан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт “Хүний амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул, нийтийн эмх замбараагүй байдал, дайн бүхий байдал зэрэг онцгой байдал бий болох үед хөгжлийн бэрхшээлтэй хүнд энэ тухай хүртээмжтэйгээр мэдээлэх, тухайн үед амь нас, эрүүл мэндийг нь онцгой байдлын нөхцөлтэй уялдуулан хамгаалах үүргийг төрийн холбогдох байгууллага хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлнэ”, 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэгт “Сонсголын бэрхшээлтэй хүн цагдаа, эрүүл мэндийн байгууллага, онцгой байдлын албаны тусгай дугаарт текст мессэж, дохионы хэлний хэлмэрчийн зайн дүрс, ярианы тусламжтайгаар хандаж, үйлчилгээ авах боломжийг төрөөс бүрдүүлнэ” гэж тус тус заасан байна.

Албан ёсны статистикийн мэдээлэл буюу нийгмийн зарим үзүүлэлтийн жилийн мэдээнд эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссоор хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлогдсон хүнийг хамруулж байна. Хөгжлийн бэрхшээлийн төрлийг төрөлхийн ба олдмол гэсэн ангиллаар тодорхойлсон. Тухайн хүнд удамшлын шинжтэйгээр бий болсон хөгжлийн бэрхшээлийг төрөлхийн, амьдралын явцад бий болсон хөгжлийн бэрхшээлийг олдмол гэсэн төрөлд хамааруулж, хөгжлийн

бэрхшээлийн хэлбэр нь бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согог нь тухайн иргэнд ямар байдлаар илэрч байгаатай холбоотой бөгөөд харааны, ярианы, сонсголын, хөдөлгөөний, сэтгэцийн, бусад (эдгээрээс бусад болон хавсарсан) гэсэн 6 ангиллаар авч үзэж байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт “Хүүхэд хамгаалал нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой олон талт, цогц, мэргэшсэн үйл ажиллагаанаас бүрдэнэ” гээд 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэгт “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд гэж эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, *эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийг*” ойлгохоор заасан. Түүнчлэн эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах, нийгмийн харилцаанд дасган зохицуулах, гэр бүлд нь эргэн нэгтгэх үе шат бүхий хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний талаар нарийвчлан зохицуулсан байна.

Нийгмийн эмзэг бүлэгт тулгамдаж буй гамшгийн талаар болон гамшгаас хамгаалах ажлыг хууль эрхийн акт, баримт бичгээр зохицуулаагүйгээс түүнийг хэрэгжүүлэх явцад олон төрлийн ээдрээтэй хүнд тулгамдсан асуудал гарч үүнийг дагасан учрах хохирлын хэмжээ байнга нэмэгдэж байдаг. Үүний нэгэн адил гамшиг, онцгой байдлын үед нийгмийн эмзэг бүлгийн хамгааллын нарийн төвөгтэй асуудлыг ч хууль тогтоомж, бодлого зохицуулалтаар ханган ажиллах асуудал өнөөдөр тулгамдаж байна.

2003 онд анх Гамшгаас хамгаалах тухай хуулийг баталж гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, онцгой байдлын байгууллага болон гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулж ирсэн.

Гамшгийн үед нийгмийн эмзэг бүлгийг хамгаалахтай холбоотой олон улсын эрх зүйн баримт бичгийг судлан үзвэл нарийвчилсан зохицуулалт байхгүй боловч тэдний нийгмийн хамгааллыг бий болгохтой холбоотой дараах зохицуулалтууд байна.

Тухайлбал,

- Хүний эрхийн түгээмэл тунхаглал

- Хүүхдийн эрхийн тухай конвенц, НҮБ 1989 он
- Ерөнхий Асамблейн 1992 оны 10-р сарын 16-ны өдрийн №475 тогтоол, “Насжилтын талаарх тунхаглал”
- Саламанкагийн тунхаглал 1994 он
- Дакарын үйл ажиллагааны хүрээ “Бүх нийтийн боловсролын талаар гаргасан баримт бичиг” 2000 он
- “Биеийн үйлдэл, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал (ICF ангилал)” Дэлхийн эрүүл мэндийн байгууллага 2001 он
- “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сэргээн засах, тэгш боломж олгох, ядуурлыг бууруулах, нийгэмшүүлэх хамтарсан бичиг баримт” Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллага 2004 он
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, НҮБ 2006 он
- Хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагын Удирдамж” Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Хөгжил, хөгжлийн бэрхшээлийн олон улсын консорциум 2010 он
- НҮБ-ын 64 дүгээр ассамблейн A/RES/64/131 тогтоол
- “Хөгжлийн бэрхшээлийн талаарх дэлхийн тайлан” Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Дэлхийн банк 2011 он
- Хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагын дэлхийн анхдугаар чуулганаас гаргасан “АГРА Тунхаглал” 2012 он
- Ази, Номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан “Эрхийг бодит болгоё” Инчеоны стратеги 2012 он
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт
- НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хөтөлбөр-2030

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 22-р зүйлд “Хүн бүр нийгмийн гишүүний хувьд нийгмийн халамж эдлэх, түүнчлэн нэр төрөө хадгалах, биеэ боловсруулж хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ улс төрийн бүтэц, нөөц бололцоотой уялдуулан үндэсний хүчин чармайлт хийгээд олон улсын хамтын ажиллагааны замаар хэрэгжүүлэх эрхтэй” гэж заасан нь бүх нийтийн эрхийг хангасан заалт юм. Мөн Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн

тухай олон улсын пактын “оролцогч улсууд нийгмийн даатгалыг оролцуулан хүн бүрийн нийгмийн хангамжинд хамрагдах эрхийг хүлээн зөвшөөрнө” гэсэн заалтаар баталгаажина.

1994 оны ЮНЕСКО-гийн Саламанкагийн мэдэгдэлд “Сургуулиуд хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгмийн гарал, сэтгэлийн хөдөлгөөн, хэл яриа болон бусад нөхцөл байдлыг үл харгалзан хүүхэд бүрийг авч сургах ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй ба авьяаслаг хүүхдүүд, хараа хяналтгүй ба ажил, хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд, алслагдсан ба нүүдэлчин өрхийн хүүхдүүд, хэл, соёл ба үндэсний цөөнхийн хүүхдүүд болон бусад ялгаварлан гадуурхагдсан бүлгийн хүүхдүүд бүгд сургуульд хамрагдах ёстой гэж тэмдэглэсэн байдаг. Тэгш хамруулах боловсрол нь бүх хүүхэд, залуучууд болон насанд хүрэгчдийн сурах хэрэгцээг хангахад чиглэгдсэн бөгөөд энэхүү үзэл баримтлал нь 1990 оны Бүх нийтийн боловсролын дэлхийн бага хурал болон Тусгай хэрэгцээт боловсролын асуудлаарх Саламанкагийн мэдэгдлийн суурь болж Дакарын боловсролын форумар дахин баталгаажсан.

Хүүхдийн эрхийн тухай конвенцийг 1989 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр баталж, 1990 оны 9 дүгээр сарын 2-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон бөгөөд Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэмд тунхагласан зарчмуудын дагуу нийгмийн бүх гишүүдийн угаас заяасан нэр төр, тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь дэлхий дахинд эрх чөлөө, шударга ёс, энх тайвныг хангах үндэс болно гэж үзэж, Нэгдсэн Үндэстний ард түмэн дүрэмдээ хүний үндсэн эрх, хувь хүний нэр төр, үнэ цэнэд итгэдгээ нотолж, нийгмийн дэвшлийг хангах, амьдралын түвшинг дээшлүүлэхэд илүү эрх чөлөөтэйгээр дэмжлэг үзүүлэх саналтай байгааг анхаарч, Хүний эрхийн түгээмэл тунхаглалд хүүхэд онцгой халамж, туслалцаа авах эрхтэй гэж тунхагласныг санаж, гэр бүл, түүний гишүүдийн, ялангуяа хүүхдийн өсөж бойжих, аж төрөх жам ёсны орчин, нийгмийн үндсэн нэгж болохын хувьд нийгэмд хүлээх хариуцлагыг бүрэн хэмжээгээр үүрүүлэхэд шаардлагатай хамгаалалт, туслалцаа хүртэх ёстойг ойлгож, аз жаргал, хайр, ойлголцол бүхий гэр бүлийн орчинд өсөж бойжих нь хүүхдийн бүрэн, өв тэгш хөгжлийг хангах болохыг хүлээн зөвшөөрч, хүүхдэд ийм онцгой халамж тавих шаардлага байгаа тухай Хүүхдийн эрхийн тухай 1924 оны Женевын тунхаглал, Ерөнхий Ассамблейгаас 1959 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр баталсан Хүүхдийн эрхийн тунхаглал болон Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн

эрхийн тухай олон улсын пакт /тухайлбал 23, 24 дүгээр зүйлүүд/, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт /тухайлбал 10 дугаар зүйл/, түүнчлэн хүүхдийн аж байдлын асуудал эрхэлсэн олон улсын болон төрөлжсөн байгууллагуудын холбогдох баримт бичиг, дүрэмд тусгагдаж хүлээн зөвшөөрснийг анхааралдаа авч энэхүү конвенцийг баталсан. Уг конвенцийн 3 дугаар зүйлд “Оролцогч улсууд хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч буюу түүний төлөө хуулийн дагуу хариуцлага хүлээх бусад этгээдийн эрх, үүргийг харгалзан, хүүхдийг хамгаалах, халамжлах зорилгоор хууль тогтоох болон захиргааны бүхий л зохистой арга хэмжээг авна” хэмээн заасан.

1991 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблей ахмад настнуудад чиглэсэн “Нэгдсэн Үндэстний зарчмууд”-ыг гаргасан ба энэ нь прагматик шинжтэй чухал баримт бичигт тооцогддог. Уг баримт бичгээр ахмад настны бие даан амьдрах эрх (independence), нийгмийн амьдрал дахь оролцоо (participation), нийгмийн халамж үйлчилгээ (care), өөрийгөө хөгжүүлэх боломж (self-fulfillment), эрхэм чанар (dignity) зэргийг тухайлан авч үзжээ.

Эдгээр зарчмууд нь Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад заасан эрхүүдтэй нягт хамааралтай 5 хэсэгт хуваагддаг.

Нэгдүгээрт, “Бие даан амьдрах эрх” гэсэн хэсэгт хүрэлцээтэй хоол хүнс, ус, орон байр, хувцас, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, цалин хөлстэй ажиллах боломж, сурч боловсрох бололцоо хамаарна.

Хоёрдугаарт, “Оролцоо” гэсэн хэсэгт ахмад настнууд өөрсдийн сайн сайхан амьдралд нөлөөлөх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх ажилд идэвхитэй оролцох, залуу үетэйгээ өөрсдийн мэдлэг, туршлагаа хуваалцах мөн эвлэлдэн нэгдэх, хөдөлгөөнд оролцох боломжийг тусгажээ.

Гуравдугаарт, “Халамж” болон онцгой байдлын үед гамшгаас хамгаалах гэсэн хэсэгт ахмад настнууд гэр орондоо, эсхүл эмнэлэгт байх үедээ гэр бүлийн халамж, эрүүл мэндийн үйлчилгээ хүртэж, хүний язгуур эрх, эрх чөлөөг эдлэх ёстойг тусгаж ялангуяа нийгмийн халамж, үйлчилгээний түвшинд ахмад настан гэр бүлийн болон нийгмийн түвшинд тухайн улсын соёл, зан заншлын онцлогт нийцсэн нийгмийн халамж үйлчилгээг тухай бүр авах, өөрсдийн бие даасан байдлаа хадгалж үлдэхэд шаардлагатай нийгмийн болон хууль зүйн үйлчилгээг хүртэх боломжтой байх тухай дурджээ.

Дөрөвдүгээрт, “өөрийгөө хөгжүүлэх боломж” гэсэн хэсэгт ахмад настнууд өөрсдийн нийгэм дэх боловсрол, соёл, оюун санаа болон нөхөн сэргээх нөөц бололцоог хүртэх замаар өөрсдийгөө бүрэн хөгжүүлэх боломж эдлэх ёстой гэсэн зарчим байна.

Тавдугаарт нь “эрхэм чанар” гэсэн хэсэгт ахмад настнууд бусдаар хүндлүүлэн, аюулгүй амьдарч, мөлжлөг, биеийн болон сэтгэл санааны дарамтаас ангид байж, нас, хүйс, яс үндэс, арьсны өнгө, гарал үүсэл, хөгжлийн бэрхшээл, эд хөрөнгийн байдал, бусад нөхцөл байдлаас үл хамааран эрх тэгш байх ёстой бөгөөд эдийн засагт оруулсан хувь нэмрээсээ үл хамааран үнэлэгдэх гэсэн хэсэгт хуваан авч үзсэн байна.

Энэ пактад ахмад настны эрхийг тусгайлан тодорхойлоогүй ч пактын 9 дүгээр зүйлд “Энэхүү Пактад оролцогч улсууд нийгмийн даатгалыг оролцуулан, хүн бүрийн нийгмийн хангамжид хамрагдах эрхийг хүлээн зөвшөөрнө” мөн онцгой нөхцөлд гамшгаас хамгаална гэсэн нийгмийн хамгааллын нэг хэлбэрийг баталгаажуулжээ.

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын зохицуулалт нийгмийн бүхий л гишүүдэд чиглэсэн учир уг пактад заасан бүх эрхийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд мөн адил эдлэх эрхтэй юм. Цаашилбал, өндөр настны эрхийн талаар тодорхой арга хэмжээ авах шаардлага байдаг тул Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад нэгдэн орсон улсууд өөрийн нөөц бололцоог боломжит дээд хэмжээгээр дайчлан ажиллахыг пакт өөрөө шаарддаг. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 2 дугаар зүйлд заасан гадуурхахыг хориглосон ерөнхий заалт нь хүнийг насаар ялгаварлан гадуурхахыг хориглох асуудлыг багтааж буй гэж мөн тайлбарлаж болно. Түүнчлэн, олон улсын цөөнгүй баримт бичгүүд, оролцогч улсуудын хууль тогтоомжоор ахмад настанд ялгавартай хандахыг хориглосон байдгийг тэмдэглэх хэрэгтэй. Зарим улс орнуудад тэтгэвэрт гарах нас, эсхүл дээд боловсролын хүртээмж зэрэгт насаар ялгаварлан гадуурхахыг хүлээн зөвшөөрсөн байдаг ба энэ хандлагыг бууруулах, арилгахад чиглэсэн тодорхой санаачлагуудыг гаргаж байна. Энэ талаар ялангуяа Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооноос улс орон бүр энэхүү хандлагыг өргөжүүлэн түргэтгэх арга зам хайх хэрэгтэй хэмээн зөвлөсөн байна.

“Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр - Дэлхий нийт XXI зууныг “Насжилтын зуун” хэмээн нэрлэж, 2002 онд Мадрид хотноо Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 156 орны Засгийн газрын тэргүүнүүд оролцсон Ерөнхий чуулганаараа насжилтын асуудлаархи олон улсын төлөвлөгөөг хэлэлцэж, Улс төрийн тунхаглалыг гарган, бүс нутаг, гишүүн орнуудад насжилтын асуудлаар өөрийн онцлог байдлыг тусгасан бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж ажиллахыг зөвлөсөн.

Дэлхийн тунхаглал батлагдсанаас 10 жилийн дараа 2000 оны 4 дүгээр сарын 26-28-нд Сенегал улсын Дакар хотноо зохион байгуулагдсан Дэлхийн боловсролын форумас 164 улс орны 1100 төлөөлөгчид амлалтаа дахин нотолж, Дакарын үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг баталж, *2015 он хүртэл хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээг тодорхойлж, дэлхий дахины Бүх нийтийн боловсролын 6 зорилтыг дэвшүүлсэн нь нийгмийн эмзэг бүлгийн хүрээнд энэ зорилтыг хэрэгжүүлэх нөхцөл бий болгосон.*

Хөгжлийн бэрхшээлтэй Хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй бүх хүн хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлэх явдлыг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих, түүнчлэн тэдний нэр төр, нандин чанарыг хүндэтгэн дэмжихэд оршино. Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согогтой бөгөөд уг согог нь бусад төрлийн бэрхшээлтэй нэгдэн нийлсний улмаас бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад учруулахуйц болсон этгээдийг ойлгохоор заасан.

Харин Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрмээр 0-16 насны хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих зохицуулалтыг тусгасан.

Нэгдсэн үндэстний байгууллагаас 2015 онд “Тогтвортой Хөгжлийн хөтөлбөр-2030” баримт бичгийг батлан дэвшүүлж буй 17 зорилтыг 193 улс харилцан хүлээн зөвшөөрч, хэрэгжилтийн арга замыг бэхжүүлэх болон тогтвортой хөгжлийн төлөөх олон улсын хамтын ажиллагааг сэргээх зэрэг 169 зорилт болон биелэлтийг харуулах 304 үзүүлэлтийг дэвшүүлсэн.

Цаг уурын өөрчлөлт болон түүний үр дагавартай яаралтай арга хэмжээ аван тэмцэх гэсэн зорилт нь дэлхийн улс орнуудад энэ чиглэлд цогц арга хэмжээ авах үүргийг хүлээлгэж, гамшгийн эрсдлээс хамгаалах үндэсний механизмыг боловсронгуй болгох шаардлагыг тодорхойлсон байна.

Гамшгийн үед нийгмийн эмзэг бүлгийг хамгаалахтай холбоотой үндэсний эрх зүйн баримт бичгийг судлан үзвэл дараах зохицуулалтууд байна. Үүнд:

- Үндсэн хууль 1992 он
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 2016 он
- Хөдөлмөрийн тухай хууль 1999 он
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль 2011 он
- Нийгмийн даатгалын тухай хууль 1994 он
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль 1994 он
- Нийгмийн халамжийн тухай хууль 2012 он
- Боловсролын багц хууль 2002 он
- Барилгын тухай хууль 2016 он
- Эрүүл мэндийн тухай хууль 2011 он
- Хүүхдийн эрхийн тухай хууль 2016 он
- Хүүхэд хамгааллын тухай хууль 2016 он
- Ахмад настны тухай хууль 2017 он
- Гамшгаас хамгаалах тухай хууль 2020 он
- Бусад холбогдох хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын холбогдох тогтоол, журам

Дээд хүчин чадал бүхий Монгол улсын Үндсэн хууль нь хүний эрх эрх чөлөөг баталгаажуулж

- амьд явах /16.17, эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах /16.2/,
- өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний туслалцаа авах /16.5/,
- эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах /16.6/,
- сурч боловсрох /16.71/,

- гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төрөөс хамгаалах /16.11/,

- эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулах, хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх/16.14/ зэргээр нийгмийн хамгааллын эрхийг зааж өгсөн ба төрөөс

хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцахаар /19.1/ тусгасан нь дээрх эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэх баталгаа болж өгсөн. Өөрөөр хэлбэл гамшгийн үед нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг хамгаалах үүргийг төр хариуцах зохицуулалт юм.

Монгол улс Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцид нэгдэн орсноос хойш дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдаг. Үүнд:

- 2012 оны 12 дугаар сард НҮБ-ын Хүний эрхийн хороонд Монгол Улсын Засгийн газар анхны тайлан илтгэлээ хүргүүлсэн бөгөөд Монгол Улсын Засгийн газраас “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай” НҮБ-ын конвенцийг 2013-2016 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлсэн. 2015 оны 04 дүгээр сард НҮБ-ын Хүний эрхийн хороонд тайлан илтгэлийг Монгол Улсын Засгийн газар хэлэлцүүлсэн.

- 2019 онд Монгол Улсын Засгийн газар НҮБ-ын Хүний эрхийн хороонд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн 2 болон 3 дугаар тайланг нэгтгэн хүргүүлэн ажиллаж байна.

Түүнчлэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний орон тооны бус зөвлөл, аймаг дүүрэгт ажиллах салбар зөвлөлийн ажиллах журмыг Засгийн газрын 2016 оны 136 дугаар тогтоолоор, “Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай бүх яамд болон Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дэргэд дэд зөвлөл байгуулах тухай” Засгийн газрын 2017 оны 116 дугаар тогтоолоор, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм”-ийг Засгийн газрын 2016 оны 200 дугаар тогтоолоор, “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам”-ыг Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор, “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үнэмлэх олгох журам, үнэмлэхийн загвар”-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/109 дүгээр тушаалаар, “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие

даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам”-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/184 дүгээр тоот тушаалаар, “Мэргэжлийн ур чадварын олон улсын тэмцээнд амжилттай оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүнд урамшуулал олгох ба урамшуулал олгох журам”-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/212 дугаар тушаалаар, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоолоор тус тус батлан мөрдүүлж, “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ”-ний стандарт боловсруулах салбар дундын ажлын хэсэг ажиллаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр дараах төслүүдийг хэрэгжүүлж байна. Үүнд:

✓ Хятадын Засгийн газрын буцалтгүй тусламжаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв”-ийг барих төсөл /2015-2019 он/

✓ Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /Жайка/-ын “Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих” төсөл /2016-2020 он/

✓ Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /Жайка/-ын “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах” төсөл /2015-2019 он/ хэрэгжиж байна

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрх, түүнийг хангах, хэрэгжүүлэх, хамгаалах талаар төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, оролцоо, баримтлах зарчмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад орших бөгөөд дараах хуулиудад тусгасан заалтыг харуулбал:

Хөдөлмөрийн тухай хуулиар хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр хөдөлмөрийн харилцаанд оролцогч ажилтан, ажил олгогчийн нийтлэг эрх, үүрэг, хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн ганцаарчилсан ба хамтын маргаан, хөдөлмөрийн нөхцөл, удирдлага, хяналт болон хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тодорхойлж талуудын харилцан эрх тэгш байдлыг хангах чиглэж байгаа ч тус хуульд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн

хөдөлмөрлөхтэй холбоотой асуудал, ажил, амралтын цаг, цалин хөлсийг тусгайлан зохицуулсан байна.

Нийгмийн даатгалын тухай хуулиар нийгмийн даатгалын төрөл, хэлбэр, хамрах хүрээг тогтоож, нийгмийн даатгалд даатгуулж шимтгэл төлөх, нийгмийн даатгалын санг бүрдүүлэх, зарцуулах болон нийгмийн даатгалын байгууллага, нийгмийн даатгалын байцаагчийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байгаа энэ нь нийгмий халамжийн нэг төрөл болон хэрэгжиж байна.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар нийгмийн даатгалын тухай хуульд заасны дагуу шимтгэл төлж тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтоож олгохтой холбоотой харилцааг зохицуулдаг.

Нийгмийн халамжийн тухай хуулиар нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээний төрөл, хамрах хүрээг тогтоох, нийгмийн халамжийн сан бүрдүүлэх, уг сангийн хөрөнгийг зарцуулах, нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх, нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо, чиг үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулсан.

Эрүүл мэндийн тухай хуулиар эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндсэн зарчмыг тодорхойлж, иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийг хангахад аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэний гүйцэтгэх үүрэг, эрүүл мэндийн байгууллага, ажилтны үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулж өгсөн. Эрүүл мэндийг хамгаалах гэж хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохион байгуулах замаар анагаах ухаан, нийгэм, эдийн засгийн цогц арга хэмжээг хэлдэг бөгөөд гамшгийн үед өндөр настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ эрүүл мэндийн байгууллагаас хүргэх асуудлыг зохицуулсан.

Хүүхдийн эрхийн тухай хуулиар хүүхдийн эрхийг хангах тогтолцоог бий болгох, хүүхдийн эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн бүрэн эрхийг тодорхойлж өгсөн.

Ахмад настны тухай хуулиар ахмад настны эрхийг хангах, амьжиргаа, хөгжил, оролцоог дэмжих, нийгмийн үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэх,

төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын үүргийг тодорхойлж, тэдгээрийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоосон байна.

Ямар ч улс оронд гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажлыг амжилттай хэрэгжүүлэхэд энэхүү үйл ажиллагаанд оролцогч төр, орон нутгийн захиргааны болон аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус олон нийтийн байгууллага, иргэд, олон улсын болон хандивлагч орнуудын оролцох эрх, үүрэг, харилцаа хамтын ажиллагааг нарийн зохицуулсан хууль, эрх зүйн баримт бичгийг батлан мөрдөж хэрэгжүүлдэг байх нь ихээхэн ач холбогдолтой.

Төрийн зүгээс гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдал, хариу арга хэмжээ, сэргээн босголтын талаар явуулах үйл ажиллагааг баталсан хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж хэвших нь болзошгүй гамшгийг хамгийн хохирол багатай даван туулах гол үндэс болж өгдөг.

Гамшгаас хамгаалах болон нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг хамгаалах тухай хууль тогтоомжууд нь бусад олон хуулийн адил Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцсэн байх шаардлагатай. Монгол Улсын Их Хурал 2003 онд анх удаа “Гамшгаас хамгаалах тухай хууль”-ийг баталж, мөрдөж эхэлснээр гамшгаас хамгаалах үйл ажиллагааны орчин шинэчлэгдэн, хүн амын аюулгүй орчинд амьдрах нөхцөл бололцоог хангахад чухал ач холбогдолтой эрх зүйн баримт бичиг болсон юм.

2020 онд *Гамшгаас хамгаалах тухай хуулийг шинэчлэн баталж* гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, онцгой байдлын байгууллага болон гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулж байна.

Тэгвэл төрөөс гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдал, хариу арга хэмжээ, сэргээн босголтын талаар явуулах үйл ажиллагаагаа баталсан хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж хэвших нь болзошгүй гамшгийг хамгийн хохирол багатай даван туулах гол үндэс болж өгдөг. Гамшгаас хамгаалах чадавхийг дэлхийн улс орнууд гамшгаас хамгаалах эрх зүйн зохицуулалт, гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоо, эдийн засаг, нийгэм, хүн амын эмзэг байдлын түвшин, эдгээрийн үнэлгээ, гамшгийн эмзэг байдлыг бууруулах арга хэмжээ, байгалийн болзошгүй аюулыг эртнээс сэрэмжлүүлэх хүчин чадал, мэргэжлийн боловсон хүчний хангамж, аврах ажлын багаж, техник хэрэгслийн

хангалт, хүн амын гамшгаас хамгаалах боловсрол болон бараа, материалын нөөц бүрдүүлэлтийн боломжоор ойлгож, аливаа болзошгүй гамшигтай тэмцэх, аль болох хамгийн бага хохирол амсах нь гамшгийн удирдлагыг хэрхэн зөв оновчтой хэрэглэснээс шууд хамаардаг гэж үзэж байна.

Өнөөгийн байдлаар нийгмийн эмзэг бүлэгт тулгамдаж буй гамшгийн талаар болон гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах ажлыг хууль эрхийн акт, баримт бичгээр зохицуулаагүйгээс түүнийг хэрэгжүүлэх явцад олон төрлийн ээдрээтэй хүнд тулгамдсан асуудал гарч байна.

Гамшгийн өмнө, гамшгийн үед болон гамшгийн дараа гамшгийн удирдлагын бүтцийг зөв тодорхойлж, Засгийн газар, төрийн болон аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, олон улсын болон хүмүүнлэгийн байгууллагуудын хоорондын ажиллагааг цаг алдалгүй сайн зохион байгуулсанаар үр дүнд хүрэх боломжтой.

Олон улсын туршлагаас харахад гамшгийн аюулаас хүн амыг сэрэмжлүүлэх, мэдээн сурталчлах ажил нь гамшгийн менежментийн бүх асуудалтай нягт холбогддог байна.

Гамшгаас хамгаалах мэдээлэл сурталчилгааг буруу зохион байгуулсанаас болж ард иргэдийн дотор айдас бухимдал төрөх, авч буй арга хэмжээний талаар ташаа ойлголт авах, болж буй үйл явдалд хайнга хандах зэрэг сөрөг үр дагаврууд гарах нь олонтаа. Хэрвээ гамшгаас хамгаалах мэдээлэл сурталчилгааг цаг хугацаанд нь үнэн зөв хүргэвэл харин ч учирч болзошгүй хохирлоос сэрэмжлэх, үйл ажиллагаагаа сайтар зохион байгуулах давуу талыг олгодог.

Засгийн газар, олон улсын тусламжийн байгууллага, хүмүүнлэгийн болон төрийн бус байгууллага эдгээр үйл ажиллагаанд оролцоход үнэлгээ хийсэн байхыг шаарддаг.

Тиймээс гамшгийн үед болон дараа ч юуны түрүүнд нийгмийн эмзэг бүлгийн болон тэжээгчээ алдсан хүүхдийн хамгааллын үнэлгээг хийх үүрэгтэй. Олон улсад гамшиг онцгой байдлын үеийн нийгмийн эмзэг бүлгийн хамгааллын төсөл, хөтөлбөрүүд 2 төрлийн багц хяналтын механизмаар үйлчилэх бөгөөд гамшгийн үед үүссэн нөхцөлд нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг яаралтай анхааралдаа авч бүртгэх ажил маш чухал энэ нь тухайн тохиолдолд хохирол, эрсдэлийг бууруулах, хамгаалах ач холбогдолтой. Түүнчлэн гамшиг үүссэн нөхцөлд нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн хамгааллын байгууллагын барилга

байгууламж эвдэрч нурах, үүнээс үүдэн хэвийн үйл ажиллагаа алдагдан нүүлгэн шилжүүлэх тохиолдол ч гарч болзошгүй юм. Энэ тохиолдолд байгууллага бүр үйл ажиллагаагаа, хаана ч ямар ч нөхцөлд тасалдуулахгүй хэвийн үргэлжлүүлэх орон зайг бий болгох шаардлагатай болно.

Дараагийн гол чухал асуудал бол Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг олон нийтийн хүч, оролцоонд тулгуурлан хэрэгжүүлэх үзэл санаа дэлхий нийтэд, ялангуяа уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшигт ихээхэн өртөмтгий хүн ам шигүү суурьшсан Ази, Зүүн Азийн орнуудад ихээхэн дэлгэрч байна. Тухайлбал орон нутгийн иргэд гамшгийн эрсдэлийг бууруулахад бие биедээ харилцан туслалцаа үзүүлэх, тухайн орон нутгийн гамшгийн нөхцөл байдал, болзошгүй гамшгийн эрсдэлийн талаар мэдлэг, чадвартай болох, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс үүдэлтэй гамшигт үзэгдлийг хохирол багатай даван туулахын тулд дасан зохицох олон талт ажлыг санаачлан хэрэгжүүлж байна.

Олон нийтэд тулгуурласан гамшгаас хамгаалах менежментийн үзэл санааг Монгол Улсад 2001 оноос хойш олон улсын байгууллагын дэмжлэг туслалцаатайгаар нэвтрүүлж байгаа хэдий ч олон нийтийн оролцоог хангах, идэвх санаачилгыг нь дэмжих төрийн бодлого, эрх зүй, төсөв, санхүүгийн зохицуулалт хангалтгүй байна.

Гамшгийн эрсдэлийг бууруулах дэлхийн гуравдугаар бага хурал Япон улсын Мияаги мужийн Сендай хотноо 2015 оны 03 дугаар сард зохион байгуулагдсан. “Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд авч хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ” баримт бичгийг баталж, долоон зорилтыг дэвшүүлж, үйл ажиллагааны 4 тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон. Үүнд:

1. Гамшгийн эрсдэлийг ойлгох;
2. Гамшгийн эрсдэлийг удирдах засаглалыг бэхжүүлэх;
3. Гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд хөрөнгө оруулах;
4. Гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд бэлэн байдлыг хангах, гамшгийн дараах сэргээн босгох, нөхөн сэргээх үе шатанд “Сайжруулан барьж байгуулах” үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

Монгол Улс нь Ази, Номхон далайн бүсийн эдийн засаг, нийгмийн комиссын гишүүн орны нэг бөгөөд Ази, Номхон далайн бүс нутаг дахь хөгжлийн

бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг бодит болгоё” Инчеоны стратегийн 10 зорилгын “Хөгжлийн бэрхшээлийг хамруулсан гамшгийн эрсдэлийг бууруулах, менежментийг баталгаажуулах» гэсэн 7 дахь зорилт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлд хамаарсан томоохон эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Дүгнэлт

Нийгмийн хамгааллын хүрээг зөвхөн хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд үзүүлэх туслалцаа төдийгөөр хязгаарлахгүй, материаллаг туслалцаанаас гадна тэдний онцлогт тохирсон хамгааллын янз бүрийн хэлбэрийг бий болгох, нөгөө талаар нийгмийн хамгааллын үүрэг, хамрах хүрээг нэмэгдүүлэх шаардлага үүссэн. Түүнчлэн гамшгийн үе шатуудад болон тайван цагт гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, аврах хүч хэрэгсэл, удирдлагын шуурхай үйл ажиллагааг бүх түвшинд хангахдаа нийгмийн эмзэг бүлэгт тохирсон арга, хэрэгслийг тухайлан зохицуулах зайлшгүй шаардлага бий болсон.

“Эмзэг байдал” гэсэн ойлголтод гамшгийн үед илүү өртөх магадлалтай, өөрийгөө аюул ослоос хамгаалах чадваргүй эсвэл асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй хүн буюу өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, хүүхэд зэргийг хамааруулан тэднийг хамгаалахад тохирсон бодлого, төлөвлөлт боловсруулах шаардлагатай.

Олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг хамгаалах нь зайлшгүйг хүлээн зөвшөөрч, нийгмийн хамгаалал, халамжийн зохицуулалтыг илүү тусгаж өгсөн байна. Харин Тогтвортой хөгжлийн бодлого-2030 баримт бичигт “Цаг уурын өөрчлөлт болон түүний үр дагавартай яаралтай арга хэмжээ аван тэмцэх” гэсэн зорилт дэвшүүлсэн нь дэлхийн улс орнуудад энэ чиглэлд цогц арга хэмжээ авах үүргийг хүлээлгэж, гамшгийн эрсдлээс хамгаалах үндэсний механизмыг боловсронгуй болгох шаарлагыг тодорхойлсон байна.

Монгол улсын хувьд нийгмийн эмзэг бүлэг гэсэн ойлголтыг тодорхойлоогүй тул тэднийг гамшгийн үед хамгаалах тухайлсан бодлого, төлөвлөлт хийх эрх зүйн үндэслэл бүрдээгүй байна. Харин хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд “Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд гэж эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийг” ойлгохоор заасан нь дэвшилтэт зохицуулалт болжээ.

Ашигласан бүтээл

- Үндсэн хууль 1992 он
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 2016 он
- Хөдөлмөрийн тухай хууль 1999 он
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль 2011 он
- Нийгмийн даатгалын тухай хууль 1994 он
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль 1994 он
- Нийгмийн халамжийн тухай хууль 2012 он
- Боловсролын багц хууль 2002 он
- Барилгын тухай хууль 2016 он
- Эрүүл мэндийн тухай хууль 2011 он
- Хүүхдийн эрхийн тухай хууль 2016 он
- Хүүхэд хамгааллын тухай хууль 2016 он
- Ахмад настны тухай хууль 2017 он
- Гамшгаас хамгаалах тухай хууль 2017 он

www.Legalinfo.mn, www.nso.mn

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал, бодлого үйл ажиллагаа”-77-р тал

Ц.Давхарбаяр, г.жаргал, “нийгмийн хамгааллын эрх зүй”, уб 2010 он. 7-11-р тал
Р.Ганбат, Р.Жаргалмаа, “Онцгой байдлын үед дэхь хүүхэд хамгааллын гарын авлага” УБ 2017 он 56-р тал

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйл. төрийн мэдээлэл сэтгүүл, 2016, №9

Монгол Улсын иргэний хуулийн 23.24 дүгээр зүйл., төрийн мэдээлэл сэтгүүл, 2002 он, №7

Ахмад настны нийгмийн хамгаалал ба хүний эрхийн асуудал судалгааны тайлан 10 дахь тал

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, “хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал, бодлого үйл ажиллагаа”-77-р тал

“МОНГОЛ ДОХИОНЫ ХЭЛИЙГ ХУУЛИАР БАТАЛГААЖУУЛАХ НЬ”

А.Энхбаатар¹

¹ Монгол Улсын Сонсголгүй Иргэдийн
Үндэсний Холбооны Ерөнхийлөгч

Хураангуй

Дэлхийн олон улс орнууд нь өөрийн сонсголгүй иргэдэд зориулсан дохионы хэлийг хүлээн зөвшөөрч албан ёсны хэл болгон хуульчилсан байдаг.

Энэ нь сонсголын бэрхшээлтэй иргэдийн эрх тэгш байдал болон сурч боловсрох, танин мэдэх, аливаа бүх төрлийн үйлчилгээг саадгүй авах боломжийг нээж, нийгмийн харилцаанд эрх тэгш хамруулах бодлого болгон хэрэглэж, үр дүнгээ өгөн, өөрчлөгдөн шинэчлэгдэж, уламжлагдан хэрэглэгдсээр байна.

Дэлхийн улс орнууд нь дохионы хэлийг хэлгүй, сонсголгүй хүмүүсийн албан ёсны хэл гэж хүлээн зөвшөөрдөг.


Манай дэлхий дээр 200 гаруй үндэстэн дохионы хэлээр хоорондоо харилцдаг бөгөөд тэрхүү үндэстэн бүрийн дохионы хэл нь тухайн үндэстний соёл, онцлогийг өөртөө шингээсэн байдаг. Тэр дундаа үндэсний дохионы хэл нь нийгэмдээ тэгш хамрагдан оролцох боломжийг сонсголгүй хүмүүст олгодог.

Сонсголгүй Иргэдийн Дэлхийн Холбооноос дэлхий дахинаа 70 сая гаруй сонсголгүй иргэд байгаагийн **80** хувь нь хөгжиж байгаа орнуудад байдаг гэсэн судалгаа байдаг.

1995 онд Дэлхийн түүхэнд **анх** Африкийн тивийн Уганда улсад үндэсний дохионы хэлний тухай санаачлан хуульчилж баталсан байдаг билээ. Тэр үеэс хойш дохионы хэлийг үндсэн хуулиараа 51 улс баталсан байна.

Сонсголгүй ярианы хэлийг үндэсний албан ёсны хэлний хамт эрх тэгш байдлаар хуульчилсан байдаг. Энэ нь дохионы хэлийг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн Нэгдсэн Үндэсний Байгууллагын 193 орны 25 хувийг эзэлж байна.

АЛБАН ЁСНЫ ДОХИОНЫ ХЭЛИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН ОРНУУД



Сонсголгүй Иргэдийн Дэлхийн Холбоог **анх** 1951 онд Итали улсын Ром хотод үүсгэн байгуулаад энэхүү хурлаар тус Холбооноос дохионы хэлийг сонсголын бэрхшээлтэй иргэдийн нэгдүгээр хэл хэмээн тунхагласнаар улс орон бүр өөрсдийн дохионы хэлийг бий болгон хөгжүүлж иржээ. Сонсголын бэрхшээлтэй иргэдийн эх хэл бол дохионы хэл юм.

Түлхүүр үг: Олон улсын туршлага, Дохионы хэлний эрхийн ойлголтын тухай хууль, "Сонсголгүй адилсал"

Үндэслэл

Манай улсын хувьд хэлгүй, сонсголгүй хүүхдүүдэд зориулсан тусгай сургууль байгуулагдаад 56 жил болж байгаа хэдий ч дохионы хэлийг албан ёсоор батлан мөрдөж буй явдал байхгүй байна. Энэ нь хэлгүй, сонсголгүй хүүхдүүдийн сурч боловсрох, танин мэдэх зэрэг эрх байнга зөрчигдөж байдаг тул үндэсний дохионы хэлний эрхийг батлаж мөрдүүлэх хэрэгцээ шаардлага тулгараад байна.

Сонсголын бэрхшээлтэй иргэдийн дохионы хэл нь нийгмийн харилцаанд орох, бусдын ялгаатай байдлыг ойлгох, хүлээн зөвшөөрөх, ялгаварлан гадуурхлаас хамгаалах зорилготой бөгөөд дохионы хэлийг албан ёсоор хуульчилж батлаагүй байгаа нь тэдгээр иргэдийн сурч мэдэх эрх хаагдаж, бусдын адилаар боловсролтой болох эрх зөрчигдөж байдаг.

“Сонсголгүй адилсал”

Монголын Шинжлэх ухааны салбарынхан аль хэдийн ингэж нэршиж тогтсон юм. Үүнийг сонсголгүй хүмүүсийн дунд байх ижил төстэй үнэт зүйл, үнэлэмж, зан үйл, гэх мэтээр тайлбарлаж болно. Өөрөөр хэлбэл бусдаас ялгарах үнэт зүйлтэй байж, ижил төстэй хүмүүстэй бүлгээрээ адилсах боломжтой гэж ойлгож болно.

Сонсголгүй иргэдийн дунд олонх нь хүлээн зөвшөөрсөн “нийтлэг” үнэлэмж, зан үйл нь үнэт зүйл юм. Нэг болон нилээн олон хүний тогтсон ойлголт, нийтлэг шинж чанар, үнэт зүйл нь тэднийг нэгтгэж байгаа үйл явцыг "адилсал" гэж тодорхойлж болно. Тухайн бүлэг хүмүүс нь бусдаас ялгарах, ондооших нь тухайн бүлгийн нийтлэг үнэт зүйл болно. Гадуур явагдаж байдаг сонсголгүй хүмүүст зориулсан сургалтад өөрсдийн үнэт зүйлсийг ойлгох, мэдрэх шинээр нээх, итгэх, бахархах сэтгэл төрүүлэх гэсэн утгаар энэ сэдвийг оруулсан байдаг. Эдгээр сэтгэлзүйн асуудлууд нь энгийн хүнд ойлгомжгүй байдаг ба сонсголгүй иргэд болон жирийн иргэдийн хоорондын харилцааг улам холдуулж байдаг.

Тиймээс Төрийн холбогдох байгууллага нь Сонсголгүй Иргэдийн Үндэсний Холбоотой хамтран “Монгол Дохионы хэлний тухай хууль”-ийн төслийг боловсруулж амьдралд хэрэгжүүлэх нь сонсголгүй иргэдэд зориулсан нэн чухал шийдвэр болно.

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Манай улсад Монгол Дохионы хэлний тухай хуультай болж сонсголын бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийн төлөө ажиллах төслийн баг байгуулж хамтран ажиллахад бэлэн байна.

Олон улсын туршлага, судалгааны арга зүй

2017 онд хуралдсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгээс 09-р сарын 23-ны өдрийг “ Дохионы хэлний олон улсын өдөр” хэмээн Дэлхий даяар, жил бүр уламжлал болгон тэмдэглэж байх тэмдэглэлт өдөр болгон албан ёсоор баталсан билээ.

Дэлхий дахинаа байгаа 70 сая гаруй сонсголгүй хүний дөнгөж 2% нь албан ёсны боловсрол эзэмших боломжтой байгаа бол 1 % -ээс цөөн хувь нь албан ёсоор ажил эрхэлж байна. Сонсголгүй хүмүүст тулгарч буй хамгийн том бэрхшээл бол хүмүүс энгийн хүмүүсийн хийдэг адил ажил, хөдөлмөрийг сонсголгүй иргэд эрхлэхэд нь хөгжлийн бэрхшээл байх явдал саад болдог гэж үздэг доромжлол юм.

Дохионы хэлийг албан ёсны хэл гэж хүлээн зөвшөөрдөг 51 улс орны 28 нь Европт байдаг. Европын парламентаас бүх гишүүн орнуудаас дохионы хэлийг албан ёсны хэл гэж хүлээн зөвшөөрөхийг шаардсан тогтоолыг 1988 оны 6-р сарын 17-нд баталсан байна. Тус парламентаас 1998 онд үүнтэй төстэй тунхаг бичгийг дахин гаргажээ.

Дохионы хэлийг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн үлдсэн улс орнуудын **зургаа** нь Өмнөд Америкт, **дөрөв** нь Африкт (Кени, Өмнөд Африк, Уганда, Зимбабве), **гурав** нь Номхон далайн улс орнуудад (Папуа, Шинэ Гвиней, Шинэ Зеланд, Австрали), **Дөрөв** нь Азид (Өмнөд Солонгос, Япон, Филиппин, Тайланд) байдаг бөгөөд Мексик, АНУ, Канад нь дохионы хэлийг албан ёсоор хүлээн зөвшөөрдөг Хойд Америкийн улсууд юм. Дохионы хэлийг Өмнөд Африкийн **6** дахь албан ёсны хэл болгож баталсан байна.

АЛБАН ЁСНЫ ДОХИОНЫ ХЭЛ /ТИВ/



The legal recognition of sign languages by type of legislation буюу **Дохионы хэлийг албан ёсны хэл** хуульчилсан хүлээн зөвшөөрсөн орон улсууд

1995	УГАНДА	2009	БОСНА БА ХЕРЦЕГОВИНА
1995	ФИНЛЯНД	2009	МАКЕДОНИ
1995	СЛОВАК	2009	УНГАР
1995	ЛИВТА	2009	НОРВЕГИ
1996	ӨМНӨД АФРИК	2010	КЕНИ
1996	КОЛУМБ	2010	ЗИМБАБВЕ
1997	ПОРТУГАЛИ	2010	КАТАЛОНИ /ИСПАНИ/
1999	ЛАТВИ	2010	ЧИЛИ
1999	ТАЙЛАНД	2011	УНГАР /шинэчилсэн/
2001	УРУГВАЙ	2011	ИСЛАНД
2002	БРАЗИЛ	2011	ПОЛЬШ
2002	СЛОВЕНИ	2011	ЯПОН
2002	РУМАН	2012	ОРОС
2002	ГЕРМАН	2014	ДАНИ
2003	ВАЛЛОНИ /БЕЛЬГИ/	2015	ФИНЛЯНД /шинэчилсэн/
2005	АВСТРИ	2015	СЕРБИ
2005	ТУРК	2015	ӨМНӨД СОЛОНГОС
2005	МЕКСИК	2015	ШОТЛАНД /ИХ БРИТАНИ/
2006	ШИНЭ ЗЕЛАНД	2015	ПАПУА ШИНЭ ГВИНЕЙ
2006	КИПР	2016	МАЛТИ
2006	ФЛАНДЕРС /БЕЛЬГИ/	2018	ФИЛИППИН
2007	ЭСТОНИ	2019	КАНАД
2007	ИСПАНИ	2020	НИДЕРЛАНД
2008	ЭКВАДОР		
2008	ЧЕХ		
2009	ШВЕД		

Ямар улс орнууд дохионы хэлийг албан ёсны хэл гэж хүлээн зөвшөөрдөг вэ?

№	Албан ёсны дохионы хэл зөвшөөрөгдсөн улс
1	Австри
2	Бельги
3	Босна ба Херцеговина
4	Бразил
5	Чили
6	Колумб
7	Кипр
8	Чех
9	Дани
10	Эквадор

11	Эстони
12	Финлянд
13	Герман
14	Унгар
15	Исланд
16	Япон
17	Кени
18	Латви
19	Литва
20	Македони
21	Мальта
22	Мексик
23	Шинэ зеланд
24	Норвеги
25	Папуа Шинэ Гвиней
26	Польш
27	Португал
28	Руман
29	Орос
30	Серби
31	Словак
32	Словени
33	Өмнөд африк
34	Өмнөд солонгос
35	Испани
36	Швед
37	Турк
38	Уганда
39	Уругвай
40	Венесуэл
41	Зимбабве
42	АНУ
43	Нидерланд
44	Филиппин

45	Канад
46-51	орон улсууд

Манай байгууллагаас гаргасан судалгаагаар дохионы хэлний чадварын түвшин маш сайн 100, сайн 300, дунд 600, муу /тодорхойгүй/ сонсголгүй иргэн байдаг гэсэн тоо баримт байдаг. Нарийн судалгаа хийх нь зардал өндөр гарах магадлалтай ба тухайлбал сонсголгүй иргэний дохионы хэл мэддэг болон мэддэггүй сонсголгүй хүн бүрийг хөдөө орон нутгаас нарийн тоо баримтаар гаргах боломжгүй байна.

Дохионы хэлний чадвар түвшин

Маш сайн	Сайн	Дунд	Муу
100 хүн	300 хүн	600 дээш	Мэдэхгүй /Тодорхойгүй/

Эрүүл мэндийн яамнаас гаргасан дүлийрэлт, сонсгол бууралтаас сэргийлэх, хянах төлөвлөгөө 2020-2030 авлагын мэдээллээс харвал “манай улсад хүүхдийн дүлийрлийн асуудлыг эмнэлзүйн хүрээнд шийдвэрлэсэн цөөн тооны судлагаа шинжилгээний ажлуудаас өөр нийт хүн амын дунд хийгдсэн дүлийрэлт, сонсгол бууралтын нарийвчилсан судалгаа үгүй, ялангуяа тархалтын тандалт, судалгааны асуудал өмнө нь ч хөндөгдөж байгаагүй болно” гэжээ.

Тиймээс дохионы хэл эзэмшсэн байж болох сонсголгүй иргэдийг олох, хэрэв дохионы хэл мэдэхгүй бол зааж сургах ажлыг зохион байгуулахад зардал хомс байдаг учир Төр засгаас дэмжлэг авах хэрэгтэй байдаг. Мөн дохионы хэл эзэмшсэн иргэд маш цөөхөн байгаа нь судалгаагаар ажиглагдсан байдаг.

Дээрх үндэслэлээр энэхүү судалгаанд “Монгол дохионы хэлний тухай хууль”-ийг онцолж авч үзсэн.

Тус конвенц нь дохионы хэлний тухай нарийн тодорхойлж, үнэт зүйл болгон төлөвшсэн ойлголтыг өгөх явдал юм.

2009 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц, Ази, номхон далайн бүсийн Хөгжлийн Бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг бодит болгоё” 2013-2022 оны Инчеоны стратеги, Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хууль тус тус батлагдсан билээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн дагуу 2; Дохионы хэл, 9; Хүртээмж, 21; Харилцан ойлголцол (Эрх чөлөө ба хүртээмж), 22; Харилцан ойлголцол (хувийн нууц), 24; Боловсрол, 30; Соёл (Дохионы хэл, сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн соёл) гэсэн заасан зүйлийг монгол дохионы хэлний тухай хуулийн дагуу боловсруулалт хийн хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Дохионы хэлний тухай хуулийг баталснаар сонсголгүй иргэдийн дохионы хэлийг эзэмших, дохионы хэлээр мэдлэг мэдээллийг олж авах, сурах, хамгаалуулах, хэрэглэх, гадаад дохионы хэлийг сурах олон төрлийн боломж нээгдэх ба сонсголгүй хүмүүс нь дохионы хэлээр амьдран, амьдрах эрхээ баталгаажуулах боломж бүрдэх юм байна.

Үр дүн

Сонсголгүй иргэдийн дэлхийн холбоо, Ази тивийн сонсголгүй иргэдийн холбоотой хамтран манай байгууллагад зөвлөгөө, санал зөвлөмжийг ирүүлсэн юм.

Дохионы хэлийг албан ёсны хэл гэж хүлээн зөвшөөрсөн 51 улс орны хуулиас судалж, манай оронд тохиромжтой таарах зарим зүйл заалтаас жишээ авч өөрийн иргэдийн амьдралд хувь нэмэртэй болгон Монгол дохионы хэлний тухай хуулийг батлах шаардлагатай хэмээн зөвлөгөө өгч байна.

Мөн тус холбооны явуулсан судалгаанд бүх улс орны байршилд дохионы хэлний чадамж жигд бага үзүүлэлттэй гарсан байна. Өөрөөр хэлбэл нийт судалгаанд хамрагдсан сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн 45 орчим хувь нь ямар нэг хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг дохионы хэлэнд мэдэрч байсан гэж хариулжээ. Мөн дохионы хэлний тухай хуулиар баталгаажуулах нь маш их хэрэгтэй гэж олон хүн хариулсан байна.

Дохионы хэлний чадварын түвшинд дээрх байдал илүү ажиглагддаг байна.

Мөн дээрх холбооны шалгуур асуултанд сонсголгүй иргэд “мэдэхгүй” гэсэн хариултыг олон өгч байсныг дурдах хэрэгтэй.

Энэ үр дүн нь сонсголгүй иргэд дохионы хэлний тухай хууль, хүний адилсалдын хоорондын харилцаа, тэдний аливаа зөрчилтэй холбоотой асуудлуудыг үнэлж мэдэхгүй, насанд хүрэгчдэд, хүүхэд залуучуудтай сэтгэл зүйн

орчин бүрдсэн эсэх мэдээлэл, ойлголтгүй байгааг харуулж байсан нь нэг чухал үр дүн юм.

Дохионы хэлний тухай хууль батлах ач холбогдол

- 1) Бүхий л ард иргэд нь дохионы хэлийг сурсанаар эсхүл ойлголттой болсноор хэлний талаарх сонирхлыг дээшлүүлэн, харилцааны орчныг бүрдүүлэн, ард иргэдийн Монгол Дохионы хэлний ур чадварыг сайжруулах
- 2) Сонсголын бэрхшээлтэй хүүхэд дохионы хэл сурснаар хэлний чадвар болон амьдрах чадвар нь сайжрахад чухал хувь нэмэр оруулна
- 3) Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн дохионы хэл хэрэглэх орчин нөхцөлийг сайжруулснаар хэл ярианы ур чадвар дээшлэн, нийгэм дэх оролцоо нь сайжран, бие даан нийгэмд амьдрах боломжтой болно
- 4) Дохионы хэлний хадгалалт, боловсруулалт, судалгааны бүтэц сайжирснаар дохионы хэлний соёлд хувь нэмэр оруулах боломжтой
- 5) Дохионы хэлний орчуулагчийн чанарыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулах боломжтой
- 6) Дохионы хэлний хэлмэрчийн зайн дүрс, ярианы тусламжтайгаар хандаж, үйлчилгээ авах

Хэлцэмж

Тус холбооны судалгаанд, Олон улсын жишгээс ашиглан хуулийн ажлын хэсгийг байгуулах, стратегийн төлөвлөгөөг боловсруулах нь хэрэгжилт, шинжилгээ, үнэлгээ, үр дүнгийн гол үзүүлэлтүүдийг тоон утгаар хэмжиж, түүнд хамааралтай нийгмийн харилцаанд эрх зүйн орчинг бүрдүүлж, цаашдын албан ёсны дохионы хэлний хуультай болох шинэчлэлийн их ажилд хувь нэмэр болно хэмээн тооцож байна.

Дохионы чадварын түвшингийн судалгаа ажиглалтын аргаар хийж гүйцэтгэсэн болно.

Дүгнэлт

“Монгол дохионы хэлний тухай хууль” гэж байхгүйгээс сонсголгүй иргэдийн эрх зүйн орчин, хэл яриа, ойлголцлын чадамж сул, боловсрол мэдлэг олж авч чаддаггүй, нийгмийн гадуур амьдардаг зэрэг асуудлууд байна.

Олон улсын жишгээс харвал дохионы хэлний тухай хуульд байдаггүй улс оронд хүүхэд залуучууд, сонсголгүй иргэд нь нийгмийн харилцаанд оролцох эрх зүйн орчин байхгүй маш хэцүү орчин нөхцөлд аж төрдөг гэх үр дүн гарсан байдаг.

Монгол орны сонсголгүй иргэдийн төлөө ажилладаг аливаа хэлбэрийн бүхий л байгууллагын үйл ажиллагааны идэвхи маш сул, дэмжлэггүй, бие дааж ажиллахад санхүүгийн хүндрэлтэй байдаг зэргээс сонсголгүй хүмүүс нь түүнээс гарсан хор уршгийг хамгийн их мэдэрч байдаг байна. Төрийн бус байгууллагууд бие дааж ажилласан ч сонсголын бэрхшээлтэй хүмүүсийг дохионы хэлээр сургах, тэдэнд зориулсан тусгай хэлийг хуулийн хүрээнд хамгаалах, батлах ач холбогдлыг нь дангаар хэрэгжүүлж дийлэхгүй учир дээрх хуулийн ажлыг Төрийн зүгээс эрх зүйн орчны дэмжлэг тусалцаа авах нэн шаардлагатай болохыг тус судалгааны үр дүнгээс харлаа.

Цаашид бид төр болон төрийн бус байгууллагатай хамтран ажлын баг байгуулахаар энэ хуулийг баталгаажна гэдэгт найдаж байна.

Ашигласан материал

- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тухай НҮБ-ийн конвенц-2008 он
- ✓ Ази, номхон далайн бүсийн Хөгжлийн Бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг бодит болгоё” 2013-2022 оны Инчеоны стратеги
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 2016 он
- ✓ Дүлийрэлт, сонсгол бууралтаас сэргийлэх, хянах төлөвлөгөө 2020-2030 /ЭМЯ/
- ✓ <https://www.un.org/en/observances/sign-languages-day>
- ✓ <http://undocs.org/A/RES/72/161>
- ✓ <http://wfdeaf.org/get-involved/wfd-events/international-week-deaf/internationalweekofthedeaf/>
- ✓ <http://wfdeaf.org/news/resources/infographics-legal-recognition-sign-languages-type-legislation/>
- ✓ https://www.wikiwand.com/en/Legal_recognition_of_sign_languages
- ✓ <https://ikon.mn/n/zv0>
- ✓ <http://cad.ca/media-centre/news-events/cad-request-official-iced-apology/>

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БЭЛГИЙН ЭРХ ЧӨЛӨӨГ ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

1. Л.Эрдэнэхүү¹, Т.Сумъяабазар²

¹ИЗОУИС

²Их Засаг хууль зүйн сургууль

Хураангуй

Хүний аливаа эрх нь хоорондоо харилцан хамааралтай тул бэлгийн болон нөхөн үржихүйн эрх нь бусад эрхтэй, ялангуяа нийгмийн амьдралд оролцох, хөдөлмөрлөх эрхтэй харилцан уялдаатай. Эдгээрийг олон улсын баримт бичигт баталгаажуулсан ч эрхээ эдлэх нөхцөл, баталгааг төр бүрдүүлэх ёстой юм.

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй залуучууд, эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн чиглэлээр хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүд батлагджээ.

Гэвч эдгээрийг хэрэгжүүлэх механизм бүрэн ажиллахгүй, төрийн удирдах болон гүйцэтгэх шатны байгууллагуудын чиг үүрэг ерөнхий, мөн хуулийг хэрэгжүүлж байгаа албан хаагчдын мэдлэг хангалтгүй, хүний эрхэд суурилсан хандлага сайтар төлөвшөөгүйгээс шалтгаалан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бэлгийн эрхийн хэрэгжилтэд бодитой ахиц гарахгүй жилээс жилд энэ гэмт хэргийн тоо өсөж байгааг нь хяналт шалгалт, статистик тоон баримт, судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Энэ жилийн эхний 9 сарын судалгааны үр дүнгээс харахад хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд хүчиндэх гэмт хэргийн хохирогч болсон тохиолдол 3 дахин өссөн байх бөгөөд энэ төрлийн гэмт хэргийн тоо жилээс жилд өссөөр байна. Мөн энэ төрлийн гэмт хэрэг нуугдмал байгаа бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд өргөдөл, гомдол, мэдээлэл гаргах боломж хомс бөгөөд бэлгийн хүчирхийлэлд өртсөн хэдий ч мэдэгдэхгүй гэмт хэрэг, зөрчлийг нуугаад өнгөрөх, эрх бүхий байгууллагад гомдол гаргах чадвар, чадамжгүй энэ талын мэдлэг, мэдээллээр дутмаг байна.

Энэхүү асуудал нь бидний анхаарах, засаж сайжруулах шийдэх ёстой чухал асуудлуудын нэг мөнөөс мөн бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн эрх чөлөөх хамгаалах хэрэгцээ шаардлага тулгараад байна.

Иймд эдгээр асуудлуудын шалтгаан нөхцлийг олж тогтоож, түүнд шийдэл эрэлхийлж энэхүү судалгааны ажлыг бичсэн болно.

Түлхүүр үг: хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, бэлгийн эрх, эрх чөлөө, хүчиндэх гэмт хэрэг, бэлгийн дарамт учруулах, инноваци

1. Удиртгал

Сэдэв сонгосон үндэслэл: Цагдаагийн Ерөнхий газар болон Үндэсний статистикийн хорооны сүүлийн 3 жилийн судалгааны материалуудаас үзэхэд хүчиндэх гэмт хэргийн дийлэнх хохирогч нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүчиндэх гэмт хэргийн хохирогч болж байгаа хамгийн том шалтгаан бол тэдний биеээ хамгаалж чадахгүй байдал, боловсрол, асран хамгаалагч харгалзан дэмжигчийн болон эрх бүхий байгууллага олон улсын гэрээ, конвенц, холбогдох хууль тогтоомжид заасан үүргээ зохих ёсоор биелүүлдэггүйд оршиж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй охид, хөвгүүдийг үе тэнгийнхэнтэй нь харьцуулахад бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэл 3 дахин өндөр байдаг бөгөөд тэдний эрх хууль ёсны ашиг сонирхлыг шат шатанд хамгаалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохих ёсоор авч байх хэрэгтэй юм.

Манай улсын хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн эрх, эрх чөлөө хэрхэн хамгаалагддаг, эрхийг хамгаалах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх механизм хэрхэн хэрэгждэг зэргийг судалж, бидэнд тулгамдаж буй асуудлыг олж тогтоон түүнд шийдэл эрэлхийлэх нь энэхүү сэдвийг сонгох болсон үндэслэл юм.

Судалгааны ажлын зорилго: Сүүлийн гурван жилийн судалгааны үр дүнгээс харахад хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд хүчэндэх гэмт хэргийн хоригч болсоор байх бөгөөд энэ төрлийн гэмт хэргийн тоо өссөөр байна. Өссөөр байгаа шалтгааныг нь олж тогтоох түүнд шийдэл эрэлхийлэх, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн эрх, эрх чөлөөг хамгаалах төрийн оролцоог нэмэгдүүлэхэд санал дэвшүүлэх, шинэ санал дэвшүүлэх замаар тэдний бэлгийн эрх, эрх чөлөөг хамгаалах нь энэхүү судалгааны ажлын үндсэн зорилго болно

Судлагдсан байдал, шинэлэг тал: Швейцарын Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр 2014 онд IRIM судалгааны байгууллагаас хийсэн “Монгол Улс дахь жендерийн тэгш байдлын талаарх үзэл хандлага” баримт бичгийн судалгаа, Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын санхүүжилтээр 2013-2014 онд “Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрхийн үндэсний төв” төрийн бус байгууллагаас хийсэн судалгаа, Хүний эрхий үндэсний комиссын 18 дахь илтгэл зэрэг судалгаа хийсэн байна.

Гэвч 2016 оноос хойш хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бэлгийн эрх, чөлөөг дагнан судалсан судалгааны ажил байхгүй байна.

Иймд холбогдох хууль тогтоомж шинэчлэгдэж Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хууль шинэчлэгдэн батлагдаж хэрэгжиж эхэлсэн, нэмэлт өөрчлөлтүүд орсон цагаас хойш анх удаа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн эрх,

эрх чөлөө, түүнд тулгамдаж буй асуудлыг судалж байгаа нь энэхүү **судалгааны ажлыг шинэлэг тал** болно.

Судалгааны арга: Энэхүү судалгааны ажлыг бичихдээ баримт бичиг судлах буюу эмпирик болон индуктив аргыг үндэс болгон хөгжлийн бэршээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн эрх чөлөөний талаарх эрх зүйн хэм хэмжээнүүдийг судлан мэдээлэл цуглуулахын зэрэгцээ, тохиолдлуудыг шинжлэн судалж, ганцаарчилсан ярилцлага хийж, асуудалд анализ хийн дүгнэлт өгч мэдээллээ боловсруулж санал дэвшүүлэх байдлаар бичсэн.

Анализын арга: Статистик тоон судалгаа болон олон улсын эрх зүйн хэм хэмжээ, олон улсын гэрээ, конвенц, дотоодын хууль тогтоомжийн агуулга, сүүлийн жилүүдийн хохирогчийн болон гэмт хэргийн өсөлт бууралтын судалгааны дүнг нэгтгэн дүгнэсэн.

Харьцуулалтын арга: хөгжлийн бэршээлтэй охид, эмэгтэйчүүдийн бэлгийн эрх чөлөөний хэрэгжилтийн ялгаа болон адил төсөөтэй зүйлсийг гаргахын тулд энэхүү аргыг ашигласан.

Ярилцлагын арга: Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчтэй ярилцаж эрх зүйн хувьд тулгамдаж буй асуудал болон гэмт хэргийн гаралт, гомдол мэдээлэл хэрхэн гаргаж байгаа болон хүчиндэх гэмт хэрэг болон бэлгийн дарамт учруулах зөрчлийн нуугдмал байгаа талаар ганцаарчилсан ярилцлага хийж мэдээлэл авсан болно.

Нэгдүгээр бүлэг

1.1. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн эрх чөлөөг хамгаалах эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй зарим асуудал

1.1.1. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн боловсрол, бэлгийн эрх эрх чөлөөг хамгаалах төрийн үүрэг

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангийн тайланд хөгжлийн бэрхшээлтэй залуучууд, эмэгтэйчүүд өөрийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийн талаар бие даасан шийдвэр гаргаж чаддаггүй бөгөөд бие махбод, сэтгэл санааны хүчирхийлэлд өртөмтгий байдал түгээмэл байгааг дурджээ.

Хөгжлийн бэрхшээлтэй залуучууд, эмэгтэйчүүдийг бэлгийн харилцаанд орох шаардлагагүй, хүүхэд төрүүлэх, гэрлэх боломжгүй, чадваргүй гэх үзэл тэдний мэдээлэл авах, хүчирхийллээс ангид байх, найдвартай, аюулгүй нөхөн

үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломжийг нь хязгаарладаг ажээ. Түүнчлэн бэлгийн хүчирхийлэлд өртөх, хүсээгүй жирэмслэх, бэлгийн замаар дамжих халдвар авах эрсдэлийг нэмэгдүүлдэг байна. Хөгжлийн бэрхшээлтэй охид, хөвгүүдийг үе тэнгийнхэнтэй нь харьцуулахад бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэл 3 дахин өндөр байна.

Охид, эмэгтэйчүүдийг худалдаалах, бэлгийн мөлжлөгтэй холбогдсон гомдлын тоо, мөрдөн байцаалт, шүүх болон ял оногдуулах үйл ажиллагаа, түүнчлэн хохирогчдод туслалцаа үзүүлэх, нөхөн сэргээх хөтөлбөрүүдийн талаарх мэдээлэл хомс байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хохирогч эмэгтэйчүүдийн онцлог 13 хэрэгцээ, эмзэг байдалд дэмжлэг үзүүлэх чиглэлээр цагдаагийн ажилтнууд, нийгмийн болон эрүүл мэндийн ажилтнуудад сургалт явуулдаггүй байна.

Монгол Улсын нэгдэн орсон Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай, Гэр бүлийн тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай зэрэг хууль, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр, Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр -т тус тус баталгаажуулжээ. Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэм, эдийн засаг, улс төрийн хүрээний идэвхтэй оролцогч болохыг баталгаажуулсан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай хуулийг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцтой нийцүүлж 2016 онд баталсан нь Монгол Улсад эрх зүйн ээлтэй орчин бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн болно.

Бэлгийн эрх, эрх чөлөөний талаар зөвлөгөө, мэдээллээр хангагдах эрхийг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, дотоодын хууль тогтоомжоор баталгаажуулснаас гадна эрүүл мэнд, нөхөн үржихүйн, ялангуяа бэлгийн цогц боловсрол олгох хичээлийн агуулгыг насны болон жендерийн хувьд тусгай хэрэгцээт бүлгийн онцлогт тохируулан боловсруулж, ерөнхий боловсролын сургуульд албан сургалтаар, их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт сонгон судлах хичээлийн хөтөлбөрт оруулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нөхөн үржихүйн эрүүл мэнд, жендерт суурилсан хүчирхийллээс сэргийлэх, эрүүл

мэндийн тусламж, үйлчилгээ авах боломжийн талаар сургалт зохион байгуулах, брайл үсгээр сурталчилгааны материал боловсруулж түгээх, хараагүй, харааны бэрхшээлтэй эсхүл хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүмүүст зориулан хэвлэн нийтлэгдсэн бүтээлийг хүртээмжтэй болгох зэргийг холбогдох баримт бичгүүдэд тусгажээ.

Тодруулбал:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэг “Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, дарамтад өртөх, гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үр дүнтэй арга хэмжээ авах”, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг “Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, гэмт хэрэгт өртсөн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд үзүүлэх эрүүл мэнд, хууль зүйн, сэтгэл зүйн болон бусад шаардлагатай үйлчилгээг тэдгээрийн сэтгэл зүй, нас бие, сэтгэхүйн онцлогт нийцүүлэн мэргэшлийн түвшинд чанартай үзүүлэх” зэргийг дурдаж өгсөн байна.

Гэвч хэрэгжүүлэх механизм бүрэн ажиллахгүй, төрийн удирдах болон гүйцэтгэх шатны байгууллагуудын чиг үүрэг ерөнхий, зарим тохиолдолд тодорхойгүй, мөн хуулийг хэрэгжүүлж байгаа албан хаагчдын хандлага, мэдлэг хангалтгүй зэргээс шалтгаалан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг бодитой хамгаалж чадахгүй байна. Цаашлаад эдгээр хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээ, нас зэргийг тооцдоггүйн улмаас хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн эрх эрх чөлөөний асуудал орхигдох, анхаарлын гадна үлдэх явдал түгээмэл байна.

Хоёрдугаар бүлэг

2.Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн эрх чөлөөнд тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх инновац

2.1.Эрх зүйн асуудал

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 12-р бүлэг Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт Хүчиндэх, Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, бэлгийн мөлжлөг, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох хэргүүдийг хамруулан тооцно.


Цагдаагийн ерөнхий газраас Хүний эрхийн Үндэсний Комисст ирүүлсэн мэдээлэлд Эрүүгийн хуульд заасан бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд хохирогчоор тогтоогдсон тохиолдол цөөнгүй байна. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлд заасан

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Хүчиндэх гэмт хэрэгт 2018 онд улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 24 эмэгтэй хохирогчоор тогтоогдсоны


- 7 нь насанд хүрээгүй охид,
- 17 нь насанд хүрсэн эмэгтэйчүүд байна.

Харин 2019 онд бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг нийт 610 бүртгэгдсэн байна.




(Зураг:1)

Монгол улсад 2020 оны байдлаар нийт 11690 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаа бөгөөд үүнээс 4412 эмэгтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна.



(Зураг:2)


“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”




(Зураг:3)

2020 оны эхний 9 сарын тоон үзүүлэлтээс харахад бэлгийн дарамт үзүүлэх зөрчил болсноос хойш хүчиндэх гэмт хэрэг даруй 3 дахин нэмэгдсэн байна.

Энэ төрлийн гэмт хэрэгт орон нутагт амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд илүү хүчирхийлэлд өртсөн байна. (Зураг:4-с харна уу.)



(Зураг:4)



(Зураг:5) Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ангилал

Орон нутагт:

- насанд хүрээгүй 6,
- насанд хүрсэн 1 эмэгтэй хүчиндэх гэмт хэргийн хохирогчоор тогтоогдсон байна.


2018 онд тус хуулийн 12.2 дугаар зүйлд заасан Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, 12.3 дугаар зүйлд заасан Бэлгийн мөлжлөг, 12.5 дугаар зүйлд заасан Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох, 15.5 дугаар зүйлд заасан Хууль бусаар үр хөндөх гэмт хэргүүдэд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд хохирогчоор тогтоогдоогүй. Энэ нь энэ гэмт хэргийн нуугдмал байдал ямар хэмжээнд байгааг харуулж байна. Гэвч хүний эрхий Үндэсний Комиссын 18 дугаар илтгэлээс үзэхэд энэ төрлийн гэмт хэрэг гарсаар байгаа бөгөөд өргөдөл, гомдол өгдөггүй энэ төрлийн гэмт хэргүүд нуугдмал байсаар байна.

Харин 2020 оны эхний 9 сарын байдлаар

- ✓ Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 530 гарсан бол
- ✓ Хүчиндэх гэмт хэрэг 431 гарсан байна. Эдгээр гэмт хэргийн гаралтын өмнө оны мөн үетэй харьцуулаад үзвэл
- ✓ Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг -382

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

✓ Хүчиндэх гэмт хэрэг-320 тус тус өссөн байна. (Зураг:6-с үзнэ үү.)



(Зураг:6)

Бэлгийн дарамт учруулах нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг байсан бол 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс Зөрчлийн тухай хууль руу орж бэлгийн дарамт учруулсан этгээд Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээдэг болсон билээ.

Гэвч хууль тогтоогч хуульчлахдаа “Бусдад ажил, албан тушаал, нэр төр, алдар хүнд, эд хөрөнгө, сэтгэл санааны үр дагавар үүсгэж бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийх сэдлээ үг хэлээр, биеэр, өөр хэлбэрээр илэрхийлсэн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.” гэж заажээ. Гэтэл **үг хэлээр, биеэр, өөр хэлбэрээр илэрхийлсэн** гэдэгт яг ямар үг, биеэр гэдэгт яг ямар үйлдэл, өөр хэлбэрээр гэдэгт яг хэлбэрийг оруулах нь ойлгомжгүй бөгөөд тодорхойгүй байна аа. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бэлгийн эрх чөлөөг хамгаалах хамгийн чухал механизм бол урьдчилан сэргийлэх, болон хариуцлагын механизм бөгөөд хүчиндэх гэмт хэрэг үйлдэхийг таслан зогсоох механизм бол бэлгийн дарамт учруулах явдлын таслан зогсоох явдал юм.

Бэлгийн дарамт учруулсан аливаа үйлдлийн таслан зогсоож байж хүчиндэх гэмт хэргийн гаралтын тоо буурах юм.

Үүнийг тулд маш нарийн буюу тогтоосон хэм хэмжээг бий болгох шаардлагатай байна.

2.2. Гомдол гаргах, хүлээн авах болон түүнийг хянан шийдвэрлэх механизм түүнд тулгамдаж буй зарим асуудал.

Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч С.Болортуяатай ярилцлага:

Асуулт: -Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн эрх, эрх чөлөө хэрхэн зөрчигдөж байна вэ? Энэ төрлийн гэмт хэргүүд нийгэмд хэр их гарч байна вэ?

Хариулт: -Бэлгийн дарамт учруулах зөрчил болон хүчиндэх гэмт хэргийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэд хохирогч болох тохиолдол их бөгөөд харамсалтай нь энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлүүд ихэвчлэн нуугдмал байдаг. Учир нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд гомдол гаргах тохиолдол цөөн бөгөөд гомдол гаргах боломж дутмаг байдаг байна.

Асуулт: Энэ төрлийн гомдол, мэдээлэл хэр их эрдэг вэ? Нуугдмал байгаа шалтгаан нөхцөл нь юу байна?

Хариулт: - Цөөн тооны гомдол бол ирдэг тэдгээрийг бол хуулийн дагуу шийдвэрлэлдэг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа нь өргөдөл, гомдол, мэдээлэл дээр үндэслэж явагдах бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэд өргөдөл, гомдол, мэдээлэл гаргадаггүй. Үүнээс болоод тэдний эрх хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөөд хоцорч байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд өргөдөл, гомдол, мэдээлэл гаргахад дараах асуудлууд тулгамдаж байна. Үүнд

✓ Харааны бэрхшээлтэй хүмүүс дийлэнх нь бичиж чаддаггүй бөгөөд өргөдөл бичих боломжгүй байдаг. Өөрийгөө ямар хүнд хүчиндүүлсэн, хэн өөрт нь бэлгийн дарамт учруулсныг нь мэддэггүй.


✓ Хэлгүй хүмүүс өөрийгөө хүчирхийлүүлснийг бусдад хэлж чаддаггүй бөгөөд бичиг үсэггүй байх нь элбэг.

✓ Тэргэнцэртэй хүмүүс тэр бүр цагдаагийн байгууллага дэр очоод өргөдөл гомдол өгөх боломжгүй. Тэргэнцэртэй хүмүүс гадуур гарах боломж бага.

✓ Асран хамгаалагч харгалзан дэмжигчээ заавал дагуулж явахаар болдог. Тэдний зав чөлөөг хардаг.

✓ Хэрхэн өргөдөл, гомдол, мэдээлэл гаргах аргыг мэддэггүй энэ талаар мэдээлэл, мэдлэг дутмаг байдаг.

✓ Оюуны бэрхшээлтэй хүмүүс боловсрол бага бөгөөд бичиг үсэг мэддэггүй гэх мэт олон олон бэрхшээлүүд байдаг бөгөөд эдгээр нь энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил нуугдмал байгаа гол шалтгаан болж байна.



(Зураг:7)

Дээрх тоон үзүүлэлтээс харвал эмэгтэй хүмүүс гэмт хэргийн хохирогч болж байх бөгөөд гэмт хэрэг үйлдэж буй этгээдүүд нь гэмт хэрэг үйлдэхдээ хохирогчийн биеэ хамгаалж чадах байдал, хэргийн талаар бусдад мэдэгдэх чадваргүй байдлыг нь далимдуулан үйлддэг бөгөөд дараах тохиолдлуудаас харж болно.

Тохиолдол:№1

Би хэнд хүчирхийлүүлснээ мэдэж чадаагүй, бэлгийн замын халдварт өвчин авч байсан. Эмнэлэгт үзүүлэхээр очиход “Хараагүй байж хэнээсээ авдаг байна. Эрийн донтой байх нь ээ” гэж эмч хэлж байсан. Би эмнэлэгт очих дургүй. Яагаад өвчин авсан талаар асуухгүй байж шууд дүгнэлт хийдэг.

Харааны бэрхшээлтэй эмэгтэйтэй хийсэн ганцаарчилсан ярилцлага

Тохиолдол:№2

Хөдөө орон нутагт амьдардаг эмэгтэйчүүд, ялангуяа харааны бэрхшээлтэй эмэгтэйчүүд хүчирхийлэлд их өртдөг. Жишээ нь би хэнд хүчирхийлүүлснээ мэдэж чадаагүй, бэлгийн замын халдварт өвчин авч байсан. Эмнэлэгт үзүүлэхээр очиход “Хараагүй байж хэнээсээ авдаг байна. Эрийн

донтой байх нь ээ” гэж эмч хэлж байсан. Би эмнэлэгт очих дургүй. Яагаад өвчин авсан талаар асуухгүй байж шууд дүгнэлт хийдэг.

Харааны бэрхшээлтэй эмэгтэйтэй хийсэн ганцаарчилсан ярилцлага

Тохиолдол:№3

Хүчинд автаж үеэлтэйгээ бэлгийн харилцаанд орсон. Энэ тухайгаа аав, ээждээ хэлсэн ч аав дүүгээ загнаад л өнгөрсөн. Бид нар дүүгийнхтэй нь нэг хашаанд хамт амьдардаг. Тухайн үед цагдаад хэлээгүй өнгөрсөн. Нэг хашаанд байдаг болохоор дахиад хүч хэрэглэхвий гэхээс их айдаг. Хааяа жорлон орох гээд явж байхад сэмхэн манайд ороод ир гээд чирээд байдаг. Согтуу үедээ мессеж бичиж гараад ир гэх зэргээр айлгадаг.

Оюуны бэрхшээлтэй эмэгтэйтэй хийсэн ганцаарчилсан ярилцлага

Үүнээс харахад хүчиндэх гэмт хэрэг үйлдэгдсэн ч нуусан байх бөгөөд бэлгийн дарамт учруулах зөрчил үргэлжилсээр байгаа нь харагдаж байна. Гэвч тэд нуусаар.

Тохиолдол:№4

Манай ээж энэ хүнтэй суугаад 2 хүүхэд гаргасан. Хойд эцэг надтай байнга бэлгийн харилцаанд ордог. Энэ нь бараг 5 жил болж байна. Ээжид хэлсэн ч ээж энэ хүнээс салаад, яаж амьдрах вэ гэж хэлдэг. Би тэр хүний хүүхдийг хүртэл гаргасан. Цагдаад хэлэх гэхээр ээжийгээ бодоод чаддаггүй.

Оюуны бэрхшээлтэй эмэгтэйтэй хийсэн ганцаарчилсан ярилцлага

Энэ мэтчилэн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн биеэ хамгаалах чадваргүй байдлыг ашиглан хүчирхийлэх явдал гэр бүлийн гишүүд, ойр дотны хүрээллийн дотор түгээмэл бөгөөд тэднийг хамгаалах, мэдээллээр хангах, сэтгэл зүйн, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээний тогтолцоо байхгүй байна. Нөгөөтээгүүр эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг ихэнхдээ гэр бүлийн хүрээнд үйлдэж байгаа тул илрэх нь бага байна.

Энэ төрлийн гэмт хэргүүд ихэвчлэн нууц далд аргаар үйлдэгддэг бөгөөд хөдөө орон нутагт амьдардаг эмэгтэйчүүд, ялангуяа харааны бэрхшээлтэй эмэгтэйчүүд хүчирхийлэлд их өртдөг.

Иймээс хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдийг бэлгийн хүчирхийллийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, нуугдмал, далд гэмт хэргийг илрүүлэхэд чиглэсэн хяналтын механизмыг сайжруулж, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг гомдол гаргах боломжийг бий болгох шаардлагатай бөгөөд гомдол гаргах механизмыг боловсронгуй болгох арга зам эрэлхийлэх шаардлагатай байна.

2.3. Инновац

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн эрх, эрх чөлөөг хамгаалахын тулд инновацын ашиглах хэрэгцээ шаардлага бидэнд нэгэнт бий болжээ.

Бидний амьдарч буй нийгэм инновац, цахим бодлогыг биднээс шаардаж буй энэ зуунд бид цаг үетэйгээ хөл нийлүүлэн алхаж хүний эрхийг хамгаалах бодлогод инновац, цахим бодлогын ашиглах нь зүйтэй юм.

Бэлгийн болон нөхөн үржихүйн талаарх боловсролыг хаанаас авдаг эсэх талаар судалгаа хийсэн бөгөөд судалгаанд оролцогчид дараах байдлаар харуулжээ.



(Зураг:8)

Гэтэл телевизүүдийн мэдээлэл нь **харааны болон сонсголын бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй бус** байгааг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооноос 2015 онд Монгол Улсын Засгийн газарт өгсөн зөвлөмжид дурдсаныг анхаарах хэрэгтэй. Манайх энэхүү зөвлөмжийн одоогоор хүртэл биелүүлээгүй байна. Үүнээс харахад бидэнд инновацыг ашигласан шийдэл хэрэгтэй байна. Бид цахим орчныг ашиглан гар утсаар болон компьютерээр энэ бүх асуудлыг шийдвэрлэх хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн боловсролын нэмэгдүүлж тэдний бэлгийн эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх боломжтой юм.

3. Дүгнэлт, дэвшүүлж буй санал

Энэ бүхнийг дүгнэн үзвэл төр хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн эрх, эрх чөлөөг хамгаалах Олон улсын гэрээ, конвенц болон дотоодын хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байхыг хэрэгцээ тэдний эрхийг хамгаалах эрх бүхий байгууллага, ажилтан, албан тушаалтан үүргээ хангалтгүй биелүүлж байна. Үүнээс улбаалан хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн эрх, чөлөө зөрчигдөж хүчиндэх гэмт хэргийн хохирогч болох тохиолдол жилээс жилд өссөөр байна.

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн эрх, эрх чөлөөг хамгаалах урьдчилсан нөхцөл хангагдаагүй бөгөөд 2020 оны 01 сарын 10 өдөр зөрчлийн

тухай хуульд хийсэн нэмэлт өөрчлөлтөөр бэлгийн дарамт учруулах гэмт хэргийг зөрчил болгосон нь эрх зүйн хувьд ухралт болсон байна. Учир нь хүчиндэх гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх гол механизм нь бэлгийн дарамт учруулахыг таслан зогсоох явдал юм.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах арга аргачлал нь хоцрогдсон бөгөөд тэдний эрх хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж чадахгүй байна. Тэд зөрчлийн болон гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл өгөх боломж, бололцоо хомс, мэдлэг дутмаг байна.

Ийм шинэ шийдэл эрэлхийлж хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн эрх, эрх чөлөөг хамгаалах нь зүйтэй юм.

Иймд судлаачийн зүгээс дараах саналыг дэвшүүлж байна.

1. Эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүчиндэх гэмт хэргийн гаралтыг бууруулж хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг хохирогч болохоос урьдчилан сэргийлэхийн тулд Зөрчлийн тухай хуулийн 6.26. дугаар зүйлд заасан Бэлгийн дарамт учруулах гэдгийг эрүүгийн хуульд оруулах, бэлгийн дарамт гэдэгт ямар ямар үг, үйлдэл, хэлбэрийг оруулахыг хууль тогтоогч болон улсын дээд шүүхээс тайлбарлаж бүх шатны шүүх эргэлзээгүй, нэг мөр ойлгож, аливаа хэрэг маргааныг шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна.

2. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд өөрсдийн бэлгийн эрх, эрх чөлөөний эсрэг зөрчил болон гэмт хэргийн талаар эрх бүхий байгуулагд мэдэгдэх боломжийг олгох, энэ төрлийн гэмт хэрэг зөрчлийн талаарх мэдээллийг саадгүй хүргэх улмаар энэ төрлийн зөрчил гэмт хэргийн нуугдмал байдлыг таслан зогсоох үүднээс мөрдөгч болон нийгмийн ажилтантай харилцах, өргөдөл, гомдол, мэдээлэл хэрхэн бичих талаар мэдээлэл авах, хууль зүйн анхан шатны зөвлөгөө авах боломж бүхий платформыг бий болгох шаардлагатай байна. Үүнийг тулд нэг талаас цахим бодлогын байнгын хороо нөгөө талаас хуульчид, нийгмийн ажилтнууд, цагдаагийн байгууллага хамтран ажиллах шаардлагатай юм.

✓ Харааны бэрхшээлтэй, хэлгүй, сонсголын бэрхшээлтэй, хөдлөх эрхтний бэрхшээлтэй, оюуны хомсдолтой зэрэг тухайн хүний хөгжлийн бэрхшээлд тохирсон зөвлөгөө, мэдээллийг олгох.

✓ Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд тус платформыг ашиглан зөрчил болон гэмт хэргийн талаар өргөдөл, гомдол мэдээллийг эрх бүхий

байгууллага, албан тушаалтанд саадгүй, хялбар аргаар хүргэх. Нийгмийн ажилтан болон хуульчидтай харилцах

3. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах мэргэшсэн хуульчидтай болох. Манай оронд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өмгөөлдөг, хууль зүйн туслалцаа үзүүлдэг мэргэшсэн хууль дутмаг байна. Жишээ нь: ярианы болон сонсголын бэрхшээлтэй хүмүүст хууль зүйн зөвлөгөө өгөх дохионы хэлтэй хуульчид маш цөөн бөгөөд тэдний эрх хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах боломж бололцоо дутмаг байна. Иймд Монголын Хуульчидын холбоотой хамтран хуульчидын мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

4. Ном зүй

1. Ibid n 1, p 7. OHCHR: Gender stereotyping as a human rights violation”, October 2013

2. Spratt, J (2013), A Deeper Silence: The unheard experiences of women with disabilities and their sexual and reproductive health experiences – Kiribati, the Solomon Islands, and Tonga, UNFPA Pacific Sub-Regional Office, Suva, Fiji, p 10

3. UNFPA (2018), Young Persons with Disabilities: Global Study on Ending Gender Based Violence and Realising Sexual and Reproductive Health and Rights, Summary Brief, p 6.

4. UNFPA Global Study on Ending Gender-based Violence and Realising Sexual and Reproductive Health and Rights, 2018. Spratt, J (2013), A Deeper Silence: The unheard experiences of women with disabilities and their sexual and reproductive health experiences – Kiribati, the Solomon Islands, and Tonga,

5. UNFPA Pacific Sub-Regional Office, Suva, Fiji, p 10 UNFPA (2018),

6. Young Persons with Disabilities: Global Study on Ending Gender Based Violence and Realising Sexual and Reproductive Health and Rights, Summary Brief, p 6.

Эрх зүйн баримт бичгүүд

7. Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын 12,1 16,1 (e),

8. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын 25 дугаар зүйл.

9. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 29.1.1

10. Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн 3.1.13

11. Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 78 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр.

12. Хараагүй, харааны бэрхшээлтэй, эсхүл хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүмүүст зориулан хэвлэн нийтлэгдсэн бүтээлийг хүртээмжтэй болгох тухай олон улсын Марракешийн гэрээ, 2015 он.

13. Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга). 2015 он. Legalinfo.mn

14. Цагдаагийн ерөнхий газраас 2019 оны 2 дугаар сарын 22-ны өдөр ирүүлсэн 01№№/122 дугаар албан бичиг.

15. Зөрчлийн тухай хууль. 2015 он.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Д.Батням¹, Э.Буяндэлгэр²

¹Их засаг олон улсын их сургууль

Хураангуй

Монгол Улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг зохицуулсан 70 гаруй хууль, эрх зүйн акт, УИХ-ын болон Засгийн газрын 5 тогтоол, салбарын сайдын 2 тушаал, Олон улсын 3 конвенцоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалдаг. Монгол улсын хэмжээнд 2020 оны хүн амын тооллогоор хөгжлийн бэрхшээлтэй 107.075 мянган хүн байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд бие даан ажиллаж амьдрахад дэд бүтэц хамгийн чухал нөлөөтэй. Гэвч манай улсын ихэнх барилга байгууламж (олон нийтийн барилга байгууламж хамрагдаад), нийтийн тээврийн тогтолцоо болон мэдээ, мэдээллийг хүргэх хүртээмж хангалтгүй байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хууль зүйн туслалцаа авах эрхийн талаар хуулиар зайлшгүй зохицуулах харилцаа хуульд тусгалаа олоогүйгээс Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хууль ёсны эрх, ашиг сонирхолыг хамгаалах Төрийн бодлого, эрх зүйн зохицуулалт хэрэгтэй байгааг судлаач бидний бие үзэж энэхүү илтгэлдээ тусгаж байгаа билээ.

Түлхүүр үг: хууль зүйн орчин, шүүх, хүний эрх, эрх зүйн мэдлэг

НЭГ. УДИРТГАЛ

Судалгааны зорилго: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах, хууль шүүхийн өмнө эрх тэгш байх, эрх зүйн мэдлэг мэдээлэл туслалцаагаар бүрэн хангагдах таатай нөхцөлийг бүрүүлэхэд оршино.

Судалгааны зорилт: Монгол улс дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдлыг судлах, тэдгээрийн хуулиар олгогдсон эрхээ мэдэж байгаа эсэх тэрхүү эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдон тулгарч буй асуудал, хууль эрх зүй болон хууль хүчний байгууллагуудаас тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх гарц шийдлийг эрэлхийлэхэд оршино.

Судалгааны ажлын арга зүй: Судалгааны ажлаа боловсруулахын тулд уг сэдэвтэй холбогдох Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн зохицуулалтыг судлахын тулд нэгдсэн мэдээ тайланг нийлүүлж үндсэн дүгнэлтэд ашиглах анализын арга, Судалгаа тус бүрээр задалж шинэлэг санаа дэвшүүлсэн синтезийн арга, Гадаадын зарим улс орны хууль тогтоомж, эрх зүйн

зохицуулалтыг Монгол улсын хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалттай харьцуулан үзсэн харьцуулалтын арга, бусад аргуудыг ашигласан болно.

Судалгааны ажлын ач холбогдол, шинэлэг байдал: Монгол улс нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хангах зорилгоор Олон улсын гэрээ конвенцод нэгдэн өрсөн билээ. Үүнийтэй холбогдуулан онд хуралдсан бөгөөд Монгол улсад зөвлөмж хүргүүлсэн олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд чухал ач холбогдолтой.

ХОЁР. ҮНДСЭН ХЭСЭГ

2.1. Ойлголт

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын 1.2-т “хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согогтой бөгөөд уг согог нь бусад төрлийн бэрхшээлтэй нэгдэн нийлсний улмаас бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад учруулахуйц болсон этгээдийг хэлнэ гэж тодорхойлсон.

Хүн төрөлхөөсөө эрх, эрх чөлөөтэй бөгөөд аливаа улсын Үндсэн хууль энэхүү эрх, эрх чөлөөг тунхаглаж, хамгаалах суурь зохицуулалтыг бий болгодог. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар Дэлхийн 198 улсын 39 улс нь Үндсэн хуулиндаа хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхахыг хориглосон заалтыг тусгасан байна.

Монгол Улсын Үндсэн хуульд тусгайлсан зохицуулалт байхгүй. Гэсэн хэдий ч Монгол Улсын иргэн бүр Үндсэн хуулийн 14 дүгээр зүйл мөн 16 дугаар зүйлд “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш”, “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна”, эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ хэмээн заасан.

Манай улс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг зохицуулсан анхны бие даасан хуулийг 2005 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль нэртэйгээр баталсан бөгөөд 2016 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг шинэчлэн баталсан. Энэ хууль нь

Монгол Улс дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудлыг зохицуулж буй суурь хууль юм.

Тус хууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахад тэднийг нийгмийн амьдралд эрх тэгш оролцоход аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг үл тэвчих, хөгжлийн бэрхшээлтэй хүний сонголт хийх эрх, хараат бус байдлыг хүндэтгэх, сурч боловсрох, хөдөлмөрлөх, нийгэмших зэрэг бүхий л харилцаанд тэгш оролцох боломжийг бүрдүүлэхээр хуульчилсан.

Ардчилсан нийгэмд шүүхийг хүмүүс засаг төрийн эрх барихын төлөө биш харин өөрсдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, аж амьдралынхаа нийгмийн хэвийн нөхцлийг сахин хамгаалуулахын төлөө байгуулдаг байна. Ийм шүүхийг ардчиллыг хамгаалах “араа шүд” гэдэг. Харин хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд энэхүү шүүхээр өөрсдийн эрхээ хангаж хамгаалуулах нөхцөл байдал хангалттай боловсронгуй болоогүй байна. Тухайлбал:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1-д зааснаар “хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хэлнэ” гэж тодорхойлсон байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь өөрсдийн эрхээ хамгаалуулахаар шүүхэд хандах эрх нь нээлттэй хэдий хэн хэрхэн хаана хандах нь учир дутагдалтай.

2. Мэдээллийн хүртээмжтэй байдлыг хангах хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд “Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагад нийцүүлэх хүрээнд мэдээллээр үйлчилдэг хуулийн этгээд нь өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэх явцад хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах, техник, технологийн хэрэгсэл, бусадтай харьцах боломж, нөхцөлийг бүрдүүлнэ гэж заасан.

3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүний таатай, аюулгүй орчинд амьдрахад иргэн, хуулийн этгээд ялгаварлан гадуурхаж үл болно. Нийтийн тээврээр зорчих, дэд бүтэц, орон сууц, олон нийтийн барилга байгууламжид саадгүй хүрэх, нийтийн тээврийн хэрэгслээр чөлөөтэй зорчих нөхцөлийг бүрдүүлээгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүн

мэдээлэл авах, бусадтай харилцахад шаардлагатай орчин нөхцөлийг бүрдүүлээгүй нь ялгаварлан гадуурхалт гэж заасан. Гэвч төр нь ХБИ-ийн эрх зүйн шаардлагатай орчинг бүрдүүлж өгч чадахгүй байгаа нь ялгаварлан гадуурхаж байгаа хэлбэр юм. Тус хуулийн 27 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй хүн шаардлагатай хууль зүйн зөвлөгөө, тусламж үйлчилгээгээр үнэ төлбөргүй хангагдах нөхцөл бололцоог бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.” гэж заасан боловч үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авахад бүрдүүлэх баримт бичгээс эхлээд нилээн чирэгдэлтэй. Холбогдох баримт бичгийг аваачиж өгсөний дараа гарах нэг хүндрэлтэй асуудал бол тухайн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлогт нь тохируулан хууль зүйн зөвлөгөө өгч чадах уу? гэдэг асуудал төрийн болон төрийн бус байгууллагууд ХБИ-н эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, хууль тогтоомжинд тусгалаа олоогүй дутмаг байна. Яг зорилтот бүлэгтээ хүрч чаддаггүй зэрэг хүртээмжийн асуудал, эрх нь зөрчигдсөн иргэд хэнд хандаж эрхээ хамгаалуулах, зөрчигдсөн эрхээ сэргээхдээ хаана хандахаа, хэнээс зөвлөгөө авахаа мэддэггүй тул хийгдэж буй ажиллагаанууд үр дүнгүй байгаа юм.

Барилга болон хот байгуулалтын тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтэц байгуулах талаар зохицуулсан. Автотээврийн тухай хуульд 20 ба түүнээс дээш нийтийн тээврийн хэрэгсэлтэй тээвэрлэгчийн тээврийн хэрэгслийн 10-аас доошгүй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тээвэрлэхэд зориулагдсан байх бөгөөд заасан хэмжээний тээврийн хэрэгсэлгүй бол Засгийн газраас тогтоосон хэмжээ, журмын дагуу жил бүр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлбөр төлөхөөр заасан. Гэсэн хэдий ч 2007 онд гарсан энэ заалт өнөөдрийг хүртэл ганц ч нийтийн тээврийн хэрэгсэл эдгээр иргэдийн зорчих боломжийг хангаагүй байна.

4. Авто замын тухай хуулийн 4.1.11-д “замын байгууламж” гэж бүх төрлийн гүүр, тавилан, гүүрэн гарц, унадаг дугуй болон явган зорчигч, хөгжлийн бэрхшээлтэй хүн зорчиход зориулсан зам...”-ыг ойлгоно гэж заасан хэдий ч Улаанбаатар хот дахь автозамын 50 гаруй хувь нь шаардлага хангах налуу боржуурыг тавьж өгөөгүй байдаг. Хэдийгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн байдлыг сайжруулах чиглэлд хуулинд маш олон асуудлыг тусгасан байх боловч бодит байдалтай уялдаагүй байгаа нь хууль эрх зүйн орчныг сайжруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Түүнчлэн хуулийн хэрэгжилт хангалтгүй

байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тэдний хууль ёсны эрх ашиг сонирхолыг хамгаалах нийгмийн ойлголт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Монгол Улсын хэмжээнд 2020 оны хүн амын тооллогоор хөгжлийн бэрхшээлтэй 107.075 мянган хүн ам байгаа нь хүн амын 3.3 хувийг эзэлж, 2010 оноос 0,8 пунктээр буурсан байна. Үүнээс 34.860 мянга буюу 32.5 хувь нь Улаанбаатар хотод амьдарч байна. Нийслэл хотын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 34.860 хүн байгаа нь суурин хүн амын 2.5 хувийг эзэлж байна. Энэ нь улсын дундажтай харьцуулахад 0,9 пунктээр бага үзүүлэлтэй байна. Монгол улсын хүн ам өсөн нэмэгдэхийн хэрээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо тогтмол өсч байгаа учир ХБИ-ийн шаардлагатай эрх зүйн орчинг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.



5. Хөгжлийн бэрхшээлтэй нийт иргэд гэр бүлийн хүчирхийлэлд өртөх магадлал их байдаг. Гэр бүлийн хүчирхийллийг хэлбэрээр нь авч үзвэл:

1. Бие махбодийн хүчирхийлэл
2. Сэтгэл санааны хүчирхийлэл
3. Эдийн засгийн хүчирхийлэл
4. Бэлгийн хүчирхийлэл


Хянах зан үйлийн хүчирхийлэлд хамгийн их өртдөг ч өөрсдийн эрхээ мэддэггүйгээс болж эрх , хууль ёсны ашиг сонирголоо хамгаалж чаддаггүй. Хуулиар заасан эрхээ эдлэхээр холбогдох байгууллагад очиход хөгжлийн бэрхшээлийн онцлогт нь тохирсон мэргэжилтэн байхгүйгээс тулгарсан асуудлыг нь бүрэн дүүрэн ойлгож шийдэж чадахгүй байна.

2.2. Судалгаа.

Тохиолдол 1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн Б хууль зүйн зөвлөгөө авах гээд хууль зүйн туслалцааны төвд очиход хөгжлийн бэрхшээлийн онцлогт нь тохирсон зөвлөгөө өгөх шаардлагатай орчин бүрдээгүйн улмаас зөвлөө авч чадалгүй гарсан. Үүний дараагаар Хууль зүйн үндэсний хүрээлэнд очиж төлбөрийн


чадваргүй гарсан. Үүний дараагаар Хууль зүйн үндэсний хүрээлэнд очиж төлбөрийн чадваргүй мөн төрөлхийн бэрхшээлтэй /Сонсголгүй, хэлгүй/ тул өөрийн хууль ёсны ашиг сонирхолоо хамгаалуулахаар ХБИЭТХ-д заасан эрхийн дагуу үнэ төлбөргүй туслалцаа авахаар очтол бүрдүүлэх баримт бичиг хангалтгүй байна гээд зөвлөгөөг мөн адил авч чадаагүй. Баримт бичиг бүрдүүлэх нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд маш хүндрэлтэй яагаад гэвэл нэг албан байгууллага руу хүмүүсээс өөр ялгаварлаж харьцах хандлага байдаг мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харилцах чавдартай хүн байхгүй байгаа нь хугацаа алдах гэх мэт зөндөө тохиолдолд хууль эрх зүйн туслалцаа авч чадалгүй эрх нь зөрчигдөж, нийгмээс тусаарлагдаж байна.

График-01. Улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо 2019 оны байдлаар




Зураг 1 Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, дүүргээр, нийт хүн амд эзлэх хувиар, 2010, 2020 он

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”




Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо 2010 онд харьцангуй өндөр өсөлттэй байсан бол 2020 оноос харьцангуй багасаж тогтворжсон эерэг үр дүнтэй байгаа боловч эрх, хууль ёсны ашиг сонирхолоо хамгаалуулж, эрхээ эдлэж байгааг дараах Цахим сүлжээгээр авагдсан судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Уг судалгаанд нийт 118 ХБИ оролцсон




2. Таны хөгжлийн бэрхшээлийн төрөл:

108 responses




3. Та өөрийн эрхийг мэдэх үү?

116 responses




4. Яагаад та өөрийн эрхийг мэддэггүй вэ?

111 responses



5. Таны эрх ямар нэгэн байдлаар зөрчигдөж байсан уу?


117 responses



- a. Зөрчигдөж байсан. Гэхдээ хамгаалуулж чадаагүй.
- b. Зөрчигдөж байгаагүй. Эрхээ сайн мэддэг учир хамгаалж чаддаг.
- c. Зөрчигдөж байгаа эсэхийг нь мэддэггүй.

6. Таны эрх ашиг ямар шалтгааны улмаас зөрчигдсөн бэ?


109 responses




- a. Би эрхээ мэдэхгүй байсан учир зөрчигдсөн. Дараа нь мэддэг болсон.
- b. Эрхээ мэдэж байсан ч хамгаалж чадаагүй.

7. Та зөрчигдсөн эрхээ сэргээж чадсан уу?

109 responses



- a. Чадсан
- b. Чадаагүй.



Судалаагааны дүнгэлт: Судалгаанд оролцсон иргэдийн 76.8 хувь нь өөрийн хуульд заасан эрхийг мэддэггүй, 15.5 хувь нь эрхээ мэддэг боловч хамгаалж чаддаггүй хаана хандахаа мэддэггүй, 7.7 хувь буюу 9 хүн нь л эрхээ эхэлдэг.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд бие даан ажиллаж амьдрахад дэд бүтэц хамгийн чухал нөлөөтэй. Гэвч манай улсын ихэнх барилга байгууламж (олон нийтийн барилга байгууламж хамрагдаад), нийтийн тээврийн тогтолцоо болон мэдээ, мэдээллийн хүргэх хүртээмж хангалтгүй байна. Нийтийн тээврийн хэрэгслийн хүртээмж дутмаг байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүн ажил хайх, эсвэл эрүүл мэндийн тусламж дэмжлэг саадгүй авахад хүндрэл учруулдаг шалтгаан юм.

Хараа болон сонсголын бэрхшээлтэй иргэд мэдээ, мэдээлэл авахад бага хэмжээний мэдээлэл тохирох форматаар байдаг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээ хангагдаж чадахгүй байгаагийн илрэл юм. Эдгээр асуудлыг зохицуулах эрх зүйн орчны хүрээнд Барилгын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Автотээврийн тухай хууль, Автозамын тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Сонгуулийн тухай хууль, Олон нийтийн радио, телевизийн тухай хууль гэх мэт 17 хууль тогтоомж үйлчилж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 3 дугаар бүлэгт хүний ажиллаж амьдрах орчин нөхцөлийн талаар зохицуулсан. Хуулийн 6 дугаар зүйлд “хөгжлийн бэрхшээлтэй

хүний таатай, аюулгүй орчинд амьдрахад иргэн, хуулийн этгээд ялгаварлан гадуурхаж үл болно”, Нийтийн тээврээр зорчих, дэд бүтэц, орон сууц, олон нийтийн барилга байгууламжид саадгүй хүрэх, нийтийн тээврийн хэрэгслээр чөлөөтэй зорчих нөхцөлийг бүрдүүлээгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүн мэдээлэл авах, бусадтай харилцахад шаардлагатай орчин нөхцөлийг бүрдүүлээгүй нь ялгаварлан гадуурхалт гэж заасан.

Мэдээллийн хүртээмжтэй байдлыг хангах хүрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль”-ийн 11 дүгээр зүйлд “Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагад нийцүүлэх хүрээнд мэдээллээр үйлчилдэг хуулийн этгээд нь өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэх явцад хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах, техник, технологийн хэрэгсэл, бусадтай харьцах боломж, нөхцөлийг бүрдүүлнэ гэж заасан. Барилга болон хот байгуулалтын тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтэц байгуулах талаар зохицуулсан.

Автотээврийн тухай хуульд 20 ба түүнээс дээш нийтийн тээврийн хэрэгсэлтэй тээвэрлэгчийн тээврийн хэрэгслийн 10- аас доошгүй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тээвэрлэхэд зориулагдсан байх бөгөөд заасан хэмжээний тээврийн хэрэгсэлгүй бол Засгийн газраас тогтоосон хэмжээ, журмын дагуу жил бүр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлбөр төлөхөөр заасан. Гэсэн хэдий ч 2007 онд гарсан энэ заалт өнөөдрийг хүртэл ганц ч нийтийн тээврийн хэрэгсэл эдгээр иргэдийн зорчих боломжийг хангаагүй байна.

Дээрх хуулийн хэрэгжилтийн хангалтгүй байдлаас харахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах, нийгэм дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх ойлголт, тэдний эрх зүйн байдлын талаарх ойлголтыг дээшлүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хэлнэ” гэж тодорхойлсон байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь өөрсдийн эрхээ хамгаалуулахаар шүүхэд хандах эрх нь нээлттэй хэдий хэн хэрхэн хаана хандах нь учир дутагдалтай Хөгжлийн бэрхшээлтэй нийт иргэд гэр

бүлийн хүчирхийлэлд өртөх магадлал их байдаг. Гэр бүлийн хүчирхийллийг хэлбэрээр нь авч үзвэл:

5. Бие махбодийн хүчирхийлэл
6. Сэтгэл санааны хүчирхийлэл
7. Эдийн засгийн хүчирхийлэл
8. Бэлгийн хүчирхийлэл

9. Хянах зан үйлийн хүчирхийлэлд хамгийн их өртдөг ч өөрсдийн эрхээ мэддэггүйгээс эсхүл хамаалуулах боломж нь хязгаарлагдмар өөрөөр хэлбэл өөрийн эрхээ хамгаалуулахаар тодорхой байгууллагад шууд хандах боломж хязгаарлагдмал учир эрх , хууль ёсны ашиг сонирхолоо хамгаалж, хамгаалуул чаддаггүй. Хуулиар заасан эрхээ эдлэхээр холбогдох байгууллагад очиход хөгжлийн бэрхшээлийн онцлогт нь тохирсон мэргэжилтэн байхгүйгээс тулгарсан асуудлыг нь бүрэн дүүрэн ойлгож шийдэж чадахгүй байна. Тиймээс хууль зүйн туслалцаа авах шаардлагатай эрх зүйн орчин,дэд бүтэцийг бий болгож хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ЕБС-аас нь эхэлж мэргэшлийн багш өөрсдийн эрхийг нь бүрэн дүүрэн таниулж АМЬДРАЛД НЬ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОЛЦООГ БИЙ БОЛГОХ ЁСТОЙ.

Санал

1. Хууль зүйн туслалцаа үзүүлдэг иргэн, аж ахуй нэгж байгууллага болон хууль шүүхийн орчныг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зохистой байдлаар явуулах шинэ гарцыг нээх
2. Иргэдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлогийг ойлгуулж туслалцаа үзүүлэхийг уриалах

ДӨРӨВ. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай хууль ., 2016 он
2. Монгол Улсын Үндсэн хууль., 1992 он
3. Авто замын тухай хууль., 2017 он
4. Барилгын тухай хууль., 2016 он
5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авлигын талаарх ойлголт, хандлагыг тодорхойлох судалгаа., 2019 он
6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа., 2019 он

4

ДЭД БҮТЭЦ

ТЭРГЭНЦЭР ЧИРЭГЧИЙН ЗАГВАР

О. Хатанбүүвэй¹, Б.Зоригтбаатар¹, Т.Амартүвшин¹

¹Монгол улс, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль,
Мэдээлэл, Холбооны Технологийн Сургууль.

Хураангуй

Засгийн газрын 2017 оны 321-р тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо хамгааллын үндэсний хөтөлбөр”-т, тэднийг нийгмийн харилцаанд бүрэн хамрагдах боломжоор хангана гэж заасан байдаг бөгөөд энэхүү оролцоог дэмжихийн тулд бид тэргэнцэр чирэгч машины нэгэн хувилбарыг бүтээхээр зорьсон билээ.

Уг машин маань, хэрэглэгчийн аюулгүй байдлыг хангасан, доргилт багатай, хангалттай чадалтай, ашиглахад хялбар, дэлхийн зах зээл дээр зарагдаж байгаа ижил төстэй төхөөрөмжөөс хямд байхаар төлөвлөсөн.

Машины хөдлөх чадвар нь моторын чадлаас шууд хамаарна. Иймд хөтлөгчийн чадлын тооцоог бүрэн хийхийн зэрэгцээ тэжээл үүсгүүрийг нарийвчлан тооцоолох шаардлага нь нэн тэргүүний зорилт болон тавигдсан юм. Энэхүү зорилтын хүрээнд хялбар шийдэл бүхий, тэргэнцэр чирэгч цахилгаан машины эхний хувилбарыг хийж улмаар туршилт зүгшрүүлэлтийн шатандаа явж байгаагаа танилцуулж байна.

Түлхүүр үг: Хаб мотор, Speed drive контроллер, хөгжлийн бэрхшээлтэй иргэний төхөөрөмж

Судалгааны ажлын зорилго

Гар ажиллагаат тэргэнцрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, ердийн зам болон бартаатай замаар зорчих чадвартай байх, хурдыг тохиромжтой байдлаар тохируулах, хэрэглэгчид ирэх ядралт стрессийг бууруулснаар суугаа хүний өдөр тутмын амьдралыг бага ч болов хөнгөлөн, нийгмийн харилцаанд ороход нь амар хялбар болгоход оршино.

Судалгааны ажлын зорилт

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай судалгааг хийх
- Хэрэглэх техник технологуюдын шийдлийг гаргах
- Бүтээлийг угсарч, туршилт зүгшрүүлэлт хийх

Удиртгал

Бидний ажлын үндсэн зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажил эрхлэлт, бие даасан байдал, олон нийтийн оролцоог дэмжих зориулалттай ямар нэгэн



*Зураг 1.
Тэргэнцэр чирэгч машин*

төхөөрөмж бүтээх явдал билээ. 2000-аад оны эхэн үеэс хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дэмжлэг болох төрөл бүрийн туслах технологиуд гарч байсны дотор гар ажиллагаат тэргэнцэрийн ашиглалтыг сайжруулах зориулалт бүхий түлхэх хөдөлгүүртэй тэргэнцрүүд (PAPAWs), моторт хөдөлгүүртэй туслах хэрэгслүүд, гар ажиллагаат болон моторт урд талын хөтөч бэхэлгээ зэргийг дурдаж болох юм. Эдгээр

төхөөрөмжүүд гар ажиллагаат тэргэнцрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, тухайлбал тэргэнцрийг бартаа саад ихтэй замаар зорчих боломжоор хангах, илүү хурдан хөдөлгөх, хэрэглэгчид ирэх ядралт стресийг бууруулах гэх мэтийн боломжуудыг нээж өгдөг онцлогтой [1]. Харин манай улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, шат зэрэг нь харьцангуй хомс тул автомат тэргэнцэрээр зорчих хүрээ нь хязгаарлагдмал байх сул талтай. Гэвч, дээр дурдсан инженерийн шийдлүүд, монгол улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өнөөгийн байдлыг судлан гаргасан судалгааны үр дүнд үндэслэн энэхүү сэдвээр бүтээл гаргахаар шийдсэн болно. Бүтээлийн хувьд бүтэц загвар энгийн, эдийн засгийн хувьд гадны бүтээгдэхүүнүүдээс харьцангуй хямд байх ёстой гэсэн шаардлагад тулгуурлав.

Энэ төрлийн машиныг үйлдвэрлэхэд төвлөрсөн хамгийн том компаниудын нэг болох Batec компани өндөр чанарын, дээд зэрэглэлийн бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэн гаргадаг ба жижиг оврын Batec Mini 2 загвар 6999\$-оор худалдаалагдаж байна. Харин, Rio Mobility брендийн бага чадлын eDragonfly 2.0 загвар 2199\$, Alibaba, Amazon гэх мэт гадаад худалдааны сайтуудаар зарагдаж ижил төстэй төхөөрөмж хамгийн багадаа 400\$-ын үнэтэй байна. Өндөр үнэтэй эдгээр бэлэн бүтээгдэхүүнийг Монгол улсад импортоор оруулан ирсэн ч дунд болон дундаас доогуур орлоготой иргэд худалдан авч хэрэглэхэд эдийн засгийн хувьд хүндрэлтэй юм. Манайд “Асаргаа сувилгаа үзүүлдэг, мөн Асруулдаг хүн бүрт” гэх тодотголтой хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан бараа


бүтээгдэхүүн худалдаалдаг “Rehtus” компани үйл ажиллагаа явуулдаг хэдий ч дээрх шалтгааны улмаас энэ төрлийн бүтээгдэхүүнийг импортоор оруулан ирдэггүй. Өнөөгийн байдлаар, монгол улсад ганц иргэн л автомат тэргэнцэр хэрэглэж байна гэсэн судалгаа байгаа юм.

Уг асуудлуудтай холбоотой, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрал ахуйн талаар 2019 онд Азийн хөгжлийн банкнаас хийсэн “Монголд хөгжлийн бэрхшээлтэй амьдрах нь” судалгааны үр дүнгээс Хүснэгт 1-т харуулав. Монгол улсад нийт 99573 хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаагаас хөдөө орон нутагт 65228, нийслэл Улаанбаатар хотод 34345 иргэд оршин суудаг. Энэхүү судалгаанаас бид өөрсдийн ажилтай холбон үзэж зөвхөн хөдөлгөөний бэрхшээлтэй иргэдийн тоо баримтыг оруулав [2].

Ажил эрхлэлт	Ажилтай	Цалинтай	Цалингүй	Ажилд авагч	Малчин	Газар тариалан	Бизнес эрхлэгч	Бусад	Нийт
Хөдөлгөөний бэрхшээлтэй иргэдийн эзлэх хувь	32.1	27.34	16.39	1.04	43.61	0.3	7.35	3.96	100

Хүснэгт 1. Монгол улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажил эрхлэлт, бэрхшээлийн төрөл (хувиар)

Техникийн ерөнхий шийдэл



Зураг 2. Төхөөрөмжийн удирдлагын хэсгийн ерөнхий бүтэц

Бид, тэргэнцэр чирэгч машины техникийн шийдлийг нэг зангилааны мотор дээр суурилан гаргасан. Машин нь моторын автомат удирдлага, жолоодлого, зай хураагуур, эх бие, тэргэнцэрийн урд дугуй өргөгч бэхэлгээний хэсгүүдээс бүтэх бөгөөд удирдлагын дотоод бүтцийг Зураг 2-т үзүүлснээр зохион байгуулсан.

Хэсэг тус бүрийн үүрэг, техникийн үзүүлэлт, түүнд хийсэн тооцоо зэргийг дараах байдлаар гүйцэтгэв.

Хөдөлгүүр, Hub motor

Машиныг хөтлөн явах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор зангилааны мотор (hub motor)-ыг гар тэргэнцэрийн урд хэсэгт байрлуулсан. Зангилааны мотор ашиглахын гол давуу тал нь гинж, туузан дамжуулга хэрэглэх шаардлагагүй учир, хөдлөх системд нийлүүлж угсрах, мөн салган авахад тун хялбар байх юм. Мөн, зангилааны моторыг машины урд эсвэл хойно аль ч талд суурилуулж болох давуу талтай [3]. Зураг 3-т түгээмэл хэрэглэдэг зангилааны моторыг харуулав. Энэхүү скүүтерт (scooter) өргөн ашиглагдадаг бөгөөд харьцангуй хямд үнэтэй.



Зураг 3. Хөтлөгч дугуй бүхий зангилааны мотор

Зангилааны мотор нь цахилгаан энергийг механик энерги болгож хувиргадаг, ерөнхийдөө статор ба ротор гэсэн үндсэн хоёр хэсгээс бүрдэх төхөөрөмж юм. Цахилгаан ороомгийг ашиглаж эргэлдэх цахилгаан соронзон орон үүсгэх ба тус ороомог нь роторын битүү хөнгөн цагаан хүрээн дээр суурилж цахилгаан эргэлдэх момент үүсгэдэг.


Бид дараах нөхцөлийг хангах хөдөлгүүрийг сонгохдоо шаардагдах чадлын тооцоонд үндэслэв. Тавьсан нөхцөл:

- Машины нийт жин: 25кг
- Тэргэнцэрт суух хүний жин: 80кг
- Тэргэнцэрийн жин: 15кг
- Нийт жин: 120кг
- Дээд хурд: 15км/ц (4.1м/с) байх

Бид дараах техникийн үзүүлэлттэй моторыг сонгосон.

- Ажиллах хүчдэл: DC36В
- Хэрэглэх гүйдэл: DC14А
- Чадал: 350Вт
- Дугуйн диаметр: 20.32см

Тооцоог шулуун замд явахаар тооцож хийж болох ч өгсүүр замаар явахад энгийн замд явахаас илүү их чадал шаардагдах тул Зураг 4-т үзүүлснээр хүчний чиглэлийг авч тооцоо хийсэн.



Зураг 4. Хүчний моментууд

Системд урагш явахад шаардагдах F_{adv} (Томьёо 2), тоормослох F_f (Томьёо 1), Ньютоны III хуулийн дагуу тэнцэржүүлэх хүч буюу нормал F_n хүчнүүдээс гадна хүндийн mg хүч үйлчилнэ.

$$F_f = \mu \cdot mg \cos \alpha = 916.6H \quad (1)$$

Энд: α – гадаргуйн налалтын өнцөг (стандартаар $\alpha = 30^\circ$)

$$F_{adv} = F_f + mg \sin \alpha = 1504.6H \quad (2)$$

Энд: μ - дугуйны үрэлтийн коэффициент (резин дугуй -цардмал замын хувьд $\mu = 0.9 \div 1$ байна)

Тооцоонд моторын мушгих T момент, дугуйн R радиус, ашигласан моторын N тоо, моторын ашигт үйлийн коэффициент E ($E = 70\%$ бол) гэсэн үзүүлэлтүүдийг нэмж тооцоолсон (Томьёо 3).

$$T = [m(a + g \sin \alpha)R] \cdot \frac{100}{E \cdot N} = 296.4 \text{ H/м} \quad (3)$$


Эндээс машиныг хөдөлгөх чадлыг тооцоолов (Томьёо 4).

$$P = T\omega = 121.5\text{Вт} \quad (4)$$

Энд: ω – өнцөг хурд, тооцоогоор $\omega = 0.41$ рад/с .

Моторын удирдлага

Бид, моторын хурдыг хааз ашиглан тааруулах, тэжээл, Hall-ын мэдрүүртэй холбох бусад гэрэл, цахилгаан тормоз зэргийг холбон нэгдсэн систем болгон ажиллуулахад DC Drive ашигласан (Зураг 5). Энэ нь ерөнхийдөө тэжээлийг мотортой холбон, өөрт хэрэгтэй хурдыг гаргаж авахад зориулсан систем юм. Бидний сонгосон моторын удирлага нь орчин үеийн цахилгаан дугуй, scooter зэрэгт түлхүү хэрэглэгддэг ба алдаагүй, хялбар ажиллагаатай зэрэг давуу талтай [4].



Зураг. 5 Моторын удирдлагын гаргалууд

Эдгээрээс гадна 350Вт хүртэлх моторт ашигладаг гар хааз, Hall-ын мэдрэгч, гурван ширхэг 12V, 14Ah багтаамжтай Lead Acid зай хураагуураас бүрдэнэ.

Моторын чадал, ашиглаж буй Drive, Inverter-ийн аүк-ыг тооцон, мөн батарейний насжилт, хэрэглэгчийн хэрэглэх хугацааг уртасгах зорилгоор зай хураагуурын нийт цэнэгийн 80% -ийг хэрэглээд 20% - ийг үлдээнэ [5] гээд түүний багтаамжийг Томьео (5)-аар тооцоолов [6]. Үр дүнд нь 12.5А.цагаас багагүй багтаамжтай батарей хэрэгтэйг гэж гарсан.

$$C' = \frac{C}{0.8} = \frac{IT}{0.8} = 12.5A.цаг \quad (5)$$

Энд: I - моторын татах номинал гүйдэл, T - ашиглах хугацаа, C - батарейн багтаамж

Үр дүн

Бодит бүтээлийн хийц, ажиллагааны тест, үнэ өртгийн тооцоо, хөндлөнгийн үнэлгээ ерөнхий бүтцийн дагуу холболт хийлээ (Зураг 6). Машины үрүүл, ац, нугас зэргийг ашиглагдахаа больсон унадаг дугуйн эд ангиудыг хямд үнээр худалдан авч ашигласан болно.



(a)



(b)

Зураг 6. (a)Тэргэнцэр чирэгч машинийг тэргэнцэртэй угсарсан байдал
(b) бэхлэгээний хэсэг

Механик хийц дээр хэд хэдэн асуудалтай тулгарлаа. Үүнд:

- материалын сонголт
- хэрэглэгчид бага ачаалал өгөхийн тулд тэргэнцэрийн урд талд байрлах жижиг дугуйнууд газраас хөндийрдөг байх асуудлыг шийдэх
- тэргэнцэрт төхөөрөмжийг хэрхэн бэхлэх
- үрүүл, ац гэх мэт дугуйны эд анги олон хямд үнээр угсралт хийх

Материалын сонголтын хувьд хэрэглэгчид хөнгөн байлгах үүднээс хөнгөн цагаан материалаар эх биеийг хийх нь хамгийн зөв шийдэл байсан ч олдоц, үнэ гагнахад хүндрэлтэй байдал, үүнээс болж үүсэх үзэмжийн асуудал зэргээс хамаарч ган төмөр материалыг сонгосон.

Машиныг шулуун замд ажиллуулан туршихад мотор, моторын удирдлага бүхий систем ямар нэгэн доголдолгүй, төлөвлөгөөний дагуу бүрэн чадлаараа ажиллаж байна (Зураг 7).



Зураг 7. Шулуун замын туршилт

Дүгнэлт

Энэхүү төслийн зорилго нь суугаа хүний нийгэмд оролцох оролцоо, бие даах байдалд тус дэм болоход орших ба уг зорилгын хүрээнд олон аргууд дундаас сонгон, олон улсад хэрэглэгддэг ч монголд төдийлөн нэвтрээгүй Electric handcycle машиныг бүтээхээр болсон. Энэхүү зорилгын хүрээнд бүтээсэн машины маань ерөнхий ажиллагаа хэвийн, шулуун замд ямар нэгэн асуудалгүй явж байсан бөгөөд машины нийт өртөг 539,290₮ (189\$) болсон нь зах зээл дээрх бүтээгдэхүүнээс хямд төхөөрөмж бүтээх зорилгоо биелүүлж чадлаа.

Харин одоогоор бүтээсэн машинд байгаа үндсэн асуудлуудыг дурдахад ган төмөр материал ашигласны давуу талууд гарсан ч машины нийт жинг ихэсгэснээс хамааран өгсүүр замд мацахад хүндрэлтэй болсон, хөтлөгч дугуйн хэмжээг багадуулсан нь бартааг туулж самбаачлах чадварыг бууруулсан. Эдгээр асуудлуудыг дараа дараагийн хөгжүүлэлтэнд анхаарч, засах шаардлагатай. Одоогийн байдлаар уг машинд зориулсан техникийн шийдлүүдийг гаргах тал дээр төвлөрөн ажиллаж байна. Эцсийн дүнд, хөгжлийн бэрхшээлтэй хүн хэрэглэхэд илүү амар хялбар болгосон бэлэн бүтээгдэхүүнийг монгол инженерийн оюун ухаан, ур чадвараар гаргахыг зорин ажиллаж байна.

Ашигласан материал

- [1]. C. Ogilvie, M. Khalili, H.F.M. Van der Loos, “How Do Mobility Add-Ons Change The Loading Conditions On Manual Wheelchair Frames”, Resna Annaul Conference, 2018.
- [2]. Азийн хөгжлийн банк, Монголд хөгжлийн бэрхшээлтэй амьдрах нь” судалгаа, ISBN 978-92-9261-957-2, 2019.
- [3]. <https://www.elecycles.com/blog/post/ebike-brushed-vs-brushless-hub-motors>
- [4]. <https://www.elecycles.com/blog/post/what-you-need-to-know-about-electric-bike-controller/>
- [5]. Noor Fazil Adull Manan, Amirul 'Ariff Bin Abdul Manaf, Azzamududdin Bin Azizuddin, “E-SCOOTER” төслийн тайлан, Малайз, Universiti teknologi Mara,
- [6]. <https://www.powerstream.com/battery-capacity-calculations.htm?fbclid=IwAR0jzJwVwd5DhD0tgQsReR3MB8npEpRK76O6fiLJFZv-3dSkHyswQ4ImFqA>

REINFORCEMENT LEARNING АШИГЛАН АВТОМАТ УДИРДЛАГАТАЙ ТЭРГЭНЦРИЙН АЛГОРИТМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Гантулга Гантөмөр¹, Луубаатар Бадарч¹

¹ ШУТИС-ийн Мэдээлэл Холбооны Технологийн Сургууль

Хураангуй

Сүүлийн жилүүдэд хиймэл оюун ашиглан хүн төрөлхтний өмнө тулгарч буй олон асуудлуудыг шийдвэрлэж байна. Үүнд мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгамдаад буй асуудлуудыг шийдвэрлэхийг оролдож байгаа юм[5]. Машин сургалтын аргуудын нэг салбар болох *Reinforcement Learning (RL)* аргын судалгаа болон хэрэгжүүлэлт өргөн хийгдэж байна. Бид энэхүү ажлаар бусдын тусламжтайгаар тэргэнцэр ашиглан явдаг хүнд зориулж *RL* ашиглан тодорхой хийсвэр орчинд өөрөө явдаг тэргэнцрийн алгоритмыг хэрэгжүүлж үзсэн болно. *RL* ашиглан сургалт явуулсны үр дүнд агент хэдий дөт замаар явж байсан ч үүссэн зам нь хэт замбараагүй байх тохиолдол олон байсан. Үүнийг бид тодорхой алгоритм хэрэгжүүлэн засаж чадсан. Мөн сургалтын явц сургаж буй орчноос хамааран хэт удах, зорилгодоо хүрч чадахгүй байх зэрэг асуудал гарсныг бид сургалтын параметруудийг өөрчлөх замаар шийдэж чадсан.

Түлхүүр үгс: Reinforcement Learning, Q-Learning, Learning Rate, Discount Rate, Reward, Agent, State, Action Environment, Q-Table, Hyperparameter

Оршил

Reinforcement Learning нь машин сургалтын үндсэн 3 аргуудын нэг юм. Энэхүү сургалтын арга нь сүүлийн жилүүдэд технологийн хурдтай хөгжил компьютер ийн тооцоолох чадвар асар их нэмэгдсэн зэргээс шалтгаалан хиймэл оюуны салбарт өндөр үр дүн үзүүлэх болсон. *RL* нь бэлэн өгөгдөл дээр бус өгөгдлийг агуулж буй орчинд хандаж ажилласнаар суралцдаг ба энэ нь бидний хэрхэн хүрээлэн буй орчинтойгоо харьцаж шинэ зүйлсийг суралцдагтай төсөөтэй хэрэгждэг арга юм. *RL*-ыг Robotics, Өөртөө удирдлагатай машин, Видео тоглоом зэрэгт өргөн ашиглаж байгаа бөгөөд бидний өдөр тутамдаа хийдэг үйлдлүүдийг хөнгөвчлөх, автоматжуулах гэх мэт зорилгоор маш олон судалгааны ажлууд хийгдэж байна. *RL*-ыг ашиглан сургасан томоохон жишээнүүд нь *DeepMind-AlpaGo*, *StarCraft-II*[2], *OpenAI-Dota2* *OpenAI Five* зэрэг юм. *RL*-ийн агент нь өөрийн хүрээлэн буй орчинд тодорхой нэг үйлдэл(action) хийх ба үр дүнд агентын нөхцөл байдлаас хамааран тодорхой хэмжээний шагнал (*reward-r*) авна. *r* ямар байхаас хамааран

тухайн нөхцөл байдалд(*state*) ямар үйлдэл(*action*) хийгээд ямар нөхцөл байдалд(*state*) орсноос хамааран дүгнэх замаар агентыг сургадаг. Ийм бүтцээр задалж үзсэнийг MDP(*Markov Decision Problem*) гэж авч үздэг. Бидний хийсэн орчин нь тэргэнцэр ашиглаж буй хүний амьдардаг орчин гэж төсөөлж хийсэн бөгөөд тухайн орчныг үнэн зөв дүрсэлж чадвал орчин ямар байхаас үл хамааран суралцах боломжтой. Бид *LR*-ын *Q-Learning* аргыг ашиглан сургалт явуулсан.

Environment (Сургалтын орчин)

Сургалтын орчин нь агент байрлах хэсэг бөгөөд агентын зорилго $\{S_T\}$, нөхцөл байдал $\{S\}$, хийж болох үйлдлүүд $\{A\}$ болон шагнал $\{R\}$ зэргийг тодорхойлсон байна.

Agent (Агент)

Агент нь тодорхой зорилгод хүрэхийн тулд тухайн орчноос хамааран дараагийн хийх үйлдлээ тодорхойлон гүйцэтгэх үүрэгтэй[1][3.1].

State (Нөхцөл байдал)

Агентын суралцах орчноос авсан мэдээлэл ба агентын зорилгоос хамааруулж бид ямар мэдээлэл авч болохыг тодорхойлно. OpenAI-ын гаргасан Dota2 тоглоомыг хүний түвшинд тоглодог Dota2 Five агентуудыг тоглоомын пикселийг агентын нөхцөл байдал болгон сургасан байдаг.

Action (Үйлдэл)

Агентын суралцах орчноос авсан мэдээлэлд үндэслэн хийж буй үйлдэл. Үйлдлийг агентын тухайн нөхцөл байдалд хийж болох үйлдлүүдээс сонгон хийнэ. Жишээлбэл DeepMind-ийн StarCraft-II[2]-ын агентын хийж болох үйлдлүүд нь тоглоомын дүрүүдийг хөдөлгөх, сонгох, барилга барих, дайрах гэх мэт байгаа юм.

Reward (шагнал)

Шагнал нь агентын хийж буй үйлдлийг үнэлэх зорилготой ба агент муу үйлдэл хийвэл харьцангуй бага, сайн үйлдэл хийвэл харьцангуй их шагнал авна. Үнэлэх утгуудыг агентын зорилгоос хамааруулан олгоно[1][3.2]. OpenAI-Dota2 Five сургалтын орчны шагнал нь тоглогчдыг ганцаар бус багаар ажиллах үйлдлийг илүүд үзэх зорилготой байх гэх мэт[G].

Q-Learning

Q-Learning нь “*model free RL*” алгоритм юм. *Q-Learning*-ийг MDP гэж тооцогддог бүх асуудлуудад ашиглаж болох юм. Энэ нь “*model free RL*” алгоритмын давуу тал юм. Агентын байж болох бүх нөхцөл байдлуудад хийж болох үйлдлүүдийг

үнэлсэн хүснэгт (Q -Table) байх ба Q -Table нь агентын хийх үйлдлийг заадаг тархи гэж ойлгож болох бөгөөд Q -Table-ийг агентын зорилгод тааруулж өөрчлөхөд Q -Learning-ийн гол утга учир оршино. Сургалтыг хэрэгжүүлэхийн тулд “Bellman Equation”-ийг ашиглана.

$$Q_{(s,a)} = r_{(s,a)} + \gamma * \max_{a'} Q_{(s',a')} \quad (1)$$

Үүнд:

s' – үйлдэл хийсний дараах агентын нөхцөл байдал.

a' – үйлдэл хийсний дараах агентын нөхцөл байдалд хийж болох үйлдлүүд.

γ – discount rate.

$r_{(s,a)}$ – өмнөх нөхцөл байдлаас үйлдэл хийсний дараа авсан шагнал.

Bellman Equation нь агентын тухайн нөхцөл байдлаас үндэслэн хамгийн зөв гэж дүгнэж буй үйлдлийг хийсний дараа агентын шинэчлэгдсэн нөхцөл байдалд хийж болох үйлдлүүдийг дүгнэсэн үнэлгээний хамгийн ихийг авч тухайн хийсэн үйлдлээ дүгнэнэ.

Агентын зорилго нь өөр өөр байж болох ч Q -Learning нь агентыг хугацааны төгсгөлд хамгийн их шагнал авдаг байхаар сургана.

$$R = r_t + \gamma * r_{t+1} + \gamma^2 * r_{t+2} + \dots + \gamma^n * r_{t+n} \quad (2)$$

$$R \rightarrow R_{max}$$

R – Нэг үеийн турш цуглуулсан шагнал.

Шагналыг хамгийн их байлгана гэдэг санаа нь агентыг зорилгоос нь хазайлгах магадлалтай бөгөөд үүнээс зайлсхийхийн тулд сургалтын параметрууд буюу “Hyperparameter” –уудыг зөв тааруулах хэрэгтэй.

Q -Learning нь Off Policy learning алгоритм юм. Энэ нь агентын сургалтын орчинд хийх үйлдэл нь ямар нэг гаднын хүчин зүйлээс хамаарахгүй гэсэн үг юм.

Hyperparameters

Machine Learning –ийг хэрэгжүүлэхэд чухал шаардлагатай хүчин зүйл болох hyperparameter нь суралцах үйл явцыг тодорхойлдог мэдээлэл юм. [1]-д hyperparameter-уудын утга сургалтын явцад нөлөөлөх нөлөөллүүдийг харуулахад ү тухайн сургалтын орчинд 1 тэй тэнцүү байх нь буруу сонголт гэдгийг харуулж байна. Хүмүүс бид Hyperparameter –уудыг сургалтанд аль болох тааруулж тодорхойлдог.

Reinforcement Learning –д:

- **Reward (reward - r)**
- **Discount rate (gamma - γ)**
- **Learning rate (alpha - α)**
- **Initial Q-Table**
- **Randomization (epsilon - ϵ)** зэрэг нь *hyperparameter* –ууд юм.

Discount rate - γ

γ нь агентын цуглуулах шагналыг тодорхой хязгаарт барих үүрэгтэй. Өмнө хийсэн үйлдлийг тухайн нөхцөл байдалд хийж болох үйлдлүүдийн үнэлэлтээс хэр их хамаарахыг зааж өгнө.

γ их байх нь харьцангуй холын үйлдлүүдээс хамаарч үнэлгээг хийнэ гэсэн санаа юм. Сургалтын орчин, шагнал, агентын зорилгоос хамаардаг.

Learning rate - α

α нь *Q-Table* –ийг ирээдүйд авч чадах шагналаас хэр их хамааруулж өөрчлөхийг зааж өгнө[1][1].

Q-Table

Сургалтын орчин дахь бүх нөхцөл байдалд хийж болох үйлдлүүдийг үнэлэх мэдээллийг агуулсан функц юм[3][7]. Сургалтыг эхлэхэд *Q-Table* –ийг тодорхой утгуудтайгаар эхэлж болох бөгөөд тэдгээр нь суралцах явцад том нөлөө үзүүлнэ.

Randomization

Reinforcement Learning –ийн бас нэг том хүчин зүйл нь Exploration юм. Энэ нь агентыг аливаа нөхцөл байдалд үнэлгээнээс хамаарахаас илүү хийж үзээгүй зүйлээ хийхийг санал болгох буюу хүнээр сониуч хүнтэй зүйрлэж болох юм. Exploration & Exploitation –ыг суралцах орчинд тааруулж тогтвортой байлгаж чадвал илүү үр дүнг үзүүлэх магадлалтай гэж үздэг[1][1.1] ба зарим тохиолдолд заавал байх ёстой зүйлийн нэг байдаг ч зарим тохиолдолд байхаасаа байхгүй байсан нь илүү үр дүн үзүүлж болох юм.

RL Grid world

Бидний бүтээсэн *Grid World* нь нэг цэгээс саадуудыг тойрон тодорхой нэг цэгт хамгийн дөт замаар очих даалгавартай бөгөөд агент нь суралцах орчны тухай

ямар ч мэдээлэлгүйгээр (*Q-Learning*) суралцах ба хийсэн үйлдэл бүрдээ харгалзах шагналуудыг авах юм. Шар өнгөөр агент, ногоон өнгөөр байг, улаан өнгөөр саадыг дүрсэлсэн болно. Энэхүү орчны бүтцийг өөрчлөн даалгаврыг хүндрүүлэх замаар *Hyperparameter* –уудын хамаарлыг гаргаж авсан. Энэхүү хамаарлуудыг зөв гаргаж авснаар сургалтын үр дүн, суралцах хугацааг хэмнэх боломжтой. Ингэснээр тэргэнцэр ашиглаж буй хүний цагийг хэмнэх, тэргэнцэр нь хурдан шуурхай ажиллах боломжтой болох юм. Сургалтын орчныг тэргэнцрийг ашиглаж эхлэхээс өмнө тэргэнцрийн удирдах хэсэгт тодорхойлж өгөх хэрэгтэй.

Тоглоомын төлвийг параметруудтай уялдуулахын тулд эхний суралцах орчны төлвийг тооцоолоод дараа дараагийн төлвүүдийг нэг нэгээр нэмэгдүүлэн тухайн төлөв бүрд харгалзах суралцах орчнуудаг гаргаж авсан. Ингэхдээ:

$$b_{size} = a * a - \text{Тоглоомын талбарын хэмжээ}$$

(*a* – талын урт)


obs - Талбар дээр байх саадын тоо

act - Тоглоомын state бүрд хийж болох үйлдлийн тоо

$$\frac{b_{size}}{obs} = 6 \text{ байхаар } obs\text{-ийг сонгосон.}$$

$$C = \ln(b_{size} * obs + b_{size} * act + obs * act) \quad (3)$$

C – Complexity score



Зураг 1 Сургалтын орчин №1

Дараа дараагийн сургалтын орчнуудыг олсон нь $a^4 + 28a^2 - 6C = 0$ (4)

Хүснэгт 1. Сургалтын орчин

№	<i>C</i>	<i>a</i>	<i>obs</i>	<i>act</i>
1	6	6	6	4
2	7	8	11	4
3	8	11	20	4

4	9	14	33	4
5	10	19	60	4
6	11	24	96	4
7	12	31	160	4
8	13	40	267	4

Сургалтын үйл явц

Сургалтын орчин - №1

Зураг 1 дээрх сургалтын орчин нь хамгийн бага төлвийн оноотой буюу $C = 6$ оноотой.

Анхны параметруудийн утга:

Reward function:

$$R = \begin{cases} \text{if agent} == \text{target} \rightarrow r = 2 \\ \text{if agent} == \text{hole} \rightarrow r = -2 \\ \text{else } (-1)/((a - 1) * 4) \end{cases} \quad (5)$$

$\gamma = 0.9$ Бидний Gridworld орчинд агент алсыг харж тухай бүрийн үйлдлээ хийх учир γ –ыг их байхаар авсан болно[1-Returns].


$\alpha = \text{None}$ (Хамгийн зөв утгыг олох)

Initial Q-Table = `np.zeros(a, a, act)` (бүх q-value –ууд 0)


Initial Q-Table–ийг 0 ээр авч рандомчлалаас татгалзсан нь хэд хэдэн удаагийн оролдлогоор сургалтын зорилго үр дүнд сөргөөр нөлөөлж байгаа нь харагдсан.

$\epsilon = 0$


Агентыг тогтвортой байлгаж бидний хийж буй туршилтыг үр дүнтэй болгохын тулд тоглоомоос рандомчлалыг хасаж тооцо




Зураг 2. With Random Q-Table




Зураг 3. With Zero Q-Table



Зураг 4. Without Random Q-Table and ϵ



Зураг 5. With Random Q-Table




Зураг 6. With Random Q-Table and ϵ

Дээрх гурван графикаас харахад дан *Random Q-Table* –ийг агентыг сургахад ашиглаж болохгүйг харуулж байна. *Random Q-Table + Epsilon Greedy* аргуудыг хослуулж үзэхэд агент сургалтын оролдлогын эхэн хэсэгт сурсан ч ϵ байгаа учир тогтворгүй явсаар олон оролдлогын дараа тогтворжиж байна. Энэ нь ϵ нь

сургалтын хугацаанд сөргөөр нөлөөлөхийг шууд харуулж байна. Зөвхөн тохирсон α болон ϵ зэргийг ашиглан хурдан хугацаанд сургаж болохыг харуулж байна.


Grid Search – ашиглан хамгийн зөв α –ыг олох нь.



Зураг 7. α range

Өөр өөр α аар нийт 12 удаа сургасны үр дүнд $\alpha = 0.7$ байхад хамгийн бага үе тоглосон байна.


Grid Search – ашиглан хамгийн зөв γ –ыг олох нь.




Зураг 8. γ range

Мөн өөр өөр γ аар нийт 12 удаа сургаснаас үр дүнд $\gamma = 0.99$ үед хамгийн бага үе тоглосон байна.

Дээрх мэдээллийг ашиглан агентыг тохирох параметртэй үед болон үл тохирох параметртэй үед ямар ялгаа гарахыг харвал тохирох параметртэй үед агент хэвийн сурч байгаа бол үл тохирох параметртэй үед агент хэт удаан сурч байгааг харж болно.



Зураг 9. Тохироогүй параметртэй



10. Тохироогүй γ тохирсон α


тухайн үйлдлээ дүгнэснээр тогтворжилт удаан явагдаж байна.

$$L = \mathbb{E}[r_{(s,a)} + \gamma * \max_{a'} Q_{(s',a')}] - Q_{(s,a)} \quad (6)$$

Дээрх тэгшитгэл агентын гаргасан алдааг бодно.


$$Q_{(s,a)} = Q_{(s,a)} + \alpha * L \quad (7)$$

Өмнө тооцоолсон алдааг ашиглан *Q-Table* –ээ шинэчлэхдээ алдааг $(1 / \alpha)$ дахин багасгаж байгаа нь хэрэв α бага байвал агентын хийсэн алдааг бууруулна. Ингэснээр жинхэнэ *Q-Table* –ын утга руу удаан дөхнө.




Мөн дээрх графикт γ -ийн буруу сонголт ямар нөлөөтэйг харж болно. Агент нь бай руу олон төрлийн замаар очиж байна. Энэ нь бидний үүсгэсэн сургалтын орчинд γ нь агентын байн дээр очих замыг бусад замаас ялгаж өгдөг гэж ойлгож болох юм. Бага байвал агент сургалтын орчинд удаан хугацаанд хайлт хийсний дараа байнд хүрэх дөт замыг олох магадлалтай болж байгаа юм.

Доорх зурагт бага болон их γ –ийг сурсан агент дээр харууллаа.




12. Бага γ



13. Их γ


Сургалтын орчин - №5

$C = 10$ Энэ талбар өмнөх талбараас харьцангуй хэцүү ба γ –ын хэмжээ их байх ёстой гэдэг нь суралцсан үр дүнгээс харагдаж байна.



Зураг 14. Суралцах орчин 5 сурсан агент


Grid Search – ашиглан хамгийн зөв α –ыг олох нь.



Зураг 11. α range


Хамгийн бага давталт хийсэн – 0.99, Хамгийн их давталт хийсэн – 0.1

Grid Search – ашиглан хамгийн зөв γ –ыг олох нь. Хамгийн бага давталт хийсэн – 0.99



Зураг 12. γ range


Хамгийн их давталт хийсэн – 0.3 (0.1; 0.2 – failed at training) Сургалтын орчин 5 –аас эхлэн параметруудийн доод хязгаар харагдаж эхэлж байна.



Зураг 13. Тохирсон параметртэй



Зураг 14. Тохироогүй параметртэй



Зураг 15. Тохироогүй γ тохирсон α

Энэхүү жишээн дээр агент 300 дахь оролдлого орчимд бай руу хүрч байгаа боловч γ -ын ялгаанаас болж тогтворжих хугацаа харилцан адилгүй байна. Үүнийг хүнээр төсөөлбөл γ их бол агент өөртөө итгэлтэй болох бөгөөд энэ нь агентыг олон төрлийн зам биш цөөхөн зам дагаж явах боломжийг олгож байна. Өөрөөр хэлбэл агент буруу үйлдэл хийсэн бол тухайн үйлдлийг маш буруу үйлдэл хийлээ гэж дүгнэх боломжтой болж байгаа юм.


Дээрх аргуудыг ашиглан нийт 8 сургалтын орчинд хэрэгжүүлж үзсэн. Үр дүнд Хүснэгт 2. Best and Worst Values

№	1	2	3	4	5	6	7	8
C	6	7	8	9	10	11	12	13
Alpha-optimal	0.7	0.7	0.7	0.7	0.99	0.999	0.999	1


Gamma-optimal	0.99	0.3	0.9	0.8	0.99	0.999	0.999	0.8
Alpha-bad	0.1	0.1	0.1	0.1	0.1	0.1	0.1	0.1
Gamma-bad	0.1	0.99	0.1	0.1	0.3	0.2	0.4	0.5
Best Actions	45	72	170	155	450	520	730	420

Оновчой зам сонгох

RL ашиглан тухайн орчинд гарган авсан зам нь хамгийн дөт зам ч тэргэнцэр явахад оновчтой зам биш болохыг доорх зурагнаас харж болно.



Зураг 16. Оновчгүй зам(Цагаанаар аггентын явсан замыг харуулав)




Зураг 17. Оновчтой зам(Цагаанаар аггентын явсан замыг харуулав)


Дээрх замыг явж буй хүнд хүндрэлгүй мөн дөт байлгах шаардлагатай. Үүнийг бид хялбар алгоритм ашиглан шийдэж чавсан.

Дүгнэлт

RL-ыг *Gridworld* орчинд хэрэгжүүлж хөгжлийн бэрхшээлтэй хүний тэргэнцрийг автоматжуулж болохыг амжилттай харууллаа. Сургалтын явцыг хурдасгах агентын чиглэл замыг засах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Цаашдаа энэхүү алгоритмыг бодит орчинд хэрэгжүүлэхийн тулд нарийн техник хангамжийн



Зураг 18. Оновчгүй зам(Цагаанаар аггентын явсан замыг харуулав)



Зураг 19. Оновчтой зам(Цагаанаар аггентын явсан замыг харуулав)

судалгаа хийх шаардлагатай ба тэргэнцрийг амар хялбар ашиглах зорилгоор техник, програм хангамжийн асуудлуудыг шийдэх шаардлагатай. Жишээлбэл хэрэглэгчид хялбар байлгах үүднээс мэдрэгч бүхий дэлгэц, ойлгоход хялбар үйлдлийн систем интерфэйс зэргийг шийдэж өгөх хэрэгтэй. Мөн тэргэнцрийн урд таарах таамаглаагүй саадуудыг тойрж хэрэгтэй ба үүнийг мөн машин сургалт ашиглан шийдэж болох юм.

Ашигласан материал

- [1] Richard S. Sutton and Andrew G. Barto “Reinforcement Learning: An Introduction” Second edition, in progress in The MIT Press Cambridge, Massachusetts London, England.
- [2] Oriol Vinyals, Timo Ewalds, Sergey Bartunov, Petko Georgiev Alexander Sasha Vezhnevets, Michelle Yeo, Alireza Makhzani, Heinrich Kuttler, John Agapiou, Julian Schrittwieser, John Quan, Stephen Gaffney, Stig Petersen, Karen Simonyan, Tom Schaul, Hado van Hasselt, David Silver, Timothy Lillicrap - DeepMind Kevin Calderone, Paul Keet, Anthony Brunasso, David Lawrence, Anders Ekermo, Jacob Repp, Rodney Tsing – Blizzard “StarCraft II: A New Challenge for Reinforcement Learning”.
- [3] Abhijit Gosavi “A Tutorial for Reinforcement Learning” - 1 Introduction in Department of Engineering Management and Systems Engineering Missouri University of Science and Technology 210 Engineering Management, Rolla, MO 65409.
- [4] Christopher Berner, Greg Brockman, Brooke Chan, Vicki Cheung, Przemysław “Psyho” Dębniak, Christy Dennison, David Farhi, Quirin Fischer, Shariq Hashme, Chris Hesse, Rafal Józefowicz, Scott Gray, Catherine Olsson, Jakub Pachocki, Michael Petrov, Henrique Pondé de Oliveira Pinto, Jonathan Raiman, Tim Salimans, Jeremy Schlatter, Jonas Schneider, Szymon Sidor, Ilya Sutskever, Jie Tang, Filip Wolski, Susan Zhang “Dota 2 with Large Scale Deep Reinforcement Learning” December 13, 2019
- [5] Tamei, Tomoya, et al. "Reinforcement learning of clothing assistance with a dual-arm robot." 2011 11th IEEE-RAS International Conference on Humanoid Robots. IEEE, 2011.

ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ОЮУТНУУДЫН НОМЫН САНГААР ҮЙЛЧЛҮҮЛЭХ БОЛОМЖ

Ж.Еркеш¹

¹Монгол Улсын Боловсролын Их Сургууль

Хураангуй

Өнөөгийн нийгэмд тулгамдаж буй түгээмэл асуудлуудын дийлэнх нь хүний эрхийн асуудлууд. Үүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай тэр бүр яригддаггүй бөгөөд жирийн хүмүүс эдлэж чаддаг эрх болгоныг хөгжлийн бэрхшээлтэй хүн эдлэж чаддаггүй. Түүний нэг нь харааны бэрхшээлтэй хүмүүсийн унших эрхээ бүрэн эдлэж чадахгүй байгаа нь юм. Уншиж, судлах чухал эрхээ эдлэж чадахгүй байгаа нь өнөө үед олон зүйлээс хоцрох шалтгаан болдог. Ялангуяа их дээд сургуулиудын оюутнуудын хувьд ихээхэн асуудалтай. Хичээлд нь хэрэгтэй олон ном зохиол, сурах бичгүүдийг тэр бүрчлэн интернэт болон олон нийтийн номын сангаас олж авах боломжгүй. Тийм учраас харааны бэрхшээлтэй их дээд сургуулийн оюутнуудын сургуулийн номын сангаар үйлчлүүлэх боломжийн талаар судлахаар болсон юм.

Түлхүүр үгс: Харааны бэрхшээлтэй хүн, оюутан, номын сан, унших эрх

Зорилго

Их дээд сургуулиудын харааны бэрхшээлтэй оюутнуудын сургуулийн номын сангаар үйлчлүүлэх боломжийг судлан тодорхойлж, цаашид харааны бэрхшээлтэй оюутнуудын унших эрхээ хэрхэн хангах тухай шинэ санаа гарган, практик ач холбогдолтой шийдэл дэвшүүлэх.

Зорилт

- Харааны бэрхшээлтэй хүн гэж хэн болох талаар тодруулах
- Харааны бэрхшээлтэй хүний унших эрхийн талаар олон улсын гэрээ конвенцийг судлах
- Монгол улсын харааны бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийг судлах
- Марракешийн гэрээ буюу унших бэрхшээлтэй хүмүүст зориулан хэвлэн нийтлэгдсэн бүтээлийг хүртээмжтэй болгох тухай эрх зүйн баримт бичигтэй танилцах
- Судалгааны хамрах хүрээ, судалгаа авах аргачлалаа тодорхойлон, хэрэгтэй мэдээлэл цуглуулахад тус болох асуулт, материалуудаа бэлдэх
- Их дээд сургуулиудад суралцаж буй харааны бэрхшээлтэй оюутнуудын тоог тодорхойлох

- Харааны бэрхшээлтэй оюутнуудад зориулагдсан их дээд сургуулийн номын сангийн үйлчилгээний талаар судлах
- Харааны бэрхшээлтэй оюутнуудаас номын сангаар үйлчлүүлдэг эсэх, хичээлд хэрэгцээтэй ном, сурах бичгүүдээ хэрхэн олж авдаг талаар судалгаа авах
- Харааны бэрхшээлтэй оюутнуудын номын сангаар үйлчлүүлж буй боломжийг дүгнэн, цаашид хэрхэн сайжруулах талаар шинэ санаа гарган, шийдэл дэвшүүлэх

Харааны бэрхшээлийн талаархи ойлголт

Нүд бол хүний хүрээлэн байгаа орчин тойрны тухай хамгийн жинхэнэ ялгавартай мэдээллийг хүнд өгдөг. Физиологчид аливаа хүн гаднаас авах мэдээллийн 75-90%-ийг харах эрхтний тусламжтайгаар авдаг гэж баталдаг. Гэхдээ хараагүй болчихвол авах мэдээллийн 75-90%-ийг авч чадахгүй болно гэсэн үг биш. Хүний биеийн ямар нэгэн эрхтний үйл ажиллагаа алдагдах буюу гэмтэхэд бие эрхтний нөгөө хэсгийн үйл ажиллагаа алдагдах буюу гэмтэхэд бие эрхтний нөгөө хэсгийн үйл ажиллагаа идэвхиждэг, өөрөөр хэлбэл шинэ нөхцөл байдлын холбоо үүсч улмаар тухайн согогийг нөхөх үйл ажиллагаа явагдаж эхэлдэг байна. Тухайлбал, хараагүй болоход тухайн хүний сонсох, тэмтрэх, үнэрлэх эрхтний үйл ажиллагаа идэвхиждэг. Харааны задлан ялгах хэсгийн гэмтлээс харах чадвар өөрчлөгдөхийг харааны бэрхшээл гэнэ. Ихэнхи орнуудад харах үйл ажиллагааны түвшнээс шалтгаалж, хараагүй-blind, сул хараатай-low vision гэсэн энгийн 2 ангиллыг хийсэн байдаг. Харааны бэрхшээл үүссэн хугацаанаас нь хамааруулж 1. Төрөлхийн хараагүй 2. Хараагүй болсон гэж хуваана. Харааны бэрхшээл үүсэх шалтгааныг: удамшлын шалтгаан, гадаад шалтгаан, тохиолдлын шалтгаан гэж 3 ангилж үзнэ. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас мэдээлснээр одоогоор дэлхий даяар 314 сая хүн янз бүрийн түвшний харааны бэрхшээлтэй бөгөөд түүний 45 сая хүн хараагүй хүмүүс байна.

Монгол улсын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд

4.1.1.“Хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь

хязгаарлагдсан хүнийг хэлнэ хэмээн заасан байдаг. Мөн тухайн хуулийн 6.1-т “Хүн бүр хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байж, үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэн, нийгмийн баялгаас адил хүртэх эрхтэй. Хүнийг хөгжлийн бэрхшээл болон эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхахыг хориглоно” гэж заасан байдаг. Мөн харааны бэрхшээлтэй хүмүүст зориулагдсан брайль бичгийн тухай 13.1-т “Брайль бичиг нь хараагүй хүний хэрэглэдэг үндсэн бичиг бөгөөд брайль бичгийг ашиглан мэдээлэл авах, боловсрол эзэмшин нийгмийн харилцаанд оролцох нөхцөл боломжоор хангана” гэсэн бол 15.1.2-т “хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг онцлог хэрэгцээнд нь тохирох ном, сурах бичиг, гарын авлага, материал, тусгай хэрэглээний сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслээр хангана хэмээн заасан байдаг. Харин 11.2-т “Хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрх, харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ” гэснээр 11.2.2-т “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан компьютерын дэлгэц дээрх бичгэн мэдээллийг дуу авиа руу хөрвүүлэн хувиргах дэлгэц уншигч, программ хангамж болон шинэ технологи, систем, тусгай хэрэглээний тоног төхөөрөмжийг хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх, тэдгээрийг эх хэл дээрээ ашиглах боломжийг бий болгоно” гэж тус тусад нь заагаад өгсөн байна.

Дэлхийн оюуны өмчийн байгууллагаас 2014 оны 12 сарын 03 өдөр соёрхон баталсан хараагүй, харааны бэрхшээлтэй, эсхүл хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүмүүст зориулан хэвлэн нийтлэгдсэн бүтээлийг хүртээмжтэй болгох тухай марракешийн гэрээг байгуулсан бөгөөд зохиогчийн эрхийн тухай асуудлыг тэрхүү гэрээнд тусгаж өгсөн байдаг.


Марракешийн гэрээний 6 дугаар зүйлд: “Энэхүү гэрээний хэлэлцэн тохиролцогч талын үндэсний хууль тогтоомж нь үр шим хүртэгч хүн болон түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд, эсхүл эрх бүхий байгууллагад аливаа бүтээлийн хүртээмжтэй хэлбэр бүхий хуулбар хийхийг зөвшөөрч байгаа бол хэлэлцэн тохиролцогч талын үндэсний хууль тогтоомж нь эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр хүртээмжтэй хэлбэр бүхий хуулбарыг үр шим хүртэгч хүний хэрэгцээнд зориулан импортлохыг мөн зөвшөөрнө” хэмээн заасан байдаг.

7 дугаар зүйлд: “Энэхүү гэрээний хэлэлцэн тохиролцогч талууд энэхүү гэрээний дагуу хязгаарлалт болон онцгой тохиолдлыг ашиглах эрхээ хэрэгжүүлж байгаа үр

шим хүртэгч хүмүүст энэхүү эрхээ хэрэгжүүлэх үйлдлийг хязгаарлаж байгаа техникийн үйл ажиллагаанаас зайлсхийхийн тулд эрх зүйн зохистой хамгаалалт болон хуулийн үр ашигтай арга хэмжээ авна.”

Харааны бэрхшээлтэй оюутнуудад зориулагдсан их дээд сургуулийн номын сангийн үйлчилгээний талаар судлахын тулд улсын томоохон 5 сургуулийг сонгож авч, харааны бэрхшээлтэй оюутны тоо, номын сангийн үйлчилгээ зэргийг судалсан байна. Мөн түүнчлэн тухайн сургуулиудын харааны бэрхшээлтэй оюутнуудаас номын сангаар үйлчлүүлдэг эсэх, хичээлд хэрэгцээтэй номнуудаа яаж олж авдаг талаар асууж лавласан.

Уг судалгаанд Монгол Улсын Их Сургууль, Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, Хөдөө Аж Ахуйн Их сургууль, Монголын Үндэсний Их Сургууль хэмээх 5 их сургуулийг сонгож авч тухайн сургуулиудын харааны бэрхшээлтэй оюутнуудын тоог тодорхойлсон нь дараах байдалтай байна.



Хүснэгт 17 Их дээд сургуулиудад суралцаж буй хараагүй оюутнуудын тоо

Дээрх тоонууд цөөхөн мэт байгаа хэдий ч хүний эрх бол хүн болгонд хамаатай, нэг ч хүн эрхээ эдлэх боломжоор дутагдах ёсгүй. Өгөгдсөн тоонууд зөвхөн тухайн сургуульд одоо суралцаж байгаа харааны бэрхшээлтэй оюутнуудын тоо бөгөөд өмнө нь суралцаж төгссөн оюутнуудын тоог оруулаагүй болно.

Мөн дээрх их сургуулиудын номын сангийн үйлчилгээний талаар судалсан ба тухайн сургуулиудын номын сангийн алинд ч харааны бэрхшээлтэй


“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

оюутнуудад зориулагдсан тусгай танхим, төхөөрөмж байхгүй. Зарим номын сангуудад брайль бичигтэй номнууд маш цөөхөн тоогоор байлаа.

Сургууль	Брайль номны тоо	Брайль номны нэр
МУИС	4	ЕБС-ийн сурах иргэний ёс зүйн боловсрол
МУБИС	3	Ардчиллын үндэс, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх
ШУТИС	0	-
МУИС	0	-
ХААИС	0	-

Хүснэгт 18 Их дээд сургуулиудын номын санд байгаа брайль номны тоо

Тухайн их дээд сургуулиудад суралцаж буй харааны бэрхшээлтэй оюутнуудаас сургуулийн номын сангаар үйлчлүүлдэг эсэх, хичээлд хэрэгтэй ном, сурах бичгүүдээ хаанаас яаж олж авдаг тухай асууж лавласан. Харааны бэрхшээлтэй оюутнууд ихэнхдээ сургуулийн номын сангаар үйлчлүүлдэггүй, Д.Нацагдоржийн нэрэмжит номын сангийн тусгай танхимаар үйлчлүүлдэг боловч хичээлд чухал хэрэгцээтэй номнуудын дийлэнх нь тэндээс олдоод байдаггүй гэсэн хариулт түгээмэл байв.



Диаграм 1 Харааны бэрхшээлтэй оюутнууд хичээлд хэрэгцээтэй ном, сурах бичгүүдээ янз бүрийн хэлбэрээр хаанаас олж авч байгаа байдал

Мөн түүнчлэн “Монголын Хараагүйчүүдийн холбоо”-ны дэргэд байрласан “Брайль ном хэвлэх төв”-д очиж брайль номны хүртээмж, хэвлэлийн талаар

судалсан байна. Иймд брайль ном хэвлэх төхөөрөмжийг 2017 онд Тайланд улс хандивласан бөгөөд манай улсын зүгээс одоогоор төхөөрөмж бэлдэж өгөөгүй байна. Дунджаар 200-300 хуудастай нэг брайль номыг хэвлэхэд 1-2 өдөр зарцуулдаг бөгөөд үүнээс гадна номын эхийг хянан тохиолдуулах үйл ажиллагаанд багагүй хугацаа зарцуулна. Бас брайль номны үсгийн хэмжээ том учраас энгийн номноос 2,3 дахин их хуудастай гарна гэсэн үг. Ингэхэд номын сангуудад брайль ном нийлүүлэх замаар тухайн асуудлыг шийдвэрлэхэд төвөгтэй байгаа нь харагдав.

Дүгнэлт

Дүгнэж хэлбэл тухайн их дээд сургуулиудын номын санд харааны бэрхшээлтэй оюутнуудад зориулагдсан тусгай үйлчилгээ, төхөөрөмж байхгүй. Брайль үсэгтэй номнуудын тоо маш цөөхөн бөгөөд яг хичээлд хэрэгцээтэй номнууд биш ихэнхи нь хандиваар авсан номнууд юм. Харин харааны бэрхшээлтэй оюутнуудын хувьд Д.Нацагдоржийн нэрэмжит номын сангаар үйлчлүүлдэг хэдий ч тэндээс хичээлд чухал хэрэгцээтэй ном, сурах бичгүүд бүрэн олдохгүй. Мөн сургуулийн номын сангаар үйлчлүүлдэггүй. Тиймээс брайль номыг хүрэлцээтэй байлгах нь бэрх, сургуулиудын номын санд брайль ном хүртээмжтэй байлгасан тохиолдолд ч харааны бэрхшээлтэй оюутан бүр брайль үсгээр уншиж чаддаггүй гэх мэт олон асуудал тулгарна. Иймд хамгийн оновчтой шийдэл нь харааны бэрхшээлтэй оюутнуудад ном сурах бичгийг сонсгох хэлбэрээр тусгай дүрс таних системээр дамжуулан хүргэх явдал юм. Ийм дүрс таних буюу файл хэлбэрээр байгаа текстийг уншиж өгдөг олон улсын програмууд зөндөө байдаг ба тухайн программыг суулгасан зөөврийн болон суурин компьютерийг номын сангийн танхимд тавих замаар энэ асуудлыг шийдэж болох юм. Мөн сургуулиудын салбар тус бүрийн хичээлд хэрэгцээтэй ихэнх ном, сурах бичгүүд файл хэлбэрээр байдаг. Жишээлбэл МУБИС-ийн номын санд одоогоор 72 ширхэг ном e-pub хэлбэрээр байгаа гэх мэт. Үүнд зохиогчийн эрхийн тухай асуудлыг марракешийн гэрээг үндэслээд хөндөгдөхгүйгээр ашиглана. Мөн түүнчлэн файл хэлбэрээр ном, сурах бичгүүдээ хуулах боломжгүйгээр байршуулж болно. Бүрэн хараагүй хүмүүст сонсох хэлбэрээр нь харин сул хараатай хүмүүст том үсгийн фонттой сонсох хувилбар хосолсон байдлаар тавьж болох юм. Энд доор хаяж суурин 2 компьютер, ном сурах бичгийн цахим хэлбэр л хэрэгтэй. Үүнд тийм ч их хэмжээний зардал зарцуулахгүй, тухайн сургуулиудын шилэн дансны мэдээллээс

харахад хэрэгжүүлж болохоор практик ач холбогдолтой ухаалаг шийдэл болно. Харааны бэрхшээлтэй оюутнуудын тоо цөөхөн хэдий ч хүний эрхийн асуудал бол хүн болгонд адилхан яригдана, нэг оюутан ч гэсэн сурах, унших эрхээ эдлэх боломжоор хангагдах ёстой.

Ном зүй:

1. Алтанчимэг.А. Харааны бэрхшээлтэй хүмүүст номын сан үйлчилгээг үзүүлэх нь. Нийтлэл. (2013.11.25). Улаанбаатар
2. Батцэнгэл.Г. (2020). Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтын сэтгэл зүйн үндэс. Улаанбаатар. 178-181 тал
3. Дэлхийн оюуны өмчийн байгууллага. Хараагүй, харааны бэрхшээлтэй, эсхүл хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүмүүст зориулан хэвлэн нийтлэгдсэн бүтээлийг хүртээмжтэй болгох тухай марракешийн гэрээ. (2014.12.03)
<https://view.publitas.com/disability/marrakeshiin-olon-ulsyn-geree/page/1>
4. Кензо.Х, Такаши.Т, Кенжи.И, Миюүки.Т. (2018). Тусгай хэргэцээт боловсрол. Улаанбаатар
5. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенци. (2011). Улаанбаатар. 25,26,27 дугаар зүйл
6. Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль. (2016.02.05). Улаанбаатар
7. WHO. (2020). Vision 2020 global initiative for the elimination of avoidable blindness: action plan 2006–2011
8. National library service for the blind and print disabled library of congress
<https://www.loc.gov/nls/>

**Хиймэл оюун ухаан: хөгжлийн бэрхшээл судлалын
инновацийн асуудал болох нь**

М.Нарантуяа¹

¹МУИС, БССТ

Хураангуй

Энэхүү баримтын шинжилгээгээр хөгжлийн бэрхшээл судлал дахь инновацийн үйл явцын талаарх мэдээллийг нэгтгэх, 21-р зууны иргэдэд шаардлагатай үндсэн чадварын нэг болох МХТ, хиймэл оюун ухааныг үр дүнтэй амьдрал ахуйдаа өргөнөөр хэрэглэн үйл ажиллагааныхаа үр дүнг нэмэгдүүлэх боломжийг өргөн ашиглаж буй өнөөгийн практикт дүн шинжилгээ хийх зорилготой. Судлаачдын үзэж байгаагаар хиймэл оюун ухаанд суурилсан шинэ технологиуд нь сурах үйлийн бэрхшээлтэй хүүхдийн оношлогоо, үнэлгээ, нийгмийн харилцаа, идэвхи санаачлагыг дэмжих хөндлөнгийн хүчний үүрэг, оролцоог автоматжуулан, хувь хүний хүчин зүйлийг багасгахад үнэтэй хувь нэмэр оруулж байгаа ч чанарын ахиц өөрчлөлтийг хэмжээсжүүлэхэд бэрхшээлтэй тулгарч, экспертийн үнэлгээний үнэ цэнийг улам илүү ойлгоход тус нэмэр болсон талаар эрдэмтэд дүгнэсэн байна. Мөн хиймэл оюун ухааны боловсролд оруулж буй хувь нэмэр, үр дүнгийн талаарх 200 орчим өгүүллээс 5% хүрэхгүй нь тэгш хамран сургах боловсрол, тусгай хэрэгцээт боловсролын салбарт хийсэн туршилтын үр дүнг танилцуулсан байна.

Түлхүүр үгс: хиймэл оюун ухаан, МХТ, сурах үйлийн бэрхшээл, тэгш хамран сургах, үнэлгээ, оношлогоо

Хиймэл оюун ухааны \ХОУ\ дор хүний МХТ-ийн хэрэглээнд шинжилгээ хийх замаар үйлдлийг урьдчилан таамаглах, зөвлөх, шийдвэр гаргахаар програмчлагдсан машинд суурилсан үйлдлийн системийг ойлгоно. ХОУ нь бидэнтэй харилцаанд орж, бидний орчныг өөрчилж байдаг. Ихэнхи тохиолдолд, ХОУ нь орчныг сайн судалснаар бие даан, дасан зохицдог. Өөрөөр хэлбэл, ХОУ нь хүний алдаа оноо бүхий замбараагүй үйлдэл, эсвэл удирдлага чиглүүлгэн дор, эсвэл үл чиглүүлэгдэх сургалтад тохиолдох үйлдэлд тодорхой алгаримт, зүй тогтлыг илрүүлэх замаар хөгждөг. Өгөгдөлд тодорхой зүй тогтлыг буюу паттерныг тогтоонгуут агуулга, дуу чимээ, дүрслэл эсвэл видео бичлэгийг боловсруулдаг буюу төлөвлөж, түүний дагуу гүйцэтгэлийг хангаж чаддаг.

Хүснэгт 1. ХОУ-ны түгээмэл арга техникүүд:

	Автомат хариултын систем	Зөвлөгөө өгөх систем	Робот	Автомат гаргалт	шийдвэр
Төрөлх хэлний сургалт	+	-	+		+
Компьютерийн дүрслэл	-	-	+	-	

Дүрэмд суурилсан загвар	+	+	+	+
Туршлагаас суралцах	+	+	+	+
Төлөвлөх төхөөрөмж	+	-	+	-
Таамаглах шинжилгээнүүд	+	+	-	+
Бэхжүүлэлттэй сургалт	-	+	+	-

Эх сурвалж: *Policy guidance on AI for children. UNICEF for every child report.2020*

Дээрх арга техникүүд нь хүний үйлдлийн асар их хэмжээний өгөгдлийн статистик шинжилгээнд суурилан программаа боловсруулдаг. Хэрэв дээрх өгөгдөл нь хязгаарлагдмал байгаа нь ХОУ нь тэр хэрээрээ хязгаарлагдмал байдаг тул зохион бүтээгчид салбар дундын нарийн шинжилгээнд үндэслэн үйлдэл, шийдвэрийг таамаглаж үр дүнгийн хязгаарлагдмал байдлыг сайжруулдаг. Тухайлбал, хүйс, жендер, арь өнгө, угсаа гарал, соёлын зэрэг мэдээллийг багтаах замаар үйлдэл буюу шийдвэрийг нарийн болгохын зэрэгцээ, хувийн мэдээлэл, цаашлаад тэгш шударга байдал, оролцоог дэмжсэн дижитал эко-орон зайн шийдлүүдийг эрэлхийлж байна.

ХОУ-ны хүүхдэд үзүүлэх нөлөөллийн талаарх судалгаанаас үзэхэд компьютерт суурилсан сургалтын хэрэглэгдэхүүнүүд хүүхдийн оюун ухааныг хөгжүүлэхэд эерэг бөгөөд эрчимтэй нөлөө үзүүлж байгааг тэмдэглэсэн байдаг: хүүхдийн гүйцэтгэлийг амжилттай чиглүүлж байгаа ба ганцаарчилсан тусламж авах өргөн боломжоор хангагдаж байгааг тэмдэглэсэн байдаг. Ялангуяа харилцааны тоглоомууд нь хүүхдэд эерэг мэдрэмжийг бий болгох замаар үр дүнг эрс нэмэгдүүлж байгааг тэмдэглэсэн байдаг.

Сурах үйлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд компьютерт суурилсан сургалтыг уламжлалт багшийн тайлбар, чиглүүлэгтэй хавсаргахыг зөвлөсөн байна. Ялангуяа, гэр бүлийн тоглоом, дасгалууд нь гэр бүлийн харилцааг сайжруулах, нэмэгдүүлэх, хамтдаа байх боломжийг нэмэгдүүлдэг гэжээ. Энэ нь ХОУ-ны боломж бас хязгаарлагдмал гэдгийг мартаж болохгүйтэй холбоотой ба ялангуяа хүүхдийн хувьд гарах сөрөг нөлөө нь бүрэн тогтоогдоогүй гэжээ. Тухайлбал, ХОУ-ны өгөгдлийн зорилтот бүлгийн тодорхойгүй байдал, агуулгын шинжилгээний боломжгүй байдал, янз бүрийн нийгмийн институцуудын өгөгдлийн хяналтгүй ашиглалт зэргээс урьдчилан сэргийлэх боломжгүй байдаг. Ялангуяа, түүхэн мэдээллийг ашиглах, тодорхой бүлгийн мэдээлэл нь ХОУ-д суурилсан суралцахууд сөргөөр нөлөөлөх магадлалтай. Нөгөө талаар, ХОУ бол

бизнесийн зорилготой тул хүүхдийн эрхэм чанар, ёс зүй, харилцаа хамтын сэтгэлгээнд үзүүлэх нөлөө олон талтай гэжээ.

ХОУ ба тусгай хэрэгцээ

ХОУ-ны оношлогоо, үнэлгээний хэрэглэгдэхүүний оюунлаг шинжийг нэмэгдүүлэхэд оруулж буй хувь нэмрийг боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдийн ганцаарчилсан сургалт, эмчилгээ, заслын үйл ажиллагааг тодорхойлоход үнэлсэн байдаг (Atanasios S.Drigas, 2012). Ялангуяа, ХОУ-ны тусламжтай бий болж буй сургалтын динамик, харилцааны, бүтээлч орныг тэмдэглэсэн байдаг.

Сэрж мэдрэхүйн үйлийн алдагдалтай суралцагчид

Эрхтэн тогтолцооны байнгын болон үүргийн урт хугацааны алдагдалтай суралцагчдын хөгжлийн үнэлгээ нь онош тавигдахаар эхлэх ба хамгийн түрүүнд хийгддэг. ХОУ нь хөгжлийг тасралтгүй хангах зорилготой ба үнэлгээний тасралтгүй шинжийг өөртөө агуулдаг гэж үзсэн. Тухайлбал, Jeorgoroulos (2003) нарын зохион бүтээсэн хэл ярианы хөгжлийн олон талт эмгэг өөрчлөлтүүдийг ялгаварлан оношлоход тохиромжтой танин мэдэхүйн зураглалыг боловсруулснаар аутизм болоод дислексийг ялгаварчлан оношлох боломжтой болсон гэж үздэг. Мөн онд Schipor (2003) нарын судлаачид Хэл заслын компьютерийн программ боловсруулсан нь хүүхдийн хүрсэн түвшинд тохирсон харилцааны тоглоомуудыг хүүхдээр сонгуулах боломжтой болгосон нь заслын үр дүнг эрс нэмэгдүүлсэн гэж үздэг (O.A.Schipor, 2003). Програмын зөвлөхөөр эхний бүлэгт компьютер, хоёрдахь бүлэгт мэргэжлийн хүн ажилласан ч үр дүнд ялгаагүй ахиц гарсныг тэмдэглэжээ. 2008 онд хийгдсэн сонсголын бэрхшээлтэй хүний гадаад хэл сурах программ нь амжилттай хэрэгжсэн ба дижитал мэдээлэл дүрслэл нь авиаг ялган мэдэрч хүртэхэд эерэгээр нөлөөлж, боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэхэд ХОУ-ны хувь нэмрийг нэмэгдүүлсэн (A.A Drigas, 2008). Мөн сонсголын бэрхшээлтэй хүнд зориулсан орчуулгын хэрэгсэл нь дуу чимээг зургаар дүрслэн харуулах ба ойлгоуцыг хэд дахин нэмэгдүүлэх боломжтой болгосон (J.Roach, 2018). Харааны мэдрэхүйн үүргийн алдагдлыг Mboshi нарын эрдэмтэд ХОУ-ны тусламжтайгаар нөхөх оролдлого хийсэн нь амжилттай хэрэгжүүлсэн байна (N.S.Mboshi, 2018).

Аутизмтай суралцагчид

Сэтгэцийн гурвалсан өөрчлөлт бүхий сэтгэлийн хөдөлгөөн-зан байдлын эмгэгийн нэг бол аутизм бөгөөд нийгмийн чадварын, хэл ярианы, харилцааны эмгэг өөрчлөлт нь тэдний хэрэгцээ сонирхол, зан байдлын давтагдашгүй онцлог болох давтамжит хөдөлгөөнийг нөхцөлдүүлдэг (I.Rapin, 2008). ХОУ нь тэдгээрийн шинжүүдийг үйлдэл, үйл ажиллагаанд илрүүлэн оношлогоог эрчимжүүлэхэд хүчтэй нөлөө үзүүлсэн байна. 2008 онд Sebe нарын эрдэмтэд харааны болон сонсголын төхөөрөмжүүдийг ашиглан сэтгэлийн хөдөлгөөний өөрчлөлттийг хэмжих компьютерийн программ нь хүн ба машины харилцан үйлчлэлд шинжилгээг айдас, гуниглал, аз жаргал, гайхах, уурлах, жигших гэсэн үндсэн 6 сэтгэл хөдлөлөөс гадна сонирхол, уйтгарлах, будлих\зөрчилдөх, гарцгүйн мэдрэмж зэрэг бусад догдлолуудыг илрүүлэх чадамжтай байсан (N.Sebe, 2006). Аутизмын өндөр гүйцэтгэлийн хэв шинжтэй хүүхдийн нийгмийн чадвараа бие даан дуушлүүлэхэд өндөр үр дүнтэй байсан программыг 2007 онд Riedl нарын эрдэмтэд боловсруулсан ба бодит нөхцөл байдал бүхий кейс нь тэдний зан байдлыг оновчлоход үр дүнтэй гээд насанд хүргчдийн алдаатай зан байдлыг эрс бууруулсанд ач холбогдол нь оршино гэж үзсэн (M.Riedl, 2007).

Унших, бичиж сурах үйлийн бэрхшээл

Суралцагчдын дунд унших бичих, үсэглэхдээ бэрхшээлтэй хүүхдүүд тохиолдох ба хүүхэд бэрд өөр өөр түвшний тусламж, ахга техник шаардагддаг (B.M.Macmillian, 2002). Энэхүү онцлогийг сургуулийн насанд хүрч байж илрүүлдэг ба сургуулийн хжл заслын мэргэжлийн боловсон хүчний хангамж хангалтгүй байдаг. Srihari (2008) нарын эрдэмтэд унших чадварын тестийн хүрээнд товч эссе гараар бичих даалгаварыг програмчлан нэгтгэснээр зөвхөн оношлогоог эрт хийх боломжоор хангаад зогсохгүй бичих чадварыг хөгжүүлэх боломжтой болгосон. Энд нэг талаас тодорхой үгийг зөв бичихтэй холбоотой хөдөлгөөнийг таних нөгөө талаас эвсэл талаас мэдрэлийн хиймэл судлуудаар дамжуулан хүлээн авуурын үйл ажиллагааг хянах боломжтой болгосон (S.Srihari, 2008).

Сурах үйлийн бэрхшээлийг эрт оношлох PLEDDOR программыг Jain (2009) нарын эрдэмтэд боловсруулж dyslexia, dysgraphia, dyscalculia зэрэг бэрхшээлийг цогцоор нь илрүүлэх программыг боловсруулсан (K.Jain, 2009). Энэхүү аргачлал нь 11 орцтой, 1 гарцтай программтай ба илрүүлэгч үзүүлэлт бүхий систем юм.

Hernandez (2009) нарын судлаачид SEDA (Systema Experto de Dificultades para el Aprendizaje) буюу Сурах үйлийн бэрхшээлтэй хүүхдийн экспертийн үнэлгээ-ий аргачлалыг боловсруулсан. Энэхүү шинжилгээ нь орцны үзүүлэлтүүдийг \нас, хүйс, боловсролын түвшин, унших чадвар, хүртэж ойлгох чадвар гэх мэт\ үр дүнгийн хамаарах хувьсагчид \ сэтгэц-хөдөлгөөний бүрэлдэхүүн, танин мэдэхүй хэл ярианы бүрэлдэхүүн, бие хүний шинжүүд\)-тай хамааралтай эсэхийг тогтоох суралцахуйн сурган-сэтгэл зүйн үнэлгээний аргачлал дээр суурилан хангалттай, дунд зэрэг, хангалтгүй гэх зэргээр үнэлдэг (J.Hernandez, 2008).

Bachera&Gross (2010) нарын үсэглэж уншихдээ бэрхшээлтэй тулгардаг бүх хүүхдэд зориудсан хэрэглээний программ боловсруулсан ба тоймгүй их хийгддэг алдааг алгоритмчлан, Poisson-ны регрессийг ашигласан байдаг. Үг сонголт, ганцаарчилсан сургалтын үе дэх гүйцэтгэл эрс нэмэгдсэн нь тогтоогдсон.

Dyslexia- тэй суралцагчид

Энэ нь суралцахуйд саад болдог түгээмэл бөгөд байнгын, мэдрэлийн гаралтай эмгэг юм. Palacios (2010) нарын эрдэмтэд генетикийн шинжилгээний компьютерийн FRBS программ боловсруулсан ба эрт оношлоход зориулагдсан. Kohli (2010) нар мэдрэлийн сүлжээ бүхий системд суурилсан ANN программыг боловсруулсан ба оношлогооны нилээд асуудлыг шийдвэрлэсэн байна (M.Kohli, 2010).

Математикт суралцах үйлийн бэрхшээлтэй суралцагчид

Ийм онцлогтой суралцагчид байдаг ба хиймэл оюун ухааны тусламжтайгаар тэдний суралцахуйд ахиц гарч байгаа үр дүнтэй байгаа (R.Abbott, 2006). Melis (2001) нарын судлаачид ActiveMath оюун ухааны хөгжлийг удирдах программыг боловсруулсан ба хөгжөөнт дасгал, загварчлал, эргэх холбоо бүхий агуулгыг хөгжүүлэн суралцагчдын оролцоог нэмэгдүүлж, тооцоолон бодох чадварыг хөгжүүлсэн. Энэхүү программын дагуу суралцагч нь өөрийгөө үнэлсний дараагаар зорилгоо сонгох буюу аль түвшний шалгалтад бэлдэхээ сонгон бие даан ажиллах хүсэл сонирхолтой болно.

Livne(2011) нарын алдаанд суурилсан математик мэдлэгийг үнэлэх программыг ашигласан ба их дээд сургуулийн шалгалтанд бэлдэх вэб-д суурилсан программ юм.

Anthony (2008) нарын Intelligent Tutoring System (ITS) программ нь алгебрийн тэнцэтгэл бодоход туслах зорилготой ба танин мэдэхүйг хөгжүүлэх загвар нь юм.

Gonzales (2013) нарын судлаачид суралцагчдад математикийн бодлого бодох чадварыг нэмэгдүүлэх ганцаарчилсан сургалтын программыг боловсруулсан. Энэхүү программыг оюуны бэрхшээлтэй суралцагчдад түлхүү ашиглаж болох ба Дауны хам шинжтэй хүүхдийн бодлого бодох сонирхлыг нэмэгдүүлэхэд үр дүнтэй байсан нь тогтоогдсон (C.S.Gonzales, 2010).

ADHD буюу Анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэгтэй суралцагчид
Сурах үйлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг хангадаг томоохон бүлэг асуудал бол анхаарлын дутмагшилтай холбоотой байдаг. Хиймэл оюун ухааны тусламжтайгаар эдгээр хүүхдийн оношлогоо, хөгжүүлэх үйл ажиллагаануудыг төлөвлөх боломжтой болсон (American Psychiatric Association). Robolledo-Mendez (2004) нарын судлаачид NeuroSky MindSet цахилгаан соронзон бичлэгийн төхөөрөмжийн тусламжтайгаар анхаарлыг судалсан.

Aguilar (2016) нарын судлаачид текст, график, аудио, видео хэрэглэгдэхүүний цогц аргачлалыг боловсруулж суралцагчидтай хамтран суралцах замаар үнэлэх боломжтой системийг боловсруулсан. Багшийн дэмжлэг оролцоог нүүрний зохих хөдөлгөөн бүхий зурган дүрслэлээр орлуулж хичээлийн удирдлагыг үр дүнтэй хангасан байна.

Anuradha (2017) ADHD буюу Анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэгтэй суралцагчдын оношлогоог SVM (support vector-machine) алгоритмыг ашиглан түргэвчилсэн загварыг боловсруулсан нь үр дүнтэй болсон байна. Энэхүү аргыг 6-11 настай хүүхдийн оношлогоонд ашиглахад 88.67%-ийн баталгаатай оношлогоо болсон гэжээ (J.Anuradha, 2010).

Дүгнэлт

Судалгааны үр дүнгээс үзэхэд, хөгжлийн бэрхшээл судлал-инновацийн талаарх судалгаа-туршилтууд харьцангуй хөгжиж байгаа салбар болох нь харагдаж байна. Шинжлэх ухааны технологийн шинэчлэлийг практикт нэвтрүүлэх ажлын хүрээнд боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдийн сургалтын шинэчлэлийн асуудал орхигдолгүй, хөл нийлүүлэн алхаж байгаа ч хэрэгжилт нь удаашралттай байгаа нь практик дээр мэдрэгдэж байгаа нь нууц биш юм. Иймд, дээрх амжилттай хэрэгжиж буй туршилт судалгаануудыг манай орны энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллагуудад суурилуулж,

үнэлгээ оношлогоо, үйл ажиллагааг оновчлоход эрчимтэй хэрэглэх хэрэгцээ шаардлага байна.

Эшлэл

- A.A Drigas, D. J. (2008). *Teaching English to hearing impaired individuals whose mother language is hte sigh language*.
- American Psychiatric Association, D. o. (огноо байхгүй).
- Atanasios S.Drigas, R.-E. I. (2012). *Artificial intelligence in special education: a decade review*. international journal of engineering education .
- B.M.Macmillian. (2002). *Rhyfm and reading: a critical review of the research methodology*. Journal of Research in reading.
- C.S.Gonzales, D. H. (2010). Automatic system for the detection and analysis of errors to support the personalized feedback.
- I.Rapin, R. (2008). *Autism:definition, neurobiology, screening, diagnosis*. Pediatric clinics of North America.
- J.Anuradha, T. V. (2010). Diagnosis of ADHA using SVM algorithm.
- J.Hernandez, G. F. (2008). *Expert system for the diagnosis of learning difficulties in children's basic education* . Applied computer and applied computational science.
- J.Roach. (2018). *AI technology helps students hwo are deaf learn*.
- K.Jain, P. J. (2009). *Computational diagnosis of learning disability*. International journal of recent trends in engineering .
- M.Kohli, T. (2010). *Identifyig dyslexic students by using Artificial Neural Network*. World Conference of Engineering .
- M.Riedl, R. F. (2007). *Graphical social scenarios:toward intervention and authoring for adolecsents wiht High Functioning Autism*.
- N.S.Mboshi. (2018). *Teaching learner with visiuial impairment in an inclusive educational settings*. International journal of education and research .
- N.Sebe, I. T. (2006). *Emotion recognition based on joint visual and audio cues*. international conference on Pattern recognition .
- O.A.Schipor, S. (2003). *Improving computer based speech therapy using a fuzzy expert system*. . Computing and Informatics.
- R.Abbott. (2006). *Automated expert modeling for automated students evaluation*.
- S.Srihari, J. R.-G. (2008). *Automated scoring of handwritten essays in reading comprehension tests*. Artificial intelligence.

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨЛТӨНД ХӨГЖЛИЙН
БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭН ЗОРЧИХОД ЗОРИУЛСАН ШАТЫГ
ОНОВЧТОЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ БОЛОМЖ**

Д. Алтанцэцэг¹

¹Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ

Хураангуй

Монгол оронд аливаа бүтээн байгуулалтыг хийж бүтээхдээ олон улсын болон улсын стандарт нормыг мөрдөж ажиллах шаардлагатай байдаг. Гэвч зарим бүтээн байгуулалтын ажил дуусахад бүх хүмүүст хүртээмжтэй, аятай тухтай орчинг бүрдүүлж чаддаггүй. Энэ нь тухайн байгууллагын бизнесийн ашигт сөргөөр нөлөөлөхөөс гадна хүний эрүүл мэндэд эрсдэл үүсгэдэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд аливаа байгууллагын нэвтрэх хэсэг нь маш чухал объект тул шатыг зөв зохион байгуулах шаардлагатай байдаг. Олон улсын стандартыг үндэслэн манай оронд шатыг хэрхэн төлөвлөж, оновчтой зохион байгуулах боломжийг судлан үзсэн болно.

Түлхүүр үг: Хүртээмжтэй орчин, гишгүүр, стандарт, хэмжээ

1. Оршил

Барилга байгууламжийн шат нь хүмүүс орон сууц, үйлчилгээний газрууд зэрэг бүхий л байгууламжид нэвтрэх үндсэн сонголт юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд шат нь маш чухал объект тул барилга баригдах үед шатыг стандартын дагуу зөв хийх шаардлагатай. Ингэснээр хүн ая тухтай явахаас гадна тэдний эрүүл мэндийг болзошгүй эрсдэлээс хамгаалж байгаа хэрэг юм. Монгол улсад одоо ашиглагдаж байгаа шатыг 2000 оноос өмнөх ба дараах гэж 2 хэсэгт хувааж болно. 2000 оноос өмнө баригдсан барилгын тооцоог Оросын холбооны улсын стандартын дагуу гүйцэтгэсэн байдаг. Харин 2000 оноос хойш баригдсан ихэнх барилгуудын орц, гарцын шат нь стандартын бус байна. Тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй хүн, харааны бэрхшээлтэй хүн, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг харгалзаж буй иргэдээс асуумж авч судалсан. Эдгээр хүмүүс худалдаа, үйлчилгээний байгууллагаар үйлчлүүлэхэд тухайн байгууллагын орох гарах хэсгийн шат зөв зохион байгуулалттай байх нь маш чухал болж байна. Мөн төрийн ба төрийн бус үйлчилгээний байгууллагууд, худалдааны төвүүдийн нийт 9 шатыг сонгон авч хэмжилт хийсэн. Иймд уг судалгааны ажлын объект болох шатны өнөөгийн байдлыг үнэлэн, цаашид хөгжлийн бэрхшээлтэй иргэн аюулгүй, эрсдэлгүй, зөв зорчиход туслах зорилгоор олон улсын стандарт хэмжээг үндэслэн барилгын шатны тооцоог хийж, санал дэвшүүлж, хэлэлцүүлэхийг зорилоо.

2. Зорилго, зорилт

Худалдаа, үйлчилгээний байгууллагын барилга байгууламжийн орох, гарах шатыг хөгжлийн бэрхшээлтэй хүн зорчиход аюулгүй байхаар хийхийн тулд судалгаа, хэмжилт хийх, стандартын дагуу тооцоо хийх, туршилт хийж үнэлэлт дүгнэлт өгөх. Дээрх зорилгыг биелүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэн тавьсан болно. Үүнд:

- Төрийн ба төрийн бус үйлчилгээний байгууллагууд, худалдааны төвүүдийн шатыг сонгон авч хэмжилт хийх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүн, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг харгалзаж буй иргэдээс судалгаа авах
- Стандартын бус шатны эрсдлийг тооцох
- Шатны стандарт үзүүлэлтүүдийг тодорхойлох
- Хөгжлийн бэрхшээлтэй хүн зорчиход зохимжтой байх шатны тооцоог стандарт нормын хэмжээнд бодох


3. Судалгааны хэсэг

3.1 Шатны олон улсын стандарт норм

Хүснэгт 1 ОХУ-ын стандарт

ШАТНЫ АЛХМЫН ХЭМЖЭЭ, ММ		ШАТНЫ МАРШЫН НАЛУУ ӨНЦӨГ, ГРАДУС
ӨРГӨН	ӨНДӨР	
4000	100	14
380	110	16
360	120	18
340	130	21
320	140	23
300	150	26
280	160	29
260	170	33
240	180	37
220	190	40

200	200	45
-----	-----	----



Зураг 1 Стандартын дагуу хийгдсэн шат



Зураг 2 Шатны налуугийн өнцөг

Хүснэгт 2 Шатыг налуугаас нь хамааруулсаннэр

Д/Д	Шатны нэр	Шатны налуу өнцөг, градус
1	Зөвшөөрөгдөх хязгаар	20-50

2	Хүн явахад тохиромжтой	30-45
3	Зөөврийн ба хавсаргасан	45-75
4	Галын ба аваарийн	=90

3.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан шатны норм

Хүртээмжтэй орчныг төлөвлөх

"Хүртээмжтэй орчин" гэдэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүн тусгай хязгаарлалтгүйгээр мэдрэх тусгай орон зайг хэлнэ.

Шат (гадаа) нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд маш чухал объект тул гишгүүр, хашлага агуулсан байх ёстой.

Төлөвлөлт, зураг төслийн үе шатанд зураг төслийн байгууллага бүр ийм орон зайн бүх шинж чанарыг харгалзан үзэж чаддаггүй.

Шатны налуу нь 1: 2-ээс ихгүй байх ёстой.

Шатны гишгүүрүүд нь тэгш, гадаргуу нь мөн тэгш байх ёстой.

Шатны ирмэг нь 0.05 м-ээс ихгүй радиустай дугуйрсан байх ёстой.

Шатны тавцан нь шулуун хөдөлгөөнөөр эсвэл эргэлт хийхэд доод хэмжээ нь 1.5 м гүн байх ёстой.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн нэвтрэх шатны нийт өргөн нь замын хөдөлгөөнийг хангахуйц өргөн байх ёстой. Дүрмийн дагуу дор хаяж 1.35 м байх ёстой.(Хүний хөдөлгөөн ихтэй бол 190 см).

Шатны гишгүүрний тоо 3 шатнаас багагүй, 12 шатнаас хэтрэхгүй байх ёстой.

1-2 алхамтай шат ашиглахыг хүлээн зөвшөөрөх боломжгүй (налуугаар солих).

Харааны бэрхшээлтэй хүмүүст чиг баримжаа олгож, шатны эхлэл ба төгсгөлийн талаар сэрэмжлүүлэхийн тулд шатны эхлэл, төгсгөлийн тавцан дээр шатнаас 0.6 м-ийн зайд анхааруулга бүхий атираат ба шар эсвэл цагаан өнгийн тод өнгөөр будсан хэсэгтэй байх ёстой. Энэ нь хараагүй хүмүүст тусална.

Гаднах шатны гишгүүрийн өргөн хамгийн багадаа 0.4 м, гадаа гишгүүрийн өндөр нь 0,12 м-ээс ихгүй байх ёстой.

Шатны хашлага нь шатны нэгэн адил чухал хэсэг юм. Энэ нь 0.9 м-ийн өндөрт 2 талаас суурилуулсан (0.85-аас 0.92 м хүртэл зөвшөөрнө).

Бариул нь дугуй хэлбэртэй, шатны хоёр талд дээд ба доод талын шатны уртаас цааш 30 см-ээс багагүй урттай хэсэгтэй байх. Бариулын хэлбэр, хэмжээ нь гараар атгахад хамгийн их тохь тухтай байх ёстой. Бариулыг найдвартай, бат бөх бэхэлсэн байх ёстой. Тэд бэхэлгээний арматуртай харьцуулахад эргэлдэж, хөдөлж болохгүй.

3.3 Монгол улсын шатны өнөөгийн байдлыг судалсан арга зүй

3.3.1 Хэмжилт, харьцуулалтын арга:

Төрийн ба төрийн бус үйлчилгээний байгууллагууд, худалдааны төвүүдийн нийт 9 шатыг сонгон авч хэмжилт хийсэн. Энэ судалгаанаас харахад стандартын дагуу зөв хийгдсэн шат 20 хувь байна. Бусад нь аль нэг үзүүлэлтээрээ шаардлага хангахгүй байна.

Хүснэгт 3 Байгууллагуудын шатны хэмжээ

№	Нэр	Гишгүүрийн хэмжээ (см)		Шат эхлэх ийн өмнөх зай (м)	Шат дууссаны дараахь зай (м)	Хашлагатай эсэх	Баригултай эсэх	Гишгүүрийн өргөн жигд эсэх	Гишгүүрийн өндөр жигд эсэх	Нэг шатны гишгүүрийн тоо	Шат хооронд эргэх зай (м)
		Өргөн	Өндөр								
1	Ерөнхий боловсролын 8-р сургуулийн байрны төв хаалга	33-36	14-17	хангалттай	хангалттай	Үгүй Налуу замтай	үгүй Налуу замтай	Үгүй	Үгүй	4	эргэлтгүй
2	Ерөнхий боловсролын 8-р сургуулийн хашааны хаалга	30, 86	7,16, 6	хангалттай	хангалттай	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	3	эргэлтгүй

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”


3	Ерөнхий боловсролын 8-р сургуулийн хашаан доторх зам	46, 54, 87,	13-20	хангалттай	хангалттай	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	5	эргэлтгүй
4	2-23-р байрны орц	32	14	1	1.4	тийм	тийм	тийм	тийм	8	1.90
5	Эмийн сан	35	12-18	1.2	1	Тийм	Үгүй	Үгүй	Үгүй	7	эргэлтгүй
6	Баян-Өндөр сумын ЗДТГ –ын байр	28	15	хангалттай	1.2	Тийм Налуу замгай	Тийм Налуу замгай	Тийм	Тийм	15	эргэлтгүй
7	2-5-р байрны тоглоомын талбайн шат	30	15	Байхгүй	хангалттай	Тийм	Үгүй	Тийм	Тийм	8	эргэлтгүй
8	Хүнсний дэлгүүр	29	9, 20	хангалттай	1.2	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	2	эргэлтгүй
9	Эрдэнэт үйлдвэрийн захиргааны байр	33	14	хангалттай	хангалттай	Тийм	Тийм	Тийм	Тийм	7+8	эргэлтгүй



Зураг 3 Хүснэгт 3-д бичигдсэн нэрсийн бодит зураг

3.3.2 Асуумж бөглөх арга

Тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй хүн, харааны бэрхшээлтэй хүн, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг харгалзаж буй иргэдээс байгууллагын гаднах шат зорчиход хэр зэрэг эрсдэлтэй байгаа тухай асуумж авч судалсан. Судалгаанд нийт 35 иргэн хамрагдсаныг доорх зурагт үзүүлэв. Судалгаанаас харахад харааны бэрхшээлтэй иргэнд шатны эхлэл, төгсгөлийн анхааруулах гишгүүр, тод өнгөөр ялгасан эхлэл, төгсгөл чухал байна, харин хөдөлгөөний бэрхшээлтэй иргэний хувьд шатны гишгүүр өндөр байх нь хамгийн их бэрхшээлтэй байдаг байна.



Зураг 4 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн шатаар явахад үүсдэг хүндрэл

4. Шийдэх арга зам

Барилга барих төлөвлөлт, зураг төслийн үе шатанд зураг төслийн байгууллага бүр стандартын шаардлага хангасан шатны орон зайн бүх шинж чанарыг харгалзан үзэж тусгах.



Орон сууцны 1-р давхрын зориулалтыг өөрчилж үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, хувь хүмүүст өргөтгөл барих зөвшөөрөл өгөхдөө өндөр шалгуур тавих, өргөтгөл барих явцад хяналт тавьж дүрэм журмыг мөрдүүлэх.

Олон улсын стандарт хэмжээг үндэслэн барилгын шатыг дараахь хэмжээгээр хийснээр хөгжлийн бэрхшээлтэй иргэн аюулгүй, эрсдэлгүй, зөв зорчих хүртээмжтэй орчин бүрдэх боломжтой юм.

Хүснэгт 4 Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан шатны хэмжээ

Д/Д	Шатны нэр	Шатны налуу өнцөг, градус
1	Гишгүүрийн өргөн	0.4 м-с багагүй
2	Гишгүүрийн өндөр	0,12 м-ээс ихгүй
3	Нэг шатны гишгүүрийн тоо	3 шатнаас багагүй,

		12 шатнаас хэтрэхгүй
4	1-2 алхамтай шат ашиглахыг зөвшөөрөх боломжгүй	налуугаар солих
5	Хашлага	0.9 м-ийн өндөрт 2 талд нь бат бөх
6	Бариул	шатны хоёр талд дээд ба доод талын шатны уртаас цааш 30 см-ээс багагүй урттай бат бөх
7	Шат эхлэхийн өмнөх зай (м)	0.8
8	Шат дууссаны дараахь зай (м)	1.5
9	Гишгүүрийн өргөн	жигд
10	Гишгүүрийн өндөр	жигд
11	Шат хооронд эргэх зай (м)	1.2
12	Шатны тавцан гүн	1.5 м
13	шатны нийт өргөн	1.35 м
14	шатны эхлэл, төгсгөлийн тавцан	шатнаас 0.6 м зайд барзгар гадаргуутай, шар өнгийн будагтай
15	Шатны налуу	20 градус



Зураг 5 Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тохирох шатны загвар

5. Үр дүн

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс худалдаа, үйлчилгээний байгууллагаар үйлчлүүлэхэд тухайн байгууллагын орох гарах хэсгийн шат зөв зохион байгуулалттай байх нь маш чухал болж байна.

Судалгааны ажлын объект болох шатны өнөөгийн байдлыг хэмжилт, зураг, асуумж зэргээр баримтжуулан үнэлсэн нь мэргэжлийн байгууллагууд анхаарлаа хандуулах цаг болсон байна гэдгийг харууллаа.

Аж ахуйн нэгж, байгууллагууд өөрсдийн барилга, байгууламжийн шатыг үнэлж шаардлагатай бол өөрчлөх, солих зэргээр зөв хандлагатай болно.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан шат бүхий хүртээмжтэй орчинг бүрдүүлсэн бизнесийн байгууллагын ашиг, орлого нэмэгдэнэ, нэр хүнд нь өснө.

6. Дүгнэлт

Олон улсын стандарт хэмжээг үндэслэн барилгын шатыг зөв зохион байгуулснаар хөгжлийн бэрхшээлтэй иргэн аюулгүй, эрсдэлгүй, айдасгүй явах боломж бүрдэнэ.

Стандартын дагуу үйлдвэрлэж суурилуулсан шатны элементүүд нь урт хугацааны аюулгүй ажиллагааг хангаж өгдөг.

Ингэснээр нэг ч гэсэн хүний эрүүл мэнд хамгаалагдах юм.

7. Ном зүй

<https://met-decor.ru/kak-rasschitat-ugol-naklona-lestnitsy-kalkulyator/>

<https://adcitymag.ru/razbiraemysya-s-uglom-naklona-lestnichnogo-marsha-2/>

<http://edc.energy.gov.mn/>

<https://legno-board.ru/mn/kakie-byvayut-lestnicy-vse-vidy-vnutri-i-snaruzhi-vashego-doma-raznovidnosti-sovremennyh-lestnic-dlya/>

Г.БАЗАР, М.СУГАР ТӨМӨР БЕТОН БҮТЭЭЦ-1 (Сурах бичиг) УБ 2019 он

Ж.ГЭРЭЛХҮҮ БАРИЛГЫН ПРОЦЕССЫН ТЕХНОЛОГИ (Сурах бичиг) 2005 он

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН
ХҮРТЭЭМЖИЙН ЭМПИРИК СУДАЛГАА: ГАМШГИЙН ҮЕИЙН
ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН ЖИШЭЭН ДЭЭР**

Ч.Батзориг¹

¹Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан

Хураангуй

Шинэ төрлийн титэм вирусээр үүсгэгдсэн цар тахал өвчний тархалт, мутаци, шинж тэмдэг, халдвараас хамгаалах заавар зэргийг иргэдэд олон сувгаар тэр тусмаа цахим хэлбэрээр шуурхай мэдээлж байна. Энэхүү мэдээлэх үүргийг хариуцсан төрийн байгууллагуудын цахим хуудас нь мэдээллийн албан ёсны эх сурвалж болохын хувьд иргэн бүрд хүртээмжтэй байх нь чухал байна. Цахим хуудасны агуулга нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй эсэхийг шалгахын тулд төрийн байгууллагын 10 цахим хуудсыг сонгон авч, олон улсын цахим хуудасны агуулгын хүртээмжийн стандартын зарим заалтыг баримтлан автомат үнэлгээний хэрэгсэл болон цахим хуудасны агуулгын хүртээмжийг үнэлэх зааварчилгаа ашиглан шалгав. Цахим хуудас дахь зураг, видео зэрэг нь хүртээмжийн стандарт зөрчсөн тохиолдлууд үнэлгээнд хамруулсан цахим хуудаснуудын дийлэнхээс илэрсэн. Өөрөөр хэлбэл, хөгжлийн бэрхшээлтэй иргэн эдгээр цахим хуудаст хандаж мэдээлэл авах үед саад бэрхшээлтэй учрах магадлалтай байна. Иймд хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг Засгийн газраас авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Түлхүүр үг: текст хувилбар, гамшгийн мэдээлэл, интернет, зөрчил, автомат үнэлгээ.

Оршил


Монгол Улсад сүүлийн жилүүдэд байгаль, нийгмийн хүчин зүйлээс үүдэлтэй аюул, ослын нэр төрөл, давтамж, хамрах хүрээ, үргэлжлэх хугацаа, учруулж буй хохирол өссөөр байна [1]. Тухайлбал, шинэ төрлийн коронавирусаар үүсгэгдсэн тахал хөрш улсаас эхлэн дэгдсэн нь Монгол Улсад шууд аюул учруулж өндөржүүлсэн бэлэн байдалд шилжихэд хүргэсэн. 2020 оны 10 дугаар сарын байдлаар нийт 38.4 сая хүн уг вирусээр халдварлаж, 1.1 сая хүн нас барсан [2] бол Монгол Улсын хувьд тус вирусийн тархалтаас сэргийлэх арга хэмжээг цаг алдалгүй авснаар дотоодод вирус халдвар бүртгэгдээгүй [3]. Гэсэн хэдий ч гаднын улс орнуудаас зөөвөрлөгдөж ирсэн 320 тохиолдол бүртгэгдээд байна [4]. Энэ шинэ төрлийн вирус нь 19 удаа мутацад орж маш эрчимтэй хувьсан өөрчлөгдөж байгаа нь вакцин бүтээхэд хүндрэл учруулж байгаагаас гадна илрэх шинж тэмдгийн хугацаа өөрчлөгдөх, гэрийн тэжээвэр амьтанд болон эхээс урагт

дамжин халдварладаг байж болзошгүй, мөн цаг агаарын нөхцөл байдлыг даган вирусийн амьдрах чадвар нь өөрчлөгдөж байгаа зэрэг онцлог байдал тогтоогдоод байна [5]. Мөн тус вирусээс хамгаалах арга хэрэгслүүдийг харьцуулж хэрхэн үр дүнтэйгээр хамгаалах арга хэмжээ авах талаар улс орнуудын судалгааны байгууллагууд зөвлөмж, заавар олон удаа шинэчлэн гаргаж байна [6]. Ийм нөхцөлд вирустэй холбоотой мэдээллийг хүн амд шуурхай, хүртээмжтэйгээр хүргэх нь чухал бөгөөд цогц мэдээллийг цахим хуудаст байршуулснаар иргэд хүссэн цагтаа хаанаас ч мэдээллийг олж авах боломжтой байна.

Ийнхүү цар тахал дэгдсэний улмаас дэлхийн улс орнуудын засгийн газар олон нийтийн хөл хорио тогтоосон нь хүн амын интернетийн хэрэглээг нэмэгдүүлж байна. Тухайлбал, цахим дэлгүүр, цахим сургалт, цахим хурал зөвлөгөөн, цахим мэдээллийн арга хэмжээ эрс нэмэгдсэн [7]. Гэвч эдгээр үйлчилгээг үзүүлж буй ихэнх цахим хуудас нь цахим хуудасны агуулгын хүртээмжийн стандартыг баримтлаагүй нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд мэдээлэл авахад саад учруулж байж болзошгүй байна [8]. Өдгөө Монгол Улсын нийт хүн амын 3.3 хувь буюу 107 мянган хүн ямар нэг хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй байна [9]. Цар тахлын үед иргэд тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрсдийгөө болон бусдыг халдвараас хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд цаг үеийн мэдээллийг шуурхай, саадгүй, хүртээмжтэйгаар авч байх ёстой. Монгол Улсын хувьд цар тахлаас урьдчилан сэргийлэх үүднээс авч хэрэгжүүлсэн чухал арга хэмжээнүүдийн нэг нь мэдээллийг албан ёсны эх сурвалжаас хүртээмжтэйгээр хүргэх тухай Улсын онцгой комиссын шийдвэр байв. Тухайлбал, тус комиссын 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн хурлаар гамшигтай холбоотой цаг үеийн мэдээллийг албан ёсны эх сурвалжаас олон нийтэд бодитой, хүртээмжтэй түгээхийг үүрэг болгосон [10].

2015 онд Хэвлэлийн хүрээлэнгээс үндэсний хэмжээнд 800 хүнийг хамруулан явуулсан “Хэвлэл мэдээлэл хэрэглэгчдийн судалгаа”-аар иргэдийн мэдээлэл хүлээн авдаг тэргүүлэх суваг нь хот, хөдөөд телевиз, цахим хуудас, социал медиа болсныг харуулсан [11]. 2019 оны байдлаар хөдөлгөөнт интернет хэрэглэгчийн бүртгэлийн тоо 3 саяд хүрсэн бол интернетийн суурин холболт хийлгэсэн бүртгэлийн тоо 303 мянгад хүрсэн байна (Зураг 1).

Зураг 1. Хөдөлгөөнт болон суурин интернет хэрэглэгчийн тоо [12].



Цахим хуудас дахь мэдээлэлд иргэд байршил, цагийн хязгаарлалтгүй хандах боломжтой тул төрийн байгууллага мэдээллээ цахим хуудастаа байршуулах эсвэл цахим мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэх нь хамгийн оновчтой зам юм [13]. Гэсэн хэдий ч цахим хуудас дахь мэдээлэл хүн бүрд хүртээмжтэй байдаггүй [14]. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүн цахим хуудаст хандахдаа дэлгэц уншигч, заагч төхөөрөмж, тусгай гар гэх мэт туслах технологиудыг хэрэглэдэг [15]. Мөн түүнчлэн ахмад настан, бага хурдтай интернет болон хуучин компьютер хэрэглэгч, мэдээллийн технологийн мэдлэг дутмаг иргэд цахим хуудаснаас мэдээлэл авахдаа бэрхшээлтэй тулгардаг байж болно [16]. Иймээс хэрэв төрийн байгууллагын цахим хуудсыг эдгээр технологи болон төхөөрөмжтэй зохицсон байхаар хөгжүүлээгүй бол зарим хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрийн байгууллагаас гаргасан цаг үеийн шинжтэй цахим мэдээлэл хүртээмжгүй байж болохоор байна.

Иймээс энэхүү судалгаагаар цар тахалтай холбоотой мэдээллийг нийтэд түгээж буй зарим төрийн байгууллагын цахим хуудас болон төрийн мэдээллийн цахим хуудас дахь агуулга хөгжлийн бэрхшээлтэй хүнд хэр хүртээмжтэй байгааг үнэллээ.

Судалгааны зорилго

Уг судалгааны ажлын зорилго нь гамшгийн үед төрөөс иргэдэд түгээж буй цахим мэдээллийн хүртээмжийг үнэлж, хөгжлийн бэрхшээлтэй хүн цахим

мэдээлэл олж авахад тулгарч болох бэрхшээлийг тодорхойлох, хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг баталгаажуулахын тулд цахим дэд бүтцийн стандартыг олон улсын стандартад үндэслэн боловсруулах шаардлагатайг харуулах юм.

Судалгааны ажлын зорилт

Дээрх судалгааны ажлын зорилгыг хэрэгжүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлсэн. Үүнд,

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан олон улсын гэрээ, конвенцыг судлах;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан Монгол Улсын эрх зүйн зохицуулалтыг судлах;
- Цахим хуудас, түүний агуулгын хүртээмжийн ойлголт, олон улсын стандартыг судлах;
- Цахим хуудасны агуулгын хүртээмжийг үнэлэх шалгуурыг олон улсын стандартад үндэслэн тодорхойлох;
- Цар тахал, гамшгийн үеийн шуурхай мэдээллийг түгээж буй зарим төрийн байгууллагын цахим хуудасны агуулгыг шалгуурын дагуу үнэлэх, үнэлгээний үр дүнд шинжилгээ хийх.

Шинэлэг байдал ба ач холбогдол

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр төрөөс авч буй арга хэмээ голчлон барилга, зам, боловсролын салбарт хэрэгжиж байна. Олон нийт дэд бүтцийн хүртээмжийн асуудал зөвхөн эдгээр салбарт тулгардаг гэсэн өрөөсгөл ойлголттой байж магадгүй. Тиймээс энэхүү судалгааны ажлаараа дэд бүтцийн хүртээмжийн асуудал мөн мэдээллийн технологийн салбарт гарч ирж байгааг харуулсанаараа онцлог юм.

Эрх зүйн зохицуулалт

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Ерөнхий Ассамблейгаас 2006 оны 12-р сарын 20-ны өдөр Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцыг баталж 2008 оны 5-р сарын 3-ны өдрөөс нэмэлтийн хамт дагаж мөрдөж эхэлсэн [17] ба Монгол Улсын Их хурал 2008 оны 12-р сарын 19-ны өдөр уг конвенцыг соёрхон баталсан [18]. Уг конвенцын 9.1.f-д “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэдээлэл хүлээн авах хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн дэмжлэг, туслалцаа

үзүүлэх зохих хэлбэрийг хөхиүлэн дэмжих”, 9.1.9-д “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс мэдээлэл, харилцаа холбооны шинэ технологи, систем, үүний дотор интернетийг хэрэглэх боломжийг нэмэгдүүлэх” гэж тус тус заажээ. Ази, Номхон далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг бодит болгоё” Инчеоны стратегийн 7 дахь зорилгыг “Хөгжлийн бэрхшээлийг хамруулсан гамшгийн эрсдэлийг бууруулах, менежментийг баталгаажуулах” гэж тодорхойлсон [19]. Эдгээр олон улсын байгууллагаас баталсан эрх зүйн баримт бичигт заасанчлан хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулахдаа хөгжлийн бэрхшээлийг нь харгалзан үзэх асуудлыг Монгол Улс гишүүн орны хувьд зайлшгүй авч үзэх шаардлагатай.

Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогыг Улсын Их хурлын 2011 оны 22 дугаар тогтоолоор баталсан. Уг тогтоолын хавсралтын 2.4-т “Аюулт үзэгдэл, болзошгүй гамшгийг тандан судлах, урьдчилан мэдээлэх арга, технологийг нэвтрүүлж, мэдээллийг хэрэглэгчид шуурхай хүргэх арга замыг боловсруулж, эртнээс сэрэмжлүүлэх тогтолцоог сайжруулна” гэж заажээ [20]. Харин 2017 оны Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын 6.1.6-д “гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгаа зохион байгуулах, мэдээллээр хангах”, 10.3.4-д “гамшгаас хамгаалах судалгаа, шинжилгээний мэдээллийг түгээх”, 10.4.3-д “гамшгийн зарлан мэдээллийг хүн амд шуурхай, хүртээмжтэй хүргэх”, 26.1.5-д “гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал, түүний эсрэг авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний талаар зарлах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тогтмол, шуурхай, хүртээмжтэй, дэлгэрэнгүй мэдээлэх” гэж заасан байна [21]. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 36.1-д “Хүний амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул, нийтийн эмх замбараагүй байдал, дайн бүхий байдал зэрэг онцгой байдал бий болох үед хөгжлийн бэрхшээлтэй хүнд энэ тухай хүртээмжтэйгээр мэдээлэх, тухайн үед амь нас, эрүүл мэндийг нь онцгой байдлын нөхцөлтэй уялдуулан хамгаалах үүргийг төрийн холбогдох байгууллага хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлнэ” гэж заажээ [22]. Гамшгийн үед эрсдэлийг бууруулахад иргэдийг мэдээллээр хангах асуудлыг ийнхүү хуульчилсан ба тэр дундаа хөгжлийн

бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэхийг онцгойлон тусгасан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний цахим мэдээллийн хүртээмжийг дэмжих бодлогын хүрээнд дараах эрх зүйн зохицуулалтууд байна. Тухайлбал, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 11.2.1-д “төрийн байгууллагын цахим хуудас хөгжлийн бэрхшээлтэй хүн мэдээллийг чөлөөтэй авах боломжийг бий болгох”, 11.2.2-т “хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан компьютерын дэлгэц дээрх бичгэн мэдээллийг дуу авиа руу хөрвүүлэн хувиргах дэлгэц уншигч, программ хангамж болон шинэ технологи, систем, тусгай хэрэглээний тоног төхөөрөмжийг хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх, тэдгээрийг эх хэл дээрээ ашиглах боломжийг бий болгох”, 11.2.4-т “цахим хуудас болон телевизийн мэдээ, мэдээлэл, танин мэдэхүйн болон өргөн нэвтрүүлгийг дохионы хэлний хэлмэрчтэй, текст унших боломжтой байдлаар нэвтрүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх” гэж заажээ [23]. Монгол Улсын стандарт “Төрийн байгууллагын вэбсайтад тавих шаардлага /MNS 6285:2016/”-ын 4.5.1-т “Хараа, сонсгол, хөдөлгөөний бэрхшээлтэй хэрэглэгчдэд зориулж аудио, видео хэлбэрээр мэдээллийг вэбсайтад тавьсан байхыг шаардана”, 4.5.2-т “Видео мэдээлэл нь текст тайлбар агуулсан байхыг шаардана”, 4.5.3-т “Аудио, видео хэлбэрийн мэдээлэл нь түгээмэл төрлийн форматаар бичигдсэн байхыг шаардана”, 4.5.4-т “Видео хэлбэрийн мэдээлэлд дохионы хэл агуулсан байх нь зүйтэй” гэсэн тусгай шаардлагуудыг тусгасан [24]. Хөгжлийн бэрхшээлтэй хүний цахим мэдээллийн хүртээмжийг дэмжих тухай эдгээр заалтуудыг төрийн байгууллага баримтлан цахим хуудас болон түүний агуулгыг хөгжүүлэх ёстой.

Цахим хуудасны агуулгын хүртээмж, олон улсын стандарт, үнэлгээ

Дэлхий дахины веб консорциумын тодорхойлсноор цахим хуудасны хүртээмж гэдэг нь цахим хуудас, түүний хэрэгсэл болон технологиуд хөгжлийн бэрхшээлтэй хүн хэрэглэж болохуйцаар загварчлагдсан ба хөгжүүлэгдсэн байхыг хэлнэ гэжээ [25]. Хэрэв цахим хуудас хүртээмжгүй бол зарим хэрэглэгчдэд мэдээлэл авахад хүндрэл үүснэ. Өнөө үед зураг, видео гэх мэт элементүүд засгийн газрын цахим хуудсуудад ихээр агуулагдах болсон. Ийнхүү дүрсээр агуулгыг баяжуулах нь мэдээллийг иргэдэд илүү ойлгомжтой, хялбар байдлаар хүргэж байгаа ч хэрэв эдгээр нь текст хувилбаргүй бол хараа болон сонсголын бэрхшээлтэй хүмүүст тохиромжгүй байж болно. Жишээлбэл, хараагүй хүн дэлгэц

уншигч технологи ашиглан цахим хуудаст зочлох үед хэрэв агуулга дахь зурагт текст хувилбар оруулаагүй бол дэлгэц уншигч технологи энэхүү зургийг хэрэглэгчдээ таниулж чадахгүй. Мөн сул хараатай хүн жижиг, бүдэг, тохиромжгүй загвартай текст агуулгыг уншихад хүндрэлтэй байдаг. Видеонд титр текст эсвэл дохионы хэлмэрч агуулаагүй бол сонсголын бэрхшээлтэй хүнд хүртээмжгүй юм [26].

Дэлхий дахины веб консорциумаас 1999 онд анх цахим хуудасны агуулгын хүртээмжийн олон улсын стандарт (WCAG 1.0)-ыг гаргаж байсан ба түүний агуулгыг 2008 (WCAG 2.0) болон 2018 (WCAG 2.1) онуудад тус тус шинэчилсэн [27]. Анхны WCAG 1.0 стандартаар цахим хуудасны агуулгыг төрөл бүрийн төхөөрөмжөөс үзэх боломжтой байх, ойлгогдохуйц байх, удирдах боломжтой байх зэрэг шаардлагыг тавьдаг [28]. Уг стандартын заалтууд цахим хуудасны агуулгын хүртээмжийн нөлөөллөөрөө Тэргүүн 1, Тэргүүн 2, Тэргүүн 3 гэсэн 3 төвшинд хуваагддаг. Харин WCAG 2.0 стандарт нь WCAG 1.0 стандарттай харьцуулахад технологи хамааралгүй, илүү ерөнхий шаардлагатай болсон [16].

2000 онд АНУ нь цахим хуудасны агуулгын хүртээмжийн стандартыг хуульчилсан бөгөөд үүнийг Section 508-ын §1194.22 зүйлд тусгажээ. Энэхүү стандартын ихэнх хэсгийг W3C-ын WCAG 1.0 стандартаас шууд хуулсан байдаг ба цөөн хэсгийг нь шинээр нэмж оруулсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан цахим хуудасны агуулгын хүртээмжийн стандартыг ийнхүү олон улсын стандартад үндэслэн боловсруулж, хуульчилснаар тус улсын төрийн байгууллагууд цахим хуудасны агуулгыг хуулийн дагуу хүртээмжтэй байхаар боловсруулах шаардлагатай болсон [29].

Цахим хуудасны агуулгын хүртээмжийг үнэлэх төрөл бүрийн арга байдаг бөгөөд заримыг нь хослуулан хэрэглэх нь үр дүнтэй байдаг. Тухайлбал, Abou-Zahra (2008) автоматаар шалгах, заавраар шалгах, хэрэглэгчээр шалгуулах гэсэн 3 аргыг хослуулан хэрэглэж оновчтой үр дүнг гаргаж авсан байна. Учир нь тухайн аргууд тус бүр өөрийн давуу болон сул талтай [30]. Мөн Luján-Mora, Masri (2013) нар үнэлгээний төрөл бүрийн аргуудыг судалж, тухайн аргуудыг хослуулан үнэлсэн үр дүнг харьцуулсны үндсэн дээр аль нэг аргыг дангаар нь хэрэглэснээс хослуулан хэрэглэх нь үр дүнтэй болохыг харуулсан [31]. АНУ-ын эрдэмтэн Jaeger (2006) дээрх аргууд дээр нэмээд вебмастерийн санал асуулга, бодлогын шинжилгээ зэргийг ашиглаж үнэлгээ хийсэн байдаг [29].

Судалгааны хэрэглэгдэхүүн, арга зүй

Энэхүү судалгаанд COVID 19 цар тахлын үед вирусийн тархалт, халдвар, шинж тэмдэг болон урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, зөвлөмж гаргаж буй, мөн цар тахлын үед хэрэгжүүлэхээр УИХ, Засгийн газар, Улсын онцгой комисс, бусад төрийн байгууллагаас гаргасан шийдвэр, бодлогын баримт бичгийг нийтэд түгээж буй төрийн байгууллагын 10 цахим хуудасны нүүр хуудасны агуулгыг WCAG 1.0 (Тэргүүн 1) стандартын зарим заалтын дагуу шалгасан. Тухайлбал, зураг, хүснэгт, видео зэргийг харуулах, хэлбэржүүлэхэд хэрэглэгддэг HTML элементүүд хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэглэдэг төхөөрөмж, технологид нийцтэй эсэхийг achecker (www.achecker.ca) автомат шалгагч болон “Нэгдсэн веб үнэлгээний аргын зааварчилгаа”-г ашиглан үнэлсэн. Цахим хуудаснуудыг 2020 оны 10-р сарын 15-аас 2020 оны 10-р сарын 25 хооронд үнэлж тоон өгөгдөл гарган авсан. Үнэлгээний үр дүнг шинжилж цахим хуудасны агуулга дахь элементүүдийн WCAG 1.0 стандартын сонгосон заалттай зөрчилдсөн хувийг тодорхойлсон.

achecker.ca автомат шалгагч: Энэхүү шалгагчийг Канад Улсын Торонтогийн их сургуулийн Зохицох технологийн нөөцийн төв хөгжүүлсэн бөгөөд нээлттэй эхийн програм юм. Уг шалгагч WCAG 1.0, 2.0, Section 508 гэсэн хүртээмжийн стандартын заалт бүрээр А, АА, ААА гэсэн 3 төвшинд “мэдэгдсэн алдаа”, “боломжит алдаа”, “анхааруулга” гэсэн 3 төрлийн алдааг мэдээлдэг [32].

Нэгдсэн веб үнэлгээний аргын зааварчилгаа: 2007 онд Нидерланд Улсын Цахим хуудасны хүртээмжийн сангаас энэхүү зааварчилгааг боловсруулсан бөгөөд цахим хуудасны хүртээмжийг WCAG 1.0 хүртээмжийн стандартын заалт бүрээр шалгах техникийн заавар юм [33].

Үнэлгээнд сонгон авсан WCAG 1.0 стандартын заалт ба үнэлгээний шалгуур: Зураг, хүснэгт, видео харуулахад хэрэглэгддэг HTML элементүүдийг шалгадаг WCAG 1.0 стандартын 1.1, 1.4, 5.1, 6.1 гэсэн заалтуудыг сонгосон. Сонгосон заалт тус бүрээр үнэлгээний шалгуурыг тодорхойлсон (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Үнэлгээний шалгуур.

WCAG 1.0 заалт	Үнэлэх шалгуур	Үнэлэх арга
1.1 Текст биш элемент (зураг) нь	(1) Зураг ALT атрибуттай байх	Achecker
		Achecker

текст хувилбартай байх	(2) Зургийн ALT атрибут хоосон биш байх (3) Зургийн ALT атрибутын текст утгатай байх	Заавраар
1.4 Хөдөлгөөнт үзүүлэн ойлгуулах хувилбартай байх	(4) Видеонд титр болон дохионы хэлмэрч агуулагдсан байх	Заавраар
5.1 Хүснэгтийн мөр болон баганын толгойг ялгасан байх	(5) Хүснэгтийн толгойг ялгахдаа ТН таг хэрэглэсэн байх	Achecker
6.1 Хэлбэржүүлэх кодгүй үед баримтыг унших боломжтой байх	(6) Хэлбэржүүлэх код ажиллахгүй үед агуулга саадгүй уншигддаг байх	Achacker & Заавраар

Тэмдэглэл: ALT атрибут нь цахим хуудаст оруулж буй зургийн текст тайлбарыг харуулахад ашигладаг тэмдэглэгээ юм. Харин ТН таг нь хүснэгтийн мөр, баганын толгойг ялгахад хэрэглэдэг тэмдэглэгээ юм. Хэлбэржүүлэх код нь цахим хуудасны өнгө, үзэмжийг бүтээхэд ашигладаг хавсарга код юм.

Судалгааны үр дүн, шүүн хэлэлцэхүй

1.1 Текст биш элемент (зураг) нь текст хувилбартай байх

Текст биш элемент буюу зураг нь текст хувилбартай байх шаардлагын дагуу 10 цахим хуудсыг аchecker хэрэгсэл болон зааварчилгаа ашиглан үнэлэхэд нийт 875 зураг илэрснээс 8 цахим хуудасны 170 зураг буюу нийт зургийн 19.4 хувь нь зурагт текст хувилбар оруулахад ашигладаг ALT атрибутгүй байна. Мөн 8 цахим хуудасны 195 зураг буюу нийт зургийн 22.3 хувь нь хоосон утгатай ALT атрибут ашигласан зөрчил илэрсэн бол 2 цахим хуудасны 61 зураг буюу нийт зургийн 7 хувь нь тодорхой утга илэрхийлээгүй тэмдэгтүүд агуулсан байна. Хэрэв хараагүй иргэн текст уншигч хөтөч ашиглан эдгээр цахим хуудаст хандвал нүүр хуудас дахь нийт зургийн 48.6 хувийг ойлгож чадахгүй байж болохоор байна. Өөрөөр хэлбэл, барагцаагаар нийт зургийн тал хувь нь хараагүй иргэдэд хүртээмжгүй гэж үзэж болохоор байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. (1)-(3) шалгуурыг зөрчсөн зургийн тоо, хувь, дундаж.

Шалгуур	Илэрсэн нийт зөрчлийн тоо, хувь	Зөрчил илэрсэн цахим хуудасны тоо	Дундаж
	Нийт зургийн тоо 875 (100%)		
(1) Зураг ALT атрибуттай байх	170 (19.4%)	8	21.3
(2) Зургийн ALT атрибут хоосон биш байх	195 (22.3%)	8	24.4
(3) Зургийн ALT атрибутын текст утгатай байх	61 (7%)	2	30.5
Нийт	426 (48.6%)	10	

1.4 Хөдөлгөөнт үзүүлэн ойлгуулах хувилбартай байх

Зургаан цахим хуудаснаас нийт 20 видео илэрсэн. Эдгээрээс 8 видео буюу 40 хувь нь дохионы хэлмэрч эсвэл титр агуулаагүй байна. Хэрэв сонсголын бэрхшээлтэй хүн эдгээр цахим хуудаст хандвал видео хэлбэрээр өгч буй нийт мэдээллийн 40 хувийг олж авах боломжгүй гэж үзэж болохоор байна.

5.1 Хүснэгтийн мөр болон баганын толгойг ялгасан байх


Үнэлгээнд хамруулсан 10 цахим хуудасны 3-аас нь нийт 10 хүснэгт илэрсэн бөгөөд бүх хүснэгтийн мөр баганын толгойг ТН таг ашиглан ялгасан байна. Хараагүй хүн текст уншигч технологи ашиглан эдгээр хүснэгтэд агуулагдсан мэдээллийг саадгүй хүлээн авч чадахаар байна.

6.1 Хэлбэржүүлэх кодгүй үед баримтыг унших боломжтой байх

Үнэлгээнд хамрагдсан 10 цахим хуудаст нийт 120 хэлбэржүүлэлтийн файл (CSS) холбогдсон байв. Эдгээр хэлбэржүүлэлтийн файлуудыг салган нүүр хуудсыг ачаалахад 7 цахим хуудасны нүүр хуудас дахь агуулга уншихад хүндрэлтэй болж байв. Тухайлбал, зураг нь текстийг далдлах, агуулгын зарим хэсэг нь харагдахгүй болох зэргээр баримтыг унших боломжгүй болгож байв. Эдгээр 120 хэлбэржүүлэлтийн файлаас 29 файлд дээрх зөрчлийг үүсгэх код агуулагдсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэглэдэг зарим туслах технологи хэлбэржүүлэлтийн файл ашигладаггүй тул мэдээлэл авахад саад учрах магадлалтай.


Энэхүү судалгаанд үнэлсэн 10 цахим хуудасны нүүр хуудаст агуулагдах нийт зургийн 48.7 хувь нь текст хувилбаргүй, нийт видеоны 40 хувь нь дохионы хэлмэрч эсвэл титр агуулаагүй, нийт хэлбэржүүлэлтийн 24.2 хувь нь агуулгыг ойлгомжгүй болгосон зэрэг зөрчилтэй байна. Харин эдгээр цахим хуудасны нүүр хуудаст ашигласан бүх хүснэгтийн мөр, баганын толгойг ялгасан байсан учраас зөрчил илрээгүй байна (Зураг 2).

Зураг 2. Зураг, видео, хүснэгт, хэлбэржүүлэлтийн алдааны хувь.



Үнэлгээнд хамруулсан 10 цахим хуудасны 8 нь 2-4 шалгуурыг зэрэг зөрчсөн байна. Харин 5-6 шалгуур зэрэг зөрчсөн цахим хуудас байхгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүн туслах технологи ашиглан эдгээр цахим хуудаст хандаж мэдээлэл авах үед 80 хувьд нь 2-4 төрлийн мэдээллийн хүртээмжийн саад бэрхшээлтэй тулгарч болзошгүй байна (Зураг 3).

Зураг 3. Үнэлгээний шалгуур хангаагүй цахим хуудасны тоо.



Дүгнэлт

Энэхүү судалгааны хүрээнд цар тахлын үед үүнтэй холбоотой мэдээллийг иргэдэд шуурхай хүргэж буй албан ёсны эх сурвалж болох төрийн байгууллагын 10 цахим хуудасны нүүр хуудас дахь агуулга хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хэр хүртээмжтэй байгааг олон улсын цахим хуудасны агуулгын хүртээмжийн стандартын зарим заалтыг ашиглан үнэллээ. Цахим хуудасны агуулгын хүртээмжийг үнэлэх төрөл бүрийн аргуудаас автомат болон заавраар үнэлэх гэсэн 2 аргыг хослуулан хэрэглэж, тоон өгөгдөл гарган авч шинжилгээ хийсэн. Үнэлгээний үр дүнгээр сонгон авсан 10 цахим хуудасны 8 нь судалгаанд ашигласан 2-4 шалгуурыг зөрчсөн байна. Цахим хуудаснуудын агуулгад оруулсан зургуудын бараг тал хувь, видеоны 40 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэглэдэг технологид нийцэхгүй буюу хүртээмжгүй байж болзошгүй гэж үнэлэгдсэн бол хэлбэржүүлэх баримтын 24.2 хувь нь алдаатай код агуулснаар мөн хүртээмжийг бууруулах магадлалтай гэж үнэлэгдсэн байна. Харин цахим хуудаснуудын агуулгад оруулсан бүх хүснэгтийн мөр, баганын толгойг ялгасан нь хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэглэдэг технологид 100 хувь нийцсэн буюу хүртээмжтэй гэж үнэлэгдсэн. Иймээс төрийн байгууллагын цахим хуудсыг хөгжүүлэх, агуулгыг баяжуулахад зураг, видеог хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэглэдэг технологид нийцтэй буюу хүртээмжтэй байхаар бүтээж, оруулах шаардлагатай.

Зөвлөмж

Судалгааны ажлын дүгнэлтийг үндэслэн дараах зөвлөмжийг санал болгож байна. Үүнд,

1. W3C байгууллагаас гаргадаг цахим хуудасны агуулгын хүртээмжийн стандартад үндэслэсэн төрийн байгууллагын цахим хуудасны агуулгын стандарт боловсруулж, мөрдүүлэх;
2. Төрийн байгууллагын цахим хуудас хариуцсан ажилтанд цахим хуудасны агуулгын хүртээмжийн талаар мэдлэг олгох;
3. Харилцаа холбоо, мэдээлэл технологийн асуудал хариуцсан төрийн төв байгууллага болон хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудал хариуцсан төрийн төв байгууллага цахим хуудасны агуулгын хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хамтарч ажиллах нь зүйтэй.

Ашигласан материал

- [1] Б.Ууганбаяр, "Гамшгаас хамгаалах менежментийн хөгжлийн чиг хандлага," *"Хууль сахиулах үйл ажиллагаа: онол, практикийн тулгамдсан асуудал"* олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл, vol. 1, pp. 155-174, 2016.
- [2] "WHO Coronavirus Disease (COVID-19) Dashboard," World Health Organization, 2020. https://covid19.who.int/?gclid=CjwKCAjwiaX8BRBZEiwAQQxGxw2_UM8ldVXNdaETC-T1CS_oZ8xCSv2IT2VrzefdRnYibzqwL-Rc0RoCbuMQAvD_BwE.
- [3] "Sharing COVID-19 experiences: The Mongolian response 2020," World Health Organization, 2020. <https://www.who.int/mongolia/news/detail/02-11-2020-sharing-covid-19-experiences-the-mongolian-response>.
- [4] "Коронавируст халдвар (COVID-19)-ийн нөхцөл байдлын мэдээлэл," Эрүүл мэндийн яам, 2020. <https://covid19.mohs.mn/>.
- [5] "Коронавируст халдвар (covid-19)-ын эргэн тойронд: тандалт, судалгааны тойм – 7," Эрүүл мэндийн яам, 4 2020. <https://bit.ly/2JbYcEs>.
- [6] "Ковид-19-н эргэн тойронд: тандалт, судалгааны тойм – 41," Эрүүл мэндийн яам, 2020. <https://covid19.mohs.mn/p/cat/post/58/>.
- [7] "Monitoring COVID-19 Impacts on Households in Mongolia," The World Bank, 2020. <https://www.worldbank.org/en/country/mongolia/brief/monitoring-covid-19-impacts-on-households-in-mongolia>.
- [8] A. Miron, "A Lesser Known Impact of COVID-19: People with Disabilities May Be Denied Access to Online Resources," *World Wide Accessibility*, 2020. <https://www.globenewswire.com/news-release/2020/05/20/2036492/0/en/A-Lesser-Known-Impact-of-COVID-19-People-with-Disabilities-May-Be-Denied-Access-to-Online-Resources.html>.

- [9] "Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн статистик, тоо баримт 2019," Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, 2019. <http://www.gadpwd.gov.mn/uploads/files/%D0%B8%D0%BD%D1%84%D0%BE%D0%B3%D1%80%D0%B0%D1%84%D0%B8%D0%BA-converted.pdf>.
- [10] "Улсын Онцгой Комиссын хурлын тэмдэглэл," Улсын Онцгой Комисс, 2020.
- [11] "Хэвлэл мэдээлэл - хэрэглэгчдийн судалгаа," Хэвлэлийн хүрээлэн, 2015. [Online]. Available: https://www.mom-rsf.org/uploads/tx_ifrogmom/documents/5-243_import.pdf.
- [12] "Монгол Улсын харилцаа холбооны салбарын үндсэн үзүүлэлтүүд," Харилцаа, холбооны зохицуулах хороо, 2019. <https://stat.crc.gov.mn/>.
- [13] Y. Shi, "The accessibility of Chinese local government Web sites: An exploratory study," *Government Information Quarterly*, vol. 24, no. 2, pp. 377-403, 2007.
- [14] S. A. Becker, "E-government visual accessibility for older adult users," *Social science computer review*, vol. 22, no. 1, pp. 11-23, 2004.
- [15] M. Paciello, "Web accessibility for people with disabilities," in *Lawrence, KS7 CMP Books*, 2000.
- [16] J. Thatcher, *Web accessibility: Web standards and regulatory compliance*, Apress, 2007.
- [17] "Convention on the Rights of Persons with Disabilities," United Nations, 2006. <http://www.un.org/disabilities/documents/convention/-convoptprot-e.pdf>.
- [18] "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг соёрхон батлах тухай хууль," 2008. <https://www.legalinfo.mn/law/details/10034>.
- [19] "Incheon Strategy to "Make the Right Real" for Persons with Disabilities in Asia and the Pacific," The Economic and Social Commission for Asia and the Pacific, 2012. <https://www.unescap.org/sites/default/files/Incheon%20Strategy%20%28English%29.pdf>.
- [20] "Монгол Улсын Их Хурлын 2011 оны 22 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого"," 2011. <https://www.legalinfo.mn/annex/details/3371?lawid=5909>.
- [21] "Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/," <https://www.legalinfo.mn/law/details/12458>.
- [22] "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, 36-р зүйл," <https://www.legalinfo.mn/law/details/11711>.
- [23] "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, 11-р зүйл," <https://www.legalinfo.mn/law/details/11711>.
- [24] "Төрийн байгууллагын вэбсайтад тавих шаардлага," Харилцаа холбооны зохицуулах хороо, 2016. <http://crc.gov.mn/contents/raw/10/6/782/MNS6285-2016-10-03.docx>.
- [25] "Introduction to Web Accessibility," World Wide Web Consortium, <https://www.w3.org/WAI/fundamentals/accessibility-intro/#what>.

- [26] “Web Content Accessibility Guidelines 1.0,” World Wide Web Consortium, 1999.
<https://www.w3.org/TR/WAI-WEBCONTENT/>.
- [27] “Web Content Accessibility Guidelines (WCAG) Overview,” World Wide Web Consortium, 2020. <https://www.w3.org/WAI/standards-guidelines/wcag/>.
- [28] S. Harper and Y. Yesilada, “Web Accessibility: A Foundation for Research,”
Springer Science & Business Media, 2008.
- [29] P. T. Jaeger, “Assessing Section 508 Compliance on Federal E-Government
Web Sites: A Multi-Method, User-Centered Evaluation of Accessibility for
Persons with Disabilities,” Government Information Quarterly, vol. 23, no. 2, pp.
169-190, 2006.
- [30] S. Abou-Zahra, “Web accessibility evaluation,” in *Web accessibility*, London,
Springer, 2008, pp. 79-106.
- [31] S. Luján-Mora and F. Masri, “Evaluation of web accessibility: A combined
method. In Information Systems Research and Exploring Social Artifacts:
Approaches and Methodologies,” *IGI Global*, pp. 314-331, 2013.
- [32] G.Gay and C. Q.Li, “AChecker: open, interactive, customizable, web
accessibility checking,” In Proceedings of the 2010 International Cross
Disciplinary Conference on Web Accessibility (W4A) pp. 23, 2010.
- [33] Eric Velleman, Carlos A. Velasco, Mikael Snaprud, “Unified Web Evaluation
Methodology (UWEM 1.2 Core),” 2007.
<https://www.researchgate.net/publication/304033502> Unified Web Evaluation
Methodology UWEM 1.2 Core/citations.



5

НИЙГМИЙН
ХАМГААЛАЛ

БАЙНГЫН АСАРГАА ШААРДЛАГАТАЙ ХҮҮХДҮҮДЭД ОЛГОХ НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН МӨНГӨН ТЭТГЭМЖИЙН ХҮРЭЛЦЭЭ, ҮР АШИГТАЙ ЗАРЦУУЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ

Баттүшиг Төмөрчулуун¹, Жамбалбавуу Өлзийсайхан¹

¹Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт
Нийгмийн хамгааллын бодлогын судалгааны сектор

Хураангуй

Үндэслэл: Байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд нийгмийн халамжийн сангаас олгож буй мөнгөн тэтгэмж нь хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаанд байгаа хүүхдийн эмчилгээ, сувилгааны зардалд хүртээмжтэй байгаа эсэх, үр ашигтайгаар хүүхэддээ зарцуулагдаж байгаа эсэхийг судлах хэрэгцээ шаардлагын улмаас энэхүү судалгааг хийж гүйцэтгэлээ.

Зорилго: Байнгын асаргаатай хүүхдүүдэд олгох нийгмийн халамжийн мөнгөн тэтгэмжийн хүрэлцээ болон үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх боломжийг судлах.

Үр дүн: Байнгын асаргаа шаардлагатай хүүхэдтэй өрхийн 55.7 хувь нь ядуу, 25.0 хувь нь ядууралд өртөх эрсдэлтэй байна. Тухайн өрхөд эцэг эхийн нэг нь ажил хийх боломжтой байгаа ба ихэнхдээ эмэгтэйчүүд хүүхдээ асарч байна. Хүүхдээ асарч буй эмэгтэйчүүдийн дундаж нас 39 ба тэдний 2 хүн тутмын нэг нь дээд боловсролтой хэдий ч байнгын асаргаатай хүүхдээ асарч байгаа тул ажил хийх боломжгүй байна. Байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмжийг хүүхдийн хэрэгцээ болон өрхийн хэрэгцээнд зарцуулж байна. Нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 34.6 хувь нь өрхийн орлого хүрэлцдэггүйн улмаас сэргээн засах эмчилгээнд явж чадахгүй байна. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн эм тариа, эмчилгээнд сард дунджаар 500000 төгрөг зарцуулж байна. Мөнгөн тэтгэмжийг үр ашигтай зарцуулан сэргээн засах эмчилгээнд тогтмол хамруулвал дээрх хүүхдүүдийн биеийн байдал сайжрах бүрэн боломж байна.

Удиртгал

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн 7-р зүйлд оролцогч талууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ялгаварлан гадуурхалтаас хамгаалж, хамгийн дээд боломжоороо хөгжихөд нь туслах зорилготой төрөл бүрийн үйлчилгээ, дэмжлэгийг хүртээмжтэй хүргэх үүрэгтэй ажээ. Хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүхэд хөгжлөөр хоцрох илүү их эрсдэлтэй хэрнээ хүүхэд хөгжүүлэх бүх нийтийн үйлчилгээ, хөтөлбөрт хамрагдаж чадахгүй орхигдох нь их байдаг.

Монгол Улсын хэмжээнд 2019 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 107 075 иргэн байгаагийн 10.8 хувийг 18 хүртэлх насны хүүхэд эзэлж байна. Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5.6-д байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдэд Засгийн газраас тогтоосон тухайн үеийн нийгмийн халамжийн тэтгэвэртэй тэнцүү хэмжээний тусламжийг олгоно гэж заасан байдаг. 2019 онд байнгын асаргааны мөнгөн тэтгэмжид давхардсан тоогоор 11 691 хүүхэд хамрагдан сар бүр 188000 төгрөгний мөнгөн тэтгэмж авч байгаа ба тус тэтгэмж нь “Ковид-19” цар тахлын үед 288000 төгрөг болон нэмэгдсэн. Тэднийг асарч байгаа иргэнд сар бүр 123100 төгрөгний мөнгөн тэтгэмж олгож байна. Мөн байнгын асаргаанд хамрагдсан хүүхдэд жилд нэг удаа цэцэрлэг, сургуульд хүргэх унааны хөнгөлөлт, түлшний хөнгөлөлт, рашаан сувилалд амарсан бол ор, хоногийн зардал, унааны зардлыг олгодог.

Хөгжлийн бэрхшээлтэй болон байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгож буй нийгмийн халамжийн үйлчилгээ, мөнгөн тэтгэмж нь жил бүр нэмэгдэж улсаас үзүүлж байгаа үйлчилгээ сайжирсаар байна. Эмчилгээ сувилгааны үр дүнгээр биеийн байдал нь сайжирсан хүүхдэд олгох мөнгөн тэтгэмжийг зогсоох ёстой ч байнгын асаргаанд хамрагдаж буй хүүхдийн тоо жил бүр нэмэгдэж байна. Тиймээс нийгмийн халамжийн сангаас олгож буй мөнгөн тэтгэмж нь хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаанд байгаа хүүхдийн эмчилгээ, сувилгааны зардалд хүртээмжтэй байгаа эсэх, үр ашигтайгаар хүүхэддээ зарцуулагдаж байгаа эсэхийг судлах хэрэгцээ шаардлагын улмаас энэхүү судалгааг хийж гүйцэтгэлээ.

Судалгааны зорилго

Байнгын асаргаатай хүүхдүүдэд олгох нийгмийн халамжийн мөнгөн тэтгэмжийн хүрэлцээ болон үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх боломжийг судлах.

Зорилт

6. Байнгын асаргаатай хүүхдүүдийн өрхийн амьжиргааны түвшинг судлах /PMT болон ӨНЭЗС тоон мэдээлэлд шинжилгээ хийх/;
7. Мөнгөн тэтгэмжийн хүрэлцээтэй байдлыг судлах; /*Тархины саа G80 оноштой хүүхдүүдийн жишээн дээр*/

8. Мөнгөн тэтгэмжийн үр ашгийг нэмэгдүүлэх боломжийг судлах; /Тархины саа G80 оноштой хүүхдүүдийн жишээн дээр/
9. Биеийн байдал сайжрах боломжийг судлах /Тархины саа G80 оноштой хүүхдүүдийн жишээн дээр/
10. Санал, зөвлөмж боловсруулах

Арга зүй, Аргачлал

Тоон шинжилгээг хийхдээ ХХҮЕГ-ын “Өрхийн мэдээллийн нэгдсэн сан” /PMT/ болон “Нийгмийн халамж, үйлчилгээний нэгдсэн мэдээллийн систем”-ийн тоог ашигласан. Эдгээр сангууд нь нууцлалын зэрэгтэй учир санд байгаа бүх тоонд шинжилгээ хийх, гарсан үр дүнг нийтэд зарлах боломжгүй тул байнгын асаргаа шаардлагатай хүүхдийг тодорхойлох зааврын ICD-10 олон улсын өвчлөлийн ангиллын дагуу G80 буюу тархины саа гэсэн оноштой хүүхдүүдийг сонгон авч тоон мэдээлэлд шинжилгээ хийсэн.

Судалгааны мэдээлэл цуглуулалтыг гүйцэтгэхдээ чанарын судалгааны ганцаарчилсан ярилцлагын аргаар урьдчилан бэлтгэсэн асуулгын хуудсын дагуу G80 оноштой 26 хүүхдийн эцэг эхээс судалгааг авсан.

Хөгжлийн бэрхшээлтэй болон байнгын асаргаатай хүүхдүүдэд үзүүлж буй тусламж, хөнгөлөлт үйлчилгээ, өнөөгийн байдал

Монгол улсад 2019 оны байдлаар 0-18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 11 606 байгаа ба давхардсан тоогтоог 11 691 хүүхэд нийгмийн халамжийн байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдэд олгох мөнгөн тэтгэмжид хамрагдаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссоос 16 хүртэлх насны хүүхдийн байнгын асаргааг тогтоодог ба ICD-10 олон улсын өвчний ангиллын кодыг ашигладаг.

Хөгжлийн бэрхшээлтэй болон байнгын асаргаатай хүүхдүүд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль” болон “Нийгмийн халамжийн тухай хууль”-д зааснаар нийгмийн халамжийн дараах тусламж, хөнгөлөлтийг авч байна.

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Хүснэгт 19 Байнгын асаргаатай болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд олгох нийгмийн халамжийн тусламж, хөнгөлөлт

Д/д	Үйлчилгээний төрөл	Олгох давтамж	Олгох мөнгөн дүн
1	Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхэд	Сар бүр	288 000 төгрөг
2	Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхэд асарсны	Сар бүр	123 100 төгрөг
3	Орон сууцны хөнгөлөлт	Жилд 1 удаа	200 000 төгрөг
4	Түлээ нүүрсний хөнгөлөлт	Жилд 1 удаа	200 000 төгрөг
5	Цэцэрлэг, сургуульд ирж очих унааны зардал	Жилд 1 удаа	200 000 төгрөг
6	Дотоодын рашаан, сувилалд сувилуулах шаардлагатай хүнд ирж очих унааны, ор хоногийн зардлыг эрүүл мэндийн даатгалтай иргэний энгийн өрөөний тарифаар тооцон олгох	Жилд 1 удаа	
7	Зусланд амарвал эрхийн бичгийн 50 хувийг	Жилд 1 удаа	
8	Эмчийн магадлагаагаар усан эмчилгээ хийлгэсэн бол эмчилгээний төлбөрийн 70 хувийг нөхөн олгох	Жилд 1 удаа	
9	Олимп, тивийн наадам дэлхийн зэрэглэлийн тэмцээнд оролцож алт, мөнгө, хүрэл медаль хүртсэн тохиолдолд урамшуулал олгох	Тухай бүрт	Засгийн газраас баталсан жишгийн дагуу


“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль”-ийн 28.1-д Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлох, үнэлэх, тэдэнд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн бусад үйлчилгээг гэр бүл, хамт олонд нь түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, хүүхдийн хөгжлийн төвийг байгуулан, хөгжлийн хоцрогдолтой хүүхдэд тусгай хөтөлбөрийн дагуу үйлчилгээ үзүүлэхийг төрөөс дэмжинэ гэж заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаатай хүүхдүүдэд зориулсан сэргээн засах үйлчилгээ, улсын болон хувийн тусгай сургууль, цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тус шинжилгээний ажлаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн

төв” /ХБХСЗХТ/-д үйлчлүүлсэн, сувилуулсан хүүхдүүдийн тоо мэдээлэлд шинжилгээ хийлээ.

МУ-ын ЗГ-ын 2019 оны 04 сарын 03-ны өдрийн 125 дугаар тогтоолоор “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв” байгуулагдсан. Тус төв нь 2019 оны 06 сарын 02-ны өдрөөс үйл ажиллагаа явуулж эхэлсэн ба хэвтэн эмчлүүлэх 250 ортой, өдрийн үйлчилгээнд 250 хүүхэд хүлээж авах хүчин чадалтай байна.

2019 оны 6 сараас 2020 оны 9 сарыг дуустал тус төвөөр 1 517, давхардсан тоогоор нийт 6 024 хүүхэд үйлчлүүлсэн байна.


Зураг 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвөөр үйлчлүүлсэн хүүхдүүд, насны бүлгээр



Нийт үйлчлүүлсэн хүүхдүүдийн 4 397 нь амбулаторийн үйлчилгээг авсан ба насны бүлгээр харвал 23.0 хувь нь 4-5 насны хүүхдүүд 22.0 хувь нь 2-3 насны хүүхдүүд байгаа бол 12 оос дээш насны хүүхдүүд хамгийн бага үйлчлүүлсэн.

Зураг 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвөөр үйлчлүүлсэн хүүхдүүд, өвчний төрлөөр, хувиар

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”



Сэргээн засах эмчилгээнд хамрагдсан хүүхдүүдээс ICD-10 ангиллын дагуу тархины саа гэсэн өвчний оноштой хүүхдүүд хамгийн их үйлчлүүлсэн буюу 37.7 хувийг эзэлж байна. 2019 оны байдлаар байнгын асаргаанд хамрагдсан 16 хүртэлх насны хүүхдийн тоо 11 691 байгаа боловч сэргээн засах үйлчилгээнд хамрагдсан хүүхдүүдийн тоо 1 517, давхардсан тоогоор 6 024 хүүхдүүд сэргээн засах үйлчилгээг авсан байна. Байнгын асаргаатай хүүхдүүдэд сэргээн засах эмчилгээ хамгийн шаардлагатай байдаг боловч үйлчилгээнд хамрагдсан хүүхдүүдийн тоо хангалтгүй байна. Байнгын асаргаатай хүүхдүүдэд улсаас мөнгөн тэтгэмж болон халамжийн үйлчилгээнүүдийг үзүүлж байгаа ч энэ нь үр ашигтай зарцуулагдаж байна уу?, Хүүхдийн эмчилгээ, сувилгаа хэрэгцээнд хүрж байгаа эсэхийг тодорхойлохын тулд тус төвд үйлчлүүлсэн хүүхдүүдийн өрхийн амьжиргааны түвшин, ядуурлын шугамны хаана оршин байгааг тодорхойлохыг зорьлоо.

2018 оны байдлаар “Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа”-ны дүнгээр Монгол Улсын нийт өрхийн 28.4 хувь нь ядуурлын шугамнаас доогуур амьдарч байна.

Монгол Улсын хэмжээнд
Ядуурлын шугамаас доош
28.4 % (409.679 оноо)



2019 оны байдлаар 16 хүртэлх насны байнгын асаргаатай хүүхэд **11 691**

- ❖ Ядуурлын шугамаас доош **55.7 %**
- ❖ Ядууралд өртөх эрсдэлтэй **25.0 %**

ХБХСЗТ-өөр үйлчлүүлсэн ХБХ **1 517**

- ❖ Ядуурлын шугамаас доош **43.0 %**
- ❖ Ядууралд өртөх эрсдэлтэй **24.0 %**


Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны дүнгээр ядуурлын шугамны оноог “Өрхийн мэдээллийн нэгдсэн сан”-ийн оноонд индексжүүлэхэд 409.479 оноо гарч байгаа ба тус оноогоор 2019 онд 16 хүртэлх насны байнгын асаргаатай

хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамрагдсан 11 691 хүүхдийг ядуурлын шугамны хаана байгааг индексжүүлэхэд 55.7 хувь нь ядуу, 25.0 хувь нь ядууралд өртөх эрсдэлтэй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвд үйлчлүүлсэн 1 517 хүүхдийг ядуурлын шугамны хаана оршин байгааг тогтооход 43.0 хувь нь ядуурлын шугамнаас доош, 24.0 хувь нь ядууралд өртөх эрсдэлтэй байна.

Судалгааны үр дүн

Байнгын асаргаанд хамрагдсан хүүхдүүдийн мөнгөн тэтгэмжийн хүртээмжийн талаар болон өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор байнгын асаргаа авдаг 26 хүүхдийн асаргаачаас чанарын судалгааг авсан. Нийт судалгаанд хамрагдсан хүүхдээ асардаг иргэдийн 22 нь буюу 84.6 хувь нь эмэгтэйчүүд бөгөөд тэдний 72.7 хувь нь ажил хийдэггүй харин хүүхдээ асарч буй эрэгтэйчүүдийн 75.0 хувь нь ажил хийдэггүй.

Зураг 3. Судалгаанд хамрагдсан хүүхдээ асарч буй иргэдийн ажил эрхлэлт, хүйсээр



■ Ажилтай ■ Ажилгүй

■ Ажилтай ■ Ажилгүй


Ажил хөдөлмөр эрхэлдэггүй шалтгаанд нь асаргаатай хүүхдээ хардаг, судалгаанд хамрагдсан иргэдийн хувьд тухайн өрхөд нэг л хүн ажил хийдэг байх тохиолдол дийлэнх хувь нь байсан. Судалгаанд хамрагдсан иргэдийн дундаж нас 39 байсан бол ажил хийдэггүй хүүхдээ харж байгаа эмэгтэйчүүдийн 50.0 хувь нь дээд боловсролтой байна.

Шигтгээ 1.

Их сургууль төгсөөд 12 жил болж байна. Сургууль төгссөнөөсөө хойш нэг ч ажил хийгээгүй. Хүүхдээ хараад ажил хийж чаддаггүй. Насны хувьд ч тэр мэргэжлээрээ ажиллах боломжтой боловч цагийн хувьд тохирсон ажил олддоггүй. Нэг хүний цалин хүрэлцдэггүй тул хүүхдийн тэтгэмжээсээ өрхийн хэрэгцээндээ зарцуулдаг.

Судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн ихэнх нь ICD-10 олон улсын өвчний ангиллын дагуу G80 буюу хүүхдийн тархины саа оноштой байсан. Эдгээр хүүхдүүд нь бүгд байнгын асаргааны тэтгэмжид хамрагддаг ба дунджаар 5-9 настай хүүхдүүдийн эцэг, эхийг судалгаанд хамруулсан. Тархины саа өвчтэй хүүхдүүдийн хувьд өвчний оношийг эрт илрүүлэн эмчилгээ, сэргээн засах үйлчилгээнд тогтмол хамрагдвал сайжрах бүрэн боломжтой байна гэдгийг судалгаанд хамрагдсан эцэг, эхчүүд хэлж байна. Нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 38.5 олдмол хөгжлийн бэрхшээлтэй буюу нярайн шарлалт хүндэрсний улмаас үүссэн бол 61.5 хувь нь төрөх үеийн хүндрэлээс, бүтэлтээс шалтгаалан тархины саа гэсэн оноштой 4 мөчний саажилттай болсон байна. Ихэнх эцэг эхчүүд хүүхдээ саажилттай болно гэдгийг мэдээгүй байна. Өвчний оношийг сүүлд илрүүлсэн ба байнгын асаргааны мөнгөн тэтгэмжийн талаар мэдээлэлгүйн улмаас оношоо мэдсэнээс хойш 1-2 жилийн дараа хамрагдсан байдал түгээмэл байна.

Зураг 4. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн өвчний оношоо мэдсэн хугацаа, байнгын асаргааг тогтоосон хугацаа, хувиар



Нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 42.3 хувь нь 1-6 сартайдаа оношоо тодруулж тархины саажилттай болсон байна гэдгээ мэдсэн бол 42.3 хувь нь 1-12 сартайдаа, 11.5 хувь нь 1 наснаас 2 настай байхдаа мэдсэн байна. Энэ нь эрт үеийн оношилгоо маш хангалтгүй түвшинд байгааг харуулж байна. Хэдийгээр хүндрэлтэй төрсөн, нярайн шарлалтаас үүдэн хүүхдийн биеийн байдалд хүндрэл

үүссэн боловч эцэг эхчүүдийн хувьд хүүхэд нь саажилттай болно гэдгийг мэдээгүй тохиолдол их байна.

Шигтгээ 2.


Нярайн шарлалт хүндэрснээс болоод саажилттай болсон. Төрсний дараа 7 хоногтой болоод эмнэлгээс гарсан. 1 сартай болоход байнга уйлаад байхаар нь ЭХЭМҮТ-д үзүүлсэн боловч зүгээр гэсэн. Эмнэлгийн зүгээс ямарч зөвлөгөө өгдөггүй, хүүхэд чинь ийм болох эрсдэлтэй ингэж эмчилгээ хийлгээрэй гэдэг зүйлийг огт хэлдэггүй. Эмчилгээ сайтай байхад энэ хүүхдүүд эмчлэгдэх бүрэн боломжтой гэдгийг би өөрийн туршлага дээр мэдсэн. Би 10 жил гэртээ хүүхдээ асарч байгаа хүүхдээ байнга эмчилгээнд явуулдаг одоо өөрөө массаж хөдөлгөөн засал, хөдөлмөр заслыг гэрээрээ хүүхдэдээ өөрөө хийгээд өгдөг. Би дээд боловсролтой ч надад ажил хийх боломж байдаггүй. Анх саажилттай гэж оношлуулж мэдэхдээ хүү маань 1 настай байсан. Тэр үед толгойгоо даадаггүй хэвтрийн байсан хүүхэд маань одоо явдаг, ярьдаг болоод энгийн сургуульд явж байна. Хүүхэд хөгжүүлэх төв, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан хүүхэд харах үйлчилгээ маш их хэрэгтэй байна.

9 настай байнгын асаргаатай хүүхдээ асарч байгаа ээжтэй хийсэн ярилцлагаас


Мөн судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдийн 38.5 хувь нь 2 наснаас 4 настай байхдаа байнгын асаргааг тогтоолгож мөнгөн тэтгэмжид хамрагдсан байна. 16 хүртэлх насны Байнгын асаргаатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмжийн талаарх мэдээлэлгүйгээс болоод хамрагдалгүй удсан бөгөөд мэдээллийг ихэнхдээ ойр орчмын хүмүүсээс авдаг байна.

Байнгын асаргаанд байх хугацааг ихэнхдээ 1 жилээр тогтоодог ба жил бүр сунгалт хийлгэхээр комиссоор орох, мөн байнгын асаргааг дагалдах бусад тэтгэмжид хамрагдахын тулд бичиг баримт бүрдүүлэх нь иргэдэд хүндрэл бэрхшээл ихтэй байдаг.

Зураг 5. Байнгын асаргааны мөнгөн тэтгэмжийн зарцуулалт



Зураг 6. Байнгын асаргаатай хүүхдүүдийн сэргээн засах үйлчилгээнд хамрагдалт



“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 84.6 хувь нь байнгын асаргааны мөнгөн тэтгэмжийг хүүхдийн эмчилгээ, эм тариа, хэрэгцээнд зарцуулдаг бол 15.4 хувь нь өрхийн хэрэглээ, хоол хүнсэнд зарцуулдаг. Харин судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 65.4 хувь хүүхдээ ямар нэгэн байдлаар сэргээн засах эмчилгээ, сувилгаанд явуулдаг бол, 34.6 хувь нь ямар нэгэн эмчилгээ, цэцэрлэг сургуульд явуулж чадахгүй гэртээ хардаг байна. Хүүхдээ эмчилгээнд явуулж чадахгүй байгаа шалтгаан нь өрх толгойсон эх, эцэг байсан ба хүүхэдтэйгээ 2 уулаа тул ажил хийх боломж байхгүй, орлогогүй тул мөнгөн тэтгэмж нь хүрэлцдэггүй өрхийн хэрэглээндээ зарцуулаад таардаг байна.

Хүснэгт 20. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн эмчилгээ, сувилгаанд хамрагдсан байдал, жилд зарцуулах хоног, мөнгөн дүн

	Хувийн зардлаар эмчилгээ, сувилалд хүүхдийн тоо явдаг	Жилд хэдэн удаа	Зарцуулж буй хоног	Зарцуулж буй мөнгөн /жилд/
Рашаан сувилал	12	1	14 хоног	869 230
Хөдөлгөөн засал	8	4.5	12 хоног	193 750
Бариа засал	10	4	7 хоног	217 500
Зүү төөнүүр	4	2	30 хоног	3 625 000
Эм, тариа	20	тогтмол	360 хоног	100000 /сард/

Тархины саа /G80/ оноштой хүүхдүүдийн хийлгэдэг гол эмчилгээ нь хөдөлгөөн засал ба эцэг эхчүүд хүүхдээ улсын болон хувийн хөдөлгөөн засал, бусад эмчилгээ сувилалд хамруулахыг зорьдог. Хувийн зардлаар эмчилгээ, сувилгаа, эм тарианд зарцуулж байгаа мөнгөн дүнг тооцож үзвэл судалгаанд хамрагдсан 2 хүүхэд тутмын нэг нь жил бүр хувийн зардлаар рашаан сувилалд явдаг ба дунджаар 869230 төгрөг зарцуулдаг, хөдөлгөөн засал, барианд тогтмол явуулдаг ба дунджаар 193750 төгрөг зарцуулдаг, зүү төөнүүрт явж байгаа хүүхдүүд нь жилд 1-2 удаа Хөх хотруу явж эмчилгээ хийлгэдэг тул жилд дунджаар 3.6 сая төгрөг зарцуулдаг. Харин эм, тариа хэрэглэдэг хүүхдүүдийн хувьд сардаа дунджаар 100000 төгрөг зарцуулдаг байна. Эцэг, эхчүүд хүүхдээ аль болох эмчилгээнд тогтмол явуулж хөл дээр нь

босгохыг зорьдог ч мөнгөний хүрэлцээгүй байдлаас болоод явуулж чадахгүй байх тохиолдол их байна. Дээрх нэг хүүхдэд зарцуулсан мөнгөн дүнг тооцож үзвэл сард дунджаар 500000 төгрөгийг эмчилгээ, сувилгаа, эм тарианд зарцуулж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй болон байнгын асаргаа шаардлагатай хүүхдүүдэд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээ, мөнгөн тэтгэмжийн үр ашгийг нэмэгдүүлэх боломж


Нийт байнгын асаргаа шаардлагатай хүүхэдтэй өрхүүд ядуу байгааг эцэг эх нь ажилгүй, өрх толгойлсон гэх зэрэг олон шалтгаантай холбож болох ч эцэг, эхчүүдийн дунд хүүхдээ эдгэнэ, хөл дээрээ босно, нийгмийн харилцаанд оролцоно гэсэн итгэл үнэмшил бага байна. Тиймээс хүүхдээ сэргээн засах үйлчилгээнд явуулах нь багасаж, эмчилгээ сувилгааг тогтмол хийлгэхгүй эм тариагаар аргацаан өдөр хоногийг өнгөрөөх тохиолдол их ажээ.

Гэвч хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүр, байнгын асаргаа шаардлагатай хүүхэд бүр насан туршдаа хэвтрийн байна гэсэн ойлголт байхгүй ба сэргээн засах эмчилгээнд тогтмол явсан, асаргаа сувилгааг тогтмол хийлгэсэн хүүхдүүд хөл дээрээ босон энгийн сургууль цэцэрлэгт явах бүрэн боломжтой байгааг зарим жишээ харуулж байна. Тиймээс байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох тэдний асрагчдад олгох мөнгөн тэтгэмжийг тухайн хүүхдэд үр ашигтайгаар зарцуулагдах боломжийг олгохын тулд байнгын асаргааг сунгахдаа эдгэрсэн, сайжирсан байдлаар, эмчилгээ сувилгаанд явуулсан байдлыг харгалзан үзэж мөнгөн тэтгэмжийг олгох, сунгах саналыг дэвшүүлж байна.

Үүний тулд дараах цахим системийг бий болгосноор хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, байнгын асаргаатай хүүхэд, тэдний эцэг эхчүүд, үйлчилгээг хэрэгжүүлэгч нарт хариуцлагын тогтолцоо бүрэлдэж, хүндрэл чирэгдэл багасана гэж үзэж байна.

Зураг 7. Хөгжлийн бэрхшээлтэй болон байнгын асаргаатай хүүхдэд олгох нийгмийн халамжийн тусламж, хөнгөлөлтийн цахим систем


“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”



Судалгааны явцад нийгмийн халамжийн тусламж, үйлчилгээний талаарх мэдээлэл бага байсан ба ихэнхдээ ойр орчмын хүмүүсээс мэдээллийг авсан байсан. Мөн байнгын асаргаа шаардлагатай хүүхэд байнгын асаргаа шаардлагатай хүүхдийн мөнгөн тэтгэмжийн үйлчилгээний талаарх мэдээллийг өвчний онош тодорхойлсноос 1-4 жилийн дараа мэдсэн тохиолдлууд дийлэнх хувийг эзэлж байсан. Хөгжлийн бэрхшээлтэй болон байнгын асаргаатай хүүхдүүдэд олгох бусад нийгмийн халамжийн үйлчилгээг мэдэдгүй тохиолдол их байсан тул дээрх цахим үйлчилгээгээр дамжуулан иргэдэд мэдээллийг нээлттэй дэлгэрэнгүй олгох боломжтой болно.


Зураг 8. Хөгжлийн бэрхшээлтэй болон байнгын асаргаатай хүүхдэд олгох нийгмийн халамжийн тусламж, хөнгөлөлтийн цахим системийн үйлчилгээ

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”



Иргэд тус систем рүү нэвтэрснээр байнгын асаргаатай болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээний талаарх мэдээллийг дэлгэрэнгүй мэдэх боломжтой.

Зураг 9. Хөгжлийн бэрхшээлтэй болон байнгын асаргаатай хүүхдэд олгох нийгмийн халамжийн тусламж, хөнгөлөлтөд хэрхэн хамрагдах талаарх дэлгэрэнгүй мэдээлэл



“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Дараагийн хэсэгт нийгмийн халамжийн хөнгөлөлт тусламжид хэрхэн яаж хамрагдах талаарх зааварчилгаа болон тусламж хөнгөлөлтийн хэмжээг тодорхой зааж өгсөн байна. Мөн дээрх бүрдүүлэх баримт бичгүүдийг дор заасан нэвтрэх хэсэгт анх бүртгүүлэхдээ нэг удаа файл хэлбэрээр оруулсан байхад дахин бичиг баримт бүрдүүлээд явах шаардлагагүй болно.

Энэ нь иргэдийг дахин дахин явуулж бичиг баримт бүрдүүлэх шаардлагагүй болгох ба нийгмийн халамжийн хэлтсийн мэргэжилтнүүдийн ажлын ачааллыг багасгах юм. Иргэд нэг оролтоор хүүхдийнхээ бичиг баримтын болон өвчлөлийн талаарх архивыг үүсгэх боломжтой болно.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ
ХҮҮХДИЙН НЭГДСЭН ҮЙЛЧИЛГЭЭ

N-МЭЙЛ ХАЯГ
Email


НУУЦ ҮГ
Password

Сануулах Нууц үгээ мартсан уу?

НЭВТРЭХ


зураг 10. Хөгжлийн бэрхшээлтэй болон байнгын асаргаатай хүүхдийн эмчилгээ, сэргээн засах үйлчилгээний талаарх мэдээллийг оруулах хэсэг

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”



Дээрх хэсэгт иргэд хүүхдийн эмчилгээ сувилгаанд хамрагдсан байдлыг оруулах мэдээллэх боломжтой ба энэ нь бусад хөнгөлөлт үйлчилгээ болон хувийн зардлаар хамрагдсан эмчилгээний буцаан олголтыг авах боломжийг бүрдүүлэх юм. Мөн эндээс нийгмийн халамжийн мөнгөн тэтгэмж нь хэр үр ашигтайгаар хүүхэддээ хүрж зарцуулагдаж байгааг харах боломжтой болно.

Зураг 11. Хөгжлийн бэрхшээлтэй болон байнгын асаргаатай хүүхдийн мөнгөн тэтгэмжийн үр ашигтай зарцуулалтыг хянах боломж



“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Дээрх мэдээллийг эцэг эхчүүд оруулах ба ингэснээр халамжийн хэлтэст очиж уулзан бичиг баримт бүрдүүлэн цаг алдалгүйгээр эмчилгээнд хамрагдсан буцаан олголтынхоо мөнгийг авах боломжтой болно. Мөн энэ нь эцэг эхчүүдэд хүүхэддээ тогтмол эмчилгээ сувилгаа хийлгэх, хүүхдийн биеийн байдал сайжрах, тухайн хүүхдийн мөнгөн тэтгэмжийг үр ашигтайгаар зарцуулах, хариуцлагын тогтолцоог нэмэгдүүлэх гээд олон давуу талуудыг бий болгох болно.

#	УСАН ЭМЧИЛГЭЭ	ЭХЛЭХ ОГНОО	ДУУСАХ ОГНОО	НИЙТ ХОНОГ	ҮНИЙН ДҮН	БАТАЛГААЖСАН ЭСЭХ	БУЦААН ОЛГОСОН ХЭМЖЭЭ
1.	Усан Эмчилгээ1	2020-08-05	2020-08-11	7	210000	Тийм	105000

#	ЭМИЙН НЭР	ОГНОО	ҮНИЙН ДҮН	БАТАЛГААЖСАН ЭСЭХ
1.	Эм1	2020-09-02	35000	Тийм
2.	Эм2	2020-11-05	62000	Үгүй

#	НЭР	ОГНОО	ҮНИЙН ДҮН	БАТАЛГААЖСАН ЭСЭХ	БУЦААН ОЛГОСОН ХЭМЖЭЭ
1.	Бусад1	2020-09-26	100000	Үгүй	

Дүгнэлт

2019 оны байдлаар 16 хүртэлх насны байнгын асаргааны мөнгөн тэтгэмжид хамрагдсан хүүхдүүдийн тоо 11 691 байна. 2018 оны “Өрхийн нийгэм эзийн засгийн судалгаа”-ны дүнгээр Монгол улсын ядуурлын түвшин 28.4 хувь ба 16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдийн 55.7 хувь нь ядуурлын шугамнаас доогуур, 25.0 хувь нь ядууралд өртөх эрсдэлтэй байна. Мөн 2019-2020 оны эхний хагас жилд ХБХСЗХТ-өөр үйлчлүүлсэн байнгын асаргаатай 1 517 хүүхдийг ядуурлын шугамны хаана оршиж байгааг тооцож үзэхэд 43.0 хувь нь ядуу, 24.0 хувь нь ядууралд өртөх эрсдэлтэй байна.

Тоон мэдээнд шинжилгээ хийхээс гадна ХБХСЗТ-өөр хамгийн их үйлчлүүлсэн Тархины саа /G80/ оноштой 26 хүүхдүүдийн асрагчаас чанарын судалгааны ганцаарчилсан ярилцлагын аргаар судалгааг авсан. Байнгын асаргаа шаардлагатай хүүхэдтэй өрх нь ядуу, ядууралд өртөх эрсдэлтэй байгаа нь чанарын судалгааны үр дүнгээр батлагдсан. Тухайн өрхөд эцэг эхийн нэг нь ажил хийх боломжгүй байгаа ба нэг хүний цалин, халамжийн мөнгөн тэтгэмжээр тухайн өрхийн орлого хязгаарлагдаж байна. Мөн чанарын судалгаанд хамрагдсан иргэдийн 19.2 хувь нь өрх толгойлсон эх, эцэг байна. Судалгаанд хамрагдсан иргэдийн дундаж нас 39 ба 84.6 хувь нь эмэгтэйчүүд, тэдний 72.7 хувь нь ажил хийдэггүй. Мөн ажил хийхгүй хүүхдээ асарч буй эмэгтэйчүүдийн 50.0 хувь нь дээд боловсролтой боловч хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдээ төрснөөс хойш ажил хийх боломжгүй хүүхдээ асарч байна. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн сургууль, цэцэрлэгт хамрагдалтын түвшин бага байгаа ба эцэг эхчүүд нь ажлын туршлагагүй, ажлын цагийн уян хатан нөхцөлгүйн улмаас ажил хийх боломжгүй байна.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хувьд байнгын асаргаанд 1-4 настай байхдаа хамрагдсан тохиолдол ихэнх хувийг эзэлж байна. Иргэдийн дунд халамжийн үйлчилгээний талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг байгаагийн улмаас байнгын асаргаанд хожуу хамруулсан, халамжаас үзүүлж буй тусламж, хөнгөлөлтийг мэдэхгүй байх тохиолдол их байна. Халамжийн үйлчилгээний талаарх мэдээллийг ихэнхдээ, ам дамжсан яриа, ойр орчмын хүмүүсээс авч байна. Мөн байнгын асаргааг жил бүр сунгуулахаар комиссын хурлаар орох, бусад дагалдах тусламж, хөнгөлөлтөд хамрагдахын тулд бичиг баримт бүрдүүлэх тухай бүр халамжийн газарт хандах нь байнгын асаргаатай хүүхэдтэй эцэг эхчүүдийн хувьд маш их хүндрэлтэй байна.

Судалгаанд хамрагдсан тархины саа /G80/ оноштой хүүхдүүдийн оношийг эрт илрүүлэн сэргээн засах эмчилгээнд тогтмол хамруулвал сайжрах бүрэн боломжтой байна. Байнгын асаргааны мөнгөн тэтгэмж нь сар бүр 188000, асрагчид 123100 нийт 311100 төгрөг олгож байна. 2020 оны 4 сараас ковид 19 цар тахлын үед 411100 төгрөг болгон нэмэгдүүлж олгож байна. Тухайн мөнгөн тэтгэмжийг судалгаанд

хамрагдсан нийт өрхийн 84.6 хувь нь хүүхдийн хэрэгцээнд зарцуулж байгаа бол 16.4 хувь нь өрхийн хэрэгцээнд зарцуулж байна. Мөн нийт хүүхдүүдийн 65.4 хувь нь ямар нэгэн сэргээн засах эмчилгээнд явдаг бол 34.6 хувь нь эмчилгээ, сувилгаанд явдаггүй. Дээрх оноштой хүүхдүүдийн хувьд сард дунджаар 500000 төгрөгийг эмчилгээ, эм тарианд зарцуулж байна. Хүүхдээ эмчилгээнд явуулж чадахгүй байгаа шалтгаан нь өрх толгойсон эх, эцэг байсан ба хүүхэдтэйгээ 2 уулаа тул ажил хийх боломж байхгүй, орлогогүй тул мөнгөн тэтгэмж нь хүрэлцдэггүй өрхийн хэрэглээндээ зарцуулаад таардаг байна.

ХБХСЗХТ-ийн үйл ажиллагаа 2019 оны 6 сараас эхлэн хэвийн үргэлжилж байгаа ба өдрийн эмчилгээндээ 250 хүүхэд хүлээж авах хүчин чадалтай, хэвтэн эмчлүүлэх 250 ортой байна. Гэвч ХБХ-үүдийн хамрагдалтын түвшин хангалтгүй байна. Судалгааны явцад эцэг эхчүүд хүүхдээ сэргээн засах эмчилгээнд тогтмол явуулж чадахгүй байгаа нь ажиглагдсан ба сэргээн засах төв хүрэлцээ муутай, хол гэх зэрэг шалтгааныг дурдаж байсан. Сэргээн засах төвийн үйл ажиллагааг тогтвортой, нөөц бололцоог бүрэн дүүрэн ашиглахын тулд мэдээллийг нэмэгдүүлж, заавал эмчлүүлэх шаардлагыг тавих хэрэгтэй гэж үзэж байна.

Нийгмийн халамжийн мөнгөн тэтгэмжийг үр ашигтайгаар зарцуулах боломжийг тодорхойлохын тулд цахим систем ашиглаж болох санааг дэвшүүлж байгаа ба энэ нь хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаатай хүүхэдтэй эцэг эхчүүдийн хувьд дараах давуу талуудыг бий болгоно.

- Мэдээлэлээр бүрэн хангагдана;
- Үйлчилгээнд хамрагдахын тулд бичиг баримт бүрдүүлэх олон дахин явах хүндрэл бэрхшээлгүй болно;
- Халамжаас олгох мөнгөн тэтгэмжийг хэрхэн үр ашигтай зарцуулах талаар эерэг зуршилтай болно;
- Хүүхдийг тогтмол эмчилгээнд явуулснаар хүүхдийн биеийн байдал сайжирна;
- Хүүхдийн биеийн байдал сайжирснаар эцэг эхийн сэтгэл санаа тогтвортой болох, итгэл үнэмшилтэй болно;

- Цаашлаад эцэг эх, болон хүүхэд нийгмийн харилцаанд оролцох боломжтой болно.

Хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаатай хүүхдүүдтэй эцэг эхчүүдийн хувьд хүүхдээ тогтмол харснаар сэтгэл санааны хувьд хямрах, амьдралын итгэл үнэмшил буурах, хүүхдээ эдгэрэхгүй гэсэн оюун санааны хямрал үүссэн байгаа нь судалгааны явцад ажиглагдсан. Тиймээс нийгмийн харилцаанд оролцохын тулд ажил хөдөлмөр эрхлэхийн тулд улсаас хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаатай хүүхдийг, тэдний эцэг эхийг дэмжхээс гадна эцэг эхчүүд өөрсдөө хариуцлагаа ухамсарлан бэлэнчлэх сэтгэлгээгүйгээр хөгжих ёстой гэж үзэж байна.

Санал, зөвлөмж

- Байнгын асаргаатай хүүхэдтэй өрхийг ядуурлаас гаргах, ядууралд өртөх эрсдэлийг бууруулахын тулд эцэг , эхийг хөдөлмөр эрхлэх, нийгмийн харилцаанд орох боломжоор хангах;
- Мөнгөн тэтгэмжийн үр ашигтай зарцуулалтыг нэмэгдүүлэхийн тулд асаргааны хугацааг сунгахдаа, мөнгөн тэтгэмжийг олгохдоо эмчилгээ, сувилгаанд хамрагдсан байдлыг шалгадаг байх, хариуцлага тооцдог байх;
- Нийгмийн халамжийн үйлчилгээний мэдээллийг иргэдэд хангалттай түгээдэг байх, хөнгөлөлт, тусламжид хамрагдах явцыг цахимжуулах;
- Хуулийн нэр томъёог өөрчлөх, байнгын асаргаатай, эдгэрэх боломжгүй гэж тусгаарлахгүй байх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд эрт үеийн оношилгоо, иргэдэд өгөх эрүүл мэндийн мэдээлэл, зөвлөгөө хамгийн их хэрэгтэй байна.

Ном зүй

- ХНХЯ, (2011 он). *Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц*. Улаанбаатар
- ХНХЯ, ХХҮЕГ. (2019). *Нийгмийн халамжийн хууль, тогтоомжийн эмхэтгэл*. Улаанбаатар.
- ҮСХ, (2018). *Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа*. Улаанбаатар

ТАРХИНЫ СААТАЙ ХҮҮХДИЙН ХӨГЖИЛД ГЭР БҮЛИЙН ОРОЛЦОО

Б.Сувд-Эрдэнэ¹

¹Хувь судлаач

Хураангуй

Тархины саатай хүүхдийн хөгжил, сэргээн засах эмчилгээ, үйлчилгээнд мэргэжлийн эмч, сэргээн засалчтай адилаар гэр бүлийн үүрэг оролцоог олон улсын түвшинд чухалчилж үзэх болжээ. Сүүлийн жилүүдэд манай улсад нярайн өвчлөл, тэр дундаа нярайн шарлалт огцом нэмэгдэж, үүнээс шалтгаалсан тархины саатай хүүхдийн тоо өссөөр байна. Үүнтэй холбогдуулан манай улсын тархины саатай хүүхдийн хөгжилд гэр бүлийн оролцоо, тэдгээрт тулгарч буй хүндрэл бэрхшээл, нөхцөл байдлыг тодорхойлохыг зорьсон. Ингэхдээ эцэг эх, асран хамгаалагчдаас урьдчилан бэлтгэсэн асуулгыг авч нэгтгэн боловсруулсан бөгөөд дараах голлох үр дүнгүүд гарлаа. Нэгдүгээрт, хүүхдийнхээ өвчний онош, эмчилгээ үйлчилгээний талаар дийлэнх эцэг эхчүүд холбогдох эмч, мэргэжилтэн, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссоос хангалттай мэдээлэл, зөвлөгөө авч чаддаггүй байна. Хоёрдугаарт, эрт оношилгоо боломжийн түвшинд байгаа ч мэдээллийн дутмаг байдал нь тархины саатай хүүхдүүд сэргээн засах эмчилгээ, үйлчилгээнд хамрагдаж эхлэх хугацаанд сөргөөр нөлөөлж байна. Гуравдугаарт, эмнэлэгт сэргээн засах үйлчилгээ хийлгэх давтамж бага, эмчилгээний үргэлжлэх хугацаа богино байгаад зогсохгүй эцэг эхчүүд гэрийн нөхцөлд дасгал, хөдөлгөөнийг төдийлөн хийлгэдэггүй байна. Иймд эцэг эхчүүд хүүхдийнхээ хөгжлийн бэрхшээлийн талаар чанартай мэдээлэл, зөвлөгөөг богино хугацаанд авах боломжийг сайжруулах хэрэгтэй юм. Мөн холбогдох байгууллага, мэргэжлийн эмч, сэргээн засалчийн зүгээс гэр бүлд чиглэсэн хүүхдийн өдөр тутмын үйл ажиллагаанд хийх сэргээн засах эмчилгээний зааварчилгаа, эцэх эхийн оролцоог нэмэгдүүлэхүйц хөтөлбөр боловсруулж өгөх шаардлага тулгарч байна.

Түлхүүр үг: эцэг эх, бага насны хөгжил, мэдээлэл, сэргээн засах хөтөлбөр

Удиртгал

Нийслэлийн Эрүүл мэндийн газраас жил бүр эрхлэн гаргадаг “Нийслэлийн хүн амын эрүүл мэндийн үзүүлэлт” статистик мэдээний тайланд 2012 оноос эхлэн нярай хүүхдийн өвчлөлийн тоо мэдээг танилцуулжээ(Хүснэгт 1). Улаанбаатар хотод 2012-2019 онд төрсөн нийт хүүхдийн тоо 37-42 мянган хооронд харьцангуй тогтвортой байсан бол нярайн хүүхдийн өвчлөлийн тоо энэхүү долоон жилийн хугацаанд 2.7 дахин нэмэгдэж, 6472-оос 17526 болж өсжээ. Өөрөөр хэлбэл 2012 онд нийт амьд төрсөн хүүхдийн 17.4 хувь нь өвчилсөн бол 2019 онд нийт амьд төрсөн хүүхдийн бараг тэн хагас буюу 42.5 хувь нь өвчилсөн байна.

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Хүснэгт 1: Улаанбаатар хотын Нярай хүүхдийн өвчлөл ба Нярайн шарлалтын тоо, 2012-2019 он

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Амьд төрсөн хүүхэд	37214	40187	41786	41731	40687	38404	40703	41206
Нярайн хүүхдийн нийт өвчлөлийн тоо	6472	6880	7115	8494	8465	11859	15858	17526
<i>Нярайн өвчлөлийн амьд төрсөн хүүхдэд эзлэх хувь</i>	17.4%	17.1%	17.0%	20.4%	20.8%	30.9%	39.0%	42.5%
Перинаталь үед үүссэн эмгэгийн тоо	5509	6332	6041	7484	7432	10065	13412	14989
Нярайн шарлалт	1609	1710	469	644	1865	4610	6250	6430
<i>Нярайн шарлалтын амьд төрсөн хүүхдэд эзлэх хувь</i>	4.3%	4.3%	1.1%	1.5%	4.6%	12.0%	15.4%	15.6%

Эх сурвалж: “Нийслэлийн хүн амын эрүүл мэндийн үзүүлэлт” 2012-2019, Судлаачийн тооцоолол

Энэхүү Улаанбаатар хотын нярайн өвчлөлд перинаталь үед үүссэн эмгэг дийлэнх буюу 80-90 орчим хувийг эзэлдэг. Эдгээр перинаталь үеийн эмгэг дотроос нярайн шарлалт сүүлийн жилүүдэд огцом нэмэгджээ. Тодруулбал, 2017 онд нярайн шарлалтын тоо хэмжээ өмнөх оноос 2.5 дахин нэмэгдэж 4610-д хүрсэн бол 2019 оны байдлаар 6430-д хүрээд байна. Өөрөөр хэлбэл, нийслэл хотод 2012 онд нийт амьд төрсөн хүүхдийн 5 хүрэхгүй хувь нь нярайн шарлалтаар өвдсөн бол 2019 оны байдлаар 15 гаруй хувь нь нярайн шарлалтаар өвджээ.

Нөгөө талд, нярайн шарлалт хүндэрсэн үед үүсэх сөрөг үр дагавар нь тархины гэмтэл, тэр дундаа тархины хөнгөнөөс хүнд хэлбэрийн саажилт билээ. Хэдийгээр энэхүү эмгэгээс урьдчилан сэргийлэх бүрэн боломжтой ч мэдээллийн дутмаг байдал, анхаарал болгоомжгүй, хариуцлагагүй байдлаас шалтгаалан насан туршдаа бүрэн эдгэхгүй үлдэх тархины саа өвчтэй үлдэж буй бяцхан үрсийн тоо сүүлийн жилүүдэд нэмэгдсээр байгаа нь харамсалтай бөгөөд тэдний нэг нь манай хүүхэд юм.

Энэ бүхэн эхэн үедээ манай шинэ гэр бүлд хүнд хэцүү санагдаж байсан ч сүүлийн 3 жилийн хугацаанд хүүхдийнхээ өвчний онош, онцлог, хүүхдээ хэрхэн сайжруулж болох талаар Монгол болон бусад орнуудын сэргээн засах эмчилгээ, үйлчилгээ, дасгал хөтөлбөрийг өөрсдийн боломжоороо судлан хэрэгжүүлснээр хүүхэд мань сайжирсаар байна. Эдгээрийн үр дүнд тархины саатай хүүхдэд цаг алдалгүй, эрт тусалж, сэргээн засах, хөгжүүлэх үйл ажиллагааг тууштай, үр дүнтэй хэрэгжүүлснээр бие бялдар, оюун ухааны хувьд эрүүл хүүхдийн түвшинд хүрэх боломжтойг ойлгож мэдсэн явдал юм.

Түүнчлэн, надтай адилхан нөхцөл байдал, хүндрэлийг туулж буй олон аав, ээжүүдтэй туршлага хуваалцаж, санал бодлыг сонсоход тэдгээрийн ихэнх нь зөвхөн эмч, мэргэжилтэн, сэргээн засалчид суурилсан эмчилгээ үйлчилгээ голчлон авч байгаа ажиглагдсан. Хэдийгээр тэд хүүхэддээ бүхнээ зориулж байгаа ч саажилтын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл дутмаг, нарийн хөтөлбөр, төлөвлөгөөгүйн улмаас хүүхдийнхээ хамгийн хурдацтай хөгжиж дэвших, эмчилгээний үр дүн өндөр байх цонх үеийг үр ашиг багатай, боломжит хэмжээгээр нь ашиглаж чадахгүй байх шиг санагдсан.


Нөгөө талд, Шигтгээ 1-д дурдсанчлан тархины саатай хүүхэд гэлтгүй эрүүл хүүхдийн бага нас, тэр дундаа амьдралын эхний 3 жил хүүхдийн тархины хөгжилд нэн чухал үе болохыг эрдэмтэн, судлаачид батлан харуулж, үр дүнгээ онцолсоор байна. Иймд тархины саатай хүүхдийн хөгжилд мэргэжлийн эмч, сэргээн засалчдаас гадна өдрийн ихэнх цагийг хамт өнгөрүүлж буй гэр бүл, эцэг эхийн оролцоо зайлшгүй чухал нь тодорхой юм. Өөрөөр хэлбэл, эцэг эх, гэр бүлийн оролцоо тархины саатай хүүхдэд хэн бүхнээс илүү ирээдүйн амьдралыг нь шийдэхүйц, хамгийн чухал үр нөлөөтэй хүчин зүйл болж байна.

Иймд энэхүү судалгааны ажлаар тархины саатай хүүхдийн хөгжилд эцэг эх, гэр бүлийн оролцооны ач холбогдол, үр нөлөөний талаар олон улсад хийгдсэн судалгааны ажлуудын үр дүн, санал зөвлөмжийг судлахын зэрэгцээ манай улсын тархины саатай хүүхдийн хөгжилд гэр бүлийн оролцоо, тэдгээрийн нөхцөл байдал, тулгарч буй хүндрэл бэрхшээлийг судалгаа, шинжилгээгээр харуулахыг зорилоо.

Шигтгээ 1: Бага насны хүүхдийн хөгжил [1]

Хүний насан туршийн амьдралыг авч үзвэл амьдралын эхний жилүүд тархины хамгийн эрчимтэй хөгжлийн үе бөгөөд хүний эрүүл мэнд, нийгмийн амьдралын чадамжид хамгийн хүчтэй нөлөө үзүүлдэг хүний хөгжлийн хамгийн чухал үе юм [2].

Зураг 1: Хүний хөгжлийн хөрөнгө оруулалтын эргэх ашиг



Эх сурвалж: Жеймс Хейкман, 2009

Нобелийн шагналт, эдийн засагч Жеймс Хейкман (2009) бага насны хүүхдийн хөгжил, боловсролын хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулахын үр ашгийг тооцоолжээ. Тэрээр 6 хүртэлх насны хүүхдийн хөгжилд оруулсан 1 доллар тутмын эргэх ашиг нь 12.90 доллар (Зураг 1) гэдгийг тооцоолж хувь хүний хөгжилд оруулсан хөрөнгө оруулалт нь зөвхөн боловсрол олж авч буй тэр хэсэг хүмүүст бус улс орны эдийн засгийн хөгжилд бүхэлд нь өндөр үр ашигтай байдаг хэмээн бага насны хөгжлийн хөрөнгө оруулалтын ач холбогдлыг тодруулсан. Мөн бага насны хөгжил нь насан туршийн амжилттай суралцах, чанартай амьдрахын эх үндэс төдийгүй бага насны хөгжлийн хөрөнгө оруулалт нь хамгийн ухаалаг хөрөнгө оруулалт гэдгийг онцолжээ. Хүүхдийн амьдралын эхний 3-4 жилд тархины жин амьдралын туршид дахин давтагдахгүйгээр нэмэгдэж, хүнд байх ёстой тархины нийт жингийн 80 хүртэлх хувь нь энэ насанд бүрэлдэн бий болдог (Майн Конгбайер, 2014) байна.


Хүүхэд 3 нас хүрэхэд бүхий л мэдрэхүйгээрээ дамжуулан хүмүүстэй, гадаад ертөнцтэй харилцан, таньж мэдсэн бүхэн нь өөрийнх нь бусдаас үл хамаарах насан туршийн туршлага болон үлддэг байна (Големэн-Рак, 1987 болон Кац, Щульц нар 1997). Энэ нь хүүхдийг бага наснаас нь зохион байгуулалттай сургалтад хамруулахаас илүүтэй өдөр бүрийн ээж аавын хүүхэдтэйгээ харилцсаны үр дүнд

бий болсон туршлагын чанар нь хүүхдийн тархины болон бусад талын хөгжилд нөлөөлдөг болохыг тодруулж байгаа юм.

Хүүхдийн тархины хөгжлийн хэрэгцээ хангагдахгүй байх, ялангуяа тэдний амьдралын эхний жилүүдэд буюу эрчимтэй хөгжлийн үед энэ байдал тохиолдвол хожим засаж залруулахад ихээхэн хүчин чармайлт, хөрөнгө төсөв шаардагдах төдийгүй хүссэн үр дүнд хүрэх найдлага ч эрс багасдаг.

Хүний тархинд хараа, сонсгол гэх мэт мэдрэхүйн чанарууд эхлэн хөгжиж, хожуу 9 сар орчмоос хэл яриа, нэг нас хүрэхийн үед дээд мэдрэлийн үйл ажиллагаанууд хөгжиж эхэлдгийг доорх зургаас харж болно. Өөрөөр хэлбэл, тархи эхэндээ олон шинэ холбоосоор хурдтай баяжиж байгаад яваандаа шинэ холбоос нэмэгдэх хурд буурч, өмнөх энгийн үйлдлийн хэлхээн дээр тулгуурласан илүү нарийн төвөгтэй үйлдлийн хэлхээнүүд бүрэлдэн тогтдог байна (Зураг 2).

Зураг 2: Хүүхдийн тархины мэдрэлийн эсийн хөгжил



Эх сурвалж: Харвардын Их Сургуулийн Хүүхэд хөгжлийн төв

Судлагдсан байдал

Судалгааны зорилготой нийцүүлэн хөгжлийн бэрхшээлтэй, тэр дундаа тархины саатай хүүхдийн хөгжил, сайжралд гэр бүлийн оролцооны үзүүлэх нөлөө, ач холбогдлыг онцолсон олон улсын судалгааны ажлуудыг тоймлон авч үзэхэд ихэнх нь эцэг эхийн оролцоотой байдлын хүүхдэд үзүүлэх нөлөөг тооцсон бол зарим судалгаагаар эцэг эх, гэр бүлд хэрхэн нөлөөлж байгааг судалсан байна.

Эцэг эхийн оролцоо нь хүүхдэд нөлөөлж буй байдлыг судалсан судалгаануудыг авч үзвэл Parette болон бусад судлаачид нь 5 сараас 2 хүртэлх насны тархины саатай 24 хүүхдийн хөдөлгөөн засал эмчилгээнд гэр бүлийг нь 6 сарын турш өндөр оролцоотой байлган судалсан бөгөөд энэ хугацаанд хүүхдүүдийн хөдөлгөөний хөгжил нь тэдний эцэг эхийн эмчилгээнд оролцсон оролцооны түвшин болон зарцуулсан цаг хугацаатай хамааралтайгаар ахисан болохыг тогтоожээ [3]. Нидерландын Utrecht их сургуулийн эрдэмтэн Katelaar нь 2-7 насны хөнгөн болон дунд зэргийн тархины саатай нийт 55 хүүхдийн эмчилгээнд эцэг эхийн оролцооны нөлөөг судалжээ. Ингэхдээ 28 хүүхдийн эцэг эхэд хүүхдийн өдөр тутмын үйл ажиллагааны зааварчилгааг өгсөн бол 27 хүүхдийн эцэг эх өдөр тутмын заавар өгөөгүй бөгөөд бүгд энгийн хөдөлгөөн заслын эмчилгээг гэрийн нөхцөлд хийсэн. Эцэг эхэд нь өдөр тутмын зааварчилгаа өгсөн 28 хүүхдийн үйл ажиллагаанд илүү ахиц гарч, эцэг эх нь нөгөө бүлгээс илүү хүүхдээ хөгжүүлэх дадал суусан байжээ [4]. Мөн Норвеги дахь Ослогийн Эрүүл мэндийн шинжлэх ухааны сургуулийн эрдэмтэд дунджаар 58 сартай тархины саажилттай 55 хүүхдийг судалгаандаа хамруулсан. Энэхүү судалгаагаар тархины саажилттай хүүхдийн өдөр тутмын үйл ажиллагаанд асран хамгаалагчийн оролцоо, хүрээлэн буй орчны өөрчлөлт маш хүчтэй нөлөөтэй гэж дүгнэсэн байна [5]. Нидерландын Гронингений Анагаахын сургуулийн эрдэмтэд 2011 онд тархины саажилтын өндөр эрсдэлтэй нярайн эмчилгээнд гэр бүлийн оролцоог судлахад мэргэжилтэн болон эцэг эхийн харилцан ижил оролцоо нь эрт үеийн эмчилгээнд маш чухал, цаашид гэр бүл төвтэй үйлчилгээ эцэг эхчүүдэд зайлшгүй хэрэгтэй байгааг дурджээ [6].

Харин хүүхдийн хөгжил, дэвшлээс гадна эцэг эх, гэр бүлд үзүүлж буй нөлөөг онцолсон судалгаануудын хувьд Синдней их сургуулийн эрдэмтэн Shepherd нь хүүхдийн физик эмчилгээний талаарх судалгаандаа “Хүүхдийг эмнэлэг рүү нөхөн сэргээх эмчилгээнд зөөхийн оронд энэ нөхөн сэргээх эмчилгээ, хөдөлгөөн заслыг хүүхдийн өдөр тутмын үйл ажиллагаанд оруулах, дадал зуршил болгож өөрчлөх нь чухал юм. Энэ өөрчлөлтөд эцэг эхийн үүрэг хамгийн их байдаг. Ингэж эцэг эхийн үүрэг, оролцоо нэмэгдсэнээр тэд хүүхдийнхээ хөгжлийн бэрхшээл, чадварын талаар илүү ойлголттой болж өдөр тутамд хүүхдийнхээ чадварыг илүү бодитой харж чаддаг

болдог. Түүнчлэн энэ нь эцэг эхчүүдийн өөрсдийн чадамжид итгэх итгэлийг нэмэгдүүлж улмаар стресс бухимдлыг нь бууруулдаг” гэжээ [7]. Мөн Catanese болон бусад судлаачид Унгарын Петогийн аргад суурилсан хөтөлбөрийг 4-7 насны тархины саатай 34 хүүхдэд хэрэгжүүлж үр дүнг хяналтын бүлэгтэй харьцуулан судалжээ. Энэ хөтөлбөрт хүүхдийн физик эмчилгээ нь сургууль, гэр бүл, нийгмийн орчинд хийгддэг ба эцэг эхтэйгээ хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийн хөдөлгөөний хөгжилд ахиц гарсан бөгөөд хөдөлгөөн засалд оролцоотой байсан эцэг эхчүүд стандарт бүлэгтэй харьцуулбал сэтгэл зүйн дарамт бага байгаа нь ажиглагджээ [8]. Түүнчлэн олон улс орнууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүлд тэдний хүүхдийн хөгжилд гэр бүлийн оролцоог чухалчилж, хүүхдийг дэмжих **гэр бүл төвтэй хөтөлбөр** бүхий төрөл бүрийн үйлчилгээг боловсруулан ашиглаж эхэлсэн байна. Энэхүү гэр бүл төвтэй хөтөлбөрт “Гэр бүл” бол хүүхдийн амьдралд хамгийн чухал мөн байнгын тогтвортой гэдгийг хүлээн зөвшөөрч, эмч мэргэжилтнүүд эцэг эхчүүдийг шаардлагатай мэдээллээр хангаснаар, хүүхдийн эмчилгээнд эн тэнцүү оролцоотой, хариуцлагатай байж, тэд хамтран ажиллах боломж бүрддэг [9] гэжээ. Мөн хүүхдийнхээ хөгжлийн бэрхшээл, ирээдүйн талаар хангалттай мэдээлэл авсан эхчүүдэд сэтгэлзүйн дарамт бага байгааг тогтоожээ [10]. Гэр бүл төвтэй хөтөлбөрт эцэг эхчүүд хүүхдийнхээ зорилгыг тодорхойлох, эмчилгээний хөтөлбөрт идэвхтэй оролцож, эмч, засалчидтай тэгш эрхтэй хамтран ажилласнаар хүүхдийн хөгжил, бие даасан байдлын хувьд оролцоогүй эцэг эхтэй харьцуулахад сайн, эмчилгээ илүү үр дүнтэй байсныг [11] баталсан байдаг.

Манай улсын хувьд тархины саатай хүүхдийн сэргээн засах эмчилгээ болон эцэг эхийн оролцоотой холбоотой дараах судалгааны ажлууд хийгдсэн байна. Тархины саатай хүүхдийн сэргээн засах эмчилгээ үйлчилгээний талаар Б.Сувд ба Ц.Жавзансүрэн нар нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн протез, ортопедийн хэрэгцээ шаардлага их байгаа гэж дүгнэсэн [12]. Харин Р.Отгонсайхан, Х.Циендолгор нар нь хүүхдэд хөдөлгөөн заслын эмчилгээг бага насанд тасралтгүй буюу дунджаар 15 хоногоос дээш хоног хийх нь үр дүнтэй гэж үзжээ [13]. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагчдын сэтгэл зүй, амьдралын нөхцөл байдлын талаар судалсан М.Эрдэнэ-Оюуны судалгаа нь хөгжлийн

бэрхшээлтэй хүүхдийн гэр бүлд ядуурал, нийгмийн сөрөг хандлага, нийгэмд эзэлж буй байр суурь, хүүхэд асрахтай холбоотой олон асуудал байгааг онцолжээ [14]. Мөн Б.Энхтуяагийн сургуулийн насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурлага, боловсролд сургууль, багшаас гадна эцэг эхийн оролцооны талаар судлахад манай эцэг эхчүүд хүүхдийнхээ сурлага хүмүүжил, төлөвшилд төдийлөн анхаардаггүйг тогтоожээ [15]. Харин хөгжлийн бэрхшээлтэй тэр дундаа тархины саатай бага насны хүүхдүүдийн хөгжил, сэргээн засах эмчилгээнд гэр бүлийн оролцоог чухалчилсан, хоорондын холбоо хамаарлыг онцолсон судалгааны ажил одоогоор хийгдээгүй байна.

Судалгааны зорилго

Манай улсад сүүлийн жилүүдэд нярайн шарлалт болон бусад төрлийн шалтгаанаас тархины саажилт, хөдөлгөөний хоцрогдолтой хүүхдүүдийн тоо сүүлийн жилүүдэд нэмэгдсээр байна. Хүүхдийг нярай, бага насанд зохистой арга хэмжээ авснаар хөгжлийн бэрхшээл үүсэхээс 70 хувь сэргийлэх боломжтой, гэвч хөгжлийн хоцрогдолтой 9 сартай хүүхдүүдийн 9 хувь, 24 сартай хүүхдүүдийн дөнгөж 12 хувь нь шаардлагатай үйлчилгээг авч байна гэсэн судалгаа байдаг [16]. Иймд хөгжлийн бэрхшээлтэй тэр дундаа тархины саатай бага насны хүүхдэд цаг алдалгүй, эрт тусалж, сэргээн засах, хөгжүүлэх үйл ажиллагааг тууштай, үр дүнтэй хэрэгжлүүлснээр бие бялдар, оюун ухааны хувьд эрүүл хүүхдийн түвшинд хүрэх боломжтой. Энэхүү боломжийг хангахын тулд эцэг эхийн мэдлэг, мэдээлэл, гэр бүлийн оролцоо зайлшгүй чухлыг дээр дурдсан билээ.

Тиймээс эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийнхээ хөгжил, сэргээн засах эмчилгээнд оролцоотой эсэх, тэдгээрийн нөхцөл байдал, тулгарч буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлох суурь судалгааг олон улсын туршлага, арга зүйд үндэслэн судлахыг зорилоо. Энэхүү зорилгын хүрээнд тархины саатай хүүхэдтэй эцэг эхчүүдээс хүүхдийнхээ өвчний талаарх мэдээллийг хангалттай авсан эсэх, оношлогдсоны дараа хүүхдээ эмчилгээнд хамруулж эхэлсэн хугацаа, тэдний хүүхэддээ үзүүлж буй асаргаа, улсын болон хувийн эмнэлгийн эмчилгээ, үйлчилгээнд хамрагдах байдал, давтамж, зарцуулдаг цаг хугацааг, гэр бүл нь эмчилгээнд тэр дундаа хөдөлгөөн

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

заслын эмчилгээнд хэр их оролцоотой байдаг, гэрийн нөхцөлд тасралтгүй тогтмол хүүхдээ хөгжүүлж буй зэргийг асуулгын аргаар авч нэгтгэн дүгнэсэн болно.

Судалгааны арга зүй ба түүвэрлэлт

ХБХ-ийн эцэг эхчүүдээс тус судалгааг авахдаа боломжит байдлыг харгалзан үзсэний дүнд ХБХСЗХТөвд үйлчлүүлж буй хүүхдүүдийн асран хамгаалагчдаас асуулга анкетийн аргаар, мөн тархины саажилт, тархины бусад төрлийн эмгэгтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн Фэйсбүүкийн “Нандин сувд” нэгдлээр дамжуулан цахимаар асуулга авсан. Судалгааны санал асуулгыг бусад улсад хийсэн ижил төстэй судалгааны санал асуулга болон өөрийн туршлага, судалгааны зорилгод үндэслэн боловсруулав.

Судалгааны зорилгын дагуу эх олонлог нь манай улсын нийт тархины саажилт оноштой хүүхэд, тэдний гэр бүл, эцэг эх болно. Гэвч Үндэсний статистикийн хороо, Эрүүл мэнд хөгжлийн төв болон бусад нээлттэй эх сурвалжид тархины саатай иргэд, хүүхдийн нарийн тоо мэдээллэдэг. Харин хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, статистикийг хараа, сонсгол, яриа, хөдөлгөөн, сэтгэц, хавсарсан, болон бусад гэсэн ерөнхий 7 төрлөөр олон нийтэд мэдээллэж байна.

Хүснэгт 2: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, өсвөр насныхны тоо, төрлөөр, 2019 он

Хөгжлийн бэрхшээлийн төрөл	5 хүртэлх		5-9 нас		10-14 нас		14-19 нас		Нийт тоо	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Хараа	164	7.8	338	10.3	326	10.6	527	11.0	1355	10.2
Сонсгол	122	5.8	175	5.3	215	7.0	380	7.9	892	6.7
Яриан	122	5.8	238	7.2	213	6.9	302	6.3	875	6.6
Хөдөлгөөн	394	18.7	634	19.3	570	18.5	831	17.3	2429	18.3
Сэтгэц	329	15.6	627	19.1	677	22.0	1063	22.1	2696	20.3
Хавсарсан	277	13.2	434	13.2	357	11.6	535	11.1	1603	12.1
Бусад	698	33.1	837	25.5	715	23.3	1174	24.4	3424	25.8
Нийт	2106	100.0	3283	100.0	3073	100.0	4812	100.0	13274	100.0

Эх сурвалж: Эрүүл мэндийн үзүүлэлт-2019

Иймд боломжит статистик мэдээллийг харгалзан үзвэл Эрүүл мэнд хөгжлийн төвөөс гаргасан “Эрүүл мэндийн үзүүлэлт-2019” тайлангийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тооноос хөдөлгөөний болон хавсарсан гэсэн ангилалд багтсан хүүхдүүдийн тоог эх олонлог болгон төлөөлүүллээ (Хүснэгт 2). Тодруулбал, 19 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдээс хөдөлгөөн болон хавсарсан төрөлд багтах 4032 хүүхдийг эх олонлог болгон авсан.

Оновчтой түүврийн хэмжээг тодорхойлохдоо түүврийн харьцаа болон дунджийн хувьд 95%-ийн итгэх интервалд (хамгийн багадаа 10%-ийн ач холбогдлын түвшинд) статистикийн хувьд найдвартай байх хамгийн бага хангалттай хэмжээний түүврийг тооцож үзэхэд 94 хүүхэд байна.

2020 оны 11 сарын 3-ны өдрөөс 11 сарын 7-ны өдрийн хооронд ХБХСЗХТөвд эмчилгээ хийлгэж байсан 36 хүүхдийн асран хамгаалагч, Фэйсбүүк группээс цахим хэлбэрээр 140 эцэг эх буюу нийт 176 хүн түүвэр судалгааны асуулгад хамрагдсан. Эдгээрээс асуулга дутуу бөглөсөн болон тархины гэмтлээс гадна бусад өвчин (дауны синдром, аутизм, эпилепси гэх мэт)-ий оноштой хүүхдүүдийн эцэг эх хариултыг хасах замаар зөвхөн тархины саажилттай, хөдөлгөөний болон хавсарсан бэрхшээлтэй 132 хүүхдийн асуулгыг сонгон авч судалгааны үр дүнг нэгтгэн боловсруулсан болно.

Судалгааны үр дүн



Судалгааны түүврийн ерөнхий мэдээлэл

Судалгаанд оролцсон нийт эцэг эхчүүдийн 92 хувь нь эмэгтэй, үлдсэн 8 хувь нь эрэгтэй байсан. Насны хувьд тэн хагас нь буюу 50 хувь нь 26-35 настай, 36 хувь нь 36-45 нас, 7 хувь нь 18-25 настай үлдсэн 6 хувь нь 46-аас дээш настай байлаа (Зураг 3 ба 4).

Зураг 3: Судалгаанд оролцсон хүмүүс, хүйсээр

Зураг 4: Судалгаанд оролцсон хүмүүс, насны ангиллаар

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”





Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, Судлаачийн тооцоолол

Судалгаанд эцэг эхчүүдийн 43 хувь нь хүүхэд нь оношлогдсоноос хойш ажил хийхээ больсон, 32 хувь нь ажил эрхэлдэг, 25 хувь нь ажил эрхэлдэггүй байв. Нийт оролцогчдын дөрөвний гурав нь буюу 75 хувь нь Улаанбаатар хотод, 17 хувь нь аймгийн төвд үлдсэн 8 хувь нь сумын төв болон хөдөө амьдардаг байна (Зураг 5 ба 6).

Зураг 5: Судалгаанд оролцсон хүмүүс, ажил эрхлэлтийн байдлаар

Зураг 6: Судалгаанд оролцсон хүмүүс, оршин суугаа газраар



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, Судлаачийн тооцоолол


Үндсэн асуулгын үр дүн

Нийт судалгаанд хамрагдсан тархины саажилттай хүүхдийн 52 хувь нь эрэгтэй, 48 хувь нь эмэгтэй байна. Насны ангиллаар нь авч үзвэл 0-3 насны хүүхэд 25 хувийг эзэлж байсан бол 4-6 насны хүүхэд хамгийн их буюу 39 хувийг эзэлж


“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

байна. Тодруулбал, хөгжлийг дэмжих хамгийн чухал насан дээр байгаа бага насны хүүхдүүд судалгаанд оролцогчдын гуравны хоёрыг буюу 64 хувийг эзэлсэн байна. Харин 7-10 настай хүүхдүүд 28 хувийг эзэлсэн бол 11-18 насны хүүхэд үлдсэн 8 хувийг бүрдүүлж байна (Зураг 7 ба 8).

Зураг 7: Хүүхдийн хүйс



Зураг 8: Хүүхдийн насны ангилал




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, Судлаачийн тооцоолол

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 52 хувь нь хөдөлгөөний, 48 хувь нь хөдөлгөөн болон бусад бэрхшээл хавсарсан бэрхшээлтэй байсан (Зураг 9). Нийт хүүхдүүдийн 76 хувь нь эрт буюу 0-1 насанд, 20 хувь нь 1-3 насанд, 2 хувь нь 3-аас дээш насанд оношлогдсон бол үлдсэн 2 хувь нь бүрэн оношлогдоогүй байна (Зураг 10) Эндээс Монгол улсад хөгжлийн бэрхшээлтэй, тэр дундаа тархины саажилттай хүүхдийг эрт илрүүлэх, оношлох ажиллагаа харьцангуй боломжийн түвшинд байна гэж харагдаж байгаа ч судалгааны асуулгын саналаар саажилттай болсон шалтгаан нөхцөл тодорхойгүй, нарийн шинжилгээгүй, илрэх шинж тэмдгээр ДЦП гэсэн ерөнхий онош тавьсан гэсэн тайлбар цөөнгүй ирсэн.

Зураг 9: Хүүхдийн бэрхшээлийн хэлбэр

Зураг 10: Оношлогдсон хугацаа




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, Судлаачийн тооцоолол

Эцэг эхчүүдээс холбогдох байгууллага, эмч, мэргэжилтнүүд, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын зүгээс хүүхдийн өвчний онош, тархины саатай холбоотой мэдээлэл, зөвлөгөө өгсөн эсэхийг тодруулж асуухад 10 орчим хувь нь мэдээлэл огт аваагүй байна. Харин мэдээлэл, зөвлөгөө авсан эцэг эхчүүдийн 20 гаруй хувь нь хангалттай гэж үзсэн бол үлдсэн 70 хувь нь хангалтгүй гэж үнэлжээ. Бага насны хүүхэдтэй (0-6 нас) эцэг эхийн хувьд мэдээлэл авсан байдал нь бусад эцэг эхтэй харьцуулахад адилхан байгаа нь сүүлийн жилүүдэд ч холбогдох байгууллага, эмч мэргэжилтнүүдийн зөвлөгөө, мэдээлэл өгөх байдал өөрчлөгдөөгүйг илтгэж байна (Зураг 11). Түүнчлэн хүүхэд бүрт тусгайлан зориулсан эмчилгээний хөтөлбөрийг судалгаанд оролцогчдын 84 хувьд нь боловсруулж өгөөгүй байна. Бага насны хүүхэдтэй эцэг эхчүүдийн хувьд бусад эцэг эхчүүдтэй харьцуулахад 6 нэгж хувиар өндөр буюу 19 хувьд нь боловсруулж өгсөн хэдий ч энэ нь төдийлөн хангалттай биш юм (Зураг 12).

Зураг 11: Мэдээлэл авсан байдал

Зураг 12: Хөтөлбөртэй эсэх

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, Судлаачийн тооцоолол

Хангалттай мэдээлэл өгсөн эцэг эхчүүдийн тэн хагас нь хүүхдээ оношлогдсоноос 1 сарын дотор, 33 хувь нь 1-3 сарын хугацаанд, үлдсэн 17 хувь нь 3 сарын дараагаас хүүхдээ эмчилгээнд хамруулж эхэлсэн байна. Харин мэдээлэл хангалтгүй авсан эцэг эхчүүдийн гуравны нэг нь буюу 33 хувь 1 сарын дотор, 30 орчим хувь нь 3 сараас хойш хамрагдсан бол 13 хувь нь хүүхдээ одоогоор эмчилгээнд хамруулаагүй байна. Мэдээлэл огт аваагүй эцэг эхчүүдийн 8 хувь нь огт эмчилгээнд хамрагдаагүй, ихэнх 42 хувь нь хожуу буюу 3 сарын дараагаас хүүхдээ эмчилгээ үйлчилгээнд хамруулж эхэлжээ (Зураг 13). Манай улсын хувьд эрт үеийн оношилгоо боломжийн түвшинд байгаа ч хүүхдийн онош, өвчний талаар мэдээллийг хангалтгүй өгснөөр хүүхдийг бага дээр нь эрт үеийн үйлчилгээ авах хугацаанд нөлөөлж байна гэж харагдаж байна.

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Зураг 13: Эмчилгээ эхэлсэн хугацаа




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, Судлаачийн тооцоолол

Судалгаанд оролцсон хүүхдүүдийн хувьд дийлэнх нь буюу 61 хувь 7 хоногт 1-2 удаа сэргээн засах эмчилгээнд хамрагддаг бол 24 хувь нь 3-4 удаа, үлдсэн 15 хувь нь 5-аас дээш удаа хамрагдаж байна. Хүүхдийн насны ангиллаар нь харьцуулж харвал бага насны хүүхдүүдийн хувьд бусад хүүхдүүдээс харьцангуй олон удаа хамрагдаж байна. Тодруулбал, 0-6 насны хүүхдүүдийн 40 орчим хувь нь долоо хоногт 3-6 удаа эмчилгээ, сэргээн засах үйлчилгээнд хамрагддаг бол 7-оос дээш насны хүүхдүүдийн хувьд 20 гаруй хувь нь хамрагдаж байна. Харин эсрэгээр 7-оос дээш насны хүүхдүүдийн хувьд 70 хувь нь 1-2 удаа дасгалд хамрагддаг бол бага насны хүүхдүүд 55 хувьтай байна (Зураг 14).


Эмчилгээний үргэлжлэх хугацааны хувьд нийт хүүхдийн ихэнх нь буюу 70 хувь нь 30 минут хүртэл, 28 хувь нь 31-60 минут, дөнгөж 2-3 хувь нь 60-аас дээш минут эмчилгээ хийлгэдэг байна. Насны ангиллын хувьд эмчилгээний үргэлжлэх хугацаа нь төдийлөн ялгаагүй байна (Зураг 15). Нэгтгэн үзвэл гурван хүүхэд тутмын хоёр нь 7 хоногт 1-2 удаа давтамжтай, 30 минут хүртэлх хугацаагаар сэргээн засах эмчилгээ, үйлчилгээнд хамрагдаж байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм.

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Зураг 14: Эмчилгээний давтамж



Зураг 15: Үргэлжлэх хугацаа




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, Судлаачийн тооцоолол

Гэрийн нөхцөлд хүүхдийнхээ хөгжлийг дэмжих дасгал хөдөлгөөн хийлгэдэг эсэхийг тодруулан асуухад таван эцэг эх тутмын гурав нь (61 хувь) үгүй гэж хариулжээ. Үүний голлох шалтгаанууд нь “Цаг зав гардаггүй” (31 хувь), “Ямар дасгал хийлгэхээ мэдэж байгаа ч хийж чаддаггүй” (28 хувь) болон “Ямар дасгал хийхээ мэддэггүй” (22 хувь) гэсэн байна. Харин 40 хүрэхгүй хувь нь хүүхдээ хөгжүүлэх, хөдөлгөөн заслыг гэрийн нөхцөлд хийлгэж чаддаг гэсэн байна. Тэдний хагас нь буюу 46 хувь нь 7 хоногт 3-5 удаа, 21 хувь нь 1-2 удаа, үлдсэн 30 гаруй хувь нь 6-аас дээш удаа дасгал хөдөлгөөн хийлгэж байна (Зураг 16). Хүүхдийн хөгжил, хөдөлгөөний сайжрал, чадваруудад хамгийн чухал цаг үеүдэд хөдөлгөөн засал, эмчилгээнд эцэг эхийн оролцоо ийнхүү бага байгаа нь эцэг эхийн мэдээлэл, хүүхэд хөгжүүлэх хөтөлбөр дутмаг байгаа нь харагдаж байна.

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”


Зураг 16: Та гэрийн нөхцөлд хүүхдээ хөгжүүлэх дасгал хөдөлгөөн хийлгэдэг үү?



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, Судлаачийн тооцоолол

Сэргээн засах эмчилгээ, үйлчилгээ авдаг хүүхдийн хувьд ХБХСЗХТөвд хамгийн ихээр буюу 41 хувь нь үйлчлүүлдэг байна. Харин 38 нь хувь гэрээр сэргээн засалч, бариач хөлслөн дасгал хөдөлгөөн хийлгэдэг байна. Тусгай цэцэрлэг болон ЭХЭМҮТ-д сэргээн засах үйлчилгээнд хамрагддаг хүүхдүүд 25 орчим хувьтай байгаа бол хувийн эмнэлэг, хүүхдийн төв сувилал болон бусад газраар 10 хүрэхгүй хувь нь үйлчлүүлдэг байна (Зураг 17).

Зураг 17: Эмчилгээ хийлгэдэг газар




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, Судлаачийн тооцоолол

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Хүүхдээ эмчилгээнд хамруулдаг эцэг эхчүүд жилийн дөрвөн улирал тогтмол хамруулж чадаж байгаа эсэхийг асуухад Улаанбаатар хотод оршин суудаг эцэг эхчүүдийн хувьд 30 хувь нь чаддаг, 70 хувь нь чаддаггүй гэсэн бол аймгийн төв амьдардаг эцэг эхчүүдийн 18 хувь нь чаддаг, 82 хувь нь тогтмол хамруулж чаддаггүй байв. Харин сумын төв, хөдөө оршин суудаг эхчүүд 100% үгүй буюу тогтмол үйлчилгээ авж чаддаггүй гэж хариулсан бөгөөд энэ сумын төвд сэргээн засах мэргэжилтэн байхгүй гэсэн шалтгаантай байсан (Зураг 18).

Зураг 18: Эмчилгээг 4 улирал тогтмол хийлгэдэг эсэх




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, Судлаачийн тооцоолол

Судалгаанд оролцсон тархины саажилттай эцэг эхчүүдийн ерөнхий нөхцөл байдлыг тодорхойлохын тулд доорх асуултуудыг асуусан болно. Тэднээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асрахад дэмжлэг, туслалцаа авч чаддаг эсэхийг асуухад санал нийлэхгүй 36 хувь, огт санал нийлэхгүй 18 хувь нь байсан бол санал нийлнэ гэж 21 хувь, бүрэн санал нийлнэ гэж 3 хувь нь хариулсан байна. Миний хүүхэд сэргээн засах үйлчилгээ, эмчилгээнд сайн хамрагддаг гэдэгтэй нийт 54 хувь нь санал нийлэхгүй, 12 хувь нь мэдэхгүй, 34 хувь нь санал нийлж байв. Хүүхдийнхээ хөгжлийн бэрхшээлийн талаар холбогдох байгууллага, мэргэжилтнүүдээс хангалттай мэдээлэл авч чаддаг эсэхэд 61 хувь нь санал нийлэхгүй хандлагатай, 20 хувь нь санал нийлсэн бол 20 хувь нь мэдэхгүй байв. Харин хүүхдийнхээ боловсрол, хөгжлийг дэмжихэд бүрэн бэлтгэгдсэн эцэг эхчүүд 39 хувь, бэлтгэгдээгүй нь 34 хувь бол 19 хувь нь мэдэхгүй байна. Мөн 38 хувь нь хүүхэдтэйгээ өдөр тутмын үйл

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

ажиллагаа идэвхтэй, үр бүтээлтэй байдаг, 41 хувь нь үр бүтээлгүй, 22 хувь нь мэдэхгүй гэжээ (Зураг 19).


Зураг 19: Та дараах зүйлстэй хэр санал нийлж байна вэ?



“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Эцэг эхийн нөхцөл байдлыг харуулсан асуултуудын “Огт санал нийлэхгүй, Санал нийлэхгүй, Мэдэхгүй, Санал нийлнэ, Бүрэн санал нийлнэ” гэсэн чанарын хариултыг -2-оос +2 хооронд тоон утга руу шилжүүлэн индексжүүлэн тооцоход дараах байдалтай байна. Эцэг эхчүүдийн хувьд “Би хүүхэдтэйгээ өдрийг үр дүнтэй өнгөрүүлж чаддаг”, “Би хүүхдийнхээ боловсрол, хөгжлийг дэмжихэд бүрэн бэлтгэгдсэн” гэдэгт мэдэхгүй буюу эргэлзээтэй гэж хариулсан бол “Би хүүхдийнхээ хөгжлийн бэрхшээлийн талаар холбогдох байгууллагаас хангалттай мэдээлэл авдаг”, “Би хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асрахад дэмжлэг, туслалцаа авч чаддаг”, “Миний хүүхэд сэргээн засах үйлчилгээ эмчилгээнд сайн хамрагддаг” гэдэгтэй санал нийлгэхгүй хандлагатай байна (Зураг 20).

Зураг 20: Та дараах зүйлстэй хэр санал нийлж байна вэ?
 (-2=Огт санал нийлэхгүй, -1=Санал нийлэхгүй, 0=Мэдэхгүй, +1=Санал нийлнэ, +2=Бүрэн санал нийлнэ)



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, Судлаачийн тооцоолол

Эцэг эхүүд хүүхдийн хөгжлийн сайжралын талаар асуухад олонх нь буюу 55 хувь нь “Хөгжлийн хоцрогдол их ч өмнөхөөсөө дээрдсэн”, 30 хувь нь “Хөгжлийн хоцрогдол их, сайжрал байхгүй”, 11 хувь нь “Хөгжлийн хоцрогдол бага зэрэг үлдсэн” гэж дүгнэсэн бол “Хөгжлийн хоцрогдлоо гүйцсэн”, “Оношлогдсон үеэсээ муудсан” гэж хариулсан эцэг эхчүүд тус тус 2 хувь байв (Зураг 21).

Зураг 21: Оношлогдсон цагаас хойш таны хүүхдийн хөгжил хэр их сайжирсан бэ?

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн, Судлаачийн тооцоолол

Дүгнэлт

Манай улсад сүүлийн жилүүдэд нярай хүүхдийн өвчлөл, тэр дундаа нярайн шарлалт огцом нэмэгдэж байна. Тодруулбал, 2017 онд нярайн шарлалтын тоо хэмжээ өмнөх оноос 2.5 дахин нэмэгдэж 4610-д хүрсэн бол 2019 оны байдлаар 6430-д хүрчээ. Нярайн шарлалт хүндэрсэн үед үүсэх сөрөг үр дагавар нь тархины гэмтэл, тэр дундаа тархины хөнгөнөөс хүнд хэлбэрийн саажилт билээ. Хэдийгээр энэхүү эмгэгээс урьдчилан сэргийлэх бүрэн боломжтой ч мэдээллийн дутмаг байдал, анхаарал болгоомжгүй, хариуцлагагүй байдлаас шалтгаалан насан туршдаа бүрэн эдгэхгүй үлдэх тархины саа өвчтэй үлдэж буй бяцхан үрсийн тоо нэмэгдсээр байна. Дэлхий дахинд тархины саатай хүүхдийн хөгжил, сэргээн засах эмчилгээ, үйлчилгээнд мэргэжлийн эмч, сэргээн засалчтай адил эцэг эх, гэр бүлийн үүрэг оролцоог чухалчилж байна. Иймд олон улсын туршлагад үндэслэн манай улсын тархины саатай хүүхдийн хөгжил, эмчилгээ, үйлчилгээнд асран хамгаалагч, эцэг эхийн оролцоо, тэдгээрт тулгарч буй хүндрэл бэрхшээл, нөхцөл байдлыг тодорхойлохдоо эцэг эх, асран хамгаалагч нараас урьдчилан бэлтгэсэн асуулгыг авч нэгтгэн боловсруулсан бөгөөд дараах голлох үр дүнгүүд гарлаа.

- Хүүхдийнхээ өвчний онош, эмчилгээ үйлчилгээний талаар дийлэнх асран хамгаалагч, эцэг эхчүүд холбогдох эмч, мэргэжилтэн, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссоос хангалттай мэдээлэл, зөвлөгөө авч чаддаггүй (68 хувьд хангалтгүй, 9 хувьд огт өгөөгүй) байна.

Энэхүү байдал сүүлийн 6 жилийн хугацаанд төдийлөн өөрчлөгдөөгүй байна. Мөн тухайн тархины саатай хүүхдэд зориулсан эмчилгээний тусгай хөтөлбөрийг нийт оролцсон хүүхдийн дөнгөж 17 хувьд нь боловсруулж өгчээ.

- Эрт оношилгоо боломжийн түвшинд байгаа ч мэдээллийн дутмаг байдал нь тархины саатай хүүхдүүд сэргээн засах эмчилгээ, үйлчилгээнд хамрагдаж эхлэх хугацаанд нөлөөлж байна. Тодруулбал, хангалттай мэдээлэлтэй эцэг эхчүүдийн 50 хувь нь нэг сарын дотор хүүхдээ эмчилгээнд хамруулж эхэлдэг бол мэдээлэл огт аваагүй эцэг эхчүүдийн хувьд 40 гаруй хувь 3 сарын дараагаас, 10 орчим хувь нь огт эмчилгээнд хамрагдаагүй байна.
- Хөдөлгөөний болон хавсарсан бэрхшээлтэй гурван хүүхэд тутмын хоёр нь 7 хоногт 1-2 удаа давтамжтай, 30 минут хүртэлх хугацаагаар сэргээн засах эмчилгээ, үйлчилгээнд хамрагдаж байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм. Мөн жилийн дөрвөн улирал тогтмол хамруулж чаддаггүй (84 хувь) байна. Тухайлбал хөдөө орон нутагт оршин суудаг хүүхдүүдийн хувьд эмчилгээ, үйлчилгээнд хамрагдах боломж туйлын хомс байна. Үүний шалтгаан нь хөдөө орон нутагт сэргээн засах төв, мэргэжилтэн хангалтгүй, хүрэлцээгүй байдагтай холбоотой юм.
- Эцэг эхчүүдэд гэрийн нөхцөлд дасгал, хөдөлгөөнийг төдийлөн хийлгэдэггүй, хүүхдийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцоо бага (61 хувь оролцоогүй) хангалтгүй түвшинд байна. Үүний голлох шалтгаанууд нь “Цаг зав гардаггүй”, “Ямар дасгал хийлгэхээ мэдэж байгаа ч хийж чаддаггүй” болон “Ямар дасгал хийхээ мэддэггүй” гэжээ.
- Хүүхдийн хөгжлийн сайжралын хувьд эцэг эхчүүдийн дийлэнх (55 хувь) нь хүүхдээ оношлогдсон үеэс бага зэрэг сайжирсан боловч хоцрогдол хөгжлийн өндөр гэж дүгнэж байна. Харин 30 хувь нь сайжрал байхгүй, хөгжлийн хоцрогдол их гэж үзжээ.

Дээрх бүгдийг нэгтгэн үзвэл манай улсад эцэг эхчүүд саажилтын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл дутмаг, оролцоо бага байгаа нь хүүхдэд хөдөлгөөн, хэл яриа, оюун ухаан зэрэг бүхий л талын чадваруудыг дээшлүүлэх боломжтой цонх үеийг үр дүнтэй, боломжит хэмжээгээр нь ашиглаж чадахгүй, хоцрогдлыг нөхөх боломжийг багасгаж байна. Эдгээр асуудлыг шийдвэрлэх гарц гаргалгааг олон улсад хийгдсэн судалгааны ажлуудын үр дүн, туршлагаас үзвэл:

1. Хүүхдийнхээ хөгжлийн бэрхшээлийн талаар эцэг эхчүүд дэлгэрэнгүй, чанартай мэдээллийг богино хугацаанд, хялбар аргаар найдвартай эх үүсвэрээс олж авах боломжийг хангаж өгснөөр эцэг эхчүүдийн оролцоонд нөлөөлж хүүхдүүд аль болох бага насанд эмчилгээнд хамрагдсаар үр дүн өндөр байна.
2. Хүүхэд оношлогдсон даруйд эмч, эмнэлгийн байгууллага, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс зэрэг мэргэжилтнүүд хүүхэд бүрт тусгайлан зориулсан хөтөлбөрийг боловсруулж, гэрийн болон эмнэлгийн нөхцөлд эцэг эхийн оролцоог тодорхой түвшинд байлгаж, зааварчилгаа зөвлөмжийг шат дараалалтай өгснөөр хүүхдийн хөгжлийн хурд, чадварууд илүү нэмэгдэнэ.
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, гэр бүлийг хүүхдийн эмчилгээнд мэргэжилтнүүдтэй ижил тэгш оролцоотой, үүрэг хариуцлагатай байх “Гэр бүлд суурилсан” эмчилгээ үйлчилгээг улсын хэмжээнд нэвтрүүлэх шаардлага байна гэж үзэж байна.

Цаашид эдгээр арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхэд шат шатны судалгааг хийж, олон талын мэргэжлийн баг хамтран ажиллавал олон хүүхдийн амьдралд маш том хувь нэмэр болно гэдэгт бүрэн итгэлтэй байна.

Талархал

Энэхүү судалгааны асуулгыг эцэг эхчүүдээс авахад тусалсан ХБХСЗХТөвийн эмч С.Төрболд, статистикч Б.Элбэгдорж нарт болон судалгаанд идэвхтэй хамрагдсан Фэйсбүүкийн “Нандин сувд” группын эцэг эхчүүддээ гүн талархал илэрхийлье.

Ашигласан материал

- [1] Б.Болдсүрэн, Н.Болормаа, Л.Мөнхжаргал, Б.Төртогтох ба Т.Цэндсүрэн, “Бага насны хүүхдийн цогц хөгжил,” НҮБ-ийн Хүүхдийн сан, Улаанбаатар, 2020.
- [2] P. D. Shonkoff JP, “From neurons to neighborhoods: the science of early childhood development,” *National Academy Press*, 2000.
- [3] H. L. S. J. Parette HP, “Correlates of therapeutic progress by infants with cerebral palsy and motor delay,” p. 159–163, 1984.
- [4] M. Katelaar, “Children with cerebral palsy: A functional approach to physical therapy,” 1999.
- [5] S. Østensjø, E. B. Carlberg ба N. K. Vøllestad, “Everyday functioning in young children with cerebral palsy: functional skills, caregiver assistance, and modifications of the environment,” 2003.
- [6] T. Dirks ба M. Hadders-Algra, “The role of the family in intervention of infants at high risk of cerebral palsy: a systematic analysis,” *Developmental medicine and child neurology*, 2011.
- [7] R. B. Shepherd, “Physiotherapy in Paediatrics,” 1995.
- [8] A. Catanese, G. Coleman, J. King ба R. DS, “Evaluation of an early childhood programme based on principles of conductive education,” *J Pediatr Child Health*, pp. 418-422, 1995.
- [9] L. SHELTON, J. E. S ба J. H. B, “Family- centered Care for Children with Special Health Care Needs,” *Association for the Care of Children’s Health*, 1987.
- [10] A. ,. G. ,. R. ,. D. ,. R. ,. & D. ,. L. Miller, “Stress, appraisal, and coping in mothers of disabled and nondisabled children,” *Journal of Pediatric Psychology*, 1992.
- [11] J. Milner, C. Bungay, D. Jellinek ба D. M. Hall, “Needs of disabled children and their families.,” pp. 399-404, 1996.
- [12] Б.Сувд ба Ц.Жавзансүрэн, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах эмчилгээ, үйлчилгээний хэрэгцээ,” *“Хөгжлийн бэрхшээл судлал салбар шинжлэх ухааныг хөгжүүлэх нь” Эрдэм шинжилгээний онол, практикийн II хурал*, pp. 65-68, 2013.
- [13] Р.Отгонсайхан ба Х.Циендолгор, “Тархины саатай хүүхдүүдийн хөдөлгөөн засал эмчилгээний үр дүнгийн судалгаа,” *“Хөгжлийн бэрхшээл судлал нь салбар дундын шинжлэх ухаан болох нь” Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл*, 2018.
- [14] М.Эрдэнэ-Оюун, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн нийгэм, сэтгэл зүйн байдлыг судалсан нь,” *“Хөгжлийн бэрхшээл судлал нь салбар дундын шинжлэх ухаан болох нь” Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл*, 2017.

- [15] Б.Энхтуяа, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжилд эцэг эхийн оролцооны байдлыг судалсан нь,” *“Хөгжлийн бэрхшээл судлал салбар шинжлэх ухааныг хөгжүүлэх нь” Эрдэм шинжилгээний онол, практикийн II хурал*, 2013.
- [16] E. Feinberg, M. Silverstein, S. Donahue ба R. Bliss, “The impact of race on participation in part c early intervention services,” *Journal of Developmental and Behavioral Pediatrics*, pp. 32(4)1-2, 2011.
- [17] WHO&WB, “World report on disability,” 2011.
- [18] UNICEF, “Report The State of the World's Children,” 2013.
- [19] WHO, “Developmental difficulties in early childhood prevention, early identification, assessment and intervention in low- and middle-income countries,” 2012.
- [20] Institute of Medicine and National Research Council, “From Neurons to Neighborhoods: The Science of Early Childhood Development.,” 2000.
- [21] UNESCO, “Inclusion of Children with Disabilities: The Early Childhood Imperative,” 2012.
- [22] Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар,” 2018.
- [23] Brussels, “Early childhood intervention analysis of situations in Europe: key aspects and recommendations,” *European Agency for Development in Special Needs Education*, 2005.
- [24] S. Bazyk, “Changes in attitudes and beliefs regarding parent participation and home programs: an update.,” *American Journal of Occupational Therapy*, pp. 723-8, 1989.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ

Г.Золзаяа¹, Б.Өсөхбаяр²

¹ХААИС, Эдийн засаг бизнесийн сургууль

²ХААИС, Инженер, технологийн сургууль

Хураангуй

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөгжлийн бэрхшээлийн төрлөөр болон насаар нь авч үзэхэд бага, залуу насныхны дунд төрөлхийн хөгжлийн бэрхшээлийн тохиолдол өндөр, харин нас ахихын хирээр олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эзлэх хувь нэмэгдэх хандлагатай байна.

Уг судалгаанаас харахад хараа, сэтгэц, хөдөлгөөний бэрхшээлтэй иргэдийн тоо 2003-2019 онд аймаг бүрт өсөлттэй байсан ба цаашид ч өсөх хандлагатай байна. Сонсгол, хавсарсан, бусад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо аймаг болгонд харилцан адилгүй байна. Сонсголын хөгжлийн бэрхшээл Баян-Өлгий, Ховд, Баянхонгор аймгуудад бууралттай байхад, Говьсүмбэр, Өмнөговь аймгуудад өсөлттэй байна. Сонсголын хөгжлийн бэрхшээл Баянхонгор аймагт олон жилийн дунджаар бууралттай байгаа ч кластер шинжилгээний дүнгээс онцгой анхаарах аймагт орсон нь бодит утгаар тоо буурахгүй байгааг харуулна. Харааны хөгжлийн бэрхшээл дээр онцгой анхаарах 9 аймаг, нийслэл байгаа бол анхаарах шаардлагатай 6 аймаг байгаагаас харахад улсын хэмжээнд харааны бэрхшээл нь тулгамдаж буй асуудал болсон байна.

Түлхүүр үг: Өсөлтийн дундаж хурд, кластер шинжилгээ

Оршил


Дэлхий дээр нэг тэрбум гаруй хүн ямар нэгэн хөгжлийн бэрхшээлтэй амьдарч байгаа бөгөөд бараг 200 сая гаруй хүн үйлдлийн бэрхшээлтэй амьдарч байна. Хөгжлийн бэрхшээлийн тархалт ихсэж байгаа нь олон нийтийн анхаарлын төвд зайлшгүй орох шаардлагатай байна. Энэ нь хүн амын насжилт өндөр болсноор хөгжлийн бэрхшээлтэй болох эрсдэл өсч, мөн чихрийн шижин, зүрх судасны өвчин, хавдар, сэтгэцийн эрүүл мэндийн өвчин гэх мэтийн эрүүл мэндийн архаг нөхцөл байдал дэлхийн хүн амын тулгамдсан асуудал болж байна[1].

Албан ёсны статистик буюу нийгмийн зарим үзүүлэлтийн 2019 оны мэдээллээр монгол улсад хөгжлийн бэрхшээлтэй 107.0 мянган иргэн (нийт хүн амын 3.24 хувь) байгаагийн 61.0 мянга нь эрэгтэйчүүд, 46 мянга нь эмэгтэйчүүд байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 42.8 хувь нь төрөлхийн, 57.2 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй байна. Энэ нь хүн амын дунд олдмол байдлаар хөгжлийн бэрхшээлтэй болох тохиолдол өндөр байгааг харуулж байна[2]

Судалгааны хэрэглэгдэхүүн, арга зүй

Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр нь бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согог нь тухайн иргэнд ямар байдлаар илэрч байгаатай холбоотой байдаг. Уг судалгаанд 2003-2019 оны хараа, сэтгэц, хөдөлгөөн, сонсгол, хавсарсан, бусад гэсэн хөгжлийн бэрхшээлийн зургаан төрлөөр Улаанбаатар хот болон 21 аймгийн тоон мэдээлэл цуглуулж, статистик-эконометрикийн хугацааны цувааны шинжилгээ, олон хэмжээст шинжилгээ хийж, үр дүнг гаргасан.

График 1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн бэрхшээлийн төрөл, аймаг, хувиар



Эх сурвалж: www.1212.mn

Хугацааны цувааны шинжилгээнд аймаг тус бүрийн өсөлтийн дундаж хурдыг тодорхойлж, хувиар илэрхийлсэн болно[3].

$$T_p = \frac{y_i}{y_{i-1}} * 100\% \quad (1)$$

$$\bar{T} = \sqrt[n]{T_{p1} * T_{p2} * \dots * T_{pn}} \quad (2)$$

Кластерийн шинжилгээ нь 2 буюу хэд хэдэн үзүүлэлтийг нэгэн зэрэг харгалзан, бие биенээсээ ялгарах бүлгүүдэд хувааж, алгоритм нь объектуудын хоорондох дундаж зайны нийлбэрээр хэмжигдэх евклид орон зайн олонлогийг байгуулж, бүх хувилбар дотроос тэдгээрийн хамгийн бага утгаар “ойрын хөрш” –ийг тодорхойлох замаар нэгтгэх объектуудыг илрүүлдэг[4].

$$D_{k,j} = \sqrt{(x_{i,j} - x_{k,j})^2} \quad (3)$$

Судалгааны үр дүн

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоонд шинжилгээ хийж, өсөлтийн дундаж хурдыг тооцож үзэхэд дараах дүгнэлт гарч байна.

Хүснэгт 1. 2003-2019 оны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн бэрхшээлийн хандлага, төрөл, аймаг, нийслэлээр, хувиар

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Аймаг, нийслэл	Хөгжлийн бэрхшээлийн төрөл					
	Хараа	Сэтгэц	Хөдөлгөөн	Сонсгол	Хавсарсан	Бусад
Баян-Өлгий	7.3	13.7	2.4	-2.6	-1.3	-1.9
Говь-Алтай	7.8	12.3	6.2	5.2	2.6	5.3
Завхан	3.8	13.6	6.0	-1.2	0.5	1.0
Увс	9.4	13.0	6.4	3.4	0.2	7.8
Ховд	5.0	7.2	4.7	-2.8	10.0	1.0
Архангай	4.6	8.7	5.0	2.7	-1.8	-1.0
Баянхонгор	1.8	9.1	2.2	-4.9	-4.9	3.3
Булган	2.2	8.6	3.6	9.2	-3.5	0.5
Өвөрхангай	5.2	16.2	2.9	-1.6	8.6	-2.2
Хөвсгөл	8.7	11.9	2.9	3.0	2.8	-0.8
Орхон	9.4	14.8	10.7	2.4	11.6	2.0
Говьсүмбэр	11.3	16.9	6.4	11.2	1.5	3.9
Дархан-Уул	8.1	11.0	8.3	6.4	-11.2	10.8
Дорноговь	8.9	12.8	10.1	2.8	10.2	1.6
Дундговь	2.5	17.5	2.6	0.1	-0.6	1.7
Өмнөговь	5.9	9.8	5.8	9.8	-1.8	13.9
Сэлэнгэ	10.2	11.1	6.8	3.3	3.8	7.6
Төв	4.7	14.3	2.6	4.0	-4.6	0.0
Дорнод	1.7	10.5	7.0	-0.5	1.0	-1.5
Сүхбаатар	8.2	12.4	5.4	-3.3	-3.1	5.8
Хэнтий	5.9	12.0	5.8	4.3	0.9	-1.7
Улаанбаатар	6.9	10.6	7.5	0.1	5.5	2.8
Ерөнхий дундаж өсөлтийн хувь	6.3	12.2	5.5	2.3	1.2	2.7

Хөгжлийн бэрхшээлийн хараа, сэтгэц, хөдөлгөөний төрлүүд сүүлийн 17 жилийн хугацаанд байнга өссөн байна. Нийт аймгуудын хувьд авч үзвэл сэтгэцийн хөгжлийн бэрхшээл хамгийн их буюу 12.2 хувийн өсөлттэй байгаа бол харааны хөгжлийн бэрхшээл 6.3 хувийн өсөлттэй байна.

Дархан-Уул аймгийн хавсарсан хөгжлийн бэрхшээл энэ онуудад 11.2 хувь буюу хамгийн их буурсан үзүүлэлттэй байгаа бол Орхон аймагт 11.6 хувийн өсөлттэй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрөөс хүргэх үйлчилгээг хүртээмжтэй болгох, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, эдийн засгийн оролцоо, ядуурлын түвшин, боловсрол, тэгш бус байдал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд статистик-эконометрикийн кластер шинжилгээний үр дүнг ашиглаж болно.

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Хүснэгт 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн кластер шинжилгээний үр дүн

Хөгжлийн бэрхшээлийн төрөл	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрөөс хүргэх үйлчилгээний кластер шинжилгээ		
	Онцгой анхаарах	Анхаарах	Сайжруулах
Хараа	Баян-Өлгий Увс Баянхонгор Говьсүмбэр Дархан-Уул Дорноговь Дундговь Төв Дорнод Улаанбаатар	Ховд Булган Хөвсгөл Сэлэнгэ Сүхбаатар Хэнтий	Говь-Алтай Завхан Архангай Өвөрхангай Орхон Өмнөговь
	Баян-Өлгий Увс Ховд Булган Орхон Төв Улаанбаатар	Говь-Алтай Баянхонгор Хөвсгөл Говьсүмбэр Дархан-Уул Дорноговь Өмнөговь Сэлэнгэ Дорнод Сүхбаатар	Завхан Архангай Өвөрхангай Дундговь Хэнтий
Хөдөлгөөн	Баян-Өлгий Говь-Алтай Увс Орхон Говьсүмбэр Дорноговь Хэнтий Улаанбаатар	Ховд Баянхонгор Булган Өвөрхангай Дархан-Уул Сэлэнгэ Дорнод Сүхбаатар	Завхан Архангай Хөвсгөл Дундговь Өмнөговь Төв
	Баянхонгор Сүхбаатар Улаанбаатар	Говь-Алтай Увс Архангай Булган Хөвсгөл Орхон Говьсүмбэр Дархан-Уул Дорноговь Өмнөговь Сэлэнгэ Төв Дорнод	Дундговь Ховд Баян-Өлгий Завхан

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

		Хэнтий	
Хавсарсан	Баян-Өлгий Өвөрхангай Орхон Говьсүмбэр Дорноговь Улаанбаатар	Говь-Алтай Ховд Хөвсгөл Дундговь Сүхбаатар	Завхан Увс Архангай Баянхонгор Булган Дархан-Уул Өмнөговь Сэлэнгэ Төв Дорнод Хэнтий
	Бусад	Завхан Баянхонгор Орхон Дорнод Сүхбаатар Улаанбаатар	Говь-Алтай Увс Ховд Говьсүмбэр Дархан-Уул Дорноговь Дундговь Өмнөговь Сэлэнгэ

Харааны хөгжлийн бэрхшээл дээр онцгой анхаарах 9 аймаг, нийслэл байгаа бол анхаарах 6 аймаг байна. Харааны хөгжлийн бэрхшээлд ихэвчлэн хөдөө орон нутагт амьдардаг, бага орлоготой хүмүүс, өндөр настнуудад харааны бэрхшээл түгээмэл тохиолддог байна.

Сонсголын хөгжлийн бэрхшээл сүүлийн 17 жилийн хугацаанд 2.3 хувийн өсөлттэй, кластер шинжилгээгээр манай улсын 16 аймаг, нийслэлд онцгой анхаарах, анхаарах шаардлагатай байгаа нь харагдаж байна. Энэ нь 15-35 насны залуучуудын 50 орчим хувь нь сонсголын бэрхшээлтэй болох эрсдэлтэй байгааг харуулна. Үүнд: чихэвч, гар утас, баар, цэнгээний газар, спортын үйл ажиллагааны дуу шуугиан нөлөөлж байна.

Дүгнэлт

Монгол улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо цаашид жил бүр 5.03 хувиар өсөх хандлагатай байна. Энэ нь хөгжлийн бэрхшээлийн төрөл тус бүр дээр харилцан адилгүй өсөлттэй байна.

Судалгааны дүнгээс харахад сүүлийн 17 жилийн хугацаанд хөдөлгөөний хөгжлийн бэрхшээл 5.5 хувийн өсөлттэй, кластер шинжилгээний дүнгээс хөдөлгөөний бэрхшээл Улаанбаатар хот, бусад 8 аймагт илүү онцгой анхаарах шаардлагатай байгааг харж болно.

Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлийн кластер шинжилгээний үр дүнд онцгой анхаарах хэсэгт баруун аймгууд дийлэнх нь байгаа нь цус ойртолт, тархины гэмтэл, өвчлөл, орчны нөлөө зэрэг хүчин зүйлүүдээс шалтгаалсан байна.

Ашигласан хэвлэл

1. THE WORLD BANK, “Хөгжлийн бэрхшээлийн талаарх дэлхийн тайлан”
2. Монгол улсын засгийн газар, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”, 2017 он
3. Г.Золзаяа, “Тоон шинжилгээний арга зүй”, 2020 он
4. Л.Нямбат, “Эдийн засгийн хэмжил зүй”, 2014 он
5. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа”, 2017 он
6. THE WORLD BANK, “World report on disability”
7. www.1212.mn
8. www.nso.mn
9. www.niigmiintoli.mn

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН СЭТГЭЛЗҮЙН ХАНДЛАГЫН ӨӨРЧЛӨЛТИЙН СУДАЛГАА

Гомбосүрэнгийн Болормаа¹

¹ Докторант, Монгол Харааны бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын холбоо

Хураангуй

Хөгжлийн бэрхшээлийн төрөл, хязгаарлалт, гэр бүл, нийгэм зэрэг орчны хүчин зүйл, хувь хүний зан чанар, өөрийгөө тодорхойлох чадвар зэргээс хамаарч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өөрийгөө үзэх үзэл, өөрийн үнэлэмж, биеэ авч явах чадвар янз бүр байдаг. Хөгжлийн бэрхшээлийн төрөл, онцлогийг мэдсэнээр үйлчлүүлэгчийн асуудлыг ойлгоход тустай болох бөгөөд “хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдгийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хэлнэ гэсэн бол Монгол улсын хууль тогтоомжид *хөгжлийн бэрхшээлтэй хүн* гэдэг нь: “Бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан” хүнийг хэлнэ гэж тодорхойлсон байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэм сэтгэлзүйн хандлагыг EDR буюу эрх мэдэлжүүлэх судалгааны аргыг ашиглан судлах үр дүнтэй хэмээн үзэж байна.

Түлхүүр үг. Иргэн, хөгжлийн бэрхшээл, мэдрэмж, итгэл

Оршил

Манай улсад 2018 оны байдлаар нийт 105,730 хөгжлийн бэрхшээлтэй иргэн (нийт хүн амын 4.5%) байгаа бөгөөд үүнийг насны бүлгээр авч үзвэл 82 орчим хувь нь 20-64 насны иргэд байна. Үндэсний статистикийн хорооны 2017 оны мэдээгээр хөгжлийн бэрхшээлтэй хөдөлмөрийн насны 19,974 хүн хөдөлмөр эрхэлж байна. Харин хөдөлмөр эрхэлж буй тэтгэврийн насны хүн 3,018 байгаа бол хөдөлмөр эрхэлдэггүй хөгжлийн бэрхшээлтэй хүн 73,285 байна. Дээрх судалгаанаас харахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт хангалтгүй байхад нөлөөлж буй хүчин зүйлийг олж илрүүлэх хэрэгцээ шаардлага гарч байна. Хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж буй зүйл нь нэг талаас хууль эрх зүйн орчин, нөгөө талаас хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний мэдлэг, боловсрол, хичээл зүтгэл, хүчин чармайлт,

нийгмийн харилцаанд оролцох нийгэм, сэтгэлзүйн хандлага зэргээс шалтгаалдаг. Монгол Улсын үндсэн хуулиар баталгаажсан хөдөлмөрлөх, боловсрол эзэмших, эрүүл аюулгүй орчинд амьдрах зэрэг хамгийн энгийн эрхээс эхлээд үр хүүхэд төрүүлэх, өсгөн хүмүүжүүлэх үүргээ ч хөгжлийн бэрхшээлтэй иргэд эдэлж, үүргээ биелүүлэх боломж байхгүй байна. Хэдийгээр НҮБ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц (2008), хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (2016), нийгмийн халамжийн тухай хууль, нийгмийн даатгалын тухай хууль, эрүүл мэндийн тухай хууль, эоловсролын тухай хууль, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, хөдөлмөрийн тухай хууль, гэр бүлийн тухай хууль, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зэрэг бусад хууль тогтоомж, тэдгээртэй холбогдон гарсан бүхий л дүрэм журам хангалттай ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсд хандах нийгмийн хандлага сайн бус, тэднийг ойлгох ойлголт мэдлэг, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өөрсдийнх нь нийгэм сэтгэлзүйн хандлага ч төдийлөн тааламжгүй байнаа нь судлах ёстой зайлшгүй сэдэв хэмээн үзэж байна.

Судалгааны зорилго, зорилт, шинэлэг байдал, ач холбогдол

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэмд ажиллаж, амьдрах орчныг бүрдүүлэх, ялангуяа сэтгэл зүйн нөлөөллийг судлах хэрэгцээ шаардлага нь хүн төрөлхтний түүхэн хөгжлийн турш анхаарал хандуулах асуудлын нэг байсаар ирсэн. Харин Монгол Улсад хөгжлийн бэрхшээл судлал нь нэлээд хожуу буюу 21 дүгээр зууны эхээр эхэлсэн. Иймд энэхүү судалгааны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэм сэтгэлзүйн хандлагын өөрчлөлтөд EDR буюу эрх мэдэлжүүлэх судалгааны-үр дүн нөлөөллийг судлах зорилго тавьсан.

Судалгааны зорилгодоо хүрэхийн тулд дараах зорилтыг дэвшүүлсэн. Үүнд:

- Судалгааны сэдэвтэй холбоотой онолын материалд анализ хийх;
- Эрх мэдэлжүүлэх судалгааны аргазүйг судлах;
- Эрх мэдэлжүүлэх судалгааны аргыг турших;

- Туршилтын үр дүнг боловсруулж, Хөгжлийн бэрхшээлтэй иргэд (цаашид ХБИ гэх)-ийн нийгэм сэтгэл зүйн хандлагын өөрчлөлтөд нөлөөлөх боломжийг илрүүлэх.

Судалгааны түүвэр: Хөгжлийн бэрхшээлтэй иргэд

Судалгааны объект:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэм-сэтгэлзүйн хандлага ойлголт.
- Уг судалгааг Улаанбаатар хотод амьдардаг 18-35 насны тулгуур эрхтний бэрхшээлтэй, харааны бэрхшээлтэй, сонсголын бэрхшээлтэй, хүнд хэлбэрийн саажилттай 34 иргэн болон тэдгээрийн асран хамгаалагчийг хамруулан явуулсан болно.

Судлах зүйл: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэм сэтгэлзүйн хандлага ойлголтын өөрчлөлт:

- Дэд бүтцэд хандах хандлага
- Хөдөлмөр эрхлэлтэнд хандах хандлага
- Нийгэмд хандах хандлага
- Асуудалд хандах хандлага
- Бие даан амьдрахад хандах хандлага

Судалгааны арга:

- Баримт бичиг судлалын арга
- Кейс анализийн арга
- Статистик боловсруулалтын арга

Шинэлэг тал: Энэхүү судалгааны ажлын шинэлэг тал бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэм сэтгэлзүйн хандлага ойлголтыг өөрчлөхөд олон улсын практикт хэрэглэгддэг EDR аргын үр дүн, ач холбогдлыг тодорхойлоход оршино.

Практик ач холбогдол:

Уг судалгааны ажлын практик ач холбогдол нь EDR буюу эрх мэдэлжүүлэх судалгааны аргазүйн агуулга, зарчмыг дэвшүүлж, тодорхойлоход оршино.

Үндсэн хэсэг (Онол, арга зүйн үндэслэл, судалгааны үр дүн)

Хөгжлийн бэрхшээлийг дөрвөн үндсэн ангилалд хувааж үздэг. Үүнд:

- Мэдрэх эрхтний бэрхшээл (харах, сонсох). Энэ нь хамгийн түгээмэл тохиолдох хөгжлийн бэрхшээлийн төрөл юм.
- Бие, тулгуур эрхтний бэрхшээл (архаг өвчин, хөдөлгөөний хомсдол, нуруу нугасны гэмтэл)
- Оюуны үйл ажиллагааны бэрхшээл (юмыг ойлгох, тусгах чадвар алдагдсан, оюуны хомсдол, тархины гэмтэл, аутизм, суралцах чадварын алдагдал)
- Нүдэнд харагдахгүй, бусад бэрхшээлүүд (хөгжлийн бэрхшээлтэй нь шууд ил харагдахгүй байх, уншиж чадахгүй байх, сэтгэл хөдлөлөө илэрхийлж чадахгүй байх г.м)

Хөгжлийн бэрхшээлийн гэмтэл согогийн хэлбэрээр нь:

- Хөдөлгөөний болон биеийн хүчин чадлын:
- Мэдрэх эрхтэний (харах, сонсох үйл ажиллагааны):
- Харилцааны (хэл ярианы хөгжлийн хоцрогдол согог):
- Бодох, сэтгэцийн үйл ажиллагааны(оюуны хомсдол):

Хөгжлийн бэрхшээлийн талаарх олон улсын ангилал:

1. **Импэйрмент:** Хүний биеийн анатомын бүтэц, физиологи сэтгэл зүйн үйл ажиллагаа алдагдаж, үйлдлийн бэрхшээлтэй болохыг хэлнэ.
2. **Дисэйбилити:** Үйл ажиллагааны бэрхшээлтэй
3. **Хандикап:** Нийгмийн амьдралд оролцох боломжоор хязгаарлагдсан байх буюу оролцооны бэрхшээлтэй хэмээн ангилсан байдаг.

Онолын үзэл баримтлалын хүрээнд: *Маслоугийн хэрэгцээний шатлал*

Америкийн эрдэмтэн судлаач Абрахам Маслоу 1940-өөд оны үед хэрэгцээний шатлалын онолоо боловсруулан гаргасан. Хүнд маш олон талын хэрэгцээ байдаг ба эдгээр нь чанд эрэмбэлэгдэн, шаталсан байдаг гэж А.Маслоу үзсэн.

К.Роджерс-Хүмүүнлэг хандлага. Сонголт хийх эрх чөлөө нь өөрийнхөө төлөө хийж болох хамгийн том боломж юм. Монгол улсын үндсэн хуулинд заасанчлан сонгох, сонгогдох эрх нь хүн бүрт адил тэгш заяагдсан ч хүмүүс өөрсдийн эрхээ мэдэхгүй, бусдын санаатай болон санаандгүй үйлдлээр эрхээ бүрэн дүүрэн эдэлж чадахгүйд хүрдэг. Сэтгэлзүйч George Armitage Miller-ийнхээр сонголтын тоонд хязгаар гэж бий бөгөөд эрх чөлөөгөө эдлэхэд хамгийн тохиромжтой хэм хэмжээ байдаг энэ нь 7 ± 2 юм. Хүний сонголтын тоо олон болохын хирээр сонголтын боломжуудтай бүрэн танилцаж өөрт хэрэгцээтэй зөв шийдвэр гаргахад хүндрэлтэй байдаг бол хүн чөлөөт сонголт хийх боломжоор хангагдаагүй тохиолдолд хүний хөгжил хязгаарлагддаг. Үүнийг Роджерсийн Хүмүүнлэг хандлагаас харвал зөвхөн хувь хүний *чөлөөт сонголтын* үндсэн дээр л бие хүний хөгжлийн хөдөлгөгч хүч, хувийн дахин давтагдашгүй шинж төлөвшдөг

Хаяг наах онол. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол эрхлэлтийг дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургууль, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн кабинет гэх мэтээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эрүүл хүмүүсээс тусгаарлаж буй тусгай орчин, тусгай үйлчилгээ нь нэг талаасаа таатай орчин, боломжоор хангаж байгаа мэт боловч нийгмээс гажуудагч тусгаар хүн мэтээр ойлголт сэтгэгдэл төрүүлж, эрүүл хүн болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ойр байдлыг холдуулж, нийгмийн зүгээс сөрөг хандлага, буруу ойлголт бий болох нөхцөл болж байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрсдийн асуудлаа бодитоор нь үнэлж, нүүр тулахыг хичээж байдаг ч эргэн тойрны хүмүүсийн санаатай болон санаандгүй байдлаар зүүсэн “хаяг”-аас үүдэн өөрийгөө орхих /өөртөө санаа тавихгүй, амьдралын төлөөх тэмцлээ алдах/, өөртөө гутрах зэрэг мэдрэмжүүд бий болж байдаг. Филипс, хүн сэтгэл судлаачаас тусламж авахаар хандах үед ямар байдалд ордогийг судалсан. Хүн бүрээс өөрт нь ямар тусламж хэрэгтэй байгаа талаар мэдээлэл авсан бөгөөд хүн өвчлөлийн шинж болон түвшинээс хамааралгүй

сэтгэцийн тусламж хэрэггүй хүмүүстэй ч харьцдаг. Сэтгэл мэдрэлийн эмнэлэгт эмчлүүлж буй эрүүл хүн, эмнэлгийн тусламж авахыг ч эрмэлзэхгүй байгаа сэтгэл мэдрэлийн өвчтэй хүнээс илүү сөрөг ойлгоцтой болохыг тогтоосон.

Үүнээс үзэхэд хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн байдал, сэтгэцийн эрүүл мэндийн байдлаас үл харгалзан аливаа хаяг наалгасан хүний орчноо үзэх үзэл, бусадтай харьцах харилцаа сөрөг болдог байна. Мөн эрүүл хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй хэрхэн харьцах талаар ойлголтуугийгээс үүдэн өрөвдөж туслах, тусгай хүн мэтээр харьцах, эсвэл юу ч хийж чадахгүй гэж дутуу үнэлэх хандлагаас шалтгаалж хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хаяг нааж, бодит байдалд үнэлэлт өгөх чадвар, өөртөө итгэх итгэлд нь сөргөөр нөлөөлж байна.

Алфред Адлер-Бие хүний бодгалийн онол. Хүн бүрт байгалиас заяагдсан дутуу дулимаг байдлаа нөхөх гэсэн эрмэлзэл байдаг. Үүнийгээ нөхөх эрмэлзэл нь хүнийг аль нэг талаа сайжруулан хөгжүүлэхэд нөлөөлдөг. Гэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бусдаас дутуу гэсэн мэдрэмж илүү байдаг бөгөөд хүн бүр өөрийн дутуу дулимаг байдлын мэдрэмжээ даван туулахад эрмэлздэг. Гэвч дутуу дулимаг байдлын мэдрэмж нь гадны нөлөөллүүдээс үүдэн ихэсч болно. Ингэснээр дутуу дулимаг байдлаа бодит байдлаас хол зөрүүтэй хэтрүүлэн үнэлэх нөхцөл үүсдэг. Жишээлбэл: тэргэнцэртэй иргэний асуудлаар харьцахдаа тухайн ХБИ-тэй биш түрж яваа хүнтэй нь харьцдаг. Энэ байдал нь бусад хүн өөрийг нь үл ойшоож, дутуу үнэлсэн юм шиг мэдрэмж төрч, хүмүүсийн ийм хандлагаас үүдэн дутуу байдлаа улам мэдэрч, гутрах өөрийгөө хэн ч биш мэтээр бодох нь бий. Альфред Адлер нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг сэтгэлзүйн онолын үүднээс тайлбарласан. Тэрээр “Бие эрхтний дутуу дулимагийн судалгаа ба түүнийг сэтгэцийн хувьд нөхөн гүйцээх нь” бүтээлдээ хүнийг нэг өвчин эмгэг бусад өвчнөөс илүү зовоож, мөн биеийн нэг хэсэг илүү өртөмтгий байдгийг тайлбарласан. Бие эрхтний дутуу дулимаг хөгжилтэй хүмүүс дутуу дулимаг байдлаа мэдэрсэн эхний үедээ эмгэгтээ санаа зовж, шаналж байснаа түүнийхээ эсрэг тэмцсэнээр ялан дийлж гарсан байдаг гэж үзжээ. Хүн өөрийнхөө сул талыг байнга нөхөхийг ямагт эрмэлзсэнээр улам сайн хөгждөг болохыг Адлер 3 ангилсан. Үүнд:

1. Би бусдаас дутуу
2. Би бусдаас илүү
3. Би бусадтай адил

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандаж буй нийгмийн хандлагын загвар

Хүн төрөлхтний түүхийн явцад хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай ойлголт янз бүр байсан. Дундад зууны үед хөгжлийн бэрхшээлтэй байгаа нь шашин шүтлэгтэйгээр холбоотойгоор илэрхийлэгдэж байсан ба тухайлбал муу ёрын сүнс, ямар нэг хараалаас болсон, байгалийн гай гамшигт өртсөн гэх мэтээр тайлбарлагдаж байсан 17-р зуунаас эхлэн хөгжлийн бэрхшээлтэй байгааг эмнэлгийн загвар буюу өвчтөн гэдгээр авч үзэж тэднийг зөвхөн эмчлэх хэрэгцээтэй гэж тодорхойлж байсан. 20-р зуунаас хөгжлийн бэрхшээлтэй хүнийг халамж хүртэгч, халамжлуулагчийн загвараар тодорхойлж байлаа. 21-р зууны дунд хагасаас дэлхийн олон улс оронд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдийнхөө төлөө олон янзын хөдөлгөөн өрнүүлсэний үр дүнд НҮБ-ийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцийг баталж, уг конвенцид олон улс орнууд нэгдэн орсноор хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхэд тулгуурсласан хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загварыг албан ёсоор баталгуулсан.

Нөгөөтэйгүүр орчин үеийн олон улсын түвшинд “Хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар” гэсэн шинэ үзэл баримтлал гарч ирээд байна. Хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар бол хөгжлийн бэрхшээл нь хувь хүндээ биш нийгэмд байна гэсэн үзэл юм. Жишээлбэл, тэргэнцэртэй иргэн налуу зам, лифт байхгүй бол тухайн барилга байгууламжид орж чадахгүй. Тиймээс нийгэм хариуцлагаа хүлээх ёстой гэж үздэг. Энэ үзэл нь НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцид тусгагдсан байдаг. Тэгвэл анагаах ухааны загвар, нийгмийн загвар хоёр юугаараа ялгаатай вэ? Хамгийн гол асуудал нь хаанаа байна вэ гэдэг нь харах өнцгөөрөө ялгаатай. Анагаахын загвараар бол өдөр тутмын амьдралд хүндрэл гарч, нийгмийн оролцоо хангагдахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүнээс өөрөөс нь

шалтгаалж байна гэж үздэг. Өөрөөр хэлбэл, “Та хөгжлийн бэрхшээлтэй болохоор боловсрол эзэмшиж, ажилд орж чадахгүй” гэсэн үзэл бодол. Харин нийгмийн загварын үзэл баримтлалаар бол “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хүлээн авах боломжгүй нийгмийн орчны байдлаас болоод тэд боловсрол эзэмшиж, ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байна” гэж үздэг. Тийм болохоор хөгжлийн бэрхшээлтэй хүнд ямар ч асуудал байхгүй. “Нийгэм л өөрчлөгдөх ёстой” гэсэн үг. Нийгмийн орчин өөрчлөгдсөнөөр хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн оролцоо хангагдана. Өнөөгийн олон улсын түвшинд хөгжлийн бэрхшээлийн тухай нийгмийн дээрх үзэл баримтлал бий болоод байгаа бол сэтгэлзүйн талаас Экологийн хандлагаар тодорхойлогдож байна.

Экологийн хандлагаар авч үзвэл хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тулгамдсан асуудал нь тухайн хүний хэрэгцээ болон орчны хангамж, нөхцөл хоёрын хооронд үл зохицолдлогоо гарснаас болсон гэж үздэг. Хүн ба түүний хүрээлэн буй орчны харилцан зохицолдоогүй байдлаас тухайн хүнд стресс хямрал бий болсноос асуудал гарчээ гэж үздэг байна. Жишээ нь гэнэт осолд орж хөгжлийн бэрхшээлтэй болсноор хувь хүнд хямрал үүссэн байж болно. Нийгмийн халамж хүртэж чадаагүй, нийгмээс тусгаарлагдмал, ганцаардмал байх нь стресс үүсгэж болно. Эсвэл тухайн хүний бэрхшээлийг давах чадвар муу байснаас хямрал гарсан байж болно. Үүний дагуу бол хувь хүн ба орчинд нөөц бололцоо, хүлээлт хооронд зай үүсэхэд энэ нь бухимдал болж асуудал үүсдэг.

Гермэйн, Гиттерман ийм хямрал үүсэх тохиолдлыг авч үзсэн байна. Үүнд:

1. Амьдралын хямрал, өөрчлөлтийн үеүд
2. Орчны дарамтаас буюу зохих хариу үйлдэл үзүүлэхгүй мэдрэг бус орчинтой үед
3. Хувь хүний орчиндоо дасан зохицох чадвар нь бага тохиолдолд асуудал үүсдэг гэжээ. Тухайлбал төрөлхийн буюу эрт хөгжлийн бэрхшээлтэй болсон хүмүүс нь хожим хөгжлийн бэрхшээлтэй болсон хүмүүстэй харьцуулахад

орчиндоо дасан зохицох, хандлага нь илүү байдаг боловч өвчин хүндрэх, дордох тохиолдолд мөн хүнд байдал үүсдэг. Экологийн онолоор хүн аливаа өөрчлөлтийн үед орчиндоо дасан зохицох чадвар, хандлага маш чухал бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ба орчны харилцан нөлөөллийг сайжруулснаар хүний хямралд өртөх тохиолдол бага байж болохоор байна.

Орчин нь амьдрах орчин байр суурь гэсэн хоёр бүрэлдэхүүнтэй бөгөөд эхнийх нь илүү орон байрны нөхцөлтэй холбоотой бол дараагийнх нь хүний өөрт байгаа онцлог, онцгой чадвар чадамжаараа бий болгосон байр суурь буюу “үр дүнтэй” байр суурь, бас үндэс угсаа, хүйс хөгжлийн бэрхшээл болон бэлгийн чиг хандлагаасаа болон ялгаварлан гадуурхагдсаны улмаас бий болсон сөрөг байр суурь гэсэн хоёр төрөлтэй байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сэтгэлзүйн хандлагын өөрчлөлтийн судлах EDR-судалгааны арга зүйн нэг болох Италийн АИФО байгууллагын хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эрх мэдэлжүүлэх замаар тэдний нийгмийн тэгш оролцоог хангах, тэдний нийгэм сэтгэлзүйн хандлага ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор энэхүү судалгааны аргыг боловсруулсан байна. EDR буюу эрх мэдэлжүүлэх судалгаа гэдэг нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрсдөдөө тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд оролцох оролцоог бий болгох замаар өөрсдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлсэний үр дүнд тэдгээр харилцаа хандлагыг өөрчлөхийг хэлнэ.

Эрх мэдэлжүүлэлийн судалгаа: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүсэл тэмүүлэл, эмзэг байдал, тэдэнд тулгарч буй бэрхшээлүүдийг тогтоох зорилготой. Уг судалгаа нь төрөл бүрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тэдгээрийн төлөөлөл урьдчилан тодорхойлсон сэдвээр холбогдох мэдээллийг цуглуулж, уулзалтаар харилцан мэдээлэл солилцон, тэдгээр тулгарч буй хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх талаар хамтдаа ярилцах юм.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэм сэтгэлзүйн хандлага ойлголтыг эерэгээр


“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

өөрчлөхөд EDR аргаар судалгаа хийхдээ харааны, сонсголын, хөдөлгөөний зэрэг янз бүрийн хөгжлийн бэрхшээлтэй 34 залуус оролцохоор гарын үсэг зурсан ба нэг нь Эрдэнэт хотод амьдардаг бусад нь Улаанбаатар хотод амьдардаг. Судалгаанд оролцогчидтой эрх мэдэлжүүлэх судалгааны аргаар тулгамдаж буй асуудлын талаар мэдээлэл солилцон үр дүнд тэдний нийгэм сэтгэл зүйн хандлага өөрчлөгдөж буй эсэхийг тогтоох зорилгоор ярилцлага явууллаа.

Судалгааны үр дүнгээс харахад, судалгаанд оролцогчдын 90 гаруй хувийнх нь хандлага өөрчлөгдсөн байгаа нь эерэг байдал юм.

Үүнийг хандлагаар нь авч үзвэл, нийгэмд хандах хандлагын өөрчлөлт нь дундажаас дээш түвшинд бусад төрлийн хандлага болох дэд бүтцэд, хөдөлмөр эрхлэлтэд, асуудалд хандах, бие даан амьдрах хандлагуудын өөрчлөлт маш сайн байлаа.

Зураг 7. Хандлагын өөрчлөлт (хувиар)



Судалгаанд оролцогчдын өөрт тулгараад буй асуудал бэрхшээлд хандах хандлага, хөдөлмөр эрхлэлтийн байдалд хандаж буй хандлага нь хамгийн их өөрчлөгдсөн. Энэ нь хувь хүнд үүсээд байгаа асуудлаа шийдвэрлэх гарцыг олж харах, амьдралд хандах, нөхцөл байдлаа дээшлүүлэх боломжийг эрэлхийлэх хувийн чадварыг дээшлүүлж буй том алхам юм.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлага, амьдрах нөхцөлд тохирсон дэд бүтцэд хандаж буй хувь хүний хандлага сайжирч байгаа нь хувь хүний нийгэмд дасан зохицох чадварыг нэмэгдүүлэх боломж гэж харж байна.

Мөн бие даан амьдрах хандлагын өөрчлөлт нь бусдаас хамааралгүй байх, өөртөө итгэлтэй амьдрах, сэтгэл гутрал, стрессээ даван туулах, түүнээс урьдчилан сэргийлэх хувь хүний дотоод бүтцийг бүрдүүлэх чухал алхам гэж үзэж байна.

Оролцогчдын хувьд дундажаас дээш түвшинд өөрчлөгдсөн буюу бусад хандлагуудтай харьцуулахад харьцангуй өөрчлөхөд түвэгтэй бүтэц нь нийгэмд хандах хандлага байлаа. Иймд ХБИ-д хамгийн ихээр тулгарч буй, цаашилбал нийгмийн хүрээнд авч үзэх чухал асуудал бол нийгмийн хандлагын тухай асуудал байна.

Энэ талаар дэлхий нийтээр анхаарлаа хандуулж байгаачлан манай орон ч анхаарч тодорхой алхмуудыг хийж байгаа ч бодит амьдрал дээр дорвитой өөрчлөлт болохгүй байгааг харууллаа.

Олон нийтийн хандлага, ялгаварлан гадуурхсан мэт мэдрэмж нь зөвхөн хүмүүс хоорондын харьцаа хандлагаар хязгаарлагдахгүй, эрүүл мэнд, нийгмийн халамж үйлчилгээ, эдийн засгийн дэмжлэг, боломж бололцоо, олон нийтийн үйлчилгээний хүртээмж гэх мэт өргөн хүрээнд яригдаж цаашилбал гэр бүлийн харьцаа хандлагыг ч агуулсан асуудал болох юм. Энэ нь хүний эрхийг зөрчиж байгаа нийтлэг алдаа болохыг бодлого, боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэгч байгууллага, хувь хүний түвшинд онцгойлон анхаарах, түүнд чиглэсэн үйл ажиллагааг явуулах шаардлагатай байна.

Дүгнэлт

Дэлхий нийтийн практикт өргөнөөр хэрэглэгдэж байгаа EDR буюу эрх мэдэлжүүлэх судалгааны аргын ХБИ-ийн хандлагыг өөрчлөх боломжийг судлан тодорхойлж зорилгоор 30 гаруй ХБИ-ийг ганцаарчлан судлах аргаар судалгаа явуулсан.

Тухайн аргыг ХБИ-тэй ажиллах, тэдний хандлагыг өөрчлөн нийгэмшүүлэх, цаашилбал тэдэнд тулгараад байгаа асуудлыг илрүүлэх, шийдвэрлэх арга замыг тодорхойлох, бодлого боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх түвшинд зорилготойгоо уялдуулан ашиглах боломжтой нь судалгааны үр дүнгээс харагдлаа. EDR аргыг сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, төрийн ба төрийн бус байгууллагын ажилтан гэх мэт ХБИ-тэй ажилладаг субъектууд практик үйл ажиллагаандаа хэрэглэх бүрэн боломжтой юм.

Хөгжлийн бэрхшээлийн төрөл, онцлогийг мэдсэнээр үйлчлүүлэгчийн асуудлыг ойлгоход тустай болох бөгөөд “хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдгийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хэлнэ гэсэн бол Монгол улсын хууль тогтоомжид *хөгжлийн бэрхшээлтэй хүн* гэдэг нь: “Бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан” хүнийг хэлнэ гэж тодорхойлсон байна.

Гэхдээ энэ аргыг оюун санаа буюу оюуны хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хэрэглэх боломжгүй. Зөвхөн мэдрэхүйн эрхтний болон тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хандлагыг өөрчлөх, тэднийг нийгэм-сэтгэл зүйн зан үйлийг эерэг түвшинд өөрчлөхөд эхний ээлжинд хэрэглэх бүрэн боломжтой бөгөөд хэд хэдэн удаа зорилготойгоор давтан зан үйлийг бэхжүүлэхэд хэрэглэж болно.

НҮБ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцид Монгол Улс 2008 онд нэгдэн орж Монгол Улсын Засгийн газар уг конвенцийн 8 дугаар зүйлд зааснаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх үүргийг хүлээсэн юм. Үүнтэй холбоотойгоор олон төсөл хөтөлбөрүүд хэрэгжсэн бөгөөд хүн амын тухайн зорилтот бүлэгт чиглэсэн үйл ажиллагаа, хандлагын өөрчлөлтүүд хийгдсэн нь тодорхой алхам болж чадаж байна. Өнөөдөр дэлхий нийтээр шийдвэр гаргалт оролцоонд хувь хүний өөрийн оролцоог нэмэгдүүлэхэд хүчин чармайлт тавьж байгаа ч хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрсдөдөө тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд идэвхтэй оролцох нь амьдрах чадавхийг нь нөхцөлдүүлэх, идэвх санаачилгыг бий болгох чухал алхам гэж үзэх боллоо. Үүнд чиглэсэн аргуудын нэг нь EDR судалгааны арга зүй юм.

Тухайн арга нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрт тулгамдаад байгаа асуудал бэрхшээлийг судлаачтай ярилцах замаар тодорхойлж, түүний учир шалтгааныг бие даан ойлгож ухаарч, түүнийг шийдвэрлэх арга замыг хамтран хэлэлцэж, дүгнэлт шийдвэрт хүрэх явдал юм. Ийнхүү асуудал, түүний учир шалтгааныг олж харж, шийдвэрлэх гарцыг тодорхойлох нь хувь хүний нийгэмд болон өөртөө хандах хандлагыг нь өөрчлөхөд илүү ач холбогдолтой юм. Ийд тухайн арга зүйг мэргэжлийн хүмүүс эзэмшин өөрсдийн практикт хэрэглэх нь ач холбогдолтой юм.

Тухайлбал;

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

- Хувь хүн сэтгэл санааны хямрал буюу дутуу дулимагийн хам шинжийг даван туулах сэтгэл зүйн бэлэн байдалтай, урам зоригтой болох
- Нийгмийн орчны дарамтыг сөрөх, нийгэмд дасан зохицох хүч энергийг бий болгох
- Өөртөө итгэх итгэлтэй болох
- Нийгмийн хандлагыг өөрчлөх, түүнд тохирсон хариу үйлдэл үзүүлэх дадал хэвшилтэй болох
- Бие даан амьдрах талаар ойлголт төсөөлөл нь эерэгээр өөрчлөгдөх
- Хүмүүс хоорондын харьцаа хандлагад өөрчлөлт орох
- Цаашилбал, гэр бүлийн хүрээнд тухайн аргыг хэрэглэснээр тэдний сэтгэл санаанд эерэг байдлыг авчирах, ХБИ-тэй харилцах харьцаа хандлагыг нь өөрчлөх
- Цаашилбал, нийгмийн институтийн хандлага, үйлдлийг өөрчлөх эерэг нөлөөтэй тул тухайн аргыг нийгмийн практикт нэвтрүүлэх хэрэгцээ байна гэж үзлээ.

Энэ аргыг хэрэглэж буй мэргэжлийн хүмүүс нь ХБИ-ийн нийгмийн хандлагыг эерэг түвшинд өөрчлөхөд мэдрэмжтэй туршлагатай хандах нь зүйтэй юм.

Ашигласан хэвлэл

- Б.Туяа. 1998. Бие хүний сэтгэл зүй, сэтгэл заслын өрнөдийн онол, гол төлөөлөгчид. УБ хот.
- НҮБ. 2008. "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц."
- Олон улсын хөдөлмөрийн байгууллага. 2011. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажил олгоход туслах гарын авлага. УБ хот.
- УИХ. 2016 он. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай. УБ хот.
- Үндэсний статистикийн хороо. 2018. "Нийгэм бизнесийн статистик ." УБ хот.
- Хөдөлмөр, нийгэм хамгааллын яам, Жайка. n.d. "Мэдээллийн эмхтгэл ." 2019.
- Хөдөлмөр, нийгэм хамгааллын яам, Хүний эрхийн үндэсний комисс. 2014. Инчоны стратеги: Ази, Номхон далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан эрхийг бодит болгоё. УБ хот.

ХАРАА, СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ҮЗҮҮЛЖ БУЙ НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭ БА ОРЧНЫ ХҮРТЭЭМЖИЙГ СУДАЛСАН ҮР ДҮН

Түмэнбаярын Батдулам¹

¹Монголын үндэсний их сургуулийн
анагаах ухааны сургууль

Хураангуй

Дэлхийн даяар 1 тэрбум гаруй хүн буюу нийт хүн амын 15 орчим хувь нь хөгжлийн бэрхшээлтэй амьдарч байна. ДЭМБ-ын тодорхойлсноор хөгжлийн бэрхшээлийг 7 (хөдөлгөөн, хараа, сонсгол хэл яриа, оюун ухаан, уналт, хавсарсан, бусад) ангилж үздэг [WHO, WB, 2011]. 2018 оны Үндэсний Статистикийн Хорооны мэдээгээр Монгол улсад хөгжлийн бэрхшээлтэй 105.730 иргэн байгаа ба энэ нь нийт хүн амын 3.2 %-ийг эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлийн төрлөөр авч үзвэл, хараа 10.9%, хэл яриа 4.1%, сонсгол 8.0%, хөдөлгөөн 20.4%, сэтгэц 19.3%, хавсарсан 6.9%, бусад 30.4%-ийг тус тус эзэлдэг [ҮСХ,2018].

Монгол Улсад 15-59 насны ажиллах хүчний тоонд ХБИ 28%, 6-18 насны хүн амын дунд 43% нь бичиг үсэгт тайлагдаагүй байна. Хараа, сонсгол, оюуны бэрхшээлтэй иргэдийн хувьд эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээг энгийн иргэдийн адил хүртэх эрхтэй ч, барилга байгууламж, нийтийн зам тээврийн хүртээмжгүй байдлын улмаас тэд нийгмийн үйлчилгээнд бүрэн хамрагдаж чаддаггүй. Мөн нийгмийн харилцаанд тэгш оролцох боломж нөхцөлийг бүрдүүлсэн хууль эрх зүйн зохицуулалт ч хангалтгүй байна [АХБ, 2019].

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн үйлчилгээнд хамруулах, хүртээмжтэй орчинг бүрдүүлэх, тэдгээрийн оролцоог нэмэгдүүлэх, тэгш эрхийг хангахтай холбоотой асуудлыг авч шийдвэрлэх томоохон арга хэмжээний нэг нь хамт олонд түшиглэн хөгжүүлэх үйлчилгээ гэдгийг дэлхийн улс орнуудад хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний дэлхийн тайланд дурдсан байна [WHO, WB, 2011].

Манай улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн үйлчилгээнд хамрагдалт болон орчны хүртээмжийн чиглэлээр цогц байдлаар судалсан судалгааны ажил бараг байхгүй байна. 2013 онд хийгдсэн судалгаанд хөдөлгөөний бэрхшээлтэй, тэргэнцэр хэрэглэдэг иргэдэд эмнэлгийн байгууллагын орчны хүртээмжийг үнэлсэн байдаг [Д.Мөнх-Учрал,2013]. Олон улсад хөгжлийн бэрхшээлийн хэлбэр тус бүрээр нарийвчлан судалж, судалгааны үр дүн нь бодлого боловсруулахад түлхүү ашиглагддаг.

Иймд Монгол улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн үйлчилгээ болон орчны хүртээмжийг нарийвчлан судалж, бодлогын баримт бичгүүдийг тэдний

хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх, зөвлөмж боловсруулах, улмаар хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Түлхүүр үг: Барилга, мэдээлэл, үйлчилгээ, хууль эрх зүй

Судалгааны ажлын зорилго

Хараа, сонсголын бэрхшээлтэй иргэдэд үзүүлж буй нийгмийн үйлчилгээ ба орчны хүртээмжийг судлахад оршино.

Судалгааны зорилт

1. Хараа, сонсголын бэрхшээлтэй иргэдэд олон нийтийн барилга, мэдээллийн хэрэгслийн орчны хүртээмжийг судлах
2. Хараа, сонсголын бэрхшээлтэй иргэд эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдалтыг тогтоох

Судалгааны ажлын практик ач холбогдол

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээнд хамрагдалт болон олон нийтийн барилга, мэдээллийн хэрэгслийн орчны хүртээмжийн бодит байдлыг тогтоон үнэлэх, хянах, сайжруулах арга зүйг тодорхой болгосон.
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн үйлчилгээнд бүрэн хамруулж, үйлчилгээний ба орчны хүртээмжийг бүрдүүлэхийн тулд салбар дундын бодлого, хамтын үйл ажиллагаа, уялдаа холбоог хангах, олон улсын эрүүл мэнд ба хөгжлийн бэрхшээл үйл ажиллагааны ангиллыг (ICF-The International Classification of Functioning, Disability and Health) үйл ажиллагаанд нэвтрүүлэх шаардлагатайг судлан тогтоосон.
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой хууль эрх зүйн бодлогын бичиг баримтуудад хараа, сонсголын бэрхшээлтэй иргэдийг нийгмийн үйлчилгээнд хамруулах болон орчны хүртээмжийг сайжруулах талаар шинжлэх ухааны үндэстэй тусгайлсан зүйл заалтуудын үндэслэлийг боловсруулсан.

Судалгааны ажлын шинэлэг тал

1. Хараа, сонсголын бэрхшээлтэй иргэдийн нийгмийн үйлчилгээ ба орчны хүртээмжийг Монгол Улсын нөхцөлд судалж, олон улсын аргачлалын дагуу үнэлсэн анхны суурь судалгаа болсон.
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгамдаж буй асуудлыг анагаах ухаан, нийгмийн эрүүл мэнд, социологи, нийгмийн ухаан, хууль зүйн ухааны хүрээнд нь уялдуулсан салбар дундын судалгаа (interdisciplinary study) болсон.

Хамгаалахаар дэвшүүлж буй асуудлууд

1. Олон нийтийн барилга, мэдээллийн хэрэгслийн орчны хүртээмж нь хараа, сонсголын бэрхшээлтэй иргэдийн онцлог хэрэгцээ шаардлагад төдийлөн нийцэхгүй байна.
2. Хараа, сонсголын бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын нийгмийн үйлчилгээнд хамрагдалт хангалтгүй байна.
3. Үйлчилгээний ба орчны хүртээмжийн талаарх хууль эрх зүйн тусгайлсан зохицуулалт шаардлагатай байна.

Судалгааны ажлын ёс зүйн асуудал


Судалгааны арга аргачлалаа АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хороогоор хэлэлцүүлж ёс зүйн зөвшөөрөл авсны дараа хийж гүйцэтгэсэн. Анагаах ухаан, биологийн судалгааны ёс зүйн хэм хэмжээг баримталж, Эрүүл Мэндийн Сайдын 2018 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 217 тоот тушаал, Олон улсын гэрээ, Хельсинкийн тунхаглал (WMA, 2014), хүнийг хамруулсан био-анагаахын судалгааны удирдамж (CIOMS,2002)–ын удирдамж-13-ийг баримталсан. Эмзэг бүлгийнхнийг хамруулсан судалгааг хийхдээ хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эцэг, эх, асран хамгаалагчдад судалгааны зорилго, ач холбогдол, ашигтай болон эрсдэлтэй тал, нууцыг чандлан хадгалах талаар мэдээлэл өгч, бичгээр зөвшөөрөл авсан.

Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй

Судалгааг шууд ажиглалт, өрхөд суурилсан агшны судалгаа, баримтын судалгааны аргаар хийв.

Түүвэр, судалгааны хамралт ба мэдээлэл цуглуулсан арга:

1. Зураг 1. Орчны хүртээмжийн судалгааны хамарсан хүрээ:



Өрхөд суурилсан агшны судалгаа

Эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдалтыг судлахдаа хараа, сонсголын бэрхшээлтэй 148 иргэнийг хамруулсан. 2015 оны ҮСХ-ны статистик тооллогоор илэрсэн хараа, сонсголын бэрхшээлтэй нийт иргэдийн тоог (N=9,676) суурь үзүүлэлт болгон авч, 95 хувийн магадлал (1.96), алдааны хязгаар (0.08), түүврийн бус алдааг 5 хувиар тооцож, Улаанбаатар хотоос 67 (45.3%) иргэн, хөдөө орон нутгаас 81 (54.7%) иргэн нийт хараа, сонсголын хөгжлийн бэрхшээлтэй 148 иргэнийг судалгаанд хамруулсан. Түүвэрлэлтийн хэмжээг тооцоход доорх томъёог ашиглав.

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

$$n = \frac{N * z^2 * p * (1 - p)}{(N - 1) * e^2 + z^2 * p * (1 - p)}$$

Z - Итгэх хязгаар 1.96 (95%)

P - Үзүүлэлтийн суурь түвшин (0.5)

e²- Алдааны хязгаар 0.08

$$n = \frac{9676 * 3.84 * 0.5 * (1 - 0.5)}{(9676 - 1) * 0.0064 + 3.84 * 0.5 * (1 - 0.5)} = \frac{9288.96}{62.88} = 148$$

Хүснэгт 1. Судалгааны түүвэр хүн ам

Аймаг, дүүрэг	Судалгаанд хамруулахаар тооцсон ХБ хүний тоо	Судалгаанд хамрагдсан ХБ хүний тоо
Өвөрхангай аймаг	40	40
Дорнод аймаг	40	41
Улаанбаатар хот	35*2	67
Нийт	150	148

Байршлын ялгааг гаргахын тулд түүврийг хот, хөдөөгөөр ялгаатай хийсэн ба Улаанбаатар хотын төвийн 2 дүүрэг, Дорнод (хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамгийн их ба Улаанбаатар хотоос алслагдсан) болон Өвөрхангай аймгийг (хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамгийн их ба Улаанбаатар хотод арай ойр) зорилтот түүврийн аргаар сонгосон. Судалгааг явуулахдаа анхан шатны нэгжээс 35-40 өрхийг сонгон авахад төлөөлөх чадвар сайн болох нь 1998 оны судалгаа, ижил төрлийн судалгаа хийсэн бусад орны туршлагаар нотлогдсон юм. Энэ байдлыг үндэслэн энэ удаагийн судалгаанд нэг түүвэр нэгжээс хөдөө орон нутгаас 40, хотоос 35 өрхийг тус тус сонгон 2 аймаг, 2 дүүргээс нийт 150 өрхийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулсан. Судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн, тэдний асран хамгаалагч нараас 10 бүлэг, 105 асуумж бүхий судалгааг авсан. Өрхийн асуумж судалгаа нь хараа, сонсголын бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамрагдаж буй байдал болон тэдний хэрэгцээг тодорхойлох зорилготой. Нийгмийн үйлчилгээнд хамрагдаж буй байдлыг (75%-100%-тай хамрагдвал “сайн”, 50%-74.9%-тай бол “дунд”, 49.9% -иас доош бол муу буюу хангалтгүй) үнэлсэн.

Үр дүнгийн боловсруулалт

Олон нийтийн барилгын орчны хүртээмжийн судалгааны өгөгдлийг Microsoft Office Excel программд кодолж, алдааг шалгасны дараа үр дүнгийн статистик боловсруулалтыг “SPSS 23” программыг ашиглан гүйцэтгэсэн. P утга нь 0.05-аас бага байх тохиолдолд ялгааг статистик үнэн магадлалтай гэж үзсэн. Үйлчилгээний чанарыг ServQual загвараар үнэлэхэд дараах томъёогоор олсон. $(quality) = P(perception) - Ei(expectations)$ (1) Тэгшитгэл (1)-д зааснаар тооцсон үр дүн нь: Хүлээлт нь үйлчилгээний үзүүлэх дээд үзүүлэлт, одоогийн гүйцэтгэл нь үзүүлж буй үйлчилгээ, энэ 2 зөрүү хүртээмжийг илэрхийлнэ.

Хүснэгт 2. Одоогийн гүйцэтгэл, хүлээлт хоорондын зөрүүг :

Үнэлгээ	Маш хангалтгүй	Хангалтгүй	Дунд зэрэг	Хангалттай	Маш хангалттай
α утга (зөрүү)	$5 \geq \alpha$	$2.99 \leq \alpha \leq 3.99$	$1.99 \leq \alpha < 2.99$	$1 \leq \alpha < 1.99$	$0 \leq \alpha < 1$

Мэдээллийн хэрэгслийн хүртээмжийн үнэлгээний үр дүнг хараа, сонсголын бэрхшээлтэй иргэдийн хэрэглэх боломж хэр бүрдсэн байгаа дээр чанарын судалгааг хийсэн. Нийгмийн үйлчилгээнд хамрагдалтыг тооцохдоо судалгааны өгөгдлийг Microsoft Office Excel программд кодолж, алдааг шалгасны дараа үр дүнгийн статистик боловсруулалтыг “SPSS 23” программыг ашиглан гүйцэтгэсэн.

Судалгааны ажлын үр дүн


1. Олон нийтийн барилга, мэдээллийн хэрэгслийн орчны хүртээмжийн судалгааны үр дүн

Олон нийтийн барилгын орчны хүртээмжийн судалгаа

Судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн голлон үйлчлүүлдэг 7 салбарын 100 байгууллагын барилгын орчныг судалж үзсэн. Олон нийтийн барилгын орчны хүртээмжийн судалгааг хийхдээ хөгжлийн бэрхшээлийн онцлогт тохируулан байгууллагын орох, гарах хэсэг, дотоод орчин, ариун цэврийн өрөө, мэдээлэл авах, гадаад орчин гэсэн 5 хэсэг 18 шалгуур үзүүлэлтээр харааны бэрхшээлтэй иргэдэд үнэлсэн. Харааны бэрхшээлийг иргэдийг дотор нь сул хараатай, хүнд гэж 2

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”


ангилдаг. Сонсголын бэрхшээлтэй иргэдийн барилгын орчны хүртээмжийг 5 хэсэг, 12 шалгуур үзүүлэлтээр үнэлсэн. Сонсголын бэрхшээлтэй иргэдийг дотор нь дунд зэргийн сонсгол бууралт 40-59.9 дб, хүнд хэлбэрийн сонсгол бууралт 60-89.9 дб, дүлий бүрэн сонсголгүй 90-120 дб гэж ангилдаг. Хөгжлийн бэрхшээлийн зэргээс хамаарч хүртээмжийн ялгаатай байдлыг судалсан. Харааны бэрхшээлтэй иргэдийн хувьд олон нийтийн барилгын орчны дундаж үнэлгээ 23.7%-тай хүртээмжгүй байна. Олон нийтийн барилгын орчны мэдээлэл үйлчилгээний хүртээмжийн хэсэг бусад үзүүлэлтээс арай өндөр буюу 32.8%-тай дунд зэрэг байгаа бол ариун цэврийн өрөөний хэсэг 15%-тай хамгийн муу, хүртээмжгүй байна. Олон нийтийн барилгын орчны хүртээмжийн үнэлгээний 18 шалгуур үзүүлэлтээс, “өрөө тасалгаанууд сайн гэрэлтүүлэг, хаягтай” гэсэн 1 үзүүлэлт нь маш сайн хүртээмжтэй, “харааны бэрхшээлтэй хүний хөтөч бариул нь хонгил коридорын хананд байгаа”, “үйлчлүүлэхээр ирсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслах, угтах, хөтчийн үйлчилгээтэй” гэсэн 2 үзүүлэлт нь сайн хүртээмжтэй, “шалны гадаргуу нэг түвшинд”, “ариун цэврийн өрөөний хажуугийн хананаас 20 см -ийн зайд толийг байрлуулсан”, “байгууллагын гадна талбайд хөгжлийн бэрхшээлтэй зорчигчид зориулсан авто машины зогсоол төлөвлөсөн” гэсэн 3 үзүүлэлт нь дунд зэргийн хүртээмжтэй, 12 үзүүлэлт нь муу буюу хүртээмжгүй байв.



Зураг 2. Харааны бэрхшээлтэй иргэдэд олон нийтийн барилгын орчны судалгааны дундаж дүн (хувиар)

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Сонсголын бэрхшээлтэй иргэдийн хувьд олон нийтийн барилгын орчны үнэлгээ дунджаар 30.4%-тай дунд зэргийн хүртээмжтэй байна. Дотоод орчны хүртээмжийн хэсэг бусад үзүүлэлтээс арай өндөр буюу 39.3% байгаа бол, мэдээлэл үйлчилгээний хэсэг 20.2%-тай хүртээмжгүй байна.



Зураг 3. Сонсголын бэрхшээлтэй иргэдэд олон нийтийн барилгын орчны судалгааны дундаж дүн (хувиар)

Олон нийтийн барилгын орчны үнэлгээний 12 шалгуур үзүүлэлтээс, “өрөө тасалгаанууд сайн гэрэлтүүлэг, хаягжилттай” гэсэн 1 үзүүлэлт маш сайн хүртээмжтэй, “ариун цэврийн өрөөг ялгасан тусгай тэмдэглэгээтэй”, “байгууллагын зохион байгуулалт үйлчилгээний талаарх мэдээллийг урсдаг бичгэн зараар харуулдаг” гэсэн 2 үзүүлэлт сайн хүртээмжтэй, “танай байгууллагын гадна талбайд хөгжлийн бэрхшээлтэй зорчигчид зориулсан авто машины зогсоол төлөвлөсөн” гэсэн 1 үзүүлэлт дунд зэргийн хүртээмжтэй, 9 үзүүлэлт муу буюу стандарт хангаагүй, хүртээмжгүй байсан.

Олон нийтийн барилгын орчны хүртээмжийг судалсан хүснэгт-3 аас харахад хараа, сонсголын бэрхшээлтэй иргэдэд олон нийтийн барилгын орчин, орон зай дунд зэргийн хүртээмжтэй байна. Нийтийн тээвэр, соёл урлаг, үзвэр үйлчилгээний салбарын байгууллагуудын стандарт үзүүлэлтүүд хамгийн өндөр буюу харааны бэрхшээлтэй иргэдэд 61.0%, сонсголын бэрхшээлтэй иргэдэд 53.0% сайн байна. Боловсролын салбарын байгууллагууд харааны бэрхшээлтэй иргэдэд 31.0% дунд,

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

сонсголын бэрхшээлтэй иргэдэд 12.0% муу, бусад 5 салбарын хувьд олон нийтийн барилгын орчин, орон зай нь (27-45%) дунд зэргийн хүртээмжтэй байна.

Хүснэгт 3. Олон нийтийн барилгын орчны хүртээмжийн судалгааны нэгдсэн дүн, хувиар


Байгууллагын ангилал	Тоо	Харааны бэрхшээлтэй иргэн	P утга	Сонсголын бэрхшээлтэй иргэн	P утга
Төрийн захиргаа	19	45.0	0.0051	36.0	0.0011
Хөдөлмөр, халамж хамгаалал, даатгал	18	38.0	0.0015	27.0	0.0023
Эрүүл мэндийн салбар	19	39.0	0.0300	31.0	0.0600
Боловсролын салбар	11	31.0	0.0067	12.0	0.0090
Нийтийн тээвэр, соёл урлаг, үзвэр үйлчилгээ	10	61.0	0.0028	53.0	0.0041
Нийтийн худалдаа, банк санхүү үйлчилгээ	10	43.0	0.0029	30.0	0.0029
Орон сууцны барилга, амралт рашаан сувилал, шүүх цагдаа	13	42.0	0.0040	33.0	0.0021

Мэдээллийн хэрэгслийн хүртээмжийн судалгаа

Судалгаанд олон улсын цахим хуудасны хандалтын хүртээмжийг сайжруулах заавар” (ISO WCAG 2.0) стандартыг удирдамж болгон 22 шалгуур үзүүлэлттэй үнэлгээний хуудсаар 7 чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 100 байгууллагын цахим хуудсанд үнэлгээ хийсэн. Үнэлгээнд хүртээмжтэй буюу маш сайн үнэлгээтэй салбар байгууллага байхгүй, сайн үнэлгээтэй хүртээмжтэй салбар байгууллага нь номын сангууд, бусад 5 салбарын байгууллагуудын дундаж үнэлгээ (29-41%)–тэй дунд, аймаг, орон нутгийн Засаг даргын тамгын газруудын хүртээмжийн үнэлгээ 15%-тай

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

муу, хүртээмжгүй гэж тус тус үнэлэгдсэн. Харааны бэрхшээлтэй иргэдэд мэдээллийг хүлээн авах цахим хуудасны хүртээмжийн дундаж үнэлгээ 34.8%-тай буюу дунд зэргийн хүртээмжтэй гэж үнэлэгдсэн.



Зураг 4. Байгууллагуудын цахим хуудасны хүртээмжийн үнэлгээ

Олон нийтийн 31 телевизийн хувьд эфирийн цагийнхаа турш дохионы хэлээр тайлбар хүргэж буй телевиз байхгүй бөгөөд хоёр телевиз буюу MNB, TV9 телевизүүд зөвхөн үндсэн мэдээллийн хөтөлбөрөө дохионы хэлээр танилцуулж байна. Сонголын бэрхшээлтэй иргэдэд олон нийтийн телевизийн нэвтрүүлгээр дамжуулан мэдээлэл хүлээн авахад хүртээмжгүй байна. Энэ нь тухайн телевизийн 1 өдрийн эфирийн цагийн 5% бөгөөд сонголын бэрхшээлтэй иргэд телевизийн мэдээлэл хүлээн авах боломж хязгаарлагдмал байгааг харуулж байна. Харааны бэрхшээлтэй иргэдэд Юнивишн, Скаймедиа интернет телевизийн (IPTV) үйлчилгээ мэдээлэл хүлээн авахад хүртээмжгүй байна.

2. Эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдалтыг судалсан дүн


Судалгаанд хамрагдагчдын хүн ам зүйн ерөнхий байдал

Судалгаанд хараа, сонголын бэрхшээлтэй 148 иргэн хамрагдсан ба (n=67) 45.3% нь харааны бэрхшээлтэй, (n=81) 54.7% нь сонголын бэрхшээлтэй иргэд

байв. Үүнд: Улаанбаатар хотоос (n=67) 45.3%, хөдөө орон нутгаас (n=81) 54.7% бөгөөд Дорнод аймаг (n=44) 29.7%, Өвөрхангай аймаг (n=37) 25.0%-ийг тус тус эзэлж байлаа.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдалтын дүн

Өрхийн эмч гэрээр харааны бэрхшээлтэй иргэдэд хотод 56.0%, хөдөө орон нутагт 54.8%, сонсголын бэрхшээлтэй иргэдэд хотод 52.4%, хөдөө орон нутагт 41.0%-тай тус бүр үзлэг хийсэн байна. Мөн өрхийн эмч үзлэгийн дараа 2-р шатлалын аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг рүү харааны бэрхшээлтэй иргэдийг хотод 68.0%, хөдөө орон нутагт 71.4%, сонсголын бэрхшээлтэй иргэдийг хотод 69.0%, хөдөө орон нутагт 61.5%-тай тус тус илгээсэн байна. Эмнэлгийн үзлэг оношилгоо хийлгэхэд харааны бэрхшээлтэй иргэд хотод 72.0%, хөдөө орон нутагт 83.8%, сонсголын бэрхшээлтэй иргэд хотод 78.0%, хөдөө орон нутагт 89.2% нь тус тус төлбөр төлдөггүй гэж хариулсан байна.




Зураг 5. Хараа, сонсголын бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдалт хот, хөдөө орон нутагт (хувиар)

Хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хуралд харааны бэрхшээлтэй иргэд хотод 80.0%, хөдөө орон нутагт 71.4%, сонсголын бэрхшээлтэй иргэд хотод 90.5%, хөдөө орон нутагт 84.6% тус бүр хамрагдсан байна. Хөгжлийн бэрхшээлийг тодорхойлохтой холбоотой эмнэлгийн тусламж үйлчилгээнд харааны бэрхшээлтэй иргэд хотод 32.0%, хөдөө орон нутагт 47.6%, сонсголын бэрхшээлтэй иргэд хотод 38.1%, хөдөө орон нутагт 43.6% нь тус

тус хангалуун байдаг гэж дүгнэсэн байна. Хараа, сонсголын бэрхшээлтэй иргэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд дунд зэрэг хамрагдаж байна. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд харааны бэрхшээлтэй иргэд хотод 65.8%, хөдөө орон нутагт 61.5%, сонсголын бэрхшээлтэй иргэд хотод 63.0%, хөдөө орон нутагт 60.0% -тай тус тус хамрагдаж байгаа нь дунд зэргийн үзүүлэлттэй байна.

Боловсролын үйлчилгээнд хамрагдалтын дүн


Бидний судалгаанд 0-18 насны хүүхдүүд (n=35) 23.5%, насанд хүрэгчид 19-60 түүнээс дээш насны (n=113) 76.5% хараа, сонсголын бэрхшээлтэй иргэд хамрагдсан. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн боловсролд хамрагдаж буй байдлыг хот, хөдөө орон нутгийн түвшинд харьцуулж үзэхэд сургуулийн өмнөх боловсролд харааны бэрхшээлтэй хүүхдүүд хотод 35.7%, хөдөө орон нутагт 21.3%, сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд хотод 38.6%, хөдөө орон нутагт 25.4% тус бүр хамрагдаж байна. Тусгай хэрэгцээт боловсролын бага ангид харааны бэрхшээлтэй хүүхдүүд хотод 56.4%, хөдөө орон нутагт 25.5%, сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд хотод 71.4%, хөдөө орон нутагт 27.5%-тай хамрагдан суралцаж байна.



Зураг 6. Хараа, сонсголын бэрхшээлтэй иргэдийн боловсролын үйлчилгээнд хамрагдалт (хувиар)

Бүрэн бус дунд боловсролд харааны бэрхшээлтэй хүүхдүүд хотод 40.8%, хөдөө орон нутагт 23.5%, сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд хотод 61.4%, хөдөө орон нутагт 25.2%-тай хамрагдан суралцаж байна. Бага ангиас дунд ангид дэвшин суралцахад олон багш орж, анги танхимууд солигддог зэрэг нөхцөлөөс хамаарч бэрхшээл тулгарч, улмаар суралцаж буй хүүхэд 20%-иар буурсан үзүүлэлт

харагдаж байна.Цаашид ерөнхий боловсролын болон тусгай сургуулиа төгсөөд хараа, сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд үргэлжлүүлэн техник мэргэжлийн сургуульд 20%, их дээд сургуульд 10% -тай дэвшин суралцаж байгаа нь эрс багассан үзүүлэлт харагдаж байна. Хараа, сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд боловсролд хангалттай хамрагдаж чадахгүй байна. Үүнд сургалтын хөтөлбөрийн чанар, хүртээмжгүй байдлаас үүдэлтэй элсэлтийн ерөнхий шалгалтыг өгөх мэдлэг чадвар дутах, тухайн шалгалтыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн онцлог хэрэгцээнд тохируулан авах орчин нөхцөлийг бүрдүүлээгүй зэрэг гол хүчин зүйлүүд нөлөөлж байна.



Зураг 7. Хараа, сонсголын бэрхшээлтэй иргэд хот, хөдөө орон нутагт боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй байдал (хувиар)


Хараа, сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд боловсролын үйлчилгээнд хамрагдахад нийтийн тээвэр, зам, явган хүний гарц, дохиоллын хүртээмжгүй байдал хамгийн ихээр (70-80%) саад бэрхшээл учруулж байна. Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй байдлыг харьцуулж үзэхэд харааны бэрхшээлтэй хүүхдүүд хотод 35.7%, хөдөөд 18.2%, сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд хотод 46%, хөдөөд 20% хамрагдаж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамрагдалтын дүн

Судалгаанд хамрагдсан нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 20-25% нь цалинтай ажил хөдөлмөр эрхэлж байна. Төрийн байгууллагад цалинтай ажилд 20.0%, хувийн хэвшлийн байгууллагад цалинтай ажилд 25.0%, мал, хөдөө аж ахуйд


“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

хувиараа хөдөлмөр эрхэлдэг цалингүй 40.0%, гэр бүлийн бизнест цалингүй хөдөлмөр эрхэлдэг 33.0% байна.



Зураг 8. Хараа, сонсголын бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал (хувиар)


Хөдөлмөр зуучлалын байгууллагаас ямар нэгэн үйлчилгээ авч байсан талаар тодруулахад сонсголын бэрхшээлтэй иргэдийн 40.0%, харааны бэрхшээлтэй иргэдийн 25.0% нь тухайн байгууллагаар үйлчлүүлж байсан байна. Хөдөлмөр зуучлалын газрын үйл ажиллагааг 50% нь хангалтгүй гэж дүгнэсэн байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөр эрхлэх үед тухайн байгууллага ажлын байрыг нь тохируулж, шаардлагатай туслах хэрэгслүүдээр хангаж байсан талаар судлахад 14,3% нь тохируулж өгч байсан гэж хариулсан. Эндээс дүгнэхэд ажил олгогчид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлог байдал тэдэнд хэрхэн ажлын байрыг нь тохируулж өгөх талаарх ойлголт мэдлэг нь туйлын хангалтгүй байна. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамрагдаж буй байдлыг харьцуулж үзэхэд харааны бэрхшээлтэй иргэд хотод 20.0%, хөдөө орон нутагт 15.82%, сонсголын бэрхшээлтэй иргэд хотод 22.5%, хөдөө орон нутагт 25.75%-тай байна. Хотод хувийн хэвшилд, хөдөө орон нутагт мал маллах ба газар тариалангийн ажил эрхэлж байгаагаас дүгнэхэд хараа, сонсголын бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал хангалтгүй байна.



Зураг 9. Хараа, сонсголын бэрхшээлтэй иргэд хот, хөдөө орон нутагт хөдөлмөр эрхлэлтэд хамрагдаж буй байдал


Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдалтын дүн

Нийгмийн хамгааллын тухай хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэн өндөр насны тэтгэвэрт гарах үед аль нэг тэтгэвэр, тэтгэмжээ сонгох эрхтэй байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд ихэвчлэн ажил хийж байгаагүй учраас тэтгэвэр бага тогтоогддог тул дийлэнх нь халамжийн тэтгэмжээ сонгодог. Судалгаанд хамрагдсан Улаанбаатар хотын харааны бэрхшээлтэй иргэдийн 52%, хөдөө орон нутгийн харааны бэрхшээлтэй иргэдийн 33.3%, сонсголын бэрхшээлтэй иргэдийн хотод 45.2%, хөдөө орон нутагт 20.5% нь халамжийн тэтгэмжийг нийгмийн даатгалын сангаас авч байна. Мөн өндөр насны тэтгэврийг харааны бэрхшээлтэй иргэд хотод 16.0%, хөдөө орон нутагт 31.0%, сонсголын бэрхшээлтэй иргэд хотод 14.3%, хөдөө орон нутагт 5.1% нь авч байна. Энэ тэтгэврийг ажил хөдөлмөр эрхэлж байгаагүй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд Нийгмийн халамжийн сангаас олгодог.



Зураг 10. Хараа, сонсголын бэрхшээлтэй иргэдийн нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдалт (хот, хөдөө нутагт хувиар)

Нийгмийн халамжийн тэтгэвэрт харааны бэрхшээлтэй иргэд хотод 32.0%, хөдөө орон нутагт 19.0%, сонсголын бэрхшээлтэй иргэд хотод 54.8%, хөдөө орон нутагт 56.4% нь хамрагдаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асран хамгаалагчийн тэтгэмжийг харааны бэрхшээлтэй иргэд хотод 48.0%, хөдөө орон нутагт 45.2%, сонсголын бэрхшээлтэй иргэд хотод 23.8%, хөдөө орон нутагт 48.7% нь тус тус авч байна. Байнгын асаргаа шаардлагатай иргэнд олгох тэтгэмж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сар бүр олгодог тэтгэмжид харааны бэрхшээлтэй иргэд хотод 24.0%, хөдөө орон нутагт 33.3%, сонсголын бэрхшээлтэй иргэд хотод 16.7%, хөдөө орон нутагт 33.3% нь тус бүр хамрагдаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлог хэрэгцээнээс хамаарч тэдэнд үзүүлэх туслах үйлчилгээнүүд өөр байдаг. Нийгмийн хамгааллын үйлчилгээнд тусдаа туслах үйлчилгээний зардал гэж байхгүй. Харин тэр туслах үйлчилгээг гэр бүлийн гишүүд асран хамгаалагч нар гүйцэтгэдэг. Харааны бэрхшээлтэй иргэдэд хөтөч нь болж, сонсголын бэрхшээлтэй иргэдэд дохионы орчуулагч, хэлмэрчийн үүргийг гүйцэтгэж гол туслагч нь болж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс нийгмийн халамж үйлчилгээний аль хэсэг нь илүү хэрэгцээтэй талаар судлахад харааны бэрхшээлтэй иргэдийн хотод 84.0%, хөдөө орон нутагт 59.5%, сонсголын бэрхшээлтэй иргэдийн хотод 59.5%, хөдөө орон нутагт 66.7% нь “бэлэн мөнгөний санхүүгийн дэмжлэгүүд нэн тэргүүнд хэрэгцээтэй” гэж хариулсан байна. Нийгмийн халамж, хамгааллын тэтгэвэр, тэтгэмж, тусламжид харааны бэрхшээлтэй иргэд хотод 35.3%, хөдөө орон нутагт 28.95%, сонсголын бэрхшээлтэй иргэд хотод 34.53%, хөдөө орон нутагт 27.33 % -тай тус бүр хангалтгүй хамрагдаж байна.



Зураг 11. Хараа, сонсголын бэрхшээлтэй иргэдийн нийгмийн үйлчилгээнд хамрагдалт (хувиар)

Эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж буй байдлыг зураг 11-т харууллаа.

Хараа, сонсголын бэрхшээлтэй иргэдийн нийгмийн үйлчилгээнд хамрагдахтын дундаж үзүүлэлт нь эрүүл мэнд 50%, боловсрол 27%, хөдөлмөр эрхлэлт 21.5%, нийгмийн халамжийн үйлчилгээнд 32% -тай тус тус хамрагдаж байна.

Хэлцэмж

Олон нийтийн барилгын орчны хүртээмж

Америкийн эрдэмтэн С.Старк нар 2007 онд хийсэн олон нийтийн байгууллагуудын барилгын орчны хүртээмжийн судалгаанд орчны хүртээмжтэй байдлын үнэлгээний дундаж оноо (54.2-97.8%) ба корреляцийн коэффициентээр нь гаргахад ариун цэврийн өрөөний үзүүлэлт (0.99), барилгын доторх ашиглалт (0.92), барилгын орох хэсэг (0.84), ая тухтай байдал (0.76) тус бүр гарсан байна. Энэ нь судалгаанд хамрагдсан үйлчилгээний барилга байгууламжуудын орчны үнэлгээ нь хүртээмжтэй, сайн гэж үнэлэгдсэн байна. Энэ нь Америкт Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон хүртээмжийн талаар гаргасан стандарт, дүрэм журмуудыг маш сайн мөрдөж хэрэгжүүлдэг нь харагдаж байна.¹ Харин бидний судалгаанд нийтийн тээвэр, соёл урлаг, үзвэр үйлчилгээний байгууллагад ариун цэврийн өрөөний хүртээмж харааны бэрхшээлтэй иргэдэд 40.0%, сонсголын бэрхшээлтэй иргэдэд 65.0%, иргэний зориулалттай нийтийн орон сууцны барилгын орчны хүртээмж харааны бэрхшээлтэй иргэнд 42.3%, сонсголын бэрхшээлтэй

иргэнд 33.1%-тай байна. “Тулгуур эрхтний хөдөлгөөний бэрхшээлтэй тэргэнцэртэй иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тэгш хамрагдах боломж” судалгаагаар Монгол Улсад эмнэлгийн барилгын орчин хүртээмжгүй гэж үнэлэгдсэн байна. [Мөнх-Учрал Д нар, 2012] Бидний судалгаагаар эрүүл мэндийн салбарын байгууллагад барилгын орчны хүртээмж харааны бэрхшээлтэй иргэдэд 50.5%, сонсголын бэрхшээлтэй иргэдэд 54% хүртээмжтэй байгаа нь судлаач Д. Мөнх-Учралын судалгааны үр дүнтэй харьцуулахад өндөр үзүүлэлттэй байна. Энэ нь хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээс хамаарч хэрэгцээ шаардлага нь өөр өөр байдагтай холбоотой юм.

Мэдээллийн хэрэгслийн үйлчилгээний хүртээмж

Нийгмийн үйлчилгээнд хамрагдахын тулд мэдээллийн аль хэрэгслээс голлон мэдээлэл авдаг талаар судалж үзэхэд телевизийн нэвтрүүлэг, мэдээнээс харааны бэрхшээлтэй иргэдийн 64,2%, сонсголын бэрхшээлтэй иргэдийн 74,1% авдаг гэж хариулсан. Иймээс бид тэдний мэдээллээ голлон авдаг олон нийтийн телевизийн хүртээмжийн үнэлгээг хийхэд олон нийтийн телевизийн хувьд 1 өдрийн эфирийн цагийн 5%-д сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулж мэдээллийг дохионы хэлмэрч орчуулагчийн үйлчилгээтэй хүргэж байна. Интернет телевизийн хувьд телевизийн удирдлага дээр ямар нэг тэмдэглэгээ байхгүй, ихэнх удирдлагын асааж унтраах товч нь зүүн дээд буланд байрладаг бол уг удирдлагынх баруун дээд буландаа байрласан байсан, Vox ассан эсэх нь мэдэгдэхгүй, нууц үг оруулах хэсэгт бичиглэл хийгдэж байгаа эсэх мэдэгдэхгүй, стандарт 5 тоон дээрх товруу хийгдээгүй учир суваг солиход төвөгтэй байсан, нэвтрүүлэг гарч байх үед ямар суваг гарч байгаа (хэддүгээр суваг дээр байгаа) нь мэдэгдэхгүй, цэсийн мэдээлэл, солигдож байгаа эсэх нь мэдэгдэхгүй, ямар нэг дуут дохиолол байхгүй, цэсийн мэдээлэл бүрэн хүртээмжгүй байна. Харин 2016 онд хийгдсэн судалгаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хамаарах мэдээллийг цахим сайтуудад илүү байршуулсан байна [Максима, 2016]. Тиймээс бид судалгаандаа байгууллагуудын цахим хуудасны хүртээмжийн судалгааг хийж үзэхэд 34.8%-тай дунд зэрэг байгаа нь хараа, сонсголын бэрхшээлтэй иргэд мэдээллийг хүлээн авахад хангалтгүй байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдалт

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлийг тодорхойлохдоо эмчийн анхан шатны үзлэг хийж, улмаар Эмнэлгийн хяналтын комисс оношийг баталгаажуулан, эцсийн шатанд Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс шийдвэр гаргадаг. Гэхдээ оношилгоо, үнэлгээ нь гагцхүү анагаах ухааны талаас, өвчний 10-р ангилалд түшиглэн хийгдэж хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг тогтоох ба нийгэм, эдийн засаг, орчны хүртээмжийн чухал хүчин зүйлсийг төдийлөн тооцдоггүй. Хөгжлийн бэрхшээлийг анагаах ухааны өнцгөөс харж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг голлон эмнэлгийн эсвэл асрамжийн сувилалд сэргээн засах үйлчилгээг үзүүлж байгаа нь өөрөө хүндрэл бэрхшээлийг үүсгэж байна[АХБ, 2019]. Бидний судалгаанд хамрагдсан хараа, сонсголын бэрхшээлтэй иргэдийн 50% нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдаж байна. Үлдсэн 50% нь эрүүл мэндийн байгууллагуудын үйлчилгээ ба орчны болон нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжгүй байдлаас хамаарч хамрагдаж чадахгүй байна.

Боловсролын үйлчилгээнд хамрагдалт

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд 20% Улаанбаатар хотод тусгай сургуулиудад суралцаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ерөнхий боловсролын сургуулиудад суралцуулах, тэгш хамруулах алхмууд хийж байгаа боловч суралцаж буй хүүхдүүдийн 70% нь сургуульд хүрэх замд нийтийн тээврийн сонголт байхгүй, хүргэж өгөх, авах хүнгүй, замдаа ядардаг зэрэг бэрхшээлтэй тулгардаг байна[АХБ,2019].Манай судалгаагаар хараа, сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийн 27% нь боловсролд хамрагдаж, нийтийн зам, тээвэр, сургалтын гарын авлага, сургуулийн орчны хүртээмжгүй байдал нь тулгардаг гол бэрхшээл гэсэн дүгнэлт нь дээрх судалгааны дүнтэй ойролцоо байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамрагдалт

2014 оны байдлаар 15 ба түүнээс дээш насны ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлт 25.2% байсан бол нийт хүн амын хувьд энэ үзүүлэлт 62.1% байжээ[ҮСХ,2014]. Бидний судалгаагаар хараа, сонсголын бэрхшээлтэй иргэдийн 21.5% нь хөдөлмөр эрхэлж байна. Энэ нь дээрх судалгааны дүнтэй ойролцоо байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бэрхшээлийн хэлбэрт тохируулж ажлын зарыг тавьж сурталчлах, тухайн хүнд тохирсон ямар ажлууд байгааг танилцуулж сонгоход нь

туслах болон ажил олгогч ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хооронд нь холбон зуучлах, ажлын байран дээр сургах үйлчилгээ хангалтгүй байгааг харуулж байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдалт

Монгол Улсын нийгмийн халамжийн тогтолцоонд дутагдаж байгаа нэг чухал зүйл бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн үнэлгээтэй уялдаж тэдний авч буй тэтгэмж ба үйлчилгээг онцлог хэрэгцээнд нь нийцүүлэх шаардлагатай юм. Дэлхийн зарим улс орнуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн шаардлага хэрэгцээг тодорхой түвшнүүдэд хувааж, илүү өндөр түвшний хэрэгцээнд илүү өндөр дүнтэй мөнгөн тэтгэмж олгох хөгжлийн үнэлгээний тогтолцоо нэвтрүүлээд байна[WHO,WB,2011]. Хөдөлмөрийн чадвар алдалт нь 80%-д тогтоогдоогүй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд халамжийн тэтгэмжээс бусад үйлчилгээнүүдэд хамрагдах боломжгүй байдаг. Манай судалгаанд хамрагдсан хараа, сонсголын бэрхшээлтэй иргэдийн 32% нь нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд халамжийн бага хэмжээний тэтгэмжээс өөр орлогогүй, тогтсон ажил эрхэлдэггүйгээс ядууралд их ертдөг.

Олон салбар дундын хамтын уялдаа холбоо

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн үнэлгээний зохистой тогтолцоог нэвтрүүлснээр бие даан амьдрах чадварыг дэмжих үйлчилгээ, тусгай тоног төхөөрөмж, сэргээн засах эмчилгээ, бусад шаардлагатай нийгмийн үйлчилгээг үзүүлэх нөхцөл бүрдэж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн харилцаанд оролцох чадварыг сайжруулж болно [АХБ, 2019].

Хараа, сонсголын бэрхшээлтэй иргэд нийгмийн үйлчилгээнд бүрэн хамрагдаж чадахгүй байгаа нь мэдээллийг авах боломж хязгаарлагдмал, олон нийтийн барилга, нийтийн тээврийн үйлчилгээ ба орчны хүртээмжгүй байдал, хууль эрх зүйн тусгайлсан зохицуулалт дутмаг, хэрэгжилт нь хангалтгүй байдлаас хамаарч байгааг бид илрүүллээ. 2016 оны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн тодорхойлолттой уялдсан, хөгжлийн бэрхшээлийг цогцоор нь үнэлэх аргачлал бол” Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл эрүүл мэндийн олон улсын ангилал” (ICF) юм.

Тус аргачлалаар эмгэг согог, хөдөлгөөний саатал, нийгмийн оролцоог хязгаарлах нөхцөл байдлыг бүхэлд нь хөгжлийн бэрхшээл хэмээн тодорхойлж, тухайн хүний үйлдэл чадварт нөлөөлж буй хувь хүний болон орчны нийгмийн хүчин зүйлсийг харгалзан авч үздэг ангилал юм.

Судалгааны үр дүнгээс дүгнэхэд цаашид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн үйлчилгээнд бүрэн хамруулах, тэдэнд хүртээмжтэй орчин бүрдүүлэхэд салбар дундын хамтын үйл ажиллагааг сайжруулахын тулд олон улсын эрүүл мэнд ба хөгжлийн бэрхшээлийн үйл ажиллагааны ангиллыг (ICF) нэвтрүүлэх шаардлагатай байна. Мөн олон нийтийн барилгын орчин, нийтийн тээврийн автобусны үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, стандартуудыг шинэчлэн боловсруулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй хүртээмжтэй орчин бүрдүүлэх, хүртээмжийн хуулийг боловсруулж, батлуулах, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

Дүгнэлт

1. Олон нийтийн барилгын орчны стандарт 37.5% хангасан ($p > 0.0002$), нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмж 2.52-2.90 дунд зэрэг ($p > 0.0001$), мэдээллийн хэрэгслийн хүртээмж 34.8% дунд зэргийн хүртээмжтэй байгааг онцгой анхаарах шаардлагатай. Бэрхшээлийн зэрэг нэмэгдэх тутам үйлчилгээ ба орчны хүртээмж нь статистик ач холбогдол бүхий буурч байна.
2. Хараа, сонсголын бэрхшээлтэй иргэдийн 50% нь эрүүл мэнд, 27% нь боловсролын үйлчилгээнд, 21.5% нь хөдөлмөр эрхэлж, нийгмийн халамжийн үйлчилгээнд 32% нь хамрагдаж байгаа нь хангалтгүй байна. Дийлэнх хэсэг нь дээрх нийгмийн үйлчилгээнүүдэд хамрагдахгүй байна.

Судалгааны ажлын зөвлөмж

Хууль эрх зүйн тусгайлсан зохицуулалт, хэрэгжилтийг сайжруулах хүрээнд:

1. Авто тээврийн тухай хуульд:

Нийтийн тээврийн хэрэгслээр зорчиж байгаа хараагүй хүнд зориулж буудлын нэрийг зарлах, сонсголын бэрхшээлтэй иргэнд зориулж буудал бүрт нэр, хаяг,

чиглэлийг бичмэл болон зурган хэлбэрээр электрон самбар дээр зарлаж мэдээлэх

2. Авто замын тухай хуульд:

Авто замын гэрлэн дохио нь хараагүй хүнд зориулсан дуут дохиогоор тоноглогдсон байх

3. Барилгын тухай хуульд:

Орон сууц, нийгмийн дэд бүтцийн байгууламжийг ашиглалтад оруулах барилгын комиссын бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулах

Барилгын зураг төсөлд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлог хэрэгцээг хангаж хүртээмжтэй болгох арга хэмжээг тусгах

4. Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд:

Төрийн байгууллагын цахим хуудас нь хараа, сонсголын бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байх

Харааны бэрхшээлтэй хүнд зориулсан компьютерын дэлгэц дээрх бичгэн мэдээллийг дуу авиа руу хөрвүүлэн хувиргах дэлгэц уншигч, туслах хэрэгслийг хэрэглээнд нэвтрүүлэх, тэдгээрийг эх хэл дээрээ ашиглах боломжийг бий болгох; Сонсголын бэрхшээлтэй хүн цагдаа, эрүүл мэндийн байгууллага, онцгой байдлын албаны тусгай дугаарт текст мессеж, дохионы хэлний хэлмэрчийн зайн дүрс, ярианы тусламжтайгаар хандаж, үйлчилгээ авах боломжийг төрөөс бүрдүүлэх

5. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуульд:

Эрүүл мэндийн байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ тэдний онцлог хэрэгцээ, шаардлагыг хангасан хүртээмжтэй орчин, техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байх

20 ба түүнээс дээш ортой эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагад нийт орны тодорхой хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүртээмжтэй байх, тэдэнтэй харилцах ур чадвар, дохионы хэл, арга техник эзэмшсэн туслах ажилтан ажиллуулах

6. Хараа, сонсголын бэрхшээлтэй иргэдийн онцлог хэрэгцээ, нөхцөлийг бүрэн тусгасан “Хүртээмжийн тухай хууль”-ийг боловсруулах;
7. **Барилгын хөгжлийн төв, олон нийтийн барилгын орчныг хүртээмжтэй болгох хүрээнд:**

Барилгын архитектурын даалгавар, экспертүүдийн шалгах, үнэлгээ өгөх хуудас, барилгын ажлыг хүлээн авах баримт бичгүүдэд хараа, сонсголын бэрхшээлтэй иргэдийн онцлог хэрэгцээг тусгасан заалтуудыг оруулах;

Барилгыг хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд хараа, сонсголын бэрхшээлтэй иргэдийн төлөөллийг оролцуулж хэрэгжилтийг хянаж ажиллах;
8. **Нийслэлийн тээврийн газарт, нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах хүрээнд:**

Нийтийн тээврийн хэрэгслүүд буудлын талаарх мэдээллийг аудио бичлэгээр зарладаг байх;

Нийтийн тээврийн зогсоол, буудлын мэдээллийн самбарыг брайль бичиглэлтэй болгох, дуу хоолойгоор зарлагч автомат төхөөрөмжийг, байрлал заагчтай холбож зарлах зэргээр харааны бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй болгох;

Нийтийн тээврийн хэрэгслүүд буудлын талаарх мэдээллийг автомат бичгийн самбар байрлуулж, байршил заагчтай холбож зарлаж байх.
9. **Харилцаа холбооны зохицуулах газарт, мэдээллийн хэрэгслийн хүртээмжийг сайжруулах хүрээнд:**

Олон улсын веб контентын хандалтын хүртээмжийг сайжруулах (ISO WCAG 2.0) заавар, стандартыг МУ-д нэвтрүүлж хэрэглэх; заавал мөрдөх стандарт болгож батлах;

IPTV телевизийн ITU-T. H-702 олон улсын стандартыг заавал мөрдөх стандарт болгож батлах;
10. **Эрүүл мэндийн хөгжлийн төвд, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах хүрээнд:**

Хөгжлийн бэрхшээлийг цогцоор үнэлэх аргачлал болох “Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл эрүүл мэндийн олон улсын ангилал” (ICF-The International Classification of Functioning, Disability and Health) –ыг нэвтрүүлэх;

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамт олонд түшиглэн сэргээн засах, хөгжүүлэх чиглэлийг дэмжих;

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэгч бүх шатлалын эмнэлгийн байгууллагуудын үйлчилгээ ба орчны хүртээмжийг сайжруулах сургалтыг зохион байгуулах;

11. Нийслэлийн боловсролын газарт, Боловсролын үнэлгээний төвд, боловсролын үйлчилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлэх хүрээнд:

Бүх шатны боловсролын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудыг суралцах, мэргэжил эзэмших сургалтын болон суралцах орчны саадгүй орчныг бүрдүүлж бодлогоор дэмжих;

Ерөнхий эрдмийн шалгалтыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлог хэлбэр хэрэгцээнд тохируулан хүртээмжтэй хэлбэрээр авах;

Их дээд сургуульд элсэн орсон хөгжлийн бэрхшээлтэй оюутан сурагчдыг суралцахад туслах сургалтын ба сургуулийн хүртээмжтэй орчин бүрдүүлэх чиглэлээр ажиллах хариуцсан нэгж байгуулах;

Их дээд сургуулиуд хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад зориулж онлайн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

12. Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газарт, нийгмийн хамгааллын салбарын бодлогын түвшинд:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлог хэлбэр, хэрэгцээ, шаардлагад тулгуурласан олон талт хөгжлийн үнэлгээний тогтолцоог нэвтрүүлж, тэтгэвэр, тэтгэмжийг олгож, үйлчилгээнүүдийг үзүүлэх;

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлж буй тэтгэвэр, тэтгэмжийг хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулан нийгмийн халамжийн тэтгэврийг нэмэгдүүлж байгааг өөрчилж, хөдөлмөрийн хөлсний доод түвшинтэй уялдуулан тогтоох;

Туслах үйлчилгээний зардлыг олгож, туслах үйлчилгээг нэвтрүүлэх

13. Аймаг, дүүргийн хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсүүдэд, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх хүрээнд:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ур чадварыг сайжруулах зорилгоор ажлын байран дээр дагалдуулан суралцуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлог хэрэгцээнд тохируулсан ажлын байр бий болгох;

Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тохируулсан ажлын байр бий болгож авч ажиллуулсан аж ахуйн нэгжийн татварын хөнгөлөлтийг нэмэгдүүлэх;

- 14. Олон нийтийн телевизүүдэд, олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх хүрээнд:** Хөгжлийн бэрхшээлтэй иргэд тэдний гэр бүлийнхэнд зориулсан эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээнд хамрагдах талаар мэдээлэл өгөх төрөлжсөн тусгай нэвтрүүлгийг тогтмол бэлтгэж явуулах.

**ТӨРИЙН ӨМЧИЙН ИХ, ДЭЭД СУРГУУЛЬД
ТУЛГУУР ЭРХТНИЙ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ОЮУТАН
СУРАЛЦАХ БОЛОМЖИЙГ ҮНЭЛЭХ НЬ**

¹ Д.Мөнх-Учрал, ² Б.Түвшинбаатар, ³ Т.Оюун-Эрдэнэ

¹ Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль

² Арьс Өвчин Судлалын Үндэсний Төв

³ Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв

Хураангуй

Монгол улсын хэмжээнд нийт 105.730 хөгжлийн бэрхшээлтэй иргэн (ХБИ) амьдарч байгаа нь хүн амын 3.2 хувийг эзэлж байна. Монгол улс 2008 онд ХБИ-ийн эрхийн тухай конвенцыг баталж, ХБ-тэй иргэдэд хүртээмжтэй барилгын орчин бүрдүүлэх чиглэлээр хэд хэдэн стандартуудыг баталсан. Гэвч тус стандартуудын хэрэгжилт туйлын хангалтгүйн дээр энэ чиглэлээр хийсэн судалгаа эрдэм шинжилгээний ажил ховор байдаг.

Зорилго: Төрийн өмчийн их, дээд сургуулиудад тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй (ХБ) оюутан суралцах боломжийг үнэлэх

Аргазүй: Судалгаанд Улаанбаатар хотын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчийн 13 их, дээд сургуулийн 30 барилгын орчинд үнэлгээ хийсэн.

Их, дээд сургуулиуд ХБ-тэй оюутанд зориулсан автомашины зогсоолгүй (93.3 хувь), зогсоолоос барилга руу нэвтрэх тэгш гадаргуутай замгүй (36.7 хувь), барилгын төв үүдэнд налуу замгүй (83.3 хувь), стандарт бус буюу хэт огцом налуу зам (16.7 хувь) байршуулсан байна.

Их, дээд сургуулиуд давхар хооронд зорчих лифт төлөвлөөгүй (90 хувь), ариун цэврийн өрөө ХБ-тэй оюутан үйлчлүүлэх нэмэлт тоноглол байршуулаагүй (эмэгтэй 96.7 хувь, эрэгтэй 83.3 хувь), лекц, семинарын өрөөний зарим стандарт үзүүлэлтүүд ХБ-тэй оюутанд хүртээмжгүй байна.

Түлхүүр үг: Тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээл, хүртээмжтэй орчин

Үндэслэл

Дэлхий дахинд 1 тэрбум гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэн амьдардаг бөгөөд үүнээс Ази Номхон Далайн бүсэд 650 сая орчим буюу 10 хүн тутмын 1 нь хөгжлийн бэрхшээлтэй амьдарч байна.¹ Монгол улсын хэмжээнд нийт 105.730 хөгжлийн бэрхшээлтэй иргэн (ХБИ) амьдарч байгаа нь хүн амын 3.2 хувийг эзэлж байна.

Монгол улс ХБИ-ийн эрхийг хангах, тэгш боломжийг бүрдүүлэх зорилгоор 2008 онд ХБИ-ийн эрхийн тухай конвенцыг баталж, 2009 онд НҮБ-д албан ёсоор бүртгүүлснээр энэхүү конвенц Монгол улсад хэрэгжих болсон. Гэвч холбогдох бусад

хууль, эрхзүйн баримт бичгийг конвенцын үзэл санаа, агуулгатай нийцүүлэх ажлыг орхигдуулсны улмаас конвенцын хэрэгжилт туйлын хангалтгүй байна.

Монгол улс 2004 онд ХБИ-дэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль (БД 31-101-04), 2009 онд Иргэний барилгын төлөвлөлтөд ХБХ-ий шаардлагыг тооцсон орон зай орчин (MNS 6055:2009) зэрэг стандартыг баталж их, дээд сургуулиудад ХБИ-нд хүртээмжтэй орчин бүрдүүлэх талаар тодорхой заалтуудыг тусгасан байдаг. Гэвч төрийн өмчийн их дээд сургуулиудын орчинд тус стандарт (нормаль)-ын хэрэгжилт хангалтгүйн дээр ХБИ-д их, дээд сургуульд суралцах боломж хязгаарлагдмал байна.

Судалгааны зорилго

Төрийн өмчийн их, дээд сургуулиудад тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй (ХБ) оюутан суралцах боломжийг үнэлэх

Судалгааны зорилт

3. Төрийн өмчийн их, дээд сургуулиудын тулгуур эрхтний ХБ-тэй оюутанд хүртээмжтэй барилгын гадаад орчинд үнэлгээ хийх
4. Төрийн өмчийн их, дээд сургуулиудын тулгуур эрхтний ХБ-тэй оюутанд хүртээмжтэй барилгын дотоод орчинд үнэлгээ хийх

Шинэлэг тал, практик ач холбогдол

Төрийн өмчийн их, дээд сургуулиудын тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй оюутанд зориулсан барилгын гадаад болон дотоод орчинд үнэлгээ хийж шинжлэх ухааны үндэслэлтэй нотолгоо бүрдүүлж буйгаараа ач холбогдолтой.

Судалгааны хэрэглэгдэхүүн ба аргазүй

Судалгааны загвар: Агшингийн судалгаа

Төрийн өмчийн их, дээд сургуулиудад тулгуур эрхтний ХБ-тэй оюутан суралцах боломжийг үнэлэхэд Улаанбаатар хотын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчийн их, дээд сургуулийн (n=16) орчинд үнэлгээ хийхээр төлөвлөсөн.

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Судалгаанд хамрагдах түүврийн нэгжийг сонгохдоо **НИЛЭНХҮЙ** түүвэр ашигласан бөгөөд үнэлгээ хийх боломжтой (n=13) сургууль тус бүрээс хичээлийн төв байр (n=1), салбар сургууль (n=2) сонгож нийт 30 барилгын орчинд үнэлгээ хийсэн.

Хүснэгт 1. Үнэлгээ хийсэн их, дээд сургуулиуд

№	Сургууль	Төв	Салбар
1	АШУҮИС	1	2
2	СЭЗИС	1	-
3	МУИС	1	2
4	СУИС	1	2
5	ДХИС	1	2
6	БХИС	1	2
7	УБИС	1	-
№	Сургууль	Төв	Салбар
8	ШУТИС	1	2
9	КУДС	1	-
10	ТДС	1	-
11	ХААИС	1	2
12	ХУИС	1	1
13	МУБИС	1	2

Мэдээ материал цуглуулсан арга

Төрийн өмчийн их, дээд сургуулиудад тулгуур эрхтний ХБ-тэй оюутан суралцах боломжийг үнэлэхэд 7 бүлэг 94 асуулт бүхий үнэлгээний хуудас ашигласан. Үнэлгээний хуудсыг дараах стандарт (нормаль)-д тулгуурлан боловсруулсан.

4. Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газар. “ХБИ-дэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль (БД 31-101-04)” УБ 2004 он,
5. Стандартчилал хэмжил зүйн газар. Монгол улсын стандарт. “Иргэний болон үйлдвэрлэлийн барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай орчин” MNS 6055: 2009
6. Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам. Монгол улсын барилгын дүрэм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох дүрэм. (БД 31-112-11) УБ 2011 он

Хэмжилт хийсэн багаж

Тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй оюутанд зориулсан төрийн өмчийн их, дээд сургуулиудын орчин дахь хэмжилтийг дараах багаж ашиглан хийсэн.

3. Малайз улсад 2011 онд үйлдвэрлэсэн талбайн урт, өргөн, өндөр, эзлэхүүн м2 лазер хэмжигч BOSCH багажийг ашиглан хэмжилт хийсэн.
4. БНХАУ-д 2011 онд үйлдвэрлэсэн талбайн гадаргуугийн налуу, өнцгийн лазер хэмжигч LAISAI LS 165 багажуудыг тус тус ашигласан.


Судалгааны мэдээллийг Spss 22.0 програмыг ашиглаж боловсруулалт хийсэн.

Судалгааны үр дүн

Судалгаанд БСШУСЯ-ны харьяа төрийн өмчийн 13 их, дээд сургуулийн 30 барилгын орчинд үнэлгээ хийсэн. Үүнээс төв сургууль 14, салбар сургууль 16 байсан ба барилгын 26.7 хувь нь их, дээд сургуулийн зориулалтгүй байсан.


Их, дээд сургуулиудын барилгын гадна талбайд ХБ-тэй оюутанд зориулсан автомашины зогсоолгүй (93.3 хувь), тэмдэглээ байршуулаагүй, зогсоолоос сургуулийн барилгад нэвтрэх чиглэлд тэгш гадаргуутай замгүй (36.7 хувь) байсан.

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”



Зураг 1. Төв хаалганд налуу зам байршуулсан байдал

Их, дээд сургуулиудын 16.7 хувь нь стандарт бус буюу хэт огцом налуу замтай, 83.3 хувь нь огт налуу замгүй байгаа нь тулгуур эрхтний ХБ-тэй оюутан бие даан сургуулийн барилгад нэвтрэх боломж хязгаарлагдмал байгааг харуулж байна.



Зураг 2. Төв хаалганы өргөн, бариулын өндөр, босгоны стандарт


Төв хаалганы өргөнд тэргэнцрийн орон зайг тооцсон эсэхийг үнэлэхэд 80 хувь нь стандарт (800 мм өргөн), 20 хувь нь стандарт бус (800 мм бага) байна. Төв хаалганы бариулын өндөр 70 хувь стандарт (900-1065 мм өндөр), 30 хувь нь стандарт бус, төв хаалганы босгоны өндөр 33.3 хувь нь стандарт (шалтай нэг түвшинд), 66.7 хувь нь стандарт бус байгаа нь тулгуур

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

эрхтний ХБ-тэй их, дээд сургуулийн барилгад бие даан нэвтрэх боломж хязгаарлагдмал байгааг харуулж байна.

Хүлээлгийн өрөөнд тулгуур эрхтний ХБ-тэй оюутны орон зайг тооцсон байдлыг үнэлэхэд хүлээлгийн өрөөний талбай 80 хувь нь стандарт (1000 мм^2), 80 хувь нь сургуулийн бүтэц, үйл ажиллагааны тухай мэдээллийг стандартын дагуу байршуулсан (900 мм өндөр, 90 хувь нь хүлээлгийн өрөөнд тэргэнцрийн орон зайн бүсчлэлийг тооцсон (1500 мм диаметр) зэрэг давуу талууд ажиглагдсан.

Үнэлгээнд оролцсон их, дээд сургуулиудын 100 хувь нь 2 ба түүнээс дээш давхар байсан ба давхар хооронд зорчих шатны бариулын өндөр 60 хувь нь стандарт бус (800 мм өндөр), шатны ирмэгийн налуу стандарт бус (30 хувь) байсан. Мөн үүнээс гадна лавлагаа мэдээлэл (63.3 хувь), хувцасны өлгүүрийн (73.3 хувь) өндөр стандарт бус (800 мм өндөр) байгаа нь тулгуур эрхтний ХБ-тэй оюутанд хүртээмжгүй байгааг харуулж байна.




Зураг 3. Давхар хооронд зорчих лифт, өргүүр төлөвлөсөн байдал

Их, дээд сургуулиудын 10 хувь нь давхар хооронд зорчих лифт төлөвлөсөн бол 90 хувь нь огт лифтгүй байсан ба лифтний хаалганы өргөн стандарт бус, хянах самбар, бариулын өндөр тохиромжгүй (950 мм өндөр), тасалгаанд ХБ-тэй хүний орон зайг (1400 мм урт, 1350 мм өргөн) тооцоогүй байгаагаас харахад тулгуур эрхтний ХБ-тэй оюутан их, дээд


“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

сургуулийн 2 ба түүнээс дээш давхарт гарах боломж хязгаарлагдмал байгааг харуулж байна.




Зураг 4. Ариун цэврийн өрөөний стандарт

Их, дээд сургуулиудын ариун цэврийн өрөөний талбайн хэмжээ 93.3 хувь стандарт (2000 мм урт, 2000 мм өргөн), тэргэнцрийн орон зайг тооцсон байдлаар нь авч үзвэл ариун цэврийн өрөөнд 33.3 хувь нь, бие засах тасалгаанд 86.7 хувь нь стандарт бус буюу тэргэнцрийн орон зайг (1500 диаметр) тооцоогүй, ариун цэврийн өрөөний суултуурт нэмэлт тоноглол байршуулаагүй (93.4 хувь), усны татуурга ХБИ-нд хүртээмжгүй (83.3), дуудах товч байршуулаагүй (100 хувь), гар угаах тосгуур хэт өндөр (73.3 хувь) байгаагаас харахад тулгуур эрхтний ХБ-тэй оюутан их, дээд сургуулиудын ариун цэвэр ба эрүүл ахуйн зориулалттай өрөөг бие даан ашиглах боломж хязгаарлагдмал байгааг харуулж байна.



Зураг 5. Ариун цэврийн өрөөний эрэгтэй суултуурт нэмэлт тоноглол байршуулсан байдал

Их, дээд сургуулиуд эмэгтэй суултуурт 100 хувь стандарт нэмэлт тоноглол (Хэвтээ 650 мм, босоо 800 мм) байршуулаагүй байсан бол эрэгтэй тосгуурт 16.7 хувь нь стандарт нэмэлт тоноглол (Нэмэлт тоноглол 800 мм өндөрт) байршуулсан байна.



Зураг 6. Лекцийн өрөөнд тэргэнцрийн орон зайг тооцсон байдал

Их, дээд сургуулиудын 96.7 хувь лекцийн талбайг стандартын дагуу төлөвлөсөн бөгөөд лекцийн өрөөний гадна (56.7 хувь), лекцийн өрөөнд (70 хувь) тэргэнцрийн орон зайг тооцсон байна.

Их, дээд сургуулиудын лекц, семинарын өрөөг тулгуур эрхтний ХБ-тэй хүртээмжтэй төлөвлөсөн эсэхийг үнэлэхэд хаалганы өргөн (Лекц 73.3, Дад 76.7 %), хаалганы бариулын өндөр (Лекц 80, Дад 66.6%), хаалганы босго (Лекц 36.7, Дад 46.7 %), ширээний өндөр (Лекц 96.7, Дад 80%), залгуурын өндөр (Лекц 70, Дад 46.7 %) стандарт буюу ХБ-тэй оюутанд хүртээмжтэй байсан.

Харин лекцийн өрөөний цонхны өндөр (Лекц 46.7, Дад 33.3% хувь), цонхны хөшигний татуурга (Лекц 56.7, 46.7%), гэрлийн унтраалганы өдөр (Лекц 63.3, Дад 43.3 %) стандарт бус буюу тулгуур эрхтний ХБ-тэй оюутан хүртээмжгүй төлөвлөсөн байна.

Дүгнэлт

Их, дээд сургуулиуд ХБ-тэй оюутанд зориулсан автомашины зогсоолгүй (93.3 хувь), зогсоолоос барилга руу нэвтрэх тэгш гадаргуутай замгүй (36.7 хувь), барилгын төв үүдэнд налуу замгүй (83.3 хувь), стандарт бус буюу хэт огцом налуу зам (16.7 хувь) байршуулсан байна.

Их, дээд сургуулиуд давхар хооронд зорчих лифт төлөвлөөгүй (90 хувь), ариун цэврийн өрөө ХБ-тэй оюутан үйлчлүүлэх нэмэлт тоноглол байршуулаагүй (эмэгтэй 96.7 хувь, эрэгтэй 83.3 хувь), лекц, семинарын өрөөний зарим стандарт үзүүлэлтүүд ХБ-тэй оюутанд хүртээмжгүй байна.

Номзүй

5. Д.Мөнх-Учрал, О.Чимэдсүрэн. Ц.Эрдэнэсамбуу. Тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тэгш хамрагдах боломж. Улаанбаатар: 2012. х.7
6. Монгол улс. Төрийн мэдээлэл. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль. Улаанбаатар: Засгийн газрын дэргэдэх хэвлэх үйлдвэр. 2011.
7. Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газар. Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх норм дүрэм. БНБД 30-01-01. Улаанбаатар: 2000
8. Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газар. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль. БД 31-101-04 Улаанбаатар: 2004.

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ТУСЛАМЖ ХҮССЭН ТАНИХ ТЭМДГИЙГ ШИНЭЭР НЭВТРҮҮЛЭХ НЬ”

Б. Анударь¹, Ч. Дэлгэрмаа²

^{1, 2} МУИС-НШУС-н нийгмийн ажлын IV түвшний оюутан

Хураангуй

Судалгаанд дэвшүүлэн гаргаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан таних тэмдэг нь тухайн иргэдийг нийгмийн амьдралд иргэд олон нийтээс сайн дураараа туслаж дэмжиж байх хэрэгцээг хангахын тулд гаргаж ирсэн зүйл юм. Таних тэмдгийг нэврүүлэхийн тулд энэ зүйлийн талаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санал бодлыг сонсож, мөн иргэд олон нийтээс судалгаа авсан. Судалгаандаа МУИС дээр таних тэмдгээ танилцуулсны үндсэн дээр туршилт судалгаа хийж үр дүнг гаргасан. Хөгжлийн бэрхшээлийн аль ч төрлөөс хамаарахгүйгээр энэхүү таних тэмдэг нь тухайн иргэдэд нийгэмд оролцоход нь нэн тэргүүний хэрэгцээт зүйл болохыг судалгааны үр дүнгээс гаргасан болно.

Түлхүүр үг: Хөгжлийн бэрхшээл, хүндрэл, олон нийтээс тусламж хүссэн таних тэмдэг, олон нийт

I БҮЛЭГ. ОРШИЛ

1.1 Судалгааны үндэслэл

Монгол улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэн 2018 оны байдлаар 105732 байна. Эдгээр иргэд нь олон нийтийн газар, гудамж талбай, зам, барилга орон сууц, хувийн болон нийтийн тээвэр, бусад бүх төрлийн үйлчилгээний байгууллагуудаар явах болон үйлчлүүлэхэд тэдэнд маш их хүндрэл бэрхшээлүүд тулгарч байна. Мөн ХБИ нийгмийн харилцаанд орох, өөрсдийгөө хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэх, суралцах, тусламж үйлчилгээ авах болон өгөх, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулах зэрэг олон хэрэгцээ шаардлага гардаг. Зарим тохиолдолд тэдэнд ямар нэгэн хүндрэл бэрхшээл тулгарахад хэн нэгнээс тусламж гуйх шаардлага гардаг. Тэднийг тусламж гуйхад нь сайн дураараа тусалдаг хүмүүс цөөнгүй байдаг ч нөгөө талд ХБИ-ээс цааргалах, төвөгшөөх, тусламж гуйж буй байдалыг нь үл ойшоох, дургүйцэх, тэдэнд хандан зүй бус үг хэллэг хэлэх, туслахаас татгалзах зэрэг тохиолдолууд мөн адил цөөнгүй гарч байна. Эдгээр үйлдэдүүд нь ХБИ-д эвгүй байдалд орох, сэтгэл санаагаар унах, өөртөө гутрах, өөрсдийгөө дутуу үнэлэх зэрэг сэтгэл зүйн хувьд олон таагүй мэдрэмжүүдийг төрүүлж байдаг. Тиймээс ХБИ-д сайн дураараа тусалдаг хүмүүс хэрэгтэй байгаа бөгөөд энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд “Олон нийтээс тусламж хүссэн таних тэмдэг”-ийг шинээр нэврүүлэх хэрэгцээ шаардлага их байна. Бид дэд бүтцийн асуудалыг хурдан хугацаанд шийдэхэд төвөгтэй ч гэсэн энэхүү таних тэмдгийг ашигаснаар эхний ээлжинд тулгамдсан асуудлаа шийдэж чадахад нь туслаж чадна.

1.2 Судалгааны зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд “Олон нийтээс тусламж хүссэн таних тэмдэг” -ийг шинээр нэвтрүүлэх зорилгоор анхан шатны тандалт, ажиглалт, судалгаа явуулж, үр дүнг боловсруулахад энэхүү судалгааны ажлын зорилго оршино.

1.3 Судалгааны зорилт

Судалгааны зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- ХБИ-д олон нийтийн газраар явахад тулгардаг хүндрэл бэрхшээлүүдийг тодорхойлох
- “Олон нийтээс тусламж хүссэн таних тэмдэг” –ийн талаарх ХБИ-ийн зүгээс үзүүлэх хандлагыг тандан судлах
- “Олон нийтээс тусламж хүссэн таних тэмдэг” –ийн талаарх олон нийтийн зүгээс үзүүлэх хандлагыг тандан судлах
- “Олон нийтээс тусламж хүссэн таних тэмдэг”-ийг шинээр нэвтрүүлэх нь ХБИ-д хэрэгтэй эсэхийг тодорхойлох
- ХБИ-д зориулсан “Олон нийтээс тусламж хүссэн таних тэмдэг”-ийг МУИС дээр турших
- ХБИ-д зориулсан “Олон нийтээс тусламж хүссэн таних тэмдэг”-ийг шинээр нэвтрүүлэхийн давуу тал болон ач холбогдолыг тодорхойлох

1.4 Судалгааны шинэлэг тал:

Энэхүү судалгаа нь ХБИ-д тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор “Олон нийтээс тусламж хүссэн таних тэмдэг”-ийг шинээр санаачилж, анх удаа МУИС дээр туршилт явуулж, үнэлгээ дүгнэлт хийсэн судалгаа юм.



Бид судалгааныхаа явцад “Тусламж хүссэн таних тэмдэг”-ийн туршилтын загварыг гаргасан. Энэхүү таних тэмдэг нь ХБИ-нд үүссэн хүндрэл бэрхшээлийг даван туулахад нь иргэд болон олон нийтийн зүгээс тусламж үзүүлэх зорилготой тэмдэг юм. Тухайлбал, иргэд, олон нийт “Хүүхдийн 108 утас” болон “Жирэмсэн эмэгтэй” зэрэг лого таних тэмдэгүүдийг гаднаас нь хараад шууд ойлгож тэдэнд үйлчилгээ авах болон бэрхшээлээ даван туулж чадахад нь тусладаг. Үүнтэй адил хөгжилийн бэрхшээлтэй иргэнд

энэхүү таних тэмдэг байх хэрэгтэй юм. Энэ загварыг ашиглан бид МУИС дээр туршилтын тандалт судалгаа явуулсан болно.

II БҮЛЭГ. ОНОЛ СУДАЛГААНЫ ТОЙМ

2.1 Сэдвийн судлагдсан байдал

- 2018 онд МУИС, АУС,НЭМ-ийн хөтөлбөрийн баг Т. Батдулам, Ц. Мөнхнасан, О. Мөнхтуул нарын Хараа, сонсгол, хэл яриа, хөдөлгөөний бэрхшээлтэй иргэдэд нийтийн тээврийн хэрэгслийн үйлчилгээний чанар, хүртээмжийг үнэлэх нь судалгаа
- 2018 онд Санхүү эдийн засгийн их сургуулийн Д. Гэрэлчимэг, М. Анударь нарын тэргэнцэртэй иргэдэд тулгардаг зам тээврийн асуудлууд, үйлчилгээний байгууллагуудын хүртээмжтэй байдлын судалгаа зэрэг эдгээр судалгаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийтийн тээвэр болон бусад үйлчилгээний газруудаар үйлчлүүлэхэд хэр зэрэг хүртээмжтэй байгааг судалсан судалгаа юм.

Харин энэхүү судалгаа нь шинэ санаа дэвшүүлэн гаргаж түүн дээрээ тулгуурлан тандалт судалгаа хийж байгаагаараа илүү шинэлэг юм.

2.2 Судалгааны таамаглал

Монгол улсад хөгжилийн бэрхшээлтэй иргэд олон нийтийн газраар явах болон үйлчлүүлэхэд хүндрэл бэрхшээлүүд их тулгарч байгаа бөгөөд таних тэмдгийг шинээр нэвтрүүлж хэрэгжүүлэх шаарлагатай өндөр байна гэж таамаглаж байна. Мөн иргэд олон нийтийн зүгээс энэ таних тэмдгийг дэмжинэ байх гэсэн таамаглал дэвшүүлж байна. Туршилтын судалгаа хийхэд мөн эерэг өөрчлөлт их гарах байх гэж таамаглаж байна.

III БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

3.1 Ерөнхий арга зүй

Судалгааны арга зүйн хувьд ажилглалтын арга, анкетийн арга, туршилтын аргыг ашигласан. Анкетийн судалгааны мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй 30 иргэн, хөгжилийн бэрхшээлгүй жирийн 50 иргэнээс авсан. Судалгааны мэдээлэл цуглуулахад тоон аргын магадлалт бус тохиолдлын замбараагүй түүвэлэлт ашигласан. Судалгааны асуултанд анхдагч болон хоёрдогч асуулттай бөгөөд хариултийн төгсгөлөөс хамааран нээлттэй, хаалттай, хагас нээлттэй асуулгаар, нэг сонголттой хариултаар мөн шүүлтүүр асуулт, хэрхэн тавьж байгаагаас нь шалтгаалан шууд болон шууд бус асуултаар тус тус авсан.


3.2 Судалгааны хүн ам

- Хөгжлийн бэрхшээлтэй 30 иргэн
- Санал бодлыг нь асуусан хөгжлийн бэрхшээлгүй жирийн 50 иргэн

3.3 Судалгааны түүвэрлэлт ба хамрагдалт

Судалгаанд, түүвэрлэлтийг хийхдээ 2019 оны эцсийн байдлаарх нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг түүврийн эх олонлогоо болгон түүвэрлэлт хийсэн билээ. Мөн иргэдийн санал бодлыг тусгах үүднэс нийт 50 иргэнээс судалгаа авсан. Энэ судалгааны хүрээнд туршилт хийсэн учраас хөгжлийн бэрхшээлтэй 30 иргэнийг тохиолдлын замбараагүй түүвэрлэлтээр түүвэрлэн авсан.

Зураг 1. Түүвэрлэлтийн үе шатууд .



3.4 Сургалт, мэдээлэл цуглуулалт

Судалгааны бэлтгэл ажлын хүрээнд ярилцлага авагч нарт зориулан судалгааны зорилгыг ойлгуулах, ярилцлага өгөгчтэй зүй зохистой харьцах мөн асуулгыг зөв бөглөх зааварчилгаа өгөх, асуулга бөглөх дадлага эзэмшүүлж зорилгоор эхний шатанд 10-н хөгжлийн бэрхшээлтэй иргэнээс туршилтын судалгааг авч дахин хянаж засаж сайжируулан үндсэн судалгааны мэдээлэл цуглуулалтыг 2020 оны 10-р сарын 25-оос 11-р сарын 02-ны хооронд 80-н хариулагч тус бүрээс ярилцлагын аргыг ашиглан мэдээлэл цуглуулсан болно.

3.5 Мэдээлэл боловсруулалт, шинжилгээ

Асуулгын хуудсаар цуглуулсан мэдээллийн бүрэн байдал, хариултуудын уялдаа холбоог хянаж засварлах, нээлттэй асуултуудаар цуглуулагдсан мэдээллүүдийг бүлэглэн кодлох, мэдээллийг компьютерт шивж оруулах ажлуудыг судалгааны бүх гишүүд гүйцэтгэсэн. Судалгааны мэдээллийг нийгмийн судалгааны статистик шинжилгээний SPSS11.5 багц программын тусламжтайгаар компьютерт оруулан, боловсруулалт хийж, энгийн тайлбар статистикийн аргаар шинжилгээ, тайлбаруудыг хийсэн.

3.6 Судалгааны хязгаарлагдмал байдал

Энэ удаагийн судалгаа цаг хугацаа болон санхүүгийн хязгаарлагдмал байдалтай холбоотойгоор зөвхөн Улаанбаатар хотод байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс 30 иргэнийг хамруулсан ба тэдний үзэл бодол тэдний таних тэмдгийг нэвтрүүлэх санал ба хандлага ямар байгааг судалсан. Судалгааны мэдээллийг үнэн зөв алдаагүй байлгах үүднээс бүх асуултыг асуулгын аргаар авсан.

IV БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

4.1 “Хөгжилийн бэрхшээлтэй иргэдэд тусламж хүссэн таних тэмдгийг шинээр нэвтрүүлэх нь” иргэдийн санал бодлын тандалт судалгаа

4.1.1 Судалгаанд оролцсон ХБИ шинж байдал

Судалгаанд нийт 40 ХБИ хамрагдсан ба хүйс, нас, хөгжлийн бэрхшээлийн төрлөөр нь ерөнхий үзүүлэлтүүд ямар байгааг эхлээд авч үзлээ. Үүнийг судалсанаар ХБИ ерөнхий төлөв байдал, үзүүлэлтийг харж болох юм.

Энэхүү судалгаанд нийт судалгаа өгсөн ХБИ-ийн 60% нь эрэгтэй ба үлдсэн 40% нь эмэгтэй байсан (График 4.1.1). Мөн насаар нь авч үзвэл 18-25 насны ХБИ дийлэнх хувийг, харин 25-30 насны иргэд болон 30 дээш насны иргэд талаас бага хувийг эзэлж байна. Энэ нь судалгааны түүврийг ХБИ хөгжлийн ерөнхий газар болон харьяалал бүхий МСҮТ-ээс судалгаа авсан нь 18-25 насны иргэд дийлэнх байгаатай холбоотой юм. (График 4.1.2).

График 1.1 Судалгаанд хамрагдсан ХБИ хувийн жин, хүйсээр





График 1.2 Судалгаанд хамрагдсан ХБИ хувийн жин, насны ангилалаар




“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Хүснэгт 1.1 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн бэрхшээлийн төрлөөр нь авч үзэхэд судалгаанд оролцсон иргэдээс харааны бэрхшээлтэй иргэн 33,3 хувийг эзэлж байна. Энэ хүснэгтээс харахад хөгжлийн бэрхшээлийн бүх төрлийг хамруулсан ба оюун ухааны бэрхшээл болон, хавсарсан эмгэгтэй иргэн хамгийн цөөн буюу тус бүр нэг нэг иргэн оролцсон байна.

	Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid Харааны бэрхшээл	10	33.3	33.3	33.3
Сонсгол, хэл ярианы бэрхшээл	3	10.0	10.0	43.3
Оюун ухааны бэрхшээл	1	3.3	3.3	46.7
Хөдөлгөөний бэрхшээл	6	20.0	20.0	66.7
Сэтгэцийн эмгэг	5	16.7	16.7	83.3
Хавсарсан эмгэг	1	3.3	3.3	86.7
Бусад хэлбэрийн эмгэг	4	13.3	13.3	100.0
Total	30	100.0	100.0	

(Хүснэгт 1.1 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувийн жин, хөгжлийн бэрхшээлийн ангилалаар)

4.1.2 ХБИ олон нийтийн газраар үйлчлүүлэхэд тулгамдаж буй асуудлын талаар судалсан нь



“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний өдөр тутамдаа үйлчлүүлдэг газрыг судалж үзсэн. Графикаас харахад ХБИ гэрийнх нь ойролцоо дэлгүүр, СУ, жижиг хүнсний дэлгүүр зэрэг газраар ордог нь хамгийн их хувийг буюу 39,7 хувийг эзэлж байна. Мөн нийтийн тээврээр үйлчлүүлдэг нь 22,7 хувийг эзэлдэг байхад сардаа нэгээс хоёр удаа эрүүл мэндийн газар болон нийгмийн халамжийн байгууллага ордог нь харагдаж байна. (График 1.3)

	Responses		Percent of Cases
	N	Percent	
\$Set_2.2 ^a			
Стандарт бус зам, гарц, гэрлэн дохио, шат	12	24.5%	40.0%
Хүмүүс айдаг	1	2.0%	3.3%
Үйлчилгээний газруудад оочирлох	2	4.1%	6.7%
Хүмүүстэй ойлголцоход хэцүү	10	20.4%	33.3%
Айдастай байдаг	2	4.1%	6.7%
Нийтийн тээвэрт үйлчлүүлэхэд хэцүү	5	10.2%	16.7%
Бичиг үсэг мэдэхгүй	3	6.1%	10.0%
Том үйлчилгээний газруудаар үйлчлүүлэхэд хэцүү	9	18.4%	30.0%
Туслах хүн байхгүй байдаг	1	2.0%	3.3%
Суралцах болон хөгжихөд хүндрэлтэй байдаг	2	4.1%	6.7%
Байхгүй	2	4.1%	6.7%
Total	49	100.0%	163.3%

Хүснэгт (1.2) Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээний газруудад үйлчлүүлэхэд тулгардаг хүндрэл бэрхшээлийг нь нээлттэй асуултын аргаар авсан тул багцлаад эдгээр дурьдсан хүндрэл бэрхшээл тулгарсан (давхардсан тоогоор) Хамгийн их хувийг эзэлж байгаа нь стандарт бус зам гарц гэрлэн дохионы асуудал юм. Энэ нь хөгжлийн бэрхшээлийн бүх төрлөөс

хамаарч тулгарч байгаа асуудлын нэг болоод байна. Мөн судалгаанд оролцсон иргэдийн хариултаас дурьдвал хүмүүстэй ойлголцоход гардаг хүндрэл, томоохон үйлчилгээний байгууллагаар үйлчлүүлэх нь мөн нилээд их хувийг эзэлж байна.

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

(График 1.4) Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүндрэл бэрхшээл тулгарсан үед тусламж авдаг эсэх нь хувиар




Графикаас харахад ХБИ тусламжийг байнга хэн нэгний ойр дотны хүнээсээ эсвэл тааралдсан иргэнээс тусламж авдаг нь харагдаж байна. Огт тусламж авдаггүй иргэн нь 13%-г эзэлж байна. (График 1.4)

Хүснэгт (1.3) ХБИ аль төрлөөс нь хамаарч тусламж авдаг эсэх нь		2.3 Та хүндрэл тулгарахад хэн нэгнээс тусламж авдаг уу?			Total
		Байнга	Хааяа	Огт авдаггүй	
1.3 Та хөгжлийн бэрхшээлийн аль төрөлд хамаардаг вэ?	Харааны бэрхшээл	3	6	1	10
	Сонсгол, хэл ярианы бэрхшээл	1	2	0	3
	Оюун ухааны бэрхшээл	0	1	0	1
	Хөдөлгөөний бэрхшээл	4	2	0	6
	Сэтгэцийн эмгэг	3	2	0	5
	Хавсарсан эмгэг	1	0	0	1
	Бусад хэлбэрийн эмгэг	0	1	3	4
	Total	12	14	4	30

Дээрх судалгаанаас харахад харааны бэрхшээлтэй иргэн болон хөдөлгөөний бэрхшээлтэй иргэн байнга болон хааяадаа үйлчилгээ авдаг нь харагдаж байна. Харин хавсарсан болон бусад хэлбэрийн бэрхшээлтэй иргэн нь судалгаанд оролцсон иргэдийн дунд байхгүй байна. Мөн тусламж авах хэлбэр нь хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээс хамаарч байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүрд тусламж заавал хэрэгтэй биш юм. (Хүснэгт 1.3)

4.1.3 ХБИ-ийн таних тэмдгийн талаар санал бодол



Уг графикаас харахад судалгаанд оролцсон нийт иргэдээс 28 иргэн уг таних тэмдгийг дэмжинэ гэж хариулсан. Үлдсэн 2 иргэн нь мэдэхгүй болон үгүй гэсэн хариултыг өгсөн. (График 1.5). Эдгээр дэмжинэ гэсэн судалгаанд оролцсон иргэдээс таних тэмдэг нь таньд ямар ашиг тустай талаар асуухад иргэдээс үнэхээр өөрийнх нь асуудлыг бага ч болов шийдэж чадахаар байсан нь сайхан байсан. Иргэд шат гарцаар аюулгүй гарч чадна, тусламж заавал хэлж авалгүйгээр сайн дураараа тусалдаг болно, би өөрөө ХБИ ч гэсэн бусад бэрхшээл тулгарч байгаа ХБИ-ддээ тусламаар байна, гэнэтийн тохиолдолд үнэхээр хэрэгтэй гэсэн санаа, надад нийтийн тээврээр үйлчлүүлэхэд илүү хялбар болно, бусадтай харилцахад хялбар болно, бичиг үсэггүй учраас үнэхээр хэрэгтэй байна, өөрт төрдөг таагүй мэдрэмж маань багасна, нийгмийн харилцаанд илүү оролцож эхлэнэ, үйлчилгээний газруудаар хялбар үйлчлүүж эхлэнэ гэх мэт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдөр тутамдаа оролцох оролцоог илүү хөнгөвчилж, хүмүүсийн туслах хэлбэр зэрэг нь арай өөр болно гэх зэргээр тухайн иргэдийн тулгарч байгаа асуудлыг багасгаж өгөхөөрөө илүү ашиг тустайг гэж хариулсан. Харин үгүй хэмээн хариулсан иргэн маань өөрөө хэл ярианы бэрхшээлтэй учир бусадтай ойлголцоход болохоор дэмжихгүй хэмээн хариулсан байна.

Таних тэмдгийг гаргаснаар та нийгмээс ямар хүлээлттэй байгааг судалж үзэхэд давхардсан тоогоор нийгэм бүхлээрээ эерэг хандлагатай болно гэж 27 иргэн, хүмүүс сайн дураараа тусалддаг байна гэж 8 иргэн, ХБИ айдаггүй жигшдэггүй байна гэж 5 иргэн, ХБИ илүү ойлгож дэмждэг болно гэж 5 иргэн, мөн тухайн иргэд бэрхшээлээ даван туулахад


хялбар болно гэж 1 иргэн хариулсан байна. Үүнээс харахад нийгмийн талаас эерэг байвал болно, харин бидний зүгээс маш олон эерэг давуу тал гарахаар санаа байгааг хэлсэн.

Бүлгийн дүгнэлт

Нийт судалгаанд хөгжлийн бэрхшээлтэй 30 иргэн оролцсон ба хөдөлгөөний болон харааны бэрхшээлтэй иргэн ихэвчлэн оролцсон. Судалгаанд оролцсон иргэдийн дийлэнх хувь нь бүх төрлийн дэлгүүрээр үйлчлүүлдэг. Харин эдгээр иргэдэд тулгарч байгаа асуудлын дийлэнх хувийг нь зам, гарч байгаа нь судалгаагаар ажиглагдсан. Таних тэмдгийг нийгэмд үнэхээр нэвтрүүлвэл дэмжих эсэх дээр нийт иргэдийн 94% нь дэмжинэ. Мөн нийгмээс эерэг, биднийг ойлгоод дэмжих хэрэгтэй гэсэн хүлээлтийг тавьж байна гэж хариулсан. Үүнээс харахад ХБИ-ийн дунд энэхүү таних тэмдэг нь үйлчилгээнд нэвтрүүлвэл тэдгээр иргэдийн тулгамдаж буй асуудлаас бага ч гэсэн хөнгөвчилж чадахаар байна гэдгийг судалгааны үр дүнгээс харж болохоор байна.

4.2 “Хөгжилийн бэрхшээлтэй иргэдэд тусламж хүссэн таних тэмдгийг шинээр нэвтрүүлэх нь” иргэдийн санал бодлын тандалт судалгаа


4.2.1 Судалгаанд оролцсон иргэдийн хувийн жин



“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Судалгаанд нийт 45 иргэн оролцсон бөгөөд үүнээс 37.8% ийг 20-с доош насныхан, 28.9% нь 21-30 насныхан, 17.8% нь 31-40 насныхан үлдсэн 15.5% ийг 41-ээс дээш насныхан тус тус оролцсон. Энэхүү судалгаанд 17-30 насны иргэд ихэнх хувийг эзэлж байна. (График 2.1)


График 2.2 Судалгаанд оролцсон иргэдийн хувийн жин, хүйсээр



Нийт судалгаанд оролцогчидын 33% эрэгтэй, 67% нь эмэгтэй оролцогчид байна. Судалгаанд хамрагдсан иргэдийн ихэнх хувийг эмэгтэй хүмүүс эзэлж байна. (График 2.2)


4.2.2 Судалгаанд оролцсон иргэдийн ХБИ-нд хэрхэн тусламж үзүүлэх талаар

График 2.3 Судалгаанд оролцсон иргэдийн бэрхшээлтэй иргэн тусламж гуйвал та туслах эсэх



Дээрх графикаас харахад тандалт судалгаанд хамрагдсан нийт иргэдийн ихэнх буюу 71.1% нь ХБИ тусламж гуйвал ямар ч үед туслана гэж хариулсан байна. Мөн зав чөлөө, боломж таарвал туслаад, завгүй боломжгүй үе таарвал тусалж чадахгүй гэсэн нь 28.9%

байна. Харин ХБИ-нд огт туслахгүй гэсэн хүн 0% байна. Үүнээс үзэхэд иргэд ХБИ-нд туслахгүй байх магадлал бага байна. Ихэнх иргэд ХБИ тусламж гуйвал ямар нэгэн байдлаар туслана гэж хариулсан байна. (График 2.3)



Дээрх тандалт судалгаанд хамрагдсан иргэдийн 89% нь ямар нэгэн тохиолдлоор хөгжилийн бэрхшээлтэй иргэнд туслаж байсан байна. Харин нийт иргэдийн 11% нь ХБИ-нд огт туслаж байгаагүй гэж хариулсан байна. Судалгаанд оролцогчидын 89% буюу ихэнх жирийн иргэд ХБИ-нд туслаж байсан бөгөөд энэ нь хөгжилийн бэрхшээлтэй иргэдэд тусламж авах шаардлага их гардаг гэдэгийг харуулж байна. (График 2.4)


Хүснэгт 2.1 Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд туслахад танд ямар мэдрэмж төрдөг вэ?

№	Хүснэгт 2.3	Valid	Total
1	Хүнд туслаж чадсандаа баярладаг	44.4%	100%
2	Бусдад хэрэгтэй хүн гэсэн мэдрэмж төрдөг	2.2%	100%
3	Тусалсандаа сэтгэл хангалуун таатай байдаг	42.2%	100%
4	ХБИ дотроо өрөвддөг	2.2%	100%
5	Зөв үйлдэл хийлээ гэж боддог	8.9%	100%
6	Мэдрэмж төрдөггүй	6.7%	100%

Хөгжилийн бэрхшээлтэй иргэнд тусалж байсан иргэдэд ихэвчлэн хүнд тусласандаа баярлах, сэтгэл хангалуун таатай мэдрэмжүүд төрдөг байна. Харин зарим тохиолдолд ХБИ-ийг дотороо өрөвдөж, зовиурлах мэдрэмж төрдөг байна. Хүснэгтийн тоон үзүүлэлтээс

харахад ихэнх иргэд маань ХБИ-нд тусалсандаа сэтгэл хангалуун байж, дотороо дургүйцэх, эвгүй мэдрэмж төрөх нь бага байдаг байна. (Хүснэгт 2.1)

4.2.3 Судалгаанд оролцсон иргэдийн таних тэмдгийн талаарх санал бодол



Хөгжилийн бэрхшээлтэй иргэдэд зориулж шинээр “Тусламж хүссэн таних тэмдэг”-ийг нэвтрүүлэхийг зорьж буй энэ санааг эсэргүүцэж, дэмжихгүй гэсэн иргэн байхгүй байсан бөгөөд тандалт судалгаанд хамрагдсан хүмүүс 100% бүгд дэмжиж байна гэж хариулсан. (График 3.1)



“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДАЛЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Энэхүү тандалт судалгаанд хамрагдсан бүх иргэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусламж хүссэн таних тэмдгийг шинээр нэвтрүүлэхийг дэмжиж мөн хэрэгжиж эхэлвэл сайн дураараа оролцож, ХБИ-дэд тусална гэж хариулсан. (График 3.2)

Хүснэгт 3.1 Таних тэмдгийг гаргаснаар нийгэмд ямар өөрчлөлт гарна гэж бодож байна вэ?

№		Valid	Total
1	ХБИ тусламж авахад амар хялбар болно	35.6%	100%
2	ХБИ нийгмийн харилцаанд тэгш оролцох боломжоор хангана	22.2%	100%
3	Нийгэм бүхлээрээ эерэг хандлагатай болно	20%	100%
4	ХБИ-г илүү ойлгодог болно	35.6%	100%
5	Хүмүүс сайн дураараа тусалдаг болно	20%	100%
6	Хүмүүсийн хооронд үл ойлголцол гарахаа болино	8.9%	100%
7	Илүү олон хүн ХБИ-нд тусламж үзүүлдэг болно	6.7%	100%
8	Нийгэмд зөв зүйлс сайн үйлс олон болно	6.7%	100%
9	ХБИ илүү эерэг сэтгэл ханамжтай болно	8.9%	100%
10	Мэдэхгүй	4.4%	100%

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусламж хүссэн таних тэмдгийг шинээр нэвтрүүлээд, ашиглаж эхэлвэл дараах давуу талууд нийгэмд бий болно гэж судалгаанд хамрагдсан иргэд үзсэн. Үүнд:

- ✓ ХБИ тусламж авахад амар хялбар болно
- ✓ ХБИ нийгмийн харилцаанд тэгш оролцож эхлэнэ
- ✓ Нийгэм бүхлээрээ эерэг хандлагатай болно
- ✓ Жирийн иргэд ХБИ-г илүү ойлгодог болж, үл ойлголцол гарахаа болино
- ✓ Илүү олон хүн сайн дураараа ХБИ-нд тусладаг болно
- ✓ Нийгэмд зөв зүйлс сайн үйлс олон болно
- ✓ ХБИ-д өөрсдөө илүү эерэг сэтгэл ханамжтай болно

Мөн энэ тэмдгийг шинээр нэвтрүүлсэнээр нийгэмд ямар өөрчлөлт гарахыг мэдэхгүй байгаа хүмүүс байсан ба энэ нь судалгаанд оролцогчидын 4.4% нь байсан. (Хүснэгт 3.1)

4.3 Туршилтийн судалгаа

МУИС-ийн хэмжээнд нийт 110 хөгжлийн бэрхшээлтэй оюутан байдаг ба үүнээс энэ хичээлийн жилд 70 оюутан идэвхитэй суралцаж байгаа. Их сургуульд хөгжлийн

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

бэрхшээлтэй иргэн суралцахад зориулсан орчин нь дутмаг байдаг учир оюутнуудад их хүндрэлтэй байдаг. Үүдээр орж ирэх болон нэг давхарт л налуу зам байдаг. Тиймээс МУИС дээр уг туршилт судалгааг 2020 оны 10 сарын 25 с 11 сарын 10 хүртэлх хугацаанд таних тэмдэг бүхий посторыг МУИС-ын бүрэлдэхүүн сургуулиудад байршуулж, мөн фэйсбүүк группүүдэд хуваалцсанаар оюутнуудад мэдээлэл хүргэсэн. Үүнтэй зэрэгцэн бид хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудтай уулзаж таних тэмдгээ тайлбарлаж хэлээд өгсөн.



(Зураг 2) Туршилтын судалгааны посторыг сургууль болон номын санд нааж байх үеийн зураг



(Зураг 3) Туршилтын судалгааны посторыг сургуулийн гүрддэд танилцуулсан байдал

Таних тэмдгийг хөгжлийн бэрхшээлтэй 5 оюутантай уулзаад өгсөн. Харин үүнээс хоёр нь энэ хугацаанд хичээлдээ суусан ба таних тэмдгээ хэрхэн ашигласан талаар бидэнтэй хуваалцсан.

МУИС-ийн түүхийн ангийн оюутан нь 100% харааны бэрхшээлтэй. Түүнд сургууль дээр ирэхэд болон явахад, хичээлийн анги танхимаа олох, номоо скайнарадаж сонсоход хүндрэлтэй байдаг. Тэгээд таних тэмдгээ автобуснаас сургуульруугаа явахад хүндрэлтэй байдаг учир тэр хүртэлх замд хүний зайлшгүй хэрэгцээ гарсан учир өргөсөн. Хэсэг хугацааны дараа нэг оюутан ирээд тусалсан. Мөн ангиа олоход гээд өргөхөд ч гэсэн оюутнууд ирээд тусалсан тухайгаа бидэнтэй хуваалцсан. Тэрээр бидэнд энэ таних тэмдэг надад үнэхээр хэрэгтэй байсан. Хүндрэл бэрхшээл тулгарахад хэн нэгнээс заавал ярьж, гуйж тусламж авалгүйгээр сайн дураараа хүн ирээд тусалж байгаа нь сайхан байна гэсэн. Урьд нь заавал хүнд хэлээд, тухайн хүн нь надад дуртай дургүй, заримдаа төвөгшөөсөн байдал ажиглагдаж байсан. Харин энэ таних тэмдгийг хүмүүс мэддэг болсноор надад сайн дураараа ирж асуугаад тусалж байгаа нь илүү амар хялбар байгаа тухай хэлсэн.

Хоёр дахь оюутан маань МУИС-ийн нийгмийн ажлын 5-р түвшний оюутан. Хөдөлгөөний бэрхшээлий болон хэл ярианы бэрхшээлтэй. Хөдөлгөөний бэрхшээлээсээ болоод бичихээр гар нь салгалаад байдаг нь өөрт нь хүндрэлтэй байдаг тухай хэлсэн. Харин хэл ярианы бэрхшээл нь хичээл танилцуулах илтгэл тавихад удаан яридаг болохоор хүндрэл тулгардаг хэмээсэн. Таних тэмдэг байршуулсанаас хойш ахин уулзахад тэмдгээ 2 удаа ашигласан. Эхнийх нь шалгалтын үед шоглоом будахад хэн нэгнээс тусламж авах хэрэгтэй байсан. Таних тэмдгээ энгэр дээрээ наасан байсан учраас шалгалтыг багштай хамт авч байсан оюутан мэдээд ирж тусалсан гэсэн. Харин хоёр дахь тохиолдол нь ус шүүгчээс халуун ус авахад гар нь чичрээд хүндрэлтэй байдаг болохоор тэр үед ашигласан ба нэг эмэгтэй оюутан ирж тусалсан гэлээ. Тухайн оюутны хувьд хөдөлгөөний бэрхшээл нь алхахад тиймч хүндрэл тулгардаггүй ч гэсэн хичээлээ бичих, шалгалтын шоглоом будахад хүндрэлтэй байдаг тухай хэлсэн. Энэ таних тэмдэг нь яг энэ тулгарсан хүндрэлийг нь даван туулахад маш их тусалсан байна.

Бүлгийн дүгнэлт: Бид таних тэмдгийг МУИС-н оюутнуудад нүдэнд харагдах газар байршуулсан ба үүнтэй зэрэгцэн бид яг энэ үеэр хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудтайгаа уулзаж түүнийгээ тайлбарлаж хэлээд хүндрэл тулгарсан үедээ гаргаад ашиглаарай бид оюутнуудад танилцуулж хэлсэн тухайгаа хэлээд өгсөн. Ашигласан хоёр оюутанд тэрээр

ээрэгээр өөрчлөлтүүд их гарсан ба хүндрэл бэрхшээлийг нь хэн нэгний сайн дурын тусламжийн үндсэн дээр даван туулж чадсан нь сайхан байлаа. МУИС хэмжээнд үүнийг цаашид хэрэгжүүлж илүү олон хөгжлийн бэрхшээлтэй оюутанд таних тэмдгээ өгөх тал дээр цаашид анхаарч ажиллана.

IV БҮЛЭГ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

4.1 Ерөнхий дүгнэлт

Энэхүү судалгаагаар ХБИ нд нийгмийн амьдралд саадгүй оролцож чадахад нь ямар хүндрэл бэрхшээл тулгарч байгаа болон түүнийгээ даван туудахад нь туслаж таних тэмдгийг шинээр нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага байгаа эсэх, түүнийг нийгэмд нэвтрүүлвэл дэмжих тал дээр ХБИ судалгаа авч судалсан. Мөн иргэд олон нийтийн зүгээс ХБИ хэрхэн тусалдаг, хэр олон удаагийн давтамжтой тусалж байсан болон энэ таних тэмдгийг нэвтрүүлвэл дэмжих эсэх талаар судаллаа.

Хөгжилийн бэрхшээлтэй иргэд нийгмийн харилцаанд орох, олон нийтийн газараар явах, үйлчлүүлэх явцад тэдэнд бусдаас тусламж гуйх болон авах тохиолдлууд гардаг. ХБИ-с авсан дээрх судалгааны үр дүнгээс үзэхэд харааны, сонсгол хэл ярианы, хөдөлгөөний болон эдгээр нь хавсарсан төрөлийн хөгжилийн бэрхшээлтэй иргэд нь бусад төрлийн хөгжилийн бэрхшээлтэй иргэдээсээ илүү тусламж авах шаардлага ихтэй байдаг байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь гэр, ажил болон сургуулийнхаа эргэн тойрны дэлгүүр, СУ-гээр хамгийн их үйлчлүүлдэг. Ингэхдээ зам гарц болон гэрлэн дохио маш их асуудалтай хүндрэлтэй байгааг судалгаанд оролцсон иргэдийн дийлэнх нь хариулж байсан. Үүнээс үзэхэд ХБИ бусад хүмүүсийн адил аль дуртай гэсэн газраараа орж үйлчлүүлж чадахгүй байна. Тухайлбал үзвэр үйлчилгээ, кофе шоп, томоохон зах худалдааны төвүүдээр энгийн хүн шиг дураарай очиж үйлчлүүлж чадахгүй байна. Зөвхөн өөрт аль ойр байгаа хүнсний дэлгүүрээр үйлчлүүлдэг нь маш ихээр ажиглагдсан. Таних тэмдгийг шинээр нэвтрүүлэхэд иргэдийн 94 хувь нь дэмжсэн ба маш эерэгээр хүлээж авсан. Үүнийг нэвтрүүлсний дараагаар мөн ХБИ тулгамдаж байгаа асуудал тухайлбал цаг хугацаа хэмнэх, шат болон явган хүний гарцаар аюулгүй гарах, нийтийн тээврээр үйлчлүүлэхэд илүү хялбар болох, хүмүүсээс тусламж заавал хэлж авахгүй байх, бусадтай ойлголцож харилцахад илүү хялбар болох, өөрт төрдөг таагүй мэдрэмжүүд нь багассах, нийгмийн харилцаанд илүү оролцож эхлэх, үйлчилгээний газруудаар хялбар үйлчлүүж эхлэх зэрэг давуу талууд бий болно гэдгийг харуулж байна.

Харин иргэд олон нийтийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй иргэн тусламж гуйвал ямар ч үед туслахаар төлөвтэй байгаа нь судалгаанаас харагдсан. Мөн ямар нэгэн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэнд туслаж байсан ба тусалснаар маш эерэг сэтгэгдлийг өөртөө авч байсан. Тусламж хүссэн таних тэмдгийг шинээр нэвтрүүлэхэд иргэд 100% дэмжинэ гэж хариулсан. Мөн тусламж хүссэн таних тэмдгийг бариад зогсож байгаа иргэнд туслах нь ч гэсэн маш эерэг байсан.

Туршилтын судалгааны явцад гарсан үр дүн нь маш эерэг байсан юм. Зөвхөн хоёр оюутан тухайн тэмдгийг ашигласан ч гэсэн тухайн оюутанд тулгарсан хүндрэл бэрхшээлийг хэн нэгний сайн дурын оролцоотой даван туулж чадаж байсан.

Эцэст нь бидний судалгааны таамаглал бүхэлдээ биелсэн юм. Монгол улсад хөгжилийн бэрхшээлтэй иргэд олон нийтийн газраар явах болон үйлчлүүлэхэд хүндрэл бэрхшээлүүд их тулгарч байсан нь бидний судалгааны нэг таамаглал батлагдсан юм. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зүгээс үүнийг гаргавал дэмжинэ гэсэн нь 94 хувийн үзүүлэлттэй байсан нь үнэхээр энэ иргэдэд энэхүү таних тэмдгийн хэрэгцээ шаардлага өндөр байгааг харуулснаар бидний бас нэг таамаглал батлагдлаа. Мөн иргэд олон нийтийн зүгээс энэ таних тэмдгийг дэмжинэ байх гэсэн таамаглал дэвшүүлсэн маань 100% батлагдаж туршилтын судалгаа хийхэд мөн эерэг өөрчлөлт их гарах байх гэсэн таамаглал маань биелэсэн.

Тиймээс ХБИ-д сайн дураараа тусалдаг хүмүүс олон байгаа бөгөөд ХБИ-ийн өмнө тулгамдаж буй дээрх асуудлуудыг шийдвэрлэхийн тулд “Олон нийтээс тусламж хүссэн таних тэмдэг”-ийг шинээр нэвтрүүлж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж дүгнэж байна. Бид энэ нийгэмд бага бага алхамаар ХБИ-ийг хөгжилийн бэрхшээлгүй мэт амьдрах орчинг нь бүрдүүлж өгөх хэрэгтэй.

4.2 Санал зөвлөмж

Ухуулга сурталчилгааны чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний саналууд

Дээрх ерөнхий дүгнэлтүүдэд үндэслэн дараах зөвлөмжүүдийг ухуулга сурталчилгааны чиглэлээр хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна. Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд нийгэмд адил тэгш оролцох боломжийг хангах
2. Олон нийтийн нөлөөллийн ажил ихээр хийх хэрэгтэй.
3. ХБИ-ийн талаарх иргэдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх
4. ХБИ-ийн сурч, хөгжих, ажиллах боломжуудыг нэмэгдүүлэх

5. Таних тэмдгийг стандарт хэмжээний дагуу гаргаж, ХБИ-дэд үнэгүй тараах хэрэгтэй.

Ашигласан материал

- *Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагуудын THE UNIVERSAL PERIODIC REVIEW-д өргөн барих хамтарсан илтгэл, 2010 он*
- *МУИС-д суралцаж буй хөгжилийн бэрхшээлтэй суралцагчдын “СУРАЛЦАХУЙГ” дэмжих оюутанд үйлчлэх төвийн хэрэгцээ, бакалаврын судалгааны ажил., Н.Буянсайхан., УБ 2020*
- *Хөгжлийн бэрхшээл судлал нь салбар дундын шинжлэх ухаан нь болох нь- 2018 сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл., УБ 2018*
- *SPSS, Д. Чимгээ., 2013*

ТЭРГЭНЦЭРТЭЙ ИРГЭДИЙН АРИУН ЦЭВРИЙН АСУУДЛЫГ ШИЙДСЭН ТҮГЭЭМЭЛ ЗАГВАРЫГ БИЙ БОЛГОХ НЬ

А.Лхамсүрэн¹, Б.Отгон-эрдэнэ², Ч.Энхжавхлан³, Т.Эрхэс⁴

¹Эм Ай Юү дээд сургуулийн 3-р дамжааны оюутан

²ОУУБИС-н 1-р дамжааны оюутан

^{3,4} МУБИС-н 3-р дамжааны оюутан

Хураангуй

Энэхүү судалгаа нь тэргэнцэртэй иргэдийн ариун цэврийн өрөөний хүртээмжтэй байдлын талаар судалгаа хийх, ажиглалт явуулах, хүртээмжтэй болон хүртээмжгүй газруудыг тодорхойлох, гарц гаргалааг эрэлхийлэхэд зорьсон болно. Уг судалгаа нь асуулгын, ярилцлагын болон ажиглалтын гэсэн гурван үндсэн аргаар явагдсан. Асуулгын аргаар нийт 30 хүн, ярилцлагын аргаар бэрхшээлийн хүндрэл, тусгай хэрэгцээ болон амьдардаг орчны хувьд ялгаатай 5 хүн судалгаанд оролцсоны 90-ээс дээш хувь нь гэрээс гадуур сургууль, ажил, албан байгууллагууд болон олон нийтийн газруудын ариун цэврийн өрөөнд тэргэнцэртэй хүнд орох хангалттай зай, бариул, нэмэлт тоноглол байдаггүй зэргээс үүдэн ашиглахад хүндрэлтэй болохыг хөндсөн. Үүнээс гадна томоохон сүлжээ болон их дэлгүүрүүд, боловсролын байгууллагууд, олон нийтийн үзвэр үйлчилгээний газруудыг төлөөлүүлэн 20 гаруй объектийн ариун цэврийн өрөөний хүртээмжтэй байдалд ажиглалт хийснээс маш цөөн тооны газрын төлөвлөлтийг тэргэнцэртэй хүнд хүртээмжтэй гэж дүгнэсэн. Судалгааны үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй болон энгийн иргэдэд нээлттэй ариун цэврийн өрөөний түгээмэл загварыг бий болгож шийдэх нь зөв гаргалгаа гэсэн саналыг дэвшүүлж байна.

Түлхүүр үг: Хүртээмжтэй ариун цэврийн өрөө – хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан ашиглах боломж бололцоог олгосон туслах хэрэгсэл, нэмэлт тоноглол зэргийг стэндартын дагуу төлөвлөсөн ариун цэврийн өрөө

Катетер – Хүзүү болон нуруу нугасны гэмтлээс үүдсэн хүнд хэлбэрийн мэдээ алдалттай хүмүүст шээсний сүвээр болон давсгаар байрлуулж шээс гадагшлуулахад хэрэглэгдэх эмнэлэгийн тусгай хэрэглэгдэхүүн

Бариул, нэмэлт тоноглол – тулгуур эрхтний бэрхшээлтэй хүн суултуурт суухдаа тулах болон барихад зориулагдсан нэмэлт хэрэгсэл

Бүхээг – Нийтийн ариун цэврийн газрын суултуур болон угаалтууруудыг нэг хүний хэрэгцээнд зориулах байдлаар тус бүрт нь тусгаарласан жижиг өрөө

Удиртгал

Монгол улсын үндсэн хууль болон бусад хууль, дүрэм, журмуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тэдний хэрэгцээ шаардлагыг хангасан, хүртээмжтэй, бие даан бусдын адил амьдарч, ажиллаж хөдөлмөрлөх эрх чөлөө, боломж болзолыг хангах тухай тодорхой чиглэл бүхий заалтууд бий. Гэтэл хуулийн тэдгээр заалтууд бодит амьдрал дээр хэрэгждэггүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах, ажиллах болон сурч боловсрох орчны хүртээмжтэй байдлын асуудал бүрэн шийдэгдэхгүй, яригдсаар маш урт хугацаа өнгөрсөөр байна. Тэгвэл хүртээмжтэй байдлаар тохижуулагдаагүй энэ орчинд хөгжлийн

бэрхшээлтэй тэр дундаа тэргэнцэртэй иргэдийн бие даасан чөлөөт байдлын асуудал нэгээхэн хурц асуудлуудын нэг юм. Тэдний олон нийтийн байгууллагуудаар үйлчлүүлэх, гудамж талбайд чөлөөтэй зорчихоос гадна хөндөгддөг өөр нэг чухал асуудал бол тэргэнцэртэй иргэдийн эрүүл ахуйд нийцэхүйц ариун цэврийн өрөөний хүртээмжтэй байдал юм. Монгол улсын хэмжээнд тэргэнцэртэй иргэдэд зориулагдсан стандартад нийцсэн ариун цэврийн өрөө гэлтгүй энгийн иргэд ороод үйлчлүүлэх боломж бүхий цэвэр тохитой газрууд ч ховор байдаг билээ. Тиймээс энэхүү судалгаандаа хүнд болон хөнгөн хэлбэрийн саажилттай, тулгуур эрхтний гэмтэлтэй, хөдөө орон нутагт болон хот суурин газарт амьдардаг тэргэнцэртэй иргэдийн төлөөлөлтэй уулзаж тэдэнд тулгарч буй асуудлуудыг тодорхойлж ярилцах, тэргэнцэртэй иргэдийн дунд цахим асуулга явуулах, нийслэл хот дахь олон нийтийн үйлчилгээний газрууд, албан байгууллага болон төрийн бус байгууллагуудын ариун цэврийн өрөөнд ажиглалт дүгнэлт хийх замаар бодит асуудлуудыг тодруулах, баг хамт олноороо болон мэргэжлийн хүмүүстэй санал бодлоо солилцож гарц гаргалгааг эрэлхийлэхийг зорьсон болно.

Судалгааны зорилго

Тэргэнцэртэй иргэдийн ариун цэврийн өрөөний хүртээмжтэй байдал, эрүүл ахуйн үйлчилгээнд тулгарч буй асуудлыг судалж, гарц гаргалгааг эрэлхийлэн, тэргэнцэртэй иргэдэд ээлтэй дэд бүтцийн шинэчлэлтийг хийж, арга замыг судлахад энэхүү судалгааны зорилго оршино.

Судалгааны зорилт, ач холбогдол

Судалгааг хийхдээ тэргэнцэртэй иргэдийн олон талын төлөөлөлтэй уулзаж ярилцах, ариун цэврийн өрөөний орчны судалгаа хийж зургаар баталгаажуулах, энгийн иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй нийт иргэдэд зориулагдсан түгээмэл загварын боломж, бололцоог тооцолох.

Судалгааны хэрэглэгдэхүүн, арга зүй


Энэхүү судалгааг хийхдээ Google Form дээр 15 асуулт бүхий асуулга боловсруулж түүврийн байдлаар 30 хүнээс авсан. Мөн Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо, Түгээмэл хөгжил бие даан амьдрах төвийн мэргэжилтэн, нийгмийн ажилтнуудтай холбогдож санал, зөвлөгөө авснаас гадна бэрхшээлийн хүндрэл, амьдардаг орчин зэргээрээ ялгаатай 5 хүнээс ярилцлагын аргаар судалгаа авсан. Түүнээс гадна, E-mart, CU, Номин их дэлгүүр, гэх мэт сүлжээ болон их дэлгүүрүүд, Сэргээн засах сургалт

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

үйлдвэрлэлийн төв, ерөнхий боловсролын сургуулиуд, их дээд сургуулиудын хичээлийн байр, оюутны дотуур байр, City Toilet буюу нийтийн ариун цэврийн газруудын хүртээмжтэй байдалд ажиглалтын аргаар судалгаа хийсэн.

Google Form дээрх асуулгын график үзүүлэлтүүд:

График 1: Судалгаад оролцогчдын нас болон хүйсийн үзүүлэлт



Судалгаанд оролцсон иргэдийн 20 нь буюу 66,7 хувь нь 20-30 насны залуучууд байна. Мөн нийт хүмүүсийн 19 буюу 63,3 хувь нь эмэгтэйчүүд, 11 буюу 56,7 хувь нь эрэгтэйчүүд байна. Энэхүү үзүүлэлтийг нь ЖАЙКА олон улсын хамтын ажиллагааны байгууллага, ХНХЯ-ны жил бүр хамтран гаргадаг "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа 2019" мэдээллийн лавлахад дурдагдсан Улаанбаатар хотод байгаа нийт хөгжлийн бэрхшээлтэй 35589 иргэний 7399 иргэн буюу 20,7 хувь нь 20-34 насны залуучууд гэсэн статистиктай харьцуулахад нийслэлд байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн багагүй хувийг хөдөлмөр эрхлэх насны залуу хүмүүс эзэлдэг болох нь харагдаж байна. (график 1)

График 2: Ариун цэврийн өрөөг шууд ашигладаг болон катетер хэрэглэдэг хүмүүсийн үзүүлэлт.



Графикт үзүүлсэнээр судалгаанд оролцсон нийт иргэдийн дийлэнх буюу 63.3% өдөр тутамдаа ариун цэврийн өрөө, суултуурыг шууд ашигладаг бол 36.7% нь нэмэлт хэрэгсэл болох катетер ашигладаг байна. (график 2)

График 3: Катетер ашиглахад гардаг хүндрэлүүдийн үзүүлэлт



Катетер хэрэглэсэнээс үүсдэг сөрөг үр дагаваруудын талаар нийт судалгаанд оролцогчдын 53.3% нь эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг буюу нян бактер үүсэх эрсдэл өндөр гэж үзэж байна. (график 3)


График 4: Катетерийг суллаж цэвэрлэх давтамж



“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Катетер ашигладаг нийт 11 хүн судалгаанд оролцсоноос 6 нь өдөрт 1-3 удаа 3 нь 3-5 удаа шээсний уутаа суллах шаардлагатай болдог байна. Тэгэхээр катетер ашигладаг хүн өдөрт дунджаар 3-5 удаа ариун цэврийн өрөө буюу нойл ашиглах шаардлаг тулгардаг. (график 4)


График 5: Ариун цэврийн өрөөг бие даан ашиглаж чаддаг эсэх үзүүлэлт




Уг графикаас харахад судалгаанд оролцогчдын 56.6% нь хэн нэгний туслалцаагүйгээр ариун цэврийн өрөөг ашиглахад ямар нэгэн байдлаар хүндрэл тулгардаг байна. (график 5)

График 6- А болон Б: Тэргэнцэртэй иргэдийн гадуур болон гэртээ ариун цэврийн өрөө ашигладаг давтамж

6-А



6-Б




Судалгаанд оролцсон тэргэнцэртэй иргэдийн гэртээ байхдаа болон гадуур явах үедээ ариун цэврийн өрөө ашигладаг давтамжийг судалхад 21 хүн буюу 70% нь гэртээ байхдаа дунджаар 1-5 удаа, 23 хүн буюу 76.7% нь гадуур явж байхдаа дунджаар 1-3 удаа ариун

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

цэврийн өрөө ашигладаг гэжээ. Үүнээс үзэхэд тэргэнцэртэй хүмүүсийн ихэнх хувь нь ариун цэврийн өрөөний хүртээмжгүй байдлаас болж ашиглах давтамж нь бага байдаг. (график 6 А-Б)

График 7 А-Б: Олон нийтийн үйлчилгээний газруудын ариун цэврийн өрөөг ашиглахад тулгардаг хүндрэл бэрхшээл

7-А




7-Б



Судалгаанд оролцогчдийн 27 хүн буюу 90% нь үйлчилгээний газрууд болон бусад албан байгууллагуудын ариун цэврийн өрөөг ашиглахад бэрхшээлтэй байдаг бөгөөд тэргэнцэрээс суултуурт шилжин суухад хангалттай зай, хананы бариул болон нэмэлт тоноглол байдаггүй гэх зэрэг асуудлууд ихэвчлэн тулгардаг байна. (график 7 А-Б)

График 8: Ариун цэврийн өрөөний хүртээмжгүй байдлаас болж хоололтоо хязгаарладаг эсэх



“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”


Судалгаанд оролцсон нийт хүмүүсийн 29 буюу 96.7% нь ариун цэврийн өрөө ашиглахад үүсдэг хүндрэлээс болж өдөр тутамдаа ямар нэгэн байдлаар хоололтоо хязгаарлах шаардлагатай байдаг байна. (график 8)

График 9: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ариун цэврийн стандартын талаарх мэдээлэлтэй эсэх



Нийт судалгаанд оролцогчдын 76.6 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ариун цэврийн стандартын талаарх мэдлэг, мэдээлэлгүй байна. (график 9)


График 10: Олон нийтийн үйлчлүүлдэг байгууллагуудын ариун цэврийн өрөөний хүртээмжтэй байдлыг 1-5 хүртлэх тоогоор үнэлсэн байдал.



“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”



10-B

10-Г



10-Д


10-E



Нийслэл хот дахь албан болон олон нийтийн газруудын ариун цэврийн өрөөнд үнэлгээ өгөх асуулгад, нийт судалгаанд оролцсон иргэдийн дийлэх нь болосролын салбарын байгууллагууд, үзвэр үйлчилгээний газрууд болон амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх газруудад дунд болон дундаас доош үнэлгээ өгсөн байна. Тодруулбал, сургууль, цэцэрлэг, номын сангийн ариун цэврийн өрөөний орчинд нийт хүмүүсийн 70 хувь нь, кино театр, музей гэх мэт үзвэрийн газруудад 76,6 хувь нь, цэцэрлэгт хүрээлэн, парк зэрэг чөлөөт цагаа өнгөрөөх газруудад 86,6 хувь нь дунд, муу, маш муу гэсэн үнэлгээг өгчээ. Мөн кофешоп, ресторануудын орчинд нийт судалгаанд оролцсон хүмүүсийн 73,3 хувь, нисэх онгоцны буудал, нийтийн ариун цэврийн газруудад 63,3 хувь нь дунд болон түүнээс доош үнэлгээ өгчээ. Харин И-март, Си Юү зэрэг томоохон сүлжээ дэлгүүрүүдийн ариун цэврийн өрөөний хүртээмжтэй байдлыг нийт судалгаанд оролцсон хүмүүсийн 36,7 хувь нь сайн болон маш сайн гэж үнэлсэн нь бусад газруудынхтай харьцуулахад харьцангуй эерэг үзүүлэлт юм. (график 10 А - Е)


“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

График 11: Өөрийн гэр болон тогтмол ашигладаг ариун цэврийн өрөөг хүртээмжтэй болгож тохижуулсан эсэх асуумж




Судалгаанд оролцогчдийн 17 хүн буюу 56.7% нь бэрхшээлийн төрлөөс хамаарч өөртөө тохируулан бариул болон нэмэлт тоноглол суурьлуулж тохижуулсан бол үлдсэн 13 хүн буюу 43.3% нь яаж тохижуулахаа мэдэхгүй эсвэл тохижуулах шаардлагагүй гэсэн шалтгааны улмаас тохижуулаагүй гэсэн хариултыг өгчээ. (график 11)

График 12: Хамгийн хүртээмжтэй ариун цэврийн өрөөний дэд бүтцийн санал асуулгын үр дүн



Судалгаанд оролцсон иргэдийн хариултаас харахад давхардсан тоогоор тэргэнцэр орж гарч, эргэхэд чөлөөтэй зайтай, бариул, гишгүүр, нэмэлт тоноглол, мөн суултуур, угаалтуур, хатаагч, хаалганы бариул унтраалга нь намхан байвал тэргэнцэртэй хүн хэрэглэж болохуйц хүртээмжтэй байна гэж үзжээ. (график 12)

График 13: Ариун цэврийн өрөө болон катетертэй холбоотой санал асуулгын үзүүлэлт



Судалгаанд оролцогчдын ихэнх хувь нь ариун цэврийн өрөөний хүртээмжтэй байдлын стандартаа дагаж мөрдөх, хүртээмжтэй мөн стандартад нийцсэн нойлын тоог нэмэгдүүлэх, нэмэлт тоноглол, тусламж дуудах товч суурьлуулах катетер, памперс солих нэмэлт зайтай байх зэрэг асуудлыг шийдвэрлэхийг хүсэж байна.

Хүүрнэх аргаар хийсэн судалгааны дүгнэлт

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ариун цэврийн өрөөний хүртээмжтэй байдлын асуудлыг хөндөхдөө хүзүү нугасны болон мэдрэлийн замын гэмтэл бэртлээс үүдсэн бүтэн мэдээ алдалттай, дөрвөн мөчний сажилттай буюу катетер гэх мэт нэмэлт хэрэгсэл зайлшгүй шаардлагатай хүмүүс, нуруу нугасны болон тулгуур эрхтний гэмтлээс үүдсэн хагас мэдээ алдалттай буюу ариун цэврийн өрөө, суултуур ашиглах боломжтой, тэргэнцэр, суга таяг

хэрэглэдэг аль эсвэл хоёуланг нь хослуулж хэрэглэдэг хүмүүс, хот суурин газар оршин суудаг тэргэнцэртэй иргэдээс гадна хөдөө орон нутаг, гэр хороололд амьдардаг иргэдийн гэх мэт олон талын төлөөллийг хамруулж ярилцахыг зорьсон. Эдгээр ярилцсан хүмүүс нь Түгээмэл хөгжил бие даан амьдрах төвийн гишүүд, ажилчид болон Сэргээн засах сургалт үйлдвэрлэлийн төвийн төгсөгч, суралцагч нарын төлөөлөл юм. Хүн бүртээ дунджаар 15-20 минут ярилцсан бөгөөд тэдэнтэй хийсэн ярилцлагаас ариун цэврийн өрөө буюу нойлын өрөөний хүртээмжтэй байдалд чухалчилж авч үзэх шаардлагатай дараах хэд хэдэн нийтлэг хүндрэл брэхшээлүүдийг тодруулсан болно. Судалгаанд оролцогчдын ярилцлагын тэмдэглэлтэй хавсралт хэсгээс уншиж танилцана уу.

Судалгаанд оролцогчдын дурдсан нийтлэг хүндрэлүүд:

1. Катетерийг удаан хугацаанд хэрэглэх нь шээсний сүв, давсаг үрэвсэх, цаашлаад бөөрний үйл ажиллагаа алдагдахад хүргэдэг.
2. Өрхийн болон түргэний эмч нар катетерийг хэрхэн солих талаар хангалттай мэдлэг туршлагагүй, эмнэлэгт очихоор оочер дараалал ихтэй, хүн олонтой зэрэг шалтгаануудын улмаас катетераа гэрийн нөхцөлд өөрсдөө солих болон гэр бүлийн хүнээрээ солиулдаг.
3. Долоо хоног бүр ариутгах цаг гардаггүй, өөр хэн нэгэн хүний тусламж зайлшгүй хэрэг болдог зэргээс үүдэн катетер болон суурьлуулсан хэсгийн ариутгал халдваргүйжүүлэлт бараг хийгддэггүй.
4. Катетер болон шээсний уудыг аюулгүй, цэвэр авч явахад анхаарал их шаарддаг.
5. Живх байнга хэрэглэх нь арьс түлэгдэх, улайх, нойтон оргих цаашлаад шээс гадагшлахаа болих зэрэг асуудлуудыг дагуулдаг.
6. Гадуур явж байгаа үед шууд ороод үйлчлүүлэх хүртээмжтэй нойлын өрөө бараг байдаггүй, хүртээмжгүй тохижуулагдсан ихэнх нойлд шээсний уутаа суллах, живхээ солих боломж байдаггүй.
7. Ариун цэврийн өрөөний хаалга нь хүнд байдгаас болоод түлхэх эсвэл татахад хүч их шаарддаг, тэргэнцэр багтахааргүй нарийхан, бүхээгний доторх нь тэргэнцэртэй хүн эргэх боломжгүй жижиг байх тохиолдол маш олон газруудад байдаг.
8. Хувцас цүнхээ тогтоох өлгүүр байдаггүй, байсан ч өндөрт байрладаг.
9. Суултуурын дээрх нэмэлт зөөлөвч тогтворгүй байдаг, суух үед хажуу тийшээ хазайх, салж унах эрсдэлтэй байдаг.

10. Бариул байдаггүй. Зарим газрын бариулууд барихад тохиромжгүй, суултуураас хол байрласан, гар хальтардаг, сууриараа хөдөлдөг байх нь элбэг тохиолддог.
11. Суултуур нь өндөр, хөл газар хүрэх боломжгүй үед хөлний доороос тулж тэнцвэрээ хадгалахад дэмжлэг үзүүлэх гишгүүр байдаггүй.
12. Мөн ихэнх тохиолдолд почки ардаа байрладаг учраас эргэж харж усаа татахад хүндрэл гардаг. Почкины ус татах товч нь хатуу байдаг.
13. Нойлын цас, хогийн сав хүрэхэд хол байрладаг.
14. Угаалтуур болон гар хатаагч хүрэхэд тохиромжгүй өндөрт байрладаг. Угаалтуурын доод босоо хэсэг нь тэргэнцэртэй хүний хөлд тулж угаалтуурт чөлөөтэй ойртоход саад болдог.
15. Shangri La, Holiday Inn, Blue Sky, E-mart гэх мэт томоохон зочид буудал, сүлжээ дэлгүүрээс бусад ихэнх жижиг газрууд, албан байгууллагууд, нийтийн ариун цэврийн газрууд хүртээмжгүй, стандартад нийцээгүй байдаг.
16. Хөдөө орон нутгийн болон гэр хорооллын хүмүүст бие даан ашиглаж болох зориулалтын суултуур, тоног хэрэгсэл байдаггүй.
17. Ихэнх газруудын нойлын тохижилт стандартад нийцээгүй, хүртээмжтэй нойлын тоо хэмжээ хангалтгүй, бусдаас тусламж авахад хүндрэлтэй байдаг зэргээс болж гадуур явахдаа хооллолт болон шингэн зүйл уухдаа хязгаарлалт хийх шаардлагатай болдог.

Нийлсэл хот дахь байгууллагуудын ариун цэврийн өрөөний бодит жишгүүд


Судалгааны хүрээнд нэр бүхий томоохон сүлжээ их дэлгүүрүүд, ерөнхий боловсролын, их дээд сургуулиуд, олон нийтийн, үзвэр үйлчилгээний болон нийтийн ариун цэврийн газрууд гэх мэт 20 гаруй объектын ариун цэврийн өрөөнд ажиглалт хийсэн. Тэдгээрээс маш цөөн тооны хэдэн газруудын тохижилт нь стандартад нийцсэн хүртээмжтэй байсан. (зураг 3-8) дээрх ариун цэврийн өрөөнүүд нь угаалтуур нь намхан тэргэнцэртэй хүний хөлд тээглэх саадгүй, хана болон шаланд нэмэлт бариул суурилуулсан унтраалга болон хаалганы бариул нь тэргэнцэртэй хүний гар хүрэхүйц, хогын сав болон нойлын цаас нь суултууртай ойрхон байрласан, мөн ус татах товчлуурыг суултуурын хажуу талд байрлуулж ус татахад хялбар болгосоноор тэргэнцэртэй хүн ашиглахад хүртээмжтэй нөхцлийг бүрдүүлсэн байна. Харин зураг (зураг 9-14) дээрх ариун цэврийн цэврийн өрөөнүүдийн доторх бүхээгний хаалга нь тэргэнцэр багтхааргүй, доторх зай нь тэргэнцэр эргэхэд хангалтгүй, хана болон

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”


шаланд нэмэлт бариулт суурилуулаагүй, почки нь ард талдаа байрласан тул хөгжлийн бэрхшээлтэй хүн арагшаа эргэж усаа татахад хүндрэлтэй, мөн угаалтуурын доод хэсэг тэргэнцэртэй хүний хөл багтахуйц зайгүй учраас чөлөөтэй ойртох нөхцлийг хязгаарлаж хүртээмжгүй байдлыг бий болгож байна.

Монгол улсад барилга байгууламжын хүртээмжтэй байдлыг хангах олон стандарт байдгын нэг нь MNS 6055:2009 “Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин” стандарт юм. (зураг 1-2) Уг стандарт нь хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан ашиглах хүртээмжтэй, аюулгүй ариун цэврийн өрөөний төлөвлөлтийн стандартад нийцсэн жишиг болно.

Зураг 1




Зураг 2




Хүртээмжтэй ариун цэврийн өрөө:

Зураг 3



Зураг 4



Зураг 5



Зураг 6



Зураг 7



Зураг 8



Хүртээмжгүй ариун цэврийн өрөө:

Зураг 9



Зураг 10



Зураг 11



Зураг 12

Зураг 13

Зураг 14

Дүгнэлт

Дээрх судалгааны үр дүнгүүдээс үзэхэд тэргэнцэртэй иргэдэд тулгарч буй нэн түрүүний асуудал бол нойлын хүртэмжтэй байдал буюу хангалттай орон зайн шийдэл, бариул, нэмэлт тоноглолын суурьлуулалт зэрэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлог хэрэгцээнд нийцсэн стандартын дагуу нойлын бүхээгийг албан байгууллагууд, олон нийтийн үйлчилгээний газрууд, нийтийн ариун цэврийн зориулалт бүхий газруудад зайлшгүй шийдэж

өгсөн байх явдал гэж харагдаж байна. Гэтэл нийслэл хотын дахь бүх шатны төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, олон нийтийн, үзвэр үйлчилгээний газруудад зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хүртээмжтэй нойлын өрөөг тохижуулах боломж бололцоо, орон зай, барилгын шинэчлэлт засварын нөхцөл зэрэг нь төдийлөн хялбар ажил биш юм. Жишээлбэл, эхнээсээ орон зайн хувьд стандартад нийцээгүй, нэмэлт бүхээг хийх боломжгүй ариун цэврийн өрөөг хүртээмжтэй болгохын тулд ханыг нь нураах, цахилгаан болон сан техникийн шугамыг шинэчлэн засах зэрэг маш олон ажил, цаг хугацаа, төсөв шаардлагатай болдгоос үүдэн ихэнх байгууллагууд ариун цэврийн өрөөндөө өөрчлөлт хийхэд хүндрэл учирдаг. Хэдийгээр судалгаанд оролцсон иргэдийн дийлэнх нь хамгийн хүртээмжтэй нойлтой газраар Holiday Inn, Shangri La зэрэг томоохон зочид буудлууд, E-mart, Улаанбаатар гэх мэт сүлжээ их дэлгүүрүүдийг нэрлэсэн байгаа нь сүүлийн үеийн томоохон үйлчилгээний газрууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байдлыг харгалзан үздэг болохыг илтгэж байна. Гэвч хүн бүр тэдгээр цөөн тооны газруудад үйлчлүүлэх магадлал бага, мөн зөвхөн ариун цэврийн өрөөг ашиглах зорилгоор тухайн газруудад нэвтрэх боломжгүй учраас төдийлөн нээлттэй биш юм.

Мөн үүнээс гадна ариун цэврийн өрөөний асуудал бол зөвхөн тэргэнцэртэй иргэдэд тулгардаг асуудал биш гэдгийг бид санах хэрэгтэй. Нийслэлийн захын дүүргүүд, гэр хорооллуудад нийтийн ариун цэврийн газрын тоо хэмжээ хүртээмжгүй байдгаас иргэд байшин, барилга, хашааны булан тохойд задгай бие засах, ариун цэврээ сахих үүднээс нойтон алчуур ихээр хэрэглэх зэрэг нь орчны бохирдол, хог хаягдлын хэмжээ нэмэгдэх нэг эх үүсвэр болдог билээ. Тэгвэл энэ асуудлыг нэг дор шийдэж болох хамгийн зөв арга нь бүх төрлийн барилга, байгууламжийн ариун цэврийн өрөөг шийдэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд тохирсон, хүртээмжтэй, хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран бүх иргэд чөлөөтэй ашиглаж болохуйц байдлаар шийдэх явдал юм. Хэрэв тухайн байгууламжийн ариун цэврийн өрөө дотроо нийтэд зориулсан олон тооны нойлын бүхээгтэй бол дор хаяж нэг бүхээгийг хөгжлийн бэрхшээлтэй хүний стандартад нийцүүлэн тохижуулах нь зүйтэй. Өөр нэг томоохон шийдэл бол хотын захын хорооллуудын тодорхой цэгүүдэд, автобусны буудалд ойрхон эрэгтэй, эмэгтэй 2 бүхээг бүхий нийтийн нойлуудыг төлөвлөж барих явдал юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусдаа бүхээгийн оронд “Монгол Улсын Барилгын дүрэм - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох дүрэм БД 31-112-11”-ын “3.8. Ариун цэврийн өрөө” бүлэгт заасанчлан угаалтуур, хатаагч, бариул, унтраалга зэргийг тохирсон өндөрт байрлуулж, хананы бариул, гишгүүр зэрэг нэмэлт тоноглолыг шийдсэн эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн өрөөний түгээмэл загварыг хэрэглээнд нэвтрүүлэхэд хангалттай юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүний урхийн тухай хууль: 4.1.4. “түгээмэл загвар” гэж нэмэлт тохиргоо, тусгай загвар шаардахгүйгээр бүх хүн ашиглахад тохиромжтой, энгийн бүтээгдэхүүн, программ, орчин болон үйлчилгээний хэв маягийг хэлнэ.

Үүний үр дүнд гэр хорооллуудад ил задгай бие засах тохиолдлууд буурахаас гадна иргэдийн нойтон алчуурын хэрэглээ багасч хогоо хаях цэгүүд нэмэгдсэнээр орчны бохирдлыг тодорхой хэмжээнд бууруулна гэж үзэж байна. Мэдээж хэрэг энэхүү судалгааны

гол зорилго болсон гэр хороололд амьдардаг эсвэл гадуур яваа тэргэнцэртэй иргэд чөлөөтэй ашиглах боломж нээгдэх юм. Уг хүртээмжтэй ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ, арчилгаа болон бүрэн бүтэн байдлыг ойролцоох байгууллагын жижүүр, дэлгүүр, мухлагийн эздэд гэрээ байгуулан хариуцуулах замаар хянах боломжтой. Гэхдээ ийм төрлийн нийтийн ариун цэврийн газар нь хотын зах, гэр хорооллуудын автобусны буудалтай ойролцоо төлөвлөгдвөл тохиромжтой боловч хотын төвд олон тооны нийтийн ариун цэврийн газрыг барих нь төдийлөн зөв төлөвлөлт биш юм. Энэ тохиолдолд ойролцоогоор 2км тутамд нэг нийтийн ариун цэврийн өрөөний түгээмэл загвар байхаар, тэгэхдээ хотын төвд үйл ажиллагаа явуулж байгаа, гадна талаасаа тэргэнцэртэй хүн ороход хүртээмжтэй тохижуулагдсан объектуудын нэг эсвэл В1 давхарт байхаар шийдэж өгвөл энгийн болон хөгжлийн бэрхшээлтэй нийт иргэдэд нээлттэй, мөн хотын төвийн өнгө төрхөнд сөргөөр нөлөөлөхгүй байх юм.

Ашигласан ном зүй, эх сурвалж

1. Монгол Улсын Барилгын Дүрэм – Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох дүрэм, БД., 31-112-11 нүүр
2. Хүн бүрт ээлтэй хот – Түгээмэл хөгжил бие даан амьдрах төв, Баянгол дүүрэг ЗДТГазар., 2020 он.
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа, УБ., 2019 он
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хууль 2016
5. Estandard.gov.mn

Хавсралт

Хүүрнэх аргаар хийсэн судалгааны ярилцлагын тэмдэглэл

Иргэн Э 33 настай:

2014 оноос хойш катетер ашиглаж байгаа. 20-25 хоногтоо нэг удаа сольж шинийг хэрэглэдэг бөгөөд өдөртөө хэр их шингэн зүйл ууснаасаа хамаараад хэдэн удаа суллаж асгах нь ялгаатай байдаг. Удаан хугацаанд хэрэглэснээс болж бөөрний үйл ажиллагаанд нөлөөлөх, шээсэнд тундас үүсэх зэргээс болж зарим тохиолдолд 15 хоног хэрэглээд шинээр сольдог. Гуурс нь маш нарийхан байдаг учраас шээсэнд тундас их хэмжээгээр үүсвэл дотор талд нь амархан өнгөр тогтож шээс гадагшлах боломжгүй болдог. Анх хэрэглэж байхдаа өрхийн эмнэлэгт очиж эсвэл түргэн дуудаж солиулдаг байсан. Гэхдээ зарим түргэний эсвэл өрхийн эмч нар катетер сольж чаддаггүй байх тохиолдол гардаг болохоор сүүлдээ өөрөө сольчихдог болсон. Миний хувьд катетер хэрэглэхэд тулгардаг хамгийн том хүндрэлүүд гэвэл үргэлж доороос татах, зүүгдэх мэдрэмж төрдөг. Тэрнээс гадна үрэвсэх тохиолдол маш элбэг байдаг. Уг нь катетер хэрэглэж байгаа бол дор хаяж долоо хоногт нэг удаа зориулалтын уусмалаар ариутгаж цэвэрлэж байх ёстой байдаг боловч тэгэж цэвэрлэгээ халдваргүйжүүлэлт хийхэд заавал өөр нэг хүний тусламж шаардлагатай болдог, ажлаас гадуурх чөлөөт цаг бага байдаг зэргээс болоод бараг хийж чаддаггүй. Үрэвссэн тохиолдолд аль болох хөдөлгөхгүй байх эсвэл хэвтэх нь эдгэрэлтэд илүү дээр нөлөөлдөг. Катетерийг

удаан хугацаагаар хэрэглэсэн хүмүүсийн ихэнх нь үрэвсэл болон бусад хүндрэлээс болоод давсгаа цоолуулж катетер суулгуулах нь элбэг байдаг.

Хүндээр бие засахын тулд эм ууж төлөвлөж байгаад ариун цэврийн өрөө ашигладаг. Мөн түүнээс гадна катетерээр дамжаад шээсний саванд хуримтлагдсан шингэнийг суллаж асгахын тулд мэдээж хэрэг нойлын өрөө ашиглах шаардлагатай болдог. Тэр үед тулгардаг хамгийн гол хүндрэл бол ихэнх албан байгууллага, нийтийн үйлчилгээний газруудын нойлын өрөөний хаалга нь тэргэнцэр багтахааргүй нарийхан байдаг. Багтаад дотогш орлоо гэхэд тэргэнцэрээ эргүүлж гарах хангалттай зай байдаггүй. Нойлын өрөөний суултуурыг ашиглахад хамгийн чухал хэрэгсэл бол зориулалтын бариул. Гэвч томоохон зочид буудлууд, ресторан болон сүлжээ дэлгүүрүүдээс бусад ихэнх газрын нойлын өрөө бариулгүй дээрээс нь тухайн хүн санамсаргүй байдлаар уналаа гэхэд гадаах хүмүүст мэдэгдэж дуудах яаралтай тусламжийн хонх байдаггүй. Мөн хогийн сав, нойлын цаас гэх мэт хэрэгслүүдийг гарт ойрхон байрлуулж өгөх нь чухал. Зарим тохиолдолд почки нь суултуурынхаа ар хэсэгт байрласнаас болон товчлуур нь дарахад хүч их шаарддаг учраас усаа татахад төвөгтэй байх нь бий. Почкины товч хатуу дарахад хүч их шаарддагтай адил зарим нойлын хаалгыг хааж нээхэд хэтэрхий хүнд байдаг. Эдгээрээс гадна угаалгын өрөөний угаалтуур болон гар хатаагч зэрэг нь хүрэхэд хүндрэлтэй, өндөр байрласан газрууд маш олон бий. Энэнтэй хамт яригдах өөр нэг зүйл нь угаалтуурт гараа угаахын тулд хөл маань доогур нь хангалттай багтаж байх нь тохиромжтой байдаг.

Энэ мэтчилэн зүйлс хүртээмжтэй тохижуулагдаагүйгээс болоод гадуур явахдаа нийтийн үйлчилгээний газруудын ариун цэврийн өрөөг аль болох ашиглахгүй байхыг хичээдэг. Хамгийн сайн тохижилттой газар гэвэл Holiday In зочид буудал гэж бодож байна. Мөн Япон, Солонгос гэх мэт өндөр хөгжилтэй орнуудын олон улсын нисэх онгоцны буудлууд дээд зэргийн хүртээмжтэй байдаг. Миний хувьд гэрийнхээ угаалгын өрөөг тохижуулахдаа суултуур болон ваньныхаа дэргэдэх хананд бариул тогтоож өгсөн. Хэдийгээр яг зориулалтын нэмэлт тоног хэрэгсэл биш боловч өөрийнхөө гэрийн ариун цэврийн өрөөг бие даан ашиглахад маань том дэмжлэг болдог.

Иргэн У 35 настай:

Катетер хэрэглэж эхлээд дөрвөн жил болж байна. Тэрнээс өмнө живх хэрэглэдэг байсан. Гэхдээ живх байнга хэрэглэх нь гадуур явж байгаад солих шаардлага гарах үед чөлөөтэй ашиглах хүртээмжтэй нойл байдаггүй, үүнээс үүдээд удаан хугацаанд нойтон явах, улмаар арьсанд улайлт бий болох, түлэгдэх зэрэг сөрөг үр дагаварууд их гардаг байсан нь ус болон бусад шингэн зүйл уухаа хязгаарлахад хүргэдэг байсан. Харин катетер буюу гуурс хэрэглэж эхэлснээр үргэлж хуурай, арьс улайж түлэгдэхгүй, цаашлаад уух зүйлсээ хязгаарлах шаардлага гарахаа больсон. Мөн түүнээс гадна эдийн засгийн хувьд ч хэмнэлттэй тусдгаараа давуу талтай. Барагцаалаад үзвэл арван ширхэг живхийг өдөрт хоёр эсвэл гурван удаа сольж, хоёроос гурван өдөр ашиглаад дуусна. Тэгвэл хоёроос гурван өдрийн хэрэглээний живхний мөнгөөр нэг катетер худалдаж аваад ойролцоогоор хорин нэг хоног хэрэглэх боломжтой болж байгаа юм. Гэвч мэдээж хэрэг өөр бусад сөрөг талууд ч бий. Жишээлбэл, удаан хугацаанд хэрэглэснээс болж бөөр нурууны өвчин, давсагны үрэвсэлтэй

болж болно. Зохих журмынха дагуу бол эмнэлэгийн орчинд сольж байх ёстой боловч цаг авах, оочер дараалал гэх мэт бэрхшээлүүдээс болоод гэртээ сольдог. Хүндээр бие засахад эм хэрэглэж төлөвлөж байгаад ариун цэврийн өрөө эсвэл зориулалтын эвхдэг суултуур ашигладаг боловч хүзүү нугасны гэмтлээс үүдсэн дөрвөн мөчний саажилттай хүмүүсийн хувьд суултуур дээр бие даан суухад хүндрэлтэй. Тиймээс эдгээр тохиолдлуудад өөр хүний тусламж эсвэл найдвартай тоноглогдсон нэмэлт бариул, түшлэг гэх мэт зүйлс зайлшгүй хэрэг болно. Хэдийгээр суултуурт сууж ашиглах шаардлагагүй байлаа ч шээсний уутанд хуримтлагдсан шингэнийг суллаж асгахад нойлын өрөө заавал ашиглах хэрэгтэй байдаг. Энэ үед нойлын хаалгаар тэргэнцэр багтахгүй байх, дотогш ороод тэргэнцэр эргэх зайгүй байх зэрэг шалтгаануудаас болоод тухайн нойлын өрөөг ашиглах боломжгүй болдог.

Иргэн Т 31 настай:

Би өөрийн гэрийн нойлын өрөөг бие даан ашиглахад хүртээмжтэй болгохын тулд ухаалаг суултуур авч суурьлуулсан. Уг суултуур нь усаа автоматаар татахаас гадна, угаах, хатаах зэрэг маш олон төрлийн үйлдлүүдтэй байдаг нь их тус болдог. Миний бодлоор энэ төрлийн суултуур нь хагас болон бүрэн мэдээ алдалттай хүмүүст нойл ашиглахад тулгардаг ус татах, арчих гэх мэт хүндэрлүүдийг нэлээн сайн хөнгөлж өгнө. Улаанбаатар хотод байгаа миний сайн мэддэг хүртээмжтэй нойл гэвэл Blue Sky, Holiday8 Shangri La зэрэг томоохон зочид буудлууд болон сүүлд баригдсан E-mart гэх мэт томоохон сүлжээ дэлгүүрүүдийн нойлын өрөө юм. Тэрнээс гадна суултуурт суухад түшүүрэгтэй түшлэг, бариул, мөн хөлөө тавьж тэнцвэрээ хадгалах гишгүүр зэрэг зүйлсийг шийдэж өгвөл нойлын өрөө илүү хүртээмжтэй ямар ч төрлийн тулгуур эрхтний бэрхшээлтэй хүн ашиглах боломжтой болно гэж бодож байна.

Иргэн М 30 настай:

Гадуур явж байх үедээ хааяхан байгууллага, үйлчилгээний газрын ариун цэврийн өрөөг гуйж ашигладаг. Зарим нь оруулахаас татгалздаг. Тиймээс гадуур гарахдаа уух зүйлээ багасгах, хязгаарлах тохиолдол гардаг. Хэдий зарим нь зөвшөөрөөд оруулдаг ч гэсэн нойлын өрөөний хаалга нь тэргэнцэртэйгээ ороход тохиромжгүй, доторх зай нь эргэхэд хүндрэлтэй, зориулалтын бариул, нэмэлт тоноглол байхгүй байх нь элбэг. Ер нь бүх зүйл хүртээмжтэй тохижуулагдсан нойлын өрөөтэй газар тун ховор байдаг. Жишээлбэл, зай талбай томтой байлаа гэхэд зориулалтын бариул байдаггүй. Баирул суурьлуулсан мөртлөө тэргэнцэр орох боломжгүй гэх мэт. Миний бодлоор цэцэрлэг хүрээлэн, парк, автобусны буудал гэх мэт явган хүн олноор зорчдог газруудад нийтэд зориулсан ариун цэврийн өрөө, хогийн сав гэх мэт шаардлагатай зүйлсийг түгээмэл байлгавал зүгээр санагдаг.

Би өөрөө хөдөө орон нутгийн хүн. Гэртээ байхдаа үргэлж зөөврийн сав, суултуур ашигладаг. Тэгээд цэвэрлэж асгах шаарлагатай үед бусдын тусламжийг авдаг. Энэ нь үргэлж хүний тусламж авахад хүргэдэг учраас хүндрэлтэй байдаг. Нийгмийн халамжаас гурван жилд нэг удаа үнэгүй авдаг тусгай хэрэгсэл дунд бие даан бие засахад зориулагдсан эвхдэг тэргэнцэр байдаг тухай урьд нь сонсож байгаагүй юм байна. Ганцхан удаа халамжийн хүрээнд тэргэнцэр авч байсан. Миний хувьд эвхэж цэгцлээд аваад явчихдаг,

гадаа модон жорлон, эсвэл газарт нүх ухаж бэлтгээд дээр нь ашиглаж болдог зөөврийн нойлтой байсан бол гэж их боддог. Хөдөө орон нутагт бол хүртээмжтэй нойлын тухай ярих нь битгий хэл тэргэнцэртэй явахад ч хүндрэлтэй зүйл их бий.

Иргэн М 22 настай:

Миний хувьд ихэнх тохиолдолд суга таяг ашиглаж явдаг. Хэдийгээр тэргэнцэр хэрэглэдэг боловч тэргэнцэртэй байх нь замын боржур давах, налуу замын хүртээмжгүй байдлаас болоод илүү олон хүндрэл дагуулдаг. Цаашлаад ариун цэврийн өрөө ашиглахад тэргэнцэр багтахгүй байх, дотор нь эргэх зай хангалттай биш, гэмт өөр асуудлууд ч бий. Эдгээрээс болоод аль болох таяг хэрэглэхийг илүүд үздэг. Гэхдээ хэдий таягтай ч гэсэн тулгардаг хүндрэлүүд бий. Жишээлбэл, цүнх, таяг гэх мэт зүйлсээ тогттох өлгүүр байдаггүй. Байсан ч хэт өндөрт байрладаг. Мөн зарим газрын хогийн сав, нойлын цаас зэрэг нь хүрэхэд тохиромжгүй буюу хол зайд байх нь элбэг. Тэрнээс гадна суултуурт суух үед суултуурын дээд хэсгийн нэмэлт зөөлөвч хазайх, салж унах гэх мэт асуудал үүсдэг. Мөн усаа татахын тулд эргэж харах нь хүндрэлтэй байдаг учраас зайлшгүй боссоныхоо дараа эргэж татах шаардлагатай болдог. Би өөртөө тохируулан гэрийнхээ нойлын өрөөний шалыг хальтрахгүй материалаар бүрж, нойлын цаас, хогийн сав гэх мэт хэрэгслээ гарт ойрхон байрлуулдаг.

ХҮҮХДИЙН ТӨВ СУВИЛЛЫН СЭРГЭЭН ЗАСАХ АМБУЛАТОРИЙН ТАСГИЙН ХЯНАЛТАНД ХАМРАГДСАН ХҮҮХДҮҮДИЙН НИЙГМИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА

Р.Отгонсайхан, Х.Циендолгор, Н.Баяржаргал

Үндэслэл

Статистик үзүүлэлтийн 2017оны мэдээллээр Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй 103.6 мянган иргэн (нийт хүн амын 3.3 хувь) байгаагийн 44384 буюу 42.8 хувь нь төрөлхийн, 59246 буюу 57.1 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна. Тэднээс 0-14 насны хүүхэд 8 835, 14-17 насны хүүхэд 2618 байна.

“Хүн амын амьжиргааны доод түвшин гэдэг нь хэрэглээний доод хэмжээг мөнгөн хэлбэрээр илэрхийлснийг хэлнэ” гэж Монгол Улсын хуулинд заасан байдаг. Хэрэглээний доод хэмжээ гэдэг нь хүний нэн тэргүүний зайлшгүй хэрэгцээг хангах хүнсний болон хүнсний бус хэрэглээний сагсаар тодорхойлсон бараа, үйлчилгээний тоо хэмжээ байдаг. Нийгмийн халамжийн сангийн тэтгэвэрийн доод хэмжээ 243000 төгрөг байгаа нь нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр авч байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой амьдарч байна.

Монгол улсын үндэсний статистикийн хорооноос амьжиргааны доод түвшинг бүс нутгаар авч үзсэн бөгөөд Улаанбаатар хотын хувьд өрхийн 1 хүнд оногдох орлогын доод хэмжээ 185300/196000 төгрөг тогтоогдсон байна.

2017 оноос Хүүхдийн төв сувиллын сэргээн засах амбулаторийн тасгаар тархины саажилттай, хөдөлгөөний хоцрогдолтой, Дауны хам шинжтэй хүүхдүүдийг хяналтанд авч эмчилгээг графикаар хийж эхэлсэн. Эмчилгээний явцад эцэг эхчүүд хүүхдээ эмчилгээнд бүрэн хамруулахгүй, хүүхэд өвдөх, гэр хол, унааны мөнгө байхгүй гэх мэт тохиолдлууд байсан. Ар гэрийн байдал боломжтой эцэг эхчүүд хүүхдээ эмчилгээнд тогтмол цагтаа авч ирдэг, харин боломж муутай эцэг эхчүүд хүүхдийнхээ эмчилгээг тасалдаг байдал ажиглагдсан. Зарим тохиолдолд удаа дараа утсаар дуудуулдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх судалгаа олон байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийг судалсан материал ховор байна.

Түлхүүр үг: хөгжлийн бэрхшээл, тархины саажилт, хөдөлгөөний хоцрогдол, Дауны хам шинж

Зорилго

Хүүхдийн төв сувиллын сэргээн засах амбулаторийн тасагт хяналтанд эмчлүүлж байгаа хүүхдүүдийн эцэг эхчүүдийн нийгмийн байдлыг судлах

Зорилт

1. Хүүхдийн төв сувиллын сэргээн засах амбулаторийн тасгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдийн нийгмийн байдлын талаар судалгаа авч, үнэлгээ өгөх
2. Амьдралын нөхцөл, өрхийн орлого, харьяалал зэрэг нь хоорондоо хамааралтай эсэхийг судлах

Судалгааны арга аргачилал

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Судалгаанд хяналтын 67 хүүхдийн эцэг эхээс нийгмийн байдлын талаар асуумж авч агшингийн судалгаа хийж, SPSS-25 программ ашиглан статистик боловсруулалт хийлээ.

Судалгааны ажлын үр дүн


Хүүхдийн төв сувиллын сэргээн засах амбулаторийн тасгийн хяналтанд нийт 126

хүүхэд хамрагддаг. Үүнээс судалгаанд 67 /53%/ хүүхдүүдийн эцэг эхтэй холбогдож асуумж авлаа.

Судалгаанд хамрагдсан 67 хүүхдийн эрэгтэй 42 /62.7%, эмэгтэй 25 /37,3% байлаа. Насны байдлаас авч үзэхэд хамгийн бага нь 1наснаас доош хүүхэд 3 /4,5% , 1-2настай 20 / 29,9%, 2н1с-3настай 19 / 28,4%, хамгийн их 3-аас дээш насны хүүхэд 25/ 37,3% байлаа.

Оношийн бүлгээр харахад хүүхдийн тархины саажилт хамгийн өндөр 47/68,7% байсан бол хамгийн бага нь Дауны хам шинж 8/11,9%, хөдөлгөөний хоцрогдол 13 /19,4% тус тус гарлаа.


(Зураг 1)



	Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
хөдөө	10	14.9	14.9	14.9
СХД	19	28.4	28.4	43.3
БЗД	10	14.9	14.9	58.2
БГД	13	19.4	19.4	77.6
ЧД	6	9.0	9.0	86.6
ХУД	7	10.4	10.4	97.0
СБД	2	3.0	3.0	100.0
Total	67	100.0	100.0	


Зураг 1. Оношийн бүлгээр

Хөдөө орон нутгаас 10 /14,9% хүүхэд хамрагдсан байна. Дүүргүүдээс хамгийн олон хамрагдсан нь СХД 19 /28,4% байсан ба хамгийн цөөн нь СБД 2 /3% байлаа. Хөдөө орон нутгаас 14,9% хүүхэд хамрагдсан нь тус сувилал нь улсын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг нь харагдаж байна. (Зураг 2)




Зураг 2. Харьяаллын бүлгээр

Цалингийн доод хэмжээ 310.000төг байдаг ба хүүхдийн төв сувиллын хяналтын хүүхдүүдийн 11 нь ямар ч орлогогүй, эцэг эх нь ажилгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн аль нэг нь ажил эрхлэх боломжгүй хүүхдээ асарч гэртээ байдаг нь өрхийн орлогод нөлөөлдөг байна.(Зураг 3, 4)



Зураг 3. Өрхийн орлогын байдлаар




Зураг 4. Өрхийн нэг хүнд ноогдох орлогын байдлаар

Өрхийн орлогын байдлаас харахад Монгол улсын үндэсний статистикийн хорооноос амьжиргааны доод түвшин Улаанбаатар хотын хувьд өрхийн 1 хүнд оногдох орлогын доод хэмжээ 196.000 төгрөг бол бидний судалгаагаар орлогогүй 11 /16,4%, 196.000т хүртэлх 30/ 44,6%, 196-300.000т 9/ 13,4%, 301-500.000т 12/ 17,9%, 501.000т дээш 5/ 7,5% байлаа. Энэ нь судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн гэр бүлийн 41 буюу 61,2% нь өрхийн орлогын нэг хүнд ноогдох орлогын түвшинд хүрэхгүй байгааг харуулж байна.


“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Түүнчлэн гэр бүлийн байдлыг судлахад эцэг эхтэйгээ хамт байдаг 55 /82,1% хүүхэд, эх нь ганцаараа асардаг 8 /11,9%, эцэг нь ганцаараа асардаг 3/ 4,5%, эмээ өвөө дээрээ байдаг 1/1,5% хүүхэд гэж гарсан байна. Үүнээс харахад 12 /17,9% хүүхэд хагас болон бүтэн өнчин байгаа нь амьжиргааны түвшинд сөргөөр нөлөөлж байна.. (Зураг 5)



Зураг 5. Гэр бүлийн байдлаар

Харьяалал ба ахуйн нөхцөл хоорондоо хамааралтай эсэхийг харахад орон сууцанд амьдардаг хүүхэд 39 / 58,2% ихэнх хувийг эзэлж байгаа ба гэрт 13 /19,4%, гэр хорооллын хашаа байшинд 14 /20,9%, бусад буюу нийгмийн халамжийн байранд 1 /1,5% гэсэн байна. Үүнээс орон сууцанд амьдардаггүй хүүхдүүд цөөнгүй хувь эзэлж 28 /41,8% байгаа нь анхаарал татаж байна. (Зураг 6, 7, 8)



Зураг 6. Харьяалал ба ахуйн нөхцөлийн байдлаар

Зураг 7. Орлого ба ахуйн байдлаар нөхцөлийн байдлаар

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”



Зураг 8. Харьяалал ба өрхийн орлогын байдлаар

Корреляцийн коэффициент нь $p=0.01$ өрхийн орлого ба ахуй нөхцөл, өрхийн орлого ба гэр бүлийн байдал эерэг, сул хамааралтай гэж гарсан байна. (хүснэгт 1, 2)

		өрхийн орлого	нөхцөл
өрхийн орлого	Pearson Correlation	1	-.376**
	Sig. (2-tailed)		0.002
	N	67	67
нөхцөл	Pearson Correlation	-.376**	1
	Sig. (2-tailed)	0.002	
	N	67	67

Хүснэгт 1.

		өрхийн орлого	гэр бүлийн байдал
өрхийн орлого	Pearson Correlation	1	-.402**
	Sig. (2-tailed)		0.001
	N	67	67
гэр бүлийн байдал	Pearson Correlation	-.402**	1
	Sig. (2-tailed)	0.001	
	N	67	67

Хүснэгт 2.

Хүүхдийн нас ба өвчний оношийн утга $P \geq 0.05$ гэж байгаа нь бидний судалгаа $P=0.1$ гарсан нь хүүхдийн онош нь настай хамааралтайг үгүйсгэж байна. (Хүснэгт 3)

Харин өрхийн орлого ба гэр бүлийн байдал утга $P=0.001$ гарсан нь өрхийн орлогод гэр бүлийн байдал хамааралтай гэсэн таамаглал үнэн гэдгийг баталлаа. (Хүснэгт 4)

	Value	df	Asymptotic Significance (2-sided)
Pearson Chi-Square	9.804 ^a	6	0.133
Likelihood Ratio	12.175	6	0.058
Linear-by-Linear Association	2.62	1	0.106
N of Valid Cases	67		

Chi-Square Tests			
	Value	df	Asymptotic Significance (2-sided)
Pearson Chi-Square	34.317a	12	0.001
Likelihood Ratio	28.652	12	0.004
Linear-by-Linear Association	7.109	1	0.008
N of Valid	67		

Хүснэгт 3.

Хүснэгт 4.

Дүгнэлт

1. Судалгаанд хамрагдсан 67 хүүхдийн эрэгтэй нь эмэгтэйгээсээ олон байлаа. Насны байдлаас авч үзэхэд хамгийн их 3-аас дээш насны хүүхэд 25/ 37,3% байлаа. Хөдөө орон нутгаас цөөн хүүхэд хамрагдсан байгаа нь зардал мөнгө байхгүй, хол байгаатай холбоотой байх магадлалтай байна.
2. Оношийн бүлгээр авч үзэхэд тархины саажилттай хүүхдүүд хамгийн их 47/68,7% байна.
3. Хүүхдийн төв сувиллын хяналтын хүүхдүүдийн 11/16,4% нь эцэг эх нь ажилгүй, ямар ч орлогогүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн аль нэг нь ажил эрхлэх боломжгүй хүүхдээ асарч гэртээ байдаг нь өрхийн орлогод нөлөөлдөг байна. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 41 буюу 61,2% нь өрхийн орлогын нэг хүнд ноогдох орлогын түвшинд хүрэхгүй байгаа гэр бүлд өсөж байна.



6

ЭРҮҮЛ МЭНД

**ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДАЛТЫГ ТОГТООХОД ОЛОН УЛСЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ АНГИЛЛЫГ (ICF)**

АШИГЛАХ НЬ: ICF – BSSQ

Э.Насантогтох¹, С.Оюударь², Ц.Тэмүүлэн² Г.Маралгуа², Б.Марал², М.Лхамсүрэн²,

П.Батсүх³ С.Мөнхзаяа³, Б.Ариунтунгалаа³

¹Зайгал Судалгааны Институт ТББ, ²АШУУИС, Анагаах Ухааны Сургууль,

³Хавдар Судлалын Үндэсний Төв

Хураангуй

Хөхний хорт хавдрын эмчилгээ тусламж үйлчилгээ сайжирснаар хавдрын дахилт, хүндрэл, нас баралтын эрсдэлийг бууруулж, амьдрах хугацаа нэмэгдсэн. Тиймээс амьдралын чанар, өвчлөлийн шалтгаант хөдөлмөрийн чадвар алдалтыг үнэлэх асуудал нэн чухал болж байна. Хөдөлмөрийн чадвар алдалтын үнэлгээний хүчин төгөлдөр, найдвартай байдал нь зөвхөн хөхний хорт хавдар төдийгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд тулгамдаж буй асуудлуудын нэг юм. Хөдөлмөрийн чадвар алдалтыг Олон улсын өвчний ангилал (ICD) ба Олон улсын Үйл ажиллагааны ангиллаар тогтоож байна. Хөдөлмөрийн чадвар алдалтыг ICD-10 нь өвчний оношоор, ICF нь өвчтөний үйл ажиллагааны алдагдлаар ангилдаг. ДЭМБ-аас хөдөлмөрийн чадвар алдалтыг үнэлэхдээ ICD болон ICF-ыг хослуулан ашиглахыг зөвлөж байна. Олон улсын судлаачид ICF-ын үнэлгээг тухайн үндэстэн улс орны онцлогт тохируулах зорилгоор нарийвчлан үнэлэхийг зөвлөж байна. Тиймээс бид хөхний хорт хавдар оношлогдсон эмчлүүлэгчдийн хөдөлмөрийн чадвар алдалтыг Олон улсын Үйл ажиллагааны ангилал(ICF)-ыг ашиглан үнэлж асуумжийн найдвартай байдлыг тодорхойлохыг зорилгоо. Судалгааг аналитик судалгааны агшны загвараар 2020.10 – 11 сарын хооронд Хавдар Судлалын Үндэсний Төвийг түшиглэн хийж гүйцэтгэв. Судалгааны түүвэр хүн амыг магадлалт бус зорилтод түүврийн аргаар судалгаанд оруулах ба хасах шалгуурыг баримтлан бүрдүүлсэн. Судалгаанд оролцогчийн Үйл ажиллагааны алдагдлыг олон улсын стандарт “BCSQ-BC” асуумжаар тодорхойлсон. BCSQ-BC асуумж нь ICF үнэлгээний үндсэн хэсэг бөгөөд хөхний хорт хавдартай эмчлүүлэгчийн үйл ажиллагааны алдагдалтай холбоотой сүүлийн 30 хоногт тохиолдсон асуудлыг тодорхойлох 3 бүлэг 40 асуулттай. Судалгааны статистик боловсруулалт R 3.2, IBM SPSS 26.0 программыг ашиглан хийж гүйцэтгэсэн. ICF – BSSQ асуумж үйл ажиллагааны алдагдлыг 0.91, биеийн бүтцийн алдагдлыг 0.83, нийгмийн оролцооны асуудлыг 0.90 хүрээлэн буй орчноос үүдэх асуудлыг 0.79 буюу найдвартай тодорхойлж байна. Хөхний хорт хавдрын дараах үйл ажиллагааны алдагдал дунджаар 39.2 хувь, бүтцийн алдагдал 40 хувь буюу ICD үнэлгээнээс харьцангуй бага тодорхойлож байгаа нь хөдөлмөрийн чадвар алдалтыг зөвхөн өвчний оношоор тогтоох нь сул үүсгэхийг харуулж байна. Хөхний хавдрын дараах нийгмийн оролцоо, идэвх болон хүрээлэн буй орчны дэмжлэг туслалцааг үнэлж хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох нь зүйтэй байна.

Удиртгал

Дэлхий дахинд эмэгтэйчүүдийн хөхний хорт хавдрын тохиолдлын тоо өсөн нэмэгдэж байна [1]. Хөхний хорт хавдрын эмчилгээ тусламж үйлчилгээ сайжирснаар хавдрын дахилт, хүндрэл, нас баралтын эрсдэлийг бууруулж, амьдрах хугацаа нэмэгдсэн[2]. Тиймээс амьдралын чанар, өвчлөлийн шалтгаант хөдөлмөрийн чадвар алдалтыг үнэлэх асуудал нэн чухал болж байна. Хөхний хавдар оношлогдсон эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн чадвар тодорхой хэмжээгээр алдагдаж амьдралынхаа турш бие махбод, сэтгэл зүй, нийгмийн асуудалтай тэмцэх шаардлагатай болдог [3]. Хөхний хавдрын мэс заслын дараа эмчлүүлэгчид тодорхой хэмжээгээр хөдөлмөрийн чадвар алдагддаг. Тиймээс хөдөлмөрийн чадвар алдалтыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тогтоох нь нэн чухал асуудал юм.

Хөдөлмөрийн чадвар алдалтын үнэлгээний хүчин төгөлдөр, найдвартай байдал нь зөвхөн хөхний хорт хавдар төдийгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд тулгамдаж буй асуудлуудын нэг юм. Хөдөлмөрийн чадвар алдалтыг Олон улсын өвчний ангилал (ICD) ба Олон улсын Үйл ажиллагааны ангиллаар тогтоож байна. Хөдөлмөрийн чадвар алдалтыг ICD-10 нь өвчний оношоор , ICF нь өвчтөний үйл ажиллагааны алдагдлаар ангилдаг. ДЭМБ-аас хөдөлмөрийн чадвар алдалтыг үнэлэхдээ ICD болон ICF-ыг хослуулан ашиглахыг зөвлөж байна[4 -5]. Манай улсад хөдөлмөрийн чадвар алдалтыг ICD болон ICF-ыг хослуулсан ашиглахыг зөвшөөрсөн боловч одоогоор зөвхөн өвчний оношинд суурилж үнэлгээг хийж байна. ICF нь өвчтөний нийгэм эдийн засаг, сэтгэл зүйн байдлыг цогцоор үнэлж хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг тогтоодог[7 -8]. Тухайлбал, биеийн бүтэц, биеийн үйл ажиллагааны өөрчлөлт, өвчтөний өдөр тутмын амьдралын нөхцөл байдал, түүнд оролцох чадвар, хүрээлэн буй орчин, хувь хүний хүчин зүйлсийн нөлөөллийг багтаасан байдаг [9]. ICF нь бүхэлдээ 1400 гаруй категориос бүрддэг бөгөөд эмнэл зүйн практикт практикт ашиглахад хялбар болгох үүднээс ICF гол багцыг боловсруулсан байна. Олон улсын судлаачид ICF-ын үнэлгээг тухайн үндэстэн улс орны онцлогт тохируулах зорилгоор нарийвчлан үнэлэхийг зөвлөж байна. Тиймээс бид хөхний хорт хавдар оношлогдсон эмчлүүлэгчдийн хөдөлмөрийн чадвар алдалтыг Олон Улсын Үйл ажиллагааны ангилал(ICF)-ыг ашиглан үнэлж асуумжийн хүчин төгөлдөр, найдвартай байдлыг тодорхойлохыг зорилоо.

Зорилго

Хөхний хорт хавдар оношлогдсон эмчлүүлэгчдийн хөдөлмөрийн чадвар алдалтыг үнэлэх Олон улсын Үйл ажиллагааны ангилал(ICF)-ын асуумжийн хүчин төгөлдөр, найдвартай байдлыг судлах.

Зорилт

1. Хөхний хавдар оношлогдсон эмчлүүлэгчдийн үйл ажиллагааны алдагдлыг тодорхойлох
2. Олон улсын Үйл ажиллагааны ангилал(ICF)-ын үнэлгээний асуумжийн хүчин төгөлдөр, найдвартай байдлыг тодорхойлох

Шинэлэг байдал

Олон улсын үйл ажиллагааны ангилал (ICF)-ийн хүчин төгөлдөр, найдвартай байдлыг хэсэгчлэн үнэлж, практикт ашиглах боломжийг тодорхойлсноор хөдөлмөрийн чадвар алдалтын зэргийг тогтооход ICD болон ICF -ийг хослуулан ашиглах шинжлэх ухааны суурь үндэслэлийг бүрдүүлнэ.

Ач холбогдол

1. Олон улсын үйл ажиллагааны ангиллын Олон улсын Өвчний ангилалтай нийцэх байдлыг тодорхойлох суурь судалгаа болно.
2. Практикт Олон улсын Үйл ажиллагааны ангиллыг ашиглагдах боломжийг тодорхойлж, үнэлгээг эхлүүлэх шинжлэх ухааны үндэслэлийг бүрдүүлнэ.
3. Хөдөлмөрийн чадвар алдалтын зэргийг ICD болон ICF -ийг хослуулан ашигласнаар иргэд өөрийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн туслам, үйлчилгээ авах боломж бүрдэнэ.

Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй

Судалгааг аналитик судалгааны агшны загвараар 2020.10 – 11 сарын хооронд Хавдар Судлалын Үндэсний Төвийг түшиглэн хийж гүйцэтгэв. Судалгааны түүвэр хүн амыг магадлалт бус зорилтод түүврийн аргаар судалгаанд оруулах ба хасах шалгуурыг баримтлан бүрдүүлсэн. Судалгаанд хөхний хорт хавдар эдийн шинжилгээгээр батлагдсан (а), мэс засал эмчилгээ хийлгэсэн (б), судалгаанд сайн дурын үндсэн дээр хамрагдахыг зөвшөөрсөн(в) 18-аас дээш насны эмэгтэйчүүдийг (г) хамруулсан. Судалгаанд оролцогчийн Үйл ажиллагааны алдагдлыг олон улсын стандарт “BCSQ-BC” асуумжаар тодорхойлсон. BCSQ-BC асуумж нь ICF үнэлгээний үндсэн хэсэг бөгөөд хөхний хорт хавдартай эмчлүүлэгчийн үйл ажиллагааны алдагдалтай холбоотой сүүлийн 30 хоногт тохиолдсон асуудлыг тодорхойлох 3 бүлэг 40 асуулттай. Нэгдүгээр бүлэг нь биеийн бүтэц,

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

үйл ажиллагааны алдагдлыг тодорхойлдог. Хоёрдугаар бүлэг нь өвчтөний идэвх, оролцоонд тулгарч буй асуудлыг үнэлдэг. Нэг болон хоёрдугаар бүлэгт асуудлыг ликертийн оноогоор хэмжих бөгөөд асуудалгүй (1), бага (2), дунд (3), их (4) гэж үзнэ. Судалгааны өгөгдлийг асуумжийн дагуу бэлтгэгдсэн судлаачид ганцаарчилсан ярилцлагаар цуглуулсан. Судалгааны статистик боловсруулалт R 3.2, IBM SPSS 26.0 программыг ашиглан хийж гүйцэтгэсэн. Дескриптив статистикийг тоон хувьсагчийн хувьд тархалтыг үнэлж хэвийн тохиолдолд дундаж стандарт хазайлтаар илэрхийлсэн. Категори хувьсагчдыг давтамж, хувиар илэрхийлсэн. Асуумжийн найдвартай байдлыг каппа тестээр үнэлсэн.

Судалгааны ажлын үр дүн

Судалгаанд 28 – 78 насны хөхний хавдар оношлогдсон 28 эмэгтэй хамрагдсан. Судалгаанд оролцогчдын дундаж нас 54 ± 11.2 , 39.9 хувь хөдөө орон нутгийн эмчлүүлэгч байв.

Хүснэгт 1.

Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн үзүүлэлт

Үзүүлэлт	Тоо	Хувь
Боловсролын түвшин		
Дунд	19	67.9
Дээд	9	32.1
Харьяалал		
Хөдөө орон нутаг	11	39.3
Улаанбаатар	17	60.7
Гэрлэлт		
Гэрлэсэн	25	89.3
Гэрлээгүй	3	10.7
Үе шат		
I, II	12	54.5
III	7	31.8
IV	3	13.6
Дахилт		

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

	Үгүй	25	89.3
	Тийм	3	10.7
Нийт		29	100.0

Олон Улсын Үйл Ажиллагааны Ангиллын (ICF - BSSQ) асуумжийн найдвартай байдал:

Хөхний хавдрын үеийн хөдөлмөрийн чадвар алдалтыг үйл ажиллагааны алдагдалд суурилан үнэлэх асуумжийн 4 бүлгийн үнэлгээний найдвартай байдал хангалттай байна. Тухайлбал кронбахын альфа коэффициент үйл ажиллагааны алдагдлыг 0.91, биеийн бүтцийн алдагдлыг 0.83, нийгмийн оролцооны асуудлыг 0.90, хүрээлэн буй орчноос үүдэх асуудлыг 0.79 буюу тогтвортойгоор тодорхойлж байна.

Хүснэгт 2.

“ICF – BSSQ” асуумжийн найдвартай байдал

Бүлэг	Үзүүлэлт	Кронбах
Үйл ажиллагааны алдагдал	11	0.91
Биеийн бүтцийн алдагдал	5	0.83
Нийгмийн оролцоо, идэвх	11	0.90
Хүрээлэн буй орчин	13	0.79

Үйл ажиллагааны алдагдал: Хөхний мэс заслын дараа судалгаанд оролцогчдын 62.5 хувьд үйл ажиллагааны алдагдалгүй болон бага байна. Мөн судалгаанд оролцсон хөхний хавдрын мэс засал эмчилгээ хийлгэсэн эмчлүүлэгчдийн үйл ажиллагааны алдагдал 21.9 – 72.8 хувь буюу дунджаар 39.6 хувь байна.

Хүснэгт 3.

Хөхний хавдрын мэс засал эмчилгээний дараах үйл ажиллагааны алдагдал:

Биеийн үйл ажиллагааны алдагдал					
Код	Асуудал	Үгүй	Бага	Дунд	Их
b280	Өвдөлт, зовиур	33.30%	37.00%	22.20%	7.40%
b710	Үений хөдөлгөөн	44.40%	14.80%	33.30%	7.40%
b455	Дасгал хөдөлгөө	51.90%	11.10%	29.60%	7.40%

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

b730	Булчингийн хүч	35.70%	21.40%	25.00%	17.90%
b435	Дархлааны хямрал	52.00%	24.00%	20.00%	4.00%
b640	Бэлгийн харилцаа	76.00%	4.00%	16.00%	4.00%
b152	Сэтгэл хөдлөл	46.20%	26.90%	15.40%	11.50%
b130	Хүсэл сонирхол, зорилгоо биелүүлэхэд учирч буй биеийн болон сэтгэл санааны бэрхшээл	42.30%	19.20%	26.90%	11.50%
b180	Өөрийгөө үнэлэх үнэлэмж	48.10%	11.10%	25.90%	14.80%
b126	Зан авир	40.70%	25.90%	29.60%	3.70%
b134	Нойрны бэрхшээл, өөрчлөлт	32.00%	28.00%	16.00%	24.00%

Бие махбодын бүтцийн алдагдал: Судалгаанд оролцогчдын 65.7 хувь нь мэс заслын дараах биеийн бүтцийн алдагдлыг бага гэж дүгнэжээ. Хөхний хавдрын дараах биеийн бүтцийн алдагдал 0.0 – 72.2 хувь, дунджаар 40.0 хувьтай байв.

Хүснэгт 4.

Хөхний хавдрын мэс засал эмчилгээний дараах бие махбодын бүтцийн алдагдал

Код	Асуудал	Үгүй	Бага	Дунд	Их
s810	Арьс	59.30%	25.90%	3.70%	11.10%
s720	Мөрний хэсэг	45.80%	20.80%	16.70%	12.50%
s730	Гарын хэсэг	38.50%	19.20%	26.90%	15.40%
s420	Дархлааны эрхтэн тогтолцоо	38.50%	26.90%	26.90%	7.70%
s630	Нөхөн үржихүйн эрхтэн	48.00%	32.00%	8.00%	12.00%

Нийгмийн оролцоо ба идэвхийн асуудал: Хөхний хавдрын мэс заслын дараа эмчлүүлэгчдийн 16.7 хувьд нийгмийн идэвх оролцооны ямар нэг асуудал үүсдэггүй, 83.3 хувьд тодорхой хэмжээнд асуудалтай тулгардаг байв. Нийгмийн идэвхтэй амьдрал, оролцооны асуудлын түвшин дунджаар 33.6 ± 2.5 хувь байв.

Хүснэгт 4.

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Хөхний хавдрын мэс засал эмчилгээний дараах нийгмийн оролцоо ба идэвх

Код	Асуудал	Үгүй	Бага	Дунд	Их
d445	Гар	55.60%	14.80%	18.50%	11.10%
d430	Мөр болон гар	26.90%	26.90%	26.90%	19.20%
d770	Хосын харилцаа	73.10%	11.50%	11.50%	3.80%
d240	Стресс болон сэтгэл зүйн ачааллыг зохицуулах чадвар	50.00%	23.10%	23.10%	3.80%
d760	Гэр бүлийн харилцаа	61.50%	15.40%	19.20%	3.80%
d230	Өдөр тутмын үйл ажиллагаа	56.0%	24.0%	12.0%	8.0%
d920	Чөлөөт цагаар хийдэг ажил, сонирхол	44.00%	24.00%	20.00%	12.00%
d850	Хөдөлмөр эрхлэлтийн байдал	46.20%	15.40%	7.70%	30.80%
d570	Өөрийн эрүүл мэндэд анхаарал тавих	53.80%	19.20%	15.40%	11.50%
d640	Өдөр тутмын үйл ажиллагаа	55.60%	11.10%	22.20%	11.10%
d510	Усанд орох	61.5%	15.4%	7.7%	15.4%

Хүрээлэн буй орчны асуудал: Хөхний хорт хавдрын мэс заслын дараах эмчлүүлэгчид төрийн бодлого, эрүүл мэндийн байгууллага, гэр бүлийн үзүүлж буй дэмжлэгийн түвшин дунджаар 26.0 хувьтай байна. Судалгаанд оролцогчдын 4.2 хувь хүрээлэн буй орчноос ямар нэг дэмжлэг авдаггүй, саад бэрхшээлтэй тулгардаг байна.

Хүснэгт 5.

Хүрээлэн буй орчин

Код	Асуудал	Бэрхшээл болдог	Дэмжлэг	Бэрхшээлд учруулдаггүй ч тус болдоггүй

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

e115	Таны өдөр тутам хэрэглэдэг тоног төхөөрөмж, хэрэгсэл, бүтээгдэхүүн	17.9%	32.1%	50.0%
e165	Эмчилгээ, мэс заслын дараах санхүү	67.9%	25.0%	7.1%
e310	Эмчилгээ, мэс заслын дараа гэр бүлийн гишүүд	7.4%	92.6%	
e410	Гэр бүлийн гишүүдийн хандлага	7.1%	89.3%	3.6%
e315	Эмчилгээ, хагалгааны дараа таны төрөл садны хүмүүсийн туслалцаа	3.7%	81.5%	14.8%
e320	Эмчилгээ, мэс заслын дараа найз нөхөд	3.7%	81.5%	14.8%
e420	Танд найз нөхдийн өвчний талаарх хандлага	11.5%	65.4%	23.1%
e355	Эмчилгээ, мэс заслын дараа эрүүл мэндийн ажилчид	0.0%	100.0%	0.0%
e450	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн харилцаа хандлага	3.7%	92.6%	3.7%
e580	Өвчнийг эмчлэх болон урьдчилан сэргийлэх засгийн газрын бодлого, хөтөлбөр, үйлчилгээ	14.8%	44.4%	40.7%
e570	Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлого, санхүүгийн тусламж	21.4%	46.4%	32.1%
e590	Мэс заслын дараа ажилд орох/ажлаа үргэлжлүүлэхэд засгийн газраас хэрэгжүүлж буй бодлогын үзүүлж буй нөлөөлөл	17.9%	32.1%	50.0%
e465	Мэс заслын дараа таны нийгэмд эзлэх байр суурь, нийгмийн стандарт үзэл баримтлалд гарсан өөрчлөл	22.2%	33.3%	44.4%

Дүгнэлт

1. ICF – BSSQ асуумж үйл ажиллагааны алдагдлыг 0.91, биеийн бүтцийн алдагдлыг 0.83, нийгмийн оролцооны асуудлыг 0.90 хүрээлэн буй орчноос үүдэх асуудлыг 0.79 буюу найдвартай тодорхойлж байна. Бид хөдөлмөрийн чадвар алдалтыг ICF ба ICD-ийг хослуулан үнэлэх боломжтой бөгөөд цаашид бүтэн үнэлгээ хийж ICF-ийн асуумжийг боловсруулах, хөгжүүлэх, судлах шаардлагатай байна.
2. Хөхний хорт хавдрын дараах үйл ажиллагааны алдагдал дунджаар 39.2 хувь, бүтцийн алдагдал 40 хувь буюу ICD үнэлгээнээс харьцангуй бага тодорхойлож байгаа нь хөдөлмөрийн чадвар алдалтыг зөвхөн өвчний оношоор тогтоох нь сул үүсгэхийг харуулж байна. Хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход ICF -ийг ашигласнаар халамжийг зөв чиглүүлэх боломжийг судлах шаардлагатай байна.
3. Хөхний хавдрын дараах нийгмийн оролцоо, идэвх болон хүрээлэн буй орчны дэмжлэг туслалцааг үнэлж хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох нь зүйтэй байна.

Ном зүй

- [1] Parkin DM, Pisani P, Ferlay J. Estimates of the worldwide incidence of 25 major cancers in 1990. *Int J Cancer* 1999;80:827-41.
- [2] Fialka-Moser V, Crevenna R, Korpan M, Quittan M. Cancer rehabilitation: particularly with aspects on physical impairments. *J Rehabil Med* 2003;35:153-62.
- [3] Tasmuth T, von Smitten K, Kalso E. Pain and other symptoms during the first year after radical and conservative surgery for breast cancer. *Br J Cancer* 1996;74:2024-31.
- [4] Woods M, Tobin M, Mortimer P. The psychosocial morbidity of breast cancer patients with lymphoedema. *Cancer Nurs* 1995;18:467-71.
- [5] Shimozuma K, Ganz PA, Petersen L, Hirji K. Quality of life in the first year after breast cancer surgery: rehabilitation needs and patterns of recovery. *Breast Cancer Res Treat* 1999;56:45-57.
- [6] Knobf MT. Symptoms and rehabilitation needs of patients with early stage breast cancer during primary therapy. *Cancer* 1990;66(6 Suppl): 1392-401.
- [7] Aaronson NK, van Dam FS, Polak CE, Zittoun R. Prospects and problems in European psychosocial oncology. A survey of the EORTC Study Group on Quality of Life. *J Psychosoc Oncol* 1987;4:43-53.
- [8] Chevillat AL, Beck LA, Petersen TL, Marks RS, Gamble GL. The detection and treatment of cancer-related functional problems in an outpatient setting. *Support Care Cancer* 2009;17:61-7.

World Health Organization. International Classification of Functioning, Disability and Health: ICF. Geneva: World Health Organization; 2001

ТАВХАЙ УНЖИЛТТАЙ ХҮҮХДИЙН АЛХАХ ҮЕИЙН ШАГАЙН ҮЕНИЙ ДАЛАЙЦАД НАЙМЫН ТОО ХЭЛБЭРИЙН ТЭПИНГИЙН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Н.Цэсэнжав¹, Х.Энхгэрэл¹, Ц.Батчимэг²

ХБХСЗХТ-ийн хөдөлгөөн засалч¹

ХБХСЗХТ-ийн Хүүхдийн сэргээн засахын эмч²

Хураангуй

Үндэслэл: Тархины саа нь ураг нярайн тархины хөгжлийн үед тохиолддог бөгөөд, хөдөлгөөний хоцрогдол, байршлын тогтвортой өөрчлөлтийн улмаас чадвар алдагддаг даамжрах явцгүй эмгэг юм. Тархины саагийн хөдөлгөөний эмгэг нь мэдрэхүй, танин мэдэхүй, ойлгох чадвар, харилцаа, төрх үйлийн өөрчлөлт болон уналт таталт, булчин араг ясны хоёрдогч эмгэгтэй хавсран тохиолддог гэжээ.¹ Нийт тархины саатай хүүхдийн 70-80% булчингийн чангаралтай хэлбэр тохиолддог.

Шилбэний арын булчин чангарснаар өсгий ясыг хойш татаж, шагай ээтийлгэх далайцыг хязгаарлаж, алхах үеийн хөл газарт байх үеийн болон өсгий газарт хүрэх үеийн алхааны фазыг алдагдуулж эмгэг алхаа буюу тавхай унжсан алхааг (**drop foot gait**) үүсдэг. Тавхай унжилттай хүүхдүүдэд дадал болсон эмгэг алхааг засаж, зөв алхааг хэвшүүлэн алхуулах нь хоёрдогч хүндрэл болох төрх байдлын өөрчлөлт, багана нурууны мурийлт, аарцаг ясны тэнхлэгийн хазайлт, шагайн үений контрактур, шилбэний арын булчингийн чангарал зэргээс урьдчилан сэргийлэх нэн чухал ач холбогдолтой юм. Мөн манай улсад тухайн чиглэлээр хийсэн судалгааны ажил ховор, хязгаарлагдмал байгаа нь биднийг шагайн үений ээтийлгэх далайцыг 8-н тоо хэлбэрийн тэпингээр дэмжих нь хэрхэн үр дүнтэй болохыг судлах үндэслэл болсон.

Арга аргачлал: ХБХСЗХТ-д 2020 оны 5-9 сарын хооронд үйлчлүүлсэн “тархины саа” оноштой 620 (давхардсан тоогоор) үйлчлүүлэгчдээс “тавхай унжилттай” бие даан алхах чадвартай 7-10 насны 50 оролцогчдыг сонгон хамруулсан. Учир нь 7 настайд хүүхдийн алхаа бүрэн гүйцэд хөгжсөн байдаг. Харин 10-аас дээш насны, тавхай унжилттай, бие даан алхах чадвартай хүүхдүүд манай төвөөр цөөхөн тоотой үйлчлүүлсэн байна. Уг судалгааг нэг агшны загвараар явуулж статистик боловсруулалтыг SPSS 21paired программаар боловсруулсан.

Дүгнэлт: Тавхай унжилттай хүүхдүүдэд алхах үед нь 8-н тоо хэлбэрийн тэпинг ашигласнаар алхах үеийн шагай ээтийлгэх далайц нэмэгдэж тэнцвэр сайтай алхаж байна.

Түлхүүр үг: Тэпинг, шагайн далайц, алхааны фаз, тавхайн унжилт

Үндэслэл

2016 онд дэлхийд 17 сая тархины саатай хүмүүс байна гэсэн дэлхийн эрүүл мэндийн судалгаа байдаг. Манай улсад 3000-4000 тархины саатай хүүхдүүд байдаг. Тархины саа нь ураг нярайн тархины хөгжлийн үед тохиолддог бөгөөд, хөдөлгөөний хоцрогдол, байршлын тогтвортой өөрчлөлтийн улмаас чадвар алдагддаг даамжрах явцгүй эмгэг юм. Тархины саагийн хөдөлгөөний эмгэг нь мэдрэхүй, танин мэдэхүй, ойлгох чадвар, харилцаа, төрх

үйлийн өөрчлөлт болон уналт таталт, булчин араг ясны хоёрдогч эмгэгтэй хавсран тохиолддог гэжээ. Нийт тархины саатай хүүхдийн 70-80% булчингийн чангаралтай хэлбэр тохиолддог¹. Хүүхдийн алхаа хэвийн бүрэлдэн хөгжихөд үений далайц, булчингийн хүч, ясны бүтэц, нягт зэрэг бие махбодын талаас нөлөөлөх механик хүчин зүйл нь болдог. Дээрх механик хүчин зүйлсийн аль нэг нь хязгаарлагдсан тохиолдолд алхааны шинж чанар, хэлбэрт өөрчлөлт гарч алхааны явц дахь булчингийн идэвхжил, үений кинематик, кинетик өөрчлөгдөнө. 7 настайд хүүхдийн алхааны хэлбэр, хөдөлгөөнүүд бүрэн гүйцэт хөгжсөн байдаг. Насанд хүрсэн хүний алхаатай харьцуулбал бага зэргийн ялгаа гарах ба энэ нь алхам хоорондын зай, хугацааны ялгаа юм. Энэ үед хүүхдийн хараа, сонсгол, проприорцептор бүрэн гүйцэд хөгжиж дууссан байдаг учраас төрх байдлын хяналт сайжирч, тэнцвэр сайтай алхдаг².

Америкийн эрдэмтдийн 2012 оны шинэчилсэн судалгаагаар хэвийн алхаа нь **хөл газарт байх үе** (өсгий газарт хүрэх үе, хөлийн ул газарт тавигдах үе, хөлийн улан дээр биеийн жин авах үе), **хөл агаарт байх үе** (хөл газраас хөндийрөх үе, хөл агаарт байх үе, өсгий газарт тавигдах үе) гэсэн 2 үе шаттай байдаг³. Алхах үед өсгий газарт (**initial contact**) байх үед түнх нугалах далайц-25⁰, өвдөг тэнийлгэх далайц-0⁰, шагай ээтийлгэх далайц-0⁰ байдаг бол хөл газарт бүтэн улаар тавигдаж биеийн жин авах (**mid stance**) үед түнх нугалах далайц-0⁰, өвдөг тэнийлгэх далайц-0⁰, шагай ээтийлгэх далайц-5⁰ байдаг³. Өсгий газарт байх үед шагай ээтийлгэх булчин (**M.Tibialis anterior**), өвдөг тэнийлгэх булчин (**M.Guadriceps**), түнх нугалах булчингууд (**M.ilicacus psoas**) оролцдог бол хөл газарт бүтэн улаар тавигдаж биеийн жин авах үед түнх нугалах, тэнийлгэх (**M.iliopectus, G.maximus**), өвдөг тэнийлгэх (**M.Guadriceps**), шагай жийх (**M.Gastrocnemius**) булчингууд оролцдог⁴. Эдгээр булчингуудын аль нэгнийхэн хэвийн үйл ажиллагаа алдагдсанаар эмгэг алхаа үүсдэг. Жишээ нь:

Шилбэний арын булчин чангарснаар нь өсгий ясыг хойш татаж, шагай ээтийлгэх далайцыг хязгаарлаж, алхах үеийн хөл газарт байх үе болон өсгий газарт хүрэх үеийн алхааны фазыг алдагдуулж эмгэг алхаа буюу тавхай унжсан алхааг (**drop foot gait**) үүсдэг⁵.

Тэпинг нь суналттай, суналтгүй гэсэн 2 төрөл байдаг. Суналтгүй төрлийн ихэвчлэн үений давамгайлсан хөдөлгөөнийг хязгаарлаж алдагдсан далайцыг дэмжих зорилгоор ашигладаг⁶. Т.Сугаяа, Ш.Окамото нарын судалгаанд алхах үеийн шагай ээтийлгэх далайц хязгаарлагдсан насанд хүрсэн хүмүүст “тэпинг” ашигласан болон ашиглаагүй алхах үеийг

харьцуулан судлахад шагай ээтийлгэх далайцыг “тэпингээр” дэмжих нь ач холбогдолтой байсан байна⁷. Тавхай унжилттай хүүхдүүдэд дадал болсон эмгэг алхааг засаж, зөв алхааг хэвшүүлэн алхуулж сургах нь хоёрдогч хүндрэл болох төрх байдлын өөрчлөлт, багана нурууны мурийлт, аарцаг ясны тэнхлэгийн хазайлт, шагайн үений контрактур, шилбэний арын булчингийн чангарал зэргээс урьдчилан сэргийлэх нэн чухал ач холбогдолтой юм. ХБХСЗХТ-өөр 2019.06.02-2020.08.31 хоорондох тархины саатай 1092 хүүхэд үйлчлүүлснээс тавхай унжилттай 143 хүүхэд эмчилгээнд хамрагдсан байна⁸. Мөн манай улсад тухайн чиглэлээр хийсэн судалгааны ажил ховор, хязгаарлагдмал байгаа нь биднийг шагайн үений ээтийлгэх далайцыг 8-н тоо хэлбэрийн тэпингээр дэмжих нь эмчилгээний хувьд ямар үр дүнтэй болохыг судлах үндэслэл болсон.

Зорилго

Алхах үеийн шагайн үений далайцад 8-н тоо хэлбэрийн суналтгүй “тэпингийн” үзүүлэх үр нөлөөг судлах.

Зорилт

1. “Тэпингтэй” болон “тэпинггүй” алхах үеийн хөл газарт бүтэн улаар тавигдах үеийг **“G WALK”** алхааны аппаратаар үнэлэх.
2. “Тэпингтэй” болон “тэпинггүй” алхах үеийн өсгий газарт байх үеийн **(initial contact)** түнх нугалах, өвдөг тэнийлгэх, шагайн үений ээтийлгэх далайцыг **“siliconoach”** программ ашиглаж тодорхойлж үр дүнг тооцох.
3. “Тэпингтэй” болон “тэпинггүй” Алхах үеийн хөл газарт байх үеийн **(mid stance)** түнх нугарах, өвдөг тэнийлгэх, шагайн үений ээтийлгэх далайцыг **“siliconoach”** программ ашиглаж тодорхойлж үр дүнг тооцох.

Материал арга зүй

ХБХСЗХТ-өөр 2020 оны 5-9 сарын хооронд үйлчлүүлсэн тархины саа оноштой 620 (давхардсан тоогоор) үйлчлүүлэгчдээс тавхай унжилттай бие даан алхах чадвартай 7-10 насны 50 оролцогчдыг сонгон хамруулсан. Учир нь 7 настайд хүүхдийн алхаа бүрэн гүйцэд хөгжиж дууссан байдаг. Харин 10-с дээш насны тавхай унжилттай бие даан алхах чадвартай хүүхдүүд манай төвөөр цөөхөн тоотой үйлчлүүлсэн байна. 50 оролцогчдыг 2 бүлэгт хуваан 1-р бүлгийн 25 оролцогчдод эмчилгээний явцад 8-н тоо хэлбэрийн “тэпинг” ашиглаж, 2-р бүлгийн 25 оролцогчдод эмчилгээний явцад “тэпинг” ашиглахгүйгээр судалгааг

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

харьцуулж явуулсан. Уг судалгааг нэг агшны загвараар явуулж, статистик боловсруулалтыг SPSS 21paired программаар боловсруулсан.

Оролцогчдыг оруулах шалгуур:

- 7-10 настай байх
- Тавхай унжилт 20-25 градус байх
- Бие даан алхах чадвартай байх
- Шагай үений контрактур үүсээгүй байх
- Тал хэлбэрийн хөнгөн саатай байж болно.

Оролцогчдыг хасах шалгуур:

- 5-с доош настай
- Тавхай унжилт 25 градусаар доош
- Бие даан алхах чадваргүй
- Шагайн үений контрактур үүссэн
- 4 мөчний саажилтай

Хүснэгт 1. Хийгдсэн хэмжилтүүд

Үнэлгээ	Тайлбар
Далайц хэмжих (ROM)	Шагай ээтийлгэх далайцыг хэмжиж шилбэний арын булчингийн чангарлыг илрүүлсэн (gastrocnemius). Шагай жийх далайцыг тодорхойлсон.
Булчингийн хүч үнэлэх (ММТ)	Шилбэний урд булчингийн хүчийг тодорхойлсон (tibialis anterior) дундаж хүч-3 баллтай байна.
Ландмарк цэгийг тодорхойлж алхааны үнэлгээ хийхэд бэлдсэн	Алхах үеийн түнх, өвдөг, шагайн үений далайцыг тодорхойлохын тулд ташаа урд дээд хамар, өвдөгний гадна төвгөр, шагайн гадна хашлага зэрэг цэгүүд дээр маркер байрлуулж тэмдэглэгээ хийсэн.
Тэпинг ашиглаагүй 25 оролцогчдын алхах үеийг үнэлсэн	Алхааны үнэлгээний аппарат болох GWALK ашиглаж 3 метр зайд алхуулж үнэлсэн. Алхах үед нь хажуугийн хавтгайгаас камераар (240Hz) бичлэг хийсэн.

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

8-н тоо хэлбэрийн тэпинг ашигласан	25 оролцогчдыг шагайн үеэр 90 ⁰ ээтийлгэсэн байрлалд “тэпингийг” хийсэн. Зорилго нь шагай ээтийлгэх далайцыг дэмжиж шагай жийх далайцыг хязгаарласан.
Тэпинг ашигласан 25 оролцогчдын алхах үеийг үнэлсэн	Алхааны үнэлгээний аппарат болох GWALK ашиглаж 3 метр зайд алхуулж үнэлсэн алхах үед нь хажуугийн хавтгайгаас камераар (240Hz) бичлэг хийсэн.
Хөдөлгөөний анализ хийх тусгай программ (siliconoach) ашигласан	Алхах үед хажуугийн хавтгайгаас хийсэн бичлэгийг siliconoach программ руу оруулж алхах үеийн түнх нугалах, өвдөг тэнийлгэх, шагай ээтийлгэх далайцуудыг хэмжиж тодорхойлсон.

Хүснэгт 2. Хийгдсэн эмчилгээ (21 хоног 1 курс эмчилгээ)

Эмчилгээний төрөл	Зорилго
Далайцын дасгал	Шагай ээтийлгэх далайц сайжруулах
Хүчний дасгал	Шилбэний урд булчингийн хүч сайруулах
Сунгалтын дасгал	Шилбэний арын эрээн булчинг суллах
Алхуулах дасгал	10 хоногийн турш 25 оролцогчдын шагайн үенд 8-н тоо хэлбэрийн “тэпингийг” тогтмол ашиглаж, үлдсэн 25 оролцогчдод “тэпинг” ашиглаагүй гүйлтийн зам дээр алхуулах дасгал хийсэн.

Энэхүү судалгааны давуу тал болон дутагдалтай тал нь:


Манай улсад өмнө нь тавхай унжилттай хүүхдүүдэд энэ төрлийн судалгаа хийгдэж байгаагүй. Мөн алхах үед тэпинг ашигласнаар шагайн үений далайц нэмэгдэж, эмчилгээний үр дүн гарч байгаа нь давуу тал болж байна.

Манай улсад тэпинг ашиглаж хийгдсэн судалгаа ховор байна. Судалгаанд хамрагдсан оролцогчдын зарим нь эмчилгээний дундаас тасалж явсан нь судалгаанд хүндрэл учруулж байлаа.

Судалгааны үр дүн

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

1. Судалгаанд хамрагдсан 50 оролцогчийг хяналтын болон судалгааны бүлэгт хувааж тэпинг ашигласан (25 оролцогч) болон тэпинг ашиглаагүй (25 оролцогч) үеийн хөл газарт бүтэн улаар тавигдаж биеийн жин авах үеийг “G WALK” аппарат ашиглаж харьцуулан үнэлсэн байдал.



Зураг 1. Алхааны үнэлгээ (алхах үед тэпинг ашигласнаар шагайн үений ээтийлгэх далайцыг нэмэгдүүлж хөл газарт бүтэн улаар тавигдаж байна)

Хүснэгт 3. Алхах үед өсгий газарт хүрэх үеийн (initial contact) шагайн үений өнцөг

Үзүүлэлтүүд	Тэпингтэй	Тэпинггүй
Түнх нугалах	22.2±2.6 - Түнх нугалах өнцөг багассан байна.	23.8±5.8 - Түнх нугалах өнцөг ихэссэн байна.
Өвдөг тэнийлгэх	20.8±5.1 - Өвдөг тэнийх өнцөг ихэссэн байна.	12.8±3.5 - Өвдөг нугалах өнцөг ихэссэн байна.
Шагай ээтийлгэх	29.40±7.7- Шагай ээтийлгэх өнцөг ихэссэн байна.	<u>24.0±7.0</u> - Шагай жийх өнцөг ихэссэн байна.

Тэмдэглэл: Дундаж утга±Стандарт хазайлт, *p<0.142 статистик ач холбогдол бүхий

Хүснэгт 4. Алхах үед хөл газарт бүтэн улаар тавигдаж биеийн жин авах үеийн (mid stance) шагайн өнцөг

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Үзүүлэлтүүд	Тэпингтэй	Тэпинггүй
Түнх нугалах	4.6±2.0 - Түнх нугалах өнцөг багассан байна.	9.8±3.3 - Түнх нугалах өнцөг ихэссэн байна.
Өвдөг тэнийлгэх	14.2±5.5 – Өвдөг тэнийх өнцөг ихэссэн байна.	3.4±1.8 - Өвдөг нугалах өнцөг ихэссэн байна.
Шагай ээтийлгэх	25.4±3.8 – Шагай ээтийлгэх өнцөг ихэссэн байна.	21.2±2.5 - Шагай жийх өнцөг ихэссэн байна.

Тэмдэглэл: Дундаж утга±Стандарт хазайлт, * $p < 0.017$ статистик ач холбогдол бүхий.

Хэлцэмж


- П.Мөнхжаргал, Т.Сугаяа, Ш.Окамото нарын 2018 оны судалгаанд алхах үед шагайн үений ээтийлгэх далайц хязгаарлагдсан насанд хүрсэн хүмүүст тэпинг ашигласан болон ашиглаагүй алхах үеийг харьцуулан судлахад шагайн үений ээтийлгэх далайцыг дэмжих нь ач холбогдолтой байсан байна⁸. Манай судалгаанд тавхай унжилттай хүүхдүүдэд алхах үед нь тэпинг ашигласан болон ашиглаагүй алхах үеийг харьцуулна судлахад шагайн үений ээтийлгэх далайцыг дэмжиж алхуулах нь ач холбогдолтой байгаа нь эдгээр эрдэмтдийн судалгааны үр дүнтэй нийцэж байна.
- Г.Болормаа, Р.Сайто, М.Юүри нарын 2018 оны судалгаанд спортын тамирчдад шагай үений холбоосны булгаралт, гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор дөрөө хэлбэрийн 1/2 суналгүй тэпинг ашигласан нь статистикийн ач холбогдолтой ($p < 0.05$) байсан байна⁹. Манай судалгааны тавхай унжилттай хүүхдийн шагайн үений жийх далайцыг 8-н тоо хэлбэрийн суналтгүй тэпингээр хязгаарлаж зөв алхуулах нь шагай үений холбоосны булгаралт, гэмтлээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой энэ нь дээрх судалгааны үр дүнтэй нийцэж байна.
- Z.Rojhani-Shirazi, S. Amirian нарын 2015 оны судалгаанд харвалтын дараах талын биеийн саатай тавхай унжилттай бие даан алхах чадвартай 60 оролцогчдыг хамруулж, хөдөлгөөн засал эмчилгээний үед 30 оролцогчийн тавхайг 10 хоногийн турш тэпингээр сойж, үлдсэн 30 оролцогчийг тэпинг ашиглахгүй зөвхөн эмчилгээнд хамруулж харьцуулан судалсан байна. Судалгааны дүнд тэпинг ашигласан 30 оролцогчид шагайн үений ээтийх далайц сайжирсан нь статистикийн ач холбогдолтой (* $p < 0.01$) байсан байна¹⁰. Хөдөлгөөн засал

эмчилгээний явцад тэпинг ашиглах нь статистикийн ач холбогдолтой байгаа нь манай судалгааны үр дүнтэй нийцэж байна.


- Солонгос улсын эрдэмтэд болох Sun-Hye Jung, Sun-Hae Song, Da-Rye Kim, Seul-Gi Kim, Ye-Jin Park нарын 2016 оны судалгаанд тархины саагийн үеийн шагайн өөрчлөлтийг тэпингээр дэмжих нь хоёрдогч хүндрэл болох төрх байдлын өөрчлөлт, булчингийн чангарал, аарцгийн хазайлт, шагайн үений контрактур зэргээс урьдчилна сэргийлэх нь $p < 0.05$ статистикийн ач холбогдолтой байсан байна¹¹.
- Бидний судалгааны баг тавхай унжилттай хүүхдүүдэд алхах үед нь 8-н тоо хэлбэрийн тэпинг ашигласнаар шагайн үений ээтийлгэх далайц нэмэгдэж, статистик ач холбогдол бүхий үр дүнтэй байгаа нь эдгээр судалгааны үр дүнтэй нийцэж байна.

Дүгнэлт

- Тэпинг ашиглаагүй алхах үед шагайн үений ээтийлгэх далайц хязгаарлагдаж, жийх далайц давамгайлж алхаж байсан бол тэпинг ашиглаж алхах үед жийх далайц хязгаарлагдаж, ээтийлгэх далайц давамгайлж тавхай газарт бүтэн улаар тавигдан алхаж байна. (зураг 1.)
- Эмчилгээний өмнө алхааны өсгий газарт хүрэх (initial contact) үе хийгдэхгүй түнх, өвдөг нугарах өнцөг ихэсгэж, өлмий хэсэгт биеийн жинг авч байсан бол тэпинг ашигласнаар эмчилгээний дараа түнх, өвдөг нугарах өнцөг багасаж, шагай ээтийлгэх далайц ихэсгэж, өсгий газарт хүрэх үе хийгдэж байна. (Хүснэгт 3.)



- Эмчилгээний өмнө алхааны хөл газарт байх (mid stance) үед өвдөг нугарах өнцөг ихэсгэж, тавхай унжсан байрлалд байсан бол, тэпинг ашигласнаар эмчилгээний дараа өвдөг тэнийх өнцөг ихэсгэж тавхай бүтэн улаар тавигдаж байна. (Хүснэгт 4.)



- Тавхай унжилттай хүүхдийн хөдөлгөөн засал эмчилгээний үед шагай ээтийлгэх далайцыг 8-н тоо хэлбэрийн тэпингээр дэмжиж алхуулах нь үр дүнтэй байна.

Талархал

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн дарга Р.Галбадрах.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн ЭМСЗ-ын газрын дэд дарга Ц.Батчимэг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн ЭМСЗ-ын газрын хөдөлгөөн засалч А.Нямсүрэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвөөр үйлчлүүлж судалгаанд хамрагдсан хүүхдүүд болон тэдний эцэг эхчүүдэд талархал илэрхийлье.

Ном зүй

- [1] Ц.Наранцэцэг, Yi Young Koong, Сэргээн засах анагаах ухаан сэтгүүл, Тархины саатай хүүхдийн хөлийн булчингийн чангаралд ботулин токсин-а тарьсан эмчилгээний үр дүн (2017) 7-р дугаар (хуудас 113).
- [2] Х.Ариунаа, Сэргээн засах анагаах ухаан сэтгүүл, Хүүхдийн алхааны хөгжил (2019) 9-р дугаар (хуудас 8-12).
- [3] Lynn Lippert, S. Clinical kinesiology and Anatomy (2011) part 4 (260-326)
- [4] Levine David, Richards Jim, Wittle Michael (2014) “Whittle’s Gait Analysis”, Published by Churchill Livingstone.
- [5] А.Балжинням, (2009) сэргээн засах судлал (хуудас 75-82)
- [6] Rick Rosa, Dr. “Ankle Sprains in Basketball Kinesio Tape Vs Traditional rigid athletic tape in treating ankle sprains.” Recovery doc; Dec. 2018.
- [7] П.Мөнхжаргал, Т.Сугаяа, Ш.Окамото, Сэргээн засах анагаах ухаан сэтгүүл “Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд- сэргээн засах”, Шагайн үений өнцгийн өөрчлөлт нь Босго давж алхах үеийн төрх байдлын нөлөөлөл (2018) 8-р дугаар (хуудас 56-57).

- [8] Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн статистик мэдээ (2020).
- [9] Г.Болормаа, Р.Сайто, Т.Юүри, Сэргээн засах анагаах ухаан сэтгүүл, Алхах үед тавхай газарт байх үеийн шагайн үений далайцад дөрөө хэлбэрийн суналтгүй наалтын үзүүлэх нөлөө (2018) 8-р дугаар (хуудас 57-58).
- [10] Z. Rojhani-Shirazi, S. Amirian, and N. Meftahi, “Effects of ankle kinesiо taping on postural control in stroke patients,” *Journal of Stroke and Cerebrovascular Diseases*, vol. 24, no. 11, pp. 2565–2571, 2015.
- [11] Sun-Hye Jung^{a,b}, Sun-Hae Song^b, Da-Rye Kim^c, Seul-Gi Kim^c, Ye-Jin Park^c, Yeon-Jung Son^c, and GyuChang Lee^c, “Effects of kinesiо taping on the gait parameters of children with cerebral palsy a pilot study,” *Korean Academy of Physical Therapy Rehabilitation Science*, Published online December 30, 2016.

ХАВТГАЙ ТАВХАЙН АЛХААНЫ ФАЗЫГ СУДЛАХ НЬ

А.Нямсүрэн¹, Ц.Батчимэг²

ХБХСЗХТ-ийн Хөдөлгөөн засалч¹

ХБХСЗХТ-ийн ЭМСЗ хариуцсан дэд дарга²

Хураангуй

Үндэслэл: Алхаа нь тодорхой хэмнэлээр хөл гар солбицож хөдөлснөөр хүний бие дэлхийн татах хүчний төвөөс урагш шилжиж буй хөдөлгөөн юм. Хэвийн алхааны өсгий газарт хүрэх үед шилбэ болон талус яс дотогш эргэж, өсгий ясны үе (subtalar) бүхэлдээ гадагш эргэх хөдөлгөөн хийгддэг. Хавтгай тавхай нь хөлийн нум ялгарч харагдахгүй байхыг хэлнэ. Хөлийн нумын өнцөг 131°-152° бол хэвийн, 130°-аас бага тохиолдолд хавтгай гэж үзнэ. Хавтгай тавхайн бэлбэрхий ясны эмгэг, талус ясны буруу хөгжил, Х хэлбэрийн хөл болон тархины саажилт, мэдрэл булчингийн эмгэгүүдийн үед тохиолддог. Хавтгай тавхай нь ихэвчлэн өсгий ясны үений (subtalar) тогтворгүй байдлаас үүсдэг гэж үздэг. Хавтгайн тавхай нь биед ачаалал ихсэх тусам өвдөлт болон үений сул байдал, ахиллын шөрмөсний богиносолт, алхааны өөрчлөлт илэрч эдгээр шинж тэмдэг 10 наснаас хойш илүү тод илэрнэ. Мөн хавтгай тавхайтай хүүхдүүд алхах болон гүйх үед дотогш гишгэх хандлага их байдгаас улны хальсны үрэвсэлд өртөмтгий байдаг. Иймд хавтгай тавхайтай хүүхдийн алхаанд гарах өөрчлөлтийг тогтоож хөдөлгөөн заслын эмчилгээний төлөвлөгөөг тодорхой болгох шаардлагатай байна. Мөн манай улсад хавтгай тавхайн эмгэгийн судалгаа ховор байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл болсон.

Зорилго: Хавтгай тавхайн алхааны фазыг судлах.

Арга аргачлал: 2020.01-09 сар хүртэл Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвөөр тавхайн эмгэгтэй 181 хүүхэд үйлчлүүлсэн. Үүнээс хавтгай тавхай оноштой 80 хүүхэд байсан бөгөөд энэхүү судалгаанд 4-7 насны 40 хавтгай тавхайтай хүүхэд, 40 хөлийн нум хэвийн хүүхдийг сонгон хамруулсан.

Үр дүн: Хавтгай тавхайн нумын өнцөг нас ихсэх тусам 130°-аас багасаж байна. Хэвийн алхааны газарт байх үе 58,1% хөл агаарт байх үе 41,8% байсан. Хавтгай тавхайн алхааны хөл газарт байх үе 63,1% байсан. Хөл агаарт байх үе 36,8% байсан

Дүгнэлт: Алхааны хөл газарт байх болон агаарт байх үеийг настай харьцуулахад ($p < 0.004$) статистик ач холбогдолтой байсан. Хавтгай тавхайтай үйлчлүүлэгчдийн хөлийн нумын өнцөг болон алхааны фазыг үнэлэхэд өөрчлөлт нь нас ахих тусам нэмэгдэж байна.

Түлхүүр үг: Хөлийн нумын өнцөг, хөл газарт байх үе, хөл агаарт байх үе

Үндэслэл

Алхаа нь тодорхой хэмнэлээр хөл гар солбицож хөдөлснөөр хүний бие дэлхийн татах хүчний төвөөс урагш шилжиж буй хөдөлгөөн юм. Нэг алхааны тойрог нь 2 алхмаас тогтох ба нэг хөлийн өсгийнөөс, нөгөө хөлийн өсгий хүртэлх зайг хэлдэг. Алхаа нь хөл газар байх үе, хөл агаарт байх үеэс бүрдэнэ¹. Хэвийн алхааны өсгий газарт хүрэх үед шилбэ болон талус яс дотогш эргэж, өсгий ясны үе (subtalar) бүхэлдээ гадагш эргэх хөдөлгөөн хийгддэг. Хөл газарт байх үеийн төгсгөлд шилбэ болон талус яс гадагш эргэж, өсгий ясны үе (subtalar) дотогш эргэж шагай үеэр ээтийх хөдөлгөөн хийж дуусдаг². Хавтгай тавхай нь хөлийн нум ялгарч харагдахгүй байхыг хэлнэ. Хөлийн нумын өнцөг 131° - 152° бол хэвийн, 130° -аас бага тохиолдолд хавтгай гэж үзнэ³. Харин хавтгай тавхайны үед хөл газарт байх үеийн төгсгөл хэсэгт өсгий ясны үе дотогш эргэх хөдөлгөөн хязгаарлагдаж өсгий ясны үнд ирэх даралт ихэссэнээр хөлийг амархан ядраахад хүргэдэг. Мэдрэл булчингийн хөгжил хэвийн 2-3 насны хүүхдэд ясан дээр ирэх даралт нэмэгдсэнээр үений бат бөх байдал сайжирна. Мөн алхах чадвар сайжирч хөлийн тавхайнд биеийн жинг шилжүүлснээр нум үүсэх процесс явагдаж эхэлдэг⁴. Австралийн эрдэмтэн Вандервайд, Стахейл нарын шагайн үений радиографын судалгаагаар 6 сартайгаас 10 нас хүртэлх шагай тавхайн эмгэггүй хүүхдүүдийн хөлд нум аяндаа сайжирч байгааг тогтоосон⁵. Хавтгай тавхайн бэлбэрхий ясны эмгэг, талус ясны буруу хөгжил, X хэлбэрийн хөл болон тархины саажилт, мэдрэл булчингийн эмгэгүүдийн үед тохиолддог⁶. Хавтгай тавхай нь ихэвчлэн өсгий ясны үений (subtalar) тогтворгүй байдлаас үүсдэг гэж үздэг. Зарим ортопедийн эмч нар шагай тойрсон булчингуудын сулрал нь хавтгай тавхайд нөлөөлдөг гэж үзсэн. Мөн шилбэний арын (gastrocnemius) болон шаахай хэлбэрийн булчингуудын (soleus) богиносолт нь шагайн үеийг ээтийлгэх хөдөлгөөнийг хязгаарлахаас гадна өсгий ясны үений (subtalar) шилжилтийг хориглосноор хавтгай тавхай үүсэх нөхцөлийг бүрдүүлдэг⁷. Хавтгайн тавхай нь биед ачаалал ихсэх тусам өвдөлт болон үений сул байдал, ахиллын шөрмөсний богиносолт, алхааны өөрчлөлт илэрч эдгээр шинж тэмдэг 10 наснаас хойш илүү тод илэрнэ⁸. Мөн хавтгай тавхайтай хүүхдүүд алхах болон гүйх үед дотогш гишгэх хандлага их байдгаас улны хальсны үрэвсэлд өртөмтгий байдаг⁹. Иймд

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

хавтгай тавхайтай хүүхдийн алхаанд гарах өөрчлөлтийг тогтоож хөдөлгөөн заслын эмчилгээний төлөвлөгөөг тодорхой болгох шаардлагатай байна.Хавтгай тавхайн эмгэгийг судалгаа ховор байгаа.

Зорилго

Хавтгай тавхайн алхааны фазыг судлах

Зорилт

1. Хөлийн нум хэвийн болон хавтгай тавхайтай хүүхдийн хөлийн нумын өнцгийг тодорхойлох
2. Хавтгай тавхайтай болон хөлийн нум хэвийн хүүхдийн хөл газарт байх болон хөл агаарт байх үеийг үнэлэх
3. Хавтгай тавхайтай хүүхдийн алхааны фазыг настай харьцуулах

Материал арга зүй

2020.01-09 сар хүртэл Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвөөр тавхайн эмгэгтэй 181 хүүхэд үйлчлүүлсэн.Үүнээс хавтгай тавхай оноштой 80 хүүхэд байсан. Энэхүү судалгаанд 4-7 насны 40 хавтгай тавхайтай хүүхэд, 40 хөлийн нум хэвийн хүүхдийг сонгон хамруулсан.

Судалгаанд оролцох шалгуур:

1. 4-7 нас байх
2. Бие даан алхах чадвартай байх
3. Хавтгай тавхай оноштой
4. Хөлийн нумын өнцөг 130° болон түүнээс бага байх

Судалгаанаас хасах шалгуур:

1. 3 болон түүнээс доош настай байх
2. Бие даан алхах чадахгүй
3. Дагалдах оноштой (Оюуны бэрхшээл)
4. Хөлийн нумын өнцөг 131°-аас дээш

Арга аргачлал

Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдээс нас, хүйс,төрсөн он сар өдөр, биеийн жин, биеийн өндөр, гутлын размерын мэдээлэл цуглуулсан.


“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

1. Хөлийн нумыг тодорхойлоход MLA (Medial Longitudinal Arch Angle) тест ашиглан гониометрээр нумын өнцгийг хэмжсэн.
2. G-Walk алхааны аппарат ашиглан алхааны хөл газарт байх үе болон агаарт байх үеийг үнэлсэн.
3. Уг судалгааг тохиолдол хяналтын загвараар явуулж Статистик боловсруулалтыг SPSS 21 программаар хийсэн.

Үр дүн

Энэхүү судалгаанд оролцсон 7 настай хавтгай тавхайтай үйлчлүүлэгчдийн хөлийн нумын өнцөг 4 настай харьцуулахад багассан байсан

Зураг 1. Судалгаанд оролцогсдын хөлийн нумын өнцгийг насны ангиллаар



Бидний судалгаанд 40 хавтгай тавхайтай үйлчлүүлэгч хамрагдсанаас 9 буюу 22,5% эмэгтэй, 31 буюу 77,5% эрэгтэй, 40 эрүүл үйлчлүүлэгч хамрагдсанаас мөн 9 буюу 22,5% эмэгтэй, 31 буюу 77,5% эрэгтэй, дундаж наслалт 5,5 байв (Хүснэгт 1.).

Хүснэгт 1. Хавтгай болон хөлийн нум хэвийн хүүхдийн алхааны фаз

Үзүүлэлт	Нийт	Хамгийн бага	Хамгийн их	Дундаж	Стандарт хазайлт
Хавтгай хөл газарт	40	60.0	68.9	63.1	2.3477
Хавтгай хөл агаарт	40	31.1	40.0	36.8	2.3526

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Хэвийн хөл газарт	40	56.0	59.8	58.1	1.2918
Хэвийн хөл агаарт	40	40.2	44.0	41.8	1.2918

Хүснэгт 2. Хавтгай тавхайтай хүүхдийн алхааны фаз болон насны хамаарал

Үзүүлэлт	N	Age	P-утга
Хөл газарт байх үе ба нас	20	5.5	0.004
Хөл агаарт байх үе ба нас	20	5.5	0.004

Хэлцэмж

Бидний үр дүнгээс харахад, хавтгай тавхайтай үйлчлүүлэгчийн хөл газарт байх үе 63,1%, хөл агаарт байх үе 36,8% байгаа нь хавтгай тавхай нь алхааны фазад нөлөөлснийг харуулж байна. Мөн алхааны хөл газарт байх ,агаарт байх үе болон насыг харьцуулахад $p < 0.004$ бүхий ач холбогдолтой байгаа нь нас ахих тусам алхааны өөрчлөлт нэмэгддэгийг харуулж байна

- Солонгосын эрдэмтэн Ha Yong Kim, MD, Hyuck Soo Shin, MD нар 7-13 насны 26 (21 эр, 5 эм) хавтгай тавхайтай хүүхдийг оролцуулсан судалгаанд хавтгай тавхайн хөл газарт тавигдах үед кинетик болон кинематик хүч нөлөөлөн өөрчлөлт үүсдэг гэдгийг баталсан байна⁵
- Японы эрдэмтэн Yoshino Ueki, Eisuke Sakuma нар хэвийн алхааны хөл газарт байх үед шилбэ болон талус яс гадагш эргэж, өсгий ясны үе (subtalar joint) дотогш эргэж, шагай ээтийнэ. Харин хавтгай тавхайн алхааны үед өсгий ясны үе дотогш эргэхгүй, үений тэгш байдал алдагдсан гэдгийг нотолсон байна⁷
- Австралийн эрдэмтэн Linah Wafai, Aladin Zayegh нар алхааны хөл газарт байх үед биеийн жинг өсгий яс, 1-р шивнүүр, 5-р шивнүүрийн хэсэгт авдаг бол хавтгай тавхайн үед өсгий яс, 1-р шивнүүрийн дотор хэсэгт авна. Иймд алхааны хөл газарт байх үе удаан хийгдэнэ гэдгийг нотолсон байсан¹⁰.
- Хавтгай тавхай нь алхааны хөл газарт байх, хөл агаарт байх үед нөлөөлж байгаа нь зарим гадаадын судлаачдын үр дүнтэй нийцэж байна.

Дүгнэлт

Хавтгай тавхайтай үйлчлүүлэгчдийн хөлийн нумын өнцгийг хэмжихэд хэвийн нумтай хүүхдээс бага байна. Мөн алхааны хөл газарт байх болон агаарт байх үеийг үнэлэхэд өөрчлөлт нь нас ахих тусам нэмэгдэж байна

Талархал

- Энэхүү судалгааг хийхэд тусалсан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн хүүхдийн эмч Н.Бат-уянга болон Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн ЭМСЗ хариуцсан дэд дарга Ц.Батчимэг,ХБХСЗХТ-ийн нүдний эмч Булган, мөн Хүүхдийн төвийн бүх хөдөлгөөн засалч нартаа баярлалаа.

Ашигласан хэвлэл

- [1] А.Балжинням (2015 он), Сэргээн засах судлал (хуудас 75-82)
- [2] Yoshino Ueki, Eisuke Sakuma, Ikuo Wada “Pathology and management of flexible flat foot in children” Journal of Orthopaedic Science 2018 March 27
- [3] Nilsson MK, Friis R, Michaelsen MS, Jakobsen PA, Nielsen RO. Classification of the height and flexibility of the medial longitudinal arch of the foot. J Foot Ankle Res. 2012 Feb 17;5(3)
- [4] Ha Yong Kim, MD, Hyuck Soo Shin, MD, Jun Hyuck Ko, MD, Yong Han Cha, MD, Jae Hoon Ahn, MD, Jae Yeon Hwang, MD Gait Analysis of Symptomatic Flatfoot in Children: An Observational Study June 21, 2017
- [5] Vanderwilde R, Staheli LT, Chew DE, Malagon V. Measurements on radiographs of the foot in normal infants and children. J Bone Joint Surg Am 2011 Mar;70(3):407e15.
- [6] Bettmann E. The treatment of flat-foot by means of exercise. J Bone Joint Surg 2017;19-A:821e5.
- [7] Yoshino Ueki, Eisuke Sakuma, Ikuo Wada “Pathology and management of flexible flat foot in children “Journal of Orthopaedic Science 27 March 2018
- [8] Kim HW, Park J, Kang ES, Park HW. The pediatric flatfoot: its differential diagnosis and management. J Korean Soc Foot Surg. 2011;5(1):91-101.
- [9] Б.Даваажав,А.Балжинням Сэргээн засах анагаах ухааны сэтгүүл “Улны фасцийн үрэвслийн сэргээн засах эмчилгээ”2012 Dec №2
- [10] Identification of Foot Pathologies Based on Plantar Pressure Asymmetry Linah Wafai 1, Aladin Zayegh 1, John Woulfe 2, Syed Mahfuzul Aziz 3 and Rezaul Begg 4

ДУНГИЙН СУУЛГАЦЫН ХАГАЛГААНЫ ДАРААХ ҮР ДҮНГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Х. Бямбажава, Лхагвасүрэн, Г. Ням-Осор, Н. Солонго, Ц. Эрдэнэтуяа

Хураангуй

Сонсгол бууралттай хүүхдүүдийг эрт оношилж, шаардлагатай туслах хэрэгслээр хангах нь нэн чухал юм. Мөн хүнд хэлбэрийн сонсголын алдагдалтай буюу дүлий хүмүүсийг тохирох хагалгааны аргаар (дунгийн суулгац, иш тархины суулгац гэх мэт) эмчилж, сонсголыг нь нөхөн сэргээж чанарыг нь дээшлүүлэх хэрэгцээ байна.

Сонсголын бэрхшээлтэй хүүхэд суралцдаг, нийслэлийн 29 дүгээр ерөнхий боловсролын сургуулийн дунгийн суулгацтай сурагчид болон суралцагчдын эцэг эхээс дунгийн суулгацын хагалгаа, хагалгааны үр дүн, хагалгааны дараах нөхөн сэргээх хэл заслын хичээлтэй холбоотой асуудлаар судалгаа авч боловсруулж, нэгтгэн дүгнэх зорилгоор 29 дүгээр сургуулийн дунгийн суулгацын хагалгаанд орсон 22 сурагч болон тэдний эцэг эхчүүд оролцлоо. Дунгийн суулгацтай сурагчдыг түүвэрлэн, судалгааг асуулгын аргаар авч SPSS программаар үр дүнг боловсруулсан болно.

Эцэг эхчүүд дунгийн суулгацын хагалгаа болон нөхөн сэргээх, засан сайжруулах хичээлийн талаар тодорхой ойлголт, мэдлэг дутмаг, зарим тохиолдолд хүүхдийнхээ бодит байдал, бодит чадварыг хүлээн зөвшөөрч чадахгүй байна.

Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн дунгийн суулгацын хагалгаанд зөвхөн анагаахын талаас нь хандах биш боловсролын талаас, тухайлбал тусгай хэрэгцээт боловсролын салбарт энэхүү хагалгаанд орж байгаа хүүхдүүдийн боловсролын асуудал, хагалгааны дараах нөхөн сэргээх, засан сайжруулах үйл явцад анхаарлаа хандуулах цаг болсон байна.

Удиртгал

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 2020 оны мэдээнд дэлхийн нийт хүн амын 15 орчим хувь буюу тэрбум гаруй хүн ямар нэгэн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй байдаг гэжээ. Сонсголын алдагдал нь генетикийн шалтгаан, төрөх үеийн хүндрэл, зарим халдварт өвчин, чихний архаг халдвар, тодорхой эм хэрэглэх, хэт их дуу чимээнд өртөх, хөгшрөлт зэргээс үүдэлтэй байж болдог. Хүүхдийн сонсголын алдагдлын 60% нь урьдчилан сэргийлэх боломжтой шалтгаанаас болдог. Мөн орчин үеийн хүмүүсийн амьдралын хэвшилд техник технологийн эзлэх байр суурь их болсонтой холбоотойгоор хүмүүсийн сонсголоо алдах, сонсгол буурах хүчин зүйлс улам бүр нэмэгдэж байна. Тухайлбал ДЭМБ-ын судалгаагаар 1.1 тэрбум залуучууд (12-35 насныхан) амралт, зугаалгын орчны дуу чимээнд өртөж сонсголын бэрхшээлтэй болох эрсдэлтэй байна гэж гарчээ. Иймээс орчин үед дэлхий нийтээр сонсгол бууралт болон дүлийрэл нь тулгамдсан асуудал болоод байна.

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДАЛЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Сонсголын алдагдлыг оношлоогүйгээс болж дэлхийн хэмжээнд жилд 750 тэрбум ам долларын өртөг үүсдэг. Харин сонсголын бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, оношлох, арилгах арга хэмжээ нь зардал багатай бөгөөд хувь хүмүүст ихээхэн ашиг тусаа өгдөг. ДЭМБ-ын судалгаагаар одоогоор сонсголын аппарат ашиглах шаардлагатай хүмүүсийн зөвхөн 17% нь үүнийг ашигладаг гэсэн тооцоо гарсан байна.

Эрүүл болон сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн сонсголын эрхтнийг цахилгаанаар өдөөх явцад үзүүлэх мэдрэхүйн судалгааг аль 16-р зуунаас эрдэмтэд судалж эхэлсэн бөгөөд энэхүү судалгаа нь 20-р зуун хүртэл үргэлжилжээ. Эдгээр судалгааны явцад дүлий болон хэвийн сонсголтой хүмүүст цахилгаан өдөөлтийн шинж чанаруудаас хамаарч жингэнэх, тогших, исгэрэх гэх мэт сонсголын мэдрэмжүүд үүсдэг болохыг тогтоожээ. Эдгээр судалгаанууд нь дүлий хүмүүст цахилгаан дунгийн суулгац хийх санааны үндэс болсон бөгөөд хүний дотоод чихэнд суулгаж болохуйц био нийцтэй материалууд гарч ирсний дараа, мөн дуут дохиог хүлээн авч боловсруулаад, цахилгаан өдөөлтийг сонсголын мэдрэл хүлээн авч хувиргах чадвартай цахилгаан систем бий болсноор дунгийн суулгац хийх боломжтой болсон юм. 1950-аад оноос дунгийн суулгацын туршилтууд хийгдэж эхэлсэн. Эдгээр суулгацууд нь өвчтөн зөвхөн лабораторийн орчинд ирж л сонсдог байв. Харин 1957 онд Францад доктор Чарльз Эйрис өөрийнхөө өвчтөнд анхны зөөврийн дунгийн суулгацыг суулгасан байдаг. Үүнээс хойш энэхүү чиглэл эрчимтэй хөгжиж эхэлсэн бөгөөд 20-р зууны 70, 80-аад оноос худалдааны зорилгоор дунгийн суулгацууд үйлдвэрлэгдэж эхэлсэн бөгөөд олон улсад энэхүү хагалгааны арга дэлгэрч эхэлсэн.

Манай Монгол улс 2000 оноос эхлэн энэ чиглэлээр эмч мэргэжилтнүүдээ гадаадын сургалт, семинарт хамруулж эхэлсэн. Манай улсад энэхүү хагалгаа нь өндөр өртөгтэй, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн боловсон хүчин дутмаг, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдаагүй байсан учраас харьцангуй хожуу буюу 2009 онд анх хийгдсэн. Дунгийн суулгацын хагалгааг Монгол улсад хамгийн анх 2009 оны 8 сарын 2,3-ны өдрүүдэд анагаах ухааны доктор А. Өлзийбаяр, Л. Бямбасүрэн нар 2 настай төрөлхийн дүлий болон зургаан настай шалтгаан нь мэдэгдэхгүй сонсгол нь бага багаар буурсаар байгаад дүлийрсэн хоёр хүүхдэд амжилттай хийжээ.

Үүнээс хойш 10 гаруй жилийн хугацаанд 130 гаруй хүнд энэхүү хагалгааг хийгээд байна. Манай улсын хувьд дунгийн суулгацын хагалгааг хийх мэргэшсэн эмч мэргэжилтнүүд байгаа боловч гол ажил болох хагалгааны дараах хэл заслын хичээлийн чанарын үзүүлэлт тааруу

байна. Учир нь Монгол улсын хэмжээнд сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах сурдопедагог (СБХ-тэй хүүхэдтэй ажиллах багш), логопед (хэл засалч) зэрэг нарийн мэргэжлийн багш нарыг бэлтгэгддэггүй. Иймд манай улсын хэмжээнд хийгдэж байгаа дунгийн суулгацын хагалгааны талаарх мэдээлэл, тус хагалгааны дараах засан сайжруулах хичээлийн үйл явц, үр дүн, стандартыг тогтоох, нийт хийгдэж буй дунгийн суулгацын хагалгааны үр дүнг зайлшгүй судалж, нэгтгэн дүгнэх хэрэгцээ шаардлага байна.

Судалгааны зорилго

Сонсголын бэрхшээлтэй хүүхэд суралцдаг, нийслэлийн 29 дүгээр ерөнхий боловсролын сургуулийн дунгийн суулгацтай сурагчид болон суралцагчдын эцэг эхээс дунгийн суулгацын хагалгаа, хагалгааны үр дүн, хагалгааны дараах нөхөн сэргээх хэл заслын хичээлтэй холбоотой асуудлаар судалгаа авч боловсруулж, нэгтгэн дүгнэх

Судалгааны зорилт

- Дунгийн суулгацтай суралцагчдын эцэг эхээс дунгийн суулгацын хагалгаа, хагалгааны үр дүнтэй холбоотой асуудлуудаар судалгаа авах
- Хагалгааны дараах нөхөн сэргээх хэл заслын хичээлтэй холбоотой асуудлаар судалгаа авах
- Судалгаагаа боловсруулж, нэгтгэн дүгнэх

Судалгааны хэрэглэгдэхүүн арга зүй

Судалгаанд 29 дүгээр сургуулийн дунгийн суулгацын хагалгаанд орсон 22 сурагч болон тэдний эцэг эхчүүд оролцлоо. Дунгийн суулгацтай сурагчдыг түүвэрлэн, судалгааг асуулгын аргаар авч SPSS программаар үр дүнг боловсруулсан болно.

Сонсголыг үнэлэх

Ихэнх тохиолдолд сонсголын бэрхшээл нь сонсгол бууралтаас үүсдэг (ө.х сонсголын босго нэмэгддэг). Харин энэ үед сонсголын түвшингөөс хамаараад зөвхөн дунд эсвэл илүү чанга чимээг сонсдог. Эдгээр тохиолдлуудад сонсгол бууралттай байна гэж үздэг. Хүн дууг хүлээн авахад дууг хүлээн авагч болон дууны эх үүсвэрийн хоорондох зай чухал байдаг. Сонсголын ноцтой алдагдлын үед хүн зөвхөн маш чанга дуу чимээг ойрын зайд сонсдог. (дүлийрэл) Бүрэн сонсгол алдагдал нь маш ховор тохиолддог. Бүр ноцтой сонсгол алдагдлын үед ч хүн

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

бага давтамжтай чанга дууг сонсдог. (бөмбөрийн дуу, хаалга тогших, чихэн дээр хашхирах гэх мэт)

ДЭМБ-аас сонсгол бууралтын түвшин тодорхойлох дараах 2 аргыг санал болгодог.

- Аудиометр
- Үгийн сорил буюу үгийн аудиометр - Үгийн сорилоор сонсгол хэвийн байгаа эсэхийг илрүүлэх бөгөөд шивнээ яриаг ашигладаг. Хэрвээ хүн муу сонсож байвал энгийн яриа, чанга авиа, хашхирсан дуу авиаг ашиглан сонсголын түвшин тогтоодог.

Сонсгол алдагдлын ялгаатай түвшин дэх сонсголын хүлээн авалт

Хүснэгт 1.

Сонсголын байдал, сонсгол бууралтын түвшин	Сонсголын дундаж босго	Энгийн болон чанга яриаг хүлээн авах	Шивнээ яриаг хүлээн авах
Хэвийн	< 25 дБ	10 метрээс их зайд	6 м
I түвшин (хөнгөн)	26- 40 дБ	6-3 м	2 м чихэнд
II түвшин (дунд зэрэг)	41-55 дБ	3 м чихэнд	Чихэнд сонсогдохгүй
III (дунд зэргийн хүнд буюу хүндэвтэр)	56-70 дБ	Чих рүү чангаар ярих	Сонсохгүй
IV (хүнд)	71-90 дБ	Чих рүү чанга хашхирах	Сонсохгүй
Дүлий	91 дБ-ээс дээш	Сонсохгүй	Сонсохгүй

Сонсголын бэрхшээл гэж юу вэ?

Сонсголын бэрхшээл нь дараах төрлүүдэд хуваагддаг.

- Дамжуулах хэлбэрийн сонсгол бууралт (гадна чихний суваг болон дунд чихэн дэх гэмтэл- дуу дамжуулалтад саад үүсэх)
- Мэдрэл- мэдрэхүйн гаралтай сонсгол бууралт (Сонсголын мэдрэл, дунгийн бусад бүтэц, үслэг эсийн гэмтэл- дууг хүлээж авахад саад үүсэх)

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

- Ретро дунгийн сонсголын бэрхшээл (сонсголын мэдрэлийн мэдрэхүйн өвчлөлийн үед эсвэл түүний улмаас үүссэн гэмтэл)
- Сонсголын төвийн эмгэг (Сонсголын системийн төвийн хальс болон хальсан доорх гэмтэл- дохионы анализад саад үүсэх)

Дамжуулах хэлбэрийн ба мэдрэлийн гаралтай сонсгол бууралт нь захын сонсголын бэрхшээл юм.

Дамжуулах хэлбэрийн сонсгол бууралтын үед эмчийн заавраар эмчилгээ хийх ба зарим тохиолдолд мэс заслын эмчилгээ хийдэг. Сонсголын аппарат хэрэглэхэд сонсгол сайжирдаг.

Чихний дунгийн суулгацыг мэдрэл мэдрэхүйн гаралтай сонсгол бууралттай хүнд суулгадаг. Хэрэв хүн чихний дунгийн хүлээн авагчуудын ихэнх хэсгийг (үслэг эс) гэмтээсэн бол орчин үеийн ямар ч хүчирхэг сонсголын аппарат түүнд тус болохгүй. Сонсголын аппаратын тусламжтайгаар дүлий хүн бага давтамжтай чанга болон дунд хэмжээтэй, тэр ч байтугай их биш зайд яригчийн хоолойг сонсож чадна. Гэвч энэ үед өндөр давтамжтай болон аяархан дуу чимээг сонсож чадахгүй, учир нь тэдгээрийг тархинд хүлээж авахад шаардлагатай цахилгаан дохионууд болгон хувиргадаг сормууслаг эсүүд гэмтсэн байдаг. Эдгээр дуу чимээнд ярианы ихэнх гийгүүлэгчүүд ордог. Тиймээс сонсголын их хэмжээний алдагдалтай хүнд сонсголын аппаратаар сонссон яриа нь ойлгомжгүй сонсогдож, харин дүлий хүүхдэд яриаг чихээрээ сонсоод ойлгож, ярьж сурахад маш хүнд байдаг. Ихэнхдээ ийм өвчтөнүүдэд чанга, чимээтэй дуунаас болж таагүй мэдрэмж төрж, улмаар сонсголын аппарат зүүхээс татгалздаг. Энэ тохиолдолд зөвхөн чихний дунгийн суулгац нь хүүхэд болон насанд хүрэгчдэд тусална. Чихний дун ясны эсүүд нөхөн сэргэдэггүй учир ямар ч эмчилгээ хийгээд үр дүн үзүүлдэггүй. Дунгийн суулгацын үйлдэл нь мэдрэл мэдрэхүйн гаралтай сонсголын бууралтын үед хамгийн их нөлөөлдөг чихний дунгийн хүлээн авагчид нь (үслэг эсүүд) сонсголын мэдрэлийн ширхгийн үүргээ удаан хугацаанд хэвээр хадгалагдан үлддэг дээр үндэслэгддэг.

Менингитийн нөлөөгөөр сонсголоо алдсан болон маш удаан хугацааны турш дүлий байсан ч сонсголын мэдрэлийн ширхгүүдийн тодорхой хэсэг нь хадгалагддаг. Дунгийн суулгац нь ерөнхийдөө сонсголын аппаратын нэг төрөл юм. Гэсэн хэдий ч дунгийн суулгац нь сонсголын аппаратаас дуу чимээг өсгөдөггүйгээрээ ялгагддаг. Харин дуун мэдээллийг сул

цахилгаан импульсын тусламжтайгаар шууд сонсголын мэдрэлд дамжуулж, дотоод чихний сормууслаг эсүүдийг орлодог. Дунгийн суулгац нь арьсан дор байрлах имплант болон гадна талд байрлах жижиг аудио процессороос бүрдэнэ.

Дунгийн суулгац нь сонсголоо их хэмжээгээр алдсан сонсголын аппарат хэрэглэдэг хүмүүст тулгардаг хамгийн чухал асуудлуудыг шийдвэрлэдэг.

Ихэвчлэн төрөлхийн сонсголгүй 7-оос доош насны хүүхэд, хэл ярианы хөгжилтэй олдмол сонсголгүй хүнд хийдэг.

Дунгийн суулгац ашиглах үед:

- Мэдээллийг бүх давтамжийн хүрээнд, түүний дотор өндөр давтамжийн бүсэд дамжуулдаг
- Дунгийн суулгацын процессор нь өргөн динамик хүрээний дуу чимээг илүү нарийн цахилгаан импульсийн хүрээнд дамжуулдаг тул аяархан болон чанга дуу чимээнүүдийг тухтай түвшинд хүлээж авдаг.
- Дуулдацтай эргэх холбоо үүсгэдэггүй (Акустик холбоо үүсгэдэггүй)
- Чихний бөглөөс (чихэвч) ашиглахтай холбоотой болон бусад асуудлууд байдаггүй.

Иймд дунгийн суулгац нь сонсголын их хэмжээний алдагдалтай бүр хамгийн хүчирхэг сонсголын аппаратыг ч хэрэглэдэг хүмүүст аяархан өндөр давтамжтай дуу чимээг хүлээж авах боломжийг өгдөг. Дунгийн суулгацтай хүн чанга дуу чимээг тухтай түвшинд хүлээж авдаг. Иймээс хүүхэд болон насанд хүрэгчид дунгийн суулгацыг бүхэл өдрийн турш тааламжтайгаар зүүдэг, энэ нь хүрээлэн буй орчны дуу чимээг байнга (тасралтгүй) сонсох боломжийг олгодог.

Чихний дунгийн суулгацын мэс заслын үйл явцад өвчтөний дотор чихэнд (дунд) сонсголын мэдрэлийн цахилгаан өдөөлтөөр дуу чимээг хүлээн авдаг электродуудыг суулгадаг.

Гэхдээ дунгийн суулгац нь зөвхөн мэс заслын үйл ажиллагаа биш юм, энэ нь цогц үйл ажиллагааны бүрдэл юм. Үүнд гурван бүрэлдэхүүн хэсэг ордог.

1. Мэс заслын өмнөх оношилгоо, үзлэг, дунгийн суулгацын мэс засалд орох өвчтөнийг сонгох
2. Мэс засал
3. Хагалгааны дараах дунгийн суулгацтай өвчтөний сонсгол хэл яриаг нөхөн сэргээх

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Дунгийн суулгац нь эдийн засгийн өндөр үр дүнтэй анагаахын аргад хамаардаг. (Cochlear implants ..., 1995). Санхүүгийн зардал, амьдралын чанарыг дээшлүүлэх гэсэн үзүүлэлтээр энэ нь “шинэ төрсөн нярайд эрчимт эмчилгээ хийх”, “зүрх судасны мэс засал”-уудын дараагаар гуравдугаар байрыг эзэлдэг. Гаднын улс орнуудад дунгийн суулгацыг ихэвчлэн эрүүл мэндийн компанийн даатгалаар эсвэл улсын зардлаар хийдэг. Зарим хагалгаануудыг орон нутгийн төсөв болон хувийн хэвшлийнхний зардлаар хийдэг. (өвчтөн өөрөө эсвэл ивээн тэтгэгч)

Хамгийн ойрын жишээ болох манай хойд хөрш ОХУ-д хагалгааны нийт зардлын 99 хувийг улсаас даадаг байна. Харин манай улсын хувьд энэхүү хагалгаа нь 2016 оноос өндөр өртөгтэй хагалгааны жагсаалтад орсноор улсын эрүүл мэндийн даатгалын сангаас хагалгааны нийт зардлын 75%-ийг, харин хувь хүн буюу өвчтөн, өвчтөний гэр бүл 25 хувийг өөрсдөө төлж хагалгаанд орж байна.

Бид дунгийн суулгацтай хүүхдүүдийн эцэг эхээс дунгийн суулгацын хагалгаа болон хагалгааны дараах нөхөн сэргээх хичээлийн талаар 12 асуумжаар судалгаа авсан болно. Судалгааны асуумжийг хавсралтаар оруулав.

Судалгааны үр дүн

Тус сургуулийн дунгийн суулгацын хагалгаанд орсон хүүхдүүдээс 22 хүүхдийг судалгаанд хамрууллаа. Хүйсээр нь авч үзвэл 11 эр, 11 эм 50:50- ийн харьцаатай байна.

1. Насны ангиллаар авч үзвэл:

Хүснэгт 2.

N	Valid	22
	Missing	0
Mode		6.00 ^a
Minimum		6.00
Maximum		15.00

Судалгаанд 6-15 насны сурагчид хамрагдсан. 6 настнууд түлхүү харагдаж байна.

Хүснэгт 3.

Нас	Давтамж	Эзлэх хувь
6.00	4	18.2
7.00	4	18.2
8.00	1	4.5
9.00	4	18.2
10.00	2	9.1
11.00	2	9.1
12.00	1	4.5
13.00	1	4.5
14.00	2	9.1
15.00	1	4.5
Нийт	22	100.0

Судалгаанд хамрагдсан сурагчдын насыг хүснэгтээр дээрх байдлаар харууллаа.

2. Сонголын бэрхшээлийн шалтгаанаар нь ангилж үзвэл:

Хүснэгт 4.

Шалтгаан	Давтамж	Эзлэх хувь
Төрөлхийн	15	68.2
Олдмол	7	31.8
Нийт	22	100.0

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Дунгийн суулгацын хагалгаанд орсон сурагчдаас төрөлхийн сонголгүй хүүхдүүд 68,2%-ийг эзэлж байна.

3. Олдмол шалтгаанаар сонголоо алдсан сурагчдын хувьд дараах байдлаар харагдаж байна.

Хүснэгт 5.

Хэзээ сонголоо алдсан	Давтамж	Эзлэх хувь
	15	68
1 нас гарантайдаа	1	4.5
1 наснаас хойш	2	9.1
11 настайдаа	1	4.5
2 нас 4 сартайд	1	4.5
Хэзээг нь мэддэггүй	1	4.5
Хэзээг нь мэдээгүй	1	4.5
Нийт	22	100.0

4. Сонсголын бэрхшээлийг анх хэзээ оношлуулсан бэ?

Хүснэгт 6.

Нас	Давтамж	Эзлэх хувь
Хэдэн нас	.10	1
хэдэн	.30	1

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

сартайдаа сонголоо оношлуулсан	.80	1	4.5
	1.00	8	36.4
	1.40	1	4.5
	2.00	4	18.2
	3.00	3	13.6
	4.00	1	4.5
	5.00	1	4.5
	11.00	1	4.5
	Нийт	22	100.0

(.10) - 1 сартай гэж ойлгоно. Эндээс манайд дөнгөж төрсөн нярайн сонголыг шалгадаг арга техник, тоног төхөөрөмж байдаггүй байсантай холбоотой. Манай улсад 2016 оны 9 сараас Хүрээ эмнэлэг, Амгалан Амаржих эмнэлгүүд сонгол шалгах төхөөрөмжийг хэрэглэж улмаар Налайхын нэгдсэн эмнэлэг болон бусад төрөх эмнэлгүүд сонгол шалгадаг төхөөрөмжийг хэрэглэн нярайн сонголыг эрт илрүүлэх боломжтой болжээ.

5. Дунгийн суулгацыг хэзээ хийлгэсэн бэ?

Хүснэгт 7.

N	Valid	22
	Missing	0
Mode		3.00
Minimum		1.00
Maximum		12.00

Судалгаанд хамрагдсан сурагчдаас 3 настайдаа 7 хүүхэд, багадаа 1 настайдаа, хожуу буюу 12 настайдаа хагалгаанд орсон байна.

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

6. Хагалгаанд орсон сурагчдын насыг хүснэгтээр доор үзүүлээ.

Хүснэгт 8.

Нас	Давтамж	Эзлэх хувь
1.00	1	4.5
2.00	4	18.2
3.00	7	31.8
4.00	3	13.6
5.00	1	4.5
6.00	1	4.5
7.00	2	9.1
8.00	1	4.5
11.00	1	4.5
12.00	1	4.5
Total	22	100.0

7. Дунгийн суулгацын хагалгаанд орсноор таны хүүхдийн зан байдалд өөрчлөлт орсон уу? тодорхой бичнэ үү?

Хүснэгт 9.

Хариултууд	Давтамж	Эзлэх хувь
Аппарат зүүхдээ дуртай биш, төвөгшөөдөг.	1	4.5
Аппаратаа зүүх дургүй	1	4.5

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Гараагүй	1	4.5
Дуу чимээнд бага хариу үзүүлдэг, өөрийн нэрийг дуудахад сонсдог, заримдаа инээгээд байдаг	1	4.5
Заримдаа хэт их баярлаад, заримдаа уцаартай байдаг	1	4.5
Ороогүй	1	4.5
Ууртай болсон, амархан ядардаг, нүдний хараанд нөлөөлж төвийн хараатай үлдсэн.	1	4.5
Ууртай уцаартай болсон, ядардаг	1	4.5
Үгүй	11	50.0
Хагалгааны дараа нүүрний мэдрэл дарагдсаны улмаас ам нь мурийсан учир маш ихээр уурлаж гомдоллон бараг харилцдаггүй	1	4.5
Хэвийн өөрчлөлт ажиглагдаагүй	1	4.5
Хэт чанга дуу чимээг төвөгшөөдөг	1	4.5
Нийт	22	100.0

Энэ асуулгын хариултаас хүүхдүүдэд зан байдлын хувьд их, бага байдлаар өөрчлөлт илэрсэн байна. Мөн зарим тохиолдолд төвөгшөөх, аппаратаа зүүхгүй байх, хараа муудах болон нүүрний мэдрэлд нөлөөлсөн тохиолдол илэрсэн нь хүүхдийн биеийн ерөнхий эрүүл мэндтэй холбоотой байж болох юм.

8. Дунгийн суулгацын хагалгаанд орсноор таны хүүхдийн хэл ярианы хөгжилд ахиц гарсан уу? Тийм бол тодорхой бичнэ үү?

Хүснэгт 10.

Хариултууд	Давтамж	Эзлэх хувь
------------	---------	------------

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Дуудахад нэрээ мэддэг, өөр хэдэн авиаг зөв хэлдэг	1	4.5
Аав, ээж, багшаа гэх зэргээр 10-20 үгийн сантай	1	4.5
Бага зэрэг ярих гэж хичээдэг	1	4.5
Багахан өөрчлөлт байсан	1	4.5
Гараагүй	5	22.7
Дуу чимээ сонсогдох үед тааламжтай байх шиг байдаг	1	4.5
Дуу чимээнд ядардаг болсон	1	4.5
Маш сайн үр дүнтэй байгаа	1	4.5
Муухан ярьдаг	1	4.5
Мэдэгдээгүй байна. хийлгээд удаагүй байна	1	4.5
Ойр зуурын үг хэлдэг болсон	1	4.5
Сонголын үлдэгдэлтэй, авиа дуудлага хэлдэг	1	4.5
Үгүй	2	9.1
Хэл ярианд бараг өөрчлөлт орохгүй байна.	1	4.5
Хэл ярианд өөрчлөлт ороогүй	1	4.5
Эерэг сайн байгаа	1	4.5
Ярьдаг болж байгаа	1	4.5

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Нийт	22	100.0
------	----	-------

Хагалгаанд орсон сурагчдад дээрх байдлаар өөрчлөлт ажиглагджээ. Мэргэжлийн эмч, эмнэлгийн зүгээс хагалгааны үйл явц нь тухайн хүүхдийн хэл ярианы хөгжилд бага хувиар нөлөөлнө гэж үздэг бол хамгийн чухал нөлөөлөх хүчин зүйл нь хагалгааны дараах нөхөн сэргээх , хэл заслын хичээлд хамрагдах нь илүү дүнтэй гэж үздэг байна.

9. Дунгийн суулгацын хагалгаанд хэдэн төгрөг зарцуулсан бэ?

Хүснэгт 11.

N	Valid	22
	Missing	0
Median	17500000.0000	
Mode	11000000.00	
Minimum	6500000.00	
Maximum	500000000.00	

6.5 саяас 50 сая хүртэлх төгрөгөөр дотооддоо болон солонгос улсад энэхүү хагалгааг хийлгэсэн байна. Дийлэнх нь ойролцоогоор 11 сая орчим төгрөгөөр, нийт хагалгаанд орсон хүүхдүүдийн ар гэрээс дунджаар 17.5 сая төгрөг зарцуулагджээ.

10. Дунгийн суулгацын хагалгааны дараах нөхөн сэргээх, засан сайжруулах хичээлд хүүхдээ хамруулдаг уу?

Хүснэгт 12.

Хариултууд	Давтамж	Эзлэх хувь
Өдөр бүр	4	18.2
7 хоногт 2-3 удаа	10	45.5
Сард 1-2 удаа	5	22.7

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Үгүй	3	13.6
Нийт	22	100.0

Дунгийн суулгацтай хүүхдүүд нөхөн сэргээх хичээлд дээрх байдлаар хамрагддаг байна. Эндээс дунгийн суулгацын хагалгааны дараах засан сайжруулах болон хэл заслын хичээлд тогтмол хамруулж чадахгүй байгаа нь харагдаж байна. Энэ нь хүүхдийн хэл ярианы хөгжилд ахиц гарахгүй байх шалтгаан болж байна.

11.Нөхөн сэргээх, засан сайжруулах хичээлийн дараа таны хүүхдийн хэл ярианы хөгжилд ямар өөрчлөлт үр дүн гарч байна вэ?

Хүснэгт 13.

Хариултууд	Давтамж	Эзлэх хувь
Аав, ээж, хоол гэх зэргээр хэлдэг	1	4.5
Ахиц харагдаж байгаа	1	4.5
Бага зэргийн өөрчлөлт ажиглагдаж байсан ч толгой нь өвддөг болсноор хичээлд хамрагдах дургүй болсон. Дохио хэрэглээд байдаг учраас тоохгүй байсан	1	4.5
Багахан ярих гэж оролддог	1	4.5
Богино өгүүлбэрээр ойлголцдог	1	4.5
Гараагүй	4	18.2
Гарсан. ярих гэж хичээж байгаа	1	4.5
Маш ахицтай байсан	1	4.5
Мэдэгдээгүй байна	1	4.5

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Нийтэч нөхөрсөг болж байсан.	1	4.5
Нөхөн сэргээх, засан сайжруулах хичээлд явж чадаагүй учир үр дүн харагдахгүй байна	1	4.5
Нэг хоёр үгээр ойлголцдог болсон	1	4.5
Өөрчлөлт мэдэгдээгүй	1	4.5
Өөрчлөлт харагдаагүй	1	4.5
Сайн байсан	1	4.5
Үгээ зөв хэлдэг болж байгаа, амьтны дууг ялгаж мэддэг болж байгаа	1	4.5
Хараахан өөрчлөлт харагдахгүй байна	1	4.5
Хичээлд хамрагдаж байгаагүй	1	4.5
Эмээ өвөөтэйгөө ярьдаггүй ангидаа багахан ярьдаг	1	4.5
Нийт	22	100.0

Тогтмол болон тодорхой хугацаагаар хичээлд хамрагдаж байгаа хүүхдүүдийн хэл ярианд ахиц гарч байгаа нь харагдаж байгааг эцэг эхчүүд дурджээ.

12. Та хүүхдэдээ дунгийн суулгацын хагалгаа хийлгэсэндээ сэтгэл хангалуун байдаг уу?

Хүснэгт 14.

Хариултууд	Давтамж	Эзлэх хувь
Сэтгэл хангалуун байдаг	8	36.4
Сэтгэл дундуур байдаг	3	13.6
Сэтгэлд хүрээгүй	10	45.5

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Үр дүнг нь үзээгүй байна	1	4.5
Нийт	22	100.0

Эцэг эхчүүдийн сэтгэл ханамжийн байдлаас үзэхэд ихэнх нь сөрөг хандлагатай байгаа нь дунгийн суулгацын хагалгааны талаар мэдлэг мэдээлэл дутмаг, хагалгааны дараах нөхөн сэргээх, хэл заслын хичээлд хүүхдээ тогтмол хамруулаагүйгээс үүдэлтэй хагалгааны үр дүнтэй холбоотой байна.

13. Дунгийн суулгацын хагалгаа болон нөхөн сэргээх, засан сайжруулах хичээлийн талаар санал хүсэлтээ бичнэ үү?

Хүснэгт 15.

Хариултууд	Давтамж	Эзлэх хувь
Байхгүй	7	31.8
Дунгийн суулгац хэрэггүй юм байна гэж бодсон	1	4.5
Сайн мэдэхгүй байна.	1	4.5
Тууштай байсан бол гэж боддог	1	4.5
Хэл засал нөхөн сэргээх хичээлд явуулмаар байдаг ч хаана хандахаа мэдэхгүй байна	1	4.5
Хэл заслын хичээлийг илүү оруулах дохиогоор харилцахгүй байх	1	4.5
Хэл заслын хичээлд анхаарах	1	4.5
Хэл заслын хичээлд илүү анхаарах	1	4.5
Хэл заслын хичээлд түлхүү хамруулмаар байна.	1	4.5
Хэл заслын хичээлд тууштай явуулах	1	4.5

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Хэл заслын хичээлд явуулмаар байдаг	1	4.5
Хэл заслын хичээлийг сайн орох	1	4.5
Хэл заслын хичээлийг сайн оруулмаар байна.	1	4.5
Хэл заслын хичээлийг үр дүнтэй явуулах	1	4.5
Хэл заслын хичээлийн цагийг нэмэхэд анхаарах	1	4.5
Хэл заслын хичээлийн цагийн нэмэх хүсэлтэй байна	1	4.5
Нийт	22	100.0

Эцэг эхчүүдийн өгсөн хариултуудаас үзэхэд дунгийн суулгацын хагалгаа болон нөхөн сэргээх, засан сайжруулах хичээлийн талаар тодорхой ойлголт, мэдлэг дутмаг, зарим тохиолдолд хүүхдийнхээ бодит байдал, бодит чадварыг хүлээн зөвшөөрч чадахгүй байна гэсэн дүгнэлтэд хүрлээ. Мөн сонсголын бэрхшээлтэй хүүхдийн дунгийн суулгацын хагалгаанд зөвхөн анагаахын талаас нь хандах биш мөн боловсролын талаас, тухайлбал тусгай хэрэгцээт боловсролын салбарт энэхүү хагалгаанд орж байгаа хүүхдүүдийн боловсролын асуудал, хагалгааны дараах нөхөн сэргээх, засан сайжруулах үйл явцад анхаарлаа хандуулах цаг болсон байна.

Дүгнэлт

Бидний судалгааны үр дүнгээс харахад дунгийн суулгацын хагалгаанд орсон сурагчдын ихэнх буюу 36,3 хувийг 6,7 настай хүүхдүүд эзэлж байгаа нь хүмүүс сүүлийн үед дунгийн суулгацын хагалгааг ихээр сонирхож хийлгэдэг болсон байна.

Судалгаанд хамрагдсан эцэг эх болон сурагчдын судалгааны үр дүнгээс харахад хэл заслын хичээлд хамрагдсан хүүхдийн сонсох чадвар нь нэмэгдсэн. Хэл заслын хичээлд хамрагдаагүй сурагчдын сонсголд мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй байна. Иймээс хэл заслын хичээлд хамрагдах нь хагалгааны үр дүнг нэмэгдүүлэх үр дүнтэй арга болох нь харагдаж байна.

Хагалгаанд орсон сурагчдын эцэг эхчүүдийн сэтгэл зүйг харахад хагалгааны дараа үр дүн нь шууд илэрнэ /хагалгааны дараа сонсголттой болох/ гэсэн хүлээлт бий болсноор хэл заслын хичээлд хамруулахгүй байна. Мөн дунгийн суулгацын хагалгаанд 1 хүүхдэд

дунджаар 11 сая төгрөг зарцуулж байгаа нь санхүүгийн хувьд эцэг эхэд хүндээр нөлөөлж буй нь дараа дараагийн нөхөн сэргээх эмчилгээнд /хэл заслын төлбөртэй хичээлд / хамруулж чадахгүй байна.

Эцэг эхчүүд дунгийн суулгацын хагалгаа болон нөхөн сэргээх, засан сайжруулах хичээлийн талаар тодорхой ойлголт, мэдлэг дутмаг, зарим тохиолдолд хүүхдийнхээ бодит байдал, бодит чадварыг хүлээн зөвшөөрч чадахгүй байна.

Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн дунгийн суулгацын хагалгаанд зөвхөн анагаахын талаас нь хандах биш боловсролын талаас, тухайлбал тусгай хэрэгцээт боловсролын салбарт энэхүү хагалгаанд орж байгаа хүүхдүүдийн боловсролын асуудал, хагалгааны дараах нөхөн сэргээх, засан сайжруулах үйл явцад анхаарлаа хандуулах цаг болсон байна.

Ном зүй

- [1] МУБИС-ийн багш нарын хамтын бүтээл, “Багш боловсролын үндэс”. УБ, 2011.
- [2] Г.Батцэнгэл, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах сэтгэл зүйн үндэс” . УБ, 2018.
- [3] МУБИС-ийн багш нарын монгол хэлнээ хөрвүүлсэн хамтын бүтээл, “Тусгай хэрэгцээт боловсрол”, УБ, 2018.
- [4] О.Мягмар, “Судлаач багшийн гарын авлага”, УБ, 2011.
- [5] Т.Батболд, Д.Ариунаа, Б.Баярмаа, С.Батцэцэг, Д.Зол-Эрдэнэ, “Судалгааны арга зүй”, УБ, 2017.
- [6] Ч.Алтанцэцэг, Б.Оюунцэцэг, “Хэл ярианы тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхэдтэй ажиллах арга зүйн зөвлөмж”, УБ, 2018.
- [7] Хаяаши Кензо, “Тэгш хамруулан сургах боловсрол”
- [8] Д. Эрдэнэчулуун, “Гэр бүлийн сэтгэл зүйн зөвлөгөө”, УБ,2012
- [9] Ц.Гэрэлтуяа, Я.Цэвээнлхазал, Ц.Батжаргал, Д.Хорлоо, М.Ганцэцэг, Н. Нямсүрэн, Ч.Ганбилэг нарын хамтын бүтээл, “Хүүхдэд тохиолдох хөгжлийн бэрхшээл ба түүнийг засан сайжруулах аргууд”, (2004). Улаанбаатар. Өнгөт хэвлэл ХК.

[10] <https://www.who.int/news-room/fact-sheets/detail/deafness-and-hearing-loss>

[11] <https://ikon.mn/n/1nx9>

Талархал

Судалгаанд идэвхтэй хамрагдсан нийслэлийн Сүхбаатар дүүргийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 22 сурагч болон тэдний эцэг эх, ‘Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв’-ийн сонсголын эмч н. Саруул, ‘Эрүүл мэндийн яам’ -ны мэргэжилтэн н.Тунгалаг, Эрүүл мэндийн хөгжлийн газар, Нэгдүгээр төрөх эмнэлгийн нярайн эмч н.Минж нартаа бидэнд шаардлагатай мэдээллүүдийг өгч тусалсанд талархал илэрхийлье.

Хавсралт

Дунгийн суулгацтай хүүхдийн эцэг эх асран хамгаалагчдаас авах асуумж.

Хүүхдийн овог нэр:.....

1. Нас:.....

Хүйс:.....

2. Сонсголын бэрхшээлийн шалтгаан

а. Төрөлхийн

б. Олдмол

3. Хэрэв олдмол бол хэзээ сонсголоо алдсан бэ?

.....
.....

4. Сонсголын бэрхшээлийг анх хэзээ оношлуулсан бэ?

.....
.....

5. Дунгийн суулгацыг хэзээ хийлгэсэн бэ?, Хэдэн настайдаа хийлгэсэн бэ?

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

.....
.....

6. Дунгийн суулгацын хагалгаанд орсноор таны хүүхдийн зан байдалд өөрчлөлт орсон уу? Тийм бол тодорхой бичнэ үү?

.....
.....

7. Дунгийн суулгацын хагалгаанд орсноор таны хүүхдийн хэл ярианы хөгжилд ахиц гарсан уу? Тийм бол тодорхой бичнэ үү?

.....
.....

8. Дунгийн суулгацын хагалгаанд хэдэн төгрөг зарцуулсан бэ?

.....
.....

9. Дунгийн суулгацын хагалгааны дараах нөхөн сэргээх, засан сайжруулах хичээлд хүүхдээ хамруулдаг уу?

а. Өдөр бүр

б. 7 хоногт 2-3 удаа

в. Сард 1-2 удаа

г. Үгүй

10. Нөхөн сэргээх, засан сайжруулах хичээлийн дараа таны хүүхдийн хэл ярианы хөгжилд ямар өөрчлөлт үр дүн гарч байна вэ?

.....

11. Та хүүхдэдээ дунгийн суулгацын хагалгаа хийлгэсэндээ сэтгэл хангалуун байдаг уу?

а. Сэтгэл хангалуун байдаг

б. Сэтгэл дундуур байдаг

в. Сэтгэлд хүрээгүй

г. Үр дүнг үзээгүй байна.

12. Дунгийн суулгацын хагалгаа болон нөхөн сэргээх, засан сайжруулах хичээлийн талаар санал хүсэлтээ бичнэ үү?

.....
.....

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ ИЛРҮҮЛЭХ АРГАЧЛАЛЫГ ЗОХИЦУУЛАН ХЭРЭГЛЭСЭН НЬ

Х.Алтанхундага¹, Б.Туяа², Д.Баяраа³

¹ОТИС-ийн СХСС-ын тэнхимийн багш, доктор

²МУБИС-ийн Сэтгэл судлал, арга зүйн тэнхимийн эрхлэгч,

Доктор, профессор

³Үй-Цай сургуулийн захирал, Доктор, дэд профессор

Хураангуй

Бага насны хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийн илрүүлэг нь тухайн бэрхшээлийн хүндрэлийг багасгаж, хөгжлийн бэрхшээлтэй болох эрсдэлийг 30 хувиар бууруулах боломжтой болохыг Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас мэдээлсэн байна. Хөгжингүй орнуудад хүүхдийг 0-3 насанд, зарим улсад 0-5 насанд нь хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг илрүүлэх, дэмжлэг үзүүлэх хөтөлбөр, сэргээн засах болон эмчилгээ, оношилгоо зэрэгт хамруулах талаар хууль тогтоомж, дүрэм журамд тусган хэрэгжүүлж иржээ. Монгол улсад өнөөдрийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх орчныг бүрдүүлэхэд анхаарсан эрх зүйн баримт, бичгүүд батлагдан гарсан нь нэг талаасаа бага насны хүүхдийг боловсролд хамруулах, дэмжих, хөгжлийн онцлогт нийцсэн сургалтыг зохион байгуулах нэгэн үндэслэл болох боловч нөгөө талаасаа хөгжлийн бэрхшээлийг хэрхэн илрүүлэх талаарх үйл явцыг нарийвчлан тодруулсан зүйл үгүйлэгдэж байна. Тухайлбал цэцэрлэгт өдөр тутмын үйл ажиллагааны явцад үеийн хүүхдээс хөгжлийн хувьд хоцорсон, хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүй хүүхдийг илрүүлэх, тэдэнд дэмжлэг үзүүлэх ажлын зохион байгуулалт дутмаг байдал практикт харагдаж байна. Дээрх онцлог, нөхцөл байдалд үндэслэн бид хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүй хүүхдийн илрүүлэх арга, түүнийг зохион байгуулах хэрэгцээ үүсэж байна хэмээн үзэж байна. Бидний судлаачид энэхүү илтгэлээр гадаадын судлаачдын боловсруулсан аргачлалыг зохицуулан хэрэглэх ажлын онцлог, хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүхдийг илрүүлэх аргачлалыг зохицуулан хэрэглэх чиглэлээр Монгол судлаачдын хийсэн ажлын тойм, Японы судлаач Reiko Kurosawa (2008)-ийн боловсруулсан “4-5 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн илрүүлэг”-ийн аргыг зохицуулан хэрэглэсэн туршлага болон цаашид хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүхдийг илрүүлэх талаар тулгамдаж буй асуудлыг тоймлон тусгасан болно.

Түлхүүр үг: Зохицуулах хэрэглэх, Баталгаат чанар, Найдвартай байдал, Зорилтот илрүүлэг

Удиртгал

Хүүхдэд хөгжлийн бэрхшээл үүсэхээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, тэдэнд үүсэж байгаа ямар нэгэн гэмтэл согогийг засах зэрэг асуудал нь нийгмийн салбарын маш хязгаарлагдмал хүрээнд яригддаг байсан бол одоо энэ асуудлыг нийт үндэстний хэмжээнд авч үзэх болжээ. Олон улсын хэмжээнд илрүүлэг гэдэг нэгдсэн ойлголт буй болж түүнийг дараах гурван төрөлд хуваан авч үздэг байна.

Хүснэгт 1. Хөгжлийн бэрхшээлийн илрүүлгийн төрөл

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Илрүүлгийн төрөл	Онцлог
Албан бус илрүүлэг (Informal screening)	Хүүхдийн хөгжлийн асуудлаар эцэг эх, асран хамгаалагчдаас асууж тодруулах, ээлжит үзлэгүүдийн үеэр ажиглалт явуулдаг илрүүлгийн төрөл
Албан ёсны илрүүлэг (Formal screening)	Стандартчилагдсан илрүүлгийн арга хэрэгсэл ашиглан эрсдэлтэй байж болзошгүй хүүхдүүдийг хамруулан хөгжлийн хоцрогдол болон зан үйлийн эмгэгтэй хүүхдийг шигших системчилсэн илрүүлгийн төрөл.
Зорилтот илрүүлэг (Focused screening)	Эцэг эхчүүд болон багш нар хөгжлийн эрсдэлтэй байж болзошгүй байдлыг анзаарсан эсвэл төрөх үеэс эхлэн хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүй шинж тэмдэг илэрсэн хүүхдүүдийг хамруулдаг илрүүлгийн төрөл

Эх сурвалж: Lord&Jones, 2012

Барууны орнуудад Брүүкс-Ганн, Левис нар илрүүлгийг жинхэнэ оношлох үйл явц бус харин хөгжлийн бэрхшээлийн эрсдэлтэй байж болзошгүй нөхцөлийг эрт илрүүлэх үйл явц гэж тодорхойлсон бол, Кэнни, Күлбэртсон нар ердийн хүүхдүүдийн дундаас хөгжлийн бэрхшээлтэй байх эрсдэлтэй хүүхдүүдийг шигших үйл явц гэж үзсэн. Харин Лийдз илрүүлэг нь хүүхдийг оношлох эмчлэх зорилго агуулах бус харин тэднийг эрсдэлтэй, анхаарууштай, хэвийн гэсэн 3 ангилалд шигших үйл явц зэрэг тодорхойлолт байгааг дурдсан байна.

Л.С.Выготский хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг ялган таних, үнэлэхдээ уламжлалт тогтонги төлөвт (статик) бус харин хөдлөнги төлөвт (динамик) авч үзэх онолын үзэл баримтлалыг дэвшүүлсэн бөгөөд үүнийг орчин үед “Dynamic assessment” гэдэг нэр томъёогоор илэрхийлж байна. Динамик үнэлгээний гол зарчим нь үр дүнг үнэлэхээс илүүтэй үйл явцад анхаарал хандуулдаг. “Хөдөлгөөнгүй зогсонги дүрслэлээр бус гагцхүү хөдөлгөөний явцад бие махбодын онцлогийг олж илрүүлэх нь чухал” хэмээн Л.С.Выготскийн авч үзсэнчлэн динамик үнэлгээ нь нийгэм соёлын ялгаатай байдлыг илрүүлэхүйц сэтгэл зүйн хэрэгсэл,

аргачлалуудыг боловсруулж хэрэглэх онолын үндэслэл болж байна (Gindis.B 1995; Lidz.C&Gindis.B 2003).

Хүүхдийн хөгжлийн үнэлгээний тогтолцоо, судалгааны чиг хандлагад нийцсэн илрүүлгийн олон арга байдаг ч тэдгээрийн хэрэглээ, илрүүлэх чадамж нь харилцан адилгүй байна. Хөгжлийн бэрхшээлийг илрүүлэх арга нь улс орон бүхэнд ашиглахад тохиромжтой, тухайн орон нутгийн соёл, зан заншлын ялгаатай байдлыг тусгахуйц байх шаардлага гарсаар байна. Гадаадын аргачлалыг “зээлж” хэрэглэх нь түүнийг зөвхөн орчуулах асуудлаар хязгаарлагдахгүй. Аргачлалын орчуулга хэчнээн төгс, мэргэжлийн өндөр түвшинд хийгдсэн ч энэ нь аргачлалыг нийгэм-соёлын өөр нөхцөлд зохицуулах цаг хугацаа, хөдөлмөр шаардсан цогц ажиллагааны зөвхөн эхлэл юм. (Сарантуяа.Б,2020) Аргачлал зохиогдсон тухайн нийгэм, соёлын өвөрмөц онцлог, зан заншил, уламжлалт, үнэт зүйл зэрэг нь хэл ярианд тусгагдсан байх бөгөөд энэхүү онцлогт тохирч нийцсэн ижил хувилбарыг олоход ихэд төвөгтэй, зарим тохиолдолд боломжгүй болох ч талтай.

Манай улсын судлаачдын зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг илрүүлэх асуудлаар судалгааны аргачлалуудыг амжилттай зохицуулан хэрэглэж ирсэн байдаг. Тухайлбал

- ❖ Монгол улсын Хараат бус судалгааны хүрээлэнгээс “Тэгш хамруулах боловсролыг дэмжих” сэдэвт судалгааны ажлаар Вашингтон бүлгийн аргачлалыг ашиглан үйл ажиллагааны бэрхшээлтэй хүүхдүүдийн тоо, статистикийг тооцож гаргах зорилгын хүрээнд судалгааны ажлыг хийсэн байна.
- ❖ МУБИС, Нагояагийн их сургуулийн хамтарсан баг оюун ухааны сорилын Япон хувилбарыг орчуулж, Монголын нийгэм, хэл соёлын онцлогийг харгалзаж, Монгол хүүхдийн хөгжлийг үнэлэх баталгаатай “Монгол Танака Бине” аргачлал боловсруулахыг зорин ажиллаж байна
- ❖ МУБИС-ийн “Хүүхдийн хөгжлийг дэмжих төв” нь илрүүлэх, тодруулах, оношлох, тодорхойлох, ганцаарчилсан хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлийн үйл ажиллагааг зохион байгуулж ирсэн байна.
- ❖ Судлаач Б.Туяа зэрэг судлаачид хүүхдийн оюун ухааны хөгжлийн асуудлаар судалгааны аргачлалуудыг зохицуулан хэрэглэсэн байдаг.

Бидний судлаачид “Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн илрүүлэг, эрт үеийн дэмжих хөтөлбөрийг туршсан үр дүн” эрдмийн зэрэг горилсон бүтээлийн хүрээнд Японы судлаач

Reiko Kurosawa (2008)-ийн боловсруулсан “4-5 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн илрүүлэг”-ийн аргыг гинжин түүврийн аргаар хэрэглэж туршсанаар шинэлэг гэж үзэж байна.

Судалгааны зорилго, зорилт: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг (аутизмын хүрээний эмгэг, анхаарлын дутмагшил хэт хөдөлгөөнтөх эмгэг, суралцахуйн бэрхшээл, зан үйлийн эмгэгийн хүрээнд) илрүүлэх аргыг турших, үр дүнг тооцох бөгөөд дараах зорилтуудыг дэвшүүлэн тавьсан болно. Үүнд:

- ❖ Хөгжлийн бэрхшээлийн илрүүлгийн аргын талаарх онол, арга зүйн судалгааны бүтээлүүдэд дүн шинжилгээ хийх
- ❖ Reiko Kurrosawa-ийн боловсруулсан 4-5 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн илрүүлгийн аргачлалыг орчуулан Монголын нөхцөлд зохицуулалт хийх
- ❖ Хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлэх ажиглалтын хуудсаар албан ёсны (formal screening) илрүүлэг, Reiko Kurrosawa-ийн аргачлалаар зорилтот (focused screening) илрүүлэг зохион байгуулж үр дүнг дүгнэх

Судалгааны арга зүй

Судалгааны зорилгод хүрэхийн тулд баримтын шинжилгээ, ажиглалт, асуулга, математик боловсруулалт, туршилт зэрэг дараах аргуудыг хэрэглэсэн. Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүний онцлог, бэрхшээлийг илрүүлэх аргуудын талаар мэдээлэл цуглуулах баримтын шинжилгээ
2. Хүүхдийн хөгжлийн түвшинг тогтоох “Сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлэх ажиглалтын хуудас”
3. Reiko Kurrosawa (2008)-гийн “4-5 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн илрүүлгийн асуулга”
4. Судалгааны мэдээллийг боловсруулах IBM Statistics SPSS 25, Venzim программ
5. Чанарын судалгааны мэдээлэл боловсруулах Smart PLS demo программ

Японы эрдэмтэн Reiko Kurrosawa-ийн боловсруулсан “4-5 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн илрүүлэг”-ийн аргачлалыг ашиглахдаа бид зохиогч, хэвлэлийн газраас албан ёсны зөвшөөрлийг авч ашигласан болно.

Зориулалт. Оношилгооны аргачлал биш бөгөөд эцэг эх, асран хамгаалагчид, багш нар нь хөгжлийн бэрхшээлийн эрсдэлтэй байж болзошгүй (аутизмын хүрээний эмгэг, анхаарлын дутмагшил хэт хөдөлгөөнтөх эмгэг, зан үйлийн эмгэг, суралцахуйн бэрхшээлийн

хүрээнд) хүүхдийг илрүүлэх зорилготой. Энэхүү аргачлал 4 шкал, 14 дэд шкал, 125 үзүүлэлттэй бөгөөд үнэлгээг жилд хоёроос доошгүй удаа хийж, үр дүнг тооцох юм.

Үр дүнг боловсруулах: Судалгаанд оролцогч багш, эцэг эхээс тухайн хүүхдийн өдөр тутмын үйл ажиллагаа, сургалтын явцын ажиглалт зэрэгт тулгуурлан үзүүлэлт бүрийн ард байгаа хариултаас (1-огт үгүй, 2-хааяа, 3-заримдаа, 4-үе үе, 5-үргэлж) тохирох хувилбарыг сонгоно. Хариултад хамаарах оноог хооронд нь нэмж, тооцоод дундаж оноог гаргана. Тухайн хүүхдийн багш, эцэг эхээс үзүүлэлтүүдэд өгсөн онооны дунджаар дэд шкалын оноог гарган, гурваас дээш оноо авсан бол хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүйг харуулна. Мөн радарын зураг байгуулж, төв цэгээс 1-5 хүртэл дугаарласан бүсэд дэд шкалын оноог байрлуулна. Тойргийн төв 3-р бүсээс гадагшаа тэлэх зураглал хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүйг харуулна.

Найдварт байдал. Японы 4-5 настай 200 хүүхдийг хамруулан хийгдсэн судалгааны үр дүнд найдвартай байдлын коэффициент 0.87 буюу дотоод тогтвортой байдал маш сайн болох нь тогтоогдсон. Монгол түүвэр дээрх судалгааны хүрээнд тус аргачлалын найдвартай байдлыг авч үзэхэд Cronbach's Alpha, Rho_A, Composite Reliability нь 0.8-аас дээш, Average Variance Extracted 0.7-аас дээш байгаа нь найдвартай, асуулт оновчтой, тухайн дэд шкалыг бүрэн илэрхийлэхүйц байна.

Илрүүлгийн аргачлалыг Монгол түүвэр дээр зохицуулан хэрэглэх судалгааны ажлыг (2016-2020 он) эхний, туршилт хэсгээр зохион байгуулсан болно.

Судалгааны эхний хэсэг: Японы эрдэмтэн Reiko Kurrosawa-ийн аргачлалыг Монгол түүвэрт зохицуулах ажлын хүрээнд Оросын сэтгэл зүйч Ю.Л.Ханины асуулгыг зохицуулан хэрэглэх загварыг үндэслэл болгон дараах үе шаттай ажилласан болно (Туяа.Б, 2006). Үүнд:

1.Эх хувилбараас хэрэглэгчийн хэл рүү буулгасан орчуулгын урьдчилсан хувилбар боловсруулах. Японы судлаач Reiko Kurrosawa-ийн боловсруулсан “4-5 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн илрүүлэг” аргачлалыг зохиогчоос зөвшөөрөл авч, Япон–Монгол–Япон хэл рүү орчуулсан.

2. Хэл шинжээч, эх хэлийг эзэмшсэн сэтгэл зүйч, бусад мэргэжлийн хүмүүсийг оролцуулан орчуулгын урьдчилсан хувилбарт шинжээчийн үнэлгээ хийх. Хэл шинжээч болон эх хэлийг эзэмшсэн мэргэжлийн сэтгэл зүйчийг оролцуулан илрүүлгийн аргачлалын хэл найруулгыг хянаж, зохиогчийн сэтгэц хэмжил зүйн нарийн боловсруулалтыг аль болох бага хөндөж, эх материалын утга санааг хадгалахын хамтаар Монгол хүүхдийн соёл ахуйд тохирсон үг

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

хэллэг хэрэглэхийг зорьсон. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оношлох, анагаах засан сайжруулах сургалтыг зохион байгуулах, сэтгэц оношилгооны аргачлалыг зохицуулах асуудлаар ажиллаж ирсэн экспертүүд 4 шкал, 14 дэд шкалд хамаарах 125 үзүүлэлтийн хөгжлийн бэрхшээлийг илрүүлэх шинж нь хэр тохирч буй эсэхэд 1-6 хүртэл оноогоор үнэлсэн. Экспертүүдээс 4 шкалын 125 үзүүлэлтээс 107 үзүүлэлт буюу 83%-ийг “маш чухал”, 18 үзүүлэлт буюу 11%-ийг “нэлээд чухал” гэж үзсэн нь аргачлалыг хэрэглэх боломжтойг харуулж байна.

Япон хэл дээрх хувилбар болон экспертүүдийн дэвшүүлсэн санаатай харьцуулж хэл соёлын ялгаатай байдлыг тусгасан 3 асуултыг өөрчилсөн.

Хүснэгт .2. Монгол хүүхдийн онцлогт тохируулан өөрчилсөн асуултууд

Үзүүлэлт №	4-5 настай хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн илрүүлэг (Япон хувилбар)	4-5 настай хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн илрүүлэг (Монгол хувилбар)
1.3.23	Цөөн тооны нэг зүйлд хэт их анхаардаг (Усанд сэлэх зэрэг)	Зураг зурах, нэг эгнээнд юмсыг өрөх, тоолох зэрэг цөөн тооны үйлдэлд анхаарал хандуулж хийх нь их
3.3.82	Үгийг буруу хэлдэг (загасдагас, алим- халим)	Ярих үедээ заримдаа гийгүүлэгч авиа, үсгийг сольж хэлэх тохиолдол илэрдэг (шар- сар, хус-хуш, бар-бал зэрэг)
4.1.113	Цэцэрлэгт хүрээлэнгээр алхах дургүй	Цэцэрлэгтээ очихоос дургүйцдэг

Шкал-I-ын “Давтамжтай үйлдэл хийх” дэд шкалын 1.3.23 үзүүлэлтийг өөрчлөх үндэслэл нь Япон улсын сургуулийн өмнөх бага боловсролын хөтөлбөрт хүүхдийг усанд сэлж сургах чадвар тусгагддагтай холбогдох тус үзүүлэлтийг бид Монгол хүүхдийн хувьд зураг зурах, нэг эгнээнд тухайн зүйлийг дахин дахин өрөх үйлдэл ихээр хийх нь түгээмэл байдагтай холбон авч үзсэн.

Шкал-II-ын “Ярих чадвар” дэд шкалын 3.3.82 үзүүлэлтийг Монгол хүүхдийн авиан буруу дуудлага нь с,ш,д,т,л, р зэрэг авиаг ойролцоо дуудлагатай авиагаар сольж хэлэх байдлаар (Батдэлгэр, 2002) илэрдэг гэж үздэг тул бид жишээ болгож шар-сар, хус- хуш зэрэг үгийг сонгон авсан болно.

Шкал-IV-ын “Зан үйл” дэд шкалын 4.1.113 үзүүлэлтийг Монгол хүүхэд цэцэрлэгт хүрээлэнгээр алхахаас илүүтэй нийгмийн орчны нэг болох цэцэрлэгт дасан зохицох, үе тэнгийнхэнтэй харилцах зэрэгт бэрхшээл үүсэх магадлалтай холбон өөрчилсөн болно.

3. Хөгжлийн бэрхшээлийг илрүүлэх олон улсад түгээмэл хэрэглэдэг аргуудтай харьцуулах.

Илрүүлгийн асуулга, сорилуудыг мэргэжлийн хүмүүс удирдан явуулах эсвэл эцэг эх, асран хамгаалагч нар бие даан хэрэглэх гэж хоёр ангилж үздэг байна. Америкийн тусгай хэрэгцээт боловсролын академийн Roger Pierangelo & George Giuliani нарын эрдэмтдийн “The special educator’s comprehensive guide to 301 diagnostic test” бүтээл (2005) болон бусад эх сурвалжаас аутизмын хүрээний эмгэг, анхаарлын дутмагшил хэт хөдөлгөөнтөх эмгэг, зан үйлийн эмгэг, суралцахуйн бэрхшээлийг илрүүлэх аргачлалыг сонгон авсан.

Сонгон авсан дээрх бэрхшээлийн илрэх аргачлалыг харьцуулан, анализ хийсэн. Илрүүлгийн арга нь үе тэнгийн хүүхдүүдийг хамруулан бие бялдар, нийгэмшихүй, танин мэдэхүйн чиглэлээр үнэлэхдээ аливаа эмгэг, өөрчлөлт, хоцрогдлыг олж илрүүлэх, нэг эсвэл иж бүрэн байдлаар хэд хэдэн эмгэгийг илрүүлэхэд чиглэгдсэн онцлогтой байна. Үүнд

- ❖ Аутизмын хүрээний эмгэгийг илрүүлэх асуулгын шалгуур үзүүлэлт нь бага насны хүүхдийн зан үйл, харилцаа, нийгэмшил-сэтгэл зүй, харилцааны чадварыг илрүүлэхэд чиглэгдсэн.
- ❖ Анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэгийг илрүүлэх асуулгын шалгуур үзүүлэлт нь бага насны хүүхдийн анхаарлын төвлөрөлт, тогтворгүй байдал, хөдөлгөөн, зан үйл, сурах чадварыг илрүүлэхэд чиглэгдсэн.
- ❖ Суралцахуйн бэрхшээлийг илрүүлэх чиглэлээр тусдаа бие даасан асуулгын аргууд байхгүй ч хүүхдийн өсөлт хөгжил, зан үйл, сурах чадвартай холбоотой асуулгууд хоорондоо холбоотой байна.
- ❖ Зан үйлийн эмгэгийг илрүүлэх шалгуур үзүүлэлт нь дасан зохицох, өдөр тутмын үйл ажиллагаа, өөртөө үйлчлэх чадварыг багтаасан байна.

Нийтлэг илрүүлгийн туршилт судалгаа, үр дүн

Determine Sample Size

Confidence Level: 95% 99%

Confidence Interval:

Population:

Sample size needed:

2018-2019 оны хичээлийн жилд Улаанбаатар хотын хэмжээнд цэцэрлэгийн ахлах бүлэгт 29555 хүүхэд хамрагдсан (<http://www.edub.edu.mn>). Судалгааны түүврийн хэмжээг 95 хувийн итгэх магадлалтай, алдааны нарийвчлал 2.8 байхаар тооцоолсон. Судалгаанд 22 цэцэрлэгийн 28 ахлах бүлгийн 610 хүүхэд буюу

түүврийн 50-с дээш хувийг судалгаанд хамруулсан. Судалгааг “Хүүхдийн хөгжлийн ахицын ажиглалтын хуудас”-ны үнэлгээний арга зүйг ашиглан зохион байгуулсан. Хүүхэд бүрийн хөгжлийг улсын дундажтай харьцуулан, гурваас дээш чадамж нь нэгдүгээр бүлэгт хамрагдаж буй бол эрсдэлтэй, хөгжлөөр хоцрогдолтой байх магадлалтай гэж үзэж болох бөгөөд хүүхдэд илүү анхаарал тавьж, учир шалтгааныг нь тодруулах шаардлагатай. (Норжхорлоо, 2017) гэж үздэг байна.

Бидний судалгаагаар 610 хүүхдээс гурав болон түүнээс дээш чадамж нь нэгдүгээр бүлэгт 52 хүүхэд байна.

Хүснэгт.3 “Хүүхдийн хөгжлийн ахицын үнэлгээ”-ний үр дүн

Чадамж	I бүлэг	II бүлэг	III бүлэг	Нийт
Хөдөлгөөн, эрүүл мэндийн чадамж	26	23	3	52
Нийгэмшихүйн чадамж	21	26	5	52
Хэл ярианы чадамж	30	15	7	52
Орчноо таньж мэдэх, орчинтойгоо харилцах чадамж	24	20	8	52
Математикийн чадамж	31	11	10	52
Дүрслэх урлагийн чадамж	31	12	9	52
Хөгжмийн чадамж	34	12	6	52
Нийт	197	119	48	364

Нийт 52 хүүхдийн 7 чадамж тус бүрийн үнэлгээний хүснэгтээс харахад нэгдүгээр бүлэгт 54.1% буюу 197 бол хоёрдугаар бүлэгт 32.6% буюу 119, гуравдугаар бүлэгт 13.4 % буюу 48 байна. Энэ нь 52 хүүхдийн үнэлгээнд нэгдүгээр бүлэг ихэнх хувийг эзэлж байгааг харуулж байна. Судалгаагаар илэрсэн 52 хүүхдэд дараагийн шатны судалгаа болох зорилтот

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

илрүүлгийг хийх асуудал зүй ёсоор тавигдаж байгаа гэж үзэж хамрах хүрээ болгон авсан болно.

Зорилтот илрүүлгийн туршилт, судалгаа, үр дүн Нийтлэг илрүүлгийн үр дүнд үндэслэн 52 хүүхдийн эцэг эх, бүлгийн багш нарыг судалгаанд оролцох зөвшөөрлийг бичгээр авч хамтран ажилласан болно. Судалгааны 4 шкал, 14 дэд шкал, 125 асуултын хүрээнд багш, эцэг эх тус бүр хариулж дэд шкалуудын оноог гаргасан..

Дэд шкалуудын хоородын хамаарлын үзүүлэлт болон стандарт хазайлтыг мөн тодорхойлж авч үзсэн болно. Гарсан үр дүнг дараах хүснэгтээр харууллаа.

Шкал-I-ын “Нийгэмшил”, “Бусадтай харилцах”, “Давтамжтай үйлдэл хийх” дэд шкалуудын хамгийн их болон бага утга, стандарт хазайлт хоорондын хамаарлын үзүүлэлтийг харууллаа Хүснэгт 4. Дэд шкалуудын хамгийн их болон бага үзүүлэлт, стандарт хазайлтын утга (Шкал-I)

Дэд шкал		Хамгийн бага утга	Хамгийн их утга	Дундаж	Стандарт хазайлт	Корреляци
Нийгэмшил	Эцэг эх	1.0	4.1	2.3	0.86	0.82
	Багш	1.0	4.1	2.2	0.84	
Бусадтай харилцах	Эцэг эх	1.0	4.2	2.3	0.83	0.91
	Багш	1.0	4.0	2.1	0.74	
Давтамжтай үйлдэл хийх	Эцэг эх	1.9	4.1	2.4	0.73	0.83
	Багш	1.9	4.9	2.5	0.73	

Хүснэгтээс дүгнэхэд багш, эцэг эхийн үнэлгээний хоорондын хамаарлын корреляцийн коэффициент 0.82-0.91 байгаа нь хүчтэй хамааралтай, хоорондоо ижил төстэй шинж их байгааг харуулж байна. Дэд шкалуудын онооны стандарт хазайлтыг тооцоход 0.73-0.86-ийн хооронд хэлбэлзэж байна.

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Шкал-II-ын “Анхаарал төвлөрөхгүй байх”, “Хэт хөдөлгөөнтэй байх”, “Цочмог зан гаргах” дэд шкалуудын хамгийн их болон бага утга, дундаж, стандарт хазайлт хоорондын хамаарлын үзүүлэлтийг харууллаа.

Хүснэгт 5. Дэд шкалуудын хамгийн их болон бага утга, дундаж, стандарт хазайлтын хамаарал (Шкал-II)

Дэд шкал		Хамгийн бага утга	Хамгийн их утга	Дундаж	Стандарт хазайлт	Корреляци
Анхаарал төвлөрөхгүй байх	Эцэг эх	1.1	4.2	2.6	0.84	0.83
	Багш	1.1	4.2	2.7	0.78	
Хэт хөдөлгөөнтэй байх	Эцэг эх	1.4	4.0	2.7	0.76	0.84
	Багш	1.4	4.1	2.7	0.75	
Цочмог зан гаргах	Эцэг эх	1.3	3.9	2.5	0.69	0.85
	Багш	1.3	4.0	2.6	0.69	

Хүснэгт 5-аас дүгнэхэд багш, эцэг эхийн үнэлгээний хоорондын хамаарлын корреляцийн коэффициент 0.84 байгаа нь хүчтэй хамааралтай, хоорондоо ижил төстэй шинж их байгааг харуулж байна. Дэд шкалуудын онооны стандарт хазайлтыг тооцоход 0.69-0.84 -ийн хооронд хэлбэлзэж байна.

Суралцахуйн бэрхшээлтэй байж болзошгүйг илрүүлэх “Сэтгэн бодох чадвар”, “Сонсох чадвар”, “Ярих чадвар”, “Дуулах, зурах чадвар”, “Том жижиг булчингийн хөгжил” дэд шкалын үзүүлэлтүүдийн дундаж, стандарт хазайлт, хамгийн их ба бага утгуудыг тодорхойлж харууллаа

Хүснэгт 6. Дэд шкалуудын дундаж, хамгийн их ба бага утга (Шкал-III)

Дэд шкал				Дундаж		Корреляци
----------	--	--	--	--------	--	-----------

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

		Хамгийн бага утга	Хамгийн их утга		Стандарт хазайлт	
Сэтгэн бодох чадвар	Эцэг, эх	1.0	4.6	2.6	0.85	0.84
	Багш	1.4	4.6	2.7	0.81	
Сонсох чадвар	Эцэг, эх	1.0	4.5	2.6	0.82	0.85
	Багш	1.0	4.6	2.8	0.78	
Ярих чадвар	Эцэг, эх	1.0	4.0	2.5	0.81	0.63
	Багш	1.0	4.0	2.5	0.78	
Дуулах, зурах чадвар	Эцэг, эх	1.2	4.2	2.6	0.84	0.81
	Багш	1	4.4	2.8	0.88	
Том жижиг булчингийн хөгжил	Эцэг, эх	1.0	4.1	2.7	0.71	0.71
	Багш	1.1	4.3	2.8	0.78	

Хүснэгт 6 -аас үзэхэд эцэг эх, багшийн зүгээс “Сэтгэн бодох чадвар”, “Сонсох чадвар” дэд шкалаар хамгийн их утга 4.5-4.6 байна.

Стандарт алдаа 0.70-0.85, корреляци хамаарал 0.70-0.84 байгаа нь эцэг эх, багшийн оноо хоорондоо хамааралтай байгааг харуулж байна.

“Зан үйлийн эмгэгтэй байж болзошгүй”-г илрүүлэх “Зан үйл”, “Сэтгэлийн хөдөлгөөн”, “Өдөр тутмын үйл ажиллагаа” дэд шкалын онооны дундаж, стандарт хазайлт, хамгийн их ба бага утгуудыг тодорхойлж харууллаа

Хүснэгт 7. Дэд шкалуудын онооны дундаж хамгийн их ба бага утга (Шкал-ІҮ)

Дэд шкал		Хамгийн бага утга	Хамгийн их утга	Дундаж	Стандарт хазайлт	Корреляци

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Зан үйл	Эцэг эх	1.0	4.5	2.7	0.97	0.60
	Багш	1.0	4.1	2.8	0.82	
Сэтгэлийн хөдөлгөөн	Эцэг эх	1.2	4.9	2.8	0.96	0.68
	Багш	1.1	4.1	2.8	0.82	
Өдөр тутмын үйл ажиллагаа	Эцэг эх	1.1	4.3	2.6	0.81	0.70
	Багш	1.2	4.3	2.8	0.78	

Хүснэгт 7-оос дүгнэхэд Эцэг эхийн үнэлгээгээр “Сэтгэлийн хөдөлгөөн” дэд шкалын хамгийн их утгын дундаж 4.9 байна. Энэ нь эцэг эхийн зүгээс сэтгэлийн хөдөлгөөний шинжийг илүүтэй таньж мэддэгтэй холбоотой байж болох юм. Стандарт хазайлт нь 0.78-0.97, багш эцэг эхийн үнэлгээний корреляци хамаарал 0.60-0.70 байгаа нь хоорондоо хамааралтай байна. Багш, эцэг эхийн үнэлгээний хоорондын хамаарлын корреляцийн коэффициент 0.82-0.91 үзүүлэлттэй байгаа нь хүчтэй хамааралтай, хоорондоо ижил төстэй шинж их байгааг харуулж байна.

Судалгаанд оролцсон 52 хүүхдийн үнэлгээг нэгтгэн харвал давхардсан тоогоор 22, нийтдээ 17 хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүй гэж илэрсэн байгааг хүснэгтээр харууллаа.

Хүснэгт.8 Хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүй гэж илэрсэн хүүхдийн дүн

Шкал	Хүүхдийн код							Нийт хүүхдийн тоо
	2	6	8	10	30	52		
Аутизмын хүрээний эмгэгтэй байж болзошгүй	2	6	8	10	30	52	6	
Анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэгтэй байж болзошгүй	7	9	13	26	29	49	6	
Суралцахуйн бэрхшээлтэй байж болзошгүй	2	-	24	32	42	52	5	
Зан үйлийн эмгэгтэй байж болзошгүй	-	9	20	25	42	52	5	

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Судалгааны шкалуудад гурваас дээш оноо авсан 17 хүүхдэд хамгийн их хувийг эзэлсэн дараах үзүүлэлтүүд байна. Үүнд: шкал-III-ын дэд шкал 3.1 “Сэтгэн бодох чадвар” 15 хүүхэд буюу 88%, дэд шкал 3.5 “Том жижиг булчингийн хөгжил”, шкал-II-ын дэд шкал 2.2 “Цочмог зан гаргах” 13 хүүхэд буюу 76%, дэд шкал 2.1 “Анхаарал төвлөрөхгүй байх”, дэд шкал 4.2 “Сэтгэлийн хөдөлгөөн” 12 хүүхэд буюу 70% байна. Зорилтот илрүүлгийн үр дүнг авч үзэхдээ 17 хүүхэд тус бүрт радарын график байгуулж, дэд шкалын оноог хүснэгтээр харуулж тоон аргын шинжилгээг, багшийн ажиглалтын тэмдэглэлийн чанарын аргаар цуглуулсан мэдээллийн шинжилгээний хамт хос аргын судалгааг хийж үр дүнг тооцсон. Үүнийг тохиодлын арга ашиглан 6 аутизмын хүрээний эмгэгтэй байж болзошгүй 6 кодтой хүүгийн үзүүлэлт дээр үндэслэн харууллаа.

Зураг 1. Радарын зураг

6 кодтой “Б” хүүгийн үнэлгээг авч үзэхэд Шкал-I-ын 1.1 “Нийгэмшил”, 1.2 “Бусадтай харилцах”, 1.3 “Давтамжтай үйлдэл хийх” дэд шкалд гурваас дээш оноо авсан, радарын зураг тус шкалын хүрээнд тойргийн төвөөс гадагшаа тэлсэн харагдаж байна. Энэ нь аутизмын хүрээний эмгэгтэй байж болзошгүйг харуулж байна.



Дээрх үр дүнгээс үндэслэн цэцэрлэгт явж байгаа хүүхдийг үе тэнгийхэний хийж чаддаг ихэнхи зүйлийг, хийж чадаж байгаа эсэхийг нь жишиж үзээд хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүйг илрүүлж болохыг судалгааны үр дүнгээс харж болно. Мөн дэд шкалуудын хоорондын уялдаа холбоо сайн байгаа нь шкал тус бүрийг илэрхийлж чадахуйц байна гэсэн үг юм. Судалгааны үр дүнгээс үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг илрүүлэх дээрх аргачлалыг цаашид хэрэглэх боломжтой байна гэж бид үзэж байна.

Дүгнэлт

Бид энэхүү судалгааны үр дүнд дараах дүгнэлтэд хүрсэн болно.

1. Ерөнхийдөө хөгжлийн бэрхшээлийг ялган таних, үнэлэхэд динамик үнэлгээний үзэл баримтлалын хүрээнд илрүүлгийн аргачлалыг боловсруулж, оношилгооны өмнөх шат

буюу хөгжлийн бэрхшээлийн эрсдэлтэй хүүхдийг шигшин тогтоох зорилготойгоор түгээмэл хэрэглэдэг байна.

2. Судалгаанд Reiko Kurrosawa (2008)-ийн боловсруулсан “4-5 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн илрүүлэг”-ийн аргачлалыг зохицуулан хэрэглэж, найдварт чанарын коэффициентийг тооцоход 0.8-0.9 хооронд хэлбэлзсэн үзүүлэлт гарсан нь судалгааны аргачлал найдварт чанар хангасан байгааг харуулж байна. энэ нь дэд шкалуудын хоорондын уялдаа холбоо сайн, шкалыг илэрхийлж чадахуйц үзүүлэлтүүд байна гэсэн үг юм.
3. Манай улсын хувьд илрүүлгийн аргачлалыг хэрэглэж хэвшээгүй байгаа тул олон улсад түгээмэл хэрэглэж буй илрүүлгийн аргачлалуудаас хөгжлийн бэрхшээлийн дөрвөн төрлийг зэрэг хамруулан үнэлгээ хийдэг практик ач холбогдол өндөртэй Reiko Kurrosawa-ийн илрүүлгийн аргачлалыг зохицуулан хэрэглэж болох юм гэж авч үзсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг илрүүлэх аргачлалуудыг хэрэглэхэд бид дараах асуудлыг анхаарах хэрэгтэй хэмээн үзэж байна. Үүнд:

- ✓ Хөгжлийн дэмжлэг эрт оролцооны үйлчилгээнд хамруулах үйл явцад тусгагдсаны дагуу хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийн эрсдэлтэй хүүхдийг цэцэрлэг, сургуулийг түшиглэн зохион байгуулах ажлыг эхлүүлэх
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг илрүүлэх ажлын хүрээг өргөжүүлэх, эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тэдэнд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оношлох үнэлгээнд хамруулахаас өмнө илрүүлэг хийгдсэн эсэхийг анхаарч үзэх
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг илрүүлэх аргачлалуудын адаптаци хийсэн эсэхийг хянах, хэвлэлт, хэрэглээнд оруулах
- ✓ Монгол судлаачид хамтран адаптаци хийсэн өөрсдийн туршлагадаа тулгуурлан Монгол хүүхдийн онцлогт тулгуурласан хөгжлийн бэрхшээлийг илрүүлэх аргачлалыг боловсруулах

Талархал

Судалгааг зохион байгуулахад гүн туслалцаа нийслэлийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хамт олон, судалгаанд хамрагдахыг зөвшөөрсөн бүлгийн багш нар, эцэг эх асран хамгалагчдад талархсанаа илэрхийлье.

Ном зүй

- [1] Батцэнгэл.Г. (2018). Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах сэтгэл зүйн үндэс
 - [2] Норжжорлоо.Н. (2017). *Хүүхэд бүрийн хөгжлийн төлөө*. УБ
 - [3] Сарантуяа.Б (2020) Сэтгэц оношилгоо.УБ
 - [4] Туяа. Б (2006) Тестийг зохицуулан хэрэглэх туршилт судалгаа., УБ.,
 - [5] Ханин Ю. Л(1977)Стандартный алгоритм адаптации зарубежных опросных методов // Психологические проблемы предсоревновательной подготовки квалифицированных спортсменов.
 - [6] Roger Pierangelo & George Giuliani (2005) *The special educatoris comprehensive guide to 301 diagnostic test*,
 - [7] Lebeer.J (2011). *Dinamic assessment and functioning of children oriented at development and inclusive learning*.Antwerpen
 - [8] Lidz.C (1995) *Dynaic assessment and the legacy of L.C.Vygotsky*. School Pschychology International..
 - [9] Lord &Jones. (2012) *Childhood disability screening tools*.
 - [10] Singh A, Yeh CJ, Boone Blanchard S. (2017, 74(1):5-12). *Ages and Stages Questionnaire: a globale screening scale . Bol Med Hosp Infant Mex*, 54.
 - [11] Slentz.K.L, Krostinel.S& Diane.M(2008) *A guide toAssessment an Early Childhood,Infancy to age eight*,Washington State Office of Superintendent of Public Instruction,
 - [12] Shapiro,B,Church.R&Lewis.M.E(2007) *Specific Learning Disabilitise in children with disabilities*,Baltimor
- Sharon Ringwalt(2008) “Developmental Screening and Assessment Instruments with an Emphasis on Social and Emotional Development for young children ages birth through five

ТАРХИНЫ СААЖИЛТТАЙ ХҮҮХДИЙН БОБАТ ЭМЧИЛГЭЭНИЙ ДАРААХ ӨДӨР ТУТМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЙЖРАЛЫГ ҮНЭЛСЭН

Э.Баасанхүү¹ Д.Батлхам² Б.Мөнх-Эрдэнэ²

АШУУИС, Сувилахуйн сургууль^{1,2}

Хураангуй

Үндэслэл: Тархины саажилт (ТС) нь 1000 амьд төрөлтөөс 2-3,5 тохиолддог бөгөөд тархины гэмтэл, хөдөлгөөн, байрлал, тэнцвэрт байдалд, оюун ухаанд нөлөөлдөг олон шалтгаантай байдаг. Тархины саажилттай холбоотой хөдөлгөөний эмгэгийг спастик, дискинези, атакси эсвэл холимог / бусад гэж ангилдаг.

2016 онд дэлхийд 17 сая тархины саатай хүмүүс байна гэсэн дэлхийн эрүүл мэндийн судалгаа байдаг. Манай улсад 3000-4000 тархины саатай хүүхдүүд байдаг. Иймээс тархины саатай хүүхдүүд жилээс жилд Монголд төдийгүй дэлхий дахина нэмэгдэж байна. Үүнтэй холбоотой тархины саатай хүүхдэд сэргээн засах тэр тусмаа хөдөлгөөн засал (бобат) эмчилгээний дараах өдөр тутмын үйл ажиллагааны (усанд орох, хувцаслах, үс засах, хооллох, арчилгаа, бие засах) сайжралыг үнэлсэн судалгаа огт хийгдээгүй байна.

Зорилго: Тархины саажилттай хэвтүүлэн эмчлэх эмнэлэгт хийсэн бобат эмчилгээнд суурилсан хөдөлгөөн засал эмчилгээний дараах өдөр тутмын үйл ажиллагааны сайжралыг үнэлэх. **Сэдвүүд ба арга зүй:** 2020.01 сараас 2020.06 сар хүртэлх хугацаанд Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхдийн Сэргээн Засах Хөгжлийн Төвийг түшиглэн явуулсан. Хэвтэн эмчлүүлж байсан ТС өвчтэй 41 хүүхдийг түүвэрлэж авч 14 хоног буюу нэг курс эмчилгээнд хамрагдсан. Эмчилгээний өмнө ба дараа өдөр тутмын үйл ажиллагааны (WeeFIM) шалгуураар үнэлсэн.

Бүх үйлчлүүлэгчид долоо хоногт 5 өдөр Бобат эмчилгээг өдөрт 1 цагийн хугацаатай хөдөлгөөн засал эмчилгээ хийсэн. **Үр дүн:** Судалгаанд эрэгтэй 61%, эмэгтэй 39% хүүхдүүдийн эмчилгээний өмнөх ба дараах үзүүлэлтүүдийг харьцуулахад хооллох чадвар ($p \leq 0,023$), өөрийгөө арчлах чадвар ($p \leq 0,044$), усанд орох чадвар ($p \leq 0,012$), дээгүүр хувцас өмсөх ($p \leq 0,044$), доогуур хувцас өмсөх ($p \leq 0,032$), шээх үйл ажиллагааг хянах чадвар ($p \leq 0,023$), баах үйл ажиллагааг хянах чадварууд тус тус ($p \leq 0,044$) сайжирсан. Мөн WeeFIM бүх чадвараар эмчилгээний өмнө дараах харьцуулалт хийхэд сайжирсан ($p \leq 0.002$) байна.

Дүгнэлт: Бобат эмчилгээ нь үр дүнтэй бөгөөд хөдөлгөөн засал эмчилгээний судалгаа сэргээн засах анагаах ухаанд шаардлагатай байна.

Түлхүүр үг: WeeFIM, Хөдөлгөөн засал, Чадвар, Хүүхдийн сэргээн засах

Үндэслэл: Тархины саажилт (ТС) нь хүүхдийн төлөв байдал, хөдөлгөөний эмгэгийн хамгийн өргөн хүрээг хамардаг. ТС-ийн өвчтөнүүд тархины статик гэмтэл, шинж тэмдгүүд илэрч, нөлөөлөлд өртсөн хүний өсөлт хөгжилтийн явцад цаг хугацааны явцад өөрчлөгдөж байдаг. ТС-тай холбоотой өргөн хүрээний асуудлууд нь өвчтөнийг үнэлэх, сэргээн засах зорилгод хүрэхэд бэрхшээл учруулдаг^{1, 2}). ТС-ийн сэргээн засал нь олон талт арга барилыг шаарддаг.

Мэргэжилтнүүдийн гэр бүл, баг эмчилгээний зорилгоо тодорхойлсны дараа хамгийн оновчтой аргыг бий болгох ёстой. Хэдийгээр эмчилгээний хэд хэдэн арга байдаг боловч эмчилгээний шийдвэр гаргах үндэслэлтэй холбоотой шинжлэх ухааны нотолгоо хязгаарлагдмал байдаг. Гэсэн хэдий ч нэг эмчилгээг нөгөөгөөсөө илүүгээр хийдэг болохыг шинжлэх ухааны үндэслэлтэй нотолгоо байхгүй байна. Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчид эдгээр эмчилгээний аргуудыг ихэвчлэн практикт эмчилгээнд хослуулан хэрэглэдэг. Эдгээр эмчилгээний хамгийн тохиромжтой үргэлжлэх хугацаа, давтамжийг тогтоогоогүй байна¹⁾).

ТС нь дэлхий даяар 1000 амьд төрөлт тутамд 2-3.5 тархаж байна^{3, 4)}, Монгол улсад 1000 амьд төрөлтөд 1-2 байна мөн 3000-4000 тархины саатай хүүхдүүд байдаг. 2016 онд дэлхийд 17 сая тархины саатай хүмүүс байна⁵⁾. Тархины саатай хүүхдэд хөдөлгөөн заслын бобат эмчилгээ нь хөдөлгөөний үйл ажиллагаа болон өдөр тутмын үйл ажиллагааны чадваруудыг сайжруулдаг тул монгол улсад практикт үр дүнтэй хэмээн эмчилгээнд өргөн хэрэглэдэг. Гэвч монгол улсад тархины саатай хүүхдийн хөдөлгөөн засал эмчилгээний үр дүнг судалсан цөөн тооны судалгаа хийгдсэн боловч бобат эмчилгэн дээр тулгуурлан хийсэн судалгаа, баримт одоог хүртэл байхгүй байна.

Зорилго

Хүүхдийн тархины саажилттай хэвтүүлэн эмчлэх эмнэлэгт хийсэн бобат эмчилгээнд суурилсан хөдөлгөөн засал эмчилгээний дараах өдөр тутмын үйл ажиллагааны сайжралыг үнэлэх

Зорилт

1. Тархины саатай хүүхдийн өдөр тутмын үйл ажиллагааны чадваруудыг үнэлж харьцуулан судлах
2. Тархины саатай хүүхдэд хийгдсэн бобат эмчилгээний өмнөх болон дараах өдөр тутмын үйл ажиллагааг харьцуулан судлах

Судалгааны аргазүй: Бид 2020.01 сараас 2020.06 сар хүртэлх хугацаанд эмчилгээний үр дүнг эргэмж байдлаар судалсан. Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхдийн Сэргээн Засах Хөгжлийн Төвийг түшиглэн явуулсан. Хэвтэн эмчлүүлж байсан ТС өвчтэй 41 хүүхдийг түүвэрлэж авч 14 хоног буюу нэг курс эмчилгээнд хамрагдсан. Бүх үйлчлүүлэгчид долоо хоногт 5 өдөр бобат (хөдөлгөөн засал эмчилгээ) эмчилгээг өдөрт 1 цагийн хугацаатай хийлгэсэн.

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Эмчилгээний өмнө ба дараа өдөр тутмын үйл ажиллагааны (WeeFIM) шалгуураар үнэлсэн. WeeFIM үнэлгээ нь (Хооллох, Өөрийгөө арчлах, Усанд орох, Хувцаслах /дээд бие\, Хувцаслах /доод бие\, ОО ашиглах, Шээсээ хянах, Өтгөнөө хянах, Шилжих: Сандал/Тэргэнцэр, Шилжих: Суултуур, Банн/Шүршүүр, Шилжилт хөдөлгөөн:Алхах/тэргэнцэр/мөлхөх, Шат (өгсөх,уруудах), Ойлголт, Илэрхийлэх, Нийгмийн харилцаа, Асуудал шийдэх, Ой санамж) гэсэн 18 хэсэгтэй мөн 1-7-гийн хооронд оноогоор үнэлдэг. 1 оноо нь бусдын бүрэн тусламжтай, 7 нь бүрэн бие даасан байдлыг илэрхийлнэ. Хамгийн бага, хамгийн өндөр оноо тус тус 18 ба 126 оноогоор үнэлдэг⁶.

Судалгааны ажлын үр дүнг биостатистикийн үндсэн аргуудаар арифметик дундаж (M), стандарт хазайлт (s), стандарт алдаа (m), итгэх интервал (CI-95%) болон эмчилгээний өмнөх ба дараах үр дүнг paired t – тестээр харьцуулсан үр дүнг spss программыг ашиглан хийж гүйцэтгэсэн.

Үр дүн

Судалгаанд оролцогчид өдөр тутмын үйл ажиллагааны чадварыг эмчилгээний өмнөх ба дараах WeeFIM шалгуураар буюу бүх чадвараар нэгдсэн нэг үнэлгээ хийхэд өдөр тутмын үйл ажиллагаа сайжирсан ($p \leq 0.002$) болох нь харагдаж байна.

Хүснэгт-1: өдөр тутмын үйл ажиллагааны хэсэг бүрээр бобат эмчилгээний өмнө ба дараа харьцуулсан харьцуулалтын дундаж \pm стандарт хазайлт.

№	Бүлэг	Хэсэг	Эмчилгээний өмнө	Эмчилгээний дараа
1	Өөрийгөө арчлах	Хооллох	3.56 \pm 2.038	3.68 \pm 2.079*
		Өөрийгөө арчлах	3.32 \pm 2.184	3.41 \pm 2.202*
		Усанд орох	2.32 \pm 1.556	2.46 \pm 1.567*
		Хувцаслах /дээд бие\	2.78 \pm 2.006	2.88 \pm 2.027*
		Хувцаслах /доод бие\	2.66 \pm 1.970	2.80 \pm 2.052*
2	Бие засахыг хянах	ОО ашиглах	2.51 \pm 2.039	2.59 \pm 2.049
		Шээсээ хянах	4.20 \pm 2.462	4.32 \pm 2.413*
		Өтгөнөө хянах	4.22 \pm 2.434	4.32 \pm 2.413*
3	Шилжих хөдөлгөөн	Шилжих: Сандал/Тэргэнцэр	2.93 \pm 1.903	2.98 \pm 1.877
		Шилжих:Суултуур	2.66 \pm 1.931	2.73 \pm 1.924

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

		Шилжих: Банн/Шүршүүр	2.66±1.918	2.73±1.911
4	Шилжилт хөдөлгөөн	Шилжилт хөдөлгөөн: Алхах/ тэргэнцэр/мөлхөх Шилжилт хөдөлгөөн: Шат (өгсөх, уруудах)	2.73±1.911 2.17±1.759	2.24±1.758 2.24±1.758
5	Харилцаа	Ойлголт Илэрхийлэх	4.95±1.774 4.66±1.944	5.07±1.808 4.76±2.010
6	Нийгмийн ухамсар	Нийгмийн харилцаа Асуудал шийдэх Ой санамж	4.29±2.028 3.76±2.354 4.49±2.063	4.37±2.083 3.78±2.372 4.56±2.086

Тэмдэглэл: * статистик ач холбогдолтой

Хүснэгт-2: Бобат эмчилгээний өмнөх болон дараах өдөр тутмын үйл ажиллагааны чадвар алдагдлын нийт харьцуулсан харьцаа

Weefim шалгуур	Дундаж стандарт хазайлт	Р утга
Эмчилгээний өмнө	59.51±28.945	0,002*
Эмчилгээний дараа	61.10±29.150	

Тэмдэглэл: * статистик ач холбогдолтой

Хэлцэмж: Бид тархины саатай хүүхдийн сэргээн засах тэр тусмаа хөдөлгөөн заслын бобат эмчилгээний өмнөх ба дараах өдөр тутмын үйл ажиллагааг харьцуулан судалсан бөгөөд бидний судалгаагаар бобат эмчилгээ үр дүнтэй гэсэн дүгнэлт гарсан.

Турк улсын судлаачдын хийсэн судалгаанд ([Ebru Yilmaz Yalcinkaya](#), [Nil Sayiner Caglar](#)) ТС-тай 2-12 насны 28 хүүхдийг 6 долоо хоног бобат эмчилгээнд хамруулан эмчилгээний өмнө болон дараа хөдөлгөөний хөгжлийн чадвар (GMFM-88) шалгуураар үнэлсэн. Эмчилгээний дараа GMFM-88 шалгуурын хүүхдүүдийн нийт оноо эрс нэмэгдсэн

$p < 0.01$ үр дүн гарсан нь бидний судалгааны бобат эмчилгээ үр дүнтэй байна гэсэн дүгнэлттэй ижил байна.

Монгол улсад бобат эмчилгээний аргаар хийсэн судалгаа огт байхгүй байна. Тийм учраас бид цаашид тархины саатай хүүхдийн бобат эмчилгээний үргэлжлэх хугацаа, давтамж, тархины саагин хэлбэрүүд дээр өөрийн улсын нөхцөлд тулгуурлан судлах хэрэгцээ шаардлагатай байна.

Дүгнэлт

Тархины саатай хүүхдэд эмчилгээ хийснээр өдөр тутмын үйл ажиллагааны чадварууд тодорхой хэмжээнд мэдэгдэхүйц сайжирсан. Иймд бобат эмчилгээ нь үр дүнтэй бөгөөд хөдөлгөөн засал эмчилгээний судалгаа сэргээн засах анагаах ухаанд шаардлагатай байна.

Ном зүй:

- [1] McMahon M, Pruitt D, Adams VJ: Cerebral palsy in Pediatric Rehabilitation principles and practice. In: Alexander MA (ed.), Pediatric Rehabilitation, 4th ed. New York: Demos medical, 2009, pp 165–97.
- [2] Colver A, Fairhurst C, Pharoah PO: Cerebral palsy. Lancet, 2014, 383: 1240–1249.
- [3] Yeargin-Allsopp M, Van Naarden Braun K, Doernberg NS, et al. : Prevalence of cerebral palsy in 8-year-old children in three areas of the United States in 2002: a multisite collaboration. Pediatrics, 2008, 121: 547–554.
- [4] Pharoah PO, Cooke T, Johnson MA, et al. : Epidemiology of cerebral palsy in England and Scotland, 1984-9. Arch Dis Child Fetal Neonatal Ed, 1998, 79: F21–F25.
- [5] World health organization /statistic /, worldcpday.org
- [6] Ottenbacher KJ, Msall ME, Lyon N, et al. : The WeeFIM instrument: its utility in detecting change in children with developmental disabilities. Arch Phys Med Rehabil, 2000, 81: 1317–1326.
- [7] Ebru Yilmaz Yalcinkaya, Nil Sayiner Caglar, et al. : Rehabilitation Outcomes of Children with Cerebral Palsy 2014, 26(2): 285–289.

АХМАД НАСТНЫ ТАРГАЛАЛТ БА ИЛҮҮДЭЛ ЖИНГИЙН ТАРХАЛТЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Х.Бямбасүрэн¹, У.Эрхэмбаяр¹, Н.Болормаа¹, С.Гэрэлмаа¹,
Д.Нарантуяа¹, С.Өнөрсайхан¹

¹Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

Хураангуй

Илүүдэл жин ба таргалалтын шалтгаан, эрсдэлт хүчин зүйл болсон эрүүл бус хооллолт, хөдөлгөөний хомсдол манай хүн амын дунд “чимээгүй тахлын” хэмжээнд тархаж байна. Нас ахих тусам ахмад настны эрүүл мэнд болон аливаа өвчнөөр өвчлөх эрсдэл нэмэгдэж байдаг билээ. Ахмад настны таргалалт ба илүүдэл жингийн тархалт 2013 онд 65.3% (95%ИХ 59.4-71.3) байсан бол 2019 онд 68.9% (95%ИХ 65.7-72.1) болж 3.6%-иар нэмэгдсэн байна. Хүйсээр авч үзвэл эрэгтэйчүүдийн хувьд ялимгүй буурч, харин эмэгтэйчүүдэд 1.1 дахин нэмэгдсэн нь анхаарал татаж байв. Зүрх судасны өвчний гол эрсдлүүдийн нэг болох төвийн таргалалтын тархалт ахмад настнуудын дунд 62.8% (2013 он)-аас 74.0% (2019 он) болж 1.1 дахин огцом нэмэгдсэн байна. Цаашид ахмад настны амьдралын чанарыг дээшлүүлэх, хоол, хүнсний тэжээллэг чанарт анхаарах, урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамруулах, амралт, сувилал, эрүүл мэндийн үйлчилгээг зохистой, оновчтой болгоход анхаарах нь зүйтэй байна.

Түлхүүр үг: Биеийн жингийн индекс, чимээгүй тахал, төвийн таргалалт, хөдөлгөөний хомсдол, эрсдэлт хүчин зүйлс

Удиртгал

Дэлхий дахинд хүн амын өвчлөлийн байдал өөрчлөгдөж, соёл иргэншил, амьдралын буруу хэв маяг буюу зохисгүй хооллолт, хөдөлгөөний хомсдол, архи, тамхины хэрэглээтэй холбоотой халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийн нөлөөгөөр илүүдэл жин ба таргалалт асар хурдацтай нэмэгдэж, нийгэм, эдийн засгийн хөгжил болоод сая сая хүний амьдрал, эрүүл мэндэд давхар дарамт учруулж байгаа нь нийгмийн эрүүл мэндийн өнөөгийн тулгамдсан асуудлын нэг болж байна [1]. Хүн амын өвчлөл, нас баралтад нөлөөлж байгаа зонхилох 10 эрсдэлт хүчин зүйлээс хамгийн түгээмэл, зан үйлийн анхдагч эрсдэлт хүчин зүйлс нь зохисгүй хооллолт, хөдөлгөөний хомсдол, архи, тамхины хэрэглээ бөгөөд эдгээр нь илүүдэл жин, цусны даралт ихсэлт, цусан дахь өөх тос, сахарын хэмжээ нэмэгдэх зэрэг завсрын хүчин зүйл байдлаар илэрч улмаар өвчлөл, нас баралтад хүргэж байгааг Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ) тогтоогоод байна [2]. Илүүдэл жин ба таргалалтын шалтгаан, эрсдэлт хүчин зүйл болсон тамхи, архи, согтууруулах ундааны

хэрэглээ, эрүүл бус хооллолт, хөдөлгөөний хомсдол манай хүн амын дунд “чимээгүй тахал”-ын хэмжээнд тархаж байна.

Дэлхий дахинд ахмад настны тоо эрчимтэй нэмэгдэж байгаа талаар Дэлхийн насжилтын хяналтын индекс (Global Age Watch Index) - 2015 судалгааны тайланд дурьдсан байна. Өдгөө 60-аас дээш настай 901 сая ахмад настан амьдарч байгаа нь дэлхийн нийт хүн амын 12.3%-ийг эзэлж байгаа бол 2030 онд 1.4 тэрбум (16.5%), 2050 онд 2.0 тэрбум (21.5%) хүрэх төлөвтэй байна. Энэ нь манай гаригт амьдарч буй 10 хүн тутмын 1 нь 60 ба түүнээс дээш насны хүн ам байна гэсэн үг юм. Хэрэв энэ хандлага хэвээр хадгалагдвал 2050 он гэхэд 5 хүн тутмын 1 нь 60 ба түүнээс дээш насны хүн ам болохоор байна. Монгол Улсын хувьд 60 ба түүнээс дээш насны хүн ам нийт хүн амд эзлэх хувь 2015 онд 6.4% байсан бол 2030 онд 11.9%, 2050 он гэхэд нийт хүн амын 21.1%-тай тэнцэх магадлалтай байна.

2013 онд хийсэн “Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг тогтоох үндэсний 3-р судалгаа”-гаар 55-64 насны хүн амын биеийн жингийн индекс (БЖИ)-ийн дундаж хэмжээ 27.5 кг/м² байгаа ба уг үзүүлэлт эрэгтэйчүүдэд 26.6 кг/м², эмэгтэйчүүдэд 28.3 кг/м² байв. Мөн 65.3% нь илүүдэл жин ба таргалалттай, бүсэлхийн тойргийн эрсдэлээр 62.8%, эрэгтэйчүүдийн 58.7%, эмэгтэйчүүдийн 80.0% нь төвийн таргалалттай байсан нь анхаарал татах асуудал байсан тул бид энэхүү судалгааг ахмад настнуудын дунд хийж гүйцэтгэв [5].

Зорилго

Ахмад настны таргалалт ба илүүдэл жин тархалтыг улсын хэмжээнд тогтоож, ХБӨ-өөс сэргийлэх нотолгоог бүрдүүлэх

Ач холбогдол, шинэлэг тал: Энэхүү судалгааны шинэлэг тал нь ахмад настны таргалалт ба илүүдэл жингийн тархалтын түвшин, өнөөгийн байдал, чиг хандлагыг Монгол улсын хэмжээнд тогтоож, ХБӨ-нөөс сэргийлэх нотолгоог бүрдүүлэхэд оршиж нийгэм, эдийн засгийн дараах ач холбогдолтой болно. Үүнд:


- Монгол улсын засгийн газрын 2013 оны 416 дугаар тогтоолоор батлагдсан “**Эрүүл насжилт, настны эрүүл мэнд**” үндэсний хөтөлбөрийн Настны эрүүл мэндийг дэмжих, өвчнөөс урьдчилан сэргийлэх 2 дах зорилтын хэрэгжилтийг дүгнэх тоо баримт бий болов.

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

- Судалгааны талаарх ДЭМБ-ын зөвлөмжийг Монгол улс биелүүлж, олон улсын тандалт судалгааны сүлжээнд Монгол улс хамрагдсанаар цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл тодорхой болов.
- Ахмад настны таргалалт ба илүүдэл жингийн тархалтын түвшин, өнөөгийн байдал, чиг хандлагыг Монгол улсын хэмжээнд газар нутгийн бүсчлэлээр анх удаа тогтоов.

Аргазүй: Судалгааг нэг агшингийн судалгааны аргыг ашиглан Монгол улсын 55-69 насны хүн амыг төлөөлүүлэн санамсаргүй түүврийн аргаар сонгож авч eSTEPS андройд таблет ашиглан асуулгын аргаар хийж гүйцэтгэсэн [3]. Судалгааны мэдээллийн боловсруулалтыг Epi Info™, IBM SPSS.21 программын тусламжтайгаар өгөгдлийн бааз үүсгэн оруулж статистик боловсруулалтыг хийсэн. Үр дүнгийн нарийвчлалын хэмжүүр (дундаж үзүүлэлт, давтамжийн хэлбэлзэх хязгаар) болон хүн амын бүлгүүдийн ялгааг тодорхойлоход 95%-ийн итгэмжит хязгаар (ИХ)-ын утгуудыг ашигласан болно [4].

Үр дүн: Биеийн жингийн индекс (БЖИ): Монгол улсын 55-69 насны ахмадуудын БЖИ-ийн дундаж хэмжээ 27.6 кг/м^2 ба эмэгтэйчүүд (28.5 кг/м^2) эрэгтэйчүүдээс (26.6 кг/м^2) ялимгүй өндөр байна (Зураг 1).



Зураг 1. БЖИ-ийн дундаж хэмжээ, хүйсээр [5]


Бүс нутгаар харьцуулбал төвийн бүсэд хамгийн өндөр (26.2 кг/м^2), баруун бүсэд хамгийн бага (24.3 кг/м^2) байв. Байршлаар нь харахад хот, хөдөөгийн ахмадуудын БЖИ-ийн дундаж

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

үзүүлэлт ойролцоо ба хүйсээр харьцуулан үнэлэхэд статистик ач холбогдол бүхий ялгаа илэрсэнгүй.

Илүүдэл жин ба таргалалтын тархалт: БЖИ-ийн хэмжээгээр хоол тэжээлээс хамааралтай эмгэгийг илрүүлэх ДЭМБ-ын шалгуур үзүүлэлтийг ашиглан хоол тэжээлийн дутал ба илүүдлийн тархалтыг тогтоов.

Ахмад настнуудын дундах таргалалт ба илүүдэл жингийн тархалт 68.9% (95%ИХ 65.7-72.1) буюу 10 хүн тутмын 7 нь байна (Зураг 2).



Зураг 2. Таргалалт ба илүүдэл жингийн тархалт, хүйсээр [5]


Хүйсээр харьцуулахад эмэгтэйчүүд 76.5% (95%ИХ 73.1-79.9), эрэгтэйчүүд 60.6% (95%ИХ 55.6-65.6)-ээс статистик ач холбогдол бүхий өндөр байна. Бүс нутгаар авч үзвэл Баруун бүсэд 37.9% (95%ИХ 32.9-42.9) хамгийн бага, Төвийн бүсэд 53.5% (95%ИХ 49.2-57.7) хамгийн өндөр тархалттай байна.

Хот суурин газрын ахмадуудын 51.0% (95%ИХ 49.1-53.0), хөдөөгийн ахмадуудын 46.7% (95%ИХ 43.7-49.8) нь таргалалт ба илүүдэл жинтэй байна. Мөн таргалалт ба илүүдэл жингийн (БЖИ \geq 25) тархалтыг хүн амын хүйс ба байршлаар нь харьцуулан үнэлэхэд статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдаагүй болно.

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Төвийн таргалалтын тархалт: ДЭМБ-аас эрэгтэйчүүдийн бүсэлхийн тойргийн хэмжээ 90 см ба түүнээс дээш, эмэгтэйчүүдийнх 80 см ба түүнээс илүү байвал “төвийн таргалалт”-тай гэж үнэлдэг. Энэхүү шалгуурыг ашиглан төвийн таргалалтын тархалтыг тооцон, ахмад настны хүйс, бүс нутаг, байршлаар харьцуулан үнэлэв.

Манай улсын 55-69 насны ахмадуудын 74.0% (95%ИХ 70.8-76.9) нь төвийн таргалалттай ба эрэгтэйчүүдээс 58.4% (95%ИХ 53.4-63.2), эмэгтэйчүүд 88.3% (95%ИХ 85.6-90.6) нь 1.5 дахин их байгаа нь анхаарал татаж байна (Зураг 3).



Зураг 3. Төвийн таргалалтын тархалт, хүйсээр [5]

Дүгнэлт

1. Монгол улсын 55-69 насны ахмадуудын БЖИ-ийн дундаж хэмжээ 27.6 кг/м² байгаа нь ДЭМБ-ын зөвлөмж хэмжээнээс хэтэрсэн байна.
2. Ахмад настнуудын 10 хүн тутмын 7 нь буюу 68.9% нь таргалалт, илүүдэл жинтэй ба хүйсээр харьцуулбал эмэгтэйчүүд (76.5%) нь эрэгтэйчүүдээс (60.6%) статистик ач холбогдол бүхий өндөр тархалттай байна.
3. Хот суурин газрын ахмадуудын 51.0% (95%ИХ 49.1-53.0), хөдөөгийн ахмадуудын 46.7% (95%ИХ 43.7-49.8) нь, Төвийн бүсийн ахмадууд (53.5% 95%ИХ 49.2-57.7) хамгийн өндөр өөрөөр хэлбэл Монгол улсын ахмадуудын 2 хүний 1 нь таргалалт ба илүүдэл жинтэй байна.

4. Зүрх судасны өвчний гол эрсдлүүдийн нэг болох төвийн таргалалтын тархалт ахмад настнуудын дунд 62.8% (2013 он)-аас 74.0% (2019 он) болж 1.1 дахин огцом нэмэгдэж байгаа нь анхаарал татахуйц байв.
5. Цаашид ахмад настны амьдралын чанарыг дээшлүүлэх, хоол, хүнсний тэжээллэг чанарт анхаарах, урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамруулах, амралт, сувилал, эрүүл мэндийн үйлчилгээг зохистой, оновчтой болгоход анхаарах нь зүйтэй байна.

Талархал

"Халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын IV судалгаа"-г амжилттай зохион байгуулж, техник, санхүүгийн дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан ЭМЯ-ны дэргэдэх Судалгааны зохицуулах хороо, ДЭМБ-ын Женев дэх Төв байгууллагын мэргэжилтэн Стефан Савин, Патришиа Рарау, ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн төвийн мэргэжилтэн Варрик Жунсук Ким, Хожүүн Лий, Монгол дахь ДЭМБ-ын суурин төлөөлөгч Сергей Диордица, ХБӨ-ний асуудал хариуцсан мэргэжилтэн С.Болормаа, ЭМЯ-ны Дэмжих сан, НЭМГ-ын хамт олон болон судалгаанд хувь нэмрээ оруулсан бүх хүмүүст судалгааны багийн хамт олны өмнөөс гүн талархал илэрхийлэе.

Ашигласан материал

- [1] World Health Organization, Global status report on noncommunicable diseases 2014, S. Mendis, Editor. 2014, World Health Organization.
- [2] World Health Organization, Global action plan for the prevention and control of noncommunicable diseases 2013-2020. 2013, World Health Organization: Geneva.
- [3] WHO STEPS surveillance. STEPS sample size calculator
- [4] WHO STEPS Surveillance Manual. Geneva, 26 January 2017
- [5] “Халдварт бус өвчин, осол гэмтлийн эрсдэлт хүчин зүйлсийн тархалт”-ын үндэсний 3-р судалгаа, 2013 он

БУЛЧИНГИЙН ЧАНГАРЛЫН ҮЕД ГҮНИЙ МАССАЖ АППАРАТЫН ЭМЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮНГ ТООЦОХ

О.Энхжаргал¹, Ба.Дулмаа¹, Н.Бат-Уянга², Х.Туул²

ХБХСЗХТ-ийн физик эмчилгээний сувилагч¹

ХБХСЗХТ-ийн эмч²

Хураангуй

Үндэслэл: ДЭМБ-ын судалгаагаар 15 хүртэлх насны 20 хүүхэд тутмын нэг нь буюу 93 сая орчим хөгжлийн бэрхшээлтэй байна¹. НҮБ-ын конвенцод хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлж тухайн хүүхдийн хэрэгцээ боломжид нийцсэн олон мэргэжилтнүүдийн үнэлгээг үндэслэн хөгжлийн дэмжлэгт үйлчилгээг эрт эхлэх хэрэгтэй гэж тэмдэглэсэн байна³. Хөдөлгөөний хоцрогдолтой хүүхдийг сэргээн засах цогц эмчилгээ үйлчилгээнд эрт хамруулснаар цаашид гарах хүндрэлүүдээс сэргийлэх, хүүхдийн хөдөлгөөн сэтгэхүйн чадварыг сайжруулах ач холбогдолтой². ХБХСЗХТөвийн цогц эмчилгээ үйлчилгээнд 2019 оны 6 сарын 1-ээс 2020 оны 6 сарын 1 хүртэлх нэг жилийн хугацаанд 6000 хүүхэд үйлчлүүлсэн байна. Үүнээс 1100 хүүхэд хэвтэн эмчлүүлснээс булчингийн чангарал, хөдөлгөөний хоцрогдлоос эмчилгээнд 395 хүүхэд гүний массаж аппаратын эмчилгээнд орсон. Гүний массаж эмчилгээний үр дүн тооцох шаардлагатай байна. Манай улсад булчингийн чангарлын үед гүний массаж аппаратын эмчилгээний үр дүн тооцсон судалгаа ховор байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл болсон.

Зорилго: Булчингийн чангарлын үед гүний массаж аппаратын эмчилгээний үр дүн тооцох
Арга аргачлал: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвөөр 2019.6 сарын 1-ээс 2020 оны 6 сарын 1 хүртэлх 1 жилийн хугацаанд гүний массаж аппаратын эмчилгээнд 395 хүүхэд үйлчлүүлсэн. Үүнээс 2020 оны 7-8-р сард үйлчлүүлсэн 0-16 насны доод мөчний булчингийн чангаралтай 30 хүүхдийг сонгон авсан.

Үр дүн: Шагай ээтийлгэх эмчилгээ дунджаар 8.5 хоногт 3.96° градусаар нэмэгдэж үений хэвийн далайц (20°) руу ойртож үений далайц нэмэгдсэн. Өвдөг тэнийлгэх эмчилгээ дунджаар 8.5 хоногт 3.7° градусаар багасаж үений хэвийн далайц (0°) градус руу ойртож үений далайц сайжирсан.

Дүгнэлт: Гүний массаж аппаратаар эмчилгээ хийлгэсний дараа хүүхдийн өвдөг тэнийлгэх, шагай ээтийлгэх үений далайц сайжирч булчингийн чангарал суларч байна. Эмчилгээний хоногийг өвдөг тэнийлгэх, шагай ээтийлгэх үений далайц харьцуулахад ($p < 0.000$) статистик ач холбогдолтой байсан. Эмчилгээний хоног нэмэгдэхэд үений далайц нэмэгдэж байна.

Түлхүүр үг: шагай ээтийлгэх, өвдөг тэнийлгэх,

Үндэслэл

ДЭМБ-ын судалгаагаар 15 хүртэлх насны 20 хүүхэд тутмын нэг нь буюу 93 сая орчим хөгжлийн бэрхшээлтэй байна. НҮБ-ын конвенцод хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлж тухайн хүүхдийн хэрэгцээ боломжид нийцсэн олон мэргэжилтнүүдийн үнэлгээг үндэслэн хөгжлийн дэмжлэгт үйлчилгээг эрт эхлэх хэрэгтэй гэж тэмдэглэсэн байна.

Хөдөлгөөний хоцрогдолтой хүүхдийг сэргээн засах цогц эмчилгээ үйлчилгээнд эрт хамруулснаар цаашид гарах хүндрэлүүдээс сэргийлэх, хүүхдийн хөдөлгөөн сэтгэхүйн чадварыг сайжруулах ач холбогдолтой. ХБХСЗХТөвийн цогц эмчилгээ үйлчилгээнд 2019оны 6сарын 1-ээс 2020 оны 6 сарын 1 хүртэлх нэг жилийн хугацаанд 6000 хүүхэд үйлчлүүлсэн байна. Үүнээс 1100 хүүхэд хэвтэн эмчлүүлснээс булчингийн чангарал, хөдөлгөөний хоцрогдлоос эмчилгээнд 395 хүүхэд гүний массаж аппаратын эмчилгээнд орсон. Гүний массаж эмчилгээний үр дүн тооцох шаардлагатай байна. Манай улсад булчингийн чангарлын үед гүний массаж аппаратын эмчилгээний үр дүнг тооцсон судалгаа ховор байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл болсон.

Зорилго

Булчингийн чангарлын үед гүний массаж аппаратын эмчилгээний үр дүнг тооцох

1. Гүний массаж аппаратын эмчилгээ эхлэхээс өмнө өвдөг тэнийлгэх болон шагай ээтийлгэх далайцыг хэмжих
2. Гүний массаж аппаратын эмчилгээ дууссаны дараах өвдөг тэнийлгэх болон шагай ээтийлгэх далайцыг хэмжих
3. Гүний массаж аппаратын эмчилгээний үр дүн ба эмчилгээний хоногийн хамаарлыг тодорхойлох

Судалгааны ажлын шинэлэг тал: Төвийн хэмжээнд гүний массаж эмчилгээний үр дүнг тооцсон.

Судалгааны ажлын таамаглал: Гүний массаж эмчилгээ нь эмчилгээний хоногтой шууд хамааралтай байна. Чангарсан булчинг сулруулснаар үений далайц нэмэгдэнэ.

Судалгааны арга зүй, материал: Түүврийн аргаар: 7-8-р сард үйлчлүүлсэн 0-16 насны 30 хүүхдийг сонгон авсан.

ЭМС-ын 2019оны А/611 дүгээр тушаалын 11дүгээр хавсралт ЭМБүртгэлийн маягт АМ-25А маягт, ЭМС-ын 2019 оны А/611тушаалын 11 дүгээр хавсралт ЭМБүртгэлийн маягт СТ-2 – ыг тус тус ашигласан болно.

- **Гүний массаж эмчилгээний аппаратын тухай товч танилцуулга:** HIWAMAT/200/50-250Гц-ийн давтамжтай, 2фазтай, тэгш өнцөгт долгионы тусламжтайгаар тодорхой хэсэгт цахилгаан талбай үүсгэх замаар эд эсийн гүнд 8-12 см гүнд чичирхийлэх шахах нөлөө үзүүлж эмчилнэ. Эмчилгээний үргэлжлэх хугацаа 10 минутаар хоногт нэг удаа хийгддэг.

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”


- Үений далайцыг хэмжих арга: Үений далайцыг гониометрээр хэмжинэ.


Үр дүн: Шагай ээтийлгэх эмчилгээ дунджаар 8.5 хоногт 3.96⁰ градусаар нэмэгдэж үений хэвийн далайц(20⁰) руу ойртож үений далайц нэмэгдсэн. Өвдөг тэнийлгэх

	Шагай ээтийлгэх эмчилгээний өмнө	Шагай ээтийлгэх эмчилгээний дараа	Эмчилгээнд явсан хоног
Нийт	30	30	30
Дундаж	11.37	15.33	8.53

Өвдөг тэнийлгэх эмчилгээ дунджаар 8.5 хоногт 3,7⁰ градусаар багасаж үений хэвийн далайц (0⁰) градус руу ойртож үений далайц сайжирсан.

	Өвдөг тэнийлгэх эмчилгээний өмнө	Өвдөг тэнийлгэх эмчилгээний өмнө	Эмчилгээнд явсан хоног
Нийт	30	30	30
Дундаж	12.4	8,7	8.53





Дүгнэлт

Гүний массаж аппаратаар эмчилгээ хийлгэсний дараа хүүхдийн өвдөг тэнийлгэх, шагай ээтийлгэх үений далайц сайжирч булчингийн чангарал суларч байна. Эмчилгээний хоногийг өвдөг тэнийлгэх, шагай ээтийлгэх үений далайц харьцуулахад ($p < 0.000$) статистик ач холбогдолтой байсан. Эмчилгээний хоног нэмэгдэхэд үений далайц нэмэгдэж байна.

Түлхүүр үг: шагай ээтийлгэх, өвдөг тэнийлгэх,

Талархал

Энэхүү судалгааг хийхэд тусалсан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн хүүхдийн эмч Н.Бат-Уянга болон сэргээн засах эмч Х.Туул Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн хөдөлгөөн засалч Н.Цэсэнжав, мөн Хүүхдийн төвийн бүх сувилагч нартаа баярлалаа

Ном зүй

- [1] Физик эмчилгээ Н.Мөнхцэцэг 2008он
- [2] Сэргээн засах А.Балжинням 2019он
- [3] Эх хүүхдийн эрдэм судлал 2020 он

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ТЕХНОЛОГИ АШИГЛАН ЦАГ АЛДАЛГҮЙ ХҮРГЭХ

Б.Ганзориг¹

¹Ди Ти Эс Сервис ХХК 8810-0010

Хураангуй

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд нийгэмд эзлэх байр суурь, төрийн тусламж үйлчилгээг авахад хүндрэлтэй байдгаас үндэслэн тэгээр иргэдэд технологийн давуу талыг ашиглан яаралтай тусламж үйлчилгээг авахад амар хялбар болгох боломжийг олгохоор зорьж ажиллаж байгаа ба энэхүү шийдлийг өөрсдийн технологийн мэдлэг болон 2 жилийн хугацааны үйлчилгээний туршлагад үндэслэн боловсрууллаа.

Түлхүүр үг: Түргэн тусламж, цагдаагийн тусламж, онцгой байдлын тусламж, Х апп

Удиртгал

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд хэл яриа, сонсгол, харааны бэрхшээл зэргээс шалтгаалан яаралтай тусламж үйлчилгээг авахад хүндрэл учирдаг ба яаралтай тусламж үйлчилгээг авч чадаагүйгээс үүдэн эд хөрөнгө, амь нас эрсдэх эрсдэл байгаа ба энэхүү эрсдэлийг тодорхой хэмжээгээр буулгах, тэдгээр иргэдийн яаралтай тусламж үйлчилгээг авах нөхцөлийг цахим хэлбэрт шилжүүлж үйлчилгээ авах процессыг амар хялбар болгоход гол зорилго оршин байна.

Орчин цагт технологийн хурдацтай хөгжлийн үр дүнд нийт хүн амын ухаалаг утасны хэрэглээ нэмэгдэж, дата үйлчилгээний үнэ тариф хямдрахтай зэрэгцэн иргэдийн дата хэрэглээ сайжирч байгаа нь нийгэмд чиглэсэн технологийн шийдлийг хийж хэрэгжүүлэхэд учирдаг байсан гол саат тотгорыг үгүй хийсэн сайн үзүүлэлт юм.

Манай компани хувьд гар утасны байршилд суурилсан такси дуудлагын үйлчилгээг 2018 оноос хойш үзүүлж байгаа ба хэрэглэгчдийн сэтгэлд нийцсэн үйлчилгээ болж чадсан билээ. Манай бүтээгдэхүүний хамгийн гол хэсэг нь жолооч хэрэглэгч хоёрын байршлын маш нарын тодорхойлох боломжтой байдаг учир энэхүү давуу талыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн яаралтай тусламж үйлчилгээ авахад нь ашиглах боломжтой.

Ажиллагааны ерөнхий зарчим

Ажиллагааны зарчмын хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэн яаралтай тусламж үйлчилгээний Х апп-г өөрийн гар утсан дээр суулгах ба суулгах явцад тухайн иргэний талаар дараах мэдээллүүдийг бүртгэн авна:

- Овог нэр
- Регистр
- Утасны дугаар
- Хөгжлийн бэрхшээлийн тодорхойлолт
- Гэрийн хаяг
- Ажлын хаяг
- Яаралтай үед холбоо барих хүний дугаар

Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн яаралтай тусламж үйлчилгээнүүдийг нэгдсэн байдлаар дуудлагыг авч холбогдох ажилтнуудад чиглүүлэх үүрэг бүхий лавлах төв ажиллах ба энэхүү лавлах төв нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоонуудтай нягт уялдаатай ажиллана.

Лавлах төвийн хувьд бүх иргэдийн бүртгэл мэдээлэл байх ба ямар хөгжлийн бэрхшээлтэй иргэн ямар төрлийн тусламж үйлчилгээ авахыг хүсэж байгааг 24 цагийн турш хяналтад байлгах боломжийг бүрдүүлж өгөх юм. Ингэснээр яаралтай тусламж үйлчилгээ авч чадахгүйгээс үүдэлтэй эд хөрөнгө, ам нас эрсдэх эрсдэлийг бууруулах боломжтой.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд яаралтай тусламж үйлчилгээг дараах газрууд үзүүлнэ:

- Эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээ
- Цагдаагийн тусламж үйлчилгээ
- Онцгой байдлын тусламж үйлчилгээ
- Такси тээврийн тусламж үйлчилгээ

зэрэг үйлчилгээг цаг алдалгүй хүргэж ажиллах ба энэхүү үйлчилгээнүүдийг хүргэхтэй холбоотойгоор байгууллага бүртэй хамтран нэгдсэн байдлаар тусламж үйлчилгээний дуудлагыг гар утас дээр хүлээн авах, дуудлагыг өгсөн иргэний хөгжлийн бэрхшээлийн талаар ерөнхий мэдээллийг апп-с авч иргэнд тохирсон үйлчилгээг шуурхай үзүүлж ажиллана.

1. Харааны бэрхшээлтэй иргэд

Харааны бэрхшээлтэй иргэдийн хувьд гэрээс гараад явах маршрут тогтмол тоотой байдаг ба тогтсон маршрутаас санамсаргүй байдлаар хазайсан тохиолдолд гэртээ харих

замаа олоход бэрхшээлтэй байдаг. Энэ тохиолдолд ихэвчлэн ойр хавьд явж байгаа иргэдээс тусламж гуйх зэргээр замаа олохыг хичээдэг. Гэвч зарим тохиолдолд тусламж үзүүлэх иргэн олдохгүй тохиолдолд тухайн иргэн маш хэцүү байдалд орох аюултай юм.

Энэ тохиолдолд Х апп-г ашиглан өөр хамгийн ойрхон эргүүлийн цагдааг дуудах боломжтой ба эргүүлийн цагдаа иргэний ямар төрлийн хөгжлийн бэрхшээлтэйг мэдэж байгаа тохиолдолд гар утасны байршлаар нь олж очиж төрийн үйлчилгээг үзүүлэх боломжтой болно.

Яг энэ жишээгээр түргэн тусламж, онцгой болон такси үйлчилгээг харааны бэрхшээлтэй иргэний байршилд суурилан үзүүлэх боломжтой.

2. Сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй иргэн

Сонсголын бэрхшээлтэй иргэний хувьд яаралтай тусламж үйлчилгээг шууд утсаар яриад авах боломжгүй тул Х апп-г ашиглан яаралтай тусламжийн дуудлагыг өгөх ба холбогдсон цагдаа, түргэн, онцгой байдлын албан хаагчид өөрийн нөхцөл байдлын талаар Х апп-н чат хэсгийг ашиглан мэдээлэл өгч яаралтай тусламж үйлчилгээгээ түргэн шуурхай, зөв оновчтой авах боломж бүрдэх юм.

Мөн Х апп ашиглан өгсөн дуудлагын бүх процессыг гар утас дээрээ цаг алдалгүй харах боломжтой учир дуудлага өгсөн цагдаагийн ажилтан эсвэл түргэн тусламжийн ажилтан хаана ирж яваах харах боломжийг олгоно.

Дүгнэлт

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн энэ төрлийн апп-г хэрэглээнд нэвтрүүлснээр төрийн тусламж үйлчилгээ оновчтой, хурдан шуурхай болон ба лавлах төвөөр дамжин тухайн иргэний дуудлага шийдвэрлэх явж ямар байгааг цаг алдалгүй харж дэлгэрэнгүй тайлан мэдээлэлтэй болох боломжтой.

Энэхүү дэлгэрэнгүй мэдээллийг үндэслэн эдгээр иргэдэд чиглэсэн үйлчилгээг хэрхэн сайжруулах талаар маш тодорхой дата мэдээллүүд үүсэх боломжтой.

Гэхдээ энэхүү системийг нийгэмд байршуулахад төрийн холбогдох төрийн байгууллагуудын оролцоо маш чухал.

Гар утасны байршилд суурилсан технологийн хувьд 2018 оноос хойш туршигдсан систем учир алдаа гарахгүй ажиллах боломжтой.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЭРҮҮЛ МЭНДЭД ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

Д. Батням¹, Э. Буяндэлгэр¹

¹Сургууль: ИЗОУИС Хууль зүйн сургууль

Удиртгал

1.1 Сэдэв сонгосон үндэслэл: Монгол улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал бодлого үйл ажиллагааны чиглэлээр буюу хууль эрх зүйн орчин, нийгэм хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд, боловсрол, дэд бүтэц болон бусад төрлөөр хийгдсэн судалгаа баримт бичиг төрийн бодлого түгээмэл боловч эрүүл мэндийн асуудал болох тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн үржихүйн асуудал буюу бэлгийн боловсролын талаарх баримт мэдээлэл төрөөс явуулах бодлого практикт төдийлөн хэрэгжихгүй байгаа нь энэхүү сэдвийг судлан шинжлэх үндэслэл болов.

1.2 Сэдэв судалсны ач холбогдол: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэнд тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн үржихүйн асуудал буюу бэлгийн боловсролын талаар судлан шинжилснээр түүнд тулгамдаж буй асуудлын талаар тодорхой мэдээллийг олон нийтэд түгээн дэлгэрүүлж сурталчлан таниулах, төрөөс явуулах бодлогын баримт бичигт энэхүү талаар шинэ мэдээ мэдээллийн оруулж инновацын хөгжлийг шинэ түвшинд гаргах ач холбогдолтой.

1.3 Судалгааны арга: Судлаач миний бие энэхүү сэдвийг судлахдаа баримт бичиг цуглуулах арга, гадаад орнуудын жишгийг харьцуулах аргыг ашигласан ба судалгааны мэдээлэл боловсруулах анализ, синтезийн аргыг тулгуур болгон ашигласан болно.

1.4 Сэдэв судлагдсан байдал: төрөөс эрүүл мэндийн тал дээр баримтлах бодлогын баримт бичиг, эрүүл мэндийн тухай хууль, эмнэлгийн тусламж үйлчилгээний хууль сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль, Монгол улс дахь жендерийн тэгш байдлын талаарх үзэл хандлага, олон улсын гэр бүл төлөвлөлтийн холбооны тайлан монгол улсын нэгдэн орсон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн асуудал

1.5 Түлхүүр үг: хөгжлийн бэрхшээлтэй иргэн, эрүүл мэнд, нөхөн үржихүйн эрүүл мэнд, инновац, төрийн үйлчилгээ, гэмт хэрэг, боловсрол.

Үндсэн хэсэг

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндэд тулгамдаж буй зарим асуудал:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1-д зааснаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие мах бод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хамааруулна гэж заажээ.

Хөгжлийн бэрхшээлийн төрлийг төрөлхийн ба олдмол гэсэн ангиллаар тодорхойлдог байна. Тухайн хүнд удамшлын шинжтэйгээр бий болсон хөгжлийн бэрхшээлийг төрөлхийн, амьдралын явцад бий болсон хөгжлийн бэрхшээлийг олдмол гэсэн төрөлд хамааруулж байна. Тус үзүүлэлтийн хөгжлийн бэрхшээлийн хэлбэрийг бие мах бодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согог нь тухайн иргэнд ямар байдлаар илэрч байгаатай холбоотойгоор харааны, ярианы, сонсголын, хөдөлгөөний, сэтгэцийн, хавсарсан, бусад гэсэн ангиллаар авч үзэж байна.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан мэдээллээр 2018 оны эцсийн байдлаар Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй 105.7 мянган иргэн байгаагийн 59.7 мянга нь эрэгтэйчүүд, 46.0 мянга нь эмэгтэйчүүд байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 44.4 хувь нь төрөлхийн, 55.6 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна. Энэ нь хүн амын дунд олдмол байдлаар хөгжлийн бэрхшээлтэй болох тохиолдол өндөр байгааг харуулж байгаа ба Улаанбаатар хотын хувьд 2018 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 35.6 мянган иргэн байгаагийн 19.7 мянга нь эрэгтэйчүүд, 15.9 мянга нь эмэгтэйчүүд байдаг байна гэсэн судалгаа бий.

Олдмол хөгжлийн бэрхшээлтэй болох эрсдэл өндөр байгаа нь манай улсын нийт хүн амын өвчлөл, нас баралтын голлох шалтгааны нэг нь осол болж байгаатай холбоотой юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүн амыг бэрхшээлийн төрөл, насаар авч үзэхэд бага, залуу насныхны дунд төрөлхийн хөгжлийн бэрхшээлийн тохиолдол өндөр байснаа нас ахихын хэрээр олдмол бэрхшээлтэй хүмүүсийн эзлэх хувь нэмэгдэх хандлага байна.

Үндэсний статистикийн хорооны мэдээгээр Монгол Улсын нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоог 2014-2018 оны байдлаар харахад 6118 буюу 6.1 хувиар өссөн

байна. Төрөлхийн бэрхшээлтэй хүний тоо 11277 буюу 31.6 хувиар нэмэгдсэн, олдмол бэрхшээлтэй хүний тоо 5243 буюу 8.5 хувиар буурсан байна.

Дэлхийн ихэнх улс орнуудын хөгжлийн бэрхшээлийн статистикийн уламжлалт чиг хандлага зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоог тодорхойлоход чиглэгдэж байсан бол сүүлийн үед уг ойлголт нь өргөжин, тэдгээрийн нийгмийн харилцаанд оролцоход тулгарч буй өдөр тутмын хүндрэл, бэрхшээлийг илрүүлэх, шалтгааныг нарийвчлан судлах, хэрэгцээг тодорхойлох зэрэг өргөн агуулгатай болж байна. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь бусдын адил нийгмийн харилцаанд эрх тэгш оролцож, сайн сайхан амьдрах ёстой гэсэн үзэл санаанд үндэслэн хөгжиж байна. Үүнтэй уялдаж хөгжлийн бэрхшээлийн тоо мэдээллийг сайжруулах хэрэгцээ шаардлага урган гарч байна.

Үүний нэгэн адилаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгарч буй олон асуудал байгаа ба үүний нэг нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэнд, түүнд төрөөс үзүүлж буй үйлчилгээний асуудал нэн чухал байгаа билээ. Мөн эрүүл мэнд тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй иргэний бэлгийн болон нөхөн үржихүйн асуудалд төрөөс үзүүлж буй үйлчилгээ дутмаг, иргэдийн үзэл хандлага хийгээд мэдлэггүйгээс улбаалан олон асуудлууд урган гарч ирсээр байна.

Египетийн Кайр хотноо 1994 онд хуралдсан “Хүн ам ба хөгжлийн олон улсын бага хурал”-аас баталсан “Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр” -т нөхөн үржихүйн эрхийг тодорхойлохдоо хосууд болон аливаа хувь хүн хүүхэдтэй болох эсэх, мөн хэзээ, хэдэн хүүхэд төрүүлэхээ чөлөөтэй бөгөөд хариуцлагатайгаар шийдэх; энэ шийдвэрээ гаргахад хэрэгтэй мэдээлэл авахаас гадна бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн дээд түвшинд эрүүл байх; аливаа хүн нөхөн үржихүйн эрүүл мэндийн хамгийн чанартай, стандартын тусламж, үйлчилгээ авах; ялгаварлан гадуурхалт, албадлага, хүчирхийллээс ангид байж, нөхөн үржихүйн асуудлаар өөрсдөө шийдвэр гаргах эрхтэй байна гэсэн дүгнэлтэд хүрчээ.

Түүнчлэн Олон улсын гэр бүл төлөвлөлтийн холбооноос бэлгийн болон нөхөн үржихүйн эрхтэй салшгүй холбоотой хүний бусад эрхийг дараах байдлаар жагсаажээ. Үүнд: амьд явах; бэлгийн болон нөхөн үржихүйн амьдралаа өөрөө шийдэх; ялгаварлан гадуурхалтаас ангид байх; халдашгүй байх; үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх; мэдээллээр хангагдах; баталгаатай, хүртээмжтэйгээр бэлгийн боловсрол олж авах; гэр бүлээ төлөвлөх,

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

гэрлэх эсэхээ өөрөө шийдэх; эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тусламж, үйлчилгээ авах; эрүүл мэндээ хамгаалуулах зэрэг олон эрхийг багтаасан байна.

Гэтэл Монгол улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэр дундаа сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй иргэдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндтэй холбоотой асуудалд гэр бүлийн гишүүдийн хандлага хийгээд төрөөс чиглэсэн үйлчилгээ хангалтгүй байгаагийн улмаас гэр бүлийн тухай хуульд заасан эрхээ нэг мөр эдэлж чадахгүй, хүсээгүй бэлгийн харилцаанд орох, БЗХӨ өртөх, хүсээгүй жирэмслэлт, гэмт хэргийн хохирогч болох зарим тохиолдолд өөрсдөө гэмт хэрэг үйлдэх болзошгүй нөхцөл байдлууд бий болж үүнээс улбаалан үр хөндөлт болон сэтгэл санаа бие махбодоороо хохирох тохиолдол цөөнгүй гарч байгааг дараах кейс харуулж байна.

Тохиолдол №1

Харааны бэрхшээлтэй эмэгтэйтэй хийсэн ярилцлага

Хөдөө орон нутаг амьдардаг эмэгтэйчүүд ялангуяа харааны бэрхшээлтэй эмэгтэйчүүд хүчирхийлэлд их өртдөг. Жишээ нь би хэнд хүчиндүүлснээ мэдэж чадаагүй БЗХӨ авч байсан. Эмнэлэгт үзүүлэхээр очиход хараагүй байж хэнээсээ авдаг байна. эрийн донтой байх нь гэж эмч хэлж байсан. Би эмнэлэгт очих дургүй яагаад өвчин авсан талаар асуухгүй байж шууд дүгнэлт хийдэг...

Тохиолдол №2

Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүгийн асран хамгаалагчтай хийсэн ганцаарчилсан ярилцлага.

Манай хүү суумгай өвчтэй одоо 25 настай гэртээ байдаг надаас өөр хүнтэй харилцаж үзээгүй намайг хувцсаа солих, аль эсвэл нүцгэн байх үед араас тэврэх тохиолдлууд гарч байсан тухайн үед хаана хандаж хэнд хэлэхээ сайн мэдэхгүй байсан.....

Мөн ихэнх эрүүл мэндийн төвд ороход тэргэнцэртэй, эсвэл таягтай хүн үүдээр нь орохоос эхлээд их хүнд байдаг. Учир нь эрүүл мэндийн төвөөс хол, хөгжлийн бэрхшээлтэй хүн ганцаараа хүрэх газартаа очих гэхээр тэдэнд тохирох тээврийн хэрэгсэл байдаггүй

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

зэргээс шалтгаалдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тохиромжтой тоног төхөөрөмж, хэрэгслүүд (намхан ор, сайн чанарын катетер г.м) бараг байдаггүй. Эрүүл мэндийн төвүүдийн ажиллах цагийн хуваарь бусдын дэмжлэг шаарддаг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тохиромжтой бус байдаг. Ихэнх эмэгтэйчүүд эрэгтэй эмчид үзүүлэхдээ мэгдэн сандардаг. Эрүүл мэндийн ажилтнууд сонсголын бэрхшээлтэй үйлчлүүлэгчтэй хэл нэвтрэлцэж чаддаггүй. Мөн хараагүй үйлчлүүлэгчид зориулсан эрүүл мэндийн мэдээллийн гарын авлага байдаггүй. Эмч сувилагч болон бусад эрүүл мэндийн ажилтнууд хөгжлийн бэрхшээлийн талаар тэр бүр мэддэггүй, эсвэл сайн сургагдаагүй байдаг. Тэд хөгжлийн бэрхшээлийн талаар ташаа ойлголттой байх боломжтой тул таныг сонсохгүй байх талтай байдаг гэж үзсэн ба эдгээр асуудлуудыг дараах кейс харуулж байна.

Тохиолдол №3

Хөгжлийн бэрхшээлтэй гэхээр хүмүүс тэргэнцэртэй байх ёстой мэтээр төсөөлдөг. Би уналт таталт өгдөг. Эмнэлгүүдэд суух сандал цөөхөн. Би гаднаасаа ямар ч бэрхшээлгүй харагддаг учраас хүмүүс мэддэггүй. Олон хүнтэй газраар явах, хүмүүс шуугилдах, бүгчимдэх, 20-30 минут дараалалд зогсоход л өөрийн хяналтгүй шууд ухаан алддаг тул дүүргийн эмнэлгээр явж үзүүлэхэд их бэрхшээл учирдаг.

Эпилепси оноштой эмэгтэйтэй хийсэн ганцаарчилсан ярилцлага,
Улаанбаатар хот

Тохиолдол №4

Би 44 настай, тэргэнцэртэй болоод 20 жил болж байна. Эмэгтэйчүүдийн эмчид үзүүлэхийг хүсдэг ч тохирох ариун цэврийн өрөө эмнэлэг дээр байхгүй, үзлэгийн орон дээр яаж гарах уу зэрэг бэрхшээлээс айгаад одоог болтол нэг ч удаа үзүүлээгүй. Мэдээж өөртөө санаа зовж байна.

Тулгуур эрхтний бэрхшээлтэй эмэгтэйтэй хийсэн ганцаарчилсан ярилцлага,
Улаанбаатар хот

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс анхан шатны тусламж үзүүлэх багаас үйлчилгээг авах ёстой, гэхдээ эрүүл мэндийн иж бүрэн тусламж дэмжлэг шаардлагатай үед мэргэжлийн

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

үйлчилгээ, байгууллага, институтүүд бэлэн байх ёстой. Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчдийн хандлага, мэдлэг, чадварыг сайжруулахын тулд эрүүл мэндийн тусламж үзүүлдэг мэргэжилтнүүдэд боловсрол олгохдоо хөгжлийн бэрхшээлтэй холбоотой мэдээллийг өгч байх ёстой. Боловсрол олгох болон сургалт зохион байгуулахдаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өөрсдийг нь хамруулах нь мэдлэг, хандлагыг сайжруулж чадна гэж дүгнэсэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийг хангахын тулд нэн түрүүнд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг чадавхжуулж, эрхээ мэдэх, шаардах чадварт сургах, улмаар гэр бүлийн гишүүдэд хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загварын талаар ойлголт өгч, мэдээллээр хангах, нийгмийн дэмжлэгт орчин, бие даан амьдрах, туслах үйлчилгээг бий болгох замаар хөгжлийн бэрхшээлтэй охид эмэгтэйчүүдийг хэн нэгнээс хараат бус амьдрах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Монгол улсын хэмжээнд эмэгтэйчүүдийн бүх төлөөллийг хамруулж 2017 онд хийсэн жендерт суурилсан хүчирхийллийн судалгааны тайлангаас харахад судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн 14 хувь нь бэлгийн хүчирхийлэлд өртсөн гэж мэдээлж байв. Тэгвэл Комиссоос хийсэн судалгаанд Улаанбаатар хотоос оролцогчдын 18 хувь нь, орон нутгийн оролцогчдын 3.6 хувь нь бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан, 19.9 хувь нь ойр орчимд нь хөгжлийн бэрхшээлтэй хэн нэгэн бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан тохиолдлыг мэднэ гэжээ.

Цагдаагийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэлд Эрүүгийн хуульд заасан бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд хохирогчоор тогтоогдсон тохиолдол цөөнгүй байна. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлд заасан Хүчиндэх гэмт хэрэгт 2018 онд улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 24 эмэгтэй хохирогчоор тогтоогдсоны 7 нь насанд хүрээгүй охид, 17 нь насанд хүрсэн эмэгтэйчүүд байна. Энэ төрлийн гэмт хэрэгт орон нутагт амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд илүү хохирчээ. Тухайлбал орон нутагт насанд хүрээгүй 6, насанд хүрсэн 11 эмэгтэй хохирогчоор тогтоогдсон байна гэж үзжээ.

Дүгнэлт

Үүнээс үзэхэд монгол улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэр дундаа сонсголын болон харааны бэрхшээлтэй иргэдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудлыг дагаад хуульд заасан эрхээ эдэлж чадахгүй тохиолдлууд нэлээдгүй гарах мөн дээрээс нь гэмт хэргийн хохирогч болж бие махбод, сэтгэл санааны хийгээд эрүүл мэнд, эдийн засаг, нэр хүндээрээ хохирч энгийн иргэдийн дунд ялгаварлан гадуурхагдах, эмнэлгийн үйлчилгээ, тоног төхөөрөмж, боловсон хүчин зэрэг олон зүйлс дутмаг байгаа нь олон улсын гэрээнд заасан эрх нь ноцтой зөрчигдөж эмнэлгийн тусламж үйлчилгээ авах итгэл найдвар нь буурч нийгмийн харилцаанд оролцохоос зайлсхийх түгээмэл хандлага их гарч байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй нийт иргэдийн 55% нь эрэгтэй хүмүүс байдаг ба эдгээр хүмүүст чиглэсэн судалгаа, болон бэлгийн боловсролын мэдээ мэдээлэл төрөөс үзүүлж буй үйлчилгээ тун хомс байгаа юм.

Уг асуудлын шийдвэрлэх зохицуулалтын хүрээнд судлаачийн зүгээс дараах саналыг дэвшүүлж байна. үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэнд тэр дундаа бэлгийн болон нөхөн үржихүйн боловсролын талаарх цогц мэдлэг, мэдээллийг олгоход анхаарах
2. Сонсголын болон харааны бэрхшээлтэй иргэдэд мэргэшсэн зөвлөгөө мэдээлэл өгөх хэлмэрч, сэтгэл зүйч болон боловсон хүчнийг бэлтгэн гаргах
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд эмнэлгийн байгууллагаар үйлчлүүлэхэд шаардлагатай тусгай тоног төхөөрөмжөөр хангах зэрэг асуудлууд нэн тэргүүнд тулгамдаж байгаа ба үүнийг дагаад улсын болон бүх шатны эмнэлгийг тоног төхөөрөмжийг сайруулах.
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчлүүлэх нарийн мэргэшлийн эмч, тусгай тоног төхөөрөмж, боловсон хүчин бүхий нэгдсэн **ЭМНЭЛЭГТЭЙ** болох шаардлага зайлшгүй тулгарч байна.

Ашигласан материал

Хууль хуульчилсан акт:

[1] Гэр бүлийн тухай хууль. ТМ. УБ., 1999 он.

- [2] Эрүүл мэндийн тухай хууль. ТМ. УБ., 2011 он.
- [3] Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль. ТМ. УБ., 2013 он
- [4] Эрүүгийн хууль. ТМ. УБ., 2015 он.
- [5] Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль. ТМ. УБ., 2016. он
- [6] Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль. ТМ. УБ., 2016 он.
- [7] Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль. ТМ. УБ., 2016 он

Ном сурах бичиг:

- [8] Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд зориулсан эрүүл мэндийн гарын авлага, УБ., 2016 он.
- [9] Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа. УБ., 2017. он.
- [10] Үндэсний Статистикийн Хороо, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан, Швейцарын Хөгжлийн Агентлаг, Хүчирхийллийн нүцгэн үнэн, 2017 он.
- [11] ХЭҮК. хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн асуудал. УБ., 2019. он.
- [12] Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа. УБ., 2019 он.
- [13] World healthorganization. Хөгжлийн бэрхшээлийн талаарх дэлхийн тайлан. Товч дүгнэлт.
- [14] Засгийн газрын 2017 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн 321 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр.
- [15] Нэгдсэн үндэсний байгууллага. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүмүүсийн эрхийн тухай конвенц.
- [16] Швейцарын хөгжлийн агентлаг. IRIM судалгааны хүрээлэн Монгол улс дахь жендерийн эрх тэгш байдал. Нөхцөл байдлын товч үнэлгээ баримт бичгийн судалгаа. УБ., 2014. он

Бусад:

- [17] Цагдаагийн ерөнхий газраас 2019 оны 2 дугаар сарын 22-ны өдөр ирүүлсэн 01/122 дугаар албан бичиг.

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

[18] IPPF Charter guidelines on sexual and reproductive rights.


[19] <http://nhrcm.gov.mn/> Хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах шаардлагатай байна.

[20] Үндэсний статистикийн хороо. www.1212.mn. 2018 он.

[21] <https://www8.cao.go.jp/shougai/whitepaper/h30hakusho/zenbun/>

Хавсралт

図表 2 年齢階層別障害者数の推移（身体障害児・者（在宅））




注1：昭和55年は身体障害児（0～17歳）に係る調査を行っていない。

注2：四捨五入で人数を出しているため、合計が一致しない場合がある。

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

資料：厚生労働省「身体障害児・者実態調査」（～平成18年）、厚生労働省「生活のしづらさなどに関する調査」（平成23・28年）

図表3 年齢階層別障害者数の推移（知的障害児・者（在宅））




注：四捨五入で人数を出しているため、合計が一致しない場合がある。

資料：厚生労働省「知的障害児（者）基礎調査」（～平成17年）、厚生労働省「生活のしづらさなどに関する調査」（平成23・28年）

図表4 年齢階層別障害者数の推移（精神障害者・外来）

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

(単位:万人)



注1：平成23年の調査では宮城県の一部と福島県を除いている。

注2：四捨五入で人数を出しているため、合計が一致しない場合がある。

資料：厚生労働省「患者調査」（平成26年）より厚生労働省社会・援護局障害保健福祉部で作成

図表5 障害者手帳所持者数等、性・障害種別等別

(65歳未満) (単位:千人)

性	総数		障害者手帳所持者		障害者手帳の種類 (複数回答)						手帳非所持でかつ自立支援給付等を受けている者	
	数	割合	数	割合	身体障害者手帳		療育手帳		精神障害者保健福祉手帳		数	割合
総数	2,382	(100.0%)	2,237	(100.0%)	1,082	(100.0%)	795	(100.0%)	594	(100.0%)	145	(100.0%)
男性	1,359	57.1%	1,280	57.2%	593	54.8%	497	62.5%	307	51.7%	79	54.5%
女性	1,014	42.6%	950	42.5%	486	44.9%	295	37.1%	282	47.5%	64	44.1%
不詳	9	0.4%	8	0.4%	3	0.3%	3	0.4%	5	0.8%	1	0.7%

(65歳以上及び年齢不詳)

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

性	総数		障害者手帳所持者		障害者手帳の種類（複数回答）						手帳非所持でかつ自立支援給付等を受けている者	
					身体障害者手帳		療育手帳		精神障害者保健福祉手帳			
総数	3,550	(100.0%)	3,358	(100.0%)	3,205	(100.0%)	168	(100.0%)	247	(100.0%)	193	(100.0%)
男性	1,756	49.5%	1,691	50.4%	1,627	50.8%	89	53.0%	106	42.9%	64	33.2%
女性	1,772	49.9%	1,645	49.0%	1,565	48.8%	73	43.5%	130	52.6%	127	65.8%
不詳	23	0.6%	21	0.6%	13	0.4%	5	3.0%	11	4.5%	1	0.5%

注：四捨五入で人数を出しているため、合計が一致しない場合がある。

資料：厚生労働省「生活のしづらさなどに関する調査」（平成28年）

図表 6 精神障害者の男女別数

	20歳未満	20歳以上
男性	166 (62.2%)	1,431 (39.1%)
女性	101 (37.8%)	2,229 (60.9%)
計	267 (100.0%)	3,655 (100.0%)
	65歳未満	65歳以上
男性	1,130 (46.5%)	467 (31.0%)
女性	1,290 (53.5%)	1,040 (69.0%)
計	2,418 (100.0%)	1,506 (100.0%)

СЭТГЭЦИЙН ЭМГЭГТЭЙ ХҮНИЙ СЭТГЭЦ-НИЙГМИЙН РЕАБИЛИТАЦИ

Л.Уянга¹, Б.Оюунтуяа¹, Я.Сампил¹

¹СЭМҮТ

Хураангуй

Монгол улсад 2018 оны байдлаар нийт бүртгэгдсэн 105 730 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаагаас 18.3% (19 343) (2013 он) нь сэтгэц оюуны хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна. Сэтгэцийн эмгэгтэй хүнийг бие даан амьдрах чадварыг суулгах, амьдрах орчин болон өөрийгөө арчлах чадварыг нэмэгдүүлэх, нийгмийн дунд амьдрах дадал хэвшилтэй болгох зорилгоор сэтгэц нийгмийн сэргээн засах “Гэр төв”-ийг анх 2000 онд ажиллуулж эхэлсэн. Монгол орны нөхцөлд сэтгэц нийгмийн сэргээн засах үйлчилгээг үзүүлэх “Гэр төв” нь хаана ч барих боломжтой, цаг хугацаа, өртөг зардал хэмнэх олон давуу талтай юм. Сэтгэц-нийгмийн реабилитацид сэтгэцийн эмгэгт өртсөн хүмүүсийг хамруулснаар нийгэм хамт олон дунд эмчлэх боломжийг бүрдүүлж нөгөө талаар сэтгэцийн эрүүл мэндийн талаарх эерэг, зөв ойлголтууд хүн амын дунд түгэх болно.

Судалгааг тоон болон чанарын судалгааны хэлбэрээр аналитик судалгааны аргаар явуулав. Судалгаанд оролцогчид нь гэр оронгүй, асран хамгаалагч байхгүй, бие даан амьдрах чадвартай сэтгэцийн болон зан үйлийн эмгэг оноштойгоор СЭМҮТ-ийн Асрамжийн тасгийн “Гэр төв”-д 2000-2020 онд хэвтэн эмчлүүлж буй нийт 30 эмчлүүлэгчийг хамруулав.

Түлхүүр үг: Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв (СЭМҮТ), гэр,

Удиртгал

Монгол улсад 2018 оны байдлаар нийт бүртгэгдсэн 105 730 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаагаас 18.3% (19 343) (2013 он) нь сэтгэц оюуны хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна. Монгол улсад сэтгэцийн эрүүл мэндийн 6 төрлийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг. СЭМҮТ нь эдгээр тусламж, үйлчилгээг улсын хэмжээнд хэрэгжүүлэн ажилладаг ба үүнээс сэтгэцийн эмгэгтэй хүний асрамжийн үйлчилгээг СЭМҮТ-ийн Асрамжийн тасаг 122 эмчлүүлэгчтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр 30 эмчлүүлэгч нь СЭМҮТ-ийн газрын хойд хэсэгт 2.0 га газар 8 ширхэг Монгол гэрт сэтгэц-нийгмийн реабилитацид хамрагдан амьдардаг.

Сэтгэцийн өвчний улмаас алдаж гээсэн амьдрах ухааны ур чадваруудыг нөхөн сэргээхийг, тэрчлэн сэтгэцийн өвчний улмаас алдаж гээсэн бусадтай харьцах харилцааны ур чадваруудыг нөхөн сэргээхийг, тэрчлэн сэтгэцийн өвчний улмаас алдаж гээсэн сэтгэц-оюуны бусад чадваруудыг нөхөн сэргээхийг буюу шинээр эзэмшүүлэхийг сэтгэцийн өвчтөний сэтгэц-нийгмийн реабилитаци гэнэ. Биеийн өвчнүүдтэй харьцуулахад сэтгэцийн эмгэгүүдийн үед өвчтөнүүдийн сэтгэцийн ба нийгмийн энх тунх байдлууд илүү хямарна.

Иймд сэтгэцийн өвчтэй хүмүүсийн алдагдсан сэтгэцийн ба нийгмийн статусыг нөхөн сэргээхэд чиглэгдсэн сэтгэц-нийгмийн реабилитацийг сэтгэцийн эмнэлгийн байгууллагуудад тууштай нэвтрүүлэх шаардлагатай байдаг билээ.

Монгол улсад С.Бямбасүрэн нарын 1984-1986 онуудад хийсэн судалгаагаар сэтгэцийн эмгэгтэй 5929 өвчтөний хөдөлмөрийн чадварын байдлыг тодорхойлж үзэхэд тэдний 47% нь сэтгэцийн өвчний реабилитацийн арга хэмжээнүүдийг шаардсан сэтгэцийн архаг өвчтэй хүмүүс байжээ.

Олон улсын туршлагаас авч үзэхэд тухайлбал солонгос улсад 2-3 давхар амины орон сууцыг нэг давхартаа гал тогоотой, нэг өрөөнд 4 хүн байх зохион байгуулалттайгаар 20-30 хүнтэй асрамжийн төвүүд ажилладаг байна. Уг төвд 1 сувилагч, 1 сэтгэлзүйч байх ба сэтгэцийн эмгэгтэй хүмүүс бие даан амьдрахаас гадна хөнгөн хэлбэрийн хөдөлмөр эрхэлж, хамт олноороо олон нийтийн үйл ажиллагаанд оролцох, кино үзэх зэргээр нийгэм хамт олонд ойр байлгаж, нийгмийн харилцаанд оролцох боломжийг олгодог байна.

Судалгааны зорилго

СЭМҮТ-ийн асрамжийн тасгийн эмчлүүлэгчдэд бие даан амьдрах чадварыг суулгах зорилготой сэтгэц-нийгмийн реабилитацийн үр дүнг үнэлэх.

Судалгааны зорилт

1. Гэрт эмчлүүлж байгаа эмчлүүлэгчдийн мэдээллийг судлах;
2. Сэтгэцийн эмгэгтэй эмчлүүлэгчдэд сэтгэц-нийгмийн реабилитацийн үр дүнг судлах.

Шинэлэг байдал

Сэтгэцийн эмгэгтэй хүнийг бие даан амьдрах чадварыг суулгах, амьдрах орчин болон өөрийгөө арчлах чадварыг нэмэгдүүлэх, нийгмийн дунд амьдрах дадал хэвшилтэй болгох зорилгоор сэтгэц нийгмийн сэргээн засах “Гэр төв”-ийг анх 2000 онд ажиллуулж эхэлсэн. Өдгөө нийслэлд (8), орон нутагт (3) нийт 11 байна. Нийслэл дэх 8 “Гэр төв”-үүд СЭМҮТ-д байрлан, одоогийн үйл ажиллагаа нь гэр оронгүй, асран хамгаалагч байхгүй, бие даан амьдрах чадвартай сэтгэцийн болон зан үйлийн эмгэг оноштой нийт 30 өвчтөнүүдэд асрамжийн төвийн хэлбэрээр үйлчилгээ үзүүлж байна. Монгол орны нөхцөлд сэтгэц нийгмийн сэргээн засах үйлчилгээг үзүүлэх “Гэр төв” нь хаана ч барих боломжтой, цаг хугацаа, өртөг зардал хэмнэх олон давуу талтай юм.

Ач холбогдол

Сэтгэцийн эмгэгийн онош, хүнд болон хөнгөн хэлбэрээс шалтгаалан бие даан амьдрах чадвартай хүмүүсийг тодорхой хараа хяналтад жижиг бүлэг буюу 1 гэрт амьдруулснаар өвчний улмаас гээсэн амьдрах ухааны ур чадваруудыг нөхөн сэргээх буюу эзэмшүүлэх, гар нүүрээ угаах, хувцсаа өмсөх, ор дээрээ хураах, хоол ундаа өөрөө гардан идэх зэргээр бие даан өөрийгөө арчлан сувилах ур чадваруудыг нөхөн сэргээх буюу эзэмшүүлэх, мод, ногоо тарьж арчлах, хог цэвэрлэх, шал угаах зэрэг энгийн хөдөлмөрийн дадал зүйг эзэмшүүлэх буюу нөхөн сэргээх, оёдолчин, ногоочин, мужаан мэтийн түгээмэл мэргэжлийн мэдлэг олгож, дадал зүйг эзэмшүүлэх, өвчний улмаас гээсэн нийгмийн харилцааны ур чадваруудыг нөхөн сэргээх буюу бусадтай харилцах ур чадварыг эзэмшүүлэх, эрүүл аж төрөх төрх үйлийг эзэмшүүлэх, биеэ зөв авч явах төрх үйлд сургах болон өвчний улмаас алдаж гээсэн аж төрөхөд зайлшгүй хэрэгтэй бусад мэдлэг, ур чадваруудыг нөхөн сэргээх буюу эзэмшүүлэх сэтгэцийн болон нийгмийн ач холбогдолтой. Ингэснээр сэтгэцийн эмгэгт өртсөн хүмүүсийг нийгэм хамт олон дунд эмчлэх боломжийг бүрдүүлж нөгөө талаар сэтгэцийн эрүүл мэндийн талаарх эерэг, зөв ойлголтууд хүн амын дунд түгэх болно.

Судалгааны арга, арга зүй

Судалгааг тоон болон чанарын судалгааны хэлбэрээр аналитик судалгааны аргаар явуулав. Судалгаанд оролцогчид нь гэр оронгүй, асран хамгаалагч байхгүй, бие даан амьдрах чадвартай сэтгэцийн болон зан үйлийн эмгэг оноштойгоор СЭМҮТ-ийн Асрамжийн тасгийн “Гэр төв”-д 2000-2020 онд хэвтэн эмчлүүлж буй нийт 30 эмчлүүлэгчийг хамруулав. Судалгаанд оролцогчдоос тусгайлан боловсруулсан 16 асуулт бүхий судалгааны карт болон өвчний түүхийг ашиглан мэдээллийг цуглуулж, Microsoft Excel 2013 программ дээр боловсруулалт хийлээ.

Судалгааны үр дүн, шүүн хэлэлцэхүй

Нийт судалгаанд оролцогч 30 эмчлүүлэгчийг насны байдлаар авч үзвэл 35-44 нас 20% (6), 45-54 нас 53.3% (16), 55-64 нас 26.7% (8) ба хүйсийн хувьд эрэгтэй 56.7% (17), эмэгтэй 43.3% (13) тус тус эзэлж байсан бол 43.3% (13) дунд, 50% (15) бага боловсролтой, 6.7% (2) нь боловсролгүй байв. Улаанбаатар хотын харьяа 22 (73.3%), Дархан-Уул аймгийн харьяа 3 (9.9%), Баян-Өлгий аймгийн харьяа 1 (3.3%), Баянхонгор аймгийн харьяа 1 (3.3%), Булган

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

аймгийн харьяа 1 (3.3%), Өвөрхангай аймгийн харьяа 1 (3.3%), Хөвсгөл аймгийн харьяа 1 (3.3%) эмчлүүлэгч байна.

Мөн нийт судалгаанд оролцогчдыг өвчний оношны байдлаар авч үзвэл тэнэгрэл оноштой 1 (3.3%), тархины гэмтлийн шалтгаант сэтгэцийн эмгэгтэй 3 (9.9%), үлдэц шизофрени оноштой 14 (46.7%), оюуны хомсдол оноштой 12 (40%) (оюуны хөнгөн хомсдол 1 (3.3%), оюуны хүндэвтэр 10 (33%), оюуны хүнд хомсдолтой 1 (3.3%)) эмчлүүлэгч байна. Өвчин төрөлхийн ба олдмол тул 16-60 жил тус өвчнөөр өвдсөн эмчлүүлэгчид байна. Эдгээр эмчлүүлэгчид нь 2-30 жил буюу дунджаар 15 жил тус төвд хэвтэн эмчлүүлсэн байна. Эмчлүүлэгчдийн 96.7% (29/30) хувь нь хөдөлмөрийн чадвар алдалт 60-80 хувьтайгаар тогтоолгосон, 3.3% (1) нь бичиг баримтын асуудлаар хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгож чадаагүй байна.

Сэтгэцийн өвчний дахилтын байдлыг авч үзвэл гэрт эмчлүүлэгчид нь сүүлийн 1 жилийн хугацаанд 22 (73.3%) эмчлүүлэгчид сэтгэцийн өвчний дахилт өгөөгүй, 3 эмчлүүлэгч уналт таталт өгсөн, 1 (3.3%) эмчлүүлэгчид сэтгэл түгшил, айдас илэрсэн, 1 (3.3%) эмчлүүлэгчид эмгэг дур илэрсэн, 2 (6.6%) эмчлүүлэгчид үлдэц дэмийрэл илэрч тухай бүрд эмчилгээ хийлгэсэн байна. Эдгээр эмчлүүлэгчдийн 19 (66.7%) нь 1-2 төрлийн сэтгэц идэвхт эмийг өдөрт 1-2 удаа хэрэглэдэг, уналтын эсрэг эмийг 6 (20%) эмчлүүлэгч хэрэглэдэг, 1 эмчлүүлэгч сэтгэц идэвхт эм болон уналтын эмийг хавсран хэрэглэдэг ба 4 (13.3%) эмчлүүлэгч сэтгэц идэвхт эм уухгүйгээр сэтгэц-нийгмийн реабилитацид хамрагдан сэтгэцийн хувьд засрал сайжралын байдалтайгаар байдаг байна. Биеийн талаас артерийн даралт ихсэлт, хатги, нүдний үрэвсэлт өвчин, ринит, гүйлсэн булчирхайн үрэвсэл, гэдэсний халдварт өвчин, харшил, элэгний архаг өвчин, цөсний чулуу, бөөрний архаг өвчин, нойр булчирхайн архаг үрэвсэл зэрэг эмгэгүүд илэрч эмчилгээ хийлгэсэн байна. 2000-2020 онд гэрт эмчлүүлэгчдэд нас баралт болон сүрьеэ өвчин илрээгүй байв.

Эмчлүүлэгчид сэтгэц-нийгмийн реабилитацид тасралтгүй хамрагддаг ба өдөр бүр эмнэлгийн нийт эмчлүүлэгчидтэй хамт өдөрт 2 цаг хөдөлмөр эмчилгээнд хамрагддаг, үүнд: оёдолчин, ногоочин, мужаан мэтийн түгээмэл мэргэжлийн мэдлэг олгож, дадал зүйг эзэмшүүлэх, мөн эмнэлгийн ажилтнуудын тусламжтайгаар бие даан амьдрах чадвар: гар нүүрээ угаах, усанд орох, хувцсаа өмсөх, ор дээрээ хураах, хоол ундаа өөрөө гардан хийх, идэх, аяга угаах, шал угаах, хашаагаа цэвэрлэх, мод, ногоо тарьж арчлах г.м, өвчний улмаас гээсэн нийгмийн харилцааны ур чадваруудыг нөхөн сэргээх буюу бусадтай харилцах ур

чадварыг эзэмшүүлэх, эрүүл аж төрөх төрх үйлийг эзэмшүүлэх, биеэ зөв авч явах төрх үйлд сургах болон өвчний улмаас алдаж гэсэн аж төрөхөд зайлшгүй хэрэгтэй бусад мэдлэг, ур чадваруудыг нөхөн сэргээх болон эзэмшүүлэх үйл ажиллагаанд алхам алхмаар суралцдаг байна. Жил бүрийн 4-р сарын 15-наас 5-р сарын 20 хүртэл төмсний талбай болон хүлэмжид ногоо тариалах бэлтгэл ажлыг хийдэг, 5 сарын 20-ноос 9 сарын 20 хүртэл ургацаа хураах, мөн СЭМҮТ-ийн хашааны ногоон байгууламж дээр ажилчдын тусламжтайгаар ажилладаг.

Дүгнэлт

Сэтгэцийн эмгэгтэй хүн нь бусдын адил нийгэмд бие даан амьдрах чадвартай юм. Сэтгэцийн эмгэгтэй эмчлүүлэгчдийг эмнэлэгт тасгийн нөхцөлд байлгаснаас гэрийн нөхцөлд байлгаж нийгэмд бие даан амьдрах, амьдрах орчин болон өөрийгөө арчлах чадвар суулгах нь эмчилгээний үр дүнтэй байна.

Талархал

Энэхүү судалгааг хийхэд туслалцаа үзүүлсэн СЭМҮТ, Асрамжийн 1, 2-р клиник, Нийгмийн Эрүүл Мэнд Эрдэм Шинжилгээ Сургалт Гадаад Харилцааны Албанд талархал илэрхийлье.

Ашигласан хэвлэл

[1] Сэтгэцийн эмгэг судал. С.Бямбасүрэн. 2013 он

[2] Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааны үр дүн. Бүлэг 5. Хөгжлийн бэрхшээл. 2013 он

[3] Сэтгэц судлал. Л.Эрдэнэбаяр. 2012 он

[4] <https://www.1212.mn/>

АХМАД НАСТНЫ ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ АНХДАГЧ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ТАРХАЛТЫН СУДАЛГАА

У.Эрхэмбаяр^{1,2}, Х.Бямбасүрэн^{1,3}, Х.Сайнсанаа⁴, Н.Болормаа¹, П.Ундармаа¹, С.Гэрэлмаа¹,
Д.Дэлгэрмаа¹, Д.Нарантуяа¹, С.Өнөрсайхан¹

¹Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

²АШУҮИС, Нийгмийн эрүүл мэндийн сургууль

³Монгол улсын боловсролын их сургууль

⁴ Монгол улсын их сургууль

Хураангуй:

Дэлхийн улс орнуудад насны үечлэл харилцан адилгүй ялгаатай байдаг. Манай улсын “Ахмад настны тухай” хуульд эрэгтэй 60 ба түүнээс дээш, эмэгтэй 55 ба түүнээс дээш настай хүмүүсийг ахмад настанд тооцдог. Монгол улсад 60, түүнээс дээш насны хүн ам нийт хүн амд эзлэх хувь 2015 онд 6.4% байсан бол 2030 онд 11.9%, 2050 он гэхэд нийт хүн амын 21.1%-тай тэнцэх магадлалтай байна. Азийн хөгжлийн банкнаас 2018 онд хийсэн “Монгол улс – Шинжилгээ, судалгаа”-нд ахмад настны 85.5% нь нэг буюу түүнээс дээш удаа өвчилж бараг 80% нь халдварт бус өвчин(ХБӨ)-ий эрсдэлтэй байна гэж дурджээ. “Халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалт” үндэсний 4 дүгээр судалгааны хүрээнд Монгол улсын 55-69 насны ахмадуудын дунд Халдварт бус өвчний анхдагч эрсдэлт хүчин зүйлсийг судлахад 55-69 насны хүн амын 34.8% буюу 3 хүн тутмын 1 сүүлийн нэг сард архи хэрэглэсэн, 26.8% буюу 5 хүний 1 нь тамхи хэрэглэдэг, жимс, хүнсний ногооны хоногийн дундаж хэрэглээ 3.1 нэгж, үүнээс жимс 0.8, хүнсний ногоо 2.3 нэгж хэрэглэж байгаа нь ДЭМБ-ын зөвлөмж хэмжээнээс доогуур, давсны хэрэглээ ДЭМБ-ын зөвлөмжөөс 2 дахин их, 61% нь биеийн хүч их шаардсан эрчимтэй хөдөлгөөн хийдэггүй болох нь тогтоогдов. Монгол улсын хүн амын 2 хүн тутмын 1 нь ХБӨ-өөр өвчлөх өндөр эрсдэлтэй байгаа нь анхаарал татах асуудал бөгөөд хүн амд зохистой хооллолт, эрүүл амьдралын талаар зөвлөгөө өгөх нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд шаардлагатай төсөв, санхүүжилт, сургалт сурталчилгаа, хүний нөөцийн асуудалд анхаарал хандуулах шаардлагатайг харуулж байна.

Түлхүүр үг: Архи, тамхи, хүнсний ногоо, жимс, давсны хэрэглээ, хооллолт, хөдөлгөөн

Удиртгал

Дэлхий дахинд ахмад настны тоо эрчимтэй нэмэгдэж байгаа талаар Дэлхийн насжилтын хяналтын индекс (Global Age Watch Index) - 2015 судалгааны тайланд дурьдсан байна. Өдгөө 60-аас дээш настай 901 сая ахмад настан амьдарч байгаа нь дэлхийн нийт хүн амын 12.3%-ийг эзэлж байна [1]. Монгол Улсын хувьд 60, түүнээс дээш насны хүн ам нийт хүн амд эзлэх хувь 2015 онд 6.4% байсан бол 2030 онд 11.9%, 2050 он гэхэд нийт хүн амын 21.1%-тай тэнцэх магадлалтай байна [2,3]. Дэлхий нийтэд хүн амын өвчлөл, нас баралтад

нөлөөлж байгаа зонхилох 10 эрсдэлт хүчин зүйлээс хамгийн түгээмэл, зан үйлийн анхдагч эрсдэлт хүчин зүйлс нь зохисгүй хооллолт, хөдөлгөөний хомсдол, архи, тамхины хэрэглээ бөгөөд эдгээр нь илүүдэл жин, цусны даралт ихсэлт, цусан дахь өөх тос, сахарын хэмжээ нэмэгдэх зэрэг завсрын хүчин зүйл байдлаар илэрч улмаар өвчлөл, нас баралтад хүргэж байгааг Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ) тогтоогоод байна [4,5]. Илүүдэл жин ба таргалалтын шалтгаан, эрсдэлт хүчин зүйл болсон тамхи, архи, согтууруулах ундааны хэрэглээ, эрүүл бус хооллолт, хөдөлгөөний хомсдол манай хүн амын дунд “чимээгүй тахал”-ын хэмжээнд тархаж байна. ХБӨ нь хүний амьдралын буруу хэв маяг, зан үйлээс үүдэлтэй бөгөөд сэргийлэх боломжтой эрсдэлт хүчин зүйлстэй холбоотой болохыг судлан тогтоосон [6,7]. ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйлсийг танин мэдэж, улмаар түүнээс сэргийлж чадвал зүрх судасны өвчин (ЗСӨ), тархины харвалтыг 80%-иар, хавдрыг 40%-иар, чихрийн шижин (ЧШ) хэв шинж 2-оос бүрэн сэргийлэх боломжтойг эрдэмтэд нотолжээ [8]. Азийн хөгжлийн банкнаас 2018 онд хийсэн “Монгол улс – Шинжилгээ, судалгаа”-нд ахмад настны 85.5% нь нэг буюу түүнээс дээш удаа өвчилж бараг 80% нь халдварт бус өвчин (ХБӨ)-ий эрсдэлтэй байна гэж дурджээ [9]. Иймээс ахмад настнуудын ХБӨ-ий анхдагч эрсдэлт хүчин зүйлс болох архи, тамхи, давс, хүнсний ногоо, жимсний хэрэглээ болон хөдөлгөөний хомсдолын тархалтыг тогтоох зорилгоор энэхүү судалгааг гүйцэтгэв.

Зорилго

Ахмад настны халдварт бус өвчний анхдагч эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын түвшин, өнөөгийн байдал, чиг хандлагыг үндэсний хэмжээнд тогтоож, ХБӨ-өөс сэргийлэх нотолгоог бүрдүүлэх

Зорилт


- Ахмад настны архи, тамхины хэрэглээний тархалтыг тогтоох
- Ахмад настны жимс, ногоо, давсны хэрэглээг тогтоох
- Ахмад настны хөдөлгөөний хомсдол ба идэвхийг тогтоох

Ач холбогдол, шинэлэг тал: Энэхүү судалгааны шинэлэг тал нь ахмад настан буюу 55-69 насны хүмүүсийн ХБӨ-ний анхдагч эрсдэлт хүчин зүйл болох архи, тамхи, давс, хүнсний ногоо, жимсний хэрэглээ болон хөдөлгөөний дутлын тархалтын түвшин, өнөөгийн байдал, чиг хандлагыг Монгол улсын хэмжээнд судлан тогтоож, ХБӨ-нөөс сэргийлэх нотолгоог бүрдүүлж байгаад оршино.

Аргазүй: “Халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалт” үндэсний 4 дүгээр судалгааны хүрээнд нэг агшингийн судалгааны аргыг ашиглан Монгол улсын 55-69 насны хүн амыг төлөөлүүлэн санамсаргүй түүврийн аргаар сонгож авч eSTEPS андройд таблет ашиглан асуулгын аргаар хийж гүйцэтгэсэн. Судалгааны мэдээллийн боловсруулалтыг Epiinfo, SPSS.21 программын тусламжтайгаар өгөгдлийн бааз үүсгэн оруулж статистик боловсруулалтыг хийсэн. Үр дүнгийн нарийвчлалын хэмжүүр (дундаж үзүүлэлт, давтамжийн хэлбэлзэх хязгаар) болон хүн амын бүлгүүдийн ялгааг тодорхойлоход 95%-ийн итгэмжит хязгаар (ИХ)-ын утгуудыг ашигласан болно.

Үр дүн

Тамхины хэрэглээний тархалт: Монгол улсын 55-69 насны хүн амын дунд тамхины хэрэглээний тархалт 26.8% (95%ИХ 24.0-29.6), үүнээс эрэгтэйчүүдэд 49.8% (95%ИХ 45.0-54.6), эмэгтэйчүүдэд 5.8% (95%ИХ 4.1-7.4) байна. Хүйсийн байдлаар авч үзэхэд эрэгтэйчүүдийн тамхины хэрэглээ эмэгтэйчүүдээс даруй 8.6 дахин өндөр байна (Зураг 1).




Зураг 1. Тамхины хэрэглээ, хүйсээр

Архи, согтууруулах ундааны хэрэглээний тархалт: Судалгаанд хамрагдсан 55-69 насны ахмадуудын 30.7%(95%ИХ 27.7-33.8) нь сүүлийн нэг 30 хоног буюу 1 сард ямар нэг хэмжээгээр архи, согтууруулах ундаа хэрэглэсэн, 20.6% (95%ИХ 17.9-23.3) нь сүүлийн нэг жилд архи, согтууруулах ундаа хэрэглэжээ.

Судалгаанд хамрагдсан 55-69 насны ахмадууд сүүлийн 1 сард дунджаар 4.9 удаа (95%ИХ 4.4-5.3) архи, согтууруулах ундаа хэрэглэсэн байна. Эрэгтэйчүүдийн архи, согтууруулах ундааг хэрэглэсэн дундаж тоо 5.6 удаа (95%ИХ 4.4-6.6), эмэгтэйчүүдийн дунд 3.7 удаа

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”


(95%ИХ 2.8-4.6) байгаа нь эрэгтэйчүүдийн хувьд статистик ач холбогдол бүхий өндөр байна (Зураг 2).



Зураг 2. Архи, согтууруулах хэрэглээний давтамж

Жимс, хүнсний ногооны хэрэглээ: Эрүүл, зөв хооллолтын зөвлөмжид насанд хүрсэн хүн хоногт “5 нэгж” буюу 400 грамм жимс, ногоо хэрэглэхийг заасан [10]. Судалгаагаар зорилтот хүн амын жимс, хүнсний ногооны хоногийн дундаж хэрэглээг нэгтгэн тооцож, дээрх зөвлөмжид хэрхэн нийцэж байгааг үнэллээ.


Нийт 55-69 насны хүн ам хоногт дунджаар 2.8 нэгж, эмэгтэйчүүд 3.0 нэгж, эрэгтэйчүүд 2.6 нэгж жимс, хүнсний ногоо хэрэглэж байна. Судалгааны үр дүнгээс харахад эрэгтэй, эмэгтэй аль ч хүйсийн хувьд ДЭМБ-аас санал болгож буй зөвлөмж хэмжээнд хүрэхгүй байна. Жимс, хүнсний ногооны хоногийн дундаж хэрэглээ хүйсийн хувьд ялгаагүй байна. (Зураг 3).



Зураг 3. Жимс, хүнсний ногооны хэрэглээ

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

Давсны хэрэглээ: Ахмадууд хоногт дунджаар 10.2 г (95%ИХ 10.4-10.6), хүйсээр нь авч үзвэл эрэгтэйчүүд 12.1 г (95%ИХ 11.9-12.63), эмэгтэйчүүд 8.4 г (95%ИХ 8.6-8.3) давс хэрэглэж байгаа нь статистик ач холбогдол бүхий ялгаатай байна (Зураг 4).



Зураг 4. Давсны хэрэглээ, хүйсээр

Хөдөлгөөний хомсдол:

ДЭМБ-аас эрүүл мэндэд тустай, дунд зэргийн эрчимтэй хөдөлгөөнийг 7 хоногт 150 минут эсвэл өндөр эрчимтэй хөдөлгөөнийг 75 минут хийхийг зөвлөдөг [11]. Энэхүү судалгаагаар хүн амын 32.0% (95%ИХ 28.8-35.3) нь эрүүл мэндэд тустай идэвхтэй хөдөлгөөнийг хийдэггүй байна (Хүснэгт 1).


Үзүүлэлт	Эрэгтэй			Эмэгтэй			Дундаж		
	n	%	95%ИХ	n	%	95%ИХ	n	%	95%ИХ
55-69 нас	538	32.2	27.6-36.8	793	31.9	27.8-36.0	1331	32.0	28.8-35.3

Хүснэгт 1. Хөдөлгөөний хомсдолтой ахмад настны тархалт

Хөдөлгөөний идэвх: Судалгааны хүн амын хөдөлгөөний идэвхийн түвшин үнэлэхэд 27.8% (95%ИХ 25.8-29.8) хөдөлгөөний идэвх “бага”, 18.2% (95%ИХ 16.9-19.5) “дунд”, 54.0%

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ИННОВАЦИ-2020”

(95%ИХ 51.6-56.3) “их” гэсэн ангилалд тус тус багтаж байна. Хөдөлгөөний идэвх багатай хүн амын тархалтад хүйсийн ялгаа ажиглагдсангүй (эрэгтэйчүүдийн 27.2% (95%ИХ 24.7-29.8), эмэгтэйчүүдийн 28.4% (95%ИХ 26.1-30.7)). Хөдөлгөөний идэвх “дунд” хүн амын тархалт эмэгтэйчүүдийн дунд (21.7%, 95%ИХ 19.8-23.5) эрэгтэйчүүдээс (14.7%, 95%ИХ 13.1-16.4), хөдөлгөөний идэвх “их” хүн ам эрэгтэйчүүд (58.1%, 95%ИХ 55.2-60.9)-ийн дунд эмэгтэйчүүдээс (50%, 95%ИХ 47.2-52.7) тус тус илүү байна (Зураг 5).



Зураг 5. Хүн амын хөдөлгөөний идэвхийн түвшин, хүйсээр

Дүгнэлт

1. Монгол улсын 55-69 насны хүн амын 26.8% буюу 4 хүн тутмын 1 нь тамхи татаж байна. Эрэгтэйчүүдийн дунд тамхины хэрэглээ эмэгтэйчүүдээс 8.6 дахин өндөр байна.
2. Манай улсын 55-69 насны хүн амын 30.7% буюу ойролцоогоор 3 хүн тутмын 1 нь сүүлийн нэг сарын хугацаанд архи, согтууруулах ундаа хэрэглэжээ.
3. Эрэгтэйчүүдийн дунд архи, согтууруулах ундааны хэрэглээ эмэгтэйчүүдээс 1.8 дахин өндөр байна.
4. Монгол улсын 55-69 насны хүн ам хоногт дунджаар 2.8 нэгж жимс, хүнсний ногоо хэрэглэж байна. Энэ нь ДЭМБ-ын “Эрүүл, зөв хооллолтын 5 нэг” гэсэн зөвлөмж хэмжээнээс доогуур байна.
5. Манай улсын 55-69 насны хүн ам хоногт дунджаар 10.2 г давс хэрэглэж байна. Энэ үзүүлэлт нь ДЭМБ-ын зөвлөмж хэмжээнээс өндөр байна.
6. Монгол улсын 55-69 насны хүн амын 32.0% буюу 3 тутмын 1 нь хөдөлгөөний хомсдолтой байна.

Талархал: "Халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын IV судалгаа"-г амжилттай зохион байгуулж, техник, санхүүгийн дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан ЭМЯ-ны дэргэдэх Судалгааны зохицуулах хороо, ДЭМБ-ын Женев дэх Төв байгууллагын мэргэжилтэн Стефан Савин, Патришиа Рарау, ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн төвийн мэргэжилтэн Варрик Жунсук Ким, Хожүүн Лий, Монгол дахь ДЭМБ-ын суурин төлөөлөгч Сергей Диордица, ХБӨ-ний асуудал хариуцсан мэргэжилтэн С.Болормаа, ЭМЯ-ны Дэмжих сан, НЭМГ, Гялс лабораторийн хамт олон болон судалгаанд хувь нэмрээ оруулсан бүх хүмүүст судалгааны багийн хамт олны өмнөөс гүн талархал илэрхийлье.

Ашигласан материал

- [1] Global status report on road safety 2013, Supporting a decade of action, WHO, 2013.
- [2] Эрүүл мэндийн үзүүлэлт 2016 он, хуудас 84, 85 ЭМХТ, 2016 он
- [3] Үндэсний статистикийн хороо, Статистик мэдээллийн нэгдсэн сан, Монгол Улсын хүн амын тоо, насны бүлэг, хүйсээр, 2017 он, www.1212.mn
- [4] World Health Organization, Global status report on noncommunicable diseases 2014, S. Mendis, Editor. 2014, World Health Organization.
- [5] World Health Organization, Global action plan for the prevention and control of noncommunicable diseases 2013-2020. 2013, World Health Organization: Geneva.
- [6] WHO STEPS surveillance. STEPS sample size calculator
- [7] WHO STEPS Surveillance Manual. Geneva, 26 January 2017
- [8] Population proportional sampling WHO STEPS surveillance. STEPS sampling spreadsheet
- [9] НҮБ-ын төрөлжсөн агентлагийн хамтарсан багийн ХБӨ-ий НЭЗ-ийн нөлөөллийн үнэлгээ, 2016 он
- [10] WHO Healthy diet, 23 October 2018, <https://www.who.int/en/news-room/factsheets/detail/healthy-diet>
- [11] WHO Handbook for guideline development, October 2009. Geneva, World Health Organization, 2009.